

РОНАЛД ЛЭЙТХЭМ

# МАРКО ПОЛО АЯЛАЛ



БОЛОР СУДАР ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

Марко поло аялал  
Зохиолч: Роналд Лэйтхэм  
Орчуулсан: Зэлмэ О.Бүрэнжаргал  
Редактор: Г.Бадамсамбуу

ISBN: 978-99962-1-500-1

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Марко Поло аялал

### Роналд Лэйтхэм

МАРКО ПОЛО нь 1254 онд Венецийн худалдаачин Никколо Пологийн хүү болон төржээ. Түүний аав, авга ах хоёр 1260 онд Их Юань (Хятад) улсад анх очиж байсан бөгөөд 1271 онд дахин Дорныг зорих аялалдаа залуу Марког авч явжээ. Тэд Хубилай хааны дэргэд алба хашиж, тив дэлхийгээр хэрэн аялсаар тэндээ бүтэн хорин жил суужээ.

Монгол хааны албад зарагдан Эзэнт гүрний нутгаар олонтоо аялж байсан төдийгүй Энэтхэгт хүрч, Бээжингээс Бирмд очиж байсан нь эргэлзээгүй юм. Энэ урт хугацаанд Өрнөдтэй харьцах Маркогийн холбоо бүрмөсөн тасарчихаагүй нь Дорно зүг рүү аажим нэвчин тархах Загалмайн шашин, түүнийг дагасан худалдаа наймааны хэлхээ холбоо байсан биз ээ. Хятадад үндэсний үзэл ахин сэргэсэн 1368 оноос Өрнө, Дорнын харилцаа саатаж, таагүй нөхцөлд шилжсэн билээ. Марко Поло урт аянаа дуусган төрөлх Венеци хотдоо 1292 онд эргэн очсон хэдий ч 1298-99 оны Венеци, Генуягийн зөрчилдөөний улмаас олзлогдож, шоронгийн хоригдол болжээ. Тэрээр ийнхүү хоригдож байхдаа Пиза хотын иргэн, зохиолч Рустичеллотой уулзаж танилцсан байх магадлалтай аж. Энэхүү “Аялал” ном нь гярхай ажигламтгай худалдаачин, мэргэжлийн зохиолч хоёрын хамтын бүтээл юм. Марко Поло 1324 онд насан өөд болохдоо түүний үлдээсэн өмч хөрөнгө, аяны олзыг гурван охинд нь адил тэнцүү хуваан өгчээ.

Роналд Лэйтхэм нь Эртний Ромын яруу найрагч, гүн ухаантан Тит Лукреций Карийн “Орчлон ертөнцийн мөн чанар”-ыг латин хэлнээс орчуулсан дуун хөрвүүлэгч. Тэрээр 1907 онд Нортамберланд гэдэг газар төрсөн бөгөөд Баллиол Коллеж болон Оксфордыг төгсөж, Белфастын Хатан хааны Их сургуульд латин хэлний багшаар томилогдон ажиллаж байв. Дайны жилүүдийг эс тооцвол 1934-1967 онуудад “Assistant Keeper of the Public Records”-д тасралтгүй ажилласан. Лэйтхэм нь эртний эдлэл сонирхогчдын нийгэмлэг болон О.В.Е-гийн гишүүн байв. Мөн “Норманы иргэншлийг хайж олсон нь” бүтээлээ нийтлүүлж, Дундад зууны Англи, Ирланд эх сурвалжууд дахь “латин үг, хэллэг”-ийн жагсаалтыг эмхэтгэж Британий академийн цувралуудаар гаргаж байсан. Тэрээр Англи эх сурвалж дахь Дундад зууны латин үгсийн Оксфордын толийг хянан тохиолдуулж хэвлүүлсэн юм. Лэйтхэм 1992 онд таалал төгссөн.

Уг номын орчуулагчийн баримталдаг монгол язгуур үгийн үндэс эвдэхгүйн тулд шилжих болон гээгдэх эгшигийг хэвээр хадгалсан, мөн ж, ч, ш –ийн араас “и” эгшиг залган бичиж тэмдэглэснийг хэвлэлийн газрын зүгээс зөрчин БСШУЯ-аас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэл бичгийн дүрмээр засварлан буулгалаа.

"Болор судар" хэвлэлийн газар

## Орчуулагчын өчил

Марко Пологийн “Аялал” хэмээх ном 200 гаруй жилийн тэртээгээс эхлэн Баруун Европын бараг бүх хэлнээ орчуулагдан хэвлэгдэж уншигчдын хүртээл болжээ. Харин монгол хэл рүү орчуулж хэвлүүлэх үйлийг 75 жилийн өмнө эхэлж байсан түүхтэй ажээ.

Улсын төв номын санд Марко Пологийн номын монгол орчуулга гар бичмэл хоёр хувь эдүгээ хадгалагдаж байгаа нь их зохиолч Д.Нацагдоржийн орчуулга билээ. Энэ нь Герман эрдэмтэн доктор Алберт Херманы найруулсан “Их Хааны ордонд хэмээх Итали улсын Марко Пологийн Төв Ази ба Дундад улсаар аялан явсны өгүүлэл”-ийг 1936 оны үед герман хэлнээс монгол хэл рүү орчуулсан 8 бүлэг 266 хуудас гар бичмэл хувь юм. Тэрхүү гар бичмэл орчуулгыг Би.Ба(Банзрагч) гэгч хүн худам монгол бичгээр хичээнгүйлэн хуулбарлаж, үдэж дэвтэрлэсэн нь 275 хуудас гар бичмэл болсон бөгөөд “1949 оны 12 дугаар сарын 31-ний өдөр уг эх бичгээс хуулан бичиж төгсөв. БНМАУ-ын Сталины нэрэмжит Улсын нийтийн номын сан” хэмээн төгсгөжээ. Энэхүү гар бичмэл номын өөр нэг хуулбарт Б.Бадамсэрээжид гэгч хүн 1968 оны нэгдүгээр сарын 15-нд кирил монгол бичгээр гарчгийг нь сийрүүлэх оролдлого хийсэн байх ба 7 дугаар бүлгийн нэрийг сийрүүлэлгүй орхижээ. Энэ орчуулга тэр хэвээрээ олны хүртээл бололгүй, хожмийн ганц нэг судлаач сонирхож жиших төдийгөөс хэтрэлгүй хадгалагдсаар иржээ.

Мөн судлаач Мануэль Комроффийн (Manuel Komroff) найруулан бичсэнийг 1945 онд “Марко Пологийн тойрон явсан аяны тэмдэглэл” нэртэйгээр монгол хэлнээ хорголжин бараар Өвөрмонголд хэвлэж гаргасан нь Монгол улсын төв номын санд 2 хувь хадгалагдаж бий. Энэхүү номын оршилд “Цахар чуулганы Ажаа гэгээний сүргийн Чимэд Гомбожав хичээнгүйлэн бичив. Богд Чингис хааны 737 дугаар оны тавдугаар сарын 15-ны өдөр тохиов” гээд номын төгсгөлд “Богд Чингис хааны 739 дүгээр оны долоодугаар сарын 20-нд анх дармаллавай. Дармалласан газар Өөртөө засах Монгол улсын Тэргүүн ноёны ордны дармалын газар. Орчуулсан Гомбожав. Тараасан газар Өөртөө засах Монгол улсын тэргүүн ноёны ордны судар бичгийн гэр. Хоёр дэвтэр 596 хуудас” хэмээсэн нь Өвөрмонголын бичгийн хүн Гомбожав бээр 1943 онд орчуулан дуусгажээ гэсэн үг болно. Эдүгээгээс даруй 68 оны тэртээ Чингис эзний он тооллыг эрхэмлэн баримталж тэмдэглэсэн нь монгол хүний үзэл санааны сонирхолтой хандлага ажиглагдаж байгаа нь анхаарал татах баримт мөн.

Өвөрмонголын эрдэмтэн Сайшаал 1977 онд “Марко Пологийн аяллын тэмдэглэл” нэртэйгээр орчуулж Гириний ардын хэвлэлийн хорооноос (Өвөрмонголд) хэвлэн гаргаж байжээ.

Харин манай монгол уншигчид 1987 онд А.Очир, Б.Дорж, С.Идшинноров нар орос хэлнээс орчуулж, С. Бадамхатан редакторласан “Орчлонгийн элдэв сонин”(Улаанбаатар) гэсэн нэртэй Марко Пологийн аяны тэмдэглэлтэй анх танилцжээ. Энэ монгол орчуулга нь оросын эрдэмтэн И. П. Минаевийн франц хэлнээс (Бенедеттогийн хувилбарыг барьж) орос хэл рүү орчуулсан гурав дахь хэвлэлийг баримталжээ. Гурав дахь хэвлэлийг ЗХУ-ын үед гаргажээ. Зөвлөлтийн үед хэвлэсэн уг эх нь товчлон хураасан, түүхэн үйл явдал, түүхт хүмүүсийн талаарх мэдээ, мэдээллийг дутуу, бүрхэгдүү тусгасан талтай байдаг. Тухайлбал: Тэр үеийн орос орны хүн зоны ахуй амьдралын илэн далангүй байдал, Орос орон өөрөө Алтан ордны

Монгол хаадын эрхшээл захиргаанд байсныг өгүүлсэн хэсгийг “санамсаргүй” гэж орхисон байна. Энэ мэт коммунист үзэл сурталд И. П. Минаевийн орчуулга танагдан “хэлмэгдсэн” тал ажиглагдана. Тиймээс үүнийг орчуулагч би бээр Орос орчуулгын анхны хэвлэлийг хайн олж, орчуулгаа харьцуулан тулгах ажилд түлхүү ашигласан болно. И. П. Минаевийн Франц хэлнээс орчуулсан анхны эх нь 1873 оны долоодугаар сарын 11-нд Санкт-Петербург хотноо “Путешествие въ 1286 году по Татаріи и другимъ странамъ востока Марко Поло, венецианскаго дворянина Прозваннаго Милліонеромъ” гэсэн нэртэйгээр хэвлэгдэн гарсныг АНУ-ын Колумбийн Их сургуулийн Төв номын сангаас эрхлэн “цахим ном” болгон интернэтэд нийтэлснийг тулган үзэж өөрийн орчуулгаа (Рональд Лэйтхэмийн орчуулга) харьцуулан шалгахад орос эх нь зарим талаар товч, мөн хоёр зуу гаруй бэсрэг бүлэглэсэн өөр бүтэцтэй хэдий ч уг номонд өгүүлж байгаа гол үйл явдал болон утга агуулгын хувьд хол зөрөөгүй байв.

“Аялал” номын орчуулгыг хийхдээ мөхөс би Английн судлаач Рональд Лэйтхэмийн орчуулгаар 1958 онд анх хэвлэгдсэн хийгээд эдүгээ хамгийн түгээмэл дэлгэрсэн эхийг сонгож баримтлав. Мөн И. П. Минаевын 1873 оны орос орчуулга, А. Очир нарын 1987 оны монгол орчуулгыг үе үе харьцуулан нягтлах шаардлага гарч байсан болно.

Эдүгээ англи хэлээр орчуулагдсан Марко Пологийн “Аялал” номын хэд хэдэн хувилбар байх бөгөөд судалгаа шинжилгээний үнэ цэнэ, нийт уншигчдад хүртээл болсон байдлаараа Рональд Лэйтхэмийн орчуулга өөрийн давуу талтай хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн билээ. Гол нь Р. Лэйтхэм авхай 20 шахам жилийн турш эртний латин-франц хувилбаруудыг нэхэн хөөж, харьцуулах зэргээр нягт судалсан ба мөн өмнөх англи орчуулгуудыг сайтар шүүж сонгомол гэхээр хувилбарыг эмхэлж хэвлүүлсэн ба энэ нь хамгийн олон уншигчдыг хамрах болсон байна. Сүүлийн хагас зуун жилд Р. Лэйтхэмийн хувилбар орчуулга нь англи хэлт уншигчдийн “Марко Поло” болж хэвшсэн билээ.

Бид ч басхүү чадлын хирээр мөшгөн хэлэлцсээр “Лэйтхэм” хувилбарыг сонгож зүрхлэн орчуулсан нь энэ болой. Чингэхдээ Марко Пологийн дурсамж хүүрнэлийг Англи эрдэмтэн Роналд Лэйтхэм эх хэлэндээ хэрхэн уран яруу дүрслэн буулгасныг монгол уншигчиддаа утга санааг нь гажаалгүй, хэллэгийн ур дүрслэлийг нь бүдэгрүүлж мохоолгүй хүргэхийг хичээн чармайв. Орчуулахдаа өгүүлбэрийн хэмжээ, үгийн тоог тэр бүр ягштал оноож хадах зорилго агуулсангүй, харин үг, өгүүлбэр бүрийн утга, санаа монгол хүний оюун санаанд хэрхэн яаж бууж дүрслэгдэх, англи хэлц, хэллэгийн ур, утгыг монголоор яаж хэлбэл зөв, ойлгомжтой байх зарчмыг баримтлав. Орчуулгынхаа утга санаа, хэлц, хэллэгийн агуулгыг төв нуруутай байлгах үүднээс “Аялал” номынхоо англи үг, өгүүлбэрийг орос орчуулгад хэрхэн яаж буулгасныг ч бас харьцуулан тулгаж, зөв дээр гэж үзсэнээ барив. “Аялал” ном нь 20 гаруй жилийн тэртээ Улаанбаатарт хэвлэгдээд одоо олдохоо больсон “Орчлонгийн элдэв сонин” (А. Очир нар. 1987) номноос бүтцийн хувьд ялгаатай, багтааж харуулсан үйл явдал, мэдээ мэдээлэл, баримт сэлтээр харьцангуй арвин байгаа нь сонгосон эхийн онцлогоос шалтгаалж байгаа билээ. “Танилцуулга”, “Өмнөх үг”, “Төгсгөл үг”-ээс гадна үйл явдал болж буй газар орон, цаг хугацаа, түүхэн хүмүүс, нөхцөл байдлыг хооронд нь нягт холбож бичсэн өргөн агуулгатай есөн үндсэн бүлгээс бүтэж байгаа юм.

Номын “Танилцуулга” хэмээх эрдэм шинжилгээний удиртгал нь судлаачдад хандсан Роналд

Лейтхэмийн хорь гаруй жилийн нөр их хөдөлмөрийн үр дүн, эрэл хайгуулын нь товч тайлан юм. Түүний энэ номын “Танилцуулга”-д өгүүлснээр “баруун Европын ихэнх хэлээр, тэр ч атугай Ирландаар хүртэл орчуулагдсан..” гол хувилбаруудыг судалж үзсэнээр барахгүй, энэ талаар өмнөх үеийнхээ 700 гаруй жилийн туршид хуримтлагдсан судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, туурвил, тэмдэглэл зэрэг олох боломжтой эх сурвалжуудыг шүүн тунгааж он цаг, үйл явдлын дэс дарааллын уялдаа холбоог тогтоон, хаягдсан гээгдсэн бүхнийг олдоцын хэрээр нь сэргээн амилуулж байж энэхүү номыг бүтээжээ. Энэхүү номын есөн бүлэг нь харь орон, газар нутгаар 20 гаруй жил аялсан хүний үзэж харсан зүйл, учирч тохиолдсон адал явдлын тухай хүүрнэл-ярианы баримтаг тэмдэглэл боловч эрдэмтэн Роналд Лейтхэм үүнийг адал явдалт уран зохиолын туурвил мэт уран яруу дүрслэн бүтээж орчин цагийн хүмүүсийн хүртээл болгожээ.

Энэхүү номын туршид монголчуудыг “Тартар” хэмээх дуудлагаар нэрийдэж бичсэн байдаг. Энэ нь нүүдэлч татар аймгийн нэртэй холбоотой бус харин Библийн сударт чөтгөр шулмын дайчдыг “tartarus” хэмээн бичсэн байдгаас үүдэн “монгол цэрэг”-ийг Загалмайтнууд цаашид тийн нэрлэх болжээ гэж олонх судлаачид үзсээр иржээ. Энэхүү монгол орчуулгад “Аялал” номын доторх дээрх мэт нэр ус, нэршлийг тэр бүр хэт монголчлох гэсэнгүй харин түүхэн ач холбогдлыг хөндүүзэй хэмээн зүүлт, тайлбарын хамт ихэнхдээ тэр хэвээр нь, гэхдээ жирийн уншигчдад ойлгомжтой байхыг бодолцон байж буулгав. Марко Поло тэр үеийн улс үндэстнүүдийг шашин мөргөлөөр ангилан ялгаж нэрлэж асныг уг зохиолын уугуул чанарыг хадгалах үүднээс мөн л гажаалгүй баримтлав. Исламийн улс, иргэдийг бүхэлд нь “Сарацин” гэж нэрлэснийг, Монголын эзэнт гүрний харьяа Ил хаадын улсыг “Левант” хэмээсэнийг хэвээр хадгалав. Харин Христийн шашинтнуудыг бүхэлд нь “Загалмайтан” гэж, Буддын шашны янз бүрийн урсгалууд болон Азийн шашин шүтлэг, бөө мөргөлүүдийг бүгдийг нь Idolaters (онго шүтлэгтэн) гэж ерөнхийд нь нэрлэснийг монголшуулан буулгах нь зохистой гэж үзсэн болно.

Номонд гарч буй газар орон, муж ханлиг, хот балгад, хүний нэрийг уламжлалт монгол нэрээр нь харьцуулан үзэж буулгах, эсвэл англи дуудлагыг нь гажаалгүй кирилл монголоор тэмдэглээд хаалтан дотор Лэйтхэмийн англи бичлэгээр нь хадгалсны учир бол уншигч, судлаач авгай нарыг төөрөгдүүлэхгүй гэсэн санаа агуулсных билээ.

Монголын түүх бичлэгт урьд өмнө төдийлөн элбэг дурьдагдаж байгаагүй цөөнгүй сонин баримт сэлт энэ номонд орсныг уншигч, судлаач авгай нар минь анзааран тунгаана буй за.

Орчуулгын явцад зарим нэгэн үйл явдлыг улам тод томруун болгох санаа сэдлээр англи эхэд нь огт байхгүй монгол зүйрлэл авч хэрэглэсэн нь миний сэтгэлийн хөөрөл биш бөгөөд өөрийнхөө “эх монгол хэл”-ээ ядуу, дулимаг мэддэгээ нөхөх гэсэн болхи оролдлого тул та бүхэн зөв ойлгож намайг өршөөн соёрхоно гэж найдаж байна. Эдгээр зүйрлэлийн заримаас жагсаан толилуулбал: 5 дугаар талд “эвшээлгэх нум, исгэрэх сум”, 21 дүгээр талд “газар үзэж, нүд тайлсан”, 130 дугаар талд “шүдэнд орсон мах, нүдэнд орсон шороо” гэсэн бий. Эдгээр зүйрлэл нь өгүүлж буй үйл явдлыг улам тодруулан товойлгохын зэрэгцээ орчуулгын утга санааг монгол хүний чихэнд наалдацтай, сэтгэлд хоногшилтой болгож байгаа бөгөөд англиар өгүүлж байгаа утга агуулгыг гажаалгүй илэрхийлж байгаа билээ.

Мөн монгол язгуур үгийн гээгдэх болон шилжих эгшгийг хэвээр хадгалсан, ж,ч, ш-ийн араас

заавал “и” эгшиг залган амь оруулсан, зөөлний тэмдэг (ь), хатуугийн тэмдэг (ъ) –ийг хаа сайгүй хэрэглээгүй нь монгол туургатны Их эрдэмтэн Ц. Дамдинсүрэн гуайн “Кирилл цагаан толгой”-н дүрмийг санаатайгаар зөрчиж байгаа мэтээр уншигч авгай нарт санагдаж болох боловч язгуур монгол хэл бичгийн дүрмээс маань нэг их гажаагүй гэдгийг зөв тусган ойлгож өршөөн соёрхох ухаантай, боловсролтой уншигчдад энэхүү орчуулгын ном хүрч байгаа гэсэн итгэл тээн, буруу аваас миний алдаа огоорлыг уужим сэтгэлээр уучилана уу гэж хүлцэл өчмүй.

Энэхүү номыг орчуулахыг санаачилж, надтай нэг баг болж, хазайсан орчуулгыг залруулан, хальгирсан санааг тэнцүүлэн алхам тутамд минь туслаж дэмжин, тулж тэтгэсэн Сэтгүүлч Гоёохоо Г. Бадамсамбуу, миний хүү Зэлмэ Б. Эрдэнэсанаа хоёртоо гүн талархлаа өргөн ёслон хүндэтгэж байна.

Орчуулсан Зэлмэ О.Бүрэнжаргал

(Техникийн ухааны доктор)

## Уншигчдад хүргэх үг

### Дундад эртний “Bestseller”-ийн нөлөө ба “Худалч” Марко

Өрнөдийнхөн Дорно зүгийн талаар тун бага мэдлэгтэй байлаа. Тэд, Библийн номлолоос хальж гарахгүй, домог үлгэрт итгэх байдлаар ертөнцийг төсөөлөн суудаг байжээ. Энэ хачин түгжигдмэл байдал нь Монголчууд дэлхийн түүхийн тавцанд цойлон гарч ирэх үед бүр тодорхой байв. Үл дийлдэх нүсэр арми, аллага хядлага, зэрлэгүүд Дорно зүгээс нөмрөн айсууг тэд сонсон аймсаж, тааж ядацгаав. Тэгээд Загалмайтнууд мөнөөх л домог үлгэр, ариун судраасаа учир шалтгааныг хайжээ. Эцэст нь аврагч, эсвэл шулмын хүч тэртээ зүүн зүгт буйг олж сонсоцгоов. Зүүнээс сонсдох тэр дуулиан нь Монголчууд байлаа. Домгийн ёсоор бол Загалмайтнуудыг Прэстэр Жон хэмээх баатар дорноос ирж авран хамгаалах учиртай, энэ нь Иерусалимын төлөөх цуврал аян дайнд тамираа барж буй тэдэнд эрх жаргал авчирч, сүүлчийн аврагч найдлага нь болох байлаа. Тэд эхлээд Прэстэр Жон ирж явна гэж итгэв. Бурханы цэргүүд замынхаа нүгэлтнүүдийг гэсгээсээр ойртож буй хэмээн баярлалдан шуугижээ. Гэтэл биш байлаа. Аюумшигт мангасууд дөтөлж явна гэнэ. Тар-тарр, тар-няр гэх шиг хачин нэртэй хэрцгий дайчид гэнэ. Доод тив-тамаас Тартарус хэмээх адгуусан төрхтэй шулмын цэргүүд босон гарч ирэх тухай Библийн сударт өгүүлсэнтэй нэр нь таарч байна гэж итгэв. Тэд ертөнц мөхөхөд ирэх учиртай. “Бүхнийг мэдэгч нь ариун Библи билээ!”. Үүнээс үүдэн монголчуудыг Тартар хэмээх болсон ажээ. Мөн Прэстэр Жоныг ч Өрнөдийнхөн хүлээсээр байв.

Тартаруудын нутгаар аялсан жуулчин Марко Поло ч Жон хааныг хайж байсан бөгөөд дуудлага төстэйгээс болсон уу яасан “Хэрэйд ван” цол хэргэмийг “Прэстэр Жон” хэмээн эндүү итгэж “Аялал” номондоо үлгэрийн Прэстэр Жоныг үнэхээр бодит хүн байсан мэтээр бичиж үлдээжээ. Ингэж Хэрэйдийн Ван хаан Тоорил нь домогт Прэстэр Жон хэмээгдсэн адал ташаа өгүүлэмж бас энэ номонд оржээ. Энэ мэт алдаа, хэтрүүлсэн зүйлс тааралдах хэдий ч Итали зохиолч Рустичеллод Марко Пологийн хэлж бичүүлсэн уг ном хичнээн чухал түүхэн үнэнийг тээж ирснийг хүн төрөлхтөн одоо сайтар мэдэх болжээ. “Аялал” ном нь манай гарагийн хамгийн алдартай адал явдлын тэмдэглэлийн нэг бөгөөд уг хүүрнэл нь үнэн түүх энэ мэт гоц сонирхолтой байж болохын үлгэрийг анх үзүүлсэн бүтээл гэдэг.

Өрнөдийнхний бүрхэг төсөөлөлд Марко Полоос өмнөх аянчид зохих мэдээ хүргэсэн ч Марко Поло жинхэнэ ёсоор шуугиулж Дорнын ертөнцийг Европчуудад нээж өгсөнд тооцогддог. Дорнын тухай Европчуудын төсөөлөл нь инээдтэй гэнэн зүйлсээр дүүрсэн байдаг байлаа. Монголчуудын унаа морь нь ой моддоор хооллодог үлэмж биетэйг сонсож айж чичрэх ба эзэн нь хүний мах, бас нохой, могой иддэг, цээжиндээ нүдтэй, гэдсэндээ амтай, толгой гэх юмгүй, ганц хөлтэй, аварга биетэй, чармай шалдан явцгаадаг хэмээсэн цуурхалд итгэнэ. Тэгээд мөнхүү төсөөллүүдээ зурж, бичиж үлдээсэн нь бүр ч хөгтэй юм. Марко Пологийн ном тэдний төөрөгдлийг хазаарлажээ. Хазаарлаагүйсэн бол бүр элэг хөшөөм, Өрнөдийнхний сэтгэлзүйг илчилсэн марзан үлгэрүүдээр “баяжиж” үлдэх байсан биз. Гэтэл дэлхий ба хүмүүсийн тухай дээрх лүгээ адил гаж төсөөлөл тэдний “болхи бүдүүлэг” хэмээн доромж үзсээр ирсэн Монголчуудад байгаагүй гэж хэлж болно. Учир нь морьтон нүүдэлчид байгаль ертөнцийн эн хэмжээ, шинж төлвийн талаар өргөн туршлага, баримжаатай хүмүүс байлаа.



Тэд уулсын цаана уулс, хязгаарын тэртээ хязгаар, тэнгис, гол мөрөн, тэр бүхэнд хүмүүс залган сууцгаадгыг ойлгодог байжээ.

Оюун санааны хувьд Ромоос хойш эргэж хумигдсан гэмээр Европчуудын энэ төөрөгдөл-харанхуйллын үеийг эвдэхэд зохих тунгаар туслалцсанаараа, өдгөө болтол эрт зууныг эргэж танихад бид мэтэст нэгэн эш замч болж байгаагаараа эрхэм Марко Поло хүндтэй нэгэн билээ. Маркогийн гэгдэх олон зуун гар бичмэл тухайн үедээ тараагдаж, түүнээс эдүгээ “100 гаруй хувилбар үлдсэний хоёроос бусад нь ерөнхийдөө адил юм”<sup>7</sup> гэж судлаач Л.Бэргрийн бичжээ. XVI зуунд Библийн адилаар, хамгийн эртний хэвлэмэл номын нэг болсон даруйдаа энэ түүх бүр ихээр алдаршив. Дундад зууны газарзүйч Г.Б.Рамусио “Хэдхэн сарын дотор Итали даяар тархлаа” гэж бичиж байлаа. Хүмүүс анхандаа уг номыг түүх, газарзүй, аяллын баримтат бүтээл гэхээсээ илүү уран сэтгэмжийн туульс мэтээр хүлээн авсан нь жаахан урамгүй санагдахаар хэдий ч гол нь машид сонирхоцгоож байжээ. Хубилай хааны нэр Артур ван шиг, харин Катай хэмээх нэр эр зоригтны өлгий болж ойлгогдлоо. Марко Пологийн нэр удалгүй Европод адал явдал, эр зориг, цуу дуулианы үлгэр болж алдаршжээ. Баатарлаг үйлс, тэнгис далайг гатлах, харь тэртээг нээх... Аврагч шидэт хаан, Тамын дайчид байхгүйг Маркоогоос ойлгосон Өрнө дахин аажимдаа сэргэн хөдөлж, улмаар “Бага мөстлөгийн үе”<sup>8</sup>-ийг туулж байж сая дэлхийн тухай ягшмал төсөөллөө өөрчилж эхэлсэн билээ.

Европ даяараа Дорныг хорхойсон сонирхох болов. Нэр төрд донтогсод, газарзүйн нээлтийн төлөө улайрагсад тэр зүг рүү Марко Пологийн араас хошуурч, дэлхий дээр өнөө болтол аялах дураараа гайхуулдаг Европ хүн “төлөвшихөд” нөлөөлжээ. Үзэсгэлэнт цайз, гоё сүмүүдтэй, бас анхны их сургуулиуд байгуулагдсан хэдий ч тэдний соёл нь Загалмайн сүүдэр дор, байгаль, ертөнц, хүний тухай мэдлэгүүд нь номлол, цуурхлаас давахгүй хүлгэлзсээр байжээ. “Европчууд бараг мянган жил нэг л орчиндоо хаалттай суусаар байжээ”<sup>9</sup>.

Хубилай хаан, Катай орон, Тартарууд, алт эрдэнэс... шидэт ертөнц тэртээ Дорно тэртээд байх шиг Өрнийнхэнд санагдаад байлаа. Маркогийн тэмдэглэл бүхэлдээ шинэ газар, шинэ нэрс, бараа таваар, баялаг, шинэ адал явдал, шинэ нээлтүүдэд уриалсан дуудлага болж байлаа. Гэвч дорно зүг рүү Өрнийнхний шунал улам хорхойсон ассаар, идэвхтэй хөдөлж эхлэх үед нь чөлөөт худалдааны эрин дуусаж байв. Монголын эзэнт гүрэн хямарч, Их хааны домгийг хаалттай Мин улс-хятадууд орлох болов. Доголон Төмөрийн түрэмгийлэл Дундаж Азийг дамнаж, тэгээд Оттоманы Түрэгүүд гарч ирэв. Алтайн морьт нүүдэлчид ийнхүү дараалан ноёлсоор Ази руу нэвтрэх Газар Дундын тэнгис ч хаалттай болжээ. Бүхнийг хянаж, энхийг сахиулж байсан Татарууд хаашаа ч юм алга болжээ. 200 жил өнгөрөв. Эх газраар Алс Дорно руу чөлөөтэй зорчих уламжлал тасалдлаа. Баялаг Дорныг зорьё гэвэл Атлантын далайгаар хэдэн мянган бээр тойрч явахаас өөр аргагүй боллоо. Маркогийн номонд бичигдсэн олон зүйл энэ хооронд өөрчлөгдөөд байсан ч “ид шид” нь хэвээр байлаа...

Алдарт “Каталан атлас”<sup>10</sup> Маркоогоос “будаа идэж” (Дорноос Атлантыг чиглэсэн баримжаатай) зохиогдов. Дорноос мэдэж авсан зүг чиг заах зэмсэгийн дүрсийг уг газрын зурагт хавсаргасан нь луужингийн анхны зураг байлаа. Маркогийн номыг гарын авлага болгож нэрт далайчин Христофор Колумб Испаниас Монгол хүрэх дуулиант аяндаа гарлаа<sup>11</sup>. Тэр үед зүг чигийн мэдлэг алдаатай байв. Колумб бээр төөрч далийсаар, бүр эсрэг зүгт Америк тивийг санаандгүй нээж орхив. Португалийн V Афонза хааны зарлигаар нарийвчлал

бүхий анхны газрын зургийн нэгийг Маркогийн тэмдэглэлд түшиглэн бүтээжээ<sup>12</sup>. Васко до Гама гэгч бас нэгэн Португал далайчин мөн л төөрч будилан хөвсөөр Энэтхэгийг нээлээ (нээх ч юу байхав, Европчууд өөрсөддөө л “нээж” байгаа болохоос араб, монгол, хятадуудын хувьд эртнээс мэддэг орон!). Амь дүйсэн нээлтүүдийн эцэст хачин сонин, баян тансаг Энэтхэг рүү бүгд шуурцгаалаа. Олз омгоо бас бурхантайгаа холбож үзэхээ ч мартсангүй. “Шинэ газар”-ыг нээсэн Испани эр “Бурхан таалж хүмүүст хүссэн баялгийг нь харанхуйг гийгүүлэх гэрэл мэт хайрлалаа”<sup>13</sup> гэж дуу алджээ. Өрнийнхөн “God, glory, and gold”<sup>14</sup> (Бурхан, нэр алдар, алт) гэнэтийн шуналт сэдлээр ийнхүү сэрэн босож ирэв. Дэлхийг анх тойрсон жуулчин Магеллан ч Маркогоос дам нөлөө авч, Христофор Колумбын амжилт, сонирхлыг шүтэж, түүнийг давахаар зүтгэв. Олз ашиг, адал явдал хайгчид, засгийн газрууд... Эцэстээ боолын худалдаа, колончиллын өрсөлдөөнд бүгд татагдан орлоо... Дэлхий өөрчлөгдөв. Маркогийн сэрээсэн ертөнц!

Үнэндээ Марко ба Монголын Эзэнт гүрний үеийн бий болгосон хэлхээ холбоо энэ бүхний нэгэн шалтгаан нь байлаа. Хожим нь Дундад зууны газарзүйн нээлтүүдийн шалтгийг Өрнийнхөн бичихдээ арга буюу “Дорноос буцаж ирсэн Марко Поло болон Италийн худалдаач аянчдын хачирхам яриа сэлт, авчирсан үнэт эд бараа ялангуяа амттан, торго, алт, мөнгө зэрэг нь анхны нээлт хийгчдэд хүчтэй сэдэл өгч хөөргөжээ”<sup>15</sup> гэсэн билээ.

Сэрсэн домог утга замбараагүй үргэлжилсээр байв. Тартар даавуу, тартар цөцгий, тартар зайдас, тартар давтсан мах .... бас шүд хагтах (шохойжих) өвчлөл ч хожим “шүдний тартар” гэж нэрлэгдэв. Дундад зууны сүүлээр “Тартарын газрын зураг”-ууд олноор үйлдвэрлэгдэж, сүүлдээ Тартарыг хайсан газарзүйчид “Тартарын хоолой”<sup>16</sup>-г нээх хүртэл тэнэсээр тартар хэмээх монголчууд “алга болсон”-ыг үнэмшжээ.

Тартаруудын эзэмшил нутагт Марко Поло анх аялж очсоноос хойш өнөөдөр 740 жил болж байна. Марко Пологийн ном нь шинжлэх ухааны олон салбарт хамаарах дундад эртний мэдээллийг агуулж байдаг. Газарзүй, хүн судлал, амьтан судлал, соёл, эдийн засаг, улс төр, угсаатан судлалынханы хувьд түүхчдээс дутахгүй олзыг эндээс олж авч чадах ба Монгол, Хятад, Энэтхэг, Перс судлаачид төдийгүй Дундад Азийн ард түмнүүд, бас Оросууд хүртэл эндээс өөрсдийн эртний төрхийг зарим талаар таньж нээж болно. Маркогийн тэмдэглэл нь танин мэдэхүйн гурван үе буюу тэнгэр шүтлэг, шашин, шинжлэх ухаан зэрэгцэн оршиж буйг агуулснаараа сонин юм.

Ерөнхийдөө уг ном нь Монголын эзэнт гүрний дэвсгэр дээр Хятад, Энэтхэг, Перс болон бусад иргэншлүүдийг нээн харуулсан бичиглэл бөгөөд Марко Поло өөрийн номоо “Их хааны агуу амжилтын тухай өгүүлэх...”<sup>17</sup> зорилгоор бүтээсэн гэдгээ маш тодорхой бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл, энэ номын бараг тал хувь нь монголчуудын тухай өгүүлж, ном болж бичигдэх шалтгаан, ерөнхий цаад дэвсгэр (номын адал явдал) нь Монголын эзэнт гүрний тайзан дээр өрнөдөг гэж хэлж болно. Харин Өрнийнхөн энэ түүхийг “Хятад ба Хубилай хаан... Марко” гэдэг нэрсээр л мэдэх болжээ. Хубилай хааны үйл хэргийг илтгэн алдаршуулах Маркогийн “зорилго”-ыг уг ном хангалттай биелүүлжээ. “Аялал” ном нь Өрнө төдийгүй дэлхий дахинд Хубилай хаан хэмээх зүйрлэшгүй хүчирхэг, өгөөмөр, тансаг эзэн байдгийг анх хэлж өгчээ.

“Хятадыг дахин бүтээсэн Монгол хаан”<sup>18</sup> Хубилайн нэр алдар ертөнцөд дархлагдан үлдсэний нэгэн уг сурвалж ийм бөлгөө. Үе залгамжлан хүчирхийлэл, цуст байлдан

дагуулалтаар гарч ирсэнтэй харьцуулбал Хубилай хааны “өгөөмөр, хүлцэнгүй нь Венецийн худалдаачдын бишрэл гайхлыг төрүүлдэг байжээ”<sup>19</sup> гэж уг номыг уншихад эрхгүй төрнө.

Цаасаар юм худалдан авах (мөнгөн дэвсгэрт), шатдаг хар чулуу (нүүрс), газраас оргилдог тос (нефть) ... гэх мэт итгэмээргүй сонин мэдээг Марко Европод анх хүргэжээ. Түүний ярьсанд “Бурханы мэдэхгүй зүйл” ч бас багтаж байв. Хүмүүс итгэхгүй, түүнийг шоолон зугаацаж заримдаа “Худалч Марко” гэдэг байлаа. Гэвч түүний “худал” ярианд эцэстээ энэ тив бүхэлдээ автсан аж. Халуун ногоо, амттан, бохь, гаа, дарь, луужингийн тухай мэдээллүүд, торго, эрдэнэс, шаазангийн арилжааны чиг баримжаа, Европчуудын мэдэхгүй Катар (хятад), Тартарын (Монгол) ертөнц төдийгүй Зифангу (Япон), Ява, Занзибар зэрэг дэлхийн хязгаарыг тэдэнд мөн зааж өгөв. Хамгийн гол нь дэлхий ертөнцөд ид увдис, ад зэтгэрээс илүүгээр хүмүүс, соёлууд хаа сайгүй залган оршдогийг нээн хэлж, тэд зэрэгцэн аж төрж болохыг Их хааны жишээгээр ярьж өгөв.

XIII зууны гэрч-энэ номыг уншихад аялагчийн мэдлэг боловсрол эрхгүй сонирхол татдаг. Марког танихад тулгардаг нэг оньсого нь энэ юм. Марко 17 насандаа Венециэс гурван жил гаруй аялан явсаар Юань гүрэнд хүрчээ. Тэгээд тэндээ үлдэж 20 шахам жил амьдарсан байна. Монгол, хятад хэл сурч, мөн бичиг үсэгт бага зэрэг суралцжээ<sup>20</sup>. Багадаа Италид ном үзсэн гэнэ. Намтраас үзэхэд өндөр сайн боловсрол олох орчинд өсөөгүй аж. Гэтэл “Аялал” ном нь Азийн иргэншлүүд, тэдгээрийн газар нутаг ба тэдгээрийн нэр ус, цаг уур, зам харгуй, худалдаа, үйлдвэрлэл, шашин соёл, засаглал хуулийн тогтолцоо, одон зурхай, цаг тоолол, хүн ард, тэдний дүр төрх, ааш авир, зан үйл, хоол хүнсний тухай хүүрнээд зогсохгүй тухайн бүс нутаг дахь ургамал, амьтан, байгалийн тогтоцын тухай ч нарийн тодорхой өгүүлж, авьяаслаг судлаачийн гэмээр ажиглалтууд үлдээжээ. Номонд, энэ бүхнийг өгүүлэх дашрамд наймаачны гярхай нүд тасралтгүй мэдрэгдэж байдаг онцлогтой. Мөн түүхэн хэрэг явдал, домог үлгэрийг ч бас Марко номондоо нарийн багтаасан байжээ<sup>21</sup>. Жишээ нь: тартаруудын цэрэг дайны царааг мэдээлэх болон хоорондын тулаанууд, дайтах арга мэхийн тухай сонирхолтой хэсгүүд нь уг үзэгдлийг задлан шинжилж байх мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ мэт нарийн гярхай ажиглалтуудыг өргөн боловсрол эрдэмтэй хүн л амжиж гүйцэтгэхээс гадна тэдгээрийг тогтон анхаарч, марталгүй санаж учир зүйтэйгээр цэгцлэх гэдэг нэлээд туршлага, хөдөлмөр шаардах билээ. Тухайн үеийн Евразийн ихэнхийг хамарсан түүх угсаатны энэ мэт дэлгэрэнгүй “тайлан”-г хийж үлдээсэн жирийн аялагч бүү хэл мэргэжилтэн ч үлдсэнгүй.

Марко Поло шигээр аяллын тэмдэглэлийг танин мэдэхүйн нэн өгөөжтэйгээр цэгцлэн үлдээх нь тэр цагтаа бүү хэл өнөөдөр ч төвөгтэй зүйл. Тэгэхээр Марко Полог худалдаачин, аянч төдийгөөр ойлгох нь учир дутагдалтай санагдана. Тэрбээр авьяаслаг сониуч, мэдээлэл цуглуулах, боловсруулах төрөлхийн чадвартан байжээ. Түүнийг худалдаач аянчны дүртэй шинжлэн судлагч, хайгуулч гэж нэрлэвэл зохих ба Папын төлөөний лам гэгээнтнүүд (П.Карпини, В.Рубрук нарын адил) лугаа адил тодорхой зорилготой хүн болох нь бараг мэдэгдэнэ. Тэр дундаа шашин үзэл, эд засах талд онцгой анхааран шинжсэн нь “сэжигтэй”, түүнийг жирийн худалдаачнаас дээгүүр “нууцлаг” нэгэн болохыг баталдаг. Тэгээд ч тэр, Монголын Хубилай, Ромын Пап хоёрыг итгэлт зуучийн (улс төрийн дээд зиндааны, мөн дипломат элч) хувиар холбож явсан Никколо Пологийн хүү, Маффео Пологийн ач дүү гэдгийг бодолцох учиртай. Поло нар Италиас Папын төлөөлөгч гэлэн нартай хамт залуу Марко хүүг Дорно зүг рүү авч гарсан нь энгийн шалтгаантай байсан эсэхэд эргэлзмээр. Марко хүүгийн

хурц ухааныг Хубилай хаан анх уулзахдаа ихэд таашаажээ. Монгол Юань улсын албанд хожим Марко зүтгэж, хэргэм зэрэг хүртэж, гадаадад элч төлөөлөгчөөр илгээгджээ гэдэг. Энэ нь Их хааны итгэл хүлээх чадвартай “сэргэлэн эр” болж өссөний баталгаа мөн.

“Аялал” ном нь худалдаачны ам халсан яриа төдийсөн бол одоогийнх шигээр түүхэн үнэтэй сурвалжид тооцогдож, мөн Өрнөдийн төсөөллийг мэдлэгийн үндэс рүү анхлан тэлэхэд нөлөөлж чадахгүйсэн билээ. Эцэст нь, XIII зууны Дорнын амьдралыг сурвалжилсан түүхэн тэмдэглэлүүдээс<sup>22</sup> хамгийн дэлгэрэнгүй, олон чухал мэдээг агуулсан нь энэ ном болж үлдсэн төдийгүй дэлхийг өөрчилсөн түүх хэмээн хожим тооцогдох болсон юм. Хубилай хаан янз бүрийн шашнуудыг сорьж сонжин, заримдаа ном хаялцуулж өрсөлдүүлэх (Монголын Их хаадын адилаар) зэргээр үнэнийг танихыг хичээж, тэдгээрийг эерүүлэн зохицуулж байсан тухай, мөн тэрбээр Загалмайтнуудыг сонирхож Ромын Пап-д хэдэнтээ элч илгээсэн тухай зэрэг сонин түүх гарна. Олон шашныг хүлээн зөвшөөрч, зохицуулж байгаа Их хаан Хубилайн бодлогыг ийн тусгаж харуулсан нь байгалийн эрх чөлөөт хүмүүст (Монголчуудад) л байж болох өгөөмөр дадлыг илэрхийлсэн хэрэг бөгөөд энэ нь Библид “баригдсан” европчуудын ой тоонд ч орохооргүй мэдээлэл байлаа.

Их хааны өртөө шуудан, элч илгээх зарчмууд, хууль ёс, татварын тогтолцоо ямар байсан тухай гэх мэт нарийн ширийнийг хүртэл тэрбээр анзааран “судалж” байжээ. Бичлэгийн өнгө аяс нь аялагчийн сэтгэгдэл хүүрнэл хэлбэртэй байгаа нь ойлгомжтой энгүүнээс гадна дэгс худал бичжээ гэж үзвэл уг өнгө аясын үүднээс хандаж шинжлэн тайлбарлах боломжийг олгож байдаг аж. Дорноос буцаж ирснээс олон жилийн дараа бичсэн тул уг түүхэд зарим нэг алдаа мадаг үлджээ гэх өмгөөлөл ч бас бий. Он цаг зөрүүлж бичсэн зүйл ч тааралдана. Домог үлгэрийн шинжтэй уран содон зүйлс нь түүний яриаг тэмдэглэсэн зохиолч Рустичеллогийн хэтрүүлэг гэж үздэг тал ч бий. Гэвч эдгээр нь судлаачдын шийдвэрлэх асуудал болдог.

Судлаачид, сонирхогчдыг маргаанд хүргэдэг нэг эгзэг бий. Тэр нь хятадын “Цагаан хэрэм”-ийн тухай юм. Марко Поло энэ аварга хэрмийн тухай уг номонд бичээгүй орхижээ. Үүнээс болж Марког хятадад очоогүй, зүгээр л сонсож дуулснаараа энэ номыг бичсэн байх гэх үзэлтэй хүмүүс маргаан дэгдээдэг. Гярхай нарийн мэдрэмжтэй аялагч хүн “Цагаан хэрэм”-ийг мартана гэж үү, анзаарахгүй өнгөрнө гэж үү. Байж боломгүй. Гэвч Марко Поло Юань гүрэнд байсан нь маргаангүй нотлогдсон зүйл. Нөгөөтэйгүүр “Цагаан хэрэм”-ийг номондоо бичихгүй байх магадлал бас бий. Энэ нь уг хэрмийн гол сүрлэг, үлэмж урт үргэлжлэл болоод цамхагт байгууламжууд нь Мин улсын үед (Маркогоос хожим) баригдсанаар тайлбарлагдах<sup>23</sup> ба үүний өмнөх хэрмүүд нь сүрлэг сайхан бишээс гадна тасаг бусаг, жижгэвтэр, олон зуун жил орхигдож нурж эвдрэн анхаарал татахааргүй болсон, мөн Юань гүрнийхэн уг байгууламжийн үлдэгдлүүдийг тоож үздэггүйгээс шалтгаалсан байж болох билээ. Баримтаас үзэхэд Марко умар зүг рүү бараг аялал хийгээгүй мэт бөгөөд Хубилай хааны зуны нийслэл Шандуд очсон гэх боловч Шанду хүрэх замд цагаан хэрмийн өнөөгийн сүрлэг байгууламжууд байгаагүй ба эртний эвдэрхий хуучин хэрмүүд үлдсэн байжээ гэж үзвэл зохино.

Өрнийнхөн сэрэн ядсаар Дорныг сая зорьж эхлэхэд нь Ази тив хаалгаа хааж, “Монголын энх” дуусч байхтай давхацав. Дорнын хаалттай, чимээгүй үе эхэлж байв. Монголчуудын бодлогоор дэлхийг холбож байсан “Торгоны зам” дахин тасрав. Нэгдсэн хүчирхэг эрх дарх, эд баялаг, чөлөөт харилцааны эрчим дуусжээ. Татар, Катай нарын ертөнц ерөнхийдөө XX зууны төгсгөл

ийнхүү хүртэл “нуугдан алга” болов<sup>24</sup>. Өрнийн бууралт, Дорнын сэргэлт ээлжлэн сэлгэх мэт зуунууд ингэж өнгөрсөн юм. Эртний дорныг Өрнөдөд таниулагч, холбогч шалтгаан нь нүүдэлчид байлаа. Түүхийн ийм нэгэн сэлгээ хөдөлгөөнт үеийг Марко Поло дүрслэн үлдээсэн ажээ. XV зуунаас Европчууд Дорно руу тэмүүлсэн шиг XX зуунд Дорнынхон Өрнийг шүтэн дагаж, дахин сэргэлтээ эхлүүлсэн байдаг<sup>25</sup>.

Дармын ёс хийгээд Бумба, мөн бөө мөргөл, анимизм зэрэг бурхан шүтээнээ бодит зүйлсээр төлөөлүүлэн дүрсэлж, түүнийгээ тахиж шүтдэг, олон бурхант (полетист) шашин мөргөлийн соёлуудыг бүхэлд нь Idolators (үүнийг орчуулагч “Онго шүтлэгтэн” хэмээн буулгасан) гэх ганц нэрээр Марко хамруулан нэрлэсэн нь сонирхолтой. Олон бурхант шашныг түрүү үеийн (хуучирсан) шүтлэг гэх Өрнийнхний ерөнхий төсөөлөл уг номд энэ мэтээр үзэгдэнэ<sup>26</sup>. Харин Авраамын ганц шүтээнт (монотист) шашин соёлуудыг тус тусад нь Сарацин (Ислам), Загалмайтан гэх мэтээр Марко нэрлэж ялган бичсэн нь Өрнийн схоластик мэдлэгийн ул мөрийг илтгэж байдаг. Марко Поло ертөнцийн түүхийн сонирхолтой зурвас үеийг хүн төрөлхтний нэг хэсэгт хэлж өгснөөрөө азтаны нэгээр барахгүй хамгийн гол нь түүний ном эртний Грек, Хятадаас хойш тасалдсан дэлхийн түүхэн бичлэгийг залгуулагчдын нэг болж үлдсэнээрээ бүр гайхалтай<sup>27</sup>. Монголын эриний тухай Маркогийн хүүрнэл нь Европын домгийн үзлийг (тамын тартарусын домог) өөрчилж, эерэг сайн төсөөлөл үлдээж чадсан билээ. Тартаруудын бүдүүлэг хэрцгий шинж, дээрэнгүй засаглалыг тод харуулсан хэдий ч тэдний үлэмж хүчирхэг дийлдэшгүй байдал, хэнтэй ч зүйрлэшгүй сүр жавхлантай Их хаан, тогтоосон дэг журам, хэмжээлшгүй баян шударга нүүдэлчид зэргийг бахдан дуулж, тартарууд хаа сайгүй бүхнийг хянаж, ивээн тэтгэж байдгийг тодорхой үзүүлжээ. Монголчуудын бичиг захидал, мэдээлэл солилцох тогтолцоо, эрх мэдэлийн дохио тэмдэг болох тамга, гэрэгийг өргөн хэрэглэж байгаа тухай Марко Поло олонтоо дурдсан нь харилцааны олон талт хэм хэмжээг Европчуудад зааж сонирхуулсан хэрэг юм.

Европчууд Марко Пологийн өгүүлсэн шиг олон түмэн морьт баатруудын тухай, тулаанд заан хэрэглэдэг тухай огт сонсоогүй байсан ажээ. Монголчууд заанаас гадна хар хул, шонхор шувууг ахуйд ашигладаг тухай олж мэдэцгээв. Тэгээд арслан, тэмээн хяруул, аварга могой, анаашийн тухай мөн хар тамхи, секс, аллага дээрэм, өвчин эмгэг гэх мэтээр ертөнцийн бараг юм юмны тухай Марко бичиж үлдээх гэж хичээсэн мэт санагдана. Заримдаа түүний өгүүлбэрүүд гарьд шувуу, хараал жатга, мэргэ төлөг, илбэ увдис гэх мэтээр домог шүтлэг рүү хальж хөөрнө... Марко Полог нас барахаас өмнө ярьсан зүйлс, итгэмээргүй сонины нь тухай шалгаан сонжиход “Үзсэн бүхнийхээ хагасыг ч ярьж амжаагүй шүү дээ” гэж зөрүүдэлсэн гэдэг. Үнэнхүү адал явдал гэгч энэ буюу.

Марко Поло “суут ухаантан байгаагүй”<sup>28</sup> ч суут нөлөө үзүүлэгч байсан юм. Нөлөө нь 700 гаруй жил өнөө болтол үргэлжилж, Дорно дахинд түүний жуулчилсныг хүний түүхэнд тохиолдсон онцлох үйл явдлын нэг хэмээн Европчууд тэмдэглэх болжээ. Христийн ертөнцөд бусад иргэншлүүдийн тухай амьд гэрчийн мэдээг тэрбээр өргөнөөр хүргэж, тэдний төсөөлөл баримжааг өөрчлөх, сэргэн мандахад нь зориг хүч өгөгчдийн нэг болсон юм. Дундад зууны Сэргэн мандал бол өнөөгийн Европчуудын суу алдрын эхлэл. Харин Маркогүйгээр энэ түүх хэрхэх байсан бэ гэх сониуч асуулт гардаг. Энэ нь “Сэргэн мандалд хүргэх мэдлэгийн зүйлсийг Аянчин авчирсан билээ”<sup>29</sup> дүгнэлтээр хариулагдаж байж болох юм. Гэвч төсөөлөх боломжгүй. Иерусалимаас хэтэрч үзээгүй Загалмайтны явцуу ертөнц, тэдний далайчид,

колончилолын шуурга юугаар өдөөгдөх байсан бэ, эсвэл нь Европын сэргэлт хар аяндаа бүрэлдэж, хорвоо дэлхийг тэд өөрсдөө зөгнөн мэдэрч эхэлсэн үү. Библид заагаагүй болохоор, сэргэлтийнхээ шалтгааныг одоо ч Европчууд бараг мэддэггүй, будилсан хариулттай хэвээр байдаг!. Поло нар уг номыг Европ “хүмүүст хорвоо дэлхийн...бүхнийг ярьж таниулаг гэсэн...” Ертөнцийн Эзний тааллаар бичсэнээ өчсөн байдаг<sup>30</sup>. Ойлгомжтой нэг л зүйл бий. Маркогүгээр, Азийнхны тухай Европчуудын мулгуу төсөөлөл, Нүүдэлчдийг одоогийнхоос ч дорд үзсээр байх нөхцөл л улам батжих байв.

Марког бишрэн судалсан Л. Бергрийн “Өрнө дахины санхүү, арилжааг хувьсгалд хүргэсэн цаасан мөнгөний тухайд Марко Полог буцаж ирэх хүртэл Европод хэн ч бодитойгоор мэдэхгүй байв. Маркогийн анхааралд өртсөн өөр нэг зүйл бол Европчуудыг энергийн хомсдолоос аварч шинэ, харьцангуй үр ашигтай халаалтаар хангасан чулуун нүүрс байлаа. Нүдний шил (дугуй хэлбэрт шил дуран)... хараа муудахаас сэргийлэх боллоо... дугуй шил нь телескоф болон өргөжив,..хятадад наад зах 300 жил хэрэглэсэн дарь нь Европчуудын цэрэг дайнд хувьсгал болов” гэх мэтээр бичжээ.

Нүүдэлчдийн хүчирхэг дэглэм бүхий ертөнц<sup>31</sup> бууран доройтсоноос хожим (хөгжлөө дагаад) Европ төвт үзэл соёолж эхэлжээ. Тэд, Хятадууд лугаа адил бүхний төвд өөрсдийгөө дөвийлгөн тавих болтлоо “хөөрчээ”. Энэ үеэс Европчууд дэлхийг бүтээсэн мэт аашлах болов. Өнөө болтол үргэлжилсээр буй Европчуудын энэ урхагт “хятад санаа”-ны үзүүрт Монголын эзэнт гүрэн гэдэг хөөс мэт хагарахтай адил хэврэг ба тархан замхарч алга болох нүүдэлчдийн “зэрэглээ” байлаа гэх ойлголт хадагджээ. Гэтэл Эзэнт гүрний нөлөөнд байсан ард түмнүүд<sup>32</sup> тэднийг зэрлэгүүд гэж үзэж байсангүй. Хүчирхэг, өвөрмөц иргэншлийн төлөөлөгчид гэх хандлагаар хардаг байв. Харин сэргэн мандлын үеэс биднийг “зэрлэгүүд” хэмээх Загалмайтнуудын ойлголт лавширсаар XVIII зуун гэхэд хүний түүхэнд гарч ирсэн “зэрлэг сүрэг” гэх санааг түгээх голомт нь Европ болж хувирсан билээ<sup>33</sup>. Нүүдэлчдийг өөр ертөнц мэтээр адлан ойлгох болов. Улмаар Хүннү, монголчуудын тухай Хятад төвт (Синик) үзэлтэй эх сурвалжуудыг Европод “туг”-аа болгосон юм. Тэд морьт нүүдэлчдийг<sup>34</sup> бие даасан иргэншил биш “зэрлэгүүд”, “тэнүүлчид” хэмээн итгээд, улаан цайм ийм гэнэн дүгнэлтэд хүрч, үүнээсээ болж эдүгээ болтол баттай зэрэгцэн оршоор буй нүүдэлчдийг мөнөөх Европ төвт ойлголтоороо гүтгэн зүтгэлсээр иржээ. Төв Азийн морьт нүүдэлчдийн талаар огт мэдлэггүй асан тэд Хятад төвт үзлээр “тэжээл нэмж” торнисон нь энэ байлаа. Ийнхүү Европчуудын омог дээрэнгүй, Хятадын хөршөө муулах, түүхийг муугийн жишээ болгон “бүтээсэн” байжээ. Нүүдэлчдийн босгосон эзэнт гүрний ухаалаг тогтолцоог шинжилж болохуйц сурвалжууд (Марко Полог оролцуулаад) байсаар атал түүхийн талаарх “Европ төсөөлөл” ийнхүү гуйвалтгүй байсаар бараг үнэн болж өнөөгийн дэлхийд тогтсон юм.

Саяхан, 100-гаадхан жилийн тэртээ Өрнөдийн супер голомт АНУ-ын судлаачид гэхэд л “Монголын эзэнт гүрэн”-ий түүхээр бараг юу ч мэддэггүй нь инээдтэй, “цагаан арьстаны намтар”-аас өөр түүхгүй “харанхуй” сууж байгааг Ерөнхийлөгч Теодор Рузвельт өөрөө ч гайхан бичсэн байдаг<sup>35</sup>. Евротөвт үзэл гамшгийг ч Т.Рузвельт дашрамд дурдажээ. Нэг онцгой жишээ нэмэе. Америкийн Ази судлалд гэнэтийн гэмээр өөрчлөлт гарсан нь Монголыг таних алхам байжээ. Алдарт О.Латтимор<sup>36</sup>. Энэ эрдэмтэн “Зүүн Азийн түүхийг тухайн бүс нутагт гол нөлөөтэй малчин, тариачны хоёр өөр Иргэншлийн харилцан хамаарлаар авч үзэхээс биш дан ганц Хятад, түүний нөлөөгөөр тайлбарлагдахгүй”<sup>37</sup> гэсэн онолын зоримог, шинэ санааг

дэвшүүлсэн юм. XX зууны түүхийн эцэг гэгдэх А.Тойнбийн гол бүтээлд<sup>38</sup> түүний зоримог санаа нөлөөлсөн хэдий ч “варварууд”-ын (бүдүүлэг) тухай тогтсон үзлийг нь эерүүлж чадаагүй бололтой. Ямар ч атугай О.Латтимор шинэ санаа өгч чаджээ. Энэ нь “...Зүүн Европ, Азийн хөгжлийг ойлгох хүсэлтэй хэн бүхэнд Монголчуудын түүхийн бүрэн мэдлэг зайлшгүй шаардлагатай...” гэсэн АНУ-ын Ерөнхийлөгчийн сануулгыг шинжлэх ухааны үзэлд дэвшүүлснээрээ сонин юм. Танилтад үйл явц хэрэгтэй байжээ.

Хүн төрөлхтний Иргэншлийн тухай онолыг боловсруулахдаа суурин соёлыг “варвар”<sup>39</sup>-тай сөрөгцүүлэн тавих үзэлд хүрсэн нь Өрнөдийн онолчдын гол “амжилт” байжээ. Иргэншлийн тухай “тариачны тал”-ын энэ онол нь хүмүүсийн бүлгийн оршин тогтнох түүхэн чадварын тухай үндсэн асуудлыг гол болгох хирнээ дүгнэлт гаргахдаа “аж төрөх арга хэрэгслийн дэвшил”-ийг иргэншил гэнэ гэх зорилгоосоо төөрөлдсөн хариултад хүрсэн байдаг. Уг хариулт нь Коммунист монголчууд болон Өрнийг дагагч зарим монголчуудын өнөөгийн үе дамжсан “буян”-аар өвөг дээдсээ үнэлэх баримжаа болсоор байна. Энэ нь “малчны тал”-ын мэдлэгийг басамжилсан хэрэг бөгөөд дэлхий ертөнц хэзээд тэдний санаснаар байна гэж итгэдгийнх биз ээ. Гэтэл түүхэн эзэнт гүрнүүдтэй Монголын үеийг харьцуулан шинжлээд хөөс байжээ гэж хараахан дүгнэж зүрхлэхгүй болсонтой адилаар, даяар арга хэрэгсэл-мэдээллийн орчны дутмагшлийг эс тооцвол нүүдэлчдийн сэтгэхүйн хөгжил, үнэт зүйлсийн дархлаа нь өөрсөдтэй адил хүчтэйг мэдээд “хоцрогдон хатингирсан” малчид гэж хэлж чадахаа бас больж байгаа билээ. Үнэндээ, “суурин ба нүүдэл”-ийн нийгэм хэрхэн хольцон тогтнож буй анхны баримтуудыг Марко Поло тод өгүүлсэн нь Иргэншил судлалд хэрэгтэй эх сурвалж болох юм. Марко Полог энэ талаас нь ажиглалт хийсэн судлаач одоогоор алга байна.

Европчуудгүйгээр дэлхий хэрхэн оршиж байсны нэг жишээ нь Монголын үе байлаа. Нүүдэлчид бол хүн төрөлхтний суурь иргэншил. Суурь иргэншлийн өвийг хадгалан тээгчид төдийгүй дэлхий даяар эринийг эхлүүлсэн нүүдэлчид бол Монголчууд. Үүгээр ч барахгүй, өнөөдөр ч өвөг иргэншлийн үнэт зүйлсийг өөрийн оршин тогтнохуйн суурь хэмээн “Үндэсний аюулгүйн” нөхцөлөө тодорхойлсон (сонгосон хөгжлийн загвартай нь энэ үзэл санаа зөрчилддөг) орчин үеийн ганцхан орон нь Монгол болж үлдэв. Энэ нь улс төр шинжлэлд сонирхол татах феномен (хувилбар) юм. Байгалийн бэлэн нөөцөд шүтэж үйлдвэрлэл явуулдаг хүн төрөлхтний суурь иргэншил болох Нүүдэлчид, байгалиас түүхий эд олборлох аргаар оршдог хувьсалын иргэншил болох Суурьшмалуудын хоорондын зөрчил тулаан өнөө болтол далд сул үргэлжилсээр байна. Гэвч суурьшмал иргэншлийн адтай дээрэнгүй нь болон Иргэншил нь ч бас өөрийн төгсгөлтэй юм.

Суурин иргэншлийн давуу үр дагавар юу вэ. Байгаль дэлхийн нөөцийг хувирган ашиглаж хүслээ хангах мэдлэгийн тогтолцооны үр шим нь суурьшмал иргэншилиг онгирооход хүргэдэг боловч баялаг гэж үнэмшсэн бүхэндээ шунан улайрах жолоодлогогүй сэдлийг агуулдгаараа шог байдаг. Учир нь шунал гэгч нь хүний хөгжлийн аль ч үед хөгийн хэмжүүрт тооцогддог сонгодог ойлголт юм. Ядаж байхад, шуналын тухай ёс суртахууны үнэлэмж нь хүн бүгдэд адил бөгөөд балар эртнээс хэвшин тогтсон нь эдийн соёлд шүтэгч нийгмийг өөдтэй гэж үнэлэхэд саад болсоор байдаг. Байгаллаг бус нийгэмлэг мэдрэмжийн үр дагавар нь зөвхөн эрх ашиг, аминч үзлээр орчноо үнэлэх дэглэмийг сонгохоос өөрд хүргээгүй бөгөөд дэглэмийн эрчийг чангаруулах аргаар үржил тэлэлт, өсөлт хэрэгцээгээ тогтоон сааруулах үнэмшилд төгсгөлгүй хөтөлж байдаг. Үүний үр дүнд хүний заяагдмал эрх чөлөө багассаар

зохиомол “эрх чөлөө”-гөөр (хууль дүрмээр) орлуулан аргацаах туршлага хуримтлуулж, улмаар ёс суртахууны үнэт зүйлсээ тогтоол дэглэмээр солихоос өөр аргагүйд тулгадаг. Энэ нь ёс суртахуунаас дүрэм журам гэх зарчим бус дүрэм журам нь ёс суртахуун болох сөрөг эргэлтэд эрхгүй хүргэдэг. “Суурьшмал” технологи нь иймэрхүү эцсийн үр дагаврууд үйлдвэрлэдгээрээ “амиа аргацаасан” нүүдэлчдээс соёлтон давуу болж үзэгдсээр иржээ. Зүй тогтолын шинжээсээ илүүгээр прагматикч (ашигч үзэл) үнэлэмж биднийг эзэмдэж “шинэ соёл” болон хувирч байгаагийн зайлшгүй шалтгаан ийм үндэстэй.

Марко Пологийн дүрсэлснээр, Кавказаас Хятадын тэнгис хүртэл уудам хярхаггүй зайд олон соёлууд байх бөгөөд тэр бүхэн нь гэрт амьдарч, уул талаар давхилдах эрх чөлөөт Татаруудын мэдэлд оршиж байна. Нэг угсаатны даяар засаглал. Ийм үзэгдэл дэлхийн намтарт байсангүй. Уугуул хэв маягаар, дур зоргоо эдлэн аж төрөх хирнээ өөрсдийн Иргэншлийн хязгаарт хамаарах Иргэншлүүдийг эрхшээхдээ өөр өөр соёлын бодлого<sup>40</sup>бүрдүүлсэн түүх. Бас л ийм үзэгдэл Монголчуудаас эхэлжээ. Уг үзэгдлийг арга ядалт байсан гэж тайлбарлахад өнгөц болно. Сайтар оршин тогтнох хүсэл бүхий Иргэншлүүдэд өнөө болтол хамгийн тааламжтай түүхэн жишээ нь Монголчуудын засагласан энэ хэв маяг болох юм. Өөрөөр хэлбэл, өөрсдийн халдашгүйг тогтоож бусдыг ноёлон аж төрөх ба амар жимрийг байгуулах. Улс төрийн ийм “технологи”-той монголчуудыг хожим нь Европ төвт онолоор золиосолж түүхийн “чукча” болгоод зогсоогүй “хагас иргэншилт”<sup>41</sup> өрөөл татуугийн ангилалд оруулж орхисон билээ. Үнэнд гамшиг тарьж болохуйц энэ үзэл нь цаашдаа Барууны цөөнгүй судлаачийг ичээгээд байхаар зүйл болсон юм. Эдгээр асуудлын тухайд, Маркогийн тэмдэглэл нь Төв Азийн морьтон нүүдэлчид гэгч нь “Тартарус” (тамын дайчид) ба хүн идэгч мангаа бус Иргэншилтэн Европчуудын төсөөллийн уламжлалаас үл хамаарах өвөрмөц бие даасан Иргэншил мөнийг дам нотлох эх сурвалжуудын нэг болж ирсэн юм. XXI зууны зарим ажиглагчид “Маркогийн гярхай байдал нь тэр үеийн олон соёлуудыг захирч, технологи, нийгмийн шинэчлэл хийгчид нь Өрнөдийн миф төсөөлөлд оршдог “бүдүүлгүүд”-ээс хол давуу байсныг хэлж өгсөн билээ”<sup>42</sup> гэж дүгнэсэн юм.

Хятад, Өрнөдийн түүхэн сурвалжуудад нүүдэлчдийг бүдүүлэг, муухай “шулмын морьтнууд” мэтээр тэмдэглэсэн нь тааралдаж байгааг “тийм байжээ” гэж үнэмшихээсээ илүүгээр Нүүдэлчид ч бас тэднийг сул дорой, муухай хүмүүс гэж үзэж байсантай адил үнэлэмж гэж үзвэл зохино.

Монголчууд өөрсдийгөө тэнгэрээс гарвалтай ба суурьшигчдийг “газар идэгчид” гэж үздэг байв. Морь унаж чаддагүй хүнийг нүүдэлчид шоолдог. Эр чадалгүй, явганыг мөн сул дорой гэж үзнэ. Энэ үзэл нь суурин иргэдийг дорд үзэх үнэмшил болж хувирсан юм. Улс гүрэн даяараа морь унаж үзээгүй хятадууд Нүүдэлчдийн хувьд бүр ч хачин “сүрэг” байлаа. Балгаснаа шоргоолж мэт шавж амьдрахын сайхныг нүүдэлчид ойлгодоггүй. Тэд салхи мэт дураар, мөн уудам эрх чөлөөг хүснэ. Газар дэлхийг амьдчилан шүтнэ. Тиймээс суурин эрчүүдийг “жирэмсэн эмийн шээх газар холгүй, жижиг тугалын бэлчих газар”-аас хэтрэхгүй “тулга тойрсон” сулбагарт тооцно. Өнөө болтол нүүдэлч удмынхан “газар ухагчид”-ыг (тариачдыг) сул дорой гэж үзэх мөртлөө эдлэлийн чаминд нь татагдах ба үүнтэй адилаар суурьшмал иргэд ч нүүдэлчийг “зэрлэг бүдүүлэг” гэх мөртлөө тэдний баатарлаг, эрх чөлөөт байдлыг бахдан дуулах нь уламжлал болж үлдсэн юм. Ер нь хөлөг баатрууд, хүлэг морь бол аль ч үндэстний бахархал, домог болж иржээ. Баатарлаг туульсгүй хүчтэй Иргэншил нэг ч



байсангүй. Морьт нүүдэлчид харин энэ бахархалын эзэн байж, ялан дийлэхийн хүчийг өөрсөдийн нийгмийн бодит хэв маяг болгон тогтоодог байв.

Тэгэхээр Евроазийн Нүүдэлчид нь суурин иргэншлээс царайчлагчид байсан мэтээр бичдэг өнөөгийн үзэл үндэсгүй юм. Харин ч эсрэгээрээ суурьшмалуудыг дорд үздэг Баатрууд байлаа. Бас ядарч туйлдахаараа тариачид руу очиж, дээрэмдэн тоногчид байлаа гэдэг нь ч тэдний шинж чанар биш юм. Нүүдэлчид нь суурин иргэдтэй улс төр, эдийн засгийн харилцаа тогтоож ирсэн урт түүхтэй ба харилцааны горим зөрчигдөж, эрх ашиг хөндөгдвөл тулаанд дууддаг байв. Энэ бол мянга мянган жилээр үргэлжилсэн туршлага байжээ. Яг л өнөөгийн Америк лугаа төс логик үйлчилж байсан юм.

Нүүдэлчид байгалийн эрхшээлд амьдрах гэж зовж, суурьшигчид жаргадаг байсан мэт үзэл ч худлаа. Европчуудын мэддэг, тэдэнтэй хил залган суудаг ядмаг нүүдэлчдийн хувьд энэ дүгнэлт тохирч байжээ. Харин Морьтнууд бол өөр. Суурьшлийн онолчид зовлон, жаргалын ялгааг өөрийнхөө үнэмшлээр түүх бичлэгт тайлбарлаж, Морьтнуудыг зовлонд баригдагсад мэтээр харж ирсэнд л шалтгаан нь байгаа билээ. Айрагны амт үнэрийг Европчууд ойлгож чадаагүйтэй адил “шар айраг”-ийг адууны шээсэрхүү амт, үнэртэйг нүүдэлчид үнэлж ирсэн шиг л ялгаа энд оршдог. Үнэн хэрэг дээрээ энэхэн жишээний тухайд гэвэл, амтлах мэдрэмжийг төлөвшүүлдэг бага тархины дадалтай л холбоотой болохоос халуун орны үмхий үнэрт жимснүүдийг (нутгийнхны гол хүнс) анх идэхэд бид ч, Европ хүн ч адилхан огиулах гээд байдаг нь идэшний мөн чанартай бус хүний байгалийн дадалтай л холбоотой учраас тэр юм. Тиймээс Маркогийн нэгэн гавьяа бол Европчуудын явцуу дадлыг тэдний бага тархи төдийгүй их тархинд нь ч хүртэл нөлөөлж эхэлсэнд байгаа юм. Иймэрхүү нөлөөллүүд үзүүлж чадсан учраас “Марко Поло” түүхийг өөрчлөөд зогсоогүй түүхийг бүтээсэн юм<sup>43</sup>” өргөмжлөн дүгнэх зарим үнэмшилд хөтөлжээ.

Дэлхийг засах Чингис хааны мөрөөдлөөр монголчууд (мөнөөх зэрлэг Тартарууд) Евроазийн талаар эртний зохих мэдлэгтэй байсан бол аажмаар ертөнцийн бөглүү хязгаарт хумигдаж, “алга болох” мэт чимээгүй болжээ. Тэгээд XIX зуунаас хий үзэгдэл мэт хааяа харагдах болсон цагаан арьстануудын хачин эв хавгүйг нүүдэлчид шоолон хачирхдаг байв. Богино цээжтэй янхир бие, хавчиг гавал, мууран ногоон хирнээ хөнхөр нүд, инээдтэй гозгор хамар, бас гандмал үс, нялзрай цонхир арьс, эмзэг турь гэмээр төрх, инээж уйлах нь ялгагдахгүй сэтгэл хөдлөл зэрэг нь үзэшгүй муухайн тэмдэг болж байв. Хээр хөдөөд зэвхий цонхин хүмүүстэй тааралдаад чөтгөр хэмээн зэвүүцэж малчин ухаан алдсан тухай яриа ч бий. Энэ нь яг л дундад эртний Европчууд шиг гаж үнэлэмжтэй адил юм. Азийнхны хавтгай нүүр, жартгар нүд одоо ч тэдэнд хачин сонин хэвээр байгаа билээ. Соёл, гоо сайхны үнэлэмж ялгаатай, суудаг нүүдэг хоёр өөр ертөнцийн сэтгэхүйд ийм ул мөр оршиж байдаг.

Өрнөдийнхний төдийлөн мэдэхгүй нэгэн эрдэмтэн<sup>44</sup> “...түрэг-монгол ард түмэн, тэдний нүүдлийн өвөрмөц соёлыг Дорнын иргэншилд хамааруулж ч, “зэрлэг”-үүдийн зэрэглэлд оруулж ч болохгүй”<sup>45</sup> гэж бидний тухай хэлжээ. Нарийн судлахад, энэ мэт нууц нээгдсээр, гайхашруулсаар байх төгсгөлгүй туульс бол Морьт нүүдэлчид. Тэдний домог энэ өдрүүдэд улам гэрэлтэх болов. Англи хэл дээр л гэхэд сүүлийн жилүүдэд олон арван ном хэвлэгджээ. Монголчуудын дагуулсан, бүтээсэн, мөн санаачилсан Ертөнц гэж Өрнөдийнхөн бичих боллоо.

Гэвч одоо бид ганцаардсаар байна. Сүүлчийн Нүүдэлчин. Нүүдэг Монголчууд суурин соёлын бүслэлтэд шахагдаж “нүүх” тэнхээгээ барав. Бүслэлт чангаран хумигдсаар... Морьт нүүдэлчдийн цорын ганц удам “бууж өгч” байна. Домог ийнхүү мөхлөө. Аглаг талын дундуур салхи исгэрүүлэн давхих сүүлчийн морьтныг бидний нүд гашуудан харна. Баатарлаг малчны “ялагдал”-аар Иргэншлийн зөрчлийн эцсийн “тулаан” энд дуусаж байна. Үүнийг бид өөрсдөө сонгосон юм. Иргэншлүүдийн мөхлийн гунигт домог цөөнгүй үлджээ. “Одоо бидний ээлж. Бид түүхэн зүй тогтолд өртөж байна” гэж ярьцгаах болов. Өөрчлөгдөж, “дахин төрөх”-өөс өөр аврал үлдсэнгүй ээ. Тиймээс бид даяаршлийн ертөнц рүү эргэн ирж байна. Гэхдээ эзний хувиар бус дууриан дагахаар туугдан ирлээ. Харин өвгөдийн минь баатарлаг домог цуурайтсаар... “Сүүлчийн Могикан” киног үзээд урсдаг нулимс минь цогтой малчдаа хараад бүрхэх болов.

Яг энэ үед Марко Поло “Аялал” ном бидэнд маш хэрэгтэй. “Аялал” ном үнэнийг хэлж өгөх чухал нэг сурвалж учраас тэр. Ой дурсамжаа цэнэглэх хэрэгтэй болжээ, бид. Бидний “тартар”-ууд хорвоог хэрхэн өөрчилсөн бэ, дэлхийг өөрчилсөн бичлэгт өөрсдөө хэрхэн туссан бэ. Эндээс тольдон харцгаая. Өөртөө итгэх итгэлээ удаан хугацаанд алдаж ирсэн монгол угсаат бидэнд энэ ном эхлээд гайхан эргэлзэх сэтгэгдэл төрүүлдэг. Учир нь манай үеийнхэн хүчирхэг байх гэгч ямар байдгийг үзээгүй билээ. Бидний алдар суу ийм үлэмж гэж үү. Хүчирхэг, баян тансаг Их хааны жишээ, гайхаш төрүүлэм Монголчуудын түүхийг унш. Тартар хэмээгч нь та бид юм. Тэд (тартарууд) хэрхэн ид бахгай зугаалан цэнгэж, чинээлэг, толгой гэдгэр амьдарч асныг, Ертөнцийг эрхшээгч эзний ёсоор ямархан омог бардам, сүр жавхлантай аж төрж байсныг хараад гайх. Шагшин атаархуулж, сүрдээн хүндэтгүүлэхийн дээд нь монгол хүн байсны бас нэгэн үнэн түүх энэ ажээ. Энэ бас дээрэлхүү түрэмгий байсны маань ичис хөдөлгөх намтар юм. Уншихуй, баясан омогших ба эргээд тунгаах мөч хэдэнтээ таарна. Эцэст нь бид, дэлхийд хөгжлийн хурдасгуурын үүрэг гүйцэтгэсэн өөрсдийн домогт эндээс итгэнэ. Эртний Финикүүд хүн төрөлхтөнд бичиг үсэг “бэлэглээд” тарж алга одсонтой адилаар Монголчууд засаглалыг дэлхийд үзүүлээд гэртээ харьж ирсэн билээ. Итгэхэд бэрх ч үнэн түүх. Ийм үзэгдэл дэлхийд байсангүй. Хатуу ширүүн зууны тэсэн үлдэхийн төлөөх тэмцлээр илэрхийлэгдэх түүхэн энэ болцыг эдүгээчлэн буруутгах, зөвгөхийн алинаас ч илүүгээр үйл явцын шинж чанарыг танихад хичээвэл сонирхолтой болно.

Дахин ахин уншихуй та бид эндээс өөртөө итгэлтэй, дэлхийг засахын хүчрийн дэргэд улс засахын нь энгийнийг мэдэж авна. Хүчрийг давагч асан энгийнийг үйлдэх амар буй. Чухал ийм түүхэн нөхцөл бидэнд одоо эргээд тулгарлаа. Түүхээс бид ирээдүйгээ олно, эргэлзэхгүйд хүрнэ...

XX зуунд ч Монголчууд Барууны талаар бага мэдлэгтэй харанхуй байлаа. Тэд, коммунист номлолоос хальж гарахгүй, улаан сурталд итгэх байдлаар ертөнцийг төсөөлж суудаг байжээ. Америкийн харгис империализм идэхээр айсуй гэх “Тартарын үлгэр” лугаа төст үнэмшицгээж, “шүдээ хүртэл зэвсэглэсэн” хөрөнгөтнийг үзэн ядаж, айж байв. Харин удалгүй биднийг аврагч “Прэстэр Жон” бол Барууны суртал хэмээлцэх болсон билээ...

Марко Поло бол Дорныг биширсэн анхны Өрнийн хүн байв...

Г.Бадамсамбуу (Аялагч сэтгүүлч)

## Танилцуулга

Энэ ном английн уншигчдад “Марко Пологийн аялал” нэрээр танил болсон бөгөөд уг номын оршил хэсэгт уншигчдад хандан арван гуравдугаар зууны төгсгөл үеийн “Дэлхийн тухай бичиглэл” (Divisament dou Monde)-ийг танилцуулж байна гэж өгүүлсэн байдаг. Уг ном нь Хойд мөсөн далайгаас Ява арал хүртэл, Занзибараас Япон хүртэл дэлхийн асар удам газар нутгийг багтаан өгүүлсэн төдийгүй дээрх газар нутгийн ихэнхийг биеэрээ туулсан хүний хүүрнэл-яриа байгаа нь гайхалтай билээ.

Хүн төрөлхтөн үүсэн буй болсон цагаас хойш ийм өргөн хүрээ далайцтай аялсан хүн Марко Пологоос өөр байгаагүй тухай, түүний аяллын мэдээ, баримт баталгаатай төстэй бичиглэлийг хэн ч тэмдэглэн үлдээгээгүй тухай “Оршил” хэсэгт өгүүлсэн байдаг.

Марко Пологоос хоёр үеийн<sup>46</sup> дараа мэндэлсэн Ибн Батуаг хүртэл дэлхийг тойрогч гэгдэх арабын бадарчдын дунд ч түүнтэй өрсөлдөхүйц жинтэй аялагчид байсангүй. Түүний нээж таниулсан хорвоо дэлхий бараг бүхэлдээ Өрнөдийн Загалмайтнуудад цоо шинэ үл мэдэх ертөнц байлаа. Марко Пологийн аялаж өнгөрсөн зарим газар нутгаар түүнээс хойш зургаан зуу (600) илүү жил өнгөрөхөд, магадгүй “Бирмийн зам”-ыг (Burma Road) нээсэн сүүлчийн дайныг хүртэл нэг ч Европ хүний мөр гараагүй билээ. Марко Пологийн аялалд өгүүлсэн зүйлсийн ихэнхийг өнөө болтол газрын зураг дээр тэр бүр буулгаж амжаагүй байсаар байна.

Өнөө цагийн уншигчдаас зуу зуун жилээр алслагдсан үлгэр домгийн юм шиг үйл явдлыг уран хурцаар дүрслэн өгүүлсэн түүний ярианд та бид хөтлөгдөн дэлхий ертөнцөөр аялан оюун сэтгэлийн таашаал авах нь эргэлзээгүй. Тэр цаг үеийн дэлхий ертөнцтэй гүн гүнзгий танилцах хүсэлтэй хэн боловч энэ номонд өгүүлж буй хүмүүсийн хоорондын харьцаа, мэдлэг оюуны хөгжил дэвшлийг оршин буй орон зайтай нь холбон цэгнэхдээ өөрийн эрхгүй тэр ертөнцийг Марко Пологийн нүдээр харж, ухаанаар тунгаан түүний туулсан урт удаан аяллын замыг даган бэдэрнэ. Гэхдээ энэхүү аяллын замын бүдүүвч тойм нь хэнд ч хялбархан ойлгогдох төдийгүй өөрийг тань дагуулах найдвартай хөтөч болж чадна.

Барууныхан бүр Македоний Александр (Сулхарнай)-ын үеэс эхлэн Энэтхэгийн талаар бага сага мэдэж байсан ба манай эриний зургаадугаар зууны үед Малабарын эрэгт “Энэтхэгт аялагч” хочтой Космас хүрч байсан тэр л үеэс Энэтхэгийн далайг гатлан Энэтхэгт хүрэх худалдааны зам нь адал явдал хайгч Европчуудад нээлттэй болсон байлаа. Гэхдээ Энэтхэгийн умарт болон зүүн хэсэг нь нууцлагдмал хэвээрээ л байсан.

Ромын эзэнт гүрэнд хүргэж борлуулах хятад торго Дунд Азийн орнуудыг дайран тэмээн жингийн цуваагаар хөвөрсөөр сар жилийг улирсаар авч энэ их торгоны цуваа хаанаас эхтэй, хаагуур ямар улс орныг дайран өнгөрдөг талаар Барууныхан мэдэхгүй байлаа. Сересүүд<sup>47</sup> (Seres) торго хийдэг гэхээс өөр мэдээлэлгүй байв. Хятадын тухай бүүр түүрхэн сургийг МЭ VII зууны үед Теофилактус Симокатта (Theophylastus Simocatta) гэгч хүн Европынхонд анх түрүүн хүргэсэн тухай баримтыг бид олсон бөгөөд тэр хүн Константинополь дахь хааны ордонд очсон Дундад Ази дахь Түрэгийн хаант улсын элчээс үүнийг дам сонсжээ гэх аман яриа байдаг.

Чухам тэр үед, од харвах мэт огцом хүчирхэгжиж эхэлсэн Исламын улсууд далайн болон хуурай газрын худалдаа арилжааны замыг эзэгнэж Өрнө Дорнын харилцааг төмөр хөшгөөр хаах мэт тасалж орхижээ. Гэвч нэг их удалгүй худалдаа арилжааны харилцаа эргэн сэргэж урьдынхаасаа ч эрчимтэй хөгжиж эхэлсэн юм. Константинополийн загалмайтаны худалдаачид, улам бүр цэцэглэн дэвжиж байсан Италийн Пиза, Генуя болон Венецийн биеэ даасан худалдааны хот-улсынхан ер юу ч болоогүй мэт амь, амьдралаа аюулд нэрвэгдэхээс огтхон ч зоволгүй буруу номтонтой худалдаа наймаагаа улам ч өргөжүүлж байлаа. Гэвч тэдгээр худалдаачид Газар дундын тэнгисийн болон Хар тэнгисийн эргийн боомтуудаас нэг их хэтэрдэггүй байв. Далай тэнгисээс алслагдсан хот балгад, эх газрын худалдааны зам харгуй бүхлээрээ лалын зуучлагчдын бүрэн мэдэлд байсан бөгөөд тэдгээр зуучлагчид энэхүү худалдаа наймааны эзэнт гүрнийг шавхартал нь сааж дагнан эзэгнэсээр байв. Хятадууд 878 онд өөрийнхөө худалдааны боомтуудад харийнхнийг оруулахгүй хааж орхисон боловч Хятад орох далайн худалдааны замыг Араб худалдаачид аль хэдийн танин мэдээд эрх дархаа тогтоосон байжээ.

МЭ Х зууны үед бадарчилан тэнэж явсан Багдадын Массуди алс холын Африк тив, Арал нуур, Цейлон аралд очиж байсан тухайгаа тэмдэглэн үлдээсэн байдаг бөгөөд тэр хүн өмнөд Хятадаар ч орсон байж магадгүй юм. Жүүд нарын хувьд бол лалынхны татсан төмөр хөшиг өчүүхэн ч саад болоогүй юм. XII зууны үед Багдад хотод очиж байсан Наварра нутгийн Түдэла хотын жүүд санваартан Бенжамин түүний аяллыг Алс дорнодын болон Хятадын жүүдүүд хэрхэн дэмжиж байсан тухай, тэдний хөрөнгө чинээний талаар тодорхой тэмдэглэл үлдээсэн байдаг.

Ийнхүү дорноос түгэн тархах бүх идэвхжил, шинэ мэдлэгүүд Өрнөдийн Загалмайтнуудад хүртээлгүй хэвээр л байлаа. Барууны эрдэмтэд араб, жүүд хэлээр туурвисан метафизик, анагаах ухаан, алхими болон одон орны судруудыг судалж эхэлсэн боловч газарзүйн мэдлэгийг нь ашиглаагүй мэт байдаг. Исламийн нөлөөнд асан Загалмайтны нийгэмлэгүүд, мөн алс холын Хятад, Энэтхэг гэдэг нь Константинополь болон Ромчуудад мөнөөх л буруу номтон хэвээр харагдаж, тэдний харилцааг шашинжсан хэл, соёл нь зааглаж байв. Өрнө, Дорно гэгч хоёр ондоо ертөнц байлаа.

Загалмайтны анхдугаар аян дайны дараа 1100 оноос эхлэн Сири, Палестиний эргийн дагуу Ромын сүм хийдийг үнэнчээр даган биширдэг норманн буюу “франк” загварын ванлиг үүсэн тогтов. Үүгээр Өрнө, Дорно ойртсон хэдий ч найрсаг харилцаа бий болсонгүй. Өрнөөс түрэх аюул заналын өмнө лалын захирагчид өвөр хоорондынхоо тэмцэл толхилцооныг намжааж дөнгөв. Исламын бүхий л хүчийг Саладиний тугийн дор нэгтгэж чадсанаар эзлэн түрэмхийлэгчдийг далайн эрэг рүү шахан зайлуулж, хэврэгхэн боловч лалынхны тулгуур хамгаалалтыг Акра боомтод байгуулж чадсан (Арслан зүрхэт Ричардын удирдлага дор явуулсан Загалмайтны гуравдугаар аян дайны явцад Өрнийнхөн Акра боомтыг эзлэн 1291 он хүртэл эзэмшин эзэгнэж байв). Загалмайтны дөрөвдүгээр аян дайны явцад 1205 онд латиний Загалмайтнууд өөрсдийн өрсөлдөгч Герегүүдээс Константинополь хотыг булаан авч Фландри гаралтай “франк” Болдуйнийг Константиний сэнтийд залан эзэн хаанаар өргөмжлөх үед уг хотыг эзлэн авахад голлох үүргийг гүйцэтгэсэн Венецийнхний мэдэлд хотын 3/8-ыг захируулахаар өгсөн байв. Гэтэл дахин нэгдсэн Загалмайтны ертөнцийг бүхэлд нь Папын улс төрчид мэдэлдээ авахыг эрмэлзэж байлаа. Энэ зуур Дорно зүг рүү улам ойртон дөхсөн

Венецийн худалдаачид худалдаа-наймааныхаа цар хүрээг аль болох өргөтгөн тэлж, боломж бүрийг алдалгүй ашиглаж байжээ. Исламынхны хувьд, Өрнө, Дорныг заагласан төмөр хөшгийг аянга ниргэх мэт зад татаж тэдний эзэмшлийн ¼-ийг хураан авсан Загалмайтнууд бол үл мэдэх ертөнц байв.

Хурдан морь хөлөглөж, хурц зэвсэг агсан шилжих хөдлөх нь хурдан, эр зоригтой эрэмгий шалмаг Төв Азийн хээр талын нүүдэлчдийн эвшээлгэх нум, исгэрэх сум нь Европоос Хятад хүртэл тархан байршсан суурин иргэншилт хүн ардыг үхэл хагацлаар үргэлж заналхийлсан айдас хүйдсээр байнга дарамталж байлаа. Туркестанд нутагшсан Түрэг нүүдэлчид Исламын ертөнцийг байн байн довтлон түйвээсээр яваандаа перс, арабуудыг эзлэн захирсан дарангуйлагчид болон хувирсан. Тэд аажимдаа лалынханд уусан шингэж мэргэн Зөнчийн номлол шашныг даган шүтэгчид болсон төдийгүй уг шашныг Ази тивийн гүн рүү тархаан дэлгэрүүлэгчид болсон юм.

Төв Азийн зах хязгааргүй хээр талд хэсэг бүлгээрээ чөлөөтэй нүүдэллэн амьдрагч малчдад дээрх номлол, шашин хүрч чадаагүй бөгөөд тэдгээр нүүдэлч-малчдын голлох аймаг нь Монголчууд байв. XII зуунд Монголын овог аймгууд, тэдний ханлигууд бас нэгэн хагарал, эмх замбараагүй байдалдаа татагдан орж, хоорондоо дайн тулаан хийсээр байлаа. Загалмайтнууд Константинополийг эзлэн авснаас нэг жилийн дараа буюу 1206 онд, дорно зүгийн 3000 бээрийн тэртээх ариун дагшин газар Хархорумд (Karakorum) нүүдэлчид хуран чуулж, удирдагч буюу Хаанаа сонгохдоо тэр үед нэрд гарсан толгойлогч Тэмүүжинийг “Чингис хаан” нэрээр өргөмжлөв (түрэгээр Жингис гэх). Чингис хааны тогтоосон журам, зорилгын дагуу 12 жилийн турш байлдан умарт Хятадын нутагт өөрийн тусгаар улсыг байгуулаад байсан Кидан буюу сүүлд Катай (Cathay) гэж нэрлэгдэх болсон монгол овгийн улсыг байлдан эзлэв. Тэр үеэс эхлэн тэд нар “газар дэлхийг бүхэлд нь байлдан эзлэх” (98х) зорилготой байсан юм гэж Марко Поло ярьсан байдаг.

Монголчууд байлдан дагуулах үйл ажиллагаагаа эхэлснээс хойш хоёрхон үе улирах ахархан хугацаанд Энэтхэг-Хятадын, Энэтхэгийн, Арабын болон Баруун Европ гэсэн дөрвөн хойгоос бусад Евразийн эх газрыг бүхэлд нь эзлэн захирсан байлаа. Энэхүү агуу том эзэнт гүрний тэлэлтийн өлгий Дорнод хэсэг нь Эзэн Чингисийн гэрээс ёсоор түүний ор залгамжлагчийн эзэмшил, захиргаанд үлддэг байв. Харин Эзэнт гүрний үлдэж байгаа гурван салбар улс болох Оросын Европын хэсгийг багтаасан Баруун эзэмшил (Алтан ордны улс), Марко Пологийн Левантийн эзэмшил (Ил хаадын улс) хэмээн нэрлэсэн Дорно Персээс Газар дундын далай хүртлэх хэсэг, Туркестан буюу Трансоксианыг (Цагаадайн хаант улс) багтаасан Дундад Азийн эзэмшил<sup>48</sup> оршиж байсан бөгөөд эдгээрийг Чингис хааны хан хөвгүүд хуваан захирч байлаа.

Монгол цэргүүдийн дайрч өнгөрсөн нутаг ус үгүйрэн хоосорч, үхэл зовлонд нэрвэгдэн хоцордог байлаа (138х, 239х). Энэ бүхний хэтийн уршиг таамаглах аргагүй байв. Гэгээн Албаний сүмд ном үзэж байсан Мэтью Парис 1238 оны тэмдэглэлдээ, Ярмутын зах зээл май загасаар хахатлаа дүүрлээ, урьд нь Балтийн орчим руу барьсан загасаа борлуулдаг байсан Скандинавын худалдаачид тэр жил Монголчуудын халдлага, дайралтаас эмээгээд тийш явахыг болилоо гэжээ. Чөтгөр шулам нүгэлт хорвоог цээрлүүлэхээр хөлсний цэргүүдээ илгээжээ хэмээн Загалмайт шүтлэгтнүүд боджээ. Монголчуудын холбооны нэг Татар хэмээх овгийн уугуул нэр нь тамын домогт гардаг Тартарус хэмээх чөтгөрийн үр удамын нэртэй

адилхан санагдсанаас Загалмайтнууд Тартар хэмээн монголчуудыг нэрийдэх болсон ажээ. 1260 онд Ромын Пап лам дөрөвдүгээр Александр Загалмайтны ертөнцийн бүхий л жонон, хунтайж нарыг “Clamat in auribus” бухын дүрээр тулгаран ирж байгаа аюул заналхийллийн эсрэг хүчээ нэгтгэн хамтран тэмцэхийг зарлигдсан уриалгадаа: “Ухаан санаа саруул хүн бүхнийг сэргэг болгоомжтой байхыг сануулан аймшгийн дохионы бүрээний зэвүүн дуун чихэнд хонх мэт жингэнэн Бурханы хилэнгийн ташуурыг гартаа атгасан зэрлэг тартарууд замдаа таарсан бүхнийг хайр найргүй сөнөөн устгаж эвдлэн сүйтгэсээр цуст дайн нөмрөн айсууг эргэн тойронд болж байгаа үйл явдал бүхэн нотолж байна, газар дэлхийг доргион чичиргэсэн энэ аюул үл үзэгдэх чөтгөрийн хязгаараас наашлан айсуу, үүнийг зогсоох, тогтоох хүчин Загалмайн шашинт ертөнцийхөнд хараахан үгүй билээ, ирж байгаа мэдээ бүхэн эргэлзээ таамаг төрүүлхүйц ээдрээтэй байна, тулгаран ирж буй аюулыг зайлуулах арга ухаан сүвэгчлэн нөмрөн ирэх аюулаас зайласхийхийг хичээцгээ” гэж уриалж байжээ. Аз болоход Өрнийнхөн энэ аюулын гадна үлджээ. Монгол “хар салхи”-ны гол хохирогч нь Загалмайтны Герег сүмийн (Үнэн алдарт) урсгалыг шүтэгч Оросууд байсан бөгөөд Загалмайтнууд өөрийн уламжлалт өшөөтөн Исламынхнаас хавьгүй бага зовлон хохирол амсчээ. Монгол цэргийн довтолгоонд туйлдаж цөхөрсөн Лалынхан аргаа бараад Загалмайтны ноёдоос тусламж дэмжлэг эрэлхийлэн хүсэхэд: Винчестерийн хамба ламтан “ноход хоорондоо хэрэлдэж, хэмхлэлцэж байг л дээ” гэсэн хариу барьсан нь Загалмайтнууд Лалынханд ханддаг үзэл бодлын тод илрэл байлаа. Тэр ч байтугай Загалмайтны зарим ноёд Лалынхантай тэмцэлдэхэд бузар тартаруудтай холбоо тогтоохыг илүүд үзэж байв.

Иргэншлийг үл тоомсорлодог монголчуудын толгойг амлалт, өгөөшөөр амархан эргүүлнэ гэж боджээ. Хий хоосон сүсэгт автсан, зохион байгуулалттай сахил санвааргүй, шашны талаар ойлгоцгүй Тартарууд нь Загалмайтны зүгээс хаяж буй өгөөшийг дагаж амархнаар хувьсан өөрчлөгдөнө гэж тооцоолж байв. Энэ зорилгоор ямар нэгэн хязгаар хяналтгүй худалдааны чөлөөт бүсийг буй болгожээ. Худалдааны чөлөөт бүс нь дипломатууд, шашны суртал-ухуулгынхан болон худалдаачдын хувьд ёстой л диваажин байлаа. Христүүд боломжийг ашиглахыг эрмэлзэж байв. Зориг зүрхтэй, ухаалаг гярхай Францискан шүтлэгтэн лам нар болох Жиованни ди Пиано Карпинийг 1245 онд Пап лам IV Иннокентийн зараалаар, мөн Гильом де Рубрукийг 1253 онд Францийн хаан IX Луйн төлөөлөгчөөр Хархорум хүртэлх урт аялалд баптийн шашин түгээх, найрамдах саналтайгаар илгээсэн боловч тэд сонирхолтой мэдээтэй, гэхдээ маш урам муутайхан буцаж ирцгээв<sup>49</sup>.

Венеци хотын худалдаачин ах, дүү Никколо болон Маффео Поло нар өөрсдийн бараа, бүтээгдэхүүнээ борлуулах гүйлгээ сайнтай, ашиг өндөртэй зах зээл хайж олохоор зориг шулуудан 1260 онд дарвуулт онгоцоор Константинополиос гарч Крымийн хойгийн Судак боомтод хүрэлцэн ирээд зогссонгүй, амь нас амьдрал ирээдүйд нь заналхийлсан аюул осол отоож байж болох их талын зүг аяллаа үргэлжлүүлэхдээ “хүн төрөлхтний нүдийг бүлгийлгэж чихийг дэлдийлгэх” их үйлийн босгыг алхаж байгаагаа өөрсдөө ч гадарлаагүй билээ. Энэ аялал нь ердийн нэгэн худалдаа наймааны аян байсан юм. Венецийн худалдаачид Судак боомтод аль хэдийн суурьшин төвхнөцгөөсөн хүмүүс байснаар барахгүй Поло нарын ахмад нь Судакт өөрийн орон байшинтай байсныг Маркогийн яриа гэрчилдэг. Үнэ цэнэтэй бараа таваар ачаалан Ижил мөрөн дээр орших Баруун Тартаруудын эзэн Бэрх (Barka)<sup>50</sup> хааны нийслэлийг зорин аялах жинчдийг даган гарсан ах дүү хоёрын энэхүү аян нь маш ухаалаг бөгөөд ирээдүйтэй алхам байлаа. Магадгүй энэ нь бүр дээрээс бодож төлөвлөсөн зүйлийг

бодитоор хэрэгжүүлэх анхны алхам байсан төдийгүй Европын экспортод шинэ зах зээл, шинэ зам нээх мөн тал нутгийн эзэд, захирагчдын сайшаал дэмжилгийг хүлээх, худалдааны төлөөлөл төлөөлөгчдийн газрыг нээх том зорилго агуулсан байж болох. Ах дүү Поло нар зорьсон газартаа хүрч, тавьсан зорилгоо амжилттай бүтээгээд нутаг буцах гэтэл 1262 онд Бэрх хаан, Левантийн хаан Хүлэг (Hulagu) нарын хооронд дайн дэгдэж тэдний буцах замыг боож саатуулсан явдал тохиосон төдийгүй энэ дайн нь хэн ч даваж гарахын аргагүй Тартаруудын бат нягт нэгдэл задран бутрах ан цав сууж буйн шинж тэмдгийг илэрхийлж байв. Тэд нар дайн дажны хөлөөс дайжин зугтаж, элдэв мөргөлдөөн будлианд орооцолдохгүйн тулд тухайн үедээ төвийг сахин хоцорсон тартаруудын гуравдахь их эзэмшил улсын Бухара хотод толгой хоргодоцгоосон билээ.

Энд байхдаа тэд тартар хэл сурч, тэдний соёл иргэншил, ёс заншлыг судлан танилцсаар хэдэн жилийн нүүр үзсэн шиг байдаг. Тэр хоёр энэ нутагт хөл тавьсан хамгийн анхны европчууд байсан нь маргаангүй. Исламын худалдаа арилжааны төв болсон Бухара хотод үүнээс өмнө “латин хүний хөл хэзээч гишгэж байсангүй”, энэ газар нутгийг тартарууд байлдан эзлээгүйсэн бол энэ газар латин хүн хэзээ ч хөл тавих бололцоогүй байсан. Одоо ч гэсэн тэдний байдал санаа зовохооргүй амгалан тайван байгаа гэхэд эргэлзээтэй байсан нь Туркестаны хан Барах (Barak) исламын шашинд дагаж ороод удаагүй байлаа. Энэ үед тэр хоёрт азтай нэгэн учрал тохиож хорвоогийн бүх тартаруудын их эзэн Хубилай (Kublai) хааныг зорьж яваа Левантийн хааны дипломат төлөөлөгчдийн цувааныхан тэр хоёрыг хамт явахыг зөвшөөрөн урьснаар ах дүү хоёр үүнээс өмнө нэг ч европ хүн хөл тавьж үзээгүй алс холын Хятад орныг зорилоо. Хятадын түүхчдийн өгүүлснээр Хубилай хаан нь өөрийхөө хагас зэрлэг өвөг дээдсээс тэс өөр зан ааштай нэгэн байжээ. Тэр хятадын соёл, иргэншлийн сайн сайхан дээжсийг өөртөө шингээсэн, хүнлэг энэрэнгүй Буддын гүн ухааныг мөрдөн дагадаг хэдий ч хээр талын нүүдэлчний энгийн бөгөөд шавхагдашгүй их эрчим хүчийг хадгалан үлдсэн хаан байлаа. Хан-балык (Peking) хот дахь эзэн хааны ордны хашаан дотор хээр талын зэрлэг өвс ургамал тарьж ургуулсан нь хээрийн салхи шиг чөлөөтэй өссөн хээр тал нутгаа үргэлж санагалзан байдгийн нь гэрч болой. Их хаан Хубилай сүүлийн хэдэн зууны турш Хятадын нэг ч эзэн хааны санаанд багтаж, зүүдэнд нь ороогүй ухааны ур, сэтгэлийн тэнхээгээр Хятадын төрийн машины жолоог залан удирдаж байжээ.

Алс баруун зүгээс ирсэн хоёр зочныг найрсаг эелдгээр хүлээн авч, хүндэтгэн зочилж тэдний ярьж хэлсэн бүхнийг анхааралтай сонсон тунгаасны эцэст тэр хоёрт Ромын их хамбад хүргэх тусгай урилгыг гардуулан буцааж илгээсэн бөгөөд тэрхүү урилга нь “загалмайн шашны номлол, долоон урлагийн зан үйлийг төгс эзэмшсэн, танай шашны ид шид, хүчин чадлыг илтгэн үзүүлж чадах зуун санваартныг илгээнэ үү” (76x) гэсэн байжээ. Хааны санаа зорилго, хийсэн хэлэлцээ нь ах дүү хоёртой эн тэнцэх илүү олон хүнийг ашиглах бодол байсан байж магад.

Загалмайн шашин, Загалмайтнуудын талаар их хаан нэлээд ул суурьтай сонирхож байсан юм болов уу? эсвэл Мадагаскарын аралд орших “rukhi” гэдэг амьтныг үзэх сонирхолдоо хөтлөгдөн 5000 бээрийн алсад орших арал руу элч төлөөлөгч илгээж байсан шиг өнгөц сонирхол уу? эсвэл Өрнөдийн орнуудтай хийх худалдаа арилжаагаа өргөтгөх, лалынхны эсрэг Загалмайтнуудтай хэлхээ холбоо тогтоох, бүр алс хэтдээ Загалмайтны ертөнцийг байлдан дагуулах холын бодол агуулсан уу? хэн ч үүнийг одоо тааж хэлэхийн аргагүй болжээ.

Ямраар ч бай, Их хааны бодол зорилго эцсийн дүндээ нэлээд хязгаарлагдмал үр дүнд хүрсэн юм. Ах дүү хоёр Поло 1269 онд латиний Загалмайтнуудын дорнод хязгаар болох Акра хотод хүрэлцэн ирсэн үе нь цаг хугацааны хувьд нэн тааламжгүй үе байлаа.

Пап лам IV Клемент нэг жилийн өмнө өөд болоод байсан ба Латин ертөнц оюун санааны удирдагчгүй, дахин сонгон өргөмжлөх үйл явц сонгуулийн тогтолцооноос болж гацсанаас гурван жил сунжирч, Сүм хийдийнхэн маш эвгүй байдалд орж, улмаар сонгуулийн тогтолцоогоо эрс өөрчлөхөөр хэлэлцэж байгаа цаг үе таарчээ. Загалмайтныхан Дорно зүгийг зорьсон элч төлөөлөгчид илгээх талаар бодож тооцсон зүйл ч үгүй, цаг үеийн тохироо ч бүрдээгүй байлаа. Усанд хаясан чулуу шиг чимээ сураг тасарсандаа айж, зовнисон ах дүү Поло нар 1271 онд Италиас Акра орж Пап ламын бүрэн эрхэт төлөөлөгч Тедалдо Висконти гэгч өндөр хэргэм зэрэгтэй мяндагтантай уулзаж түүний тусламж дэмжилгийг авахаар болов. Тедалдо Висконти нь Дорноос заналхийлах айдас аюул, загалмайн шашныг дорно зүгт тархаан дэлгэрүүлэх боломж бололцоог эн тэнцүү үнэлж чадсан өргөн мэдлэг, холын хараатай нэгэн байжээ. Ах дүү Поло нар ийнхүү Тедалдо Висконтийн тусламж дэмжлэгтэйгээр Дорно зүгт хийх урт удаан аяндаа гарч чадсан бөгөөд тэднийг Палестинд ирэхэд шашны сонгогчдын төлөөлөл хэнийг Папаар сонгохоо нэгэнт тохирон тогтсон байсан бөгөөд тэр эрхэм нь Тедалдо Висконти байлаа.

Ах дүү хоёр Полог Акра хотод яаралтай дуудуулав. Ромын Пап ламаар шинээр сонгогдсон Тедалдо Висконти “Х Грегорий” нэрээр ширээндээ заларч, ах дүү хоёр Полод жинхэнэ дипломат элчийн итгэмжлэх жуух гардуулан, загалмайн шашныг дорно зүгт дэлгэрүүлэх “зуун санваартан”-г ахархан хугацаанд цуглуулж чадаагүй (79х) боловч Загалмайтны дунд асар их нэр хүндтэй хоёр том ламыг илгээхээр бэлдсэний нэг нь Арабын эрдэмтдийн дунд нэр алдар нь түгсэн Триполийн Уильям гэгч санваартан байлаа. Гэвч дээрх хоёр санваартанд Карпини юм уу Рубрук шиг зорьсондоо хүрэхийн тулд юунаас ч зүрхшээдэггүй их зориг, эрмэлзлэл тэмүүлэл даан ч заяасангүй тул ах дүү хоёр Поло тэдний оронд Никколо Пологийн хүү дөнгөж арван долоо нас хүрч буй Марког дагуулан Ромын Пап ламын даалгасан зүйлсийн нэгийг ч болов гүйцэлдүүлэхээр тэд холын аяндаа гарчээ. Өрнө Дорнын харьцаанд шинэ уур амьсгал оруулсан шинэ хуудас нээхээр санаачлан зүтгэсэн Ромын Пап ламын зүтгэл, итгэл талаар өнгөрч, бусдын нүдэнд өртөж анзаарагдаагүй ч аз хийморьтой нэгэн гэр бүлийнхний урт удаан аяны түүх л бидэнд үлдсэн юм. Дорныг зорьсон Пологийнхний урт удаан хугацааны аян хорин жил үргэлжилж, тэд тэр газар нутагт хэрхэн амьдарч, юу бүтээж явсныг хэн ч хэлж мэдэхгүй билээ. Тэдний амьдрал, аяны тухай энэ номонд өгүүлж буй цөөн тооны үйл явдлын зарим хэсгийг тодорхой хэмжээнд батлаж нотолж болох боломжтой ч олон олон зүйл нь эргэлзээ тээнэгэлзэл төрүүлнэ.

Сян-ян-фуд (Siang-yang-fu) (275х) болсон хар тамхины бүслэлтэд Пологийнхон оролцсон тухай мэдээ сэлтийг хятад эх сурвалжтай холбон үзэхэд төвөгтэйгөөр барахгүй уг үйл явдал 1273 онд болж өнгөрсөн бөгөөд энэ үед Пологийнхон Хятадад буцаж очих замдаа явж байсан гэж өгүүлдэг билээ. Марко Поло Ян-чаугийн (Yang-chau) (274х) амбан захирагч байсан гэдэг нь нэлээд эргэлзээтэй мэдээлэл, учир нь тэр үеийн эх сурвалжуудад амбан захирагчдын нэр, яс үндэс тэмдэглэгдээгүй байдаг. Хятадын эх сурвалжид “Нууц Зөвлөлийн зөвлөх” Поло гэж гардаг нь Венециэс очсон Полод огт хамаарахгүй зүйл билээ. Харин Марко Поло Монголын эзэнт гүрний Их хааны тусгай элчин төлөөлөгчөөр томилогдон Их монгол гүрний нутгаар



хөндлөн гулд аялаж байсан гэдэгт бол эргэлзээд байх зүйл огтхон ч үгүй (219х, 223х). Палестинаас Бээжин хүртэл аялах зам дагуух газар нутаг, хот балгадын талаар нэлээд цэгцтэй мэдээ баримтыг тэмдэглэн үлдээсний дотор номынхоо 1, 2 дугаар бүлэгт Багдад, Самарканд, Каракорум хотуудыг дайран өнгөрөв гэж гардаг боловч магадгүй эдгээр хот балгадаар биеэрээ ороогүй боловч тэдний тухай сонссоноо бичсэнийг үгүйсгэх аргагүй. Түүний сүүлч үеийн аялал нь алс хол, урт удаан хугацаагаар явсан тухай байдгийн нэг нь Бээжингээс зүүн өмнө зүг рүү Бирма орсон (Дөрөвдүгээр бүлэг) тухай болон бүр алс өмнө зүгт аялсан (тавдугаар бүлэг) тухай тус тус тэмдэглэн үлдээсэн байдаг. Их хааны төлөөлөгчөөр (309-311х) түүнийг Энэтхэгт илгээсэн тухайд бол эргэлзээд байх зүйлгүй билээ.

Марко Поло Дорнын ертөнцөд хорин жилийг өнгөрөөхдөө зөвхөн Алс дорнод нутаг орноор аялаж байсан бөгөөд Барууны ертөнцөөс бүрэн мөсөн тусгаарлагдсан байжээ гэсэн ойлголт өнөөг хүртэл давамгайлдаг билээ. Гэвч энэ нь маргашгүй үнэн биш бололтой. Бүдүүлэг Мөнх хааны ордонд европын уран дархан ажиллаж байсныг Рубрук ярьсан байдаг<sup>51</sup>, хүлээцтэй, илүү соёлжсон Хубилай хаан үүнээс ч илүү дэвшилттэй байсан нь тодорхой. Энэ бол бүх л соёл иргэншилд тэгш, тэвчээртэй ханддаг Хубилай хааны ухаалаг бодлогын үр нөлөө байсан. Монголын эзэнт гүрэнд хөл тавьсан анхны “латин” иргэд Пологийнхон байсан ч байж магадгүй, гэхдээ тэд нар сүүлчийнх нь биш байсан.

1320-иод оны үед Хятадаар аялсан Порденоны Одорик ламтны хэсэг бусад тэмдэглэл, 1307 онд Бээжинд суухаар томилогдсон католик-Загалмайтны анхны дээд хамба Жиованни ди Монте Корвиногийн дурсамж зэргээс үзэхэд Барууны загалтайтнууд шашин номоо дэлгэрүүлэх талаар Алс Дорнодод бага сага зүйл хийсээр ирсэн бөгөөд түүнийг даган барууны худалдаа арилжааны ядмагхан урсгал ч аяндаа нэвчиж эхэлжээ. Венециэс маш олон хүн Кинсай (Ханьжоу)-д ирдэг тухай Одорик ламтан тэмдэглэлдээ дурьдсан байдаг, мөн Пеголотгийн “Худалдаачны гарын авлага” (1340 он) лавлах бичигт Өнөө үед Хар далайгаас Хятад орох аяны зам чөлөөтэй, айх аюулгүйгээр өдөр шөнөгүй зорчих боломжтой гэсэн байна. Үнэнхээр нөхцөл байдал ийм тааламжтай, тов тодорхой байсан бол Пологийнхон онцгой үүрэгтэй, идэвхитэй байр сууринаас тэрхүү их аяныг манлайласан нь аргагүй байжээ гэсэн сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө. Гэвч тухайн цаг үеийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээлэл хэтэрхий ховор хомс, дутуу дулимаг байсан нь харамсалтай.

Монголын эзэнт гүрэн задран бутархын хэрээр Исламын байр суурь бэхжиж, Мин улс (1368 оноос)-ын хаанчлал тогтохтой зэрэгцэн хятадын үндэсний үзэл сэргэн сэхэж Өрнө Дорнын хооронд давашгүй хана хэрэм болон цогцлож Европынхон Дорно зүг рүү гарах гарц, орох орцгүй болж Европын хойт үеийнхэн энэхүү хана хэрмийг давах арга, тойрох зам хайхад ухаан бодол, эрч хүчээ зарсаар олон оныг улираажээ.

Пологийнхон нутаг орондоо буцахаар 1292 онд Монголын эзэнт гүрний эзэмшлээс гарахдаа Левангийн хан Аргуны шинэ хатанд шадар бараа болон Малайн хоолойг гаталж Энэтхэгийн далайг туулан урт удаан хугацаанд далайгаар аялсан тухай зарим тодорхой баримт сэлтийг тэмдэглэж үлдээсэн нь бий (311х, 333х). Энэ далайн аяны тухай Маркогийн ярьсан зүйл нь Хятад болон Персийн түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн зүйлтэй зөрөөгүй тохирч байдаг. Саявтархан олдсон Хятад эх сурвалжид энэхүү аяныг удирдан явсан толгойлогчдын нэрсийг

хүртэл тодорхой бичиж үлдээснийг олсон. Харин энэхүү далайн аяныг Пологийнон оройлон оролцож, онцгой үүрэг гүйцэтгэсэн тухайд бол Маркогийн өөрийнх нь ярьсанаас өөр баримт сэлт бидэнд үгүй билээ. 1295 онд Пологийнон Венецид буцаж ирснээр далайн аяны тухай яриа төгсгөл болдог.

1553 онд хэвлэгдсэн Маркогийн тухай номын удиртгалд ам дамжин яригдсаар ирсэн зарим нэгэн мэдээ баримт, санаанаасаа зохиосон зүйлсийг хүртэл Жиамбаттиста Рамусио нэмж оруулсан байдаг. Пологийноны эргэж ирсэн тухай Рамусиогийн өгүүлсэн зүйлс нь эгээл Арабын мянга нэгэн шөнийн үлгэрийн нэлээд аятайхан хувилбар мэт: Тэднийг үхэж үрэгдээд аль хэдийн нөхцөж одсон гэж бодож байсан гэр орныхон, ахан дүүс нь Никколо, Маффео болон Марког эргээд ирсэн гэж итгэхгүй удаан эргэлзэцгээсний эцэст бүдүүн бараг, хуучирч элэгдсэн хувцастай боловч ихэмсэг бас гоморхож гомдсон тэр гурвыг бараг л Тартарууд гэж ойлгох шахан уулзацгаажээ. Энэ явдал баяр хөөрөөр бялхсан найраар өндөрлөж, холын аянаас ирсэн гурав ч хуучирч онгосон хувцасныхаа нөхөөс, оёдлыг ханзчин нууж хадгалсан очир эрдэнэ, бадмаараг, маргад эрдэнэсээ гаргаж ахан дүүсээ алмайруулав гэжээ.

Оршил хэсэгт (72х) өгүүлснээр 1298 онд Марко нь Генуягийнханд олзлогдон хоригдож байжээ. Марко 1298 оны есдүгээр сарын 6-нд Курзолагийн дэргэд болсон тулалдаанд Венецийн завьт цэргийг удирдан байлдаж яваад олзлогдсон гэж Рамусио өгүүлсэн байдаг. Энэ нь дахиад л хоосон цуу яриа төдий зүйл байсан бөгөөд аягүй бол санаанаасаа зохиосон таамаг ч байж магадгүй. Марко нь 1299 оны тавдугаар сарын 25-нд байгуулсан энхийн гэрээний дагуу олзноос суллагдсан бололтой. Байнгын эрэл хайгуул хийсэн аялагчтай төстэй юм олзлогдон хоригдсон Маркод бараг л үлдсэнгүй, гэвч холын оронд хийсэн аяныхаа тухай өгүүлсэн түүний яриа нь хоригдогсодыг мэл гайхашруулж байжээ. Хоригдогсодын дунд Пиза хотын Рустичелло гэгч нэрд гарсан мэргэжлийн зохиолч байсан бөгөөд Маркогийн яриа түүний сонирхлыг ихээхэн татсан төдийгүй Рустичелло Маркогийн яриаг жинхэнэ мэргэжлийн хүний сонирхлоор сонсдог байжээ.

Рустичелло нь английн хаан нэгдүгээр Эдвардыг хунтайж байхад нь түүний ивээл дор байж Папын бүрэн эрхэт төлөөлөгч байсан Тедалдогийн адилаар Палестинд ажиллаж байжээ. Хорин таван жилийн өмнө Палестинд байхдаа Пологийнон адал явдалт алсын аянд гарахаар зэхэж байгаа тухай сонсож мэдсэн байхыг ч үгүйсгэх аргагүй.

Маркогийн ярьж байгаа зүйлс “Британий хэрэг явдал”, “Тройн түүх” болон Сулхарнайн тухай домог туульсаас доргүй сонирхолтой, зөвхөн Рустичеллогийн хувьд төдийгүй барууныхны хувьд яах аргагүй цоо шинэ сэдэв байсан, үүнийг мэдэрсэн зохиолч өөрөө ч яарч, Марког ч шамдуулж эхэлсэн. Марко өөрийнхөө санал бодлын талаар Венеци рүү Рустичеллод мэдээ, мэдээлэл илгээн хамтарч ажиллаж байсан нь тодорхой байдаг. Нүдээрээ харж, чихээрээ сонссон бүхнээ ой санамжиндаа тунгаан хадгалсан худалдаачин эр, түүний ярьж өгүүлсэн адал явдалт түүхийг бичиж тэмдэглэсэн зохиолч хоёрын нөхөрлөлийн үр шим болж нэгэн гайхамшигтай ном төрж номын ертөнцийг баяжуулах нь тэр. Харамсалтай нь энэхүү номын үйл явдлыг өгүүлсэн Марко Поло ч, түүний яриаг тэмдэглэн ном болгосон Рустичелло ч юутай ч зүйрлэшгүй эх мэдээллээ цаашид үргэлжлүүлэн боловсруулж бүрэн төгс бүтээл болгох санаа төрсөнгүй нь тэдний хэн нь ч суут ухаантан байгаагүйг гэрчлэхийн зэрэгцээ дундад зууны католик-загалмайн шашны үзэл, зарчим харь орны өндөр хөгжсөн соёл

иргэншлийг ойлгон хүлээн авахад саад тотгор болж байсныг ч үгүйсгэх аргагүй. Энэ бүхнийг ойлгон үнэлдэг суут ухаантан ховор байдаг билээ. Гэвч энэ гайхамшигт номыг бүтээсэн хоёр хүн тухайн цаг үедээ гайхамшигийг бүтээсэн нь эргэлзээгүй юм. Энэ номыг бүтээн туурвихад Рустичеллогийн оруулсан хувь нэмрийг дутуу үнэлсэн шиг санагддаг. Марко Пологийн гар бичмэлийг анх удаа 1928 онд түүний бусад захидал, тэмдэглэлтэй харьцуулан шүүн тунгаасан профессор Л. Ф. Бенедетто: Рустичелло эртний франц хэлээр харилцан ярианы хэлбэрээр тэмдэглэлийг хөтлөхдөө цаг хомс, ярих зүйл ихтэй насан хэвийсэн хүний аажуу тайван өгүүллийн дундуур өөрийнхөө дүгнэлт, уншигчдад хандсан гуйлт (*Que wos en diroie? Si wos die; Sachiez por voire, etc.*)-ыг байн байн хавчуулж энгийн ярианы хэлбэрээр үйлдсэн нь түүний бичлэгийн хэв маяг байсан байх гэж тов тодорхой дүгнэсэн байдаг. Номын оршил хэсэгт “эзэн хаан, ван, гүн, маркиз нар танаа” (72х) гэж хандаж гуйсан хэсэг нь Рустичеллогийн “Артуриан” романаас тэр чигээр нь хуулбарласан хэсэг байхаас гадна тэрхүү романаас нэлээд олон хэсгийг бага зэрэг өөрчилж хуулбарласан байдаг. Хоёрдахь удаагаа Хятадад аялан ирж Хубилай хаанд бараалхаж байгаа Пологийнхныг эзэн хаан хүлээн авч байгаа, залуу Марко баярлаж талархаснаа Их хаанд илэрхийлж байгаа (80х) зэрэг нь Рустичеллогийн өмнөх бүтээлдээ Артур вангийн Камелот дахь ордонд Тристаны ирж байгаатай тун чиг төстэй байгаа нь туульс бичлэгийн уламжлалыг баримталдаг өмнөх зохиолчдын барилтай ч мөн адил юм. Хамгийн эхлэл хэсэгт тэнэмэл рыцарийн тухай (*il ne trevent aventure que a mentovoïr face*) өгүүлсэн хэлбэрийг худалдааны зорилгын тухай таниулга болгожээ. Дээрхийн жишгээр түүж харьцуулаад байвал олон олон газарт Рустичеллогийн санаа хавчуулагдаж, гар дүрэгдэж гэдэг нь мэдэгдэнэ, ялангуяа номын сүүлчийн бүлгийн дайн тулааны тухай хэсэгт түүний нэгэн хэвийн сунжруу өгүүлэл, франк маягийн эелдэг харьцааг олж харж болно. Энэ мэтээр Рустичеллогийн оролцоо улам газар аван үргэлжилнэ.

Газар зүйн байршлын дэс дараа, нутаг ороны онцлогийг бичихдээ бодит байдлаас нэлээд гажсан, Ойрх Дорнодын домог, үлгэрийн нөлөөнд автсан маягтай Шидэт уулын домог, Магийн тухай үлгэр (333х,372-373х), Аламут дахь хий мөрөөдлийн диваажин (5120х) зэрэг дэвэргэн сэтгэлийн зөгнөл мөрөөдлөөс үүдсэн дүр52зургийг буулгасан байдаг. Энд өгүүлж буй түүх, үйл явдал нь Ариун газарт (Holy Land) мөргөл үйлдсэн хүмүүсийн яриа байх магадлал илүүтэй боловч Маркогийн хэлж ярьсан зүйл мэтээр хувирган номондоо оруулсан нь Рустичеллогийн зохиол бүтээлээ туурвихад хэрэглэдэг уран зохиолын нэгэн төрөл “арга барил” юм болов уу? Дорно зүгийн гүн тийш аялах тутам зохиолчийн үзэл бодлоос холдон ангижирч, Маркогийн өгүүлсэн тулалдааны дүр зураг жинхэнэ төрхөөрөө тодорч газар нутгийн нэр ус ч тохирч байх жишээтэй. Номонд гарч байгаа бас нэгэн онцлог нь яах аргагүй Рустичеллогийн Маркод хандах хандлагын илрэл болсон зүйлс байх. Тартарын ордонд Маркогийн эзлэх байр суурийг магтан биширч байгаа, ялангуяа тэдний хамгаалан асарч яваа гүнж нартаа тавьж байгаа халамж хүндэтгэл (34х),монголчуудын эр эмийн зан дадлын авьяас, эв найрамжийн тухай түүний ухаалаг ончтой хошигнол, шинэ соргог бүхнийг “гайхамшиг” гэж хүлээн авах бахархал бишрэл энэ бүхэн бол Рустичеллогийн бүтээсэн Марко Пологийн53 дүр билээ. Рустичеллотой учирч танилцаагүй бол Марко хэзээ ч ийм ном туурвин бүтээгээгүй байж мэднэ. Энэ ном нь худалдаачдад зориулсан Пеголеттогийн гарын авлагыг бодвол уншихад таатай, мэдээлэл ихтэй болсон нь маргах аргагүй үнэн. Марко гэж хэн юм бэ гэдгийг энэ номноос гадна тодорхойлсон хоёр тохиолдол байдаг. Эдгээр хоёр тохиолдол нь 1323 юм уу 1324 оны нэгдүгээр сарын 9-нд түүний хүсэл санааг бичиж баталгаажуулсан ажил хэрэгч бичигт буй бөгөөд өөрийнхөө хөрөнгийг гурван охиндоо адил

тэнцүү хувааж өгөөрэй гэсэн гэрээслэл юм. Мөн өөрийн тартар боол Питерийг чөлөөт иргэн болгоорой гэж гэрээсэлсэн байдаг.

Түүний охиддоо үлдээсэн хөрөнгө нь гайхмаар их биш боловч хангалттай арвин хөрөнгө байжээ. 1305 оны үед Марког “саятан” гэж нэрлэсэн хоч нэр үүссэн байдаг нь түүний охиддоо гэрээслэж үлдээсэн хөрөнгө мөнгөтэй яах аргагүй холбоотой гэхэд дэгсдэхгүй бөгөөд энэ хоч нь түүний ярьсан зүйлээс бус түүний тухай номноос үүдэлтэй билээ. Марко Поло гэгч нь ерөнхийдөө төлөв даруу нэгэн байжээ гэсэн дүр зураг түүний тухай номноос тод томруун харагддаг боловч он дарааллын түүх бичлэгийн даваа нугачаанд Марко Пологийн дүр зураг<sup>54</sup> бүрхэгдэн бүүдийж хоцорсон ч байж мэдэх.

Марко Пологийн туулсан урт удаан хугацаатай, алс холын аян нь түүнийг эцэж цуцахыг хайхардаггүй зориг тэвчээртэй, ухаалаг эр болохын баталгаа болохоор барахгүй тэр урт удаан аяныг ухааны хурц, сэтгэлийн тэнхээгээр туулсан нь гарцаагүй. Пологийнхон юуны өмнө аялагчид болон худалдаачдын харах нүд, сонсох чих болж явсан төдийгүй зам гудас дагуу идэх хоол, уух усаа хаанаас яаж олох, ямар төрлийн унаа хөсөг байдаг, байгалаас заяасан болон хүний гараар бүтсэн саад тотгор хаана байдаг түүнийг хаагуур нь яаж давах, тойрох, дайран өнгөрөх нутаг орны зах зээл, тэдгээрт борлуулагддаг байгалийн бүтээгдэхүүн, хүний гараар бүтсэн үйлдвэрийн бүтээгдэхүүн нь юу юу байгаа, харилцан шүтэлцэж эргэх гадаад, дотоод худалдааны урсгал, сувгийг тандах зэрэг асар их ажлыг бүтээсэн нь гарцаагүй. Аялагчид, худалдаачдыг далайн хөлөг живх осол (97х), далайн дээрэмчид (114х), жингийн цуваа, зам тоссон тонуулч дээрэмчид (110х), залилан мэхлэгч луйварчид (109х), зэрлэг араатны довголгоо (240х) зэрэг аюул осол алхам тутамд нь отон хүлээж байсан боловч нарийн зохион байгуулалт, нягт бүтэцтэй Дорно зүгийн худалдаа арилжааны ертөнц оршин тогтносоор байсан төдийгүй цэцэглэн хөгжсөөр ирсэн. Барууны худалдаачид одоо болтол Дорнын талаар өчүүхэн бага мэдлэгтэй байсан бөгөөд тэдний мэдлэг нь Газар дундын далай болон Хар тэнгисийн эрэгийн боомт хотуудаас хэтэрсэнгүй, харин энэхүү нууцлагдмал мэдээ мэдээлэл нь тэдний нүдийг нээж гайхашруулсан төдийгүй тэр хэрээрээ ашиг өгөөжтэй байв. Пологийнхны нээсэн худалдааны зам, зах зээл нь хэт өндөр үнэтэй ховор бараанаас бусад ямар ч бараа таваарыг шингээх төдийгүй маш их олз ашиг өгөхөөр байв. Өдөр тутмын улигт хэрэглээний бараа таваараас илүүгээр үнэт чулуу, хоргой торго, сонин хачин хоол амтлагч зэргийн тухай мэдээлсэн нь энэ үеэс хойш дундад зуун төдийгүй орчин үед ч гүйлгээтэй бараа худалдааг хэвшүүлэхэд нөлөөлсөн юм. Үнэт эдлэл, эрдэнийн чулууны нэрсийг жагсаан бичсэн нь үе үеийн уншигчдад сэтгэлийн таашаал өгч байгаатай адилаар номын зохиогчдод ч таатай байсан гэдэгт эргэлзэх зүйлгүй юм.

Марко тухайн үеийнхээ хот, хөдөөгийн амьдрал, нөхцөлийг үнэлж цэгнэхдээ жинхэнэ хэрэглэгчийн байр сууринаас хандаж: Худалдаа арилжаа дэлгэрсэн, дэгжин дэвжиж байгаа “сайхан” хот, будаа тариа арвижиж, мал сүрэг өссөн “өгөөж тэнүүн” хөдөө гэж бараг л хөдөлмөрийн бүтээмж юм уу, үйлдвэрийн бүтээгдэхүүнээр нь ангилсан үнэлэмж, үзүүлэлтээр дүгнэсэн байдаг. Уран барилга (186-189хх) болон соёлын бүтээлийн (190-193хх, 194-1204хх) тухай тэдгээрийн үр нөлөө, уран яруу хөг аялгуу, хийсэн материалын үнэ цэнэ, өнгө будгийн хослол зэргийг дүрсэлж, уран бүтээлчсэг мэдрэмж төдийгөөр хязгаарлалгүй өгүүлсэн байдаг. Памирийн уулс (134х) болон их Говийн (139х, 143х) тухай өгүүлэхдээ уул толгодын дундах эрүүл ариун агаар, элчилгүй их цөлийн нүд алдам уужмыг гайхан дүрсэлж

ярсан төдийгүй байгалийн сайхныг бишрэн бахархаж идэр насны сэтгэлийн жолоо алдарч байсан нь ажиглагддаг. Хэдийвээр үзсэн, туулсан улс орныхоо хот балгад, байгаль орчин, улс нийгмийн тухай өгүүлж байвч юм бүхнийг овсгоотой худалдаачны гярхай нүдээр харж байсан<sup>55</sup> нь мэдрэгддэг.

Дундад зууны Европын аль ч хэлэнд “соёл иргэншил” гэдэг ойлгоцыг илэрхийлэх үг байсангүй, харин Марко үүнийг өөрийнхөө ойлгосноор илэрхийлэхийн тулд “domersce” гэдэг үгийг хэрэглэсэн байдаг бөгөөд Марко дорнын их соёл иргэншлийн талаар өөрийн гэсэн ойлгоцтой, өргөн цар хүрээтэй мэдлэгтэй байсныг энэ үг давхар гэрчилдэг. Түүний “эрхэм сайн” гэж нэрлэн хүндэтгэдэг хүмүүс нь ажилч хичээнгүй, хууль дүрмийг ягштал мөрддөг худалдаа, үйлдвэрлэл эрхлэдэг si come bone jens doient faire хүмүүс хамаарагдана, харин “тааруухан муу” гэж үздэг хүмүүс нь залхуу, зөрүүд голдуухан байх бөгөөд тэдний дундаас л дээрэмчин тонуулчид, далайн дээрэмчид төрөн гардаг гэж тооцно.

Хүмүүсийг рыцарийн жишиг загвартай харьцуулан үнэлсэн түүний үнэлэмжээр (эсвэл Рустичеллогийнхаар) Тартар цэрэг дайчдын (156-158xx, 226-227xx, 391-392xx) байлдах ур чадварыг өндөрт тавьсан байх бөгөөд харин Бага Армений хүмүүс (91x) арчаагүй төрж муу муухай дадал зуршилтай болсоор байгаад тэр нутгийн цаг агаар, уур амьсгал муу нөлөө үзүүлж байна гэсэн байдаг. Кашгарын (135x) хүмүүс харамч хариг гэдэг бол өөрийнхөө биеэр туулж амссанаа илэрхийлсэн хэрэг. Тэр уулзаж учирч явсан хүмүүсээ арьсны өнгө буюу соёл иргэншлээр нь биш шашин шүтлэгийн онцлогоор нь ялгаж ангилсан<sup>56</sup> байдаг. Гэхдээ Загалмайн шашинтан, Жүүд шүтлэгтэн, Сарацинчууд болон Бөө мөргөлтөн буюу Онго шүтлэгтэн (Idolaters) гэсэн ангиллаас нэг их гажиж хэтрээгүй байдаг. Нестор мөргөлтөн, Якобитууд (Jakobits) болон Арменчууд нь “төгс төгөлдөр бус” загалмайн шашинтан гэж тооцогддогыг сайн мэдэж байсан боловч тэрхүү ялгаварлал, гадуурхлыг огт тоодоггүй байсан шиг байна.

Харин тэр үеийн олон улс хоорондын худалдаа арилжаанд жүүдүүд ихээхэн үүрэгтэй, тодорхой байр сууринаас оролцож байсан тухай маш өнгөцхөн дурьдсан нь гайхмаар байдаг. Лалынхныг “Магометийг шүтэгчид” гэж нэрлэн тун хайнга хөндий үл тоомсорлосон байдлаар хандаж байгаа нь тэрбээр өөрөө загалмайтан, мөн шашны дайсагналцсан уламжлалт харьцаа, бас лал худалдаачидтай зах зээлийнхээ төлөө өрсөлдөн байсны аль аль нь нөлөөлсөн бололтой. Энд, ялангуяа Буддын шашинтан, Хинди нар зэрэг “Онго шүтлэгтнүүд”-ийн хүлцэнгүйн талаар юунаас ч илүү тод харуулсан нь ертөнцийн хүний үнэн ухамсарын тухай түүний хандлага юм гэж бид таамаглаж болох байна. Буддын ариуссан лам хуврагуудын (133x) (136x) чанд дэг ёсыг Марко хүндлэн биширдэг байснаар барахгүй энэрэнгүй Буддаг Загалмайтны гэгээнтэй (146x) харьцуулан бахадсан зэрэг нь тэдний амьдралын гүн ухаанд нэвтэрч танин мэдсэн гэсэн үг хараахан биш ээ. Гэвч дорно зүгийн шашин, номлолыг хэтэрхий магтан ил тод сурталчилахгүй байхыг Маркод анхааруулж байсан нь Загалмайн шашны хяналт, дарамтаас эмээснийх байжээ. Ер нь түүний үлдээсэн гар бичмэлүүд нь шашны хяналт хараан дор бичигдсэн байх магадлал ихтэй.

Номын эх гар бичмэл болон бусад гар бичмэл хувилбаруудад загалмайн шашны сүм хийд, лам хуврагийг нэлээд чанга чимхэж шүүмжилсэн зүйл байсныг зориуд орхигдуулсан тал бий. Эдгээрийн зарим нэгэн нь загалмайн шашин, сүм хийдийн талаар зөвхөн Марко л зориглон

хэлчих санаа бодол цухалзаж байхад зарим нь мухар сүсгийн хүлээсэнд баглагдсан лам хуврагийг жигшин зэвүүцсэн өөрийнхөө болон түүний үзэл бодлыг битүүхэн талархагч шүтлэгтэн олны санаа бодлыг ч цухас хавчуулсан тайлбар маягаар илэрхийлсэн байдаг.

Байгал ертөнцийг танин мэдэх хүсэл тэмүүлэл, үзэж харснаа тогтоон тунгаах Маркогийн онцгой ажигламтгай авьяас түүнийг бусдаас ялгаруулах давуу тал байжээ. Этгээд сонин ургамал, амьтан, ялангуяа шувуудын талаар түүний өгүүлж дүрсэлсэн яриа нь орчин цагийн ургамал, амьтны хатаамал, цуглуулгатай зүйрлэшгүй тодорхой, хэн ч сонссон танигдахуйц амьд дүрслэл байдаг. Марко маань шаггүй тамирчин байснаар барахгүй, анч шонхор шувуудыг өсгөн үржүүлэх, сургаж бэлтгэх талаар Загалмайтны ертөнц, Исламынхан болон Алс Дорнодын язгууртнуудын аль алианаас нь дутхааргүй сонирхогч-мэргэжилтэн байжээ. Түүний сониуч ажигламтгай чанар нь тухайн нийгмийнхээ болон хүмүүсийн талаар чамламаар бага зүйлийг илэрхийлсэн байдаг. Түүний номонд Загалмайтны ёс заншил, Сулхарнайн тухай домгийг тусган өгүүлсэн нь Рустичеллогийн санаанаас урган гараа болов уу, харин Марког ивээн тэтгэгч Монгол хаад, ноёд болон зуугаад жилийн тэртээх тэдний өвөг дээдсийн талаар нэлээд зүйл өгүүлсэн байдаг. Их хаадын хаанчлалын (152х) дэс дарааг тооцох, тэдний хоорондын харьцааны тухай өгүүлэхдээ ихээхэн алдаа мадагтай гаргасан байдаг (ургийн зургийг хар). Түүгээр үл барам өөрийнхөө цаг үе, үйл явдлын тухай өгүүлсэн зүйлс нь бодит баримт, санааныхаа зоргоор ярьсан зүйлсийн эмх замбараагүй хутгууш байх нь олонтой боловч эдгээрийг өгүүлэхдээ бас чиг бага сага иш баримтад тулгуурласны шинж тэмдэг ажиглагддаг. Түүнээс өмнөх үед болж өнгөрсөн үйл явдлын хэсэгт “Прэстэр Жон”-ы тухайд тэмдэглэсэн нь алдаатай юм. Эх сурвалж нь энэхүү домогт хувилгаан – хаан нь Абиссинийн загалмайт удирдагчдийн нэг байх боломжтой бөгөөд үүнийг хааны үе залгамжлагчид нь бүр XV зуунд гарцаагүй нотолсон байдаг.

Харин Марко Пологийн үед бол Прэстэр Жон нь Алс Дорно зүгт орших улсын хаан гэж үздэг байжээ. Туркестанд 1148 оны эхээр Сарацинуудыг Загалмайтны ертөнцийн үл мэдэгдэх нэгэн нууцлаг Ялагч бут цохисон гэгцгээх боловч чин үнэндээ уг дайнд Загалмайтнууд ялаагүй ажээ. Энэ шуугианы дараа тун удалгүй Герег гаралтай байж болох нэр нь үл мэдэгдэх нэгэн ухаантан Загалмайтны хоёр эзэн хаан болон Пап ламд хандаж, хүч чадал урам зоригоор Барууныг хамгаалан дорно зүгийн сэтгэл татам гайхамшигт ордондоо Прэстэр Жон сууж буй хэмээсэн “Прэстэр Жоно захидал” гэгчийг илгээжээ. Төдөлгүй олны хүртээл болсон уг захидлын ачаар Дорно зүгийг зорих Европын аянчин, бадарчин бүр “бүх дэлхийг өмнөөс яригч агуу эзэнт гүрний хаан”(148х, 169х) Прэстэр Жоног хайсаар л байлаа.

Прэстэр Жоно байгаа газрыг Марко өөрөө олж мэдсэнээр өгүүлсэн байдаг. Прэстэр Жон гэдэг нууцлагдмал нэрээр чухам хэнийг нэрлэж байсныг (as he had been already by Roubrouck) аль хэдийн тааварлаж тайлсан бөгөөд тэр бол Загалмайн Нестор шүтлэгтэй түрэг овгийн Хэрэйд (Kerait) аймгийн удирдагч Тоорил (Togorul) буюу Хятадуудад Ван хан цолоор өргөмжлөгдсөн тэдний эртний танил, Чингис хааныг өсөх идэр насанд нь өргөн тэтгэж холбоотон байсан, эрийн цээнд хүрсэн хойно нь эвлэршгүй дайсан нь болсон хүн байжээ. Түүний түүхийг Рустичеллогийн арга барилаар, дэврүүн хөнгөн илэрхийлэхдээ бусад ном сударт элбэг гардаг Загалмайн шашинтны хунтайж Жорж гэж нэрээр цоллон өргөмжлөөд Хубилай хаанд хамаатуулсан байдаг.

Марко нь Ван ханыг, түүний нэрлэдэгээр Унг (Ung) хааныг овог аймгийнхаа хамт Хятадын Их хэрмийн (Түмэн газрын цагаан хэрэм) ойролцоо амьдардаг гэх мэтээр будилан өгүүлсэн байдаг. Түмэн газрын цагаан хэрмийн тухай Марко бараг дурьдаагүйгээр барахгүй нэг их ач холбогдолтой зүйл гэж бодоогүй шиг байдаг. Араб бичгийн хүмүүс түүнийг “Тог ба Магогийн хана” гэж нэрлээд их Александр энэхүү хана хэрмийн цаана зэрлэг бүдүүлэг овог аймгийнхныг хашиж соёл-иргэншилт ертөнцөөс тусгаарлан хорьсон гэдэг домогтой холбон үздэг. Энэ Хэрмийн тухай үнэндээ Марко дурьдаагүйгээр барахгүй ач холбогдолтой зүйл гэж бодоогүй шиг байдаг. Харин Маркогийн өгүүлснээс үзвэл, энэхүү хана хэрэмийг Кавказад байдаг гэх уламжлалт ойлголттой нэгэн байсан бөгөөд Унг болон Мунгул (буюу Монгол) гэдэг үгс дуудлага ойролцоо төдийгүй утга төс тул Гог ба Магог (136х) гэдэг үгс аяндаа энэ ойлгоцын хүрээнд татагдан орж ирснээс зайлахгүй.

Энэ ном бүхэлдээ эрдэм боловсрол нимгэн Марко тэр үеийн эрдэм номт хүмүүсийн таамаг үзлээс ангид чөлөөтэй байж чадсаны жишээ болдог. Таамаг үзлээс ангид чөлөөтэй байсныг нь Маркогийн газар зүйн мэдлэгийн хүрээ зөвхөн түүний гярхай ажигламтгай чанарт суурилж байсныг нотолсон баримтууд гэрчилж байгаа юм. Дундад зууны Загалмайтанд, Ислам, Хятадын ихэнх газарзүйчдийг төөрөгдүүлж байсан газар дэлхийн хэлбэр, онцлогийн тухай төсөөлөл, Диваажингийн дөрвөн мөрөний тухай эндүүрэл нь Марко Пологийн номын хэсгүүдэд тусгалаа олоогүй байгаа нь гадны нөлөөллөөс ангид байсныг давхар батлан харуулдаг. Номыг зохиогч (Рустичелло. Орч) нь Пологоос илүү мэдлэгтэй байсансан бол Алтан гадас одны байрлалаас хойшоо хэтэрч алс аялсан тухай ам алдсаныг засах байжээ, гэвч магадгүй зохиогч өөрөө ч төөрөлдөж будилаад ноцтой энэ алдаанд хүргэсэн байж бас мэдэх юм. Гэсэн хэдий боловч улс орны байдал, хот балгадын байршил, газар нутгийн онцлогийг тодорхойлох, зам харгуйн чиглэл, хол ойрын зайн баримжааг тодорхойлохдоо тун баримжаатай тэмдэглэсэн байдаг. Марко нь замын урт, цаг хугацааны баримжааг “өдөрчийн газар”<sup>57</sup> гэдэг нэгжээр тодорхойлох дуртай байжээ. Хол ойрын зай, цаг хугацааг нэгэн зэрэг илэрхийлдэг энэ нэгж их уян хатан төдийгүй тэр үеийн аян жингийн уртад хэрэглэдэг гол нэгж байжээ. Тэрбээр, Ява арлын хэмжээг (319х) болон Арабын тэнгисийн эрэг (373-377хх, 386х) орчны байдалын тухай бусдаас сонссоноо бичүүлсэн нь яах аргагүй алдаа болсон байдаг. Түүний нүдээрээ харж, биеэрээ туулсан бүхнийхээ тухай өгүүлсэн зүйлс нь бараг л гажуу зөрөөгүй яв цав тохирдог үнэн байлаа. Маркогийн аяллын чиглэл, бусад чухал өгөгдөхүүнүүдийг ашиглан тэдгээрийг газрын зурагт хөрвүүлэн буулгах гэдэг амаргүй. Гэвч XIV зууны газрын зургийг зурагзүйчид хичээн гүйцэлдүүлж чадсан билээ.

Маркогийн ном Генуя хотын залуу Колумбыг алсын аяны замд дуудан хөглөж байсныг бид мэдэхээр барахгүй, тэрхүү гар бичмэл номын хуудасны захад Колумбын тэмдэглэл үлдсэн нь бий. Харин Атлантын далайг гатлан Хятадад хүрэхээр мөрөөдөж тэмүүлсэн Генуя залуугийн алдааг Венеци эр хариуцахгүй бөгөөд тухайн үеийн газрын бөмбөрцгийн зургийн хэмжээсний зөрүү байсан юм. Газарзүйн ухааныг нэр томъёогоор баяжуулж, өнөөдөр бид нийтлэг ашиглах болсон “Хүний газарзүй”-д (Human geography) Пологийн гайхамшигт давуу чанарууд нь нэгэн гол өргөлт болтлоо нөлөөлсөн билээ.

“Сэр Жон Мандевилл” (Эрхэмсэг Жон Мандэвилийн аяллууд) болон нэртэй аялагчдийн тэмдэглэл хуудсууд шигээр ёгт үлгэрийн нүд хуурсан зургуудыг<sup>58</sup> Марко бидэнд үлдээсэнгүй, тэрбээр баримт, тэгэхдээ бүр онцгой үнэ цэнэт баримтуудыг үлдээжээ. XIII

зуунаас өмнө амьдарч асан Барууны зохиолч Страбогоос хойш, багаар бодоход хоёр зуун жилд улс үндэстнүүдийг ийн бодитоор дэлгэн өгүүлсэн Поло лугаа харьцуулах хүнийг бид олно гэж үү. Персүүд, Туркууд, Тартарууд, Хятадууд, Түвдүүд, Энэтхэгүүд болон олон үндэстнийг бид тэдний төрөх, үхэхээс авахуулаад амьдралаа хэрхэн зохицуулдгийг, тэдний биеийн согог, өмссөн зүүсний хачныг хүртэл зөвхөн хөндлөнгийн аянчны хувиар дэгсдүү харж шоолон байснаас биш тэдний дотоод бодол, мэдрэмж, итгэл үнэмшлийн талаар сонирхдоггүй байлаа. Маркогийн өгүүлсэн гайхам амьд дүр зурагтай(*tableau vivant*) тулгарсан хамгийн өөнтөгч шүүмжлэгч ч аялагчийн өөрийн үзэл болон номын Оршил-д “Хэрэв тэр үзсэн сонссон бүх зүйлсээ үнэнээр бичиж үлдээгүй бол, хэн ч энэ номноос тэдгээрийг олж үзэхгүй, мэдэхгүй, тэр бүхнээс мэдлэг авч чадахгүй маш харуусалтай байх байлаа” хэмээн даруухнаар илэрхийлснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Пологийн номын гар бичмэл нь баруун Европын ихэнх хэлээр, тэр ч атугай Ирландаар хүртэл орчуулагдсан хэдий ч тэдгээрийн алийг нь ч Пологийн тэмдэглэлийн бүрэн эх гэх боломжгүй бөгөөд тэднийг зүйж нийлүүлээд ч Эрхэмсэг Рустичеллогийн гараар бүтээсэн уугуул эхийг эргэн сэргээнэ гэх найдлага бидэнд үлдсэнгүй.

Рамусио өөрийхөө Удиртгалд энэхүү ном нь эхлээд Генуяд латин хэлээр бичигдсэн гээд түүнийгээ баримтаар нотлон өгүүлсэн төдийгүй тэр үеийн Генуя нутгийн дуудлага хэт бүдүүлэг, ямар нэг ном бүтээх боломжгүй байсан гэж нотолдог. Чин үнэндээ Рустичелло франц хэлээр анх бичсэн гэдэг нь эргэлзээгүй, учир нь тэр үеийн зохиолчид бүтээлээ бүгд л францаар туурвидаг байсан бөгөөд тухайн цаг үедээ франц хэл нь өнөөгийн чөлөөтэй хөрвөдөг мөнгө мэт өргөн хэрэглээний хэл байсан төдийгүй харин латин хэлийг сүм хийдэд л хэрэглэдэг байснаас гадна тэр үеийн иргэний нийгмийн давхрагынхан дунд өргөн дэлгэр хэрэглэдэггүй байсан.

Арвандөрөвдүгээр зууны эхээр Рустичеллогийн Италийн франц гэгдэх сонин хэлээр бичиж үлдээсэн Парисийн гар бичмэл (F) – ийн эхийг урьд өмнө түүний бичиж туурвиж байсан ном зохиол, бичиг захидлын хэв маяг, хэллэг агуулгатай харьцуулан үзэхэд үнэнхээр түүний хэллэг, оюунаар бүтсэн зүйл гэдэг нь нотлогдож байгаа учраас энэхүү (F) хувилбарыг “эх” гэж байхаар тохиролцсон билээ. Энэхүү гар бичмэл эх нь нэлээд нуруу сунжруу өгүүлэгдсэн юм шиг мөртлөө бас чиг ихээхэн хэмжээгээр хураангуйлан товчилсоны шинж тэмдэг, ул мөрийг хадгалан үлдсэн нь мэдэгддэг. Энэхүү F – эхээс хасаж танасан, хураангуйлж товчилсон зүйлсийг Латин хураангуй (L) – гаас мөн нэлээд гажгааж мушгин нутгийн Венеци аялагаар (V) бичсэнхувилбараас нөхөн олох бололцоотой.

Рамусиогийн Итали хэлээр хэвлүүлсэн эх нь бусад бүх гар бичмэл эхээс хавьгүй их мэдээ, мэдээллийг агуулсан бүрэн эх гэхэд болох бөгөөд дээрх хувилбаруудын алинд нь ч байхгүй зүйлсийг агуулсан байдаг. Рамусиогийн гар дээр байгаа латин гар бичмэл эх бол “эртний гайхамшигт эд” гэж хэлсэн удаатай. Харин зарим нэгэн судлаач-шүүмжилэгчид энэхүү латин эхийг Рамусио өөрөө зохиож, хийсэн зүйлээ үнэд оруулах халхавч болгосон гэх, зарим нь энэ латин гар бичмэл эх нь Поло өөрийнхөө гараар Рустичеллогийн оролцоогүйгээр хийсэн нэмэлт мэдээ сэлтийн цуглуулга мөн гэх нь бий.

Профессор Бенедетто: дээрх олон хувилбаруудад агуулагдаж буй үйл явдлын хэлхээс нь өөр нэгэн латин хураангуй эх (Z)59 - д бүрэн хэмжээгээр агуулагдаж байдаг бөгөөд энэхүү латин



гар бичмэл Z-хувилбарыг буюу эсвэл түүний хэсгийг Рамусио өөрийхөө ном бүтээлд ашигласан байх магадлалтай, энэ хувилбар нь биеэ даасан бас F-хувилбараас эртнийх төдийгүй Рустичеллогийн ярианы дагнасан орчуулгын бүрэн эх мөн гэжээ. Рамусиогийн бүтээл туурвил нь энэ олон гар бичмэл эхүүдийн доторх буруу зөрүү, андуу ташаа, алдаа мадагтай зүйлсийг нэг мөр болгоход нэмэр тусаар бага боловч цаашдын судалгаа шинжилгээний чиг зүгийг тодорхойлох баримжаа, таамаг дэвшүүлэх боломж олгож байгаа юм<sup>60</sup>. Энэ нь Рамусиогийн бүтээл туурвилд орсон бүхэн “жинхэнэ эх” гэсэн үг хараахан биш төдийгүй зарим нэг зүйлсийг Венецийн хоёрдахь хувилбар (VB) – аас хуулбарласан байх магадлалтай, учир нь урьд урьдын бичлэгээс нэлээд өөр зүйл байдаг, харин нэлээд хэсгийг нь Рамусио өөрөө тайлбарласан байдаг. Энэхүү бүтээлд гарч байгаа Ахмадын түүх болон Кинсайн (өнөөгийн Ханьжоу) тухай өгүүлсэн зүйлс нь дундад зууны үеийн хот балгадын тухай уран гоё дүрслэлтэй өгүүлэгдсэн төдийгүй тэр үеийн Хятадын эх сурвалж энэ тухай мэдээ баримтыг агуулсан байдаг ч Рамусиогийн үзэж танилцсан эх сурвалжууд, үзэж болох эх сурвалжуудын алинд нь ч үүнийг бататгах мэдээ, мэдээлэл байдаггүй. Гэсэн хэдий боловч дээрх бүтээлд орсон зүйлс нь Поло болон Рустичеллогийн өгүүлж<sup>61</sup>, тууривсан үйл явдал мөн гэдэгт эргэлзэх явдал огтхон чиг байхгүй. Рамусио өөрийнхөө бүтээлд Z-хувилбарт байгаа Уйгарстаны талаарх тайлбар, Оросын өвөл болон Фу -Чау дахь нуугдмал-Загалмайтны тухай баримт мэдээг огт оруулаагүй байсан бөгөөд зарим нэгэн жинхэнэ эх мэдээ ор мөргүй устаж үгүй болсон ч байх магадлалтай<sup>62</sup>. Полог шүтэн бишрэгч зарим нэгэн уншигчид ингэж их аялаж, түмэн зүйлийн сонин хачиныг үзэж, сонсож явсанаа дэлгэрэнгүй өгүүлж хүүрнэсэн хүн яагаад Хятадын онцлог болох хятад цай, ном хэвлэх аргын талаар огтхон дурсдаггүй билээ гэж гайхацгаадаг. Маш төвөгтэй асуудлын дотор хавчуулсан энэхүү товч асуулт - дүгнэлт нь Пологийн ярьсан өгүүлсэн зүйлс түүнийг тэмдэглэж баримтжуулсан бичээчийн талаар мянга мянган өөр өөр санаа бодол байгаагийн нэгэн гэрч мөн боловч тэдний өүүлэл туурвилын үнэн эсэхэд эргэлзэх шалтаг шалтгаан болохгүй юм.

Миний энэхүү “танилцуулга”-нд хөндөгдөж буй болон бусад асуудлаар илүү их мэдээ, мэдээлэлтэй болохыг мөрөөдөгч уншигч авгай нарт хандан хэлэхэд: Марко Пологийн аяллын тухай нэн чухал эх сурвалж болох англи хэлээр хэвлэгдсэн номын жагсаалтыг хавсаргаж байгааг минь анхааран толилоно биздээ. Энэ дашрамд намайг хэд хэдэн алдаа мадагт төөрөлдөн будилж явахад тэнхрүүлэн тэтгэж авсан талийгаач Профессор Моулид гүн хүндэтгэлээ илэрхийлэх нь нүдээ олсон, цаг хугацаа орон зайн тохироо гэж бодож байна.

Номын жагсаалт:

1. Frampton, J. The most noble and famous travels of Marcus Palus....into the East partes of the world, 1579.
2. Based on a Spanish translation of a very corrupt Venetian version.
3. Reissued with an introduction and detailed maps by N. M. Penzer (1929 and 1937).
4. Marsden, W. The Travels of Marco Polo ... (1818; revised by T. Wright, 1854). Based on Ramusio, with introduction and notes. Frequently reissued.
5. Yule, Sir H. The book of Ser Marco Polo the Venetian concerning Kingdoms and Marvels of the

East. Revised in the light of discoveries of H. Cordier (1903). Based primarily on a French MS (FB); invaluable for its detailed commentary.

6. Ricci, A. *The Travels of Marco Polo*, translated into English from the text of L. F. Benedetto (1931)

7. Moule, A.C., and Pelliot, P. *Marco Polo; the Description of the World* (1938). “An attempt to weave together all, or nearly all, the extant words which have ever claimed to be Marco Polo, and to indicate the source from which each word comes.”

8. Power, E. *Medieval People* (1924; reprinted in Pelican Books 1937). Chapter II is devoted to Marco Polo.

9. Komroff, M. *Contemporaries of Marco Polo* (1928). Translations of Roubrouck, Carpini, and Odoric.

10. Beazley, C. R. *The Dawn of Modern Geography* (1897 - 1906). Contains detailed criticisms of medieval works on Far Eastern travel.

Энэхүү орчуулгаа уншигч авгай нар уншиж ойлгоход аль болох хялбар тохиромжтой болгох, орчин цагийн мэдлэг, мэдээлэлтэй боломж чадлынхаа хэрээр уялдуулахыг хичээсэн бөгөөд чухам ямархан болсныг уншигч, судлаач та бүхэн шүүн тунгаана биз. Миний орчуулга F, Z хоёр хувилбарыг нэгтгэн судалж туурвисан Профессор Бенедеттогийн ном бүтээлд тулгуурласан<sup>63</sup> бөгөөд зарим нэгэн нэмэлт, тодруулга оруулсан нь бий. Гар бичмэл эх хувилбаруудад өгүүлсэн зүйлс тэр болгон хоорондоо таарч авцалдахгүй байгаа болон Пологийн өгүүлсэн бүхнийг ягштал буулгасан гэхэд бүрэн итгэх боломжгүйгээс үүдэн гар бичмэлд байгаа бүхнийг үг, үсэг алгасалгүй орчуулах зарчмыг баримтлаагүй болохыг уншигч авгай нартаа сонордуулья. Орчуулагч орчуулга хийхдээ гар бичмэл эхийн хэллэг, бичлэгийг аль болохоор орчин цагийн хэллэг, бичлэгт ойртуулахыг зорихдоо газар зүйн байршлийн ашигтай болон ашиггүйн тухай хэмжил зүйн үүднээс Пологийн хийсэн ажил хэрэгч тайлбар, Рустичеллогийн зөгнөл мөрөөдлийн бичлэгийн онцлог өнгө төрхийг хадгалан, гар бичмэлийн эртний хэлбэр маягийг хадгалахыг хичээсэн. F – хувилбарыг бичихдээ урт урт өгүүлбэртэй, богинохон богинохон 232 бүлэгт хуваасан (Бенедеттогийн орчуулга нь 234 бүлэгтэй) эх гар бичмэлийн жинхэнэ хуулга гэж итгэхэд нэг л эргэлзээ төрүүлээд байсан. Энэ орчуулгыг бүтээхдээ эвтэй, авсаархныг нь бодоод оршил үгийн хэсгээс гадна есөн бүлэгтэйгээр бүтээв. Нэмэлт тайлбар – зүүлтийг аль болохоор цөөлөх үүднээс хүмүүсийн харьцуулалт, газар орны болон орон нутгийн бүтээгдэхүүний тухай тайлбарыг тухайн сэдэв дотор нь юм уу номын товъёогт багтаахыг зорив. Хүмүүсийн болон газар ус, хот балгадын нэрийг бичихдээ эртний гар бичмэл ном судар бүтээдэг жаяг уламжлал, дорно дахины ном бүтээх уламжлалд яаж бичдэгийн аль алиныг дагаж мөрдөхийг хичээв. Жишээлбэл эртний гар бичмэл ном сударт дөрөвдэх их хааны нэрийг голдуу *Monqu* гэж бичиж тэмдэглэж ирснийг бид *Mongka* буюу *Manqu* гэж бичсэн маань дээрх нэрийг Монгол, Түрэг хэлээр дууддаг зөв дуудлаганд нь тулгуурласан<sup>64</sup> юм. Мөнх хааны өмнөх их хаан Гүюгийн нэрийг *Cui*, *Guu* гэх зэргээр гаж буруу дуудаж, бичиж байсныг монгол дуудлагад нь ойртуулан Гүюг (*Kuyuk*) гэж бичсэн маань зөв байлаа. Энэ жишгээр *Tinocain* (*Tonocain*, *Timochan*, etc.) гэж бичиж байсныг би Тун ба Кайн гэж бичсэн бөгөөд орчин үеийн газрын зурагнаас олоход

хялбар болсон төдийгүй Firdaus ба Qa'in гэж бичих шаардлагагүй болж байгаа юм. Гэхдээ би Константинополийг хэзээч Истанбул гэж бичиж байгаагүй билээ. Ийм тохиолдолд би уг нэрийг товъёог дотор дугуй хаалтанд оруулан бичиж тайлбарладаг билээ. Адилтган жиших боломжгүй нэр усыг бичихдээ гар бичмэл эхэд байгаа бичлэгийг аваад шаардлагатай гэж үзвэл англиар тайлбарладаг (жишээ нь: Changan гэхийг Ciangan, Vuju буюу Vujiu гэх мэтээр Vujui).

Уншигч Таныг төөрөгдүүлж будилуулж магадгүй, ойлгоход эгзэгтэй байж болох газар бүхэнд нь би тодруулга, тайлбар хавчуулж өгсөн боловч Элчилгүй их цөлийн дундуур бэдэрч яваа ямар ч хашир болгоомжтой аянчин-бадарчид төөрөх будилах нь байдаг шиг Та ч хүн төрөлхтний дотроос энэхүү урт удаан аяны замыг анх түрүүн туулж бидний түүхэнд үлдээсэн Пологийн мөрийг даган аялаж байгаа учраас уншигч та ч төөрч будилвал гайхах зүйлгүй шүү.

## Оршил үг

Эзэн хаад, ноёд, олон ван, гүн, бэйл, бэйс, морьтон дайчид, суурин болон нүүдэлчин иргэд, бусад хүмүүс энэ дэлхийн улс орон, газар нутаг, араатан жигүүртэн, хүн ардын амьдрал ахуйг мэдэхийг хүссэн хэн боловч энэ номыг уншигтун, эрж хайсан, сонирхож мөрөөдсөн бүхнээ эндээс олно. Та бүхэн энэ номноос Их Армени, Перс, Тартар 65, Энэтхэг болон бусад олон олон улс орон, газар нутгийн сонин содон, ид шид, гайхан бишрэм элдэв зүйлийг олж үзнэ. Энэ ном та бүхнийг Венеци хотын иргэн эрхэм журамт, цэцэн билэгт Марко Поло гуайтай учраан золгуулж, тэр эрхэмсэг хүний нүдээрээ харж, гараараа барьж, биеэрээ туулсан сонин содон бүхэнтэй ахин нэг учрах аз завшаан олгох буй за. Энэхүү номонд өгүүлэн буй бүхнийг эрхэмсэг Марко Поло гуай өөрийн нүдээр үзэж, чихээр сонссон гэдэг нь маргашгүй үнэн гэдгийг дахин батлан өгүүлсү. Эрхэмсэг Марко Поло гуайн нүдээрээ харж тогтоосон бүхнийг харсан янзаар нь, чихээрээ сонсож шингээсэн бүхнийг сонссон хэвээр нь алдаа мадаггүй, андуу ташаагүй энэхүү номондоо буулган бичсэн бөгөөд бусдын санаанаас ургасан зохиомол зүйл нэгийг ч хавчуулаагүй билээ. Номыг уншигч, сонсогч хэн боловч энэ ном үнэнхүү юм юмыг нүдээрээ харж, чихээрээ сонссон хүний чин сэтгэлийн үнэн өчил гэдэгт эргэлзэх явдалгүй бөгөөд үнэнхээр л үнэнийг агуулсан ном.

Хүн төрөлхтний элэнц дээдэс Адамийг бурхан өөрийн мутараар бүтээж, энэ дэлхий рүү илгээсэн тэр цагаас хойш Загалмайтан болон Тэрсүүд шүтлэгтэн, Тартар болон Энэтхэг өөр бусад олон үндэстэн ястны дундаас, уужим их эх дэлхийгээрээ хөндлөн гулд аялан, уул ус, ургамал амьтан, хүн ардын нь амьдрал ахуй дундуур өөрийн биеэр туучиж “газар үзэж, нүд тайлсан” хүн өнөө болтол эрхэмсэг Марко Поло гуайгаас өөр байсангүй. Хорвоо ертөнцийг хөндлөн гулд туулан аялаж, үзсэн, сонссон бүхнээ цээжиндээ хадгалж, ухаандаа тунгаан явсан Марко Поло гуайн мэдлэг, оюуны их санг ном болгохгүй бол үнэнхүү харамсалтай, гарзтай зүйл байх байлаа, түүний нүдээрээ үзэж харсан, чихээрээ сонсож дуулсан, биеэрээ амсаж туулсан бүхнийг уншигч авгай та бүхэн энэхүү номноос олж үзэх боломжтой.

Харь холын улс орон, таньж мэдэхгүй газар нутгаар бүтэн хорин зургаан жилийн туршид аялаж, амьдрахдаа Марко Поло гуай асар их мэдээ, мэдлэг хуримтлуулсан оюун билгийн шавхагдашгүй ундрага болжээ. Тэрээр Ийсус Христийн мэндэлсний 1298 онд Генуя хотын шоронд хоригдож байхдаа хамт хоригдож байсан Пиза хотын иргэн Рустичелло гэгчид өөрийн намтар түүх, адал явдлаас хэлж бичүүлснээр энэхүү гайхамшигт ном бүтсэн болой66.

Христийн мэндэлсний 126067 онд буюу Константинополийн эзэн хааны сэнтийд Болдуйн заларч, хотыг Венецийн Дожийн нэрийн өмнөөс эрхэмсэг Понте захирч байх үед ах дүү Никколо Поло болон Маффео Поло нар өөрсдийн бараа таваарыг ачаалан Венециэс Константинопольд нүүж иржээ. Энэ ах дүү хоёр удам сайнтай гэр бүлээс гаралтай, цөлх бодолтой, сийрэг гүйлгээ ухаантай, шулуун шударга эрс байлаа. Нөхцөл байдлыг эргэцүүлэн дүгнэж цэгнэсний эцэст Хар далайг гатлан худалдаа наймаа хийх нь илүү их ашиг орлого олно гэсэн таамаг шийдвэрт хүрч явахаар зэхэцгээв. Тэгээд тэр хоёр их хэмжээний үнэт эдлэл, эрдэнэс болон үзэмж төгс гоё ганган, өндөр үнэтэй бараа таваар Константинополиос худалдан авч далайн хөлөгт ачаалан Судак хотыг зорилоо.

Тэр хоёр тэнд тун их удалгүй цаашаа аялахаар шийдэн хөдөлцгөөв. Одоо энэ тухай би та нарт

өгүүлсү. Судак хотыг орхин алс замд гараад элдэв учрал, саад тотгоргүй аялсаар Тартарын ихэнх хэсгийг захиран Булгар, Сарай хотуудад суурьшин суусан Бэрх (Barka) хааны ордонд хүрэлцэн ирлээ. Эрхэмсэг Никколо, Маффео нарыг Бэрх хаан гүн хүндэтгэлтэй, ёслол төгөлдөр хүлээн авч алс холоос түүнийг зорин ирсэн тэдэнд баярлаж талархаснаа илэрхийлж байлаа. Ах дүү хоёр өөрсдийн тээж яваа эрдэнэс, үнэт эдлэл, бараа таваараа Бэрх хаанд бэлэг болгон өргөсөн бөгөөд хаан үүний хариуд бүх барааны нь үнийг хоёр дахин нугалж төлбөр хийсэн байна. Эдгээр эрдэнэс, үнэт эдлэл, бараа таваарыг ах дүү хоёр газар сайгүй явж борлуулаад хааны өгсөн үнэ шиг ашиг хонжоотой зарж борлуулах нь эргэлзээтэй байсан.

Ах дүү хоёр Бэрх хааны эзэмшил нутагт жил орчим тухлан сууж байтал Левант (Ил хаадын улс)-ийн тартаруудын хаан Хүлэг (Hulagu) болон Бэрх хааны хооронд хөнөөлт дайн дэгдэв. Хоёр хаан өөрсдийнхөө бүхий л хүчийг хуримтлуулан нэгтгэж, аль аль талдаа асар их гарз хохирол авчирсан үхлийн тулалдааныг хийж байсаар эцсийн эцэст Хүлэг хаан ялан дийлсэн юм гэж ярьцгаадаг. Дайны гал дүрэлзэн нөмөрч, тулалдааны талбар үхэдлээр дүүрсэн энэ газар нутгаар аюул осолгүй аялна гэдэг тухай санахын ч хэрэггүй байлаа. Харин ах дүү хоёрыг найрсгаар хүлээн авсан Бэрх хааныхан тэр хоёрыг дуртай газар руу нь чөлөөтэй явуулахаар байсан. Ах дүү хоёр өөрсдийн ачаа хөсөг, бараа таваартайгаа буцаж Константинополь орох тухай мөрөөдөөд ч бүтэхгүй болсон тул дорно зүг рүү аялсаар тойруу замаар эргэн харих тухай бодож, төлөвлөж эхэлжээ. Ингээд тэр хоёр Бэрх хааны нийслэлээс дорно зүг рүү хөдөлж явсаар Баруун тартарын хаант улсын хилийн дээсэн дээр орших Укака хотод хүрэлцэн иржээ. Ах дүү хоёр уг хотоос гарангуут Тигрис 68 мөрнийг гатлан элчилгүй цөлийг туулан арван долоон хоног аялсан боловч замдаа нэгээхэн ч хот, тосгодтой таарсангүй, харин малчин тартаруудын гэр, майхантай таарч байлаа.

Тэр хоёр их цөлийг туулан Бухара нэртэй баян чинээлэг, нэгэн том хотод хүрэлцэн ирлээ. Энэ мужийг мөн Бухара муж гэж нэрлэх бөгөөд мужийн захирагч нь Барах (Barak) нэртэй ноён байв. Бухара бол Персийн хамгийн сайхан хот байлаа. Ах дүү хоёр энэ нутагт ирээд саатаж дорно зүг рүү ч аяллаа үргэлжлүүлэх боломжгүй буцаад Константинополь руу ч явж чадахгүй бүтэн гурван жилийн нүүр үзлээ.

Тэр хоёрыг ингэж саатаж мунгинаж байх хооронд бүх тартаруудын Их хаан Хубилайд бараалхуулахаар Левантийн эзэн Хүлэгийн илгээсэн элч нар Бухарад хүрэлцэн ирлээ. Хубилай хаан нь эндээс зүүн-зүүн хойд зүгт дэлхийн бөмбөрцөг тэнгэрийн хаяатай нийлэх тэр алсад суудаг гэнэ. Урьд өмнө нь хэзээч латин хүний хөл гишгэж байгаагүй энэ газар нутагт эрхэмсэг Никколо, Маффео хоёртой уулзсан Хүлэг хааны элч гайхаж алмайрсан нь хязгааргүй. Тэр хоёртой танилцах зуураа тэднийг жирийн худалдаачид гэдгийг ойлгож мэдсэн элч Никколо, Маффео хоёрт хандан “Ноёд оо, хэрэв та хоёр надад итгэж байвал би та хоёрыг уул овоо шиг олз олох, ихэс дээдэс шиг хүндлүүлж зочилуулах газар хүргэж чадна гэж амлая”. Ах дүү хоёр элчид бүрэн итгэж байгаа төдийгүй бүхнээ даатгаж байгаагаа хэлэв. Элч өгүүлрүүн: “Ноёд оо, тартарын Их хаан үүнээс өмнө нэг ч латин хүнтэй уулзаж учирч байгаагүй гэдэгт би бүрэн итгэлтэй байгаа бөгөөд та хоёртой уулзахыг чин сэтгэлээсээ хүсэмжилж буй. Иймээс та хоёр намайг даган Их хаанд бараалахвал Их хаан машид баярлан та хоёрыг гүн хүндэтгэлтэйгээр хүлээн авч зочлон хүндэтгэнэ. Мөн та хоёр бидэнтэй хамт явбал зам гудас айх аюулгүй, дайрах дайрлагагүй айван тайван аялах болно.

Элчийн хэлсэн үгийг сонсонгуут ах дүү хоёр ам уралдан баярлаж талархаж буйгаа илэрхийлэн элчийн жинг даган аялах болсон заяа тавиландаа итгэж ядна. Тэр хоёр элчийн жинг даган умар-зүүн умар зүгийг чиглэн жил орчим аяласны эцэст зорьсон газартаа сая нэг юм хүрэлцэн ирлээ. Тэд нар урт аяны хол замыг туулан явахдаа хүний санаанд оромгүй олон олон сонин содон, гайхамшигтай зүйлстэй учран тааралдаж байсныг би та нарт тоочин өгүүлэхгүй, харин энэ тухай энэ бүхнийг нүдээрээ үзэж, биеэрээ туулсан Никколо Пологийн хүү эрхэмсэг Марко Поло гуайн яриагаар номондоо тэмдэглэн үлдээсү.

Эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео нар Их хааны нийслэл хотод хүрэлцэн ирэхэд Их хаан тэр хоёрыг машид хүндэтгэн хүлээн авч, мэндчилэн уулзаж, зочлон дайлсан бөгөөд ер тэр хоёрын хүрэлцэн ирсэнд ихэд таашаалтай байлаа. Их хаан тэднээс маш олон зүйлийг асууж, сонирхож байснаас зарим нэгийг тоймлон өчвөл: тэдний эзэд хаадын тухай, засаг засаглалын тухай, харьяат хараат орон газрын тухай, хууль цааз шүүх нь хэрхэн яаж ажилладаг тухай болон ноёд, хунтайж нар болон язгууртнуудын тухай онцгойлон ихэд сонирхож байв. Тэднээс бас ромын бурхан хэмээгдэх Пап ламын тухай, тэдний сүм хийдийн дэг жаягийн талаар болон Латин зан заншил үйл ажиллагаа, онцлогийн талаар асууж сонирхож байв. Эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео хоёр Их хааны асууж сонирхосон бүхнийг сайхан тартар хэлээр хэнд ч ойлгогдохоор үнэн зөв, тодорхой, ухаалаг тайлбарлан хариулж байлаа.

Хорвоогийн талыг эзэгнэн захирсан, дэлхийн бүх тартаруудын эзэн Их хаан Хубилай Латиний ертөнцийн тухай ах, дүү хоёрын үнэн бөгөөд бүрэн дүүрэн өчиг хариултыг сонсон тунгааж, тэр талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээ мэдээлэлтэй болсондоо тун сэтгэл хангалуун байлаа. Эцэст нь Их хаан өөрийн төлөөний хүнийг Ромын Пап лам руу илгээхээр шийдэж, Пап руу илгээх монгол ноёнд бараа болж дагалдан явна уу гэж ах дүү хоёроос хүсэмжлэв. Ах дүү хоёр ч Их хааны зарлиг шийдвэрийг өөрсдийн эздийн зарлиг шийдвэр шиг хүлээн авч хэлбэрэлт гуйвалтгүй даган биелүүлэнэ гэж амлав. Ингээд Их хаан ах дүү хоёрыг байлцуулан өөрийн Когатал хэмээх ноёныг дуудан ирүүлэхэд: “Би таны боол билээ-Таны тушаал зарлигийг тэнгэрийн зарлиг хэмээн биелүүлэхэд бэлэн” гэв. Их хааны зарлигийн дагуу Ромын Пап ламд хүргэх захидлыг түрэг хэлээр үйлдэн Когатал ноён болон ах дүү нарт гардуулаад Их хааны нэрийн өмнөөс Ромын Пап ламд хэлэх үгсийн талаар заавар, даалгавар өгөв. Захидалд бичсэн зүйлийн агуулга, амаар хэлэх үгсийн санааг сийрүүлбэл: Загалмайн шашны зан үйлд нэвтэрхий суралцсан, эрдмийн долоон ухааныг төгс эзэмшсэн, шашин номын гүн ухаанаар хэнтэй ч ном хаялцах чадал чадвартай бөгөөд загалмайн шашин нь онгон шүтлэгтэй зүйрлэшгүй төгс төгөлдөр боловсорсон шашин гэдгийг онгон шүтлэгтэнд итгүүлж чадахуйц зуун эрдэмт санваартныг илгээнэ үү гээд, тэдгээр лам нар гэр гэртээ онгод тахин тайж шүтэх нь чөтгөр шулмын үйл гэдгийг онгон шүтлэгтэн болон бусад буруу номтонд гүн гүнзгий ухуулан ойлгуулж, тэднийг загалмайн шашинд оруулах чадвартай байхыг дурьдажээ. Үүнээс гадна Их хаан ах дүү хоёрт Иерусалим дахь Бурханы бунхан дээрх дэн (мөнх зул)-гийн тосноос авч ирэхийг даалгажээ. Ийнхүү энэ удаагийн аяны болон элчин зараалын зорилго агуулгыг тодорхойлсон байдаг.

Их хаан өөрийн төлөөний ноён болон ах дүү хоёрт “Их хааны зараалаар яваа энэ гурван хүнийг очсон газар болгонд нь орох орон, идэх хоол, унах унаа, газарчлах улаачаар саадгүй, түргэн хангаж байгтун” гэсэн бичигтэй алтан гэрэгэ гардуулав. Эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео болон хааны элчин ноёныг хэрэгцээтэй, шаардлагатай бүхий л зүйлээр бүрэн

хангамагц тэд нар Агуу их бөгөөд дэлхийн талыг захирсан Их хаантай салах ёсыг гүйцэтгэн хөлгийн дөрөөнд хөл жийн алсын замдаа гарав.

Нэлээд замыг туулан хэсэг хугацаа өнгөрсний дараа хааны элч тартар ноён гэнэт өвдөж цаашид аялах чадалгүй болж замын нэгэн хотод үлдлээ. Өвчилж хоцорсон тартар ноёноо үлдээсэн ах дүү хоёр аянаа үргэлжлүүлэн цааш хөдлөв. Тэр хоёрын зам гудаст таарсан хүн ард, хот балгад хэн алин боловч тэр хоёрын хүсэж шаардсан болгоноор үтэр түргэн хангаж дутаж гуцах зүйлгүй, тээглэх саад тотгоргүй өдөр хоногийг элээсээр нэгэн өдөр Аяас хотноо хүрэлцэн ирлээ. Гэвч ах дүү хоёр энэхүү урт холын аяны замаа бүтэн гурван жил явж туулсан бөгөөд тэдний замыг үерлэж шуугисан гол мөрөн, гатлах аргагүй цасан тал хааж, цаг агаарын таагүй нөхцөл л саатуулж байлаа.

Тэр хоёр Аяас хотоос гаран аялсаар Христийн дахин амилсны 1269 оны дөрөвдүгээр сард Акра хотод хүрэлцэн ирцгээв. Тэнд ирээд тэр хоёр Ромын Пап лам Клемент хэдийн жанч халсан тухай дуулж мэдэцгээв. Тэр хоёр эртний зүс таних санваартан Пьяченцийн Тедалдо гэгч Мисирийн хаант улсад Ромын Пап ламын бүрэн эрхэт төлөөлөгчөөр суугаа шашин, төрийн ихээхэн эрх мэдэл, нэр нөлөөтэй католик ламтантай уулзан тартарын Их хааны элчин төлөөлөгчөөр зарагдан Ромын Пап ламд илгээсэн захидал, аман захиасыг хүргэж ирснээ танилцуулав. Ах дүү хоёрын ярьж хэлсэн бүхнийг гайхан сонссон Тедалдо ламтан тэр ах дүү хоёр Загалмайтны ертөнцийн нэр хүнд, өнөө ирээдүйд ихээхэн нөлөөлөх захидал, илгээлтийг авч ирснийг төвөггүй ойлгон хүлээж авчээ. Ах дүү хоёрын яриа, танилцуулгыг сонсож тунгаасны эцэст Тедалдо ламтан ийн өгүүлрүүн: Ромын Пап лам тэнгэрт хальсныг та хоёр бэлхэнээ мэдэж байгаа учраас дараагийн Пап лам сонгогдон тодортол тэвчин хүлээхээс өөр аргагүй бөгөөд энэ бол хамгийн ухаалаг алхам болно. Пап лам сонгогдмогц та хоёр Их хааныхаа захидал, илгээмжийг түүнд гардуулж Их хааныхаа зарлиг даалгаврыг биелүүлэхээс өөр зам одоохондоо алга байна гэв. Тедалдо ламтан чин үнэнийг өгүүлж буйг төгс ойлгосон ах дүү хоёр Ромын шинэ Пап ламыг сонготол Венеци хотруугаа явж ар гэр, амраг садантайгаа уулзахаар шийджээ. Тэгээд ах дүү хоёр Акра хотыг орхиж Хар далай хүрээд тэндээс усан онгоц хөлслөн Венеци хотынхоо зүгт хөвж одов. Эрхэмсэг Никколо Венеци хотод ирмэгцээ гэргий нь аль хэдийн ертөнцийн мөнх бусыг үзүүлээд арван таван настай хүү Марко нь өнчирч хоцорсонтой нүүр тулан учирлаа. Тэр Марко гэгч хүү бол энэхүү номыг хэлж бичүүлсэн Марко юм шүү дээ. Ингээд Никколо, Маффео хоёр Ромын шинэ Пап лам сонгогдож тодрохыг хүлээн бараг хоёр жил шахам Венеци хотдоо сууцгаалаа.

Гэвч Ромын шинэ Пап лам тодрох ямар ч шинж төлөв үгүй байсаар л байв, цаашид ингэж удаан хүлээх нь ах дүү хоёрын тэсвэр тэвчээрийг шавхсан хүлээлт төдийгүй үүнээс илүү удвал Их хаантай эргэж уулзах нүүргүй ч болж мэдэх байв. Ингээд ах дүү хоёр Никколо Пологийн хүү Марког дагуулан Венециэс гарч шууд л Акра хот руу хүрч очоод эртний танил Тедалдо ламтантайгаа уулзав. Тэд нар байдал нөхцөлийг тунгаан удтал шүүн хэлэлцсэний эцэст Никколо, Маффео, Марко гурав Иерусалим орж Их хааны захиа даалгаврын дагуу Христ бурханы оршуулгын бунхан дээрх мөнх зулын тосноос залж ирэхээр болцгоов<sup>69</sup>. Ингээд тэр гурав Акраас Иерусалим орж зулын тос залж ирлээ. Тэр гурав Иерусалимаас ирэнгүүтээ бүрэн эрхэт төлөөлөгч ламтантайгаа уулзаж ийнхүү айлтгав: “Эрхэм дээдэс минь Ромын Пап лам мөд тодрохгүй нь бололтой тийм учраас бид Их хааныхаа зүг хөдлөхгүй бол болохгүй нь бид дэндүү их удлаа” гэцгээв. Тэдний энэ хүсэлт тайлбарыг сонсож тунгаасны

эцэст Тедалдо ламтан “За тэгвэл та нарын хүслээр болтугай, буцах аяндаа бэлтгэгтүн” гэж айлдав. Ингээд ламтан Их хаанд өргөх захидал бэлтгэж “эрхэмсэг Никколо, Маффео хоёр Таны зарлиг даалгаврыг биелүүлэх чин хүсэл зорилготой ирсэн боловч Ромын Пап лам тэнгэрт хальж, шинэ Пап ламыг сонгон өргөмжлөх үйл сунжирсаар байгаа тул Их хаан таны захидлыг гардуулж, захиасыг айлтгах эзэн үгүй тул ах дүү хоёр Пап ламыг тодруулан сонгохыг хоёр жил гаруй саатан хүлээгээд буцлаа гэж” өгүүлжээ.

Ромын сүм хийдийн бүрэн эрхэт төлөөлөгч-ламтнаас Их хаанд өргөх захидлыг хүлээн авмагц ах дүү хоёр Акра хотыг орхин Их хааныхаа зүгт аяны жолоогоо залав. Ах дүү хоёр дөнгөж Аяас хотод ирэнгүүтээ Ромын шинэ Пап ламаар тэдний сайн танил Тедалдо ламтан сонгогдож Пьянченцийн Грегорий нэрээр Пап ламын сэнтийд заларсан тухай мэдээг сонсов. Тэр хоёр шинэхэн мэдээг сонсож гайхалдан байтал шинээр сонгогдсон Ромын Пап ламын элч-зараал тэр хоёрыг Аяас хотод гүйцэн ирж Никколо Маффео хоёр тэндээс цааш хөдлөөгүй<sup>70</sup> байвал яаралтай эргэн ирэхийг тушаасан Пап ламын зарлигийг айлтгав. Зарлигийг сонсож хүлээн авсан ах дүү хоёр хагартлаа баярлан яаралтай буцахаар болов. Тэр хоёрыг буцахад Армений хаан жижиг хөлөг онгоц бэлтгэн өгч гүн хүндэтгэлтэйгээр үдэж гаргасныг ярианы далимд дурьдах нь зүйтэй юм.

Тэд нар Акра хотод ирэнгүүт шууд л шинээр өргөмжлөгдсөн Ромын Пап ламд бараалхаж гүн хүндэтгэл, баярлаж талархаснаа илэрхийлэн мөргөцгөөв. Пап лам тэр хоёрыг найрсаг элэгсэгээр хүлээн авч адислаад сайн сайхан яриа дурсамжаар саатуулав. Мөн тэр хоёрт хамгийн их нэр хүндтэй, эрдэм номтой доминикан шүтлэгтэн хоёр гэлэнг тусгайлан гарган өгөв. Түүний нэгийг Виченцийн Николас, нөгөөг Триполийн Уильям хэмээх ажгуу. Пап лам эдгээр хоёр гэлэнд очсон газраа шашны хэргийг бие даан гардан явуулж бүхий л асуудлыг шийдэж байх бүрэн эрхийг олгосон зарлиг буулгав. Тэгээд тэдэнд Их хаанд өргөн айлтгах захидлыг гардуулав, захидалдаа Левантийн тартаруудын эзэн, их Хааны дүү Абага (Abaka) хаанаас загалмайн шашинт иргэд, худалдаачдыг өөрийн эзэмшил болон хараат газар нутагт далайгаар аялан хүрч арилжаа наймаа хийх, аялах жуулчлахыг зөвшөөрнө үү гэж хүссэн байдаг. Мөн түүнчлэн Их хаанд гардуулах их хэмжээний бэлэг сэлт түүний дотор уран нарийн хийцтэй болор сав суулга болон бусад үнэт эдлэлийг хамтатган тэдэнд гардуулаад Их хаанд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж буйгаа аман айлтгалаар дамжуулжээ. Дээр өгүүлэн буй бүхнийг эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео болон хоёр гэлэн хүлээн аваад Никколо Пологийн хүү Марко Полог дагуулан аян замдаа гарчээ. Аянчид маань Аяас хотод дөхөж очих үеэр Мисирийн султан Бундукдари гэгч Армений хаант улсад довлон эзэлж улс орны нь цөлмөн хоослож, хүн ардыг нь хядаж устгаж эхэлсэн төдийгүй энэ дайн самууны хөл үймээнд аянчид маань ч дайрагдан амь насаа ч алдаж мэдэх байлаа. Дайн самууны аймшгийг нүдээрээ үзэж, биеэрээ туулж яваа хоёр гэлэн цаашид аянаа үргэлжлүүлэхээс ихээхэн эмээж байцгаалаа. Эцсийн эцэст хоёр гэлэн маань цааш явахаас бүрэн мөсөн татгалзаад буцахаар шийджээ.

Ингээд Никколо, Маффео болон Никкологийн хүү Марко гурав аянаа үргэлжлүүлэн өвлийн хүйтэнд хайрагдаж, зуны халуунд төөнөгдөж зүтгэсээр тэр үед Их хаан залран сууж буй Кеменфу хэмээх баян тансаг, том хотод хүрэлцэн иржээ. Тэдний зам гудсаа үзэж харсан, уулзаж учирсан бүхнийг энэ удаа энд дурьдалгүй өнгөрч номынхоо дараа дараагийн бүлэгт гээж орхигдуулалгүй тоочин дурьдахаа амлая. Энэ хэсэгт тэр гурвын аян замд тохиолдож



байсан хүндрэл, саад тотгор болон туулах аргагүй цасан хунгараар битүү хучигдсан өвлийн тал, зогсоо жолоогүй асгарах бороо хур, гатлах аргагүй улаанаараа эргэлдсэн үертэй гол мөрөн<sup>71</sup> ээлж дараалан таарсаар тэд нар урт аяныхаа хол замыг гурван жил хагасын турш явж туулсан тухай өгүүлсү. Та бүхэнд нэгэн сонин баримтыг иш татан өгүүлбэл, эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео нарын ирж явааг урьдчилан сонссон Их хаан тэднийг дөчин өдөрчийн газар угтан уулзаж, бараа болон дагалдаж ирэх улаачдыг илгээсэн бөгөөд улаачид ч тэднийг угтан уулзаж зам зуураа элдэв учрал, саад тотгоргүйгээр эсэн мэнд дагуулан иржээ.

Эрхэмсэг Никколо эрхэмсэг Маффео болон идэр хүү Марко гурав энэ том хотод ирэнгүүтээ шууд л Их Хааны өргөө рүү явцгаав тэр гурвыг очиход тэнд Их хаан мөн хааны олон ноёд, ихэс дээдэс цугларсан байсан бөгөөд цаашид юу болсон тухай одоо би ярих уу? Тэр гурав Их хааны өмнө гүн хүндэтгэлтэйгээр өвдөг нугалан сөхөрч амар мэндийг нь асуув. Их хаан тэднийг сэтгэл хангалуун угтан авч өөдөө босож ноёдын дунд суудал эзлэхийг урив. Их хаан тэр гурваас олон олон зүйлийг сонирхон асуух ялдамд өнгөрсөн хэдэн жилийн турш хаагуур явж, юу хийж, хэрхэн амьдарч байсныг нь асууж сонирхов. Ах дүү хоёр бид сайн явж төрөлх хотдоо очиход гэр орон, ахан дүүс маань сайн байцгаасан тул бид хоёр зовох зүдэх зүйлгүй элбэг хангалуун амьдарч байлаа гэв. Тэгээд ах дүү хоёр Их хаанд Пап ламын илгээсэн захидлыг өргөн гардуулж, мөнх зулын тосоо өгөхөд Их хаан нэн тааламжтайгаар хүлээн авч тэр хоёрыг сайн явж сайхан үйл бүтээлээ гэж магтан сайшаав. Их хаан Марког харангуутаа энэ хүү юун хүн бэ гэж лавлан асуув. Их эзэнтэн минь энэ миний хүү, таны боол Марко гэж Никколо хариулахад, нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой хүү байна гэж хаан өгүүлэв. Энэ тухай түүхэнд юу гэж тэмдэглэж үлдээсэн бол? Эргэлзэх юмгүй мэдээж ихээхэн баяр хөөртэй үйл явдал болж Их хааны элчин зараал эсэн мэнд эргэж ирснийг их найр цэнгэл хөгжөөн тэмдэглэв. Баярын ширээ идээ ундаагаар бялхаж, зочин бүрийн сэтгэлийг ханатал зугаалуулж байв. Их хааны элчин зараалуудыг энд цугларсан ноёдоос дээгүүр зиндаанд өргөмжлөн хүндэтгэж байлаа. Би энд Никколо Пологийн хүү Маркогийн тухай өгүүлсү.

Тэр хүү тартар хэл, бичгийг гойд сайн сурч эзэмшсэн төдийгүй тартарын ёс заншил дэг журмыг нэвтэрхий мэдэж байлаа. Тэр хүү дөрвөн хэлээр ярьж мөн тэдгээр хэлний бичгийг төгс мэдэж байсныг нотлох баримт үлдсэн байдаг. Марко Поло хүү ухаалаг, алсын хараатай, цэцэн цэлмэг хэллэгтэй, утга төгс яриа хөөрөөтэй байсан тул Их хаан түүнийг ихэд үнэлэн цэгнэж чухал үүрэг даалгавар өгдөг байжээ. Маркогийн хүмүүстэй ярилцан хэл амаа ойлголцох чадвар, холч ухааныг бишрэн үнэлсэн Их хаан түүнийг Кара-жан гэгч мужруу өөрийн бие төлөөлөгчөөр томилон илгээсэн бөгөөд тэнд хүртэл бүтэн зургаан сар аялаж очсон билээ. Марко хааны зарлигаар түүнд оноосон үүргийг нэр төртэй биелүүлээд иржээ. Эзэнт гүрний харьяа болон хараат нутаг орон руу илгээсэн Их хааны элчин, ноёд, түшмэд эргэж ирээд тэдгээр орон, хот, газар нутагт хийсэн ажлаа хэрхэн тайлагнан танилцуулж байгааг Марко Поло нэг биш удаа нүдээрээ харж, чихээрээ сонсож байхад нэг нь ч атугай Их хаанд очсон газар орны онцлог, сонин содон зүйлсийн тухай, тэр нутаг мужийг хэн гэгч эрхэм хэрхэн захирч, удирдаж байгаа байдал, тэр орны ёс заншил, хуулийн онцлог болон журам зарчмын талаар, бизнесийн онцлог зэргийг танилцуулах юмгүй хааны өмнө амаа ангайн, нүдээ бөлтийлгөн улалзатал аашлуулж, тэнэг мунхагаараа хэлүүлээд гарцгаадаг байв. Энэ бүхнийг мэдэх болсон Марко өөрийнхөө анхны томилгооноос эхлээд л тэр нутаг орны онцлог, сонин содон зүйлс, хүн ардын амьдрал ахуйн байдал, ёс заншил, хуулийн дэг журам түүнийг хэрхэн мөрдөн биелүүлж байгаа болон ер зам гудаст таарсан, тохиолдсон хүний

анхаарал татахуйц бүхнийг нэгд нэгэнгүй ажин тогтоож, тунгаан бодож ирээд Их хаанд эмх цэгцтэй, дэс дараатай өргөн танилцуулахаар бэлтгэдэг байв. Марко хааны зарлигаар явсан анхныхаа томилолтоос эргэж ирэнгүүтээ эхлээд явсан зорилго, өгсөн даалгаврын талаар хийсэн ажлынхаа тайланг тавьдаг-журмыг хэвшил дадал болтол эзэмшиж чадсанаа харуулав. Үүнийхээ дараагаар явсан газрынхаа онцлог, сонин содон зүйлс, зам гудаст таарсан бүхнээ Их хаанд тов тодорхой өгүүлэн танилцуулахад Их хаан болон тэнд байсан ихэс дээдэс түүнийг гайхан магтаж: “за энэ залуу ухаалаг сэргэлэн төдийгүй эр зоригтой, юмыг үнэн мөнөөр нь тунгаан харах билгийн нүдтэй, саруул ухаантай, их хол явах хүн ажээ” гэцгээнэ. Энэ мөчөөс эхлэн идэр хүү Марког эрхэмсэг Марко Поло гэж дээдлэн хүндэтгэж дуудацгаах болсон бөгөөд энэ номонд ч мөн ялгаагүй тэгж хүндлэн нэрлэж бичивээ. Ингэж хүндэтгэн хандахын үндэс нь Марко Поло гуай өөрөө үнэнхүү ухаалаг, шулуун шударга, ихээхэн мэдлэг, дадлага хуримтлуулсан хүн мөн билээ.

Энэ явдлыг урт удаан түүхийн эхлэл болгох шаардлага байгаа юм уу? гэж гайхах хэрэггүй, үүнээс хойш эрхэмсэг Марко Поло бүтэн арван долоон жилийн турш Их хааны албанд зүтгэж Их Монгол улсын эзэмшил нутгаар хөндлөн гулд аялан, хааны тусгай зарлиг даалгаврыг биелүүлсээр байсан. Эрхэмсэг Марко Их хааны зарлиг тушаалыг ягштал биелүүлж, түүнийг илгээсэн нутаг орноос улам шинэ шинэ мэдээ, мэдээллийг Их хаанд авчирч өгөх болсон тул хаан түүнийг улам сонирхолтой, улам холын газар орон руу илгээх боллоо. Тэр хааны даалгавар бүхнийг ягштал биелүүлж, сонин сайхан зүйлсийн тухай шинэ шинэ мэдээтэй эргэж ирсээр байлаа. Марко Пологийн хичээл зүтгэлд Их хаан сэтгэл хангалуун байж, түүний ажил бүтээх чадвар, нөр хичээнгүй зүтгэлийг өндөр шан харамжаар урамшуулж, зэрэг зиндаа дэвшүүлэн бусад ноёдоос дээгүүр тавих болсон нь олон ноёдын дургүйцэл, атаархлыг төрүүлж байв. Дэлхийн бөмбөрцгийн энэхэн хэсэгт чухам юу болж байгааг, энд ямаршуухан сонин содон зүйлс байдгийг энэхүү гайхан бишрэм нутаг орноор хөндлөн гулд аялахдаа өөрийн нүдээр харж, чихээр сонсож, биеэр туулсан Марко Поло гуай шиг мэдэх хүн өөр үгүй билээ.

Эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео, эрхэмсэг Марко гурав Их хааны дэргэд ирж, хааны албанд зүтгэсээр бүтэн арвандолоон жилийг хамтдаа туулан улираасан тул төрсөн нутаг орондоо эргэж харих талаар хоорондоо хэлэлцэн тохирч Их хаанд айлтгацгаав. Гэвч хаан тэднийг нутаг буцаах талаар сонсохыг ч эс хүсэх бөгөөд өнгөрч одсон олон жилийг тэдэнтэй хамт үдэж, тэр гуравт машид ээнэгшин дассан төдийгүй тэр гурвыг машид хайрлан хүндэтгэх тул тэдэнтэй цаашид ч хамт байхыг хүснэ.

Яг энэ үеэр Булган (Bulagan) хатан тэнгэрт хальсан мэдээ ирлээ. Булган хатан бол Левантийн эзэн Аргуны авааль гэргий бөгөөд хатны гэрээс ёсоор түүнийг тэнгэрт хальсны хойно Аргун хан зөвхөн Булган хатны овог аймгаас шинээр хатан буулгах учиртай байжээ. Ингээд Аргун хан өөрийн албат иргэдийн дундаас Улатай, Абушка, Кожа гурвыг сонгон томилж, олон элч бараа бологсодыг дагалдуулан талийгаач хатны овог аймгаас сонгон хатан буулгахаар Их хаан руу илгээжээ. Тэр гурван ноён Их хаанд бараалхан зорьж ирсэн хэрэг зоригоо айлтгажээ. Их Хаан гурван элчийг найр хурим хөгжөөн угтан авч зочлов. Элчийг угтан зочилж, дайлж цайласны дараа Хөхжин (Kokachin) хэмээх арвандолоон настай, гоо үзэсгэлэн төгс, аялаг ээвэргүү аальтай, Булган хатны овог аймгаас гаралтай охиныг дуудуулав. Их хаан гурван элчид хандан та нарын гуйж ирсэн сүйт бүсгүй энэ байна гэхэд тэр гурав охиныг үзээд

машид бахдан таалж буйгаа хаанд айлтгав.

Ингээд Аргун хааны сүйт бүсгүйг залах цуваа ачаа хөсгөө базааж, хамгаалах, дагалдах хүмүүс жигдэрч алс замд гарахад бэлэн болжээ. Элч нар Их хааны зарлигийн дагуу ачаа хөсгөө хөдөлгөн аян замдаа гарч, ирсэн замаа даган аялсаар бүтэн найман сарын нүүр үзэв. Гэв гэнэт тэдний зам гудаст тартар ноёдын өвөр хоорондын дайн тулаан дэгдэж, жингийн зам бүрэн таслагдаж цаашид аянаа үргэлжлүүлэх аргагүй болжээ. Аргагүйн эрхэнд аяны цуваа Их хааны өргөөний зүг буцахаас өөр зам үлдсэнгүй. Яг энэ үеэр эрхэмсэг Марко Энэтхэг орсон далайн аянаасаа дөнгөж буцаж ирээд аян замынхаа тайланг тавих, зам гудсын сонин хачинг хаанд дуулгахаар зэхэж байв. Аргун хааны элч гурван ноён хааныхаа сүйт бүсгүйг далайгаар<sup>72</sup> авч явахаас өөр зам байхгүй гэдгийг ойлгон, үүний өмнө Никколо, Маффео, Марко гуравтай нүүр үзэн танилцаж байсан тул далайн аяны дадлага туршилгатай энэ гурван латин эрийг бидэнтэй хамт явуулаач гэж Их хаанаас гуйхаар өөр хоорондоо тохиролцоод байв.

Гурван элч Их хаанд бараалхаж сүйт бүсгүйг далайгаар аялаж хүргэхээс өөр зам үлдээгүйг сонордуулах ялдамд далайн аяны дадлага туршилгатай гурван латин эрсийг бидэнтэй хамт явуулна уу гэж хичээнгүйлэн гуйцгаав. Тэр гурван латин эр Их хааны итгэл найдварыг хүлээсэн хайртай албагууд нь байсан ч Аргун хааны сүйт бүсгүй, гурван элчид бараа болон нутагт нь хүргэж өгөхийг дуртай ч дургүй ч зөвшөөрөхөөс өөр аргагүй тул гурван латин эрийг тэдэнд бараа болон явахыг тушаалаа.

Эрхэмсэг Никколо, Маффео болон Марко Поло нарыг далайд гарахын өмнөхөн Их хаан дуудуулж авчраад хоёр янзын алтан гэрэгэ гардуулан Их Монгол улсын газар нутаг, Монголын харьяат болон хараат газар нутгаар дуртай цагтаа чөлөөтэй зорчин очсон газар болгондоо орох орон, унах унаа, идэх хоол, хамгаалах цэрэг, дагалдах улаачийг хэрэгцээнийхээ хэрээр авч байхыг зарлиг болгов. Мөн тэр гуравт Ромын Пап лам, Франц<sup>73</sup> болон Испаний хаад, Загалмайтны ертөнцийн бусад хаадад хүргэх мэдээ, захидлыг гардуулав.

Тус бүр нь дөрвөн шураг, арван хоёр дарвуултай арвандөрвөн хөлөг онгоцноос бүрдсэн далайн флотыг зэхэж бэлэн болгожээ. Энэ тухай бүр нарийн тодорхой зүйлийг ярьж болох боловч хэтэрхий урт сунжруу зүйл болохоос эмээж энэ удаа энд ярихаас түр татгалзъя. Энэхүү далайн флотын дөрөв, таван баг тус бүр 250 – 260 усан цэргээс бүрдэж байлаа. Хөлөг онгоцнууд далайд гарахад бэлэн болмогц Гурван элч – ноён, сүйт бүсгүй, эрхэмсэг Никколо, Маффео, Марко нар Их хаантай салах ёс үйлдэн хөлөг дээр гарахад хөлгийн баг нь нүсэр олон хүнтэй байв: тэдгээр хөлгийг бүтэн хоёр жил далайгаар хөвөхөд хүрэлцэхүйц хүнс, усаар хангахыг Их хаан зарлиг болгосон байв. Үүний дашрамд хэлэхэд, хөлөг онгоцнууд далайд гарангаа дарвуулаа босгон бүтэн гурван сар хөвсний эцэст өмнөд далайн Ява<sup>74</sup> хэмээх аралд хүрч ирлээ. Энэ арал хачин сонин зүйлээр дүүрэн байсан бөгөөд тэр тухай би энэ номондоо өгүүлэх болно. Тэд гайхамшигт арлыг орхин Энэтхэгийн далайг туулан бүтэн арваннайман сар хөвсний эцэст сая нэг юм зорьсон газрынхаа барааг харлаа. Их далайг хөвөн туулах урт аяны замдаа тэдгээр хүмүүс урьд өмнө нь үзэж, дуулаагүй, хүний санаанд оромгүй хачин сонин зүйлстэй олон олон удаа таарсан тухай энэ номондоо мөн өгүүлнэ. Одоо би та нарт далайн урт аяны замд тохиолдсон жинхэнэ үнэнээс өгүүлсү. Анх хөлөг онгоцон дээр гарахад усан цэргүүдээс гадна хүн, адгуус нийлсэн 600 (зургаан зуу) амьд амьтан байсан.

Далайн их аяны урт замд 18-аас бусад нь замдаа үрэгдэж үгүй болов. Аргун хааны гурван элчээс зөвхөн Кожа амьд сэрүүн үлдэв; харин хөлөг дээр явсан 100 (нэг зуу)-н бүсгүйчүүдээс нэг л замдаа өөд болов<sup>75</sup>. Аргун хааны эзэмшил нутагт ирээд хаан тэнгэрт хальсныг үзэж, сонсов, улс орныг түүний дүү Гахайт (Kaikhatu) удирдан захирч байлаа. Далайн аянчид газардангуугаа Аргун хааны зарлиг даалгаврыг бүрэн биелүүлсэн тухайгаа өргөн сонордуулаад сүйт бүсгүйг хэрхэх тухай, цаашид юу хийвэл зохих тухай Гахайт ханаас асууж лавлав. Хан сүйт бүсгүйг Аргун хааны идэр хөвгүүн Газан (Ghazan) хаанд хүргэж өгөх зарлиг буулгав. Тэр үед Газан хаан Персийн хилийн Хатсан модот хэмээх мужид 60000 (жаран мянга) цэрэг дайчид захиран харь орны дайсны халдлага довтолгооноос газар нутгаа сэргийлэн хамгаалаад сууж байжээ. Аянчид Гахайт ханы зарлиг ёсоор сүйт бүсгүйг Газан хаанд хүргэж өгснөөр нэгэн их аян өндөрлөв.

Ханы зарлигийг биелүүлсний дараа Никколо, Маффео, Марко гурав тэдний цаашдын зам дайран өнгөрөх учиртай Гахайт ханы эзэмшил нутагт эргэн ирцгээв. Тэр нутагт гурван латин эр бүтэн есөн сар сууж алжаал ядралаа тайлав. Түүний дараа тэр гурав эх нутгаа зорин алсын аяндаа мордохын өмнө Гахайт хантай салах ёс үйлдэхээр бараалхав. Гахайт хан Их хааны элчин зараалаар аялаж яваа тэр гуравт тус бүр нэг тохой урт, таван хуруу өргөн гурав юм уу дөрвөн марк жинтэй дөрвөн алтан гэрэгэ гардуулав. Хоёр нь шонхорын дүрстэй, нэг нь арслангийн толгойтой, дөрөвдөх нь энгийн байв. Эдгээр гэрэгэ дээр Мөнх тэнгэрийн хүчин дор Их хааны зарлигт мөргөн, түүнийг хэн ч, хаана ч хэлбэрэлтгүй даган биелүүлтүгэй, эс биелүүлвээс тэнгэрийн цаазаар гэсгээж, эд хөрөнгийг нь хураасугай гэсэн агуулгатай бичиг сийлсэн байв. Мөн Их хааны элчин энэ гурван хүнийг Их Монгол гүрний харьяат, хараат орон бүхэнд гүн хүндэтгэлтэй хүлээн авч, орох орон, унах унаа, идэх хоол, дагалдан хамгаалах цэрэг, улаачийг саадгүй гарган үйлчилж байсугай гэжээ. Алтан гэрэгэ дээр бичсэн зарлиг тушаал Их Монгол гүрний харьяат, хараат орны хаана нь ч ялгаагүй ягштал мөрдөгдөн биелж байлаа. Баримт болгон нэгэн зүйлийг энд өгүүлэхэд тэр гурвыг нэг мужаас нөгөө мужид, нэг өртөөнөөс нөгөө өртөөнд осол эндэгдэлгүй хүргэх хамгаалагч, улаачдын тоо зарим үед 200 (хоёр зуу) давж байлаа. Энэ бол яах аргагүй болгоомжлол байсан, учир нь Гахайт хан энэ улс орны хууль ёсны эзэн захирагч биш байсан учир ард олон энгийн хүмүүс түүний зарлиг тушаалыг тэр бүр ширхэгчлэн дагаж мөрдөхгүй байжээ<sup>76</sup>. Эзэн хааны элчин зараалаар яваа гурван латин эрийн тухай зарим нэгэн баримт сэлтийг нэмэн өгүүлсү. Их монгол гүрний эзэмшил газар нутгийн хаана ч очсон тэр гурвыг гүн хүндэтгэлтэй, ялдам элэгсэг угталт хүлээж байдаг байсан бөгөөд Никколо, Маффео, Марко гурав ч энэхүү хүндлэл дээдлэлийн таашаалыг эдлэн жаргаж явцгаадаг байв. Их хаан тэр гурван латин эрд гүн хүндэтгэл, бат итгэлтэй хандаж байдгийн нэгэн баталгаа нь тэр гурвын асрамж халамжид итгэн Хөхчин гүнжийг төдийгүй Манжийн хааны охинд бараа болон Левантийн эзэн Аргун хаанд хүргүүлэхээр зарлиг буулгаж байсан байх юм. Тэр гурав ч Их хааны энэхүү зарлиг тушаалыг нэр төртэй биелүүлснийг та бид бэлхнээ мэдэх билээ. Их хааны зарлигийн дагуу гадаад их далайгаар аялахад цаг агаарын элдэв аюултай үзэгдэл, өвчин зовлон, цаг бусын үхэл хагацал тохиосон хүнд бэрх замыг эсэн мэнд туулан зорьсон газартаа ирсэн тухай би дээр өгүүлсэн билээ. Харин одоо тэр гурван латин эр өндөр дээд язгуурт, үзэсгэлэн төгс хоёр залуу бүсгүйг хэрхэн асран хамгаалж, эрүүл энх саруул сайхнаар нь зорьсон газарт нь хүргэж ирсэн талаар товчхон өгүүлсү. Тэр гурван эр хоёр гоо бүсгүйг өөрийн төрсөн үрс шиг асран хамгаалж, өргөн тэтгэж явсан. Хоёр бүсгүй ч тэр гурвыг төрсөн эцэг, ах шигээ хүндлэн тэдний үг зааврыг ягштал биелүүлэн замын уртыг туулахдаа харилцан бие биедээ ээнэгшин дасаж эгээл

эцэг охид мэт болжээ. Газан хааны гэргий болон эрд гарсан Хөхчин хатан их далайг туулан гаталсан урт аяны бэрх замд гурван латин эрийн төрсөн охин, төрсөн дүү шиг болтлоо дасан ээнэгшсэн бөгөөд одоо бол Хөхчин хатан болон Газан хаан хоёр тэр гурвын төлөө хүссэн бүхнийг нь хийж гүйцээхэд бэлэн байлаа. Гурван латин эр нутаг орноо тэмцэн холын замд гарахад Хөхчин хатан уйлан хайлж, унтарсан нурам шиг гунихран хоцорчээ.

Өндөр дээд язгуурт хоёр бүсгүйд бараа болон асарч Энэтхэгийн их далайг бүтэн гатлан хөвсөөр Левантийн хаант улсад хүрэлцэн ирсэн хүнд бэрх, осол аюултай урт замын аян эсэн мэнд өндөрлөсөн тухай дээр өгүүлсэн билээ.

Одоо энэ аяны тухай яриагаа өндөрлөж бусад сэдвээр үргэлжлүүлэн хэлэлцсүгэй. Гурван латин эр Гахайт хантай салах ёс үйлдэн алсын аяндаа гарч нутгаа зорин тэмцсээр Трапезунд хотноо хүрэлцэн ирлээ. Тэр гурав Трапезундаас Константинопольд хөлөг онгоцоор ирж цаашаа Хар далайгаар дамжин хөвсөөр төрөлх Венеци хотдоо хүрэлцэн иржээ. Энэ бол Христ бурхан эргэн амилсны 1295 он байлаа. Ингээд би та бүхний сонсож тунгаасан оршил үгээ өндөрлөж, жинхэнэ номоо туурвиж эхэлье.

## Нэгдүгээр бүлэг

### Ойрх дорнод



Армений тухай өгүүлэн яриагаа эхэлье. Үнэн хэрэгтээ бол Армени нь Их, Бага гэсэн хоёр хэсгээс бүрэлдэн тогтдог. Бага Армени нь Тартаруудаас хараат засаглалтай<sup>77</sup> боловч тэднийг захирагч хан нь шулуун шударга, ухаалаг бодлоготой, эвсэг харьцаатай нэгэн болой. Эдний нутаг олон олон хот, тосгодтой боловч амьдралын эх сурвалж болсон хүнс тэжээл хүрэлцээтэй орон билээ. Энд гэрийн тэжээвэр мал, шувууд арвин элбэгээс гадна зэрлэг ан араатан маш их учир тэднийг агнах намнах нь биеийн хүчин, ухаан шаардсан нэг төрлийн биеийн тамир мэт хүч, бэлтгэлийг базаах зүйл болдог. Гэвч энэ нутгийн цаг агаар маш тааламжгүй тул хүний биед зохимжгүйгээр барахгүй сөрөг нөлөөтэй. Үүнээс үүдэлтэйгээр эрчүүдийн нь эр зориг мохоо, бие бялдар үлбэгэр дорой, ухаан санаа бүүдгэр булингартай, муу үйлэнд гаршимтгайгаас гадна үргэлж мөнхөд архидан согтуурцгаах тул эр зориг төгс, эрэмгий түрэмгий цэрэг эрсийн тухай домог яриа ч үлдсэнгүй.

Бага Армений тэнгисийн эрэг дагуу, энэ нутгийн худалдаа арилжааны төв болсон Аяс (Ayas) хэмээх хот оршино. Эндхийн зах зээл дээр төрөл бүрийн үнэртэн, амттан, торго дурдан, өндөр үнэтэй гоё чамин эдлэл, тавилга чимэглэлийн зүйлс, бусад бараа таваар ер дутуу юмгүй учир Венеци (Venice)<sup>78</sup>, Генуя (Genoa)-гийн худалдаачид энд байнга ирж худалдаа наймаа хийнэ. Энэ нутгийн гүнд нэвтрэх, энэ нутгаар дайрч гарах худалдаачид, аялагчид хэн боловч аян замынхаа гарааг эхэлдэг цэг нь Аяс хот билээ.

Бага Армени нь өмнө талаараа одоо бол Сарацины эзэмшил нутаг болох “Амласан газар” гэгч нутагтай, баруун хойт талаараа Түрэгийн Караман (Karaman) мужтай, зүүн, зүүн-хойт талаараа Түрэгтэй болоод Тартарын эзэмшил нутаг болох Кайсари (Kaisarieh), Сивас (Sivas) болон бусад олон хэсэгтэй хиллэх бөгөөд баруун талаараа Загалмайтны нутгаас хөвөн ирэх хөлөг онгоцнууд зорчих их далайгаар хүрээлэгдэнэ. Түрэгт гурван янз үндэстэн оршин сууна. Өөрсдийгөө Текинчүүд гэх Магоменийг тахин шүтэж лал шашны дэг журмыг сахин дагадаг, хүй нэгдлийн үеийн уламжлал, заншлаа хадгалан, хэл яриа бүдүүлэг нэгэн хэсэг бий. Тэд уул тал, нуга хөндийгөөр аль сайн бэлчээр устай газрыг даган нүүдэллэж мал адгуулж амьдарна. Тэд хувцас хунараа малын арьс, эсгийгээр оёж, гэр орноо ч арьс эсгийгээр бүрж сууцгаана. Тэдгээр хүмүүс Текин үүлдрийн омголон, хурдан, гоёмсог морьд үржүүлэхээс гадна үүлдэр сайнтай, чадал тэнхээтэй илжиг өсгөнө.

Бусад хоёр үндэстэн нь Текинчүүдтэй холилдон хот, тосгодоор суурьшин, хөдөө аж ахуйгаас гадна худалдаа арилжаа, гар урлал эрхлэн амьдрах Армени, Герегүүд билээ. Тэд хорвоод хосгүй үзэмж, чанартай хивс нэхэцгээнэ. Мөн гүн улаан болон бусад өнгийн торго, торгомсог даавуу болон олон төрлийн гоёмсог бөс бараа нэхнэ. Эндхийн алдар суутай хотууд гэвэл Конья, Кайсари, Сивас гээд тоо томшгүй хөвөрч өгөх бөгөөд тэр бүхнийг тоочих гэвэл цаг, цаас хоёр хайран юм болно. Энэ нутаг ус, хүн амтайгаа Левантийн Тартар хааны эзэмшил захиргаанд харьяалагдах бөгөөд Тартарууд өөрсдийн хууль журмын дагуу амбан захирагчийг тохоон томилно.

Одоо энэ хэсгийг түр орхин Их Армениар аялацгаая. Их Армени бол асар том муж. Энэ мужруу орох замын эхэн дээр Эрзинкан (Erzincan) хэмээх хээнцэр цэмцгэрхэн хот байх агаад энэ хотод тоо томшгүй олон төрлийн гар урлал, жижиг үйлдвэрлэл цэцэглэн хөгжсөн бөгөөд бакрама хэмээх чамин тансаг нэхмэл үйлдвэрлэнэ. Шүд хага ташим булгийн хүйтэн усаар угааж ариутгадаг усан сан зөвхөн энэ л хотод байх. Нутгийн ард иргэд нь Тартарын хараат армениудаас бүрэлдэнэ. Энэ нутагт хот балгад олон арвин байв ч хамгийн чинээлэг, тансаг нь Эрзинкан төдийгүй эндхийн их хамба ламтны өргөө мөн энд байх. Эрзерум (Erzerum) болон Эркис (Ercis) хэмээх бусад том хотууд бий. Требизунд (Trebizond-аас Тебриз (Tabriz) цайз хүрэх замд Байбүрт (Bayburt) хэмээх мөнгөний том уурхай оршино.

Зуны дэлгэр цагт энэ нутгийн өвс ногоо халигсан бэлчээр, цэвэр тунгалаг усыг даган Левантийн тартарын цэрэг арми адуу малдаа тарга тэвээрэг авахуулан зусдаг. Ингэж тартарын хүн, мал зунжингаа энэ нутагт байх боловч хэзээч энд өвөлждөггүй, учир нь энд маш их цас унаж хүйтэн болдог тул мал өвөлжих аргагүй юм. Ингээд намрын сэрүүн орж, өвлийн амьсгал ойртмогц тартарууд энэ нутгаас нүүж зөөлөн дулаан цаг агаартай, өвс ургамал элбэг газар мал сүргээ адуулахаар нүүн оддог.

Их армений нутгийн төвд оройгүй цац хэлбэртэй нэгэн өндөр уул<sup>79</sup> орших бөгөөд түүнийг

Ноагийн үхэгт-онгоц80 хайрдсан газар буюу Ноагийн үхэгт-онгоцны уул ч гэдэг. Энэ маш том уул бөгөөд түүнийг бүтэн тойроё гэвэл хоёр хоног явах болдог. Уулын оргил үргэлжид мөнх цасаар хучигдмал байх агаад цас мөс нь хэзээч бүрэн хайлж урсадаггүй болохоор шинэ цас хуучин цасан хучилга дээр орж улам улам зузаарсаар байдаг. Уулын хажуу бэлээр мөсөн голын ус үргэлж хайлан урсах тул эндхийн өвс ногоо өндөр, өтгөн ургах бөгөөд эргэн тойрны мал адгуус энэ их ногоонд бэлчээрлэн тарга тэвээрэг авдаг. Байнга хайлан урсах цас мөсний ус нь уулын хажуу, бэл хормойг намгархаг бамбалзуур хөрстэй болгодог.

Их Армени нь зүүн өмнөт талаараа Мосулын хант улстай, умарт талаараа Гүрж улстай хил залган нутаглах бөгөөд эдгээр улсуудын тухай удахгүй та нарт бичиж танилцуулна. Хавар цагт Гүржийн хилийн орчмоос газрын тос оргилон ундрах бөгөөд зуун хөлөг онгоцонд81 ачсан ч хүрэлцэхээр их оргилон ундрана. Энэ газрын тосыг хүнс тэжээлд хэрэглэх, хүн идэх аргагүй, харин сайн асдаг түлш болдог, бас загатнаа, маажуур туссан хүн, тэмээнд түрхэж эмчлэхэд хурдан эдгээдэг. Газрын тосыг зөөж аваачихаар алс нутгийн хүмүүс их ирдэг, бас энэхүү шатдаг тосыг ойр орчныхон нь түлш, дэнгийн тос болгон хэрэглэхээр их авдаг. Гүржийн хаад нь бүгд л Давид Малик гэдэг нэртэй байцгаах бөгөөд Давид гэдэг нь хан гэсэн үг юм. Гүржийн эдгээр хаад нь бүгд тартаруудын захиргаан дор байцгаана. Гүржийн эртний хаад нь бүгд баруун мөрөн дээрээ бүргэдийн дүрстэй төрдөг байсан гэдэг. Гүрж иргэд нь эрэлхэг зоригтой дайчид, мэргэн харваачид, тулалдааны талбарт бол харишгүй байлдагчид байдаг. Тэд эллин (герек) ёсны загалмайн шашныг шүтэн бишрэгчид бөгөөд үсээ сүм хийдэд шавилан суудаг сахил санваартан шиг тайрдаг.

Сулхарнай82 хаан баруун зүгт буцах замдаа Гүрж орныг туулан гарч зүрхлээгүйн учир нь эндхийн зам нь уулсын хоорондох гүн, нарийн хавцалаар дайрч өнгөрдөг тул хаана нь ч отоонд орж осолдож мэдэх аюултай байлаа. Нэг талаас нь тэнгисийн эрэг шахаж, нөгөө талаас нь мориор туулах аргагүй ширэнгэн ойгоор хучигдсан өндөр өндөр уулс тэнгисийн эрэг рүү тулж хавчсан савслага мэт давчуу замтай нутаг юм. Уулсын хормой захлаж, тэнгисийн эрэг даган үргэлжлэх нарийн зурвас савслага газар арван хоёр бээр гаруй үргэлжлэх бөгөөд сайн зэвсэглэсэн хэдхэн эрчүүд энэ зурвас газраар хэнийг ч оруулахгүй хааж хамгаалах бүрэн боломжтой билээ. Сулхарнай хаан энэ нутгийг тойрч гарсны учир үүнд л бий билээ. Сулхарнай хаан энэ нутагт харуулын өндөр цамхагтай цайз хэрэм барьж нутгийн иргэд, цэргийн халдлагаас хамгаалж байсан бөгөөд энэ цайзыг “Төмөр хаалга” хэмээмой. Энэхүү төмөр хаалга хэмээх цайз нь хоёр өндөр уулын хоорондох нарийн хавцлыг хааж босгосон байдаг бөгөөд тартар цэрэг нэвтрэх боломжгүй билээ. Сулхарнай хааны үед бол тартарууд байгаагүй бөгөөд нутгийн цэрэг дайчид нь Куман үндэстэн голлосон олон үндэстний холимог байжээ.

Энэ нутаг хот тосгод олонтой. Энд хаана ч байхгүй чамин тансаг торго, торгомсог даавуу болон гайхамшигтай сайхан саатай хоргой нэхдэг. Мөн дэлхийд шилдэгт тооцогдох анч шонхор энэ нутагт элбэг. Бараа таваар элбэг хүрэлцээтэй, үйлдвэрлэл, гар урлал эрчимтэй хөгжсөн газар байжээ. Энэ нутаг бүхэлдээ өндөр өндөр уулс, уулсын хоорондох гүн нарийн хавцал, хөндийгөөс тогтох учир харийн халдлагаас хамгаалахад амар хялбар байсан тул тартарууд энэ нутгийг эрхшээлдээ бүрэн оруулж чадаагүй байлаа. Энэ нутгийн ойд өөр хаана ч ургадаггүй гүүшин мод ургадаг юм.



Энд Леонард хутагтын хийд гэж нэгэн хийд байх бөгөөд түүний үүссэн түүх сонин юм. Хийдийн дэргэд уулнаас бууж урсах уснаас тогтсон нэгэн том нуур байх бөгөөд энэ нуур огт загасгүй юм. Гэхдээ жил болгон энэ нуур Мацгийн анхны өдөр загасаар дүүрч Улаан өндөгний баярын өмнөх ариун Бямба гарагийг хүртэл үргэлжлэх бөгөөд үүнээс хойш дахин ямар ч загасгүй болдог.

Энэ нутагт нэгэн зэрэг хоёр тэнгис харагдана. Нутгийн умартад Хар далай орших бөгөөд дорнод хязгаар нь Бакугийн тэнгис хэмээх Гил буюу Гилан тэнгистэй хаяа залгах бөгөөд энэхүү тэнгисийн эргийн урт нь 2800 гаруй бээр урттай тойром үүсгэн эргэн тойрон уулсаар хүрээлэгдэн жинхэнэ далайгаас алслагдан хаагдсан асар том нуур билээ. Хамгийн ойр орших их далай нь арван хоёр өдөрчийн газарт бий. Энэ тэнгисийн олон арал дээр хүн амьтан нутагшин хот балгад олныг байгуулжээ. Арлын оршин суугчид нь Перс улсыг байлдан дагуулсан Тартарын их хааны дайны хөлөөс дүрвэн зугтаагсадаас бүрэлдэх бөгөөд тэдгээр дүрвэгсэд тэнгисийн дундах арал дээр гарчихвал дайн дажны хөл, аюулаас зайлах төдийгүй тартарын захиргаа дарамтаас ч зайлана гэж бодоцгоож айван тайван айх аюулгүй амьдрах газар олсон нь энэ байжээ. Энэ тэнгист хилэм, яргай загас тэргүүтэн түмэн янзын загас арвин их. Тэнгист олон гол цутган тэжээдгийн дунд Евфрат<sup>83</sup> мөрөн хүртэл цутгана. Сүүлийн үед Генуягийн худалдаачид хөлөг онгоцоор хөндлөн гулд аялан худалдаа наймаа хийх болсон бөгөөд “гилан” хэмээх алдартай торго эндэх газрын нэрийн бараа болж эндээс эхлэн бусад газар орноор тархан дэлгэрчээ.

Энэ нутагт Тифлис (Tiflis) хэмээх том, сайхан хот байх агаад түүний эргэн тойронд олон дагуул хот, тосгод байна. Хотын оршин суугчид загалмайн шүтлэгтэй гүрж, армян хүмүүсээс бүрэлдэх боловч цөөн тооны сарацин болон жүүд оршин суугчид байх. Эндхийн бүсгүйчүүд нь торго болон торгомсог даавуу ихээр нэхнэ. Оршин суугч ард иргэд нь гар урлал, жижиг үйлдвэр эрхлэн амьдрах бөгөөд бүгд тартарын Их хааны албат харьяат нар билээ. Энд бид дээр дурьдсан газар орны чухал чухал хоёр гурван том хотыг дурьдаснаас биш дээрх нутаг оронд тоо томшгүй олон хот тосгод байх бөгөөд тэр бүхнийг тухайлан ярих, бичих гэвэл цаг цаас хоёр хүрэхгүй билээ. Гэвч бид зарим нэгэн хот тосгодын тухай дор өгүүлэх болно.

Армениас хойгуур орших газар нутгийн тухай олон зүйлийг өгүүллээ. Одоо Армений өмнөд болон дорнод талаар орших улс орон, газар нутгийн тухай өгүүлэхийг сонсоно уу. Мосулын хаант улс нь олон төрлийн үндэстэн угсаатан холилдон суурьшиж суусан том улс. Энэ улсад Магометаг мөргөн шүтэгч арабуудаас гадна Загалмайн шашны Нестор болон Якобит<sup>84</sup> урсгалыг даган шүтэгчид суух бөгөөд эдгээр Загалмайтнууд нь Ромын сүм хийдийн дэг журмаас арай өөр зан үйлийг дагана. Тэдний шүтдэг загалмайн шашныг Патриарх хэмээгч их ламтан толгойлох бөгөөд тэр их ламтнаа Католикус<sup>85</sup> гэж дуудацгаана. Патриарх нь шашны тэр урсгалын их хамба, ширээт лам, да ламтан болон бусад олон төрлийн мяндаг тушаалтныг тохоон томилж Энэтхэг, Хятад болон Багдад руу илгээх нь эгээл Ромын их хамба шиг эрх мэдэлтэй нэгэн болой. Миний очсон газар, аялсан нутгаар тархан дэлгэрсэн загалмайн шашинтнууд нь цөм Нестор болон Якобит урсгалыг тахин шүтэгчид байсныг тодруулж хэлэх нь зүйтэй юм.

Энэ нутгийнхан Мосулин хэмээх торгоор хувцас хийж, алтаар чимэглэн гангарна. Нутгийн баян чинээлэг худалдаачид нь амттан үнэртэн болон сайн чанарын багаж зэмсэг зэргэлдээх

улс орондоо зарж наймаалдаг бөгөөд эдгээр баян чинээлэг худалдаачдыг ч мөн Мосулинчууд гэж нэрийднэ.

Эндхийн уулархаг нутгийг эзлэн суух ханлигийнхнийг Курд омогтон гэнэ. Курдүүдийн зарим нь Нестор болон Якобит ёсны загалмайн шүтлэгтэй, зарим нь Сарацин шүтлэгтэй мөн Магометийг тахин шүтэгчид ч бий. Курдүүд эрэлхэг дайчин хүмүүс боловч хууль, дэг журам сахидаггүй, их замын хулгай дээрмээр амь зуудаг тусгүй хүмүүс.

Дээрх нутгийн хөрш зэргэлдээх газар орныг Мус ба Мардин гэж нэрлэх агаад энэ нутгийнхан маш их хөвөн тариална. Энэ нутагт дэгжин хээнцэр зүйлс ихээр урлан үйлдвэрлэнэ. Оршин суугчид нь гар урчууд болон худалдаачид голлох бөгөөд бүгд тартарын хааны албат, хараат хүмүүс билээ. Одоо Мосулыг орхиж Багдадын тухай өгүүлье.

Дэлхийн бүх загалмайн шашинтны тэргүүн Ром хотноо оршин суудаг шиг хорвоогийн бүх Сарацинуудын Халиф нь Багдад (Baghdad) хэмээх энэхүү асар том хотноо суурьшин суудаг ажгуу. Хот дундуур их устай том гол урсах бөгөөд аянчид тэрхүү голоор хөвөн Энэтхэгийн их далайд гарч болдог. Энэ бол худалдаачид бараа таваараа өөдөө сөөргөө зөөж тээвэрлэдэг усан зам бөгөөд Багдадаас далайд гартал бүтэн арван найман өдөрчийн зам туулна. Энэтхэг орохоор энэхүү голоор хөвж яваа худалдаачдын замд Кайс (Kais) хэмээх хот орших бөгөөд тэр хот нь Энэтхэгийн далайд гарах үүд болдог. Энэ голын сав дагуу Багдад Кайс хотуудын хооронд Басра (Basra) хэмээх том хот орших бөгөөд түүний эргэн тойронд ургах ой шугуйд ертөнцөд ижилгүй сайхан наргил мод ургана.

Энэтхэгээс Загалмайтны ертөнц рүү дамлан худалдаалж буй сувд эрдэнийн ихэнх нь Багдад хотыг дамжин өнгөрдөг. Энэ нутгийн бүсгүйчүүд алтан саагаар араатан жигүүртний дүрс товойлгон хатгасан насси, нах болон кремози гэдэг алдартай торго нэхнэ. Багдад нь Магометийн номлол, сургаалыг үзэж судалдаг хамгийн алдартай төв төдийгүй бас некромантии, байгалийн ухаан, одон орон, газар зүй, физиономийн ухааныг үзэж судалдаг төв болой. Ойрх Дорнодын хамгийн том баян чинээлэг хот нь Багдад байлаа.

Багдадын Халиф нь урьд өмнө нэг ч хүнд байгаагүй алт, мөнгө, үнэт чулуу болон бусад эрдэнэсийг эзэмшин эзэгнэсэн цорын ганц хүн байв. Би та бүхэнд нэгэн түүхэн учралын тухай өгүүлсү. Энэ явдал манай бурхан мэндэлсний 125586 онд болсон бөгөөд Монголын агуу их хаан Хүлэг (Hulagu) өөрийнхөө хүчирхэг их цэрэг армитайгаа Багдад хотын босгонд тулж ирэв. Хүлэг бол монголын эзэн дөрвөн их хаадын нэг байсан бөгөөд тэдний хамгийн ахмадыг Мөнх (Mongu) гэдэг байв. Энэ ах дүү дөрөв Катай болон хөрш зэргэлдээх бусад бүх орнуудаа байлдан эзэлсэн боловч түүндээ үл ханан бүх дэлхийг байлдан дагуулахаар зэхэж байлаа.

Байлдан дагуулалгүй үлдээд байгаа хэсгийг дөрөв хуваан эзлэхээр болж нэг нь Дорно зүгийг эзлэн эрхшээх, нөгөөх нь өмнө зүгийг байлдан дагуулах, үлдэж байгаа хэсгийг бусад хоёр нь эзлэхээр шийдсэн байв. Хүлэгт ногдож байгаа хэсэг нь өмнө зүг байлаа. Хүлэг аян дайнд мордон өмнө зүгийн нутаг орныг ээлж дараалан буулгаж авсаар Багдад хотноо тулж ирлээ. Хотын оршин суугчид асар олон төдийгүй ихээхэн хүчээр хотыг хамгаалан байгааг мэдэх Хүлэг Багдад хотыг хүчээр биш уран арга ухаанаар эзлэн авахаар шийджээ. Явган цэргийг оролцуулалгүйгээр нэгэн бум орчим морин цэрэгтэй<sup>87</sup> Хүлэг, Халиф болон түүний тойрон

хүрээлэгсдэд их цэргийнхээ зөвхөн нэгэн хэсгийг аваад хотод тулж ирчихээд байна гэж ойлгуулж чаджээ. Хот руу дайрахынхаа өмнөхөн цэргийнхээ ихэнх хэсгийг хотоос гарах замын дагуух ойд хоёр хэсэг болгон бүгүүлж отоонд үлдээжээ. Үлдэж байгаа багахан хүчээр Багдад хотын хаалганд тултал дайран довтлов. Энэхүү багахан хүчээр довтолж буй монголчуудыг өөрийн нүдээр харсан Халиф онцын юман чинээ тоосонгүй. Довтлон ирж буй монгол цэргийн хүчийг угтан гарч гэнэтийн довтолгооноор дайран устгахаар төлөвлөсөн Халиф Магометийнхаа сахиус сүлдэнд залбиран довтолгооноо эхлэв. Үүнийг хүлээж байсан Хүлэг толгойн цэргээрээ тэднийг дайран улам ч улангасуулан дуудаж тулалдсанаа гэнэт ухран ширэнгэн ой чиглэн отоонд байгаа цэргүүдийн зүг зулбан зугтав. Ялалтандаа итгэж урамшсан Халифийн цэргүүд улам ч улайран хөөсөөр зугтаж яваа цэргүүдийн гээг даран ирэхэд отоонд суусан цэргүүд гэнэт хавсран дайрч Халифийн цэргийг хиар цохиод өөрийг нь олзлон авав. Ингэж Халиф ч олзлогдож, хот ч эзлэгдэв. Хотыг эзэлсний дараа алт, эрдэнэсээр чигжиж дүүргэсэн цамхгийг олов. Үүнийг үзсэн Хүлэг хаан гайхахын дээдээр гайхаж Халифийг авчрахыг тушаав. Хүлэг хаан Халифаас ингэж асууруун: Энэ том цамхгийг яах гэж алт эрдэнэсээр дүүргэсэн юм бэ? Энэ их алт эрдэнэсээр чи юу хийж бүтээх гэсэн юм бэ? Чамайг байлдан дагуулж хот орны чинь эзлэн, алт эрдэнэсийг чинь булаан авахаар намайг ирж яваа гэж мэдээгүй гэж үү? Танай улс, хотыг, чамайг өөрийг чинь дайснаас найдвартай хамгаалаарай гэж цэрэг дайчиддаа энэ их алт, эрдэнэсээсээ өгөөгүй юм уу? гэж асуув. Үүний хариуд Халиф ганц ч үг ган хийсэнгүй бөгөөд чухам юу гэж хэлэхээ ч тэр мэдэхгүй байв. Тэгээд Хүлэг хаан хэлсэн нь: Халиф чи алт эрдэнэст хязгааргүй дуртай бас хайртаа хүн байна, тэр хайртай, дуртай алт эрдэнэсээ идэх боломжийг чамд олгоё гээд түүнийг алт эрдэнэстэй цамхагт түгжээд уух, идэх юм юу ч өгөхгүй байхыг тушаав. Халиф чи одоо энэ алт, эрдэнэсээ ханаж цадталаа идэж, уу чамд өөр юу ч өгөхгүй гээд эрдэнэсийн цамхагт хорьж орхив. Түүнээс хойш дөрөв хоноод Халиф ч үхэв. Халиф ингэж төгссөн нь бараг зөв байсан байх, учир нь амиа аврах гэж газар нутаг, хот балгад, хүн ардаа дээр нь алт эрдэнэсээ өгсөн ч тэр үхэх л байсан. Үүнээс хойш Халиф гэгчийг дахин тодруулж залаагүй билээ.

Тебризийн тухай өгүүлэхийн өмнө Багдадын зан заншил, ёс зүйн талаар яримаар байв ч энэ маань дэндүү сунжруу уйтгартай яриа болох байх гэж болгоомжлон яриагаа үүгээр дуусгавар болгоё. Харин одоо та бүхэнд нэгэн гайхамшигт үйлийн тухай өгүүлсү.

Энэ явдал Христийн дахин амилсны 122588 онд Багдад Мосул хоёрын хооронд болсон гэх бөгөөд тэр үед Багдадад Загалмайтнуудыг үзэн ядаж үргэлж хяхан хавчдаг Халиф заларч байсан юмдаг. Тэр Халиф өөрийнхөө нутагт суурьшин суусан Загалмайтнуудыг яаж лал мөргөлтэй Сарацин шиг болгох вэ гэж өдрийн бодол, шөнийн зүүд болсоор байдаг төдийгүй эс чадваас бүгдийг нь цаазлан хороох юмсан гэж мөрөөддөг байв. Энэ бодол мөрөөдлийнхөө талаар лал санваартан, бусад зөвлөгчидтэйгөө үргэлжид санаа оноогоо солилцон зөвлөцгөөнө. Хорвоогийн бүх л Загалмайтнуудад хэдий чинээ муу муухай зүйлс учирч тохиож байнав Сарацинуудад төдий чинээ сайн сайхан байх учиртай гэдэгтэй бүгд л санал нийлж байлаа. Загалмайтнуудыг муутгах, устгах шалтаг шалтгаан олохоор урт удаан хугацаанд эрэл хайгуул хийсээр байж нэгэн ийм бичвэрийг олжээ. Евангели судрын сургаал номлолд“ хэрвээ Загалмайтнуудад гичийн үр төдий хэмжээтэй үнэн сүжиг байдаг бол тэд өөрийн эзэн Бурхандаа залбиран мөргөхөд холын хоёр уул ч хоорондоо нийлэх учиртай” гэжээ. Үүнийг олж үзсэн Халиф магнайгаа хагартал баярлан одоо л бүх Загалмайтныг лал мөргөлтөн болгох эсвэл бүгдийг хөнөөн устгах шалтаг шалтгааныг оллоо гэж хөөрчээ. Ингээд Халиф өөрийн

газар нутаг дээр амьдран суугаа түм буман загалмайтан, нестор болон якобит шүтлэгтнүүдийг дуудан нэгэн дор цуглуулав. Тэгээд бурханы сургаал айлдварыг уншиж өгөөд энэ үнэн буюу гэж бүгдээс асуухад тэр чин үнэн гэж нэгэн дуугаар хариулцгаав. Та бүхэн үүнийг үнэн гэж батлан андгайлж байна уу? гичийн үр мэт тоймгүй их итгэл шүтлэгтэй Загалмайтнууд өөрийн эзэн бурхандаа мөргөн залбирч холын хоёр уулыг ч хооронд нь нийлүүлэх чадалтай юу? гэхэд тэд тэр үнэн бид үүнийг хийж чадна гэгцгээв. Тэгээд Халиф тэдэнд тэгвэл би та нарыг шалгаад үзье гэв. Түм буман Загалмайтнуудын дотор нэрийн төдий шүтлэгтэн ч цөөнгүй байх нь дамжиггүй. Тэгээд Халиф тэртээд харагдах уулсыг зааж та бүхэн шүтлэг мөргөлийнхөө хүчээр энэ хоёр уулыг хооронд нь нийлүүл, эс чадвал та бүхнийг бүгдийг чинь цаазлан хорооно гэв. Хэрвээ та бүхэн хоёр уулыг нийлүүлж чадахгүй бол та нарын шүтлэг, бурхандаа итгэх итгэл хуурамч хуудуу болох нь батлагдана. Тэгсэн цагт та бүхэн жинхэнэ бурханы төлөөлөл болох Магометийг шүтэн лал шашинд орох буюу эс зөвшөөрвөөс би бүгдийг чинь цаазлан хороосугай гэж айлдав. Ингээд Халиф Загалмайтнуудад арван өдрийн хугацаа өгөөд одоо тарцгаа, арван өдрийн дараа та бүхэн хоёр уулыг мөргөл шүтлэгийнхээ хүчээр нийлүүлэх буюу эсвэл бүгд цаазлагдан арилна гэв.

Халифийн зарлигийг сонссон Загалмайтнууд үхлийн аюул нөмрөн ирж буйг бүгд мэдрэн хирдхийн цочирдов. Гэвч тэдэнд хүний төрөл олгон бүтээсэн эзэн Бурхан нь авран хамгаална гэсэн итгэл найдварын гэгээ сүүмэлзэн байлаа. Энэ цагаас эхлэн бүхий л урсгалын загалмайн шүтлэгтэн, тэдний сахил санваартан лам хуврагууд хамтран зөвлөлдөж үхлээс гэтэлгэх арга зам байгаа эсэхийг хайцгаав. Тэдний хэн нь ч эзэн Бурхандаа мөргөн залбирч аврал энэрэл гуйхаас өөр арга зам үгүй гэдгийг сайн ойлгон ухаарч байв. Ингээд бүхий л Загалмайтнууд ялгаагүй өдөр шөнөгүй мөргөл залбирал үйлдэн өршөөлт эзэндээ болон газар тэнгэрийн бүхий л бурхадаас аврал гуйн мөргөцгөөж байсныг давтан ярих нь илүүц зүйл билээ.

Загалмайтан эр, эм, хүүхэд багачууд гэлгүй бүгд найман өдөр, найман шөнө тасралтгүй мөргөж залбиран өөрсдийн чин сэтгэлийн гуйлт хүсэлтээ бурхандаа илгээцгээв. Энэ их мөргөл залбирлын үеэр нэгэн ариун шүтлэгт хамба лам бурханы илгээсэн мэдээ дохиог хүлээн авчээ. Тэрхүү мэдээ дохионд “хамбатан та одоо тийшээ яваад – тийм гэдэг газар очиж – нэгэн өрөөсөн нүдтэй гуталчинг олж уулз” тэгээд түүнээс учир зовлонгоо хэлээд уулыг хөдөлтөл мөргөж гуйж өгөөч гэж түүнд хэлж гуй гэжээ.

Одоо би та нарт тэрхүү өрөөсөн нүдэт гуталчин ямар хүн болох, ямар амьдралыг туулж өнгөрүүлсэн тухай өгүүлсү. Тэр гуталчин үнэнхүү чин шударга бодол сэтгэлтэй, холч гүн ухаантай нэгэн байжээ. Тэр өдөр алгасалгүй мацаг барьж нүгэл хилэнцээс үргэлж зайласхийнэ. Гуталчин өдөр өнжилгүй сүмд очиж мөргөл үйлдэнэ. Өөрт ногдох хүнснийхээ талыг заавал бурханд өргөнө. Ийм чин шударга сүсэгтнийг тэр нутагт хаанаас ч эрээд дахин олдохгүй юм. Гуталчин эр Ариун Евангелийн номлол, сургаалыг үргэлжид сонсон бурхандаа залбиран мөргөх агаад нүд чинь нүгэлт хорвоогийн элдэв зүйлд бэлчээд байвал өөрийгөө чимхэж нүглээ наманчил, бүр буруу үйлрүү хөтлөөд байвал нүдээ сохолчих гэдэг зарчмыг барьсан үнэн сүжигтэн билээ. Нэг удаа энэ гуталчнаас гутал худалдан авахаар нэгэн гоо бүсгүй иржээ. Бүсгүйд ямар гутал таарахыг сонгохын тулд гуталчин бүсгүйг хөлөө үзүүлээч гэжээ, бүсгүй ч хөлөө гаргав. Тэр бүсгүйн хөл нь үнэнхүү гоо үзэсгэлэн төгс хөл байснаар барахгүй үүнээс гоо үзэсгэлэнтэй хөл өөр байдаг гэдэгт итгэх аргагүй байв. Дэлгүүрийн эзэн

гүн сүжигтэй шүтлэгтэн байсан боловч бүсгүйн хөлийг хараад ухаан самууртлаа догдлон шунал тачаал нь хөдөлжээ. Тэр бүсгүйд гутал худалдалгүй явуулж дахин дахин ирүүлэх нууц санаа агуулжээ. Бүсгүйг явсны дараа өөрийнхөө бузар шунал тачаалаас сэжиглэн өөрөө өөрийгөө зүхэж нүгэл хураасан нүдээ хурц шөвгөөр цоо хатган сохлов. Ингэж тэр нүдэндээ шүглэсэн нүглийг өөрөөсөө зайлуулан дахин хэзээч ингэж нүгэл хураахааргүй болжээ. Тэр гуталчин үнэнхүү сүжигтэн гэдгээ ингэж баталсан гэдэг. Одоо түрүүн ярьж байсан зүйлээдээ эргэн орж үргэлжлүүлсүгэй.

Өрөөсөн нүдэт гуталчныг олж ирж бурханы аврал өршөөлийг эрж гуйж мөргө гэсэн бурханы илгээлт Хамба ламын зөн совинд удаа дараа ирж байгаа учрыг хамбатан сүсэгтэн олондоо дуулгаад гуталчинг олж ирэв. Гуталчинг ирмэгц Загалмайтнуудад үхлийн аюул нүүрлэн ирчихээд байна, үүнийг зайлуулах цорын ганц арга бол мөргөл шүтлэгийн хүчээр хоёр уулыг нийлүүлэх гэдгийг хэлж мөргөл үйлдэхийг гуйв. Эхлээд гуталчин маань надад тийм ид шидийн хүчин байхгүйгээс гадна би бол хир цээргүй сүжигтэн биш шүү дээ гэв. Гэвч Загалмайтнууд түүнийг гуйж гувшисаар мөргөл үйлдэхээр болцгоов. Үүнийг ойлгож биелүүлэхэд олон үгний хэрэггүй бөгөөд тэднийг бүтээсэн Бурхандаа чин сүжигээр залбирч мөргөх л үлджээ.

Халифийн товлосон сүүлчийн өдрийн өглөө эр, эм, хүүхэд багачууд гэлтгүй бүх загалмайн шүтлэгтнүүд эртлэн босож сүмдээ цугларан хурал хуран мөргөл үйлдэж Ариун өргөлийн дуугаа дуулцгаав. Сүмдээ цугларсан Загалмайтнууд мөргөл, өргөлийнхөө дараа Авралын Загалмайгаа өндөрт өргөн уулсын хормой түшин цэлийх их талыг зүглэцгээв. Тэр их талыг арван түм гаруй Загалмайтнууд бүрхэн, Бурханы Загалмайгаа тойрон мөргөл үйлдэхээр зэхэцгээв. Мөн тэр хөндийд хэдэн мянган Сарацинаа дагуулсан Халиф ч ирсэн бөгөөд тэд Загалмайтнуудын мөргөлийн дараагаар тэднийг бүгдийг нь устгах бодолтой ирцгээжээ, учир нь Загалмайтнууд мөргөж гуйснаар уул байрнаасаа хөдлөх юм гэж тэдний хэний ч санаанд буухгүй байлаа. Том, бага ялгалгүй бүх л Загалмайтныг үхлийн өмнөх айдас хүйдэс нөмрөн бүрхэж, эргэлзээ тээнэгэлзэлдээ түгшин зовнисон тэд эзэн Бурханыхаа өршөөл авралд итгэсээр мөргөлөө үйлдэж эхэллээ. Амь гуйж мөргөл үйлдэх Загалмайтнууд тэднийг дуусгах учиртай Сарацинууд хөндий талыг бүрхэн хучиж түрхрэн уулын хормойд өрөөсөн нүдэт гуталчин Загалмайн өмнө сөгдөн, цамцаа тайлаад, гараа тэнгэр өөд өргөн амьдрал үхлийн заагт тулж ирсэн мянга түмэн Загалмайтнуудын нүгэл хилэнцийг нимгэлэн зовлонт үхлээс гэтэлгэхийн тулд хоёр уулыг хөдөлгөн хооронд нь нийлүүлэн энэ олон сүсэгтний алтан амийг аварч өршөөхийг Авралт эзэн бурханаасаа гуйж мөргөв. Гуталчин мөргөж дуусмагцаа ийн хашгирав: “Эцэг, Хүү, Гэгээн сүнсний нэрийн өмнөөс Уул таныг ургасан газраасаа хөндийрч учран нийлэхийг Гэгээн сүнсний хүчин чадалд итгэн тушааж байна” гэв. Гуталчин үгээ дуусгах тэрхэн мөчөөс эхлэн уул нурж ургасан газраасаа хөдөлж эхэллээ. Үүнийг харж зогссон Халиф болон түүний албат Сарацинууд мэл гайхан, цэл хөхөрсөн төдийгүй тэрхэн мөчөөс эхлэн олон мянган сарацинууд загалмайн шашныг шүтэн мөргөдөг загалмайтан болж хувирав. Халиф ч өөрөө нууцаар загалмайн шүтлэгтэн болсон бөгөөд түүнийг өөд болсны хойно оршуулахад хүзүүнд нь загалмай зүүлттэй байжээ. Ийм учраас тэр Халифийг бусад халифийг оршуулдаг газар нутаглуулалгүй өөр газар оршуулжээ.

Бурханы хүч чадлын ид шидийн гайхамшиг хэрхэн биеллээ олсон тухай та бүхэн дөнгөж сая сонслоо. Тэр цагаас хойш бүх Загалмайтнууд, Нестор болон якобитууд өрөөсөн нүдэт

гуталчинд хүндэтгэл үзүүлж жил болгон тэр өдрийг баяр ёслолоор тэмдэглэн угтаж өнгөрөөх болжээ. Загалмайн шүтлэгт армян, нестор, якобитууд болон бусад нь загалмайн шашны дэг жаягийн тодорхой нэгэн зүйлээр хоорондоо зөрөх<sup>89</sup> бөгөөд түүнээсээ болоод нэг нь нөгөөгөө нэг нүд үздэггүй төдийгүй бусдыгаа дандаа үгүйсгэж байдаг.

Том жижиг олон хоттой Ирак хэмээх мужийн хамгийн чинээлэг, том хот нь Тебриз билээ. Одоо би та бүхэнд Тебриз хотын тухай өгүүлсү.

Тебриз хотын оршин суугчид нь худалдаа арилжаа, гар үйлдвэрлэл эрхлэн амьдрах бөгөөд үнэт торго, алтан саатай хоргой хувцсаар гоёсон бүсгүйчүүд маш олонтой. Энэ хотын байршиж нутагшсан газар нь Энэтхэг, Багдад, Мосул, Хормуз болон бусад олон олон газраас ирэх бараа таваарыг борлуулах зах зээлд зориулагдсан мэт тохиромжтой, харь орноос зөөж тээж авчирсан бараа таваарыг эндхийн зах зээлээс худалдан авахаар үй олон латин худалдаачид<sup>90</sup> бас энд ирцгээнэ. Энэ нутгаас элбэг олдох үнэт чулууны зах зээл бас энэ хотод төвлөрчээ. Энэ хотын зах зээл нь явуулын худалдаачид ихээхэн олз ашиг олдог ээлтэй газар юм. Хотын оршин суугчид нь маш олон үндэстэн ястан, овог омгийнхон холилдсон бөгөөд шулуун шударга, сайн санаат хүмүүс нь дэндүү цөөхөн. Энэ хотод Армян, Нестор болон Якобит шүтлэгтэн, Гүрж, Персүүд олноор байхаас гадна Магометийг шүтэн мөргөдөг хотын уугуул иргэдийг Тебризис гэж нэрлэдэг. Хотын эргэн тойрныг төрөл бүрийн амтаг жимс дүүрэн ургасан цэцэрлэгт ой битүү хучина. Тебриз хотын Сарацинууд нь уур омог ихтэй, урваж шарвахыг юман чинээ боддоггүй хүмүүс байдаг. Тэд өөрсдийн шүтэн мөргөдөг Магометийн хууль гэх дэг журмыг мөрдөн дагах бөгөөд тэрхүү хууль нь өөр шашин мөргөлтэй хэнийг ч болов доромжилж хохироох, бараа таваарыг нь булаан авах нь нүгэл хилэнц биш гэж номлодог. Загалмайн шашинтнуудыг алах, шархтуулж гэмтээх нь ердийн үзэгдэл бөгөөд тийм хүмүүсийг шашин мөргөлийнхөө төлөөсөнд тарчилан зовогсод гэж нэрлэх. Үүнээс үзэхэд лал мөргөлтнүүд нь хүний ертөнцийн дэг журмыг уландаа гишгэн, улайндаа гаарсан хүмүүс бөгөөд засаг, засаглал байгаагүй бол юу болохыг хэлэхэд ч бэрх. Хорвоогийн бусад бүх Сарацинууд дээрх зарчмыг мөрдөн амьдарцгаадаг. Аллага таллага үйлдэхээр зэхэж буй Сарацинууд дээр тэдний лам хуврагууд ирээд Магометийг бурханы жинхэнэ элч гэж та бүхэн хүлээн зөвшөрдөг үү? гэж асууцгаахад тэд нэгэн зэрэг “тийм” гэж хариулбал тэдний нүгэл хилэнц арилж байгаа нь тэр гэнэ. Иймээс тэд тартарууд болон өөр бусад үндэстэн ястныг өөрийнхөө шашин мөргөлд оруулж лалын дэг журмыг мөрдүүлэх гэж хичээх бөгөөд тэдний шашин номлол нь ямарч муу үйлийг үйлдэхэд нүгэл хилэнц гэж үздэггүй билээ<sup>91</sup>. Тебриз хотын дүүрэгт Гэгээн Барсамог дурсан хүндэтгэсэн нэгэн сүм байх бөгөөд тэндхийн хамба болон лам хуврагууд нь Кармелитийн жаягийг мөрдөн дагагсад юм. Эндхийн лам хуврагууд зүгээр суухгүйн тулд үргэлжид ноосоор бүс нэхэцгээх бөгөөд их мөргөлийн үед түүнийгээ гэгээн Барсамогийн сэнтийд өргөдөг. Ингээд их мөргөл дуусмагц тэр сүмийн лам нар өөрсдийн танил нөхөд, нутгийн язгууртнуудад өнөөх ноосон бүснээсээ өгөцгөөх бөгөөд тэрхүү бүс нь биеийн элдэв өвчин, зовуурийг анагаах шидтэй тул хүн бүхэн тийм бүстэй болохыг мөрөөднө.

Одоо бид Тебризээс эргэн Персийн зүг хандъя<sup>92</sup>. Перс бол маш том нутаг орон төдийгүй урьд өмнө маш хүчирхэг, баян чинээлэг орон байсан бөгөөд одоо бол Тартарууд цөлмөн хоосолсон ядуу тарчиг нутаг болжээ. Персийн Савэх (Saveh) хэмээх хот нь Ийсус Христэд мөргөж адислуулахаар ирсэн гурван Шидтэний домгоос эхтэй. Одоо ч тэдний шарил маш гоё,

их том гурван булшинд оршуулсан хэвээр энэ хотод бий. Мөн булш болгоны дээр бөмбөгөр оройтой, маш уран гоё хийцтэй бунхан барьсан байдаг. Одоо болтол тэр гурван Шидтэний бие бүтэн төдийгүй үс, сахал нь ургасаар байдаг. Нэгийг нь Белтазар, нөгөөг нь Гаспар, гуравдахийг нь Мелхиор гэж нэрлэдэг. Эдгээр гурван хүний талаар Марко гуай нутгийн хүмүүсээс юун хүмүүс байсан талаар асууж сураглахад энд оршуулсан гурван хаан гэхээс өөр юу ч хэлж мэдэхгүй байцгаав. Гэвч Марко гуай цөхрөлтгүй хайж сурсаар олж цуглуулсан мэдээг би та нарт хүргэе.

Эндээс гурван өдөрчийн алс газар Кала Аташпарастан (Kala Atashparastan) хэмээх нэгэн хот байхыг Марко гуай олсон агаад тэр нь гал-шүтлэгтний хот гэсэн нэртэй ажгуу. Энэ хөдлөшгүй үнэн бөгөөд тэр хотын хүмүүс бүгд галд мөргөн шүтдэг ажээ. Яагаад эдгээр хүмүүс галд мөргөн шүтдэг болсон тухай одоо өгүүлсү. Нэгэн цагт энэ нутагт гэгээн зөнч төрж мэдэлсэн тул тэр нутгийн гурван хаан шинээр төрсөн гэгээн зөнч бурхан тэнгэр эзэн үү? Газар дэлхийг захирах хаан уу? эсвэл оточ уу гэдгийг сорьж тодруулахаар хэлэлцэн тохирч алт, хүж, эм аваад шинээр төрсөн гэгээн зөнч рүү явцгаажээ. Тэр гурван хааны бэлгээс алтыг авбал газар дэлхийн хаан, хүжийг авбал тэнгэр бурхан, эмийг авбал оточ болох учиртай байжээ. Гурван хаан гэгээн зөнчийн төрсөн газар ирэнгүүтээ хамгийн залуу нь хүүхдийг үзэхээр өргөөнд нь гав ганцаараа оржээ. Гэтэл тэнд яг өөртэй нь усны дусал шиг адилхан, мөн төдий нас, биений залуу эр байхтай таарчээ. Ингээд залуу хаан гайхахын ихээр гайхан мэлэрсээр гарч ирэв. Үүний дараа дунд насны хаан нь ороход мөн л түүнтэй яг адилхан, мөн тийм дунд насны эр байхыг олж үзээд гайхан алмайрсаар гарч одов. Үүний дараа тэдний ахмад хижээл насны хаан ороход мөн л түрүүчийн хоёр хаанд тохиолдсон зүйлтэй учирчээ. Ингээд тэр хаан гүн бодолд дарагдан бодлогоширсоор гарч ирэв. Ингээд тэр гурван хаан хэн юу үзсэнээ бие биедээ ярин гайхацгааж, эцэст нь гурвуулаа хамт шинээр төрсөн хүү дээр орохоор шийдээд ортол дөнгөж төрөөд арвангурав хонож байгаа нялзрай хүүхэд байлаа. Тэр гурав нялх зөнчид мөргөн залбирч авчирсан гурван бэлгээ өргөн барьтал нялх хүү гурвууланг нь аваад гурван хаанд нэгэн битүүмжилсэн хайрцаг гардуулжээ. Ингээд гурван хаан өөр өөрийн нутгийн зүг буцахаар болцгоов.

Буцах замдаа хэдэн өдөр явсны эцэст зөнч хүү тэр гуравт юу өгснийг үзэхээр шийдээд хайрцгийг нээтэл нэгэн чулуу байжээ. Энэ ямар учир утгатай зүйл болохыг тааж ядан элдвээр тайлах гэж оролдов. Хүү тэр гурвыг шинээр орсон шүтлэг шүтээндээ чулуу мэт хатуу итгэлтэй байгаарай гэж өгсөн байх гэж тайбарлацгаав. Энэ гурван хаан тэдний хүүд өгсөн сорилгын гурван бэлгийг хүү бүгдийг авсан тул тэр хүү тэнгэр бурханч мөн, газар дэлхийн хаан ч мөн бас оточ ч мөн гэж тогтов. Тэгэхээр хүү тэр гурван хаан үүнд гүн итгэлтэй байгаа гэдгийг мэдэж байсан учир та гурав энэ чулуу мэт хатуу итгэлтэй, хувирашгүй үнэнч байх ёстой гэж бэлэгдэн энэхүү чулууг өгсөн байх гэж шийдэцгээв. Яагаад тэр гуравт энэ чулуу өгсний учрыг олж ядан эргэлзэж тээнэглэзсэн гурван хаан өнөөх чулууг нэлээн хол дүүгүүрдэн шидэж орхив. Гэтэл чулуу унасан газар руу тэнгэрээс гал мушигран бууж чулуу унасан газар дүрэлзэн асах нь тэр. Гурван хаан үүнийг харангуутаа чулуунд ямархан их ид шид шингэсэн байсныг ухаарч ядан ахин дахин эргэцүүлж бодсоор чулуунд агуу их хүч чадал шингэсэн байсныг ухаарцгаав. Тэгээд тэр гурав дүрэлзэж байгаа галаас хэсгийг авч нутагтаа ирэнгүүт нэгэн сайхан сүмд дээдлэн залаад галыг унтраалгүй үргэлжид тэтгэн сэргээж галдаа сүслэн мөргөцгөөх болжээ. Галд өргөл өргөхөөр шарах хайрах зүйлээ зөвхөн энэ гал дээр л шардаг байв. Мөн гал шүтэгч бусад хүмүүс зөвхөн эндээс гал аван гал голомтондоо

ноцоож сүслэн мөргөцгөөх бөгөөд өөр хаанаас ч гал авдаггүйгээр барахгүй хэрэв гал нь бөхөж унтарвал галаа ноцоохын тулд арван өдөрчийн газраас ч хамаагүй гал авахаар зорин ирцгээдэг ажээ.

Ийм учраас тэдгээр хүмүүсийг гал шүтлэгтэн, галд мөргөгсөд гэж нэрлэх болжээ. Энэхүү галд мөргөгсөд нь маш олон хүмүүс байдаг. Энэ бүхний учир агуулгыг Марко Поло гуай хайж сурвалжилсаар олж гал шүтээнтэн нь зөвхөн энэ нутагт оршин амьдардаг болохыг тодруулжээ. Дээр өгүүлсэн гурван хаан буюу гурван шидтэний нэг нь Савэх, нөгөө нь Хавах, гуравдахь нь Кашанаас ирсэн хүмүүс байсан гэдэг.

Гал шүтлэгтний (Зороастра) талаарх яриа домгийг дэлгэрэнгүй тайлбарлаж ярьцгаасан тул Персийн бусад хот балгад, тэндхийн оршин суугчдын ёс заншлын талаар өгүүлье. Перс нь найман ханлигаас бүрэлдэн тогтдог том улс гэдгийг та бүхэн ойлгоорой. Тэднийг би дэс дараагаар нь тоочин нэрлэвэл: эхнийх нь Перс орны орох үүд болсон Казвин, хоёрдахь нь түүний өмнөд талаар орших Курдистан, гуравдахь нь Луристан, дөрөвдэх нь Шулистан, тавдахь нь Исфахан, зургаадахь нь Шираз, долоодахь нь Шабанкара, наймдахь нь Перс нутгийн алс хязгаарт орших Тун ба Кайн болой. Эдгээр ханлигууд нь цөм Казвинаас өмнө зүг рүү орших бөгөөд зөвхөн Тун ба Кайны ханлиг нь Өнчин модны мужтай хаяа дэрлэн оршдог билээ.

Эдгээр ханлигууд маш сайхан морьдтой бөгөөд тэднийг Энэтхэг оронд зарж борлуулдаг. Ийм морьд маш их үнэд хүрдэг, турений хоёр зуун фунт хүрэх үнэтэй морьд элбэг таарна. Мөн маш сайн илжиг элбэг, тэд 30 мөнгөн марк хүрэх нь жирийн явдал. Эдгээр илжиг нь бага иддэг төдийгүй маш хүнд ачаа тээвэрлэх, хол замд удаан аялах чадвараараа морь, лууснаас ч давуу билээ. Энэ нутгийн худалдаачид нь нэг газар орноос нөгөөд хүрэхийн тулд ус, ургамал үгүй элчилгүй их цөлийг туулан урт удаан аялахдаа зөвхөн амны цангаагаа тайлан бараг л амралгүй зогсоо чөлөөгүй явж байж туулдаг. Ийм урт холын аяны хүнд хүчир замыг туулахад илжиг нь мориноос хол давуутай төдийгүй хоол тэжээл голдоггүй бас жороо явдалтай хөл хөнгөн тул худалдаачид дандаа илжигэн хөсөг хөдөлгөдөг. Ийм учраас энэ нутагт илжиг мориноос илүү үнэлэгддэг билээ. Худалдаачид мөн тэмээн жингийн цуваа хөдөлгөдөг бөгөөд тэмээд нь ачаа даах, хоол тэжээл голохгүй, ус ундаагүй удаан аялаж чаддаг тул хямд төсөр хөсөг болдог. Энэ нутгийн эрчүүд Энэтхэгийн далайн эрэгт орших Кайс болон Хормуз (Hormuz) хотуудад морьдоо авчирч худалдаачдад борлуулах бөгөөд тэд нар морьдыг Энэтхэгт аваачин дээр миний ярьсан өндөр үнэд хүргэн зардаг билээ. Энэтхэгийн цаг агаар дэндүү халуун тул энд адуу үржүүлэх боломжгүй төдийгүй тэнд очсон адуу үржиж төллөдөггүй байна. Мөн тэндхийн хортон шавж нь адууны үржлийн эд эрхтэнг гэмтээдэг хорлонтой.

Эдгээр ханлигийн хүмүүсийн дотор араатан шиг авир ааштай, цусанд шунасан нь олон бий. Тэд үргэлжид бие биенээ алж талах төдийгүй өрөөл бусдын амар тайван ажил амьдралыг үргэлжид бусниулана. Тэдгээр муу хүмүүс худалдаачдад ихээхэн аюул гамшиг тарьдаг тул Левангийн тартар хаад, засаг нь тэдэнтэй ширүүн тэмцэл хийдэг байна. Тэдгээр дээрэмчдийн бүлэглэлийг хүнд хүчир торгуулиар шийтгэх хуультай, осол аюулд өртөж болох зам гудааст оршин суугчид худалдаачдын жингийн цувааг сайтар хамгаалан нэг мужаас нөгөөд хүргэж өгөх болон жингийн замын уртаас хамааран илжиг, тэмээдийг хооллох тэжээлээр хангах үүрэгтэй. Гэсэн хэдий боловч тэдгээр дээрэмчдийн довголгоо, аллага, таллагаас



худалдаачдыг бүрэн хамгаалж дийлдэггүй байв. Худалдаачид өөрсдийгөө хамгаалах цэрэг, зэвсгээр тааруухан бол лал шүтлэгтэн нутгийн дээрэмчид тэднийг алах, талах, тамлах нь энүүхэнд төдийгүй тэд энэ бузар муухай үйлээ Аллах тэнгэрийн ивээлээр, зөнч Магометийн номлолоор үйлдэж байгаа тул ямарч нүгэл хилэнц биш гэгцгээн зоргоороо аашилна.

Хотын оршин суугчид нь худалдаачид, гар урчуудаас зонхилох бөгөөд тэд худалдаа, үйлдвэрлэл эрхлэн аж төрнө. Гар урчууд нь алтан саатай хоргой, төрөл бүрийн торго хийнэ. Энэ нутагт хөвөн их ургана. Мөн улаан буудай, арвай, хөх тариа болон бусад амуу будаа элбэг дэлбэг ургах бөгөөд бүх төрлийн жимс жимсгэнэ, жимсний архи газар сайгүй бялхана. Лал шүтлэгт Сарацинууд архи уудаггүй гэж хүн болгон боддог, учир нь лалын номлол сургаал архи уухыг чандлан хориглоно. Гэвч тэд лалын шашныхаа энэ хуулийг уландаа гишгэх аятайхан арга олсон байдаг. Хэрвээ жимсний архийг гал дээр жаахан буцалгачихвал үнэр нь өөрчлөгдөж чихэрлэг амттай болдог, нэгэнт үнэр, амт нь өөрчлөгдсөн болохоор тэд энэ бүтээгдэхүүнээ жимсний архи гэдэггүй тул үнэр амтаа дагаад нэр нь ч бас өөрчлөгддөг бөгөөд тэд үүнийгээ ууцгаана.

Персийн хотуудын дотор Йезд (Yazd) хэмээх нэгэн чинээлэг сайхан, худалдаа арилжааны төв болсон хот бий. Энд йезды хэмээх торгомсог нэхмэл үйлдвэрлэж их хэмжээгээр гадагш нь зарж борлуулдаг билээ. Хотын оршин суугчид нь Магометийг шүтнэ.

Энэ хотыг дайран өнгөрөх жинчин-худалдаачид аянаа үргэлжлүүлбэл бүтэн долоо хоногийн турш нэгэн их талыг туулах бөгөөд тэр талын дунд дөнгөж гуравхан суурин байх бөгөөд тэнд хоноглож хоргодох боломжтой. Зам гудаст хасарвааний дал модны сайхан шугуй үргэлжлэх бөгөөд түүний дундуур аялаж явахад машид тааламжтай, мөн энэ шугуйд ятуу, гургууль болон бусад жигүүртэн шувууд элбэг тааралдах нь жинчин-худалдаачдад нэн ч өгөөжтэй. Долоо хоногийн урт аяны эцэст Керманы ханлигт хүрэлцэн ирнэ.

Керманы ханлиг нь Перс улсын зах хязгаар нутаг билээ. Эртнээс нааш энэ ханлигийг үе залгамжилсан захирагч захирч байсан боловч Тартарууд эзлэн авмагцаа үе залгамжилсан захирагчийн захиргааг устган оронд нь Дээд захирагчаар дандаа Тартар хүнийг тохоон томилох болсон. Энэ ханлигийн нутгаас оюу чулуу их хэмжээгээр олдсон бөгөөд түүнийг уулын асга хадыг ухаж гаргасан уурхайгаас олзворлож авдаг. Мөн сайн чанарын болд төмөр үйлдвэрлэхэд хэрэгтэй хүдэрийн судал болон хорголож их хэмжээгээр бий. Нутгийн оршин суугч гар урчууд нь цэргийн хэрэгцээнд зориулан эмээл, хазаар, давируул, сэлэм, жад болон бусад олон төрлийн хуяг дуулга урлан дархлана. Охид бүсгүйчүүд нь өнгө өнгийн торгон дээр элдэв амьтан шувууд болон бусад гоё зүйлсийг урлан хатгана. Тэд баян чинээлэг язгууртан, хэргэм тушаалтан ноёдод зориулан цонхны хөшиг хатган урласан нь хэний ч гайхал бахархалыг төрүүлнэ. Мөн тийм уран гоё хатгамалтай бүтээлэг, дэр, дэрний уут урлан бүтээнэ.

Ойрх ууланд нь хорвоод хосгүй сум шиг хурдан хоолой, омруу, хонго, салтаа нь улаан өнгөтэй шонхор үүрлэн үржинэ. Энэхүү хурдан шаламгай шонхроос зугтаж амь зайлах ямарч шувуу хорвоо дэлхийд байхгүй.

Жинчин-худалдаачид болон аялагчид Керман (Kerman) хотоос гараад бүтэн долоо хоногийн турш хот балгад, тосгон суурингаар дүүрэн тал нутгийг туулна. Ийм газар нутгаар аялаж

явахад сэтгэл амар, таатай тавгай явахаас гадна хаяагүй ан араатан элбэг төдийгүй ятуу шувууд газар сайгүй таарна. Долоо хоног аялсны эцэст аварга том өндөр эрэгт тулж ирээд зам маань хоёр хоногийн турш уулсын хормой даган аажим уруудах бөгөөд энд төрөл бүрийн жимс энд тэндгүй ургана. Урьд цагт энд мал ахуй, газар тариалан эрхлэдэг суурин иргэд олноороо байсан боловч одоо бол үгүй, харин нүүдэлч малчид тэдний орыг эзэлжээ. Өвлийн цагт Керман хот болон дээрх өндөр эргийн хоорондох нутагт чөтгөр тогтохын аргагүй хүйтэрдэг тул олон давхар зузаан болон үслэг хувцас өмсөж байж арай ядан өвлийн хүйтнийг давна.

Керманы ханлигт болсон нэгэн сонирхолтой сорилгын тухай би та нарт өгүүлэе. Энэ нутгийн хүмүүс айван тайван, найрсаг элэгсэг харьцаатай нэг нэгэндээ тус дэм болох, нэг нь нөгөөгөө хүндэтгэн асрах боломж бүрийг эрэлхийлэн амьдарцгаана. Үүнийг гярхай ажигласан хан нь түүний ордонд цугларсан түшмэд мэргэдээс ийн асууруун: Би нэг л юмыг бодоод бодоод учрыг нь олж хужирыг нь тунгаан тайлаж чадахгүй байна. Бидний хамгийн ойрын хөрш Персийн ханлигт хүмүүс нь догшин хэрцгий хэний ч үг зөвлөгөөг сонсдоггүй, үргэлжид нэг нь нөгөөгөө алж талж байхад бидний дунд тийм хүмүүс огт байхгүй төдийгүй тийм гунигт явдал манай оронд огт тохиолддоггүй билээ, үүний шалтаг шалтгаан нь юунд байна вэ? гэхэд түшмэд мэргэд нь энэ бол хөрс шорооныхоо ээл ивээлийн ялгаанд байгаа юм гэж хариулцгаав.

Энэ ярианы дараа хан Персээс, ялангуяа муу үйл, муухай явдлаараа алдаршсан Исфакан (Isfahan)-аас хөрс авчруулахаар хүмүүсээ илгээжээ. Ингээд тэдгээр газар нутгаас бүхэл бүтэн долоон хөлөг онгоц дүүрэн хөрс шороо авчруулсан байна. Авчирсан хөрс шороогоо ордныхоо давхар болгонд тусгай өрөөнүүдэд тараан асгаад дээрээс нь хивс дэвсэж хэнд ч үл ажиглагдам болгожээ. Хаан их найр дайллага зарлан хүмүүсийг авчирсан хөрс шороогоо дэвссэн өрөөнүүдэд оруулж цайллага дайллага эхэлснээс хойш төдий удалгүй хүмүүс бие биедээ эвгүй үг шидэлцэн өдөөж байснаа нударга зөрүүлж эхлэх нь тэр. Хүмүүсийн зан ааш эвдэрч, хүнлэг харьцаа бузартаж эхлэх нь унасан газар, угаасан усныхаа хөрс шороонд байдаг юм байна гэдгийг хаан өөрийн нүдээр харж итгэжээ.

Дээр өгүүлсэн их хавцгайг даган хоёр хоногийн турш уруудсаны эцэст нэгэн их тал газарт орж ирэх бөгөөд тэрхүү талын захад Камдин (Kamadin) хэмээх хот оршино. Нэгэн цагт энэ хот эд баялаг бялхсан том хот байжээ, харин одоо бол том ч биш баян чинээлэг ч биш учир нь тартаруудын довтолгооны хөлд хэд хэдэн удаа нэрвэгдэж хоцорсон хот юм. Энэ тал нутаг маш бүгчим халуун авай.

Одоо миний та нарт ярьж таниулах орныг Рудбар гэх. Энд улаан буудай болон бусад тариа будаа ихээр тарьж ургуулна. Энэ нутагт хасарваань, сугавадын алим, чавга зэрэг манай нутаг шиг хүйтэн сэрүүн газар ургадаггүй мод, жимс хаяагүй ургана. Эндхийн самар жимсээр хооллодог зэрлэг тагтаа үй түмээрээ хуран цугларсан байх. Сарацин хүмүүс зэрлэг тагтааны махыг иддэггүйгээр үл барам тэднээс машид их сэжиглэнэ. Энд гургууль болон бусад шувууд арвин их. Энэ тал нутагт бусад газар байдаггүй нэгэн онцгой шувуу байх, түүнийг ойн ятуу гэх боловч бусад ятуунаас эрс өөр. Хар цагаан алагласан өд сөдтэй, улаан хошуу мөн тийм улаан хөлтэй. Эдгээр шувууд өөр хоорондоо ч мөн ялгаатай байх нь элбэг. Одоо би та нарт энэ нутгийн нэгэн үхрийн тухай өгүүлсү. Тэдгээр үхэр нь нүсэр том биетэй, цас шиг цагаан

өнгөтэй. Тэдний эвэр нь бүдүүн, охорхон бөгөөд мөлгөр үзүүртэй. Хоёр далны нь хооронд хоёр алга дарам өндөр мөлгөр бөөрөнхий бөхтэй. Хорвоод ийм сайхан амьтан өөр байдаг болов уу гэмээр нүд булаасан амьтад байдаг. Тэднийг нуруу ачаалахдаа тэмээ шиг хэвтүүлэн ачаалах бөгөөд их ачаа даадаг хүч тэнхээтэй амьтан болой. Мөн сайн илжигний хэртэй том биетэй, том дугуй өөхөн сүүлтэй элбэг гучин фунт татах жинтэй сайхан хонь элбэг. Тэдгээр тарган хонины мах маш амттай, идэхэд зөөлөн шим тэжээл сайнтай. Энэ тал нутагт өндөр өндөр шавар хэрмээр хүрээлэн хамгаалсан хот балгад олон. Эдгээр өндөр, зузаан шавар хэрэм нь тэднийг Караунасын довтолгоо, дээрмээс хамгаалах учиртай. Караунас гэгч цагаандаа гарсан дээрэмчин тонуулчид нь энэтхэг эхтэй, тартар эцэгтэй эрлийзүүд бөгөөд дээрэм, тонуулаар амьдарна. Эдгээр тонуулчид дээрэм хийхдээ мориныхоо дэлэн дээр наалдан хэвтэж довтолгох бөгөөд дайран орох газраа хараал жатгын хүчээр харанхуй сүүдрээр хучин далдалж гэтэн довтолцгооно. Энэ харанхуй сүүдэрт бараг юм үзэгдэхгүй бөгөөд заримдаа энэ харанхуй сүүдэр долоон өдөрчийн газрыг ч хамран бүрхэх нь буй. Эдгээр дээрэмчид эндхийн газар нутаг, хүн зоныг нь сайтар мэднэ. Харанхуй сүүдрээ даган газар нутгийг бүрхэн довтолгох дээрэмчид нэгэн түм орчим байх бөгөөд заримдаа түүнээс арай цөөн, заримдаа түм илүү хүнтэй байх, тэдний дээрэм тонуулд өртөж буй газар оронд хэнийг ч үлдээлгүй, юуг ч орхилгүй хуу хаман цөлмөж орхино. Олзолж авсан хүмүүс нь амь золих төлбөр төлөх чадалгүй бол өвгөд хөгшдийг нь алж, идэр залуусыг нь барьцаанд үлдээх буюу боол болгон худалдана. Эдний удирдагч ханыг Нэгүдэр (Nigudar) гэх бөгөөд тэр бол Их Эзэн Цагаадайн удмын хүн бөгөөд түүний ач хүү билээ. Түүний мэдэлд нэгэн түмэн цэрэг байдаг бөгөөд Нигүдэр нь энэхүү их цэргийн хүчинд дулдуйдан, Цагаадай өвгийн алдар нэр, сүр хүчээр халхавчлан олон олон бузар үйлийг үйлдсэн дээрэмч тонуулчин болжээ. Нигүдэр өөрийнхөө түмэн дээрэмчдийг дагуулан өвгийнхөө эзэмшил нутаг Их Армениас оргон зайлж Бадахшаныг дайран Пашай болон Кашмир нутагт ирэхдээ цэрэг эрс, унаа хөсөг, уналага морьд ихээхнийг алуулж, гээсэн нь гүн нарийн хавцалтай, бартаа саадтай муу зам туулсных, ингэж явсны эцэст Энэтхэгийн Диливар<sup>93</sup> хэмээх мужид орж иржээ. Нигүдэр Диливар мужийн төв Диливар (Dilivar) хотыг эзлэн авч мужийн захирагч асан баян чинээлэг, ихэмсэг хан Султан Асидин гэгчийг хөөн зайлуулж орыг нь эзлэн энэ мужийг захирах болов. Тэр газар өөрийнхөө хамсаатан албатуудтай нутагшин суурьшиж хэнд ч захирагдахгүй, алба татвар төлөхгүй дураараа дургиж дунд чөмгөө жиргэж суух болов. Тэр мөн хил залган орших тартаруудтайгаа байнга шөргөөдөлцөн дайтан тулалдах болжээ. Тэд өөрсдийнхөө дээрэм тонуулын довтолгоог гуч, дөчин өдөрчийн алс хол руу хийх төдийгүй Рудбар руу байнга халдан довтолно. Өвлийн цагт газар газрын худалдаачид Хормузад цугларан Энэтхэг орноос ирэх худалдаачдыг хүлээн суухдаа турж эцсэн илжиг, луус, тэмээдээ хүч тарга авахуулахын тулд Рудбарын тал нутагт бэлчээн адуулдаг бөгөөд Караунасын дээрэмчид энэ агшнийг хүлээн харуулдаж байгаад тэдний мал адгуусыг тонон дээрэмддэг байв. Дээрэмчдийн илгээсэн харанхуй сүүдэр дундаас Марко Поло гуай азаар зайлж, дээрэмчдийн гараас мултарч чадсан. Марко Поло гуай зугтан зайлахдаа Камасал нэртэй хотод хүрч амжсан бөгөөд түүний хань хамсаатан олон нөхөд нь дээрэмчдэд баригдан боол болон худалдагдаж, зарим нь цаазлуулсан байдаг. Одоо бид арай өөр зүйлсийн тухай ярилцъя.

Эндээс өмнө зүгт хоёр өдөрчийн газар нэгэн их тал нутаг буй. Тэр их талын өмнөд хязгаарыг эмжин орших налуудуу хажуу руу хорь гаруй бээр уруудах зам бий. Энэ замыг отон тосох тоо томшгүй олон дээрэмч тонуулчдын бүлэглэл хөлхөх тул маш аюултай зам билээ. Жинчин-худалдаачид энэхүү налуу хажуугаар дайран өнгөрөх өөр нэгэн зам байх бөгөөд тэр замаар

хоёр өдөрчийн газрыг туулахад Хормузын тал хэмээх хасарваанийн дал модоор битүү бүрхэгдсэн, тунгалаг устай гол горхитой, уулын ятуу, тоть болон манай нутагт байдаггүй өөр олон төрлийн жигүүртэн шувууд жиргэж шулганасан нэгэн сайхан тал нутаг угтана.

Энэ тал нутгаар мөн хоёр өдөрчийн замыг туулан их далайн эрэг рүү тулж хөлөг онгоц зогсох татаалтай Хормуз хот руу орж ирнэ. Тэр хотод Энэтхэгээс ирэх усан онгоцоор худалдаачид цувран төрөл бүрийн амттан, үнэртэн, үнэт чулуу, сувд эрдэнэ, торгон нэхмэл, алт, зааны соёо зэрэг төрөл бүрийн бараа таваар, тоног төхөөрөмж тээж авчирна. Энэ хотод тэр бараа таваар, тоног төхөөрөмжөө наймаалж борлуулах бөгөөд түүнийг худалдан авсан газар газрын худалдаачид цааш нь дэлхийн бөмбөрцгийн уртраг, өргөргийн дагуух улс орноор тархаан түгээнэ. Энэ бол агуу том худалдаа арилжааны төв бөгөөд эргэн тойрныхоо хот балгадыг тэргүүлэн захирсан, энэ ханлигийн нийслэл хот болой. Ханы нь Руемедан Ахмад гэнэ. Халуун наранд үргэлжид шарагдах энэ нутгийн цаг агаар нь бүгчим халуун төдийгүй хүний биед нэн тохиромжгүй. Хэрвээ харийн худалдаачид өвдөж зовоод насан эцэслэвэл эндхийн хан түүний бүхий л эд хөрөнгийг сан хөмрөгтөө хураан авна. Эндхийн хүмүүс хасарваанийг янз бүрийн үнэртэн, амттантай хольж сайхан амттай дарс исгэнэ. Энэ дарсыг уусан хүн эхлээд сур харван гэдэс дотроо бүрэн цэвэрлэх агаад яван дасаж гэдэс дотор, бие махбодь нь цэвэршиж улам ч эрүүл сайхан болно. Нутгийн хүмүүс та бидний идэж дадал болсон улаан буудайн талх, махыг огт идэхгүй, идвэл тэр нь хоол болж шингэхгүй бие нь мууддаг. Тэд хасарваанийн жимс, давсалсан яргай загас, сонгиноор голдуухан хооллох бөгөөд энэ хоолондоо дасаж зохицсон байдаг.

Тэдний завь онгоц нь маш хэврэг муу байдаг нь онгоц завиа хийхдээ хадаж бэхлэдэггүй бөгөөд хушгын модны холтосоор олс томж түүгээрээ уяж бэхлэдэг билээ. Энэ олс нь далайн давстай усанд дэвтэж бэхжин урт удаан эдэлгээ даахтай болдог. Усан онгоц нь нэг дарвуул мөн нэг залууртай байх бөгөөд элдэв гоёл чимэггүй байдаг. Тэндхийн далайчид ачаагаа арьсаар хучиж татаад дээр нь Энэтхэгт аваачиж борлуулах морьдоо уяад далайд гардаг. Тэр нутагт хадаас хийх төмөр байдаггүй тул онгоцоо модон хадаасаар хадаж, олсоор уяж бэхэлнэ. Ийм онгоцоор урт удаан аялахад осолтой. Энэтхэгийн далайд байн байн далайн шуурга дэгдэж тэдний хэврэг онгоцыг живүүлэн авч одох нь олонтой билээ. Эндхийн хүмүүсийн царай хар, бүгд Магометийг шүтэж мөргөнө. Зуны цагт хүмүүс хот газраа орхин далайн эрэг, мод цэцэрлэг, ус горхи бараадна. Эс тэгвээс халуун наранд цохиулан бүгд үхэж үрэгдэнэ. Хөдөөлсөн иргэд нарнаас халхлах сүүдрэвч барин түүндээ хоргодох агаад усаа зөөхдөө том том навчаар бүтээн ууршихаас нь хамгаална. Ингээд байхад л наранд цохиулахаас зайлахад бэрх байдаг. Зуны ид халуунд тал нутгийг тойрон хиллэх элсэн цөлөөс хэд хэдэн удаа улайдмал халуун салхиар үлээх бөгөөд энэ үед хүмүүс усанд биеэ далдлан зөвхөн толгойгоо цухуйлган сууцгаана, эс тэгвээс бүгд мөхөх үйлтэй. Цөлийн энэ улайдмал халуун салхи ямархан хөнөөл дагавартай байдаг талаар тэр нутгаар явж байсан Марко гуай өөрийнхөө тайланд тодорхой өгүүлсэн байдгийг ишлэл болгосугай.

Хормузын эзэн төлөх ёстой алба гувчуураа төлөлгүй удаж байгаад хорссон Керманы хан Хормузын оршин суугчид хотынхоо гадна хөдөөлөн байгааг далимдуулан тэднийг дайран эзлэхээр шийджээ. Керманы хан 1600 морин цэрэг, 5000 явган цэргээр Хормузыг гэнэт довглохоор Рудбарын талын зүгт илгээжээ. Гэвч цэргийн жанжидын бүтэлгүй мулгуугаас болж товлосон цагтаа хүрэх ёстой газартаа очиж чадалгүй Хормузаас холгүй ойд хоноглохоор

хуарагнан бууцгаав. Маргааш өглөө нь довтолгоонд бэлтгэн хөдлөх гэж байтал цөлийн улайдам халуун салхи тэднийг нөмрөн ирж амьтай амьтан үлдээлгүй бүгдийг боомилон хөнөөхөд энэ аюулын тухай хандаа хэл хүргэх нэг ч амьд цэрэг үлдсэнгүй. Хормузын эрчүүд энэ тухай мэдмэгцээ үхдэл хүүрийн ялзрал, үнэр агаар бохирдуулж элдэв өвчин дэлгэрэхээс өмнө тэдгээрийг булж нутаглуулахаар цугларцгаав. Үхдэл хүүрийг булахаар зэхсэн нүхэнд хийхээр дэгээгээр гогдон татахад хүрсэн газраар өмрөн тасартлаа халуун агаарт түлэгдэж шалзарсан байх тул хүүр болгоны дэргэд нүх малтан өнхрүүлж хийгээд булшилцгаав.

Энэ нутгийнхан улаан буудай, арвай болон бусад тариагаа арваннэгдүгээр сард тарьж суулгаад гуравдугаар сарын эхээр ургацаа хурааж авдаг. Жимс ногоо мөн ялгаагүй энэ л хугацаанд болж боловсорч гүйцдэг. Үүнээс хойш ямар нэгэн тариа будаа, жимс ногоо хаана ч үлдээлгүй хурааж авсан байдаг. Харин хасарвааний дал модны үр жимс тавдугаар сард боловсорч гүйцдэг. Тариа будаа, жимс ногоо тарих, ургац хураах хугацаа ахархан байгаа нь ургамал ногоог хатаж хорчийтол түлж орхидог улайдам халуун эхлэхээс өмнө амжуулдагт учир нь байгаа юм. Бас нэгэн онцлог сонин зүйл гэвэл энэ нутгийнхан усан онгоцоо давирхай болон бусад ус халддаггүй зүйлээр шавж чигждэггүй, харин нэгэн төрөл загасны тосоор тосолж орхидог.

Энэ нутгийн хэн нэгэн нарт ертөнцөөс халин одвол маш сүртэй, урт удаан хугацаагаар уй гашуу болон эхнэр хүүхэд, төрөл төрөгсөд нь ойр орчноо цочиж доргитол уйлан хайлах авай. Ийм уй гашуу бүтэн дөрвөн жил үргэлжлэх бөгөөд дор хаяж өдөрт нэг удаа цугларан цурхиртал уйлж хайлцгаана. Энэ газар үхэл хагацал үргэлжийн дагуул мэт байн байн тохиолдох тул онцгой оршуулга, гашуудал гэхээр юм хийдэггүй боловч үхэж үрэгдэгсэдийнхээ хойноос их дуугаар уйлж гашуудана. Тэр ч байтугай ийм уй гашуу хөгжөөн, уйлж хайлахад мэргэжсэн, хөлсний уйлаач бүсгүйчүүд байдаг билээ. Энэ хотын сонин гэвэл иймэрхүү зүйлс байна даа.

Энэтхэгийн тухай хойно тусгайлан өгүүлэх тул энэ бүлэгт тэр талаар яриа хөөрөө өдөөлгүй орхиё. Одоо би умар зүгт эргэн тэнд орших улс орны тухай өгүүлсү. Үүний тулд арай өөр замаар дээр бидний ярилцсан Керман хотоо дайран өнгөрөхөөс өөр арга байдаггүй билээ. Дөнгөж саяхан орхиж гарсан Руемедан Ахмад хан маань Керманы ханы хараат албат гэдгийг бүү мартаарай.

Хормузаас Керман орох зам нэгэн сайхан тал хөндийг туулан өнгөрөх бөгөөд энэ нутагт хүнс тэжээл, хоол унд элбэг дэлбэг. Мөн газар дороос ундрах халуун рашаан, халуун усанд орох газар хааяагүй. Ятуу шувууны мах элбэг бөгөөд хямд. Төрөл бүрийн үр жимстэй мод болон хасарвааний дал мод газар сайгүй ургана. Улаан буудайн талх нь жигтэйхэн гашуун бөгөөд давслаг сураагүй хүн бол идэх аргагүй. Энэ нь хөрсний ус нь давстай халуун байдагтай холбоотой билээ. Дээр миний ярьсан халуун устай усанд ордог угаалгын газар нь хавар болмогц нээгдэх бөгөөд элдэв өвчин ялангуяа хамуу анагаахад нэн сайн.

Одоо би умар зүгт орших улс орны тухай яриагаа эхэлье. Керманаас гарсан аянчин жинчин, аялагсад долоо хоногийн турш сэтгэл жихүүцэм аглаг зэлүүд ус, ургамалгүй хээр талыг туулан гатална. Энэ газар чухам юутай адил төстэйг би та бүхэнд дүрслэн өгүүлсү. Эхний гурван хоногийн замд гол горхи, урсгал ус хаана ч үл үзэгдэнэ. Зам гудас таарах тогтмол ус нь нов ногоон өнгөтэй, уухын аргагүй давслаг гашуун тул хэн ч ууж эс чадна. Энэ уснаас нэг

балга амсвал дараа нь арван удаа суулгаж гүйлгэнэ. Эндхийн давс мөн ялгаагүй нэг долоох буюу хазах төдийд л гүйлгэж суулгаж эхэлнэ. Ангаж цангахын эрхээр энэ уснаас уусан морь мал ялгаагүй гүйлгэж эхэлнэ. Энэ гурван хоногийн аяны замд нэг ч айл амьтан, тосгон суурин таарахгүйгээр барахгүй амьтай голтой нэг ч амьтан үл үзэгдэх бөгөөд арга ч үгүй юм энд уух ус, идэх хоол хаанаас ч эрээд олдохгүй.

Гурван өдөрчийн урт замыг туулсны эцэст газрын гүнээс ундрах сайхан тунгалаг, цэвэр ус таарна. Зарим газар нь усны урсгалд идэгдэн үүссэн агуй, хонхор элбэг тааралдах бөгөөд тэр газраар хөрсний ус газар доогуур шурган орно. Элбэг дэлбэг цэвэр устай энэ газар аянчин жуулчид амран, адуу малаа амрааж алжаал ядаргаагаа тайлна.

Эндээс цааш бас дөрвөн хоногийн турш мөн түрүүчийн адил ус, ургамалгүй, илжигнээс өөр амьтан амьдардаггүй зэлүүд цөлийг туулна. Үүний эцэст Керманы ханлигийн нутгаас гарч Ку-банан (Kuh-banan) хэмээх хотод ирнэ.

Энэ бол том хот. Оршин суугчид нь Магометийг шүтэн мөргөнө. Энд төмөр, ган, ширээсэн болд их элбэг төдийгүй дархчуул нь ган төмрөөр маш үзэмж чанартай том толь хийнэ. Тэд мөн цайрын исэл гаргаж авах бөгөөд тэр нь нүдэнд түрхдэг сайн чанарын гавар болдог бөгөөд сподиум хэмээх нүүрс гаргаж авдаг. Эдгээрийг хэрхэн яаж гаргаж авдгийг товчхон тайбарлая. Хүдрийн судалтай газрын хөрсийг хуулан авч дээд амыг нь төмөр тороор тагласан пийшинд овоолон дор нь их гал өрдөнө. Тэрхүү овоолсон шороо шатахдаа гаргах уур утаа нь төмөр торонд наалдан хуримтлагдсаныг нь цайрын исэл гэх ба зуухны ёроолд тунаж хоцорсон үнс нүүрсийг нь сподиум гэдэг. Ингээд бид цаашдынхаа аяллыг үргэлжлүүлье. Аялагчид, жинчин-худалдаачид Кух-бананыг орхин цаашаа найман хоногийн турш аялан ус ургамалгүй элчилгүй их цөлийг туулахад нэг ч мод ургамал таарахгүй, тэндхийн тогтмол шалбааг нь жигтэйхэн давстай гашуун устай. Энэ цөлийг туулахаар зориглосон аянчид уух ус, идэх хүнсээ хүрэлцэх хэмжээгээр нөөцлөн авахаас гадна унаа унашаа ундаалах ус авахад илүүдэхгүй учир нь адуу малдаа цөлийн усыг гурилтай хутган шүүж тунгаагаад өгөхөд дуртай дургүй уруул хүргэх төдий.

Найман хоног аялсны эцэст Тун ба Кайн мужид хүрэх бөгөөд энд хот тосгод олонтой. Энэ муж Персийн хойт хилийн дагуу оршино. Энэ нутагт нэгэн их цэлгэр тал газар буй бөгөөд тэнд Өнчин Мод хэмээх мод ургана, Загалмайтнууд энэ модыг Хуурай Мод хэмээн нэрлэнэ. Тэдгээр мод маш өндөр бас бүдүүн. Навчис нь нэг тал нь ногоон нөгөө тал нь цагаан өнгөтэй. Яг туулайн бөөр модных шиг хушга ургах авч дотор нь ямарч үр, самар үгүй. Тэр мод данги хатуу гүүшин94 мэт шаргал өнгөтэй. Тэр модны эргэн тойрон зуун бээрийн тойрогт өөр мод ургадаггүй, харин нэг талд нь арван бээрийн тэртээд өөр модтой. Энэ талд Сулхарнай хаан Персийн Дарий хаантай тулгаран байлдсан тухай домог яриаг нутгийн иргэд хөөрөлдөнө. Эргэн тойрны хот тосгод чанар сайнтай эд бараагаар элбэг дэлбэг, цаг агаар нь хэт халуун биш мөн хэт их хүйтэрдэг ч үгүй тул хүн, амьтанд маш таатай тохиромжтой. Хүмүүс нь бүгд Магометийг шүтэж мөргөнө. Тэндхийн хүмүүс тун гоолиг цэвэрхэн, ялангуяа бүсгүйчүүд нь гол шиг үзэсгэлэн төгс төрцгөөсөн буй.

Одоо бид аяллаа цааш үргэлжлүүлэн Мулехэт нутгийн тухай өгүүлсү. Мулехэт гэдэг нь Сарацинаар “буруу номтон” гэсэн утгатай бөгөөд тэр газар нутгийг Шейх буюу “Уулын эзэн” хэмээгч бурангуй нэгэн эзэгнэн захирч байдаг билээ. Уулын эзний түүх намтарыг би бас

Марко гуайгаас өөр бусад олон хүнээс дуулж сонсож байсан, энэ бүхнээ одоо та нарт өгүүлсү.

Шейх буюу Уулын эзний нэрийг нутгийн хэлээр Алаодин хэмээнэ. Тэр хоёр их өндөр уулын хөндийг эзэгнэн хорвоод хосгүй баян дэлгэр, төрөл бүрийн жимс жимсгэнэ үргэлжид дэлгэрч байдаг цэцэрлэгтэй, тэр цэцэрлэг дотроо алт эрдэнэсээр чимж гоёсон баян тансаг орд харштай, мөн тэр цэцэрлэгтээ дөрвөн цорготой оргилуур байгуулсны нэгнээс жимсний дарс, нөгөөгөөс нь сүү, гуравдахиас нь зөгийн бал, дөрөвдэхээс нь ус гоожин урсах авай. Тэдгээр орд харшид гол шиг гоо үзэсгэлэнтэй эмс охид уран яруу хөгжим эгшилүүлэн, уян налархай бүжиг наадан, уянгат сайхан дуу дуулан хэн хүний сэтгэл оюун, сэрэл мэдрэмжийг эзэгнэн эдлүүлнэ. Энд ирсэн эрчүүд, залууст энэ бол жинхэнэ диваажин гэж ухаан санаа, ой санамжид нь шингэтэл ойлгуулна. Магометийн номлол сургаалд өгүүлэхдээ: Диваажинд хосгүй үзэсгэлэнт эмс охид чиний хүссэн бүхнийг гүйцэтгэж, жимсний дарс, зөгийн бал голын устай зэрэгцэн урсдаг, гэж Сарацин хүний зүрх сэтгэлийг эзэмдэн эрхшээхийн тулд Магометийн номлол сургаалд өгүүлснийг Уулын эзэн Сарацин нутгийн газар шороон дээр амилуулан босгосон учир лал шүтлэгтэн Сарацин нар үүнийг үнэнхээр Диваажин гэсэн итгэл үнэмшлээр сүслэн биширдэг байжээ. Амиа золиослох алуурчин болох хувь тавилантай залуус, эрчүүдээс өөр хэн ч энэхүү Диваажингийн цэцэрлэгийн босгыг хэзээ ч алхаж байсангүй. Диваажингийн цэцэрлэгт орох замыг хаасан маш бат бэх, хүчирхэг хамгаалалттай цайз орших бөгөөд амьд амьтан түүнийг гэтлэн давах боломжгүй, диваажингийн цэцэрлэгт орох өөр зам байхгүй билээ. Энэ орны арван хоёроос хорин насны залуу эрчүүдийг уулын эзэн өөрийнхөө нөлөө хараанаас гаргалгүй хянаж, залж байх агаад тэд нар бол уулын эзний хүн-зэвсэг билээ. Эдгээр залуус зөнч Магометийн номлол сургаалд өгүүлсэн Диваажин энд байдаг гэдгийг анир сургаар олж сонссон төдийгүй тэрхүү диваажин энд оршдог гэдэгт үнэн санаанаасаа итгэдэг байжээ. Одоо бид хэрхэхийг сонссугай.

Уулын эзэн эдгээр эрчүүд залуусаас дөрвийг, арвыг заримдаа бүр хорийг сонгон авч Диваажингийн цэцэрлэгтээ оруулна. Энэ бүхэн зөвхөн түүний хүсэл тааллаар болно. Тэдгээр залуусыг оронгуут сайхан ундалж унтуулах агаад тэднийг унтаагаар нь Диваажингийн цэцэрлэгт хүргэж орхино. Тэнд орсон залуус сэрэнгүүтээ бидний дээр өгүүлсэн баян тансаг орчны дунд байх агаад Диваажинд ирчихэж гэдэгтээ хэн ч огтхон ч эргэлздэггүй байна. Эргэн тойрон гол шиг гоолиг охид бүсгүйчүүд тэднийг асран халамжилж хүссэн бүхнийг нь үг дуугүй гүйцэлдүүлнэ. Ингэж эдгээр эрчүүд залуус дутаж гуцах, эрж хайх зүйлгүй жаргал цэнгэлдээ умбан суухаас өөр хүсэх мөрөөдөх зүйлгүй болдог ажээ.

Ийм үед уулын эзэн улам ч өгөөмөр, шударга шулуун аашлан өглөг буяны эзэн зөнч өөрөө гэдгийг уулаар нутаглах энгийн иргэдэд ухааруулан итгүүлнэ. Хэн нэгнийг алж устгах санаагаа гүйцэлдүүлэхээр алуурчин илгээхийн өмнө хэнд, ямар тунгаар мансууруулах эм уулгахаа өөрөө тохируулах агаад алуурчин болох хүнийг унтаагаар нь түүний ордонд хүргэж орхино. Мансууран унтагсад сэрэнгүүтээ хаана ирснээ ойлгож ядан гайхширч, Диваажиндаа эргэж очихын мөрөөдөл хүслэн болно. Тэгээд тэд зөнч гэж итгэн шүтсэн Уулын эзний өмнө мөргөн сөхөрч тэднийг диваажинд буцаахыг хүсэн мөргөнө. Уулын эзэн тэднийг хаанаас ирсний нь асуухад “диваажингаас” гэсэн буцаж очихын горьдлого мөрөөдөл дүүрэн хариуг сонсоно, тэд ч диваажин гэдэг юу болох тэнд хэрхэн жаргал цэнгэлдээ умбаж байснаа нэгд нэгэнгүй тоочих бөлгөө. Тэдний өгүүлэхийг сонсож суугаа Диваажинд очиж үзээгүй эрчүүд, залуус тэнд очихын мөрөөдөл хүсэлдээ автан гуниж гутрах төдийгүй аль болох хурдан төрөл

арилжиж тэрхүү диваажинд очихыг мөрөөднө.


Уулын эзэн хэн нэгэн хаад, ноёд, язгууртан дээдсийг алж устгахынхаа өмнө хамгийн шилдэг алуурчнаа сонгох үүднээс туршин шалгах аллага үйлдүүлнэ. Тэр сонгон авсан алуурчдаа хөрш зэргэлдээх нутаг орны тийм газар очоод тэр гэдэг хүнийг алчихаад ир гэж илгээнэ. Тэдгэр алуурчид эргэлзэх тээнэгэлзэх зүйлгүй, эргэцүүлж бодох ухаангүй эзнийхээ зарлиг тушаалыг үг дуугүй биелүүлнэ. Тэдгээр алуурчид аллага үйлдэх явцдаа зарим нь баригдан цаазлуулна, зарим нь амь зулбан зугтаж эргэн ирнэ. Эргэж ирсэн алуурчид эзнийхээ тушаал зарлигийг хэрхэн яаж биелүүлснээ нэгэд нэгэнгүй тоочин тайлагнах бөгөөд эргэж ирэгсэдэд зориулан том найр дайллага хийнэ. Уулын эзэн тэдний хэн нь түүний тушаал зарлигийг хэрхэн яаж биелүүлснийг тов тодорхой мэдэж байдаг байсны учир нь аллагад илгээсэн алуурчин бүрийн хойноос тэдний үйл хөдлөл бүрийг тагнан ажиглах туршуул илгээдэг байжээ. Тэгээд алахаар зорьсон хаад ноёд, язгууртан дээдэс рүү алуурчин илгээхийнхээ өмнө алуурчинтайгаа уулзан би чамайг диваажинд илгээхийн өмнө чи тэр нутгийн тийм гэгч хүнийг алчихвал амьд үхсэн алин боловч чи диваажинд очно гэж итгүүлдэг байжээ. Ийм зарлиг тушаалыг тэдгээр хүмүүс маш дуртай хүлээн авч, тэднийг аль болох хурдан диваажин руу илгээж өгөхийг гуйцгаан аллагаа үйлдэхээр явцгаана. Уулын эзний алахаар товлосон нэг ч хүн амь хэлтрээгүй юм. Цаг бусын үхлээс зайлахын тулд олон олон хаад ноёд, язгууртан дээдэс уулын эзэнтэй найрсаг дотно харилцан түүнтэй нөхөрлөхийг эрхэмлэнэ. Тэр үед тэндхийн улс үндэстэн нэгдэн нягтарч чадахгүй өөр өөрийн ашиг сонирхолд хөтлөгдөн хэсэг бүлгээрээ саланги тусгай амьдарч байсан нь энэ аймшигт аллага таллагыг улам ч хөхүүлэн өөгшүүлдэг таатай хөрс нь болж байжээ.

Дөнгөж саяхан би та нарт уулын эзэн алуурчны тухай өгүүллээ. Одоо хэн түүнийг хэзээ, хэрхэн устгасан тухай өгүүлбэ. Уулын эзэн түүний арга барилаар сургаж хүмүүжүүлсэн хоёр Шейхийг сонгон авч нэгийг нь Дамаска хотын ойролцоо, нөгөөг нь Курдистанд суулгасан байдаг. Одоо би та нарт түүнийг хэрхэн хөнөөсөн талаар ярья. Энэ явдал манай Христ бурхан төрсний 1262 онд болсон бөгөөд үүнийг Левантийн тартаруудын их эзэн Хүлэг хаан хийсэн юм. Хүлэг хаан уулын эзний үйлдэж байдаг аймшигт бузар аллагын талаар тодорхой мэдээ мэдээлэлтэй болмогцоо түүнийг хөнөөн устгах нь зөв гэдэгт огтхон ч эргэлзээгүй билээ. Тэгээд Хүлэг хаан өөрийн нэгэн жанжнаар удирдуулсан хүчирхэг ангийг түүний эсрэг илгээн бүтэн гурван жилийн турш түүний бэхлэлт цайзыг эзлэн авч чадаагүй боловч тэднийг бүслэн хааж чаджээ. Хэрэв тэдэнд уух ус, идэх хоол хүрэлцээтэй байсан бол монголчууд энэ цайзыг хэзээч эзлэн авч дийлэхгүй байв. Гуравдахь жилийн шувтаргаар тэдний ус ундаа, хүнс хоол барагдан цайз эзлэгдэв. Ингэж монголчууд уулын эзэн Алаодинийг буулган авч бүх эрчүүдийн нь хамт цаазлан хороожээ. Тэр цагаас хойш иймэрхүү уулын эзэд алуурчид дахин үүсэж буй болоогүй бөгөөд тэдэнтэй хамт тэдний бузар үйл, аллага таллага булшилагдан үгүй болсон. Одоо бид яриагаа өөр зүгт хандуулья.



## Хоёрдугаар бүлэг

### Катай орох замд



Энэхүү цайзыг орхин одох аянчид өвс ногоо халиуран найгаж, ус горхи хоржигнон урссан, жимсний модоор битүү хучигдсан намхан уул толгодтой, дэлгэр сайхан бэлчээр бүхий хөндий талыг туулан аялах бөгөөд энэ талд дутах гуцах юм огт үгүй сайхан нутаг орон ажээ. Энд хуарагнан саатах цэрэг армийнхан ус бэлчээр тэгш, хүнс тэжээл арвин, айван тайван энэ газраас ховхорч хөдлөх тун дурамжхан байдаг гэнэ. Энэ нутаг нэг захаасаа нөгөө захаа хүртэл бүтэн зургаан өдөрчийн газар бөгөөд энд хот балгад, тосгон суурин олонтой, хүмүүс нь Магометийн шашин шүтнэ. Аялагсад замдаа зарим газар тавь, жаран бээр үргэлжлэх ус ундаа, ургамал өвс огт үгүй цөлийг туулна. Аялагсад өөрсдөө уух усаа авч явах тул мал адгуусаа цөлийг туулж усанд хүртэл усалдаггүй байна.

Зургаан хоногийн аяны төгсгөлд Шибарган (Shibarghan) хэмээх нэгэн элбэг баян хотод хүрэлцэн ирнэ. Энэ хотод дэлхийн хамгийн амттай болов уу гэмээр амтат гуа асар их тарина, тэр нутгийнхан амтат гуагаа сур мэт нарийхан зүсэж наранд хатааж борцлох агаад тийн борцолсон амтат гуа нь зөгийн балнаас ч илүү чихэрлэг амттай болдог. Ийнхүү хатааж борцолсон амтат гуагаа хөрш зэргэлдээх орнууддаа их хэмжээгээр худалдана. Энэ нутагт төрөл бүрийн араатан, жигүүртэн элбэг тул хааяагүй ан аваар хөөцөлдөнө. Одоо бид

Шибарган хотыг орхин одож, би та бүхнийг Балх (Balkh) хэмээх хоттой танилцуулъя.

Балх бол хээнцэр тансаг, том хот билээ. Энэ хот одоогийнхоосоо хээнцэр тансаг, том хот байсан боловч Тартарууд болон бусад харийн булаан эзлэгчид байн байн түрэмгийлэн эзэлж, цөлмөн хоосолсоор байгаад үлдэж хоцорсон нь энэ буюу. Энэ хотод урьд нь уран гоё хийц загвартай гантиг чулуун орд, харш олон байсан хэдий ч одоо бол тэдгээр сайхан гантиг чулуун орд харшаас нурж унасан балгас л үлджээ. Энэ нутгийнхний домог яриагаар бол Сулхарнай хаан энэ хотод Дарий хааны охин гүнжтэй гэрлэж, хуримлаж байсан түүхтэй гэнэ. Энэ хотынхон Магометийг шүтэж мөргөцгөөнө. Балх хот нь Перс улсын зүүн, зүүн хойт хил дээр оршино.

Балхыг орхин Талихан (Talikh) хэмээх хотыг зүглэн гарав. Энэ газар Балхаас гараад зүүн, зүүн хойт зүгийн завсар чигийг барин арван хоёр өдөрчийн газрыг туулахад зам зуурт нэг ч айл амьтан таарсангүй, учрыг сонсвол энэ нутгийг дээрэмдэн түйвээсэн дээрэмчид, булаан эзэлгчдээс ард иргэд нь дүрвэн зайлж ууланд шивээлэн суусан гэх. Энэ нутаг оронд ус ундаа хангалттай, араатан жигүүртэн элбэг төдийгүй арслан ч байх юм. Арван хоёр өдөрчийн газар туулахад хүнд идүүлэх хүнс байтугай адуу малаа тэжээх өвс тэжээл олдохгүй тул хүмүүсээ хооллох хүнс, хоол, адуу малаа тэжээх өвс бордоогоо авч явахаас өөр аргагүй. Арванхоёр өдөрчийн урт холын замыг туулан эцэст нь Талихан хотод хүрэлцэн ирэх бөгөөд хотод тариа будаа худалдаж борлуулдаг маш том захтай. Хотын өмнөд этгээдэд орших өндөр өндөр уулс нь цул давсан уулс болой. Эргэн тойрон гучин өдөрчийн алсаас худалдаачид наймаачид, аянчин жинчин, зүсэн зүйлийн хүмүүс хорвоод хосгүй чулуун давс авахаар тасралтгүй цуврана. Давс нь маш хатуу зөвхөн бөх гэгчийн хүрз, зээтүүгээр хагалж, эмтэлж авах бөгөөд дэлхий даяараа хэрэглэвч галав юүлтэл өлхөн хүрэлцэхээр нөөцтэй билээ. Мөн ойр тойрны ууланд нь гүйлс, газрын самар ихээр ургах агаад түүнийгээ хөрш зэргэлдээх улсууддаа худалдана.

Энэ хотоос явж байгаа аянчид жинчид зүүн, зүүн хойт зүгийн завсар баримжаалан гурван хоног аялсны дараа үр жимс, тариа будаа, усан үзэм ургасан, хүн ам нягт суурьшсан сайхан оронд очно. Оршин суугчид нь Магометийг шүтнэ. Хүн ард нь хэрцгий бүдүүлэг, дээрэмчин төрхтэй. Ихэнх цагаа дарс ууж нөгцөөнө. Маш сайхан, хатуу дарс нэрдэг бөгөөд хүмүүс нь ч дарс ууж эцэс төгсгөлгүй архи дан согтуурна. Тэр нутгийнхан арван төө орчим олсоор толгойгоо ороон тогтоохоос өөр хувцас хунар, малгай өмсдөггүй. Тэд бүгд маш чадварлаг анчид, загасчид билээ. Харин алсан ангийнхаа арьсаар хувцас, гутал хийж өмсөнө. Ан амьтны арьсыг хэрхэн элдэж зөөллөхөө тэд сайн мэднэ.

Тэндээс гурван өдөрчийн зайд Ишхашам (Ishkasham) хэмээх хот зам гудагс таарах агаад тэр хотыг нэгэн гүнтэн захиран сууна, харин эндхийн бусад хот суурингууд нь цөм ууланд оршино. Ишхашам хотын төв дундуур их устай гол урсаж гарна. Энэ нутагт үхэр зараа элбэг. Анчид үхэр зарааг нохойгоор бариулан агнах бөгөөд нохой тавимагц үхэр зараа атиран арьсан дотроо нуугдахад түүний их бие, нуруу бөөрнөөс арзайн сэрвийх зүү шиг хурц өргөс нохдыг хатгаж шархдуулах нь олонтой. Ишхашам хот мөн тийм нэртэй, хүмүүс нь өөрсдийн гэсэн өвөрмөц хэлээр ярьдаг томоохон мужийн төв билээ. Хөдөө нутгийнхан нь уулаар мал, сүргээ адуулан амьдардаг малчид бөгөөд шаварлаг ууландаа газар ухаж гаргасан том том агуйд амьдардгаараа ихэд зард гарчээ.

Аялагсад, аянчид жинчид, энэ хотоос гарч гурван өдөрчийн зам туулахдаа орох орон, идэх

хоол, уух устай таарахгүй тул замд хэрэглэх хүнс, ус, орон майхнаа өөрсдөө зэхэж авч явдаг, харин морь малдаа идүүлэх өвс ногоо бол элбэг. Гурван хоногийн аяны сүүлчээр Бадахшан (Badakhshan) мужид хүрнэ. Одоо би түүний тухай та бүхэнд өгүүлсү. Бадахшан буюу Балашан нутгийн оршин суугчид нь Магомтийг шүтдэг, өөрийн гэсэн өвөрмөц хэл яриатай. Бадахшан бол нэлээд томоохон ханлиг бөгөөд газар нутаг нь арванхоёр өдөрчийн урт сунаж тогтсон, Персийн их хаан Дарийн охин болон Сулхарнайн удам угсааныхан үе залгамжлан захиран сууцгаана. Бадахшан нутгийн хаад нь одоо болтол Их Александрийн нэр, дурсгалыг мөнхжүүлэн хаадаа Zulkarnein (Сулхарнай) гэж нэрлэх агаад, манайхаар бол Александр гэсэн нэрийн Сарацин хувилбар билээ.

Бадахшан нутагт балашийн бадмаараг хэмээх маш гоё үнэт чулуу олзворлодог. Энэ чулууг мөнгөний судал хөөж ухдаг уурхайчид шиг асга хадтай ууланд ухсан хонгилоор орж газрын гүнээс олзворлодог. Балашийн бадмаараг анх Шигхинан уулнаас олдсон гэдэг. Балашийн бадмарагыг зөвхөн хааны тушаал зарлигийн дагуу, зөвхөн түүний хэрэгцээнд зориулан олзворлодгийг та бүхэн анзааран санатугай. Хааны зарлигийг гүйцэлдүүлж буй албат боолоос өөр хэн боловч бадмаараг чулууг ухах, олзворлох боломжгүй бөгөөд хэрэв тийм чулуун зүрхтэн гарсан байвал дор нь цаазлан хороож авсан чулууг нь хааны санд хураана. Бадмаараг чулууг хаан өөрийн ноёд түшмэдэд шагнал болгон, харь орны хаад, хан хүү болон язгууртан дээдэст сайн хөршийн сайхан санааны бэлэг болгон заримыг нь төлбөр гувчуур болгон илгээхээс гадна алт, мөнгөөр арилждаг билээ. Энэ нь балашийн бадмаараг чулууг үргэлжид ховор нандин, үнэ цэнэтэй эрдэнэс байлгах үүднээс хийж байгаа хорио цээр билээ. Хэрэв бадмарагыг хэн хүнгүй олзворлож, гадаад дотоодын зах зээлд хязгаар хориогүй арилжаад эхэлвэл үнэ цэнэ нь унаж, ховор нандин эрдэнэс байхаа болино. Ийм учраас бадмаараг чулууг олзворлох, гадаадад зарж борлуулах явдлыг хааны зарлигаар хорьж хаасан бөгөөд зөрчвөл зөвхөн амьтай ярих хүнд ял, торгууль ногдуулдаг билээ. Мөн энэ нутгийн өөр нэгэн уулнаас дээд зэргийн чанартай оюу номин олборлодог.

Эдгээр үнэт чулуу нь уул хаданд судал хэлбэртэй тархан оршино<sup>95</sup>. Энд мөн яндашгүй арвин нөөцтэй мөнгө, зэс, тугалгын орд бий билээ.

Энэ бүс нутаг, энд орших улс гүрэн маш эртнийх. Энд сайн үүлдрийн сайхан адуу үржүүлдгийг бид мэдэх билээ. Морьд нь омголон шаламгай, морьдоо огт тахалдаггүй уул хаданд торох юмгүй давхина. Эндхийн адууг Сулхарнай хааны Буцефал азарганы угшилтай гэцгээх агаад, анх түрүүн тэр азарганы гишгэсэн гүүнээс магнай дээрээ жижигхэн эвэртэй унага төрж бусад нь түүнээс удамшин үржжээ. Энэ үүлдрийн адуу нь бүгдээрээ хааны нэгэн авгын эзэмшилд байдаг байсан бөгөөд тэр адуунаасаа хаанд өргөхийг татгалзсан учир түүнийг цаазлан хороожээ. Үүнд өширхсөн гэргий нь тэр үүлдрийн бүх л адууг устгасан тул үр үндэс нь бүрэн мөсөн мөхжээ. Эндхийн ууланд биеийн галбир төрх нь шунган нисэхэд нэн тохиромжтой шунгаа болон саарал толгойт шонхор нутаглана. Ан араатан, жигүүртэн шувууд элбэгтэйгээс гадна аргал угалз ихтэй. Аргал угалз нь дөрвөн зуу, зургаан зуугаараа сүрэглэх бөгөөд авлаж алах нь их боловч сүргийн тоо, толгой хорогдож барагдахгүй. Сайн чанарын улаан буудай, хожгор арвай их тарьж сайн ургац хураана. Харин чидун жимсний тос огт байдаггүй боловч гүнжид болон самраас тос гарган авцгаана.

Энэ ханлигийн газар нутаг нь өндөр уулсын гүн нарийн хацал, сархиаг олонтой байгалиасаа

заяасан хэрэм цайз мэт тул ард иргэд нь харийн дайсны халдлага довтолгооноос нэг их айж түгшдэггүй. Тэдний хот, суурин нь өндөр өндөр уулсын оргил магнайд орших тул хүрч очиход нэн төвөгтэй. Эндхийн уулс нь маш өндөр тул тэдний оргилд гарахын тулд ургахын улаан нарнаас эхлээд үдшийн цагаан гэгээ тасартал бүтэн өдөр авирах болдог. Харин уулсын оргил дээрээ уужим өргөн талбайтай тэнд өтгөн шигүү өвс ногоо халиуран, мод ургамал жигдрэн, уулсын оргилоос урсан хад асган дундуур шуугин урсах гол горхитой байна. Эдгээр гол горхинд хулд болон бусад ховор үүлдрийн загастай. Уулын оргилийн агаар нь гайхамшигтай цэвэр тунгалаг төдийгүй элдэв эмгэг өвчнийг эмчилэн эдгээх увдистай, уулын хөндийн хот сууринд амьдардаг хүмүүс элдэв өвчин хуучнаа эмнэж эдгээхээр энд ирж хэдхэн хоноход л эв эрүүл, сав саруул болдог билээ. Үүнийг эрхэмсэг Марко гуай өөрийнхөө биеэр туршиж үзсэн<sup>96</sup> тул гарцаагүй үнэн ажээ. Эндхийн хоёр, гурван ууланд их хэмжээний хүхэр хуримталсан байх бөгөөд хаврын цас мөс хайлан гол горхи урсахад тэдгээр нь хүхэр шингэсэн рашаан болой.

Эрчүүд нь толгой дараалан мэргэн харваачид, анчид байх агаад, голдуухан ангийн арьсан хувцас хунартай, энд даавуу шуувуу маш ховор зэвэр, нүдний гэм л гэсэн үг. Язгууртан охид бүсгүйчүүд нь бүгд өмд өмсөх бөгөөд энэ талаар би та бүхэнд танилцуулъя. Зарим нэгэн бүсгүйчүүд нь өгзөг, гуяа махлаг мариатай харагдуулахын тулд зуун аршин хөвөн даавуугаар мянган нугалаастай хэлхэгэр өмд хийж өмсөх бөгөөд энэ нутгийн эрчүүд бөгсөөрөө махлаг тарган бүсгүйчүүдийг үзэсгэлэнтэй гоё гэдэгтэй холбоотой юм.

Бадахшанаас өмнө зүгт арван өдөрчийн газар Пашай (Pashai) хэмээх улс оршино. Хүмүүс нь хүрэн бор өнгийн арьстай, өөрсдийнхөө өвөрмөц хэл аялагатай, онгон шүтлэгтнүүд билээ. Тэд нар илбэ шидийн урлаг, ухааныг сайн эзэмшсэн хүмүүс. Эрчүүд нь үнэт чулуун шигтгээтэй алт, мөнгөн ээмэг, бугуйвч зүүцгээнэ. Тэд бүгд их залирхуу муу арга мэхтэй хүмүүс байдаг бөгөөд үүнийгээ хурдан шаламгайн шинж гэх. Цаг агаар нь маш халуун. Хүнсэндээ тутарга голдуу хэрэглэнэ. Пашай гэж нэг иймэрхүү нутаг орон байна. Одоо та бид Пашайгаас зүүн өмнө зүгт долоон өдөрчийн газар орших Кашмир (Kashmir) орноор зочилоё.

Кашмирийн хүмүүс мөн ялгаагүй онго шүтлэгтнүүд, мөн өөрийн гэсэн өвөрмөц хэл, яриатай. Гайхаж хачирхууштай нь тэд шившлэг тарнийн ид шидийг гаргууд сайн эзэмшсэн байдаг. Тэд шившлэг тарнийн хүчээр онгод шүтээнүүдээ яриулж чадна, цаг уурыг өөрчилж, түнэр харанхуйгаар бүхнийг бүрхэж чадна. Энэ бүхнийг нүдээрээ харж, биеэрээ туулаагүй хэн боловч тэдний шившлэг тарнийн ид шидэд итгэн үнэмшихэд бэрхтэй билээ. Тэд нар бол эртнээс нааш онгон шүтээнийг тархаан дэлгэрүүлсэн багш нар гэдгийг би мэдэж байсан бөгөөд онгод эндээс л тархан дэлгэрчээ.

Энэ нутгаас Энэтхэгийн далайд хүрэх замтай. Хүмүүсийн царай зүс нь хүрэн бор өнгөтэй бас туранхай. Бүсгүйчүүдийн арьс нь мөн л хүрэн бор өнгөтэй боловч бие галбир нь тэгш сайхан, хөдөлгөөн нь уян налархай. Хоол хүнс нь мах, тутарга голлоно. Тэр нутгийн цаг агаар нь намуун тогтуун эрс тэс халуун хүйтэн үгүй, хот тосгод олон, газар нутаг нь ой шугуйтай хөвч хангай, хуурай элсэн цөлийн аль аль нь бий, улс гүрэн нь хүчирхэг, харийн дайсны халдлага довтолгооноос нэг их эмээж айдаггүй.

Кашмир нь өөрийн хаантай, биеэ даасан тусгаар улс, хаан нь шулуун шударга хууль цаазыг эрхэмлэнэ. Тэд өөрсдийн даяанч нартай. Тэдгээр даяанчид нь аглаг зэлүүд газар, урц

овоохойд сууж бясалгал үйлдэх бөгөөд аливаа идээ, ундаагаа хязгаарлан мацаг санваараа сахин мөрдөнө, тэдний шашин мөргөлд харш бүхий л нүгэл хилэнцийг тэвчин, ариун ёсыг сахина. Нутгийн хүмүүс тэдгээр даяанчдаа гэгээрсэн хутагт, хувилгаад гэж үзэцгээнэ. Даяанч нар урт насална, үүнийгээ тэд өөрсдийн онгон шүтээндээ гүнээ сүсэглэн, ариун санваарыг хэлбэрэлтгүй сахин, нүгэл хилэнцийг тэвчиснийх гэж үздэг. Кашмир газар өөрсдийн сүм хийд, лам хувраг олонтой бөгөөд шашны жаяг ёсоо чандлан сахицгаах бөгөөд лам нарын өмссөн хувцас, үсээ гялайтал хуссан байх нь эгээл доминикан буюу францискан шашны лам нар гэлтэй. Энэ орны эрчүүд нь мал амьтан алж нядлах, цус асгаруулахыг цээрлэн хориглох тул Сарацин юм уу, тэдэнтэй цус холилдсон эрлийзүүд мал амьтан нядалж мах, хоолыг нь бэлтгэх ажээ. Манай нутаг орноос гадаадад гарган худалддаг шүр энэ газар ихээхэн эрэлт хэрэгцээтэй, гүйлгээ сайнтай байх юм.

Бид одоо энэ нутгаас явахдаа замаа цааш нь өмнө зүгт үргэлжлүүлэхгүй<sup>97</sup>, тэгж явбал бид Энэтхэг орчихно, одоохондоо Энэтхэгийн тухай яримааргүй байна. Бид ирсэн замаараа буцаж Бадахшаныг дайран аян замаа үргэлжлүүлэх бөгөөд өөр зам, гарц энд байхгүй билээ. Аялагчид маань Бадахшанаас гарч зүүн-зүүн хойт зүгийг баримжаалан Бадахшаны эзний дүүгийн эзэмшил нутаг болох нэгэн голын хөндийг даган арван хоёр хоног явахад Магометийг шүтдэг, дайнч омгийнхон нутагшин суурьшсан олон хот, тосгод, сууринг дайран өнгөрөв. Арванхоёр хоног аялсны эцэст Вахан (Wakhan) хэмээх нэгэн жижгэвтэр мужид хүрнэ. Энэ мужийн газар нутаг нь хайш хайшаа гурван өдөрчийн газар үргэлжлэх бөгөөд хүмүүс нь Магометийг шүтдэг, өөрсдийн гэсэн хэл яриатай, эрэлхэг дайчин эрстэй. Энэ мужийг захиран суух ноёд дээдэс үгүй, нутгийн ахлагчаа “нопа” гэх бөгөөд энэ нь манайхаар бол “гүн” гэдэгтэй ойролцоо хэргэм бөгөөд тэд бүгд Бадахшаны хааны харьяат албат ажээ. Энэ нутаг зэрлэг ан араатан элбэг, нутгийнхан ан ав хийж араатан жигүүртэнтэй хөөцөлдөх уламжлалтай. Аялагчид маань энэ нутгаас гараад зүүн хойт зүгийг баримжаалан гурван өдөрчийн газар явахдаа өндөр өндөр уул, даваа өөд мацан авирсаар ертөнцийн хамгийн өндөр уулын оргилд гарна. Энэ өндөр уулын оргилоос харахад хоёр уулын хооронд нэгэн сайхан хөндий тал буй бөгөөд дундаа том нууртай, нуурнаас нь их устай гол эх аван урсана. Энэ дэлхийн хамгийн тансаг сайхан бэлчээр энэ хөндийд байх бөгөөд энд идээшлэх ямар ч туранхай мал, адгуус аравхан хоногийн дотор л тарга тэвээрэг авдаг байна. Төрөл бүрийн зэрлэг ан араатан дүүрэн энэ нутагт асар том биетэй аргал угалз нутаглана. Тэдгээр аргал угалзын эвэр нь зургаан төө илүү урт ургах нь энүүхэнд ердийн эвэр нь гурав, дөрвөн төөгөөс богино байх гэж үгүй. Нутгийн малчид эдгээр эврээр хоол ундны аяга, таваг хийх төдийгүй бас малын хашаа хороо барина. Эндхийн чонын тоог баримжаалах аргагүй олон бөгөөд зэрлэг ан амьтныг олноор нь барьж иднэ. Хонь малын болон зэрлэг ан амьтны яс, эвэр, туурай хааяагүй цайран харагдах бөгөөд нутгийн хүмүүс тэдгээр ясаар зам гудсын дагуу овоо босгон аянчин жинчин, зорчигсодод цасаар хучигдсан ууланд замаа олох тэмдэг болгон овоолдог билээ.

Памир хэмээн нэрлэх тэр тэгш тал газрыг арванхоёр хоногийн турш явж тууллаа. Энэ хугацаанд тэр нутагт нэг ч айл амьтан, орон байр тааралдаагүй бөгөөд аялагчид хоол хүнс, ус ундаагаа өөрсдөө ачиж тээж явахаас өөр замгүй билээ. Энэ нутагт жигүүртэн шувуу ч үл үзэгдэхийн учир нь газар нь хэт өндөр бөгөөд их хүйтэн. Газар нь өндөр, агаар нь хүйтнээс болоод асаасан галын дөл дүрэлзэн бадрахгүй, илч дулаан бараг өгөхгүй, өнгө нь хүртэл бүүдгэр, гал дээр чанаж буй хоолны ус нь буцлавч хоол нь түүхийгээрээ л байгаад байх.

Одоо бид замынхаа чигийг жаахан өөрчилж зүүн хойт зүүн зүгийн завсрыг барин аялацгаана. Памирийн талыг туулан гаталсан арван хоёр хоногийн аянаа үргэлжлүүлэн бүтэн дөчин хоног зүүн, зүүн хойт зүгийг чиглэн уулсын хавцал, гүн жалга, огцом налуу хавцгайг мацан давж, олон олон гол горхи гатлан, элсэн цөлийг туулан аялав. Аяны энэ урт холын замд айл амьтан, тосгон суурин, толгой хоргодох байр аль аль нь огт таарч дайралдахгүй зэлүүд хээрээр аялан явсаар Болор (Belor) хэмээх нутагт ирнэ. Энэ нутгийнхан цөм өндөр ууланд амьдардаг, онгон шүтлэгтэн, ангийн арьсаар голдуу хувцас хунараа хийж өмссөн, зэрлэгдүү авир араншинтай базаахгүй хүмүүс байв.

Бид одоо эндээс зүүн, зүүн хойт зүгийг барин Кашгар (Kashgar) муж орохоор хөдөлж байна. Кашгар муж уг нь ханлиг байсан боловч одоо бол Эзэн хааны эзэмшил нутаг, их монгол гүрний нэгэн муж болжээ. Кашгар хот, тосгод олонтой нутаг билээ. Эдгээрээс хамгийн том, нэр гарсан нь Кашгар хот билээ. Энэ хотынхон худалдаа арилжаа, үйлдвэрлэл гар урлал эрхлэн амьдарна. Кашгарт үзэсгэлэн төгс мод цэцэгтэй цэцэрлэгт хүрээлэнгүүдтэй, үр жимс нь дэлгэрэн цэцэглэсэн усан үзмийн тариалантай. Тэнд мөн хөвөн, олс, олсны ургамал арвин ургана. Хөрс шороо нь үржил шимтэй юу ч тарьсан ургаж байдаг. Энэ нутгийн худалдаачид эндээс ертөнцийн дөрвөн зүг найман зовхист аялан өөрсдийн бараа, таваар, эд өлгийг борлуулна.

Эндхийн хүмүүс чамгүй харамч нарийн, амьдрал ахуй нь тийм муугүй боловч идэх, уухдаа ч нарийлана. Энд бас нестор шүтлэгтэн Загалмайтнууд байхаар барахгүй тэд өөрийн гэсэн сүм хийдтэй тэндээ шашныхаа зан үйлийг үйлдэнэ. Нутгийн ард иргэд нь өөрийн гэсэн өвөрмөц хэл яриатай. Газар нутаг нь таван өдөрчийн газар сунаж тогтсон хэлбэртэй. Одоо би эндээс баруун хойт зүгт орших маш том, баян тансаг Самарканд (Samarkand) хотын тухай танилцуулж яриагаа үргэлжлүүлье. Энэ хотод Загалмайтан болон Саранцин нар оршин сууна. Энэ газар нутаг, хот орон, хүн ард нь Их хааны ачийн эзэмшил<sup>98</sup>, захиргаанд байдаг бөгөөд тэр ач нь Их хаантай үргэлж сөргөлцөн дайсагналцаж байх ажгуу. Одоо би та бүхэнд энэ хотод болсон нэгэн гайхамшигт үйл явдлын тухай ярьж өгье. Энэ газар нутгийг болон бусад олон улс орныг эзэгнэн захирагч эзэн, Их хааны ах Цагаадай (Chaghatai) Христийн шашны сахил хүртэж Загалмайн шүтлэгтэн болсон билээ. Самарканд хотын эзэн Цагаадай хаан загалмайн шүтлэгтэн болохыг үзсэн эндэх нутгийн Загалмайтнууд хагартлаа баярлацгаажээ. Тэгээд тэдгээр Загалмайтнууд энэ үйлийг тэмдэглэн Гэгээн Жон Баптистийн дурсгалыг мөнхжүүлэхээр шийдэж хотодоо нэгэн том сүм босгож түүний нэрээр нэрлэв. Сүмийн адрьг тулж байх гол баганын сууринд сарацинуудын шүтдэг нэгэн сайхан том чулууг ивэн суурь болгожээ. Гэтэл Цагаадай хааныг тэнгэрт хальснаас хойш энэ явдалд өширхөж гомдсон сарацинууд уг чулуугаа хүчээр эргүүлж авахаар үгсэн тохирцгоосон байв. Сарацинууд үүнийгээ хялбархан хэрэгжүүлэх хүч, боломжтой байжээ учир нь тэд хүнийхээ тоогоор Загалмайтнуудаас арав дахин олон байлаа. Тэгээд сарацинуудын тэргүүлэгчид гэгээн Жон Баптистийн сүмд ирж сарацинуудын шүтэж мөргөдөг чулуугаа авахаар ирлээ гэж Загалмайтнуудад тулгажээ. Загалмайтнууд бид та бүхний хүссэн бүхнийг өгье! Баганын суурь чулууг бүү аваач, хэрэв чулууг баганын сууринаас сугалан авбал сүм маань нураад унана гэж учирлан учирлан гуйцгаав. Гэвч сарацинууд бидэнд алт эрдэнэс хэрэггүй зөвхөн шүтээн чулуу л хэрэгтэй тул бид ямарч байсан чулуугаа авна гэцгээжээ. Чулууг бүү аваач гэж гуйж гувших нь утгагүй боллоо. Засаг төрийн эрх мэдэл одоо бол Их хааны ачийн гарт байгаа бөгөөд тэр хаан чулууг хоёр хоногийн дотор суллан гаргаж сарацинуудад эргүүлэн өгөхийг

зарлигдан тушаав. Энэхүү тушаал зарлигийг сонссон Загалмайтнууд чухам юу хийх, яах учраа олохыг болив. Гэтэл ид шидийн гайхамшигт үйл явдал тохиолоо. Хоёр хоног өнгөрч суурь чулууг сарацинуудад өгөх өдрийн өглөө чулуунд суурилуулсан сүмийн гол багана бидний эзэн Ийсус Христийн тааллаар чулуунаас гурван тохой өргөгдөн агаарт бат бэх суурилан эгээл чулуу ивээстэй мэт болоход ивээсний чулуу хуучин сууриндаа байж л байлаа. Одоо ч тэр багана агаарт суурилан сүмийн адрыг тулсаар байгаа бөгөөд үүнийг энэ ертөнцөд учирч тохиосон хамгийн их гайхамшгийн нэг гэдэг билээ.

Одоо бид эндээс таван өдөрчийн газар орших Яркэнд (Yarkand) муж орцгооё. Эндхийн оршин суугчдын ихэнх нь Магометийг шүтдэг лал шашинтнууд бөгөөд цөөн тооны Нестор Загалмайтнууд байх. Эд бүгд миний дээр ярьсан Их хааны ачийн албат ард билээ. Эндхийн хүмүүсийн амьдралын эх сурвалж болох хүнс тэжээл хангалттай мөн хөвөн маш ихээр тариална<sup>99</sup>. Энэ газар орны талаар бидний номондоо дурсаж дурьдаад байх онцгой зүйл үгүй тул эндээс зүүн, зүүн хойт зүгт орших Хотон (Khotan) муж орцгооё.

Хотон мужид хүрэхийн тулд найман өдөрчийн зам туулах бөгөөд Их хааны эзэмшил харьяаны нутаг билээ. Оршин суугчид нь Магометийг шүтдэг лал шашинтнууд. Энд хот суурин олон хамгийн хээнцэр тансаг нь мужтайгаа ижил нэртэй нийслэл хот нь билээ. Энэ газар хүнс тэжээл, бараа таваар элбэг хангалуун. Хөвөн маш их тариална<sup>100</sup>. Эндхийн дийлэнх оршин суугчид нь хувийн эдлэн газар, усан үзмийн тариалан, өөрийн цэцэрлэгтэй. Хүмүүс нь номхон дөлгөөн худалдаа, гар урлал эрхлэн амьдрах бөгөөд цэрэг дайны үйлээс хол хөндий билээ.

Эндээсээ бид зүүн хойт, зүүн зүгийг чиглэн таван өдөрчийн газар яваад Пим (Pim) хэмээх мужид хүрнэ. Эндхийн оршин суугчид нь Магометийг шүтдэг лал мөргөлтөн бөгөөд бүгд Их хааны албат иргэд билээ. Энэ мужид хот тосгод олон боловч хамгийн хээнцэр цэмцгэр хот нь мужийн нийслэл Пим хот болой. Эндхийн гол уснаас мана, хас чулуу их хэмжээгээр олдоно. Хоол хүнс элбэг. Хөвөн их тариална. Хүмүүс нь худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал эрхлэнэ. Тэр нутагт нэгэн сонин заншил, уламжлал байдаг талаар ярья. Эр нөхөр нь алс газар одоод хориос илүү хоновол эхнэр нь өөр эрд гарах бөгөөд мөн эр нөхөр нь явсан газраа гэрлэж эхнэр авдаг үүнийг “орон нутгийн хэрэгцээг хангах” гэж нэрлэдэг билээ.

Миний та бүхэнд танилцуулсан муж, нутаг нь Кашгараас Пим хүртэл бүгд Түрэгстаны газар нутаг гэдгийг та бүхэн андахгүй мэднэ биз дээ.

Би та бүхэнд зүүн, зүүн хойт зүгт орших Түрэгстаны Чарчан (Charchan) хэмээх мужийн тухай өгүүлсү. Чарчан нь урьд цагт өгөөмөр баян хөрс шороотой, тариа будаа халигсан баян тансаг нутаг байсан боловч Тартаруудын хөлд чирэгдэн хоосорч үгүйрсэн орон болжээ. Оршин суугчид нь Магометийг шүтнэ. Хот, тосгод олон, гол хот нь Чарчан. Гол горхинд нь мана, хас чулуу элбэг их байх агаад өнгө зүс, чанар чансаа сайнтай тул Катар оронд их хэмжээгээр борлуулан арилжиж чамгүй ашиг олдог.

Хотоноос Пим хүртэл Пимээс энд иртэлх бүх газар, муж сул элсээр хучигдмал, зам харгуй нь цөм элсэн хөрстэй билээ. Эндхийн булаг ус нь шорвог амттай муу устай, хааяа нэг газарт сайхан амттай ариг ус таарна. Энэ оронд харь дайсан халдан довтлоход нутгийн ард иргэд нь гэр, мал, эхнэрхүүхдээ аван хоосон хар нутаг үлдээгээд элсэн цөлийн гүн рүү хоёр, гурван

өдөрчийн газар дүрвэн нүүж зөвхөн өөрсдөө мэддэг ус ундаа, өвс бэлчээртэй газар бүгэн сууна. Тэдний нүүдлийн ул мөрийг салхи, элс хоёр төдхөн арчиж, булаж арилгах тул хаашаа явсныг нь хэн ч олж мэдэх аргагүй болдог. Тэр нутгийнхан дайснаас ингэж дүрвэн нүүж, нуугдан бүгдэг байна. Тэдгээр хүмүүсийг зугтан нүүх үеэр тэдний цэрэг ирж мал сүргийг нь тууж одох тул дайсанд олз болохоор юм юу ч үлддэггүй байна. Тэр нутгийнхан тариа будаагаа хураан авмагцаа дайсны олз болгочихгүй, цэрэг армийнхандаа тонуулчихгүйн тулд тосгон суурин, орон гэрээсээ алс зайдуу цөл дундах агуй, нүхэнд хадгалах бөгөөд хэрэгцээ, хэрэглээнийхээ хэрээр сар сард хүрэх хэмжээгээр зөөж авчирдаг байна.

Чарчанаас гарангуут бүтэн таван хоногийн туршид элсэн манхан дундуур зүтгэн туулахаас өөр замгүй, тэндхийн ус нь муу бөгөөд шорвог, хаа нэгтэй ариг устай булаг таарна, энэ газар нутгийн талаар номондоо бичиж оруулчихмаар гойд сонин зүйл огт үгүй болой. Таван хоног зогсоо чөлөөгүй зүтгэсний эцэст их цөлийн захад буй нэгэн хотод ирнэ. Энэ их элсэн манхан цөлийг туулахаар тэмцэн зориглогсод энэ хотоос л ус ундаа, хүнс хоолоо базааж авдаг байна. Одоо бид эндээс цааш хөдлөн мөн зам зуурынхаа сониныг ч үргэлжлүүлэн өгүүлсү.

Их цөлийн захад орших хотыг Лоб (Lop) хэмээн нэрлэх төдийгүй их цөлийг ч мөн Лобын цөл хэмээнэ. Энэ хот Их хааны эзэмшил нутаг ажээ. Оршин суугчид нь цөм Магометийг шүтдэг лал шашинтнууд билээ. Лобын их цөлийг туулахаар зэхэж буй аялагчид энэ хотод долоо хоногийн турш амарч алжаал ядаргаагаа тайлдагаар барахгүй унаа хөсөгнийхөө адуу малыг амраан хүч таргыг нь сэлбэдэг. Долоо хоног амарсны дараа сарын турш хүн, адгуусаа тэжээх хоол хүнс бэлдэж аваад Лоб хотыг орхин их цөлийн зах руу хөл тавьдаг ажээ. Энэ их цөлийн сунаж тогтсон уртааш нь туулах гэвэл бүтэн жил аялдаг гэнэ, хамгийн нарийн хэсгээр нь хөндлөн туулахад нэг сар аялна. Цөлийн байгаль нь уул, элсэн манхан, тал хөндийгөөс тогтоно. Өвс ургамал үгүй. Аялал эхэлнээс хойш бүтэн хоног илүү яваад устай таарна<sup>101</sup>. Тэр ус нь нэг удаа тавь-зуун хүнийг унаа, хөсөгний нь малтай ундаллахад хүрэлцэнэ. Замдаа бүтэн хоног явж байж дараагийн булаг шандтай таарах бөгөөд тэдгээр булаг шандны гурав, дөрөв нь гашуун, шорвог муу устай, үлдэж буй хорин найман булаг шандны ус нь ариг ариун билээ. Энэ цөлд идэх хоол, уух ундаа үгүй шахам тул араатан, жигүүртэн байдаггүй. Гэвч энд нэгэн хачин сонин зүйл тохиолддогийг та бүхэнд ярьж өгсү.

Миний ярьж байгаа энэ зүйл бол гарцаагүй үнэн юм шүү. Шөнө дөлөөр их цөлийг туулан явах аянчин, жинчин, аялагчдаас хэн нэг нь ачаа хөсгөөсөө хоцрох юм уу, төөрчихөөд тэднийг гүйцэхээр яар ч явахад нь түүнээс холгүй ачаа хөсгийн нь дуу чимээ гарах, заримдаа уг хүнийг нэр усаар нь дуудах ч явдал тохиолдох бөгөөд тэрхүү дуу чимээг даган татагдах аваас дахин хэзээч эргээд зам мөрөө олохооргүйгээр төөрч, сүйрдэг байна. Ингэж хууртагдан төөрч будилсаар амь алдсан аянчин жинчин, аялагсад цөөнгүй гэнэ. Заримдаа шөнийн цагаар аялаж яваа хэсэг бүлэг аянчин жинчний зам гудас дагуу тэдний жингийн гол цуваа хажууханд нь явж байгаа юм шиг дуу чимээ гарахад нөгөө хэсэг аянчид гол хөсөгтэйгөө очиж нийлэхээр явсаар төөрч өглөө болоход хаагуур яваад хаана ирснээ ч санах юмгүй болж хоосон дуу чимээнд хууртагдсанаа мэдэцгээнэ.

Заримдаа цөлийн дундуур аянчдийг чиглэн давхилдан ирж яваа хүмүүс үзэгдэх агаад аянчид тэднийг дээрэмдэх дээрэмч тонуулчид ирж явна гэж айн сүрдэж явж байсан хатан замаа орхин дүрвэж зугтаад эргэж зам мөрөө ололгүй төөрч сүйрэх нь бий. Зарим үед гэгээн цагаан



өдрөөр элдэв хөгжим хангинан дуугарч ялангуяа бөмбөрийн дуу тодоос тод нижигнэн, зэр зэвсэг харшилдан хангинаж, хүмүүс хашгичих ад чөтгөрийн аяг, сүнсний хий үзэгдэл бодитой, биетэй мэт сэтгэл санаа үймрүүлнэ. Ийм учраас аянчид жинчид, аялагсад бие биенээсээ хараа салгалгүй зэрэгцэн явах бөгөөд шөнө унтахдаа өглөө босоод явах зүг чигээ олох тэмдэг тавиад, тэмээ малынхаа хүзүүнээс хонх зүүж унтана. Хонхны дуу гармагц хэвтрээ орхин одохоор зэхэж буй тэмээ малаа харж аргамжаа, тушаагийг нь бөхөлнө.

Эл хүнд бэрх, урт удаан аяны зам, алжаал ядрал, айдас хүйдсийг давж байж их цөлийг туулан гарна. Одоо бага зэрэг амсхийгээд та бүхэн цөлийн замыг туулан гармагц дараагийнхаа муж газрын тухай яриандаа орьё.

Аялагсад маань гучин хоногийн урт замыг туулан элчилгүй их цөлийг туучин гарч ирээд цөлийн зүүн, зүүн хойт зүгийн завсарт орших, Их хааны эзэмшил захиргааны Сачау (Sa-chau) хэмээх хотод хүрэлцэн ирнэ. Энэ нутгийг Тангуд (Tangut) муж гэх агаад, оршин суугчид нь онгон шүтлэгтэн Тангуд, нестор урсгалын загалмайн шүтлэгтэй цөөн тооны Түрэг, мөн төдий хэр лал шүтлэгтэй Сарацинуудаас бүрэлдэнэ. Тэд өөрийн гэсэн хэл, яриатай. Тангудын хүн ам нь худалдаа наймаа хийдэггүй, зөвхөн газар тариалан эрхлэнэ. Тэр нутагт тоо томшгүй олон төрлийн онгон шүтээн залсан маш олон сүм хийдтэй, нутгийн хүн ард нь тэдгээр онгондоо үргэлж өргөл барьц өргөн, онгодоо машид итгэл хүндэтгэлтэйгээр залбиран мөргөнө. Хүүхэдтэй айл болгон жил бүр хуучин он шилгээж шинэ он гарч онгон тайх баяраар хүүхэд нь онгонд хониор өргөл барьц өргөх ёслол үйлдэнэ<sup>102</sup>. Хонио гаргаж махыг нь бүтнээр (ууц чанах) нь чанаж болгоод хүүхдээрээ онгонд өргүүлэн хүүхдийнхээ эрүүл энх, амь насыг даатган залбирал мөргөл үйлдэнэ. Энэ хооронд хонины бүхэл мах онгоны өмнө өргөөстэй хэвээр байх агаад тэд үүнийг онгон мах зооглож байна гэж хэлцэнэ. Өргөл барьцаа барьж, ёслол хүндэтгэлээ дуусмагц хонинхоо бүхэл махыг гэртээ аваачин ахан дүүс, төрөл төрөгсөдөө цуглуулан баярын зоог өргөн идэж дуусгаад ясыг нь нэг дор бөөгнүүлэн цуглуулж даллага авна. Онгон тахилгын лам нарт хонины толгой, шийр, гэдэс, хэсэг мах, арьсыг нь өгнө.

Дэлхийн бүх онгон шүтлэгтнүүд өөд бологсодынхоо цогцосыг хайлж чандарладаг гэдгийг та бүхэн мэдэж байхад илүүдэхгүй. Талийгаачийн цогцосыг шарил хайлуулж чандарлах газар руу авч явах замд нь төрөл төрөгсөд нь модон гэр барьж түүнийгээ алтан саатай хоргой, торгоор бүрж шарилыг авч явах замдаа тэр гэрт тавьж бүгдээрээ шарилд идээ ундаа, архи дарс, жимс ногоо арвин ихээр өргөн ёсолдог билээ. Энэ нь талийгаачийг нөгөө ертөнцөд мөн ийнхүү хүндэтгэл ёслолтой хүлээн авна гэж бэлгэшээсэн ёслол амой. Шарилыг хайлуулахын өмнө талийгаачийн төрөл төрөгсөд цаасаар хүн, морь, нохой, тэмээний дүрс болон мөнгө цаасны дүрс хайчлан түүнийгээ шарилтай хамт шатаана<sup>103</sup>. Тэднийхээр бол шатааж буй цаасан сүг дүрс хичнээн их байвал талийгаач нөгөө ертөнцөд төдий тооны албат, зарц боол, хонь малтай очиж байгаагийн бэлгэдэл болдог байна. Мөн шарилыг хайлуулахаар залж явах үедээ шарилын өмнө төрөл бүрийн хөгжмөөр ая өргөн хөгжимдөж явах бөлгөө. Энэ бүх ёслол хүндэтгэл нь талийгаачийн зэрэг дэв, нийгэмд эзэлж байсан байр суурьтай нь шууд уялдаатай байдаг гэдгийг санагтун.

Одоо би та бүхэнд өөр нэгэн зүйлийг ярья. Онгон шүтлэгтэн хэн нэгэн талийгаач болмогц төрөл төрөгсөд нь зурхайч төлөгчдөд очиж талийгаачийн хойтхыг даатгуулдаг ёстой. Зурхайч

талийгаачийн төрсөн он, сар, өдөр, цаг нарыг асуугаад төдийд өдийд талийгаачийн цогцосыг хайлж чандарлах ёстойг товлон зааж өгдөг. Тэр өдөр нь долоо хоногийн дараа, сарын дараа, хагас жилийн дараа тохиож таарах тохиолдол цөөнгүй байдаг байна. Тийм тохиолдолд талийгаачийн төрөл төрөгсөд цогцосыг хайлах чандарлах цаг хугацаа болон болтол гэр орондоо байлгадаг. Ийм тохиолдолд тэд нар алга дарам зузаан хантай авс бэлтгэн түүнийгээ сайхан будаж зураг хөргөөр чимэглээд талийгаачийн цогцосыг авсандаа оршуулан гавар, төрөл бүрийн үнэртэн түрхэж занданшуулдаг. Цогцосны ялзарсан үнэр танар гэр орноор тархахаас сэргийлэн авсанд түүхий нунтаг шохой хийж байх завсар гарган түүнийгээ торгомсог алчуураар таглана. Талийгаачийн цогцос гэр орондоо байх бүхий л хугацаанд идээ, ундаа бэлдэн шарилын өмнө өргөж сүнсийг нь хооллож, ундалж байдаг байна. Мөн зурхайч, лам хуврагууд талийгаачийг энэ үүдээр гаргах цээртэй гэвэл өөр үүд хаалгаар гаргах буюу зарим тохиолдолд гэр, байшингийнхаа хана туургыг эвдлэн байж гаргах ч бий. Энэ бүхнийг хийхдээ талийгаачийн сүнсийг гомдоохоос айж эмээсэндээ хийдэг билээ. Зарим үед тэр айлын хүмүүсийг өвчин зовлон ээрэх, ажил төрөл нь бүтэмж урагш муутай байх, үхэл зовлон тохиолдох ч явдал гардаг, тэр тухай бүрт зурхайчид, лам хуврагууд талийгаачийн төрсөн од гарагийг зөв тодорхойлсонгүй гэх буюу талийгаачийн цогцосыг буруу зүгт гаргаж гэх мэтээр тайлбарлан айлдана<sup>104</sup>. Онгод шүтлэгтнүүдийн талийгаачийгаа хөдөөлүүлэх ёсон ийн ажээ.

Одоо би их цөлийн баруун хойт зах хязгаараар орших газар нутаг, хот мужийн тухай та нарт өгүүлье.

Урьд нэгэн цагт хаант улс байсан Хами (Kamul) муж нь олон хот тосгон сууринтай, гол хот нь Хами. Энэ муж Их цөл ба Бага цөл хэмээх хоёр цөлийн хоорондох заагт оршино. Бага цөл<sup>105</sup> нь гурван өдөрчийн газар үргэлжлэх хэмжээтэй. Оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн бөгөөд газар тариалан эрхлэнэ, уух идэх зүйл элбэг хангалуун төдийгүй цөлийг гатлан аялагчдад тариа будаагаа зарж борлуулна.

Хүн ард нь хөхүүн хөгжилтэй, дуу бүжиг найр цэнгээнд дуртай, шүлэг найраг бичиж тэрлэх, уран сайхан уншиж дуудах заншилтай бас бие сэтгэлийн таашаал авч цэнгэн жаргана. Зочин гийчин ирэхэд туйлын баяр найртай угтан авч зочлон хүндэлнэ. Гэрийн эзэн зочны хүссэн бүхнийг тааллаар нь болгохыг эхнэртээ захирч тушаагаад өөрөө элдэв шалтаг заан хэдэн хоногоор алга болно. Энэ хооронд ирсэн зочин түүний эхнэртэй авааль гэргийтэйгээ адилаар энгэр зөрүүлэн аль хүссэнээ үйлдэн цэнгэж жаргах амой. Энэ хот энэ мужийн эмс охид нь ийн байхдаа дуртай бөгөөд үүнээсээ ичиж зовох гэж үгүй, эрчүүд нь ч ингэж байх ёстой мэтээр сэтгэж хардах, зовних гэж үгүй. Энэ нутгийн эмс охид нь үзэсгэлэнтэй, хөгжин цэнгэхэд хөхүүн наалинхай ажээ.

Энэ явдал монголчуудын эзэн, Их хаан Мөнх хаанчилж байх үед болжээ. Хами мужийн эрчүүд ирсэн зочин гийчин хэнд боловч өөрсдийн авааль эхнэрийг санааныхаа зоргоор эдэлж энгэр зөрүүлэхийг өөрсдөө санаачилдгийг албатууд нь айлтгажээ. Ийнхүү зочид гийчдээ дайлах цайлах эрээ цээргүй ёсоо зогсоохыг зарлиг болгон үүнийг зөрчсөн хэн бүхэнд хүнд ял, торгууль оноон шийтгэхээр тушаан хориглов. Хами нутгийнхан тэр зарлиг тушаалыг сонсоод ихэд харамсан арай гэж гурван жил мөрдөн дагажээ. Эцэст нь тэд хуралдан зөвлөлдөөд их бэлэг сэлт бэлдэн Мөнх хаанд өргөж, ийнхүү айлтгал хүслээ илэрхийлсэн нь: Бурханы таалалд нийцүүлэн, өвөг дээдсийн захиас гэрээслэлээр буян хишиг арвижин, амуу

будааны ургац элбэг дүүрэн, аливаа муугийн зовлонгүй байхын тулд бид эмс охидоо харийнханд найр тавин эдлүүлдэг учраа гарган, урьдын энэ ёс заншийг хэвээр үлдээж өгөхийг хүсжээ. Үүнийг сонссон Мөнх хаан: “Та бүхэн урьдынхаа заншил ёсыг мөрдөн дагаж, өөрсдийгөө гутаан басамжилсан шившиг шидээсээ ичиж цээрлэхгүй бол та нарын дураар болтугай” гэж айлджээ. Ийнхүү тэд урьдын заншил ёсоо дагасаар ирсэн бөгөөд одоо ч мөн тэр л хэвээрээ<sup>106</sup>.

Их хааны эзэмшил захиргаанд орших өөр нэгэн мужийг Уйгар (Uighuristan) гэнэ. Энэ олон хот, тосгодтой том муж билээ. Эндхийн гол хотыг Хар-Хожа (Kara-Khoja) гэдэг. Хүмүүс нь онгон шүтлэгтэн, нестор урсгалын загалмайн<sup>107</sup> шашинтан бас сарацинуудаас бүрэлдэнэ. Эндхийн загалмайн шашинтан, онгод шүтлэгтэнгүүд хоорондоо гэр бүл болох нь элбэг. Тэр нутгийнхны анхны хаан эзэн нь усан нүдтэй цусан зүрхтэй хүнээс бие махбодь нь төрөөгүй, харин eska (эска) хэмээх нэгэн төрлийн модны шүүс цэцгэн дээр дусаж түүнээс ургаж амилсан гэх бөгөөд бусад хүмүүс түүний угшил гарвальтай үр удам гэцгээнэ. Онгон шүтлэгт хүмүүс нь өөрсдийн зан заншил, дэг журмыг чандлан сахидаг мөн сайхан дарс нэрдэг байна. Өвөл энэ нутагт дэлхийн бусад газар оронтой зүйрлэх аргагүй хүйтэн болдог.

Их цөлийн умарт болон зүүн умарт зүгийн завсарт орших өөр нэгэн мужийг Гингинталас (Ghinghintalas) гэх агаад арван зургаан өдөрчийн газар үргэлжлэх газар нутагтай, Их хааны эзэмшил захиргааны нутаг болой. Энэ мужид хот суурин газар олон, оршин суугчид нь онгон шүтлэгтэн, Магометийг шүтдэг лал шашинтан болон нестор урсгалын Загалмайн шашинтнуудаас гэсэн гурван бүлэглэлээс бүрэлдэнэ. Энэ мужийн хойт хязгаарт болд төмөр, хорголжийн хүдрээр баян нэгэн уултай. Мөн энэ уулнаас саламандра олзворлон авдаг судал ч бий билээ. Саламандра гэдэг нь амьтан биш бөгөөд чухам юу болохыг одоо би тайлбарлан таниулах гэж оролдоод үзье. Хорвоогийн амьд амьтан болгон дөрвөн махбодиос бүрэлдэн тогтдог гэдэг нь хэн бүхний мэдэх бодит зүйл бөгөөд ямар ч амьд амьтан гал дотор оршин амьдрах боломжгүй учраас саламандра гэдэг нь амьд амьтан биш болой<sup>108</sup>. Бодит байдалд саламандра гэж чухам юуг тэгэж нэрлээд байгааг үзэцгээе. Миний нэгэн сайн танил, ихээхэн эрдэм мэдлэгтэй түрэг Зюрфикар гэгч ухаалаг эр энэ мужид гурван жил Их хааны албанд хүчин зүтгэхдээ саламандра, хоргож, төмрийн хүдэр болон бусад зүйлсийг олзворлон авдаг байжээ. Их хаан гурван жил тутамд энэ мужийн амбан захирагчийг сольдог бөгөөд тэр нь саламандрын олзворлолт, түүгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг бараг дагнан хянадаг байна. Түрэг нөхөрийн хэлсэн зүйл, өөрийн нүдээр үзэж харснаа хэлбэл: Саламандрын судлаас ухаж авсан хүдрээ нүдэж нунтаглахад үсний ширхгээр хооронд нь холбосон мэт хэлхээтэй утас шиг юм болдог байна. Хүдрээ ухаж авсны дараа хатаана, хатаасныхаа дараа том зэс ууранд нүдэж нунтаглаад шороогий нь угааж цэвэрлэхэд баахан хэлхээтэй утас мэт зүйл үлдэнэ. Дараа нь тэдгээр утсаар сүлжиж нэхсэн ёрог даавуу үйлдвэрлэх бөгөөд тэр даавуу нь бор саарал өнгөтэй болдог. Нэхсэн даавуугаа галд хийж хэсэг байлгаад авахад шинэхэн цас шиг цав цагаан өнгөтэй болдог. Саламандрын талаар та бүхэнд миний ярьсан зүйл хөдлөшгүй үнэн бөгөөд нэг ийм даавуу одоо ч гэсэн Ром хотноо бий бөгөөд түүнийг Их хаан Ромын пап ламд бэлэг болгон илгээсэн билээ. Тэрхүү ёрог даавуугаар манай эзэн бурхан Ийсус Христэд нөмөргөх жанч хийсэн байгаа. Энэ ёрог даавуунд хир , толбо суумагц л галд хийж орхингуут эргээд цас мэт цагаан болно. Саламандра гэдэг хүдэр чулуулаг нь тартараар “шөрмөсөн чулуу” гэдэг нэртэй билээ.

Одоо бид энэ мужаасаа гараад зүүн, зүүн хойт зүгийн завсарт орших өөр нэгэн мужид очье. Аялагсад маань эндээс гараад зүүн, зүүн хойт зүгийн завсрыг чиглэн арван хоног аялахдаа ядаж нэг ч орон байр, амьд амьтантай учирч таараагүй бөгөөд бидний номонд ч дурсаж дурьдан үлдээх юм юуч үгүй болой. Арван хоногийн аяны төгсгөлд олон хот тосгодтой Сучау (Su-chau) мужид ирэх бөгөөд эндхийн гол хот нь Сучау болой. Оршин суугчид нь Их хааны харьяат албат загалмайн шашинт хүмүүс болон онгон шүтлэгтнээс бүрэлдэнэ. Сучау нь Тангуд улсын нэгэн муж болой. Эндхийн уул нуруудаар хааяагүй маш их гишүүнэ ургах агаад түүнийг явуулын худалдаачид их хэмжээгээр худалдан авч хөрш зэргэлдээх улс орноор дамлаж борлуулна. Энэ нутгаар аялах аянчид жинчид, аялагсад зөвхөн нутгийн мал адгуусыг хөсөг тээвэртээ хэрэглэнэ. Учир нь энэ нутагт маш хортой өвс ургамал ургах бөгөөд түүнийг идсэн мал, амьтны туурай нь ховхрон унадаг, харин энэ нутгийн мал нь тэр өвсөө таньдаг тул ер идэхгүй. Эндхийн цаг агаар нь цэвэр тунгалаг, хүмүүс нь хүрэн бор арьстай. Голдуу газар тариалан эрхлэн аж төрцгөөх боловч бага зэрэг худалдаа арилжаа эрхлэнэ.

Одоо бид нэгэн мужийг дайран өнгөрөх гэж байна. Эндхийн оршин суугчид нь онгон шүтлэгтэн голдуу байх авч Магоменийг шүтдэг лал шашинтнууд бий. Бас Загалмайтнууд байхаар барахгүй Загалмайн шашны гурван ч сайхан сүм энэ хотод бий. Онгон шүтлэгтний олон сүм хийд, шашин номын зан үйлээ явуулдаг лам нартай. Тэдгээр сүм хийдэд төрөл бүрийн онгон олон, зарим нь уртаараа арван тохой хүрнэ. Онгонуудаа мод, шавар, чулуугаар урлан хийж алтаар бүрсэн байдаг. Гол дунд нь том онгоноо залж, эргэн тойронд нь жижиг онгод байрлуулсан нь тэд том онгондоо залбиран мөргөж байгаа мэт санагдана. Би та бүхэнд онгон шүтлэгтний ёс заншлын талаар өмнө нь ярьж байгаагүй санагдах тул одоо энэ талаар ярьж өгье.

Юуны өмнө, шашин номынхоо дэг жаягийг хэлбэрэлтгүй мөрдөн баримтлагч онгон шүтлэгтнүүд бусад шашныхныг бодвол буяныг эрхэмлэн нүглийг тэвчин амьдардгийг санагтун. Тэд садар самуун явдлыг тэвчин зайласхийх боловч түүнийг хамгийн гол нүгэл хилэнц гэж үздэггүй. Тэдний баримталдаг зарчим нь гэвэл: Хэрэв ээ бүсгүй хүн тэдэнтэй энгэр зөрүүлэхийг эхлэн санаачилвал тэр нүгэл биш, харин лам хувраг бүсгүй хүнийг энгэр зөрүүлэхийг албадан хүчилвэл тэр нүгэл мөн. Хэрэв хэн нэгэн эр бүсгүйчүүдтэй ёс бус хурьцах юм бол тэр үхэх ялд унана. Тэд сарны тоололтой бөгөөд тэр нь манайхны сар өдөртэй бараг дүйнэ. Энэ хорвоогийн онгон шүтлэгтэн болгон мацаг барин мал амьтны амь таслахыг цээрлэн, мах иддэггүй таван хоног байдаг. Энэ таван хоногийн хугацаанд шашныхаа ёс дэг жаягийг хатуу баримтлана. Зарим нэгэн лам хувраг нь насан туршдаа ч мах амсалгүй, амьтны амь таслалгүй буян үйлдэх бөгөөд үүнийг зөвхөн гэгээрсэн лам нар л мөрддөг. Тэд хөрөнгө чинээнийхээ хэрээр эхнэр авах бөгөөд зарим нэгэн баян чинээлэг нь гуч болон түүнээс ч олон эхнэр авна. Эхнэр авахдаа инж өгнө. Тэд анхныхаа авсан авааль эхнэрийг гол эхнэрээ гэж хүндэлнэ. Хэрэв аль нэгэн эхнэр нь нөхрийнхөө санаа сэтгэлд үл нийцвэл тэр эхнэрээ төрхөмд нь буцаана. Тэндхийн эрчүүд нь өөрийнхөө үеэл, бүл эгч дүүстэй гэрлэхээр барахгүй эцгийнхээ бэлэвсэн эхнэртэй 109 ч гэрлэх явдал бий. Тийнхүү тэд нар манай ёс заншлаар бол туйлын бузар булай ёс төргүй аашилж, олон олон нүгэл хилэнц үйлдэх авч тэр бүхнээ өөрсдөө нүгэл хилэнц гэж тоолгүй мал, адгуус шиг амьдарч, аж төрнө.

Одоо энэ газар орныг орхиж умар зүгт орших өөр муж, газар орны тухай өгүүлсү. Эрхэмсэг Никколо, Маффео, Марко нар маань ажил явдлын шалтгаанаар энэ хотод бүтэн жилийг

өнгөрөөсөн боловч та бүхэнд сонордуулах, толилуулах зүйлээр ховор хомс байжээ. Ингээд энэ хотыг орхин умар зүгийг чиглэн жаран өдөрчийн зам туулах аян замдаа гарцгаая.

Аялагчид маань Канчау (Kan-chau) хотыг орхин одсоноос хойш бүтэн арванхоёр өдөрчийн газрыг туулан элсэн цөлийн умарт хязгаарт орших Эзэн (Etzina) хотод ирлээ. Энэ хот мөн Тангуд мужид хамаарна. Оршин суугчид нь онгон шүтлэгтнүүд. Энд тэмээ, үхэр маш олон. Мөн энд маш сайхан шунгаа шонхор, бор хүзүүт шонхор шувууд олноороо үржин нутагшина. Хүмүүс нь газар тариалан эрхлэн амьдрах бөгөөд худалдаа арилжаа хийдэггүй. Аялагчид, аянчид жинчид хэн боловч Эзэн хотоос дөчин хоногт хүрэлцэх хоол хүнс базааж аваад умар зүгт цэлийх говь цөлийг дөчин хоногийн турш аялан туулах замдаа гарна. Энд айл амьтан, хоргодох байр сууц, дэн буудал огт тааралдахгүй, зуны цагт уулсын хөндий хоолойгоор хаа нэгтэй цөөн тооны айл амьтан зусна. Энэ нутагт зэрлэг ан араатан элбэг байхын дотор хулан элбэг, энд тэнд армаг тармаг нарсан ойтой<sup>110</sup>. Умарыг зорьж говь цөлийг туулсан дөчин өдөрчийн урт аяны төгсгөлд өөр нэгэн мужид ирнэ, одоо энэ талаар өгүүлье.

Ингэж явсаар бид Хархорум (Karakorum) хотод ирэх нь тэр. Хот нь тойргоороо гурван бээр урт, маш бат бөх шороон далангаар хүрээлж хамгаалсан байсан нь чулуу ховортойнх бололтой. Энэ газар бол тартарууд уугуул нутгаасаа гарч анх ирж эзлэн аваад нутагшин суусан газар болой<sup>111</sup>. Би одоо та бүхэнд Тартаруудын тухай мэдэх бүхнээ ярья, тэд хэрхэн Тартарын эзэнт гүрнийг байгуулсан, хэрхэн дэлхий ертөнцийг байлдан дагуулж тархан суурьшсан бүгдийг ярья.

Жинхэнэдээ тартарууд алс умар зүгийн Чорча (Chorcha)<sup>112</sup> нутагт байсан билээ. Тартарууд нь их талыг эзэгнэн нүүдэллэх улс бөгөөд тэр улсад хот, суурин гэж үгүй боловч том том гол мөрөн олонтой, өвс ногоо халигсан өргөн уудам бэлчээртэй, ус ундаагаар гачигдаж дутагдах явдалгүй газар орон болой. Тэндхийн ард олон дээрээ ноёнгүй мэт боловч үнэн хэрэгтээ Унг Хан (Ung Khan) гэж нэрлэх нэгэн хааны нөлөө, захиргаан дор алба даяг төлнө. Унг Хан гэсэн нь тэдний хэлээр Их эзэн<sup>113</sup> гэсэн утга, санааг агуулна. Тэр хаан бол дэлхий даяар яригддаг хүчирхэг эзэнт гүрний хаан Прэстэр Жон (Prester John) мөн болой. Тартарууд түүний эрх, засгийг хүндэтгэн зөвшөөрч арван мал тутмаас нэг малаар татвар гувчуур төлж байжээ. Тартарын хүн ам маш хурдан өсөж, тоо толгой нь нэмэгдэж буйг Прэстэр Жон анзааран анхаарч, тэдний хүн ам өсөж олшрох нь яваандаа түүний нөлөөлөл, захиргаанд аюул дуудах осолтой гэж үзэн тэднийг хэд хэдэн улсад хуваан захируулахаар шийджээ. Тэгээд түүнийгээ хэрэгжүүлэхээр ноёд, түшмэдээ тартарууд руу илгээв. Прэстэр Жоны энэхүү хорлонтой санааг Тартарууд ухаж мэдэнгүүтээ машид зовнин сандарч, уугуул нутаг орноо орхин алс умар зүгт нүүдэллэн цөл газрыг туулан, амар жимэр суух нэгэн их хээр талд очиж нутаглацгаав<sup>114</sup>. Ингэж тэд Прэстэр Жоны эрх, засаглалын эсрэг тэмцэн босож алба даяг төлөхөө бүрэн мөсөн болив. Түүнээс хойш багагүй хугацаа өнгөрчээ.

Энэ явдал Христийн дахин мэндэлсний 1187 онд болсон билээ. Тэгэхэд тартарууд өөрсдийнхөө хааныг сонгон Чингис (Chingiz) хэмээн өргөмжилжээ. Чингис хаан нь билиг ухаан төгс цэцэн, эрэлхэг зоригтой баатар жанжин, ухаалаг хэрсүү жолоодогч байжээ. Түүнийг хаан өргөмжилснийг дэлхийн бүх тартарууд хүлээн зөвшөөрч харь холын улс гүрэнд тархан суурьшсан тартарууд ч Чингис хааны нутгийг тэмцэн ирж нэгдэн цугларч байв. Чингис хаан өөрөө угийн шулуун шударга зантай, энэрэнгүй зөөлөн ивээлтэй хүний ёсоор

бүх хүнтэй жигд энгийн харьцаатай байж ирсэн бүх хүнийг талархан хүлээн авдаг байв. Чингисийг тойрон нэгдэж буй тартарууд түүнд итгэл, хүч хайрлан, улам хүчирхэг болгож байлаа. Үй олон тартарууд эзнээ тойрон хүрээлж буйг олж үзсэн Чингис хаан тэднийг нум сум, бусад зэр зэвсгээр өвч зэвсэглэн, цэргийн эрдэмд сургаж харь орныг байлдан эзлэх аян дайнд зэхэж, цэрэглэн мордов. Байлдан эзэлсэн орныхоо хүн ардыг харгислан хэрцгийлэлгүй, тонож дээрэмдэлгүй өөрийн эгнээнд элсүүлэн эрхшээсээр найман мужийг байлдан эзлэв. Харин эзэлсэн орныхоо ард иргэдийг өөрт нь дагаж өөр бусад орныг байлдан эзлэхийг уриалан дуудах бөгөөд тэр орны ард иргэд ч дуртайяа нэгдсээр олон ястан үндэстэн, улс орныг эзлэн захирчээ. Чингис хааны засаглал шулуун шударга, хүн ардаа ээлтэй энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард ч түүнтэй өөрсдөө ирж нийлэн нэгдсээр байв. Нэг мэдэхэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар дэлхийг хучин бүрхсэн үй түм болсныг үзээд тэрбээр дэлхийг байлдан дагуулж, эзэмшин эрхшээхээр зоригложээ.

Юуны өмнө Христийн мэндэлсний 1200 онд Прэстэр Жонд Чингис хаан элч илгээн, – Охиноо надад гэргий болгон буулгаж өгтүгэй! хэмээн хэл хүргүүлжээ. Түүний энэхүү саналыг Прэстэр Жон ихэд басамжлан сонсохчоон болоод машинд их уурлан хорсож өгүүлрүүн: Миний охиныг гэргийгээ болгоно гэв үү? Чингис яасан ичих нүүрэндээ илэг наасан хүн бэ? тэр миний албат боол гэдгийгээ өнөө болтол ухаарч мэдээгүй хэрэг үү? гээд: “Би охиноо түүний гэргий болгосноос галд өргөчихсөн нь дээр. Эзнийхээ эсрэг боссон түүнийг цаазлан хороох шалтаг ч гарлаа” гээд элчийг хөөж явуулан дахин түүний нүдэнд үзэгдэхгүй байхыг тушаав. Эдгээр үгсийг сонсож хариуг авсан элч буцаж ирээд Прэстэр Жоны хэлснээс ганц үг газар гээлгүй хаан эзнийхээ сонорт айлтган мэдүүлэв.

Прэстэр Жон өөрийг нь гутаан доромжилсон үгсээр зүхэж, басамжлан дайрч дорд үзсэн санаагаа илээр хэлж, энэ бүхнээ Чингис хааны элчид дайж хөөн явуулсныг үзмэгцээ уур хорслоо дарж, ухаан санаагаа хөвчлөв. Тэр угийн бардам ихэмсэг, зоримог тэвчээртэй эр гэдгийг би та нарт дээр хэлсэн билээ. Тэгээд Чингис хаан хавь ойрынхоо хүмүүсийг цочиж доргим өндөр дуугаар: Прэстэр Жоны гутаан доромжилсны хариуг хэнтэй ч зүйрлэмгүй, хэзээ ч мартагдахааргүй хатуу чангаар барьж, түүний боол зарц мөн эсэхээ даруйхан үзүүлж, түүнийг гэсгээн цээрлүүлж эс чадваас хаан ширээнээсээ өөрийн дураар бууж өгсүгэй гэж андгай тавьжээ. Тэгээд Чингис хаан бүх цэрэг, ардаа дуудан цуглуулж: Урьд өмнө нь үзэгдэж дуулдаагүй нягт нямбай, гаргууд сайн бэлтгэж, тулаанд зэхэхийг зарлигджээ. “Би өөрийнхөө их цэргийг аваад чам руу очиж явна, амь бие, эд хөрөнгө, хүн ард, газар нутгаа хамгаалагтун” гэж Прэстэр Жонд элч заран тулган шаардах хэл хүргүүлжээ.

Прэстэр Жон Чингис хаан дайлаар айсууг мэдсэн авч сэтгэл үл зовон, дайн тулаанд орж үзээгүй, цэргийн эрдэм төгс сайн эзэмшээгүй, эгэл болхи Чингисийн цэргүүдийг тулалдааны талбарт хялбархан ялна гэсэн бодолтой байжээ. Тэгээд Чингис хаан үнэнхүү довтолгон ирвэл уран нарийн аргаар олзлон барьж аваад цаазлан хороосугай гэж сэтгэл дотроо товлон, заналтайяа хүлээж байлаа. Энэ хооронд тэр өөрийнхөө бүх цэрэг ардыг дуудан цуглуулснаар үл барам, харь холын газар нутагтай хараат газар орныхоо иргэдийг ч дуудан цуглуулж урьд өмнө байгаагүй их хүчээр цэрэглэн Чингис хааныг угтжээ. Ингээд сөргөлдөн өрсөлдөгч хоёр тал тулалдаанд хэрхэн бэлтгэж байгаа талаар ярилаа, одоо өөр олон зүйл нуршин тоочилгүйгээр чухам юу болсныг өгүүлбэл: Чингис хаан их цэргээ удирдан нэгэн их тал газрыг нөмрөн ирж байрлав. Түүний цэрэг эрсийн тоог тоймлон хэлэх аргагүй олон байсан

гэдэгт та бүхэн эргэлзэх явдалгүй. Тэнд ирээд Чингис хаан Прэстэр Жон айсуй явааг сонсон сэтгэл уужирч, тулалдаан хийх тал нутаг уужим дэлгэр, байлдахад нэн тохиромжтойг үзээд хөхөн баясаж байжээ.

Чингис хаан, түүний цэрэг эрсийн тухай яриагаа түр завсарлан, Прэстэр Жон болон түүний цэрэг дайчдын тухай өгүүлсү.

Прэстэр Жон Чингис хаан өөрийнхөө их цэрэгтэй Тэндүкийн их талд хуарагнан буудаллаж түүний ирэхийг хүлээж байгааг мэдэж байсан бөгөөд Прэстэр Жон ч Тэндүкийн их талд цэрэглэн ирж Чингисийн цэргийн хуарангаас хорин бээрийн зайд буудаллан хуарагнав. Хоёр тал тулалдах өдрийг хүлээн хүч юугаа бүртгэн сэлбэж байлаа. Ингэж хоёр этгээдийн их цэрэг Тэндүкийн их талд хуарагнан, их тулалдааны өмнөх анир чимээгүйн дунд түр амсхийж ажгуу. Чингис хаан өөрийн зурхайч, төлөгч Загалмайн шашинтан болон лал шүтлэгт Сарацин нарыг цуглуулан энэ дайнд Прэстэр Жон тэр хоёрын хэн ялахыг мэргэлэн хэлсүгэй гэж тушаав. Зурхайчид төлөг тавьж, хичээнгүйлэн мэргэлцгээв. Сарацинуудын мэргэ төөрч тэд олигтой юм хэлсэнгүй. Харин загалмайн шашинтан зурхайчид ийн үзүүлэв. Тэд, хааны нүдэн дээр нэгэн саваа модыг хоёр хуваан нэгэн дээр нь Прэстэр Жоны нэрийг бичээд нөгөө тал дээр нь Чингис хааны нэрийг бичээд хооронд нь зайтай хол тавиад өгүүллүүн: Энэ хоёр саваа модны нэгэн дээр таны нэр, нөгөө дээр Прэстэр Жоны нэр буй, биднийг шившлэг тарниа уншин увдис эрдмээ үзүүлмэгц хэн ялан дийлэх тавилантай байна түүний нэртэй саваа мод өөрөө хөдөлж нөгөөгийнхөө дээр гарна гэв. Чингис хаан дуртайяа таалж үтэр түргэн үзүүлэгтүн гэв. Загалмайн шашны зурхайч төлөгчид тарнийн ёсны судар номоо гарган тарни шившилгээ хийж, уншилга дуудлагаа эхэлмэгц Чингис хааны нэрийг бичсэн саваа мод өөрөө хөдлөн хуран чуулсан бүхний нүдэн дээр Прэстэр Жоны нэртэй саваан дээгүүр авиран гарчээ. Чингис хаан үүнийг үзээд хязгааргүй их баярлав. Тийнхүү загалмайн шашинтан зурхайчид мэргэ төлөг, шившлэг тарнийн хүчээр үнэнийг хэлж чадсан тул Чингис хаан тэр цагаас хойш тэднийг ихэд хүндэтгэн, худал ярьдаггүй жинхэнэ төлөгчид хэмээн ихэд тоох болжээ.

Үүнээс хоёр хоногийн дараа хоёр тал их цэргээ хөдөлгөн урьд өмнө дуудаж сонсогдоогүй догшин ширүүн тулалдаанд оржээ. Энэ аймшигт тулалдаанд аль аль тал нь үлэмж их гарз хохирол амссан боловч эцсийн эцэст Чингис хаан ялж, Прэстэр Жон алагджээ. Энэ өдрөөс эхлэн Прэстэр Жоны газар нутаг, хүн ардыг Чингис хаан алхам алхамаар ахиулан эзэлж захирсан авай. Энэ цагаас хойш Чингис хаан зургаан жилийн турш олон улс хот, газар орныг байлдан эзэлж захиран суув. Зургаадахь жилийн төгсгөл рүү Чингис хаан Хочау (Ho-chau) хэмээх хотыг бүслэн байлдаж ахуйд өвдөгөндөө сумны шарх авч түүнээсээ болон тэнгэрт хальжээ. Чингис хаан нь цэцэн билиг төгс, эрэлхэг зоригтой, ухаалаг бодолтой эзэн байсан.

Дөнгөж сая би та бүхэнд тартарууд анхныхаа хаан Чингисийг хэрхэн сонгосон, Прэстэр Жоныг хэрхэн ялж, газар орны нь эзлэн эзэмшсэн тухай тодорхой ярьсан тул одоо тартаруудын зан заншил, ёс суртахууны тухай өгүүлье.

Чингис хааныг тэнгэрт хальснаас хойш Гүюг (Kuyuk) хаан, гуравдахь нь Бат (Batu) хаан, дөрөвдэх нь Элтоу (Altou)<sup>115</sup> хаан, тавдахь нь Мөнх (Munkh) хаан, зургаадахь нь суу заль төгс Хубилай хаан ор залгамжлан өргөмжлөгджээ<sup>116</sup>. Эдгээр хаадын дотроос хамгийн агуу их, суу билигт, хүчирхэг Их хаан нь Хубилай хаан байв. Түрүүчийн таван хааныг хамтатган нийлүүлэвч Хубилай хааны сүр хүч, суу билигт эс хүрнэ. Энэ ертөнцийн бусад бүх хаад,

Загалмайтан болон Сарацин нарын хаад бүгд нийлээд ч ухаан, хүч нь хүрэхгүй тийм агуу их үйл хэргийг Хубилай хаан бүтээж чадсан бөгөөд энэ тухай номондоо би тов тодорхой хүүрнэн өгүүлнэ гэдгийг та бүхэн мэдвэл зохилтой.

Чингис хааны удам угсааны хаад, эздийг тэнгэрт хальмагц Алтай (Altai) хэмээх их ууланд оршуулдаг гэдгийг та бүхэнд хэлье. Тэдгээр эзэд, их хаадын хэн нэгэн нь алс хол энэ газраас зуун өдөрчийн хол байсан ч шарилыг нь заавал энэ ууланд авчирч онголон оршооно. Бас нэгэн гайхам сонин ёсыг өгүүлбэл: Их хаадын шарилыг онголохоор дөчин хоногийн турш залж явах зам гудаст таарсан хэнийг боловч цавчин хороож “эзэн хаанаа дагалдан нөгөө ертөнцөд очиж хүчээ өгөгтүн” гэж ерөөн шарилыг дагуулан хойллого үйлдэнэ. Мөн хүлэг морьдоор тийм хойллого үйлдэнэ. Хаан эзэн халин одмогц хамаг эрдэнэт сайн хүлэг морьдоо нөгчөөн хаан эзнээ дагалдуулан нөгөө ертөнцөд илгээн хойллого үйлдэнэ. Бас нэгэн үнэн баримт гэвэл: Мөнх хааны шарилыг онголохоор Алтайн уул руу залж явах зам гудаст тааралдсан хоёр түмэн хүнийг нөгчөөн хороож хаан эзнийхээ хойноос хойллого үйлдсэн нь үнэн билээ. Ам нээвэл, уушги нээ гэдгийг санан тартаруудын тухай яриагаа нэгэнт эхэлсэн болохоор та бүхэнд тэдний талаар ярих, хэлэх зүйл надад цөөнгүй бий билээ.

Тартарууд малын бэлчээр өвс сайтай ээвэр дулаан тал нутагт өвөлжнө. Ус, бэлчээр элбэг дэлбэг уулс, хөндий зэрэг сэрүүн сэргэг, ой модтой газар зусна. Зуны цагт сэргэг сэрүүн, сэвэлзүүр салхитай газар ялаа шумуул, хөхгүрүү, зөгий ховор байдаг тул хүн, мал амар тайван зусаж мал сайхан тарга тэвээрэг авдаг. Тэд үргэлж нутаг сэлгэн нүүж зуны гурван сарыг нэгэн бэлчээрт уягдаж талхлалгүй мал сүргээ таргалуулна. Тэд модоор хийж, эсгийгээр бүрсэн, дугариг хэлбэрт сууцтай (circular house) ба хаашаа ч нүүсэн сууцаа дөрвөн дугуйтай тэргэн дээр ачиж явна. Сууцны уурган яс мод нь бөх бат, маш хөнгөн байдаг тул зөөж, нүүж явахад ямар ч төвөггүй. Сууцаа барихдаа үүдийг нь ямагт өмнө зүг рүү харуулан барина. Мөн тэдэнд хоёр дугуйтай тэргэн дээр барьж хар эсгийгээр хучсан сайн загвартай мухлаг байх агаад хичнээн ч бороо орж байсан дотор тал нь үргэлж хуурай, тохилог байна. Тэргэнцрийг шар үхэр юм уу тэмээ хөллөж эхнэр, хүүхдээ суулган ойр зуурын хэрэглээний сав суулгаа ачна.

Гэр орны бүхий л ажил, худалдаа арилжаа хийх, мал ахуйгаа адуулах зэрэг айл гэрийн өдөр тутмын ахуй амьдралын ажил нь гэрийн бүсгүйчүүдийнх бөгөөд эрчүүл нь энэ талаар санаа зовдоггүй, дайнд мордох, ав хоморго хийх, шонхроор ангуучлах нь эрчүүдийн ажил. Тэд мах, сүүгээр хооллож алив ангийн мах, түүний дотор хээр талаар хааяагүй элбэг тарвага (pharaoh's rats) агнаж иднэ. Тэдний идэх уух юманд хорио, цээр үгүй бөгөөд адуу, нохойн мах идэж, гүүний сүү ууна. Бараг бүх амьтны махыг иднэ. Тэд бол бусдын эмс, эхнэртэй хавьтдаггүй ганц газар бөгөөд ингэхийг шившигтэй явдал гэж үзнэ. Эхнэр хүүхнүүд нь эрдээ үнэнч итгэлтэй, айл гэрийн амьдрал ахуйг авч явдаг эзэд нь эмэгтэйчүүд. Арав, хорин эхнэртэй байсан ч тэд нь хоорондоо эвтэй найртай амьдарцгаана. Хаана ч, хэзээ ч тэр олон эхнэрүүд хэрэлдэж, маргалдаж байхыг та үзэхгүй. Хүн бүхэн гэр орныхоо ажил үйлд санаа тавин, үр хүүхдээ өсгөж торниулахад хамаг анхаарал халамжаа өгнө. Тэд нар гэр бүл болохдоо хэдэн ч эхнэр авч болох бөгөөд тэжээж, хувцаслаж дийлбэл зуун эхнэр ч авч болдог. Эхнэр авах эр хүн эхнэрийнхээ эхэд инж бэлэг өгөх бөгөөд эхнэр нь нөхрийнхөө талд юу ч өгдөггүй. Анхны авсан авааль гэргийгээ их эхнэр гэх бөгөөд бусдаас илүү хүндэлнэ. Эрчүүд нь олон эхнэртэй байдаг учраас мөн олон хүүхэдтэй байна. Тэд бүл болоод үеэл эгч, дүүстэйгээ гэрлэдэг



төдийгүй, эцэг нь нас барахад ууган хүү нь өөрийн нь эх биш бол эцгийнхээ бэлэвсэн эхнэртэй гэрлэнэ. Бас ах дүүс нь насан өөд болоход тэдний эхнэртэй гэрлэнэ. Тэд эхнэр авч гэр бүл болохдоо маш хөлтэй, дорвитой найр хурим хийнэ.

Одоо би тэдний шүтлэг, шүтээний тухай өгүүлье. Тартарууд Өндөр дээд Бурхандаа өдөр бүр зөвхөн сайн сайхан, эрүүл энхийг хүсэж бойпор, хүжтэй залбирна. Тэд бас өөр өөрийн бурхантай бөгөөд түүнийгээ Начигай (Natigai) гэж нэрлэнэ. Тэр бол айл гэрийн үр хүүхэд, адуу мал, тариа будааг харж хамгаалдаг, ивээн тэтгэдэг газар-лусын бурхан гэнэ. Онгоныг айл бүр эрхэмлэн тахиж тайж, мөргөл залбирал үйлдэнэ. Тэрхүү онгоноо эсгий, цэмбээр үйлдэж гэрийнхээ ханын нүдэнд байршуулан тахидаг төдийгүй бас түүний гэргий, хүүхдийг ч эсгий цэмбээр урлан тахина. Онгоны эхнэрийг зүүн гар талд нь, хүүхдийг нь өмнө нь залж тахиж бөгөөд цөмд нь адилхан мөргөл, залбирал үйлдэнэ. Хоолоо идэхийн өмнө өөх тосоор онгоныхоо амыг тосдож мялаана, мөн түүний эхнэр, хүүхдийн амыг тосдож мялаагаад үүдэндээ гарч шөл, шүүсээр тахил өргөнө. Тийнхүү эдгээр бурхан сахиусандаа зоог, шүүсээ өргөж дуусаад өөрсдөө хоол ундаа идэж эхэлнэ. Тэд гүүний сүү уудаг, гэхдээ маш сайхан амттай цагаан дарс маягийн ундаа болгож уух бөгөөд түүнийгээ кумис (koumiss буюу айраг) гэж нэрлэнэ.

Тэдний өмсдөг хувцас нь алтан саатай магнаг торгоор хийж, булга, үен, суусар, үнэгний арьсаар доторлосон буюу хажиж эмжсэн маш тансаг билээ. Гоёл чимэглэл, эдлэл хэрэглэл нь жигтэйхэн үнэтэй. Зэр зэвсэг нь нум сум, сэлэм, бялуу байх боловч тартаруудын гол зэвсэг нь нум сум бөгөөд тэд нар үнэнхүү мэргэн харваачид билээ. Зэрлэг үхрийн буюу өөр бусад амьтны ширийг хатааж хийсэн ширээр ар зоогоо хуяглаж хамгаална. Тэд бүгд эр бяргтай, ид хавгай, эрэлхэг дайчин бөхчүүд. Тэд байлдах тулалдахдаа аль ч газрын эрчүүдээс гавшгай шаламгай, баатарлаг зоригороо онцгой содон ялгардгийн учир юундаа байдгийг би та нарт тайлбарлан таниулъя. Аян дайны алс замд тартарууд өөрсдийн агнаж алсан араатан жигүүртний махаар хооллон, гүний сүүгээр цангаагаа тайлан сар, жилээр өөр хоол унд гэлгүй, өлсөж цангалгүй явах бөгөөд унаа морьд нь хээрийн бэлчээрт таарах өвс болгоныг идэж явах тул морьдоо тэжээх арвай буудай, аага хивэг ачиж, тээж явахын хэрэггүй байдаг. Тийм учраас тэд алс хол аялан, алалдан тулалдахдаа бусдаас илүү тэсвэр тэвчээртэй, тэнхээ чадалтай байдаг. Тэд эзэд хааддаа үнэнч, сахилга дуулгавартай бөгөөд хэрэгцээ шаардлагатай үед зэр зэвсгээ агсан бүтэн хоногийн турш эмээл дээрээс буулгүй морьдоо идүүлэн хонох бол энүүхэн энд. Алив нэгэн хүчир бэрхшээл, хүнд хэцүү зүдүүрийг дааж давж гарахдаа өөр бусдаас илүү учир бага зардал сүйтгэлээр дэлхийн олон улс орон, газар нутгийг байлдан дагуулж эзэмшин эрхшээх чадвар чадавхтай ард түмэн билээ.

Тэдэнд эрхэмлэн дагаж, хэлбэрэлтгүй мөрддөг нэгэн дэг жаяг бий. Одоо тартарууд цэрэг армийнхаа бүтэц, бүрэлдэхүүнийг хэрхэн хийдгийг үзье. Тартарууд аян дайнд нэг буман цэрэгтэй гарлаа гэвэл: Арван цэрэг болгон нэг даргатай аравт болдог, арван аравт нийлээд нэгэн зуут болж зуутын дарга захирна, арван зуутаас нэг мянган бүрдэж мянганы ноён захирна, арван мянгатаас нэг түмэт бүрэлдэн түмтийн ноён захирна, арван түмтээс нэг бумат бүрэлдэн бумтын ноён захирна. Ингэж аравт аравтаар зохицуулан зассан цэргийн аль ч тушаалын дарга, ноён зөвхөн өөрийн захиргааны арван хүнтэй л тулан ажиллаж тэдгээр арван хүн өөрсдийн дарга, ноёны өмнө бүх хариуцлагыг хүлээнэ.

Хэрвээ буман цэргийн их жанжин хэн нэгнийг аль нэгэн газар руу илгээх болвол түмтийн ноёныг дуудан тийшээ явж, тийм үүрэг гүйцэтгэх мянганыг бэлэн болго гэж тушаана, түмтийн ноён өөрийхөө мянганы ноёнд төдийд бэлэн байхыг тушаан өөрт тохоогдсон үүргийг үтэр түргэн биелүүлнэ. Цэргийн дээд дарга, ноёдын зарлиг тушаал дээрээс доошлох шат шатандаа ямар ч саад бэрхшээлгүй биелж байдаг. Зарлиг тушаалыг ягштал, шуурхай биелүүлэх талаар хосгүй шалгарсан цэрэг энэ ертөнцөд тартар цэргээс өөр үгүй билээ. Зуун мянга (100000)-ыг бумт (tuk), арван мянга (10000)-ыг түмэн (tomaun) гэх мэтчлэн мянгат, зуут, аравт гэсэн бүтэцтэйг та бүхэн ойлгож мэдлээ. Их цэрэг аян дайнд мордох, ан авд гарах, шилжин нүүх зэрэг хаашаа, хаагуур явах болвол хоёр зуутыг толгойн сэргийлэхээр томилон хоёр өдөрчийн газар түрүүлүүлэн илгээнэ, мөн их цэргийн ар талыг сахин манах, хажуу талыг нь сэргийлэн хамгаалах хоёр хоёр зуутыг гаргаж дайсны гэнэтийн халдлага довголгооноос сэргийлэн хамгаалдаг билээ.

Цэргүүд алс холын аян дайнд мордохдоо элдэв ачаа, бараа биедээ үл авна. Зөвхөн айраг, сүү хийх хоёр жижиг ширэн дашмаг буюу жижигхэн арьсан тулам<sup>117</sup>, мах буцалгах жижиг тогоо ганзагалаж явна. Тэрчилэн бороо хурнаас хоргодох жодгортой байна. Бачим тулгуу бэрх үед цэргүүд гал түлж хоол, унд хийж идэлгүй, морьдынхоо судсыг ханаж цусыг нь уух төдийгөөр голоо зогоож арван хоног ч зогсоо чөлөөгүй довголгодгийг та бүхэнд өчин өгүүлсү. Цэрэг болгон өтгөрүүлж хатаасан хуурай сүүтэй явна. Сүүгээ яаж хатаадгийг өгүүлбэл: Эхлээд сүүгээ буцалтал халаана, сүү буцалмагц дээр нь хөвх тос цөцгийг хамж аваад өөр саванд хийх бөгөөд сүүлд нь тэр цөцгийгөө тос болгодог, цөцгийтэй сүү хатдаггүй. Буцалгасан сүүгээ наранд хатаан хагуу, хуурай<sup>118</sup> болгоно. Тэд аян дайнд явахдаа энэхүү хатаасан хуурай сүүнээсээ авч явах бөгөөд өглөө болгон хуурай сүүнээсээ бага зэргийг авч устай арьсан дашмагт хийж ганзагалана. Ингээд давхиж явахад хуурай сүү усанд уусаж гүйцмэгц түүнийгээ уух бөгөөд тэр нь тэдний өглөөний хоол болдог.

Тартар цэргүүд дайн тулаанд орохдоо байлдааны нэгэн уран арга хэрэглэнэ. Тэд тулааны талбараас ухран зугтаахыг хулчигар шившигтэй зүйл гэж огтхон ч тооцдоггүй. Тулалдааны талбарт байршлаа чөлөөтэй солин давхилдаж дайсны эгнээ жагсаалыг ээлж дараалан харваж өдөөнө. Тэд агт морьдоо бараг л унасан эзнийхээ харсан зүг рүү жолоо сунган давхихаар нохой мэт сургаж сургуулласан байх бөгөөд морьд нь ч жолоо эргүүлэх буюу өвдгөөрөө хавчиж залсан зүг рүү ам мэдэн давхина. Тэдгээр морьтон цэргүүд дайснаас зулбан зугтааж явахдаа улаан нүүрээр тулан тулалдахаасаа огт ялгаагүй цэцэн харваж дайсны цэрэг, морьдыг алдалгүй ононо. Тартар цэргүүд ухран зугтаахдаа эмээл дээрээ эргэн харж нэхэж яваа дайсныхаа цэрэг, морьдыг алдалгүй харван хороосоор буруулах бөгөөд нэхэж яваа дайсан ч цэрэг морьд нь цөөрсөөр байгааг онцгойлон анзааралгүй дийлж байна гэж хууртан хөөсөөр, нэхсээр, хорогдсоор байдаг. Тартарууд зугтаан зулбаж явахдаа дайсны цэрэг, морьдоос хангалттай олныг хороосноо мэдэrmэгц гэнэт эргэн дайрч дайсны цэргийн үлдэгдлийг хүйс тэмтрэн сөнөөж ялалт байгуулдаг. Энэ уран аргаараа тартар цэргүүд олон олон тулалдааны хувь заяаг шийдэн ялж, олон олон улс үндэстнийг өвдөг сөхрүүлэн эзэлж авсан билээ.

Миний та бүхэнд ярьж таниулсан болгон язгуурын тартаруудын зан заншил, төрх төлөвийг илэрхийлж буй билээ. Харин одоо цаг өөр болж, Хятад (Cathay) нутгийг эзлэн суусан Тартаруудын орчин, зан заншил өөрчлөгдөж, онго шүтлэгтэн болцгоож, өөрийн итгэл бишрэлээ орхиж байхад Левантийг эзлэн захирсан Тартарууд Сарацины хэв дадалд уусаж

байх жишээтэй.

Одоо би та нарт Тартарууд хууль цаазаа хэрхэн мөрдөн дагадаг, яаж хэрэгжүүлдэг талаар өгүүлье<sup>119</sup>: Хэн нэгэн этгээд бага сага зүйл хулгайлсан бол долоон удаа ташуурдан занчина. Хулгайлсан зүйлийн хэмжээ, учруулсан хохирлын байдлаас болж ташуурдах тоо арав арваар нэмэгдэн арван долоон удаа, хориндолоон удаа гэх мэтээр нэг зуун долоон удаа хүртэл нэмэгддэг бөгөөд олон олон гэмтэн хулгайч энэ шийтгэлийг даалгүй үхдэг байна. Морь хулгайлсан буюу өөр бусад цаазлах ялтай зүйлсийг хулгайлсан хулгайчийг сэлмээр тасар цавчин өчиггүй цаазлана. Хэрэв хулгайч хулгайлсан зүйлийнхээ үнийг ес дахин нугалан төлбөл цаазын ялаас хэлтрүүлнэ. Эзэн хаан бусад хаад ноёд, язгууртан түшмэд маш их мал хөрөнгөтэй байдаг, тэдний сүрэг доторх гүү, морь, тэмээ, шар үхэр, үнээ болон бусад бод малыг өөрсдийнхөө тамга тэмдэгээр тамгална. Тийнхүү тамгалж тэмдэглэсэн бод малыг хариулгагүйгээр бэлчээрт нь залах бөгөөд бусдын мал сүрэгтэй нийлж холилдвол тамга тэмдгээр нь таньж ялгаж салгаж авдаг. Харин хонь ямаагаа бол үргэлжийн хариулга, маллагаатай байлгана. Тэндхийн ямар ч мал бие томтой, тарга тэвээрэг сайнтай байна. Тэдэнд нэгэн хачирхалтай уламжлал заншил байдгийг би ярихаа мартаж шахжээ. Энэ сонин гэмээр зүйлийг сонсдоо, хоёр айл нэг нь дөрөв орчим насны хүүтэй, нөгөө айл нь мөн төдий хэр насны охинтой байтал тэр хоёр хүүхэд гэнэт насан өөд болчихвол талийгаач охиныг талийгаач хүүд богтлон өгч тэднийг гэрлүүлэх ёс үйлдэн, ургийн гэрээ бичиг үйлдэн түүнийгээ шатаахад утаа нь огторгуйд хөөрөн дэгдэж нөгөө ертөнцөд буй хүүхдүүдэд хүрэхэд тэд эр, эм бололцдог гэнэ. Үүний дараа эцэг эх, төрөл төрөгсөд нь хуримын баяр найр хийж идээ будаагаа тэнгэрт өргөхөд мөн л нөгөө хоёр хүүхэд хоол, зоог болон хүрнэ гэнэ. Бас нэгэн сонин заншил бол цаасан дээр зарц боол, адуу мал, бөс даавуу, мөнгө төгрөг, гэр орон, тавилга зэрэг зүйлсийг зураад мөн шатааж утаагий нь тэнгэр огторгуйд хөөргөх ахул тэдгээр зүйл нөгөө ертөнцөд халин одсон хүүхдүүд хүрч тэдний эд өлөг болдог гэх. Энэ бүхий зан үйлийг үйлдсэний дараа бие биедээ худ ураг болсны ам тангараг өргөн хүүхдүүдэд нь амьд сэрүүн байсан бол ийм л байх ёстой гэсэн ургийн холбоогоо сахицгаана.

Тартаруудын зан заншил, ёс дэгийн тухай гоёж чимэлгүй ярилаа. Харин бүх тартаруудын бурхан Их хааны тухай, түүний орд харшийн тухай энд дурсаж ярьсангүй. Цагаа болохоор би та бүхэнд тэр тухай яринаа, тэрхүү агуу гайхамшгийг энэ номонд бичиж, дурсаж үлдээнээ. Одоо бид гэдрэг эргэж, тартаруудын тухай яриагаа эхэлсэн тал нутагтаа буцаж очье. Аялагчид бид Хархорум болон тартарууд Эзэд хаад, язгууртан дээдсээ онголон оршуулдаг Алтайн уулсыг ардаа үлдээж умар зүгийг зорих аваас дөчин өдөрчийн газар цэлийн үргэлжлэх Баргу (Bargu)<sup>120</sup> хэмээх их тал нутагт ирнэ.

Оршин суугчдийг нь Мекрит (Mekrit) гэж нэрлэх агаад бүдүүлэг, зэрлэг хүмүүс байдаг. Тэдний амьдрал ахуй нь ан амьтнаас ихээхэн хамааралтай, ялангуяа цаа буганаас бүрэн хамааралтай, тэд цаа бугаа хүнс тэжээлд хэрэглэхээс гадна уналга, ачилганд ч хэрэглэнэ. Тэдний зан заншил, амьдралын хэв маяг нь тартаруудтай төстэй, бүгд Их хааны албаг боол билээ. Тэд тариа будаа, архи дарс гэдгийг огт мэдэхгүй. Зуны цагт тэр нутагт ан араатан, жигүүртэн шувууд маш элбэг, харин өвөл жигтэйхэн хүйтэн болдог тул араатан, жигүүртэн нь нүүдэллэн арилна. Зуны улиралд тэр нутгийн тоогүй олон нуур, цөөрөм, намагт усны шувууд цугларна, шувууд өд сөдөө гээж гуужих үедээ нисэж чадахгүй болох бөгөөд тэр үед нь нутгийн анчид хэдийг авлахыг хүсвэл төдийг авладаг байна. Тэр нутгийнхан мөн загас барьж

хүнсэндээ хэрэглэнэ. Дөчин хоног аялсны дараа аянчид их далайд тулж ирнэ. Эндхийн уулсаар аянч шонхорууд үүрээ засна. Энэ нутагт эр, эм хүн битгий хэл араатан амьтан, жигүүртэн шувуу ч үгүй бөгөөд зөвхөн баргхэрлак хэмээх шувууны нэгэн төрөл байх бөгөөд шонхор шувуу тэднийг ангуучилна. Баргхэрлак нь биеэрээ ятууны хэртэй, тоть шиг хөлтэй, хараацай шиг сүүлтэй нисэн дүүлэхдээ маш чадмаг, шаламгай. Тэдгээр шувуудын нисэж байх нь гайхамшигтай. Их хаан аянч шонхор бариулахаар энэ газар руу хүмүүс илгээнэ. Энэ далайн нэгэн арал дээр цагаан шонхор үүрлэнэ. Энэ муж бол алс умар зүгийн нутаг гэдгийг та бүхэн анзаарч буй биздээ, эндээс харахад Алтан гадас од хүртэл өмнө зүгт үзэгдэнэ. Энэ нутагт цагаан шонхор маш элбэг, Их хаанд хичнээн цагаан шонхор хэрэгтэй бол эндээс төчнөөнийг барьж авчируулна. Загалмайтны улс орнуудаас монгол руу илгээдэг цагаан шонхоруудыг Их хаан л авдаг байх гэж бодвол эндүүрэл болно, тэдгээр шонхорыг үнэндээ Левантийн хаадад илгээдэг, жишээлбэл Аргун хаан болон бусад хаадад хүргэдэг билээ. Хойт далай хүртлэх умарт нутгийн талаар өгүүлэхэд нэг иймэрхүү байна даа. Одоо бид эргээд Их хаанд хүрэх зам гудсын дагуух муж газраар дайран өнгөрөхдөө урьд миний цухас өгүүлсэн Канчау мужаас эхэлье. Аянчид маань Канчау мужийг орхин дорно зүгийг чиглэн сүнс, чөтгөрөөр дүүрсэн газар орныг таван хоногийн турш туулан өнгөрөхөд шөнөжин элдэв дуу чимээ, хашгираан гууглаан дундуур зогсоо жолоогүй аялсаар Эргюль (Erguiul) хэмээх ханлигт хүрч очно. Энэ бол Их хааны харьяат газар бөгөөд олон жижиг ханлигаас бүрэлдэн тогтох Тангуд улсын нэгэн муж билээ. Хүмүүс нь Нестор урсгалын загалмайтан, онгон шүтлэгтэн болон Магометийг шүтдэг лал шашинтнууд болно.

Энд хот суурин олон, нийслэл хот нь Эргюль. Энэ хотоос зүүн өмнө зүгийг чиглэн гарах зам Катай оронд хүргэнэ. Энэ зам гудас дагуу Синжу (Sinju) хэмээх хот орших бөгөөд уг хотын байрших мужийг мөн ялгаагүй Синжу гэнэ. Синжу муж олон хот сууринтай, Тангудын нэгэн хэсэг бөгөөд Их хаанд харьяалагдана. Оршин суугчдын олонх нь онгон шүтлэгтнүүд, Магометийг шүтэгчид байхаас гадна цөөн тооны Загалмайтнууд бий. Энэ нутагт заан шиг том биетэй, гадаад төрх байдал нь үзэмжтэй, нуруунаасаа бусад бүх бие нь сахлаг урт үсээр бүрхмэл, хар алаг зүсмийн зэрлэг үхэр олон. Энэ үхрийн үсний 121 урт нь гурван сөөм элбэг хүрнэ, хараад баймаар сүрлэг сайхан амьтан. Эдгээр үхрийг гаршуулан гэрийн тэжээмэл мал болгосон нь тоогүй олон, мөн өсөж үржих нь ч хурдан. Эднийг нуруу ачиж ачаа тээвэрт хэрэглэхээс гадна анжсанд хөллөж газар хагалахад зүтгүүр болгох агаад жирийн үхрээс хувь илүү хүч тэнхээтэй тул мөн төдий хэмжээний газрыг илүү хагална.

Энэ нутагт хорвоогийн хамгийн тансаг үнэртэй дээд зэргийн заар гаргаж авна. Заарыг хаанаас, яаж гаргаж авдаг талаар өгүүлбэл: Гөрөөс шиг бие галбиртай, өтгөн үсээр өвч хучигдсан өчүүхэн буганаас гаргаж авна. Түүний хөл, сүүл нь гөрөөснийх шиг, эвэргүй, дөрвөн нарийхан соёотой, үүний хоёр нь тагнайнаасаа доошоо, хоёр нь эрүүнээсээ дээшээ ургасан бөгөөд гурван хуруу орчим урт байх. Энэ амьтан их л хөөрхөн амьтан билээ. Заарыг авахдаа дээр ярьсан жижиг бугыг барьж аваад хүйснийх нь орчим гэдэсний нь арьс махны завсар хуралдсан өчүүхэн жижиг хүүдийтэй цус байх агаад тэр цус бол нөгөө анхилам сайхан үнэртэн заар 122 болой. Түүнийг арьстай нь хамт зүсэж аваад цэвэрлэнэ. Ийм сайхан анхилам үнэртэй заар энд элбэг байх юм. Оршин суугчид нь худалдаа, гар урлал, үйлдвэрлэл эрхлэх боловч тариа будаа элбэг дэлбэг.

Энэ орны газар нутаг нь өргөн уудам бөгөөд хорин таван өдөрчийн газар үргэлжилнэ. Тэнд

бас нэгэн төрөл гургуул байх бөгөөд манай нутгийн гургуулаас нэг дахин том биетэй, бараг л тогос шувуу шиг том биетэй. Заримых нь сүүл арван төө, заримых нь есөн буюу найман төө, үгүй ядаж л долоон төө урт байна. Мөн манай эндхийн гургуул шиг бие галбиртай гургуул ч бий. Дэгжин сайхан өд сөдтэй, янз бүрийн өнгө төрхтэй жигүүртэн шувууд элбэгтэй.

Хүмүүс нь бүгд онгон шүтлэгтнүүд байх. Тэд хар үстэй, намхан хамартай, мариалаг хүмүүс байдаг. Оочинд нь ургасан хэдэн үсийг эс тооцвол сахалтай хүн үгүй. Бүсгүйчүүд нь толгойн үснээс өөр биедээ огт үсгүй, гэгээлэг цагаан арьстай, турьхан нарийн гар, хөлтэй, биеийн галбир төрх нь гол шиг гоолиг. Эрчүүд нь ужид цэнгэлд нэн дуртай тул хэд хэдэн эхнэр авна. Тэдний хууль, заншлаар олон эхнэр авахыг хориглож цээрлэсэн зүйл үгүй тул тэжээж, хувцаслаж дийлж байвал хэдэн ч эхнэр авсан болдог. Язгуур гарваль доорд боловч гоо үзэсгэлэн төгс охид бүсгүйчүүдийг ноёд, дээдэс эхнэр болгон авах нь олонтой, тэд охины эхэд инж болгож, хэлэлцэж тохирсныхоо дагуу их хэмжээний мөнгө төгрөг төлнө. Одоо дорно зүг хийж буй аяллаа үргэлжлүүлэе.

Аялагчид маань Эргюль хотоос гарч дорно зүгт найман хоног аялсны эцэст Тангудын өөр нэгэн мужид хүрэх бөгөөд тэр мужийг Эгригаяа (Egrigaia) гэж нэрлэнэ. Эгригаяа мужид хот тосгод олон, гол хот нь Калачан (Kalachan) болой. Оршин суугчдын дийлэнх нь онгон шүтлэгтэн боловч нестор урсгалын загалмайн шашинтны гурван ч сүм хийд байдаг. Энэ муж Их хааны харьяат нутаг юм. Эндхийнхэн тэмээний ноосоор маш сайхан “камлот” хэмээх цэмбэ нэхнэ. Цагаан тэмээний ноосоор сайн чанарын, сайхан цагаан өнгийн “камлот” цэмбэ их хэмжээгээр нэхнэ. Нэхсэн цэмбээ гадаадын олон улс оронд гаргаж борлуулах бөгөөд Катар оронд ч гаргадаг билээ.

Одоо бид замаа үргэлжлүүлэн алс хол дорно зүгт орших Прэстэр Жоно хараат нутаг байсан Тэндүк (Tenduc) мужийг дайран өнгөрцгөөе.

Тэндүк мужид хот тосгод олон. Гол хот нь Тэндүк. Прэстэр Жоно удам угсааныхан болон эндхийн хүмүүс бүгд Их хааны харьяат албагууд билээ. Мужийг Прэстэр Жоно удам угсааны хан захиран суух бөгөөд тэр нь загалмайн шашны хувраг хүн “Прэстэр Жон” гэсэн хэргэм алдрыг зүүнэ. Түүний өөрийн нь нэрийг Жорж гэдэг. Тэрээр Прэстэр Жоно хараат нутгийн нэгээхэн хэсгийг захиран суух бөгөөд Их хааны харьяат албат билээ. Тартарын их хаад өөрсдийн гүнж буюу ойрын садан төрлийнхөө гүнжийг ямагт Прэстэр Жоно удмын хан нарт гэргий болгон буулгаж соёрходгийг та бүхэн мэдүүштэй.

Энэ мужид “камлот” хэмээх сайн чанарын тэмээний ноосон цэмбэ үйлдвэрлэхээс гадна сайн чанарын номин чулууг ихээр олзворлоно. Оршин суугчид нь мал аж ахуй, газар тариалан эрхлэнэ. Нэг хэсэг нь худалдаа арилжаа, гар үйлдвэрлэл эрхлэнэ. Мужийг захиран тохинуулагчид нь загалмайн шашинтнууд боловч олон тооны онгон шүтлэгтэн, Магометийг шүтэгч лал шашинтнуудтай. Аргон хэмээх нэгэн бүлэг хүмүүс байх бөгөөд тэд нутгийн уугуул хүмүүс лал шашинтны холимог гэр бүлээс төрсөн “эрлийз” хүмүүс билээ. Аргонууд нь бусдаасаа илүү царайлаг төдийгүй илүү ухаалаг, ажил хэрэгч хүмүүс байдаг. Энэ муж бол цагтаа Прэстэр Жон тартаруудыг болон ойр зэргэлдээх овог аймгийг эзэгнэн захирч ахуйдаа төвлөн сууж байсан нутаг билээ, одоо ч энд түүний удам угсааныхан нутаглан сууж амьдарсаар буй. Жорж хан бол түүний удмын зургаа дахь үеийн эзэн бөлгөө. Энэ газар орныг манайхаар бол Гог ба Магог гэж нэрлэх агаад харин эндхийнхэн Унг ба Мунгул гэж нэрлэх

юм. Энэ хоёр мужид өөр өөр овог аймгийнхан оршин суух агаад Унг мужид нь Гог нар, Мунгул мужид нь тартарууд нутагшин суурьшижээ.

Аялагчид маань энэ мужийг<sup>123</sup> нэвт сүвлэн долоон хоногийн турш дорно зүг рүү Катай орныг тэмцэн аялахдаа Магоменийг шүтэгч лал шашинтан, онгон шүтлэгтэн, нестор урсгалын загалмайн шашинтнууд шаван суусан хот, тосгодыг дайран өнгөрнө. Тэдгээр хүмүүс худалдаа арилжаа, гар үйлдвэр эрхлэн аж төрөх бөгөөд насич, нах хэмээх алтан саатай хоргой, төрөл бүрийн торго нэхнэ. Мөн манай нутагт байдаг шиг төрөл бүрийн ноосон даавуу нэхэж үйлдвэрлэнэ, тэдний алтан саатай хоргой, торго нь сайхан эд тул авцгаагаарай. Ард иргэд нь цөм Их хааны харьяат албатууд билээ.

Энэ газар Синдачу (Sindachu) хэмээх нэгэн хот буй бөгөөд тэнд цэргийн зэр зэвсэг, элдэв тоноглол, хэрэгсэл үйлдвэрлэдэг. Энэ мужийн Идифу хэмээх ууланд их нөөцтэй, онцгой сайн чанарын мөнгөний уурхай байдаг. Зэрлэг ан араатан, жигүүртэн шувууд элбэг.

Энэ муж, хотыг ардаа үлдээн цаашаа гурван хоног аялахад бидний зам гудаст Цагаан-нуур (Chagan-nor) хэмээх хот таарах агаад энэ хотод Их хааны нэгэн ордон байх. Хун шувуу цугларсан нуур цөөрөм, гол горхи элбэгтэй энэ газрыг Их хаан ихэд таалдаг бөгөөд байн байн энд ирнэ. Энд тогоруу, гургуул, ятуу болон бусад олон төрлийн зэрлэг шувууд дүүрэн нутаглах сайхан тал газар буй бөгөөд тэр талд Их хаан шонхор, цагаан шонхор шувуудаар ав шувуу агнаж ангуучлах дуртай билээ. Тэнд таван төрлийн тогоруу байх агаад би та бүхэнд тэдний талаар өгүүлье: Тэдний нэг нь хэрээ шиг хав хар өнгөтэй, товир том биетэй, нөгөө нэг нь дун цагаан өнгөтэй. Түүний даль жигүүр, өд сөд нь тогосынх шиг дугуй дугуй алтан өнгийн толботой. Толгой нь час улаан өнгөтэй атлаа хүзүү нь хар цагаан өнгөөр алагласан, хамгийн том биетэй тогоруу билээ. Гуравдахь нь манай нутагт байдагтай ижилхэн, дөрөвдэх нь шавилхан жижиг биетэй, хүзүү, чихийг нь тойрсон өд нь урт хар, улаан алагласан өнгөтэй, тавдахь нь өвч хар өнгөтэй мөртлөө толгой, хүзүүний өд сөд нь улаан, хар хосолсон маш үзэсгэлэнтэй бөгөөд тэдгээр тогоруу маш товир том биетэй.

Хотын ойролцоох уужим хөндийд катор хэмээх нэгэн төрлийн ятуу мэт боловч ятуунаас биеэр том шувууд сүрэглэн идээшлэх агаад тэдний тоо толгой маш их бөгөөд сүрэглэн нисэж байхыг нь хараад байгууштай. Их хаан эдгээр шувуун сүргийн хооллох дуртай хар, шар будааг тэндхийн уул, толгодын хажуугаар тарьж ургуулаад хураалгүй орхиж тэднийг хооллож байхыг зарлигдан тушаажээ. Мөн олон тооны харуул манааны хүмүүс тэр шувуудыг бусад анчид агнаж алахаас сэргийлэн хамгаалж байдаг. Өвөл болохоор энд тэндгүй хар будаа цацаж хооллоно. Будаа цацангуутаа исгэрэн дохиолоход бүгд нисэн ирж хооллоно. Тэдгээр шувуудын хоргодох хоноглох үүр гонхон олныг барьж байрлуулсан байдаг. Их хаан энэ газар ирэнгүүтээ тэдгээр шувуудыг агнаж авлана. Өвлийн хүйтэнд тэдгээр шувууд энэ хөндийгөөс дайжин нөмөр дулаан газар хурах тул тэр газар нь тэмээгээр будаа тээж аваачин асгаж хооллоно.

Аялагчид маань энэ хотоос гарч умар, зүүн умар зүгийг барин гурван хоног аялаад Шанду (Shang-tu) хэмээх хотод ирэх бөгөөд энэ хотыг эдүгээ төр барьж буй Их хаан Хубилай хаан барьж байгуулсан билээ. Энэ хотод гантиг чулуу болон бусад гоёл чимэглэл хийдэг чулуугаар цогцлоосон Хубилай хааны ордон бий. Ордны өрөө тасалгаа, танхимуудыг алтаар чимэж гоёсон нь үнээхээр үзэмж төгс болжээ. Энэ ордны нэг өнцөг нь хотын төв хүрч байхад, нөгөө өнцөг нь хотын хэрэмд тулж байх асар том өргөө билээ. Өргөө ордныг тойруулан арван

зургаан бээр урт хэрэм цогцлуулсан бөгөөд дотор нь төрөл бүрийн мод, цэцэг суулгаж зүлгэжүүлсэн төдийгүй олон усан оргилуур, гол горхи, нуга бэлчээртэй цэцэрлэгт хүрээлэнтэй билээ. Цэцэрлэгт хүрээлэнд орох тусгай хаалга, үүд үгүй бөгөөд зөвхөн хааны ордноор дамжиж орно. Энэ цэцэрлэгт хүрээлэнд торонд суулгасан Их хааны цагаан шонхор болон бусад шонхор, анч шувуудыг тэжээхэд зориулсан марал, буга, гөрөөс зэрэг зэрлэг ан амьтад цэцэрлэгт хүрээлэнд дураараа бэлчинэ. Энд хоёр зуу илүү цагаан шонхор торонд сууж байх агаад Их хаан долоо хоног бүр тэдгээр шонхорыг хэрхэн яаж арчилж, тэжээж байгааг үзэхээр өөрөө ирнэ. Заримдаа мориныхоо зоон дээр анч ирвэс сундалж ирээд цэцэрлэгт хүрээлэнгийн марал, буга, гөрөөсийг авлаж ан хоморго хийж зугаацах бөгөөд барьсан ангийн олзоороо нөгөө олон шонхор шувуудыг тэжээнэ.

Энэхүү цэцэрлэгт хүрээлэнгийн дунд Их хааны зарлигаар нэгэн сайхан том ордыг хулсаар барьжээ. Тэр ордны дотор талыг алтаар доторлож, ан араатан, жигүүртэн шувуудын зураг, чихмэлээр гоёж чимсэн байдаг. Ордны дээврийг алтдаж, маажиндсан хулсан баганаар тулжээ. Дээврийг нь мөн маажиндсан хулсаар хийсэн нь ямар ч бороо ус гоожихгүй болжээ. Тэр дээврийг хэрхэн яаж хийснийг тайлбарлан хэлж өгсүгэй. Гурван сөөм илүү бүдүүн, арав, арван таван алхам урт хулсыг үеэр нь тайрч, дундуур нь зүсэж дэлгээд дээвэр хийсэн нь тун ч уран гоё хийцтэй болсноор барахгүй бөх бат болжээ. Ийм урт цооног хулсаар ус зайлуулах хоолой хийсэн нь мөн аятайхан болжээ. Ингэж уг ордныг өвч бүтнээр нь хулсаар барьж цогцлуулжээ. Хулсан дээврийг салхи савирт нураачихгүйн тулд хооронд нь хадаж бэхэлжээ. Их хааны таалалд нийцүүлэн хулсан байшинг нүүлгэж зөөж байхаар бодож хоёр зуу илүү торгон мяндсаар аргамжиж тогтоосон байдаг.

Их хаан зуны гурван сар буюу зургаа, долоо, наймдугаар саруудыг Шанду хотод зусаж, ид дүүгсэн халууныг энд өнгөрөөнө. Их хааныг Шандуд заларч байх гурван сарын хугацаанд хулсан байшинг барьж төвхөнүүлээд бусад цагт нь хурааж хадгална. Хулсан байшинг угсарч барих, буулгаж хураах гэдэг нь сэтгэл санаа тайвширч амарсан сайхан үйл билээ.

Их хаан жил бүрийн наймдугаар сарын хорин наймны өдөр хааны ордныг орхин гарч Шанду хотоос морилон оддог билээ. Учир нь: Түүнд цас мэт цагаан, өөр ямар нэгэн өнгөний толбын төдий ч хольцгүй цав цагаан адуун сүрэг байх агаад тэр сүргийн доторх гүү л гэхэд түм гаран толгой хүрнэ. Тэдгээр гүүний сүүг зөвхөн алтан ургийн хаан язгууртан л уухаас өөр хэнч ууж үл болно. Энэхүү дэг журамд нэгэн зүйл заалт буй бөгөөд тэр нь: Цагаан гүүний сүүг хориад (horiat) омгийнхон ууж болно гэж Эзэн Чингис зарлиг болгосон нь хуучин цагт ойрадуудын дайн тулалдаанд байгуулсан гавьяа зүтгэлийг онцгойлон үнэлсэн шагнал урамшуулал билээ. Цагаан сүрэг явж байхтай тааралдвал эзэн дээдэстээ ёслон мэндлэх адил толгой гудайлган хүндэтгэл үзүүлэхээс биш цагаан сүргийн дундуур зүтгэж гарах хориотой, эсвэл явж дуустал нь хүлээж зогсоно, эсвэл ар хударгаар нь тойрч гарна. Зурхайчид болон онгон шүтлэгтнүүд Их хаанд ийн өгүүлсэн байна: Жил бүрийн зуны адаг сарын хорин найманд цагаан гүүний сүүгээр газар дэлхий, мөнх тэнгэрт цацал өргөж, залбирал мөргөл үйлдэгтүн. Ингэж Таны эд хөрөнгө, тариа будаа, мал сүргийг арвижуулан тэтгэгч, эр эм бүх хүн, ан араатан, жигүүртэн шувуудыг харж хамгаалан, ивээн тэтгэж, өсгөж үржүүлэгч онгон сахиус, газар лус, тэнгэр бурханыг тайж тахиж, ундаалан цэнгүүлж байгаа билээ гэжээ.

Ийм учраас Их хаан яг энэ өдөр орд өргөөнөөсөө гарч Шанду хотыг орхин өөр тийшээ

морилон оддог билээ. Би бас мартаж орхисон нэгэн зүйлийг та бүхэнд санаж байгаа дээрээ өгүүлэе. Тэнгэр хуйсагнаж, бороо орж уйлагнасан таа муутай нэгэн өдөр Их хааны орд өргөөнд байсан зурхайч, үзмэрч-төлөгчид уншилга тарниа үйлдэж, тэнгэр лусаа дуудан шившиж хааны ордны ойр орчимд наран ээж гийсэн цэлмэг сайхан өдөр болгоход эргэн тойрон тэнгэр бүрхэг бүүдгэр, бороо хуртай хэвээрээ байсан ид шидийн гайхамшигт эшийг үзүүлж билээ. Тэрхүү ид шидийг барин тавин үзүүлсэн хүмүүс нь төвд, кашмир овгийн хүмүүс байв. Аль аль нь онгон шүтлэгтэн билээ. Тэдгээр онгон шүтлэгтнүүд нь хорвоогийн бусад аль ч үндэстнээс илүү чөтгөр шулмын ид шидийг өвлөн эзэмшсэн байдаг. Харин өөрсдөө бол тэр хар хүчнийхээ ид шидийг Бурхан тэнгэрийн ивээлээр гэгээрсэн хувилгаадийн үзүүлж буй эш гэж бусдыг ятган сэнхрүүлж, ойлгуулахыг хичээнэ. Төвд, кашмирийн зурхайч, үзмэрч-төлөгч гэх хүмүүс нүүр гараа угаадаггүй, үс гэзгээ самнадаггүй хир буртагтаа баригдсан халтар нүүр царайтай явах нь олон. Үс гэзгээ самнаж, нүүр царайгаа угаан нүдэнд дулаан харагдахаар явавч үргэлжид ядуу хоосны туйлд хүрсэн гуйлгачин хэвээрээ байдаг. Эдгээр хүмүүс зөвхөн тэдний мөрдөн дагадаг онцгой уламжлал заншилтай талаар би та бүхэнд цухас дурьдая. Төрийн хуулиар алах ял заагдсан хүмүүсийг цаазлан хороонгуут тэдний цогцосыг эдгээр төвд, кашмир овгийн онгон шүтлэгтэнгүүд аваачиж чанаж иднэ. Харин жам ёсоороо өөд болсон хүмүүсийн бие цогцост огт гар хүрдэггүй.

Багш (Bakhshi) хэмээн нэрийдэх эдгээр ид шидтэнүүдийн үзүүлсэн бас нэгэн гайхамшигийн тухай та нарт өгүүлэе. Хааны ордны их танхимийн хойморт шалнаас дээш найман тохой өндөр сэнтийд залран суух Их хаанаас сайн арван алхам зайд их танхимийн шалан дээр өрсөн аягануудыг дарс, сүү болон бусад ундаагаар мэлтэлзтэл дүүргээд нөгөө багш гэгдэх ид шидтэнгүүд шившлэг тарниа уншихад дарстай, сүүтэй аяганууд хөөрөн нисэж Их хааны сэнтийд нисэж хүрэхийг<sup>124</sup> танхимд суусан түм илүү зочид гийчид, язгууртан дээдэс амаа ангайлган, нүдээ бүлтийлгэн харцгааж суусан. Энэ бол яахын аргагүй миний нүдээрээ харсан зүйл болохоор маргашгүй үнэн билээ. Ийм ид шидийн увдис байж байгааг тэдгээр цогцос зооглогч ид шидтэнгүүд хаана боловч хийж чадна гэж батлан хэлэх вий.

Онгод тайллагын цаг ойртмогц тэдгээр багш нар Их хаанд бараалхан ийн өгүүлрүүн: “Эзэнтээн, манай онгодыг тахиж тайлах цаг тулж ирлээ” гээд ямар ямар онгодыг яаж тахиж тайхаа нэрлэн тоочоод: “Өршөөлт Их дээдэс минь манай онгодыг тайж тахижгүй бол ган зуд нүүрлэж, гай гамшиг дайран мал сүрэг үхэж, тариа будааны ургац алдаж, өвчин зовлон ээрч, өлсөглөн ядуурал газар авахыг Эзэн дээдэс та бэлхнээ толилож буй билээ” гэнэ. “Иймд өршөөлт эзэн минь манай онгодын тахилга тайлага хийхэд хэрэгтэй ...хар түрүүтэй хонь тэдийг, хүж, гүгэл, агар болоод бусад зүйл төд төчнөөнийг гаргаж өгөхийг зарлигдан тушаана уу” гэж гуйцгаана. Мөн Их хааны ойр шадар ноёд түшмэдэд мөн л энэхүү хүсэл, гуйлтаа айлтган өөрсөддөө хэрэгтэй бүхнийг гаргуулан авч онгодоо тахиж тайх их хурал номын уншилга үйлдэж, их найр хурим цогцлооно. Онгодынхоо өмнө зул хүж асааж, бүхэл махаар идээ шүүс өргөж, шөлөөр нь тахил тавин цацал өргөж онгодоо хүссэн бүхнээр нь хооллож, ундалж элбэг баян тахилга тайж, өргөл өргөж байгаагаа үглэн дуулан шившинэ. Ингэж тэд нар онгодоо тахиж тайдаг заншилтай билээ.

Онгон болгон яг л манай бурхад шиг тус тусдаа тайлага тахилгатай. Онгон шүтлэгтэн бүхэнд зориулсан сүм хийдтэй, зарим нь бүр жижиг хот мэт бөгөөд нэг хийдэд хоёр мянга гаруй лам нар хурал номд суух нь энүүхэн энд, тэд бусад хүмүүсийг бодвол цэвэр цэмцгэр бас хувцас



хунар нь илүү сайн. Тэдгээр лам нар үс, сахлаа гилийтэл хусах бөгөөд онгодынхоо тайлага тахилга хийхдээ тэднийхээ магтаал дуудлагыг эгшиглүүлэн урьд өмнө үзэгдээгүй сайхан гэрэл гэгээ бадраана.

Багш хэмээн өргөмжилөгдсөн зарим том лам, санваартнууд нь эхнэр авч, олон хүүхэд төрүүлнэ. Үүнээс гадна өөр төрлийн шүтлэг, мөргөлтэй Синсэн (Sien-seng) хэмээх шашин байдаг. Синсэн шашны лам, саваартнууд нь маш чанга хатуу, чанд дэг журмыг ягштал сахин баримтлана. Тэд их урт насална, тэд нар зөвхөн улаан буудайн хивгээр хооллоно. Улаан буудайг бүлээн усанд дэвтээж агшаагаад өөр юутай ч хольж амтлалгүй тэр чигээр нь иддэг. Үүнээс өөр юм иддэггүй боловч ойр ойрхон мацаг барина. Тэд олон том онгод тахидаг мөн гал шүтдэг. Бусад онгод шүтлэгтнүүд синсэн шашныхныг буруу номтон гэдгийн учир нь тэд онгод шүтээндээ мөргөх, түүнийг тайж тахиx нь бусдаасаа ялгаатай билээ. Синсэн шашны лам хуврагууд хэзээч эхнэр авдаггүйгээрээ бусадаасаа онцгойрон ялгарна. Синсэн шашныхан хөх өнгийн нэхмэл ёрог даавуун хувцас өмсөж үс, сахлаа хусдаг. Шаардлагатай цагт торгон буюу торгомсог хувцас өмсөх боловч мөн л хөх өнгөтэй байна. Тэд нар нэхмэл сийрсэн дэвсгэр дээр унтаж, ертөнцөд ховор тохиох хатуу хэцүү дэг жаягтай, орчлонгийн цэнгэл, жаргал бүхнийг огоорон орхисон энгийн бөгөөд хүнд амьдралаар амьдарна.

Одоо би та бүхэнд үнэнхүү гайхмаар гайхамшигтай зүйлийг өгүүлсү. Энэ бол бүх Тартарын эздийн агуу Эзэн, суу алдарт Их Хаан-Хубилайн тухай өгүүлнэ.



Одоогийн Их хаан (Great Khan) 125-ы агуу амжилтийн тухайд өгүүлэхийг зорьсон уг номын гол санаанд ингээд ороё. Хаан (Khan) хэмээх алдар хэргэм нь манай хэлээр “Эздийн дээд Эзэн” гэсэн утгатай. Энэ хүчирхэг нэр цолд тохирох Их хаан лугаа адил эзлэн захирсан газар нутаг, эд баялгаараа харьцуулашгүй хүчирхэг хүмүүн энэ дэлхийд одоо ч байхгүй, хүн төрөлхтний өвөг Адамаас өнөөг хүртэл төрж, өсөж өндийгсөдийн дотор ч байгаагүйг бүгд мэдвэл зохино. Энэ бол та бид ярилцаад зогсож байгаа шиг энгийн бөгөөд бодит үнэн гэдгийг та минь ойлгоорой, Хубилай (Khubilai) хаан бол манай газар дэлхий дээр төр улсаа байгуулан амьдарч, тэмцэж явсан хаадын хэнтэй ч зүйрлэмгүй агуу их эзэн гэдэгт би огтхон ч эргэлздэггүй. Үүний гэрч, баталгаа нь миний энэ ном билээ.

Тэрбээр, Чингис хааны шууд удмын хүн гэдгийг юуны өмнө та бүхэнд таниулж байгаа бөгөөд зөвхөн энэ л угшил гарвал нь түүнийг бүх Тартаруудын Эзэн суухад элбэг хангалттай билээ. Тэр бол бүх Тартаруудын зургаадахь Их хаан бөгөөд Христос мэндэлсний 1256 онд Эзний сууринд заларснаар түүний засаглал эхэлжээ. Түүний ахан дүүс, ураг төрлийн олон хүн Хубилайгаар Эзэн хааны ор залгуулан өргөмжлөхийн эсрэг тэмцсэн боловч бүхнийг эр зориг, эрдэм ухааны ид хаваар тэр ялан дийлжээ. Их Эзний ор сууснаас хойш эдүгээ 1298 он болж бүтэн дөчин хоёр жил улиран оджээ. Тэрбээр одоо наян тавныхаа нас сүүдрийг зооглосон ч бие тэнхлүүн, ухаан саруул. Их хааны ор суухаасаа өмнө олон олон дайн тулалдаанд оролцон эрэлхэг зоригтой байлдагч, ухаалаг шударгуу жанжин 126 гэдгээ харуулсан. Төр барьсан цагаасаа хойш нэг л удаа дайтан тулалдсан бөгөөд энэ явдал 1286 онд болсон, энэ тухай би та нарт дурсан өгүүлсү.

Хубилай хааны авга, олон муж, газрыг захиран суух Наян хэмээх их ноён байсан бөгөөд тэр хүн өөрийн захиран суух эзэмшил муж, газраас дөрвөн буман (400 000) морин цэргийг элбэгхэн дайчилж хөдөлгөх боломжтой байжээ. Наян ноёны өвөг дээдэс, удам судраараа Их хааны албат иргэд байсан төдийгүй одоо ч тэр өөрөө Их хааны албат билээ. Гэвч тэр үед гуч эргэм настай Наян ноёныг тойрон хүрээлсэн багт цөс ихэт идэр олон эрс нэгдэн цугласан төдийгүй дайн тулааны талбарт дөрвөн буман (400 000) морин цэрэг өлхөн гаргах их ноён бээр өөрийн дээр захирах эзэнгүй болохоор шийджээ. Ингээд Их хааны ач дүү боловч түүний эсрэг цэрэглэн босож, хэзээ ч эвлэрхээргүй дайсан нь болсон, хүчирхэг их ноён Хайдуд Наян ноён элч заран; Та өөрийн зүгээс цэрэглэн хөдөлж Их хааны газар нутаг руу уулгалан довтол, би нөгөө талаас нь өөрийн бүх хүчээр цэрэглэн дайрч түүний захиргаа засаглалыг эвдэн, газар нутгийг нь эзлэсүгэй гэжээ. Наян ноёны энэ саналыг Хайду хан талархан дэмжиж, дуртайяа хүлээн авч цэрэглэн хөдлөх хугацаагаа тохирцгоов. Хайду хан өөрийн эзэмшил муж нутгаас нэгэн буман (100 000) морин цэргийг дайчлан дайны талбарт гаргахаар боллоо. Үг олдож, үхэр холдож байгуужин хэмээн, Их хаанаа уулгалан довглох аян дайнд Наян, Хайду хоёр шуурхайлан зэхэж үлэмж олон морин болон явган цэрэг хуралдуулж чаджээ.

Дээрх ноёдын хуйвалдааны тухай сэтгэл түгшим мэдээ авсан Их хаан цочирдон алмайрсангүй, харин саруул ухаантай, эрэлхэг зоригт дайчны ёсоор цэрэг дайчдаа тулалдаанд бэлтгэж эхэлсэн бөгөөд тэрхүү хоёр тэрслүү муу хулгайг даран сөнөөхгүй юм бол Их Монгол гүрний Их хааны титмийг магнайдаа асааж, энэ дэлхийн талыг эзэгнэн захирахын хэрэг юун хэмээн айлдав. Их хаан дайны бэлтгэлээ машид нууцлан хийсэн тул энэ тухай түүний Цэцдийн зөвлөлийнхнөөс өөр хэнч ажиг сэжиг аваагүй агаад хорин хоёр хоногийн дараа цэрэг дайчид их тулаанд ороход бэлэн болжээ. Энэ удаа Их хааны тугийн дор хоёр бум зургаан түмэн морин цэрэг, нэг буман явган цэрэг жагсан жигдэрсэн байв. Их хаан энэхүү тулаанд зөвхөн өөрийн ойр шадар торгон цэрэг болон эргэн тойрны орон нутгийн цэргүүдийг цуглуулсан тул цэргийн хүн хүчин дээрх тоогоор хязгаарлагдаж байгаа билээ. Их хааны бусад арван хоёр армийн цэрэг дайчдын тоог сонсоод чихэндээ итгэх аргагүй олон боловч тэдгээр цэрэг дайчид хорвоогийн олон улс гүрнийг байлдан дагуулах их аянд мордсон тул тэднийг тогтсон хугацаанд, товлосон газраа нэгэн зэрэг цуглуулах боломжгүй байлаа. Хэрвээ Их хаан өөрийн бүх цэргийг нэгэн дор цуглуулах юм бол сэтгэлдээ багтааж, нүдэндээ итгэмгүй олон байх байлаа. Энэ удаа Их хааны тугийн дор жагсаж буй гурван бум зургаан түмэн эрс бол түүний бие хамгаалагч 127 торгон цэрэг, шонхорын ав хомрогын цэргүүдээс бүрэлдэж байв.

Хэрвээ Их хаан Катайн бүх муж, нутагт тархаан байрлуулсан цэргүүдээ цуглуулахаар дуудвал элбэг гуч дөчин хоног хэрэгтэй болно. Энэхүү мэдээ чимээ Хайду хан, Наян ноёны сонорт хүрч тэд ч яаран нэгдэж нэгэн цул болж улам хүчирхэгжин хамгийн ашигтай байрлалыг эзлэх аюултай байв. Хубилай Наяныг байлдааны бэлтгэлээ базааж гүйцэхээс өмнө шуурхай довтлон гэнэдүүлэн цохихоор зэхэж түүнийг холбоотонтойгоо нэгдэх боломж бололцоо олголгүй довголохоор шийдсэн бөгөөд ингэж түүнийг ганцаардуулан амархан ялж болохыг тооцоолжээ.

Одоо бид Их хааны цэрэг, армийн талаар зарим нэгэн иш баримтыг дурьдах нь зүйд нийцэнэ гэж бодох тул энд дурьдан өгүүлсү. Катай, Мэнз болон түүний хараат бусад орон газарт хааны засаг захиргаанд сэтгэл дундуур буюу дургүйцэн эсэргүүцэгч олон олон хүмүүн байх бөгөөд ая нь олдож эв нь таарвал Их эзнийхээ эсрэг босон тэмцэхэд хэзээд бэлэн байх бөлгөө. Ийм учраас хүн ам шигүү нутаглах муж, газар, томоохон хот балгад болгоны дэргэд өөрийн цэрэг, армийг байршуулахаас өөр аргагүй байдаг. Эдгээр цэрэг нь хот, балгадаас дөрөв, таван бээрийн зайд задгай талд хуарагнан суух бөгөөд гаднын хүмүүнийг үл нэвтрүүлнэ.

Эдгээр цэргийг болон тэдний захирагч нарыг хоёр жил тутамд сэлгэн шинэчилнэ. Энэ нь тэдний дунд элдэв хуйвалдаан үүсэж бослого, тэмцэл гаргуулахгүй байх зорилготой юм. Цэргүүдэд тухайн муж, хотын орлогоос байнга төлөх Их хааны цалин пүнлүүнээс гадна цэргийн анги хуаран болгон өөрийн гэсэн үхэр сүрэгтэй байж сүү, цагаан идээгий нь хот суурин газар борлуулан оронд нь хэрэгцээтэй хүнс, бараа таваараа сольж авдаг. Цэргийн эдгээр анги, хуаран нь янз бүрийн газар нутагт гуч, дөч зарим нь жаран өдөрчийн алс хол тархан байршижээ.

Их хаан дээр миний хэлсэн цөөн цэргээ цуглуулсны дараа өөрийн зурхайч, төлөгч нараас “Энэ дайн тулаанд бид ялах болов уу? Бидний ажил үйлс бүтэмжтэй болох болов уу” гэж лавлан асуухад тэдгээр зурхайч төлөгчид нэгэн дуугаар “Таны үйл хэрэг бүтэмжтэй байж Та ялна” гэсний дагуу Их хаан цэргээ хөдөлгөн хорин хоног аялсны дараа Наян ноёны дөрвөн бумаас (400 000) цөөнгүй морин цэрэг нөмрөн бүчсэн нэгэн их тал газарт хүрэлцэн ирлээ.

Их хааны цэрэг үүр цүүрээр нөмрөн орж ирэхэд Наян ноёны цэргүүд огтхон ч ажиг сэжиг аваагүй байлаа. Их хааны цэрэг орох, гарах бүх замыг нягтлан харуулдаж, түүгээр өнгөрөх явуулын улсыг бүгдийг баривчлан цагдан хорьж, Наян ноёны цэрэгт хэл хүргэж, холбоо барих нүх сүвийг сайтар хаасан тул Их хааны цэрэг ойртож байгаа талаар ямар ч мэдээ чимээгүй нүдэн балай чихэн дүлий сууцгаажээ. Их хааны цэрэг нөмрөн орж ирэхэд Наян ноён асар цацартаа хатантайгаа зугаацан орноосоо ч өндийгөөгүй амгалан нойрсож байжээ.

Тулалдаан эхлэх өдрийн үүр цүүрээр Их хаан өөрийн биеэр Наян ноёны цэрэг отоглосон талын дундах довцог дээр гэв гэнэт гарч ирэв. Наян ноёны цэргийн хүрээнд хэн ч зүрхлэн халдахгүй гэж итгэсэн их цэрэг ямар ч ажиг сэжиггүй амарцгааж байжээ. Тэдгээр цэрэг эрс айх аюул, халдах дайсан ирнэ гэж зүүдлээ ч үгүй тул цэргийн хүрээгээ хамгаалах харуулын анги, ядаж толгойн сэргийлэх ч гаргасангүй амгалан тайван нойрсож байжээ. Яг энэ үед Их хаан довцог толгойн орой дээр гэнэт гарч ирлээ гэж дээр бичсэн билээ. Бөх бат арьсаар хуяглаж, алтлаг саа, торгоор нэмнэсэн дөрвөн зааны нуруун дээр хулгавч нумтнууд, харваачид дүүрсэн модон цамхагт Их хаан зогсож байв. Түүний тэргүүн дээр нар, саран сүлдтэй хиур өндөрт намирч, хаанаас ч харагдахаар тод үзэгдэнэ.

Хааны нэг түмэн харваачтай (10 000) гучин хороонд хуваагдсан гурван гар их цэргийн баруун зүүн гараас нөмрөн давшиж, яах ийхийн зуургүй Наяны хуаранг бүслэн шахав. Морьт суман болгоны өмнө богино жад, илдээр зэвсэглэсэн таван зуун (500) явган цэрэг жагсжээ. Цэргүүд ухрах, зугтахад явган цэрэг болгон маш сурмаг морьт цэрэгтэй сундлан ухраад, ухрахаа зогсоход үсрэн бууж дайсны цэрэг, морьдыг жадлаж, цавчиж тулалдана. Наян ноёны цэргийн хуаранг бүслэн хаасан хааны цэрэг тулалдаанд ороход аль хэзээний бэлэн болжээ.

Наян ноёны цэргүүд хүрээ хуарангий нь бүслэн хааж буй хааны цэргийг үзмэгц машид балмагдан цочирдов. Тэд яаран сандран хуяг дуулгаа өмсөн, зэр зэвсгээ шүүрэн авч энд тэндгүй тушаал заавар хангинан цэргүүд яарч сандран эгнээ жагсаалаа жигдэлж эхлэв. Хоёр этгээд эгнээ жагсаалаа жигдлэн тулаанд бэлэн болмогц исгэрэх дуу гарч, тэгээд янз бүрийн хөгжим хангинан бүрээ жимбүүр цангинаж, эрчүүд хөөрөн дуу дуулцгааж эхлэв. Тартарууд дайсантайгаа тулгарахад бэлэн болсон хэдий ч жанжны хэнгэрэг дохио цохиж эхлэхээс нааш тулаанд ордоггүй билээ. Хэнгэргийн дохио хүлээх зуурт бүх Тартарууд хөгжмөө 128 тоглож, дуу дуулцгаана. Хөгжимдөх, дуулах чимээ шуугиан хоёр талаас адилхан цуурайтна. Хоёр этгээд бэлэн болмогц Их хааны хэнгэрэг эхлэн нижигнэв. Ноёр их цэрэг шийдвэртэй тулаанд орж, нум, илд, шийдэм, жадаар алалдаж эхлэв. Явган цэргүүд хулгавч нум зэргээр өвч зэвсэглэжээ. Юу хэлэлтэй билээ?! Энэ бол аймшигтай цуст тулааны эхлэл ажээ. Агаар тэнгэрээр харвасан сум исгэрэн бороо шаагих мэт битүү асгарч байлаа. Суманд оногдсон морь, хүн газарт үхэдхийн унацгаана. Тулалдааны дуу чимээ, эрчүүдийн уухай, хашгираан чих дөжрүүлэн тэнгэрийн дуу, аянгын нижигнээ ч үл сонсогдохоор нүргэлнэ. Наян ноён загалмайн усан баталгаат шүтлэгтэн байсан бөгөөд энэ тулаанд түүний туг загалмай тэмдэгтэй байсныг уншигч та мэдвэл зохино 129.

Яалаа гэж энэ тулалдааныг ийн сунжруулан өгүүлэх билээ? Дээр миний өгүүлсэн тулалдааны дүр зураг хангалттай. Ийм амь дүйсэн аймшигт тулалдаан урьд өмнө болж байгаагүй юм шиг санагдана. Өнөө бидний цаг дор ийм үй олон эрс нэг тулааны талбарт, тэр дундаа тоо тоймшгүй морьтнууд оролцсон алалдаан байгаагүй билээ. Аль аль тал нь үй олон цэрэг эрсээ тулалдааны талбарт үхдэл болгон үлдээхийг харах байтугай бодоход ч аймшигтай. Тулалдаан үүрийн гэгээнээс үд дунд болтол удаан хугацаанд хүч тэнцэн байлдаж. Наяны талынхан тулалдааны талбараас зулбан зугтаж нуруугаа харуулахын оронд өгөөмөр сэтгэлт ноёныхоо төлөө үхсэн дээр гэж үзэцгээн тулалджээ. Гэвч эцэст нь Их хааны ялалтаар төгслөө. Наян ба түүний хүмүүс удаан тэсэхгүйгээ мэдэж зугтах гээд завдалгүй Наян ноён өөрөө олзлогдож, түүний дарга цэргүүд Их хаанд бууж өгчээ.

Наян ноёныг барьж хорьсныг дуулангуутаа түүнийг Их хаан цаазлан хороохыг зарлиг болов. Түүнийг яаж хороосон бэ гэвэл, хивсээр (carpet) бүтээж чивчиртэл баглаад, хэрцгийгээр чирч үхүүлэв. Хааны удам угсааны хүнийг цус гаргалгүй хороодог ба түүний үхлийг нар, тэнгэр гэрчлэх учиргүй тул цаазын ийм хэлбэрийг тэд сонгодог байжээ.

Энэхүү ялалтын дараа Наян ноёны ойр шадар ноёд, хүмүүс нь Их хаанд бууж өгцгөөн цаашдаа Их хааны үнэнч боол, хараат иргэд байхаа андгайлцгаав. Наяны цэргүүд нь Чорча, Каули, Барскөл болон Сикинтинжу дөрвөн мужийн иргэд байжээ.

Энэ дайнд Их хаан ялалт байгуулсны дараа Сарацин, Онго шүтлэгтэн, Жүүд болон Ертөнцийн эзэнд итгэдэггүй бусад олон ястан үндэстнүүд загалмай болон загалмайн

шашныг инээд доог болгоов. Тэд, “Загалмайтан Наянд та нарын Ертөнцийн эзний загалмай яаж тусалснийг харав уу” гэх мэтээр Загалмайтнуудыг доромж үгээр гутаан, дооглон тохуурхах болсон нь Их хааны сонорт хүрэв. Зарим нь бүр Их хааны дэргэд загалмайн шашныг гутаасан үг яриа гаргахад хаан ихэд дургүйцэн тэдгээр хүмүүсийг буруутган дахин ийм үг яриа гаргахгүй байхыг зарлигдав. Ингээд тэнд байсан Загалмайтнуудыг цуглуулан хаан ийн айлтгав: “Танай шашны загалмай Наян ноёны үйл хэрэгт нэмэр тус болоогүй нь цаанаа гүн утга учиртай билээ. Бурхан буруу явдал, бурангуй үйлийг дэмжин өөгшүүлдэггүйг та бүхэн нүдээрээ үзлээ. Наян бол Их хаанаасаа урвасан мэхлэгч байсан учраас бурхан түүнийг таалсангүй” гэв. Тэнд цугларсан Загалмайтнууд: “Хорвоогийн хүчирхэг эзэн Та чин үнэнийг айлдав. Загалмай хэзээ ч буруу үйлийг өөгшүүлдэггүй, Наян бол Их хаанаасаа урвасан муу үйлтэн байсан учраас өөрт оногдох хувь тавилангийн үр үйлээ эдлэв” гэж түрхэрцгээв.

Наяны хувь заяаны тухай Загалмайтнууд болон Их хааны хооронд загалмай болон загалмайн шашны талаар иймэрхүү яриа болов.

Наян ноёны бослого тэмцлийг дарж номхруулаад Их хаан нийслэл хот Хан-баликтаа ирж найр цэнгэл хөгжөөв.

Хайду хан Наян ноёны ялагдал, түүний үхлийн талаар сонсмогцоо ихэд сандран цочирдож цэрэг зэвсэг хөдөлгөлгүй нам гүм болов.

Арваннэгдүгээр сард Хубилай хаан нийслэл хот Хан-баликтаа эргэн ирэв130. Их хаан хоёр, гуравдугаар сарыг дуустал буюу манай Мацгийн (Улаан өндөгний баяр) өдрийг тэндээ суув. Мацгийн баяр нь Загалмайтнуудын их баярын нэг гэдгийг дуулж мэдэнгүүтээ түүнд энэ баярын тухай мэдээ сэлтийг агуулсан дөрвөн Евангели судар авч ирэхийг зарлигдав. Бурханы номыг үзэж үнэнийг ойлгосны дагуу Загалмайтны их баярын үеэр зул хүж асааж, загалмайг үнсэн ёс төрийг үйлдэхэд ноёд, язгууртнууд хааныг дагалдан дээрх зан үйлийг давтан үйлдэцгээв. Үүнээс хойш Загалмайтнуудын их баяр болох Мацгийн өдөр болон Христ бурханы мэндэлсэн өдрийн баярыг ёслон тэмдэглэх болов. Яг үүний нэгэн адилаар Сарацин, Жүүд, Онгод шүтлэгтний гол гол баярыг ч ёслон тэмдэглэдэг байв. Яагаад ийн үйлдэхийн учрыг түүнээс асуухад: Хорвоо дэлхийн хүн ардын биширдэг дөрвөн гэгээнтэн байна. Бурханыг эхлэн төлөөлөх шүтлэгийн хэлбэр нь Загалмайтны хэлэхээр бол Ийсус Христос, Сарацины Магомет, Жүүдийн Мойсей, Онго шүтлэгтний Шакъяамуни Бурхан эдгээр дөрөв ажээ. Би чин үнэн сэтгэлээрээ энэ дөрвөн бурханыг шүтэн биширч, хүндлэн залбирдаг төдийгүй тэдгээр бурхадаас аврал энэрэл хүсэн гуйж мөргөдөг гэсэн хариу өчив. Гэхдээ Их хааныг ажаад байхад Загалмайн шашинд илүү талтай мэт санагддаг. Гэвч ямар ч нөхцөл тохиолдолд Христ хэмээх агуу их хүнийг тэлэн хадаж алсан загалмайг түүний өмнө туг сүлд болгон өргөж мандуулахыг тэр үл зөвшөөрнө.

Загалмайн шашныг Та бусдаас илүүд үзэн үнэлдэг мөртлөө яагаад энэ шашныг газар сайгүй тархаан түгээж, өөрөө загалмайн шүтлэгтэн болдоггүй юм бэ гэж хэн нэгэн зүрхлэн асуувал, эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео нарыг Ромын Пап ламд элчээр зарахдаа хэлсэн тэр үг, санаагаа хэлэх байх гэж боддог. Тэр байн байн загалмайн шашин шүтлэгийн асуудлыг сөхөн Никколо Маффео нартай ярилцдаг нь үнэн боловч ингэж хариулах байсан байх: “Би загалмайн шашин шүтдэг байх ямар үндэслэл, шалтгаан байна, манай энэ хязгаар нутагт

оршин суудаг загалмайн шашинтнууд мэддэг, чаддаг юмаар маруухан төдийгүй шашныхаа үнэнд хүрэх ид чадлыг нь үзэх талаар хуруугаач хөдлөгдөггүй учир хэн тэр шашныг үнэлэн дээдлэх билээ”. Гэтэл онгод шүтээнтэн хүмүүс гайхам ид шидийг барин тавин үзүүлдэг, жишээлбэл би ёслолын их танхимд сэнтийдээ заларч суухад танхимийн голд байгаа аягатай дарсыг над руу нисгэн илгээдэг бөгөөд би тэр дарсыг амтархан уудаг. Тэд тэнгэр газрыг захиран цаг агаарын ааш араншинг сайтгаж муутгах гэх мэтээр элдэв олон гайхамшгийг үзүүлэх бөгөөд энэ бүхэн тэдний шүтдэг онгон тэдэнд ийм хүч чадлыг хайрладаг гэцгээх. Хэрвээ би загалмай шүтэж загалмайтан болвол, энэ шүтлэгийг үл зөвшөөх миний ноёд, ихэс: “Загалмайн шүтлэгийг дагаж, баптизмд ороход Танд юу нөлөөлөв? Ямар давуу тал, шид увдистай юм бэ?” гэж асуувал тэдний эргэлзээг тайлж хэлэх үг надад олдохгүй. Харин онгод шүтлэгтэн бүхэн тэдний ид шид, эрдэм чадал, гэгээрэн ариусах үйл бүхэн тэдний онгон шүтээний хүч гэх. Хэрэв би гэв гэнэт загалмайн шашин шүтдэг болвол бусдын эргэлзэл гайхширлыг төрүүлээд зогсохгүй, тэд намайг уучлашгүй нүгэл үйлдлээ гэж үзэх бөгөөд тэд ид шидийнхээ хүчээр намайг бурханы оронд хялбархан илгээнэ шүү дээ. Харин одоо та нар өөрийнхөө Пап ламдаа очиж загалмайн шашны номлол сургаалд төгс боловсорсон зуун санваартныг үтэр түргэн над руу илгээгтүн, тэд нар онгод шүтлэгтний хийдэг бүхнийг мөн хийж чаддагаа үзүүлэг, тэдний хийж байгаа зүйл, үзүүлж байгаа бүхэн нь харын зүгийн хараал жатга, архиний мансуурлын үр дагавар гэдгийг батлан харуулаг. Тэгсэн цагт л бид онгон шүтдэг шашныг өөлөн буруутгаж чадна бас би болон миний ноёд, язгууртнууд загалмайн шашинд орж загалмайлуулах болно гэв. Тэр цагт хорвоо дэлхийн энэ хэсэгт танай тэндхээс хавьгүй олон загалмайтан шашинтан төрнө. Ромын Пап лам Их хааны хүсэн хүлээсэн ном эрдэмтэй, ид шидтэй загалмайтан лам хуврагийг Их хаанд илгээвээс хаан тэднийг дуртайяа хүлээн авч загалмайн шашныг дэлгэрүүлэх үйлсэд ханцуй шамлан орохоор барахгүй өөрөө ч загалмайн шүтлэгтэн болж өөрчлөгдөнө. Ер нь Их хаан бол шинэ бүхнийг сэргээгээр хүлээн авч өөрөө ч түүнийгээ даган хялбархан өөрчлөгдөх увдистай нэгэн билээ.

Наян ноёны эсрэг хийх тулалдаанд Их хаан өөрийн биеэр цэргээ удирдан орсон нь түүний цэрэг армийг удирдах хөвгүүд ач нар болон ноёд жанжид үгүйдээ бус тэр ноёны итгэлийг эвдэж, сэтгэлийг гутаасан үйл нь Их хааны жигшил зэвүүцлийг үнэнхүү төрүүлж, ийм бузар урвалт, бослого тэмцэл дахин давтан гаргуулахгүй байх сургамж, цээрлэл үзүүлэх гэсэн чин санааных байжээ. Одоо дээрх үйлийн тухай маш тодорхой ярилцсан тул түүнийг орхин Их хааны сайн үйл, сайхан амжилтийг тод томруун өгүүлсү. Би та нарт Их хааны угшил гарвал, удам угсаа, нас сүүдрийн талаар дээр өгүүлсэн билээ. Одоо бид дайн тулалдаанд эр зориг, илд жад, нум сумын гайхамшгийг үзүүлэн эрэлхэг зоригтой тулалдсан ноёд, жанжидаа хэрхэн урамшуулж шагнадаг, эр зориг нь уландаа орж ирт мэснээс дальдиран зугтсан хуудуутай явдалтай хулчигар эрсийг хэрхэн баалдаг талаар өгүүлье<sup>131</sup>.

Дайнд гавьяа байгуулсан зуутын дарга нарыг мянгатын ноёноор, мянгатын ноёныг түмтийн ноёноор дэвшүүлэн томилж, алба дэвшсэн хүн бүрт дүйх мөнгөн цар таваг, зэрэг дэвийг нь баталгаажуулсан мөнгөн пайз (гэрэгэ) гардуулан өгөв. Зуутын даргын гэрэгэ нь цэвэр мөнгөөр, мянгатын ноёны гэрэгэ нь алтаар шарсан мөнгөөр, түмтийн ноёны гэрэгэ нь цул алтаар хийж арслангийн толгой сийлсэн байдаг. Зуут, мянгатын ноёдын гэрэгэ нь 120 сагги жинтэй<sup>132</sup>, арслангийн толгойтоо гэрэгэ нь 220 сагги жинтэй байдаг. Гэрэгэ бүрийн дээр дараах зарлигийг сийлсэн байх: “Мөнх тэнгэрийн ивгээл хүчээр Их хааны эрх сүр ертөнц дахинаа түгэн дэлгэрч, аливаа тэрсүүд бүхэн арилан сөнөтүгэй” гэсэн байдаг. Ийнхүү алтан,

мөнгөн гэрэгээг эзэмшигч бүхний зэрэг дэв, эрх мэдлийг хааны зарлигаар тогтоон, бичгээр хавсаргаж өгдөг байна.

Бумтын ноён буюу их армийн жанжны гэрэгэ нь хормойгий нь арслангийн толгой, оройгий нь нар, сар сийлэж чимсэн 300 сагги жинтэй цул шижир алт байх бөгөөд мөн дэрхийн нэгэн адил хааны зарлиг сийлээстэй байдаг. Мөн түүнд их армийн жанжин гэсэн зэрэг дэв, эрх сүрийг нь баталгаажуулсан зарлиг тушаал гардуулдаг. Эдгээр жанжид нь аян дайнд явахдаа тэдний зэрэг дэвийг илтгэсэн шүхэр толгой дээрээ өргөж явах бөгөөд суухдаа тусгай мөнгөн сандал дээр тухлана. Мөн эдгээр жанждад Их хааны алтан шонхортой гэрэгэ гардуулах бөгөөд энэ бол тэдэнд хааны зиндааны эрх мэдэл хэрэгжүүлэх баталгаа болдог. Тэд Их хаанд яаралтай элч тахар, мэдээ шуудан илгээхдээ хааны сүргээс морьд дайчлах эрхийг эдлэх бөгөөд энэ бол бусад хэний ч морийг дайчлан унах эрхтэй гэсэн үг<sup>133</sup>.

Одоо би та нарт Хубилай хаан гэж нэрлэгдэх Эздийн дээд Эзэн хэмээгдэх хүний бие бялдар, нүүр царайны талаар өгүүлсү. Хубилай хаан өндөр ч биш, нам ч биш дунд хэрийн нуруутай, тэгш чийрэг бөгөөд бие махбодь, хөл, гарын харьцаа нь тэгш зохицсон галбиртай нэгэн. Мөн тэрбээр, сарнайн өнгө мэт улаа бутарсан эрүүл цэвэрхэн царайтай, хар нүдтэй, өндөр шулуун хамартай нүдэнд дулаахан хүн билээ. Тэр албан ёсоор богтлож авсан дөрвөн их хатантай, энэ дөрвөн хатны аль нэгнээс төрсөн ууган хүү нь эцгийнхээ хаан ширээг залгамжлах эрхтэй. Эдгээр дөрвөн хатдыг хатан-хаан гэх боловч бүгдийг тус тусын нь алдраар дуудан хүндэтгэнэ. Хатан бүр өөрийн орд харш, эдлэн газартай төдийгүй гэртээ тус бүр гурван зуун үзэсгэлэн төгс боол, шивэгчинтэй. Тэдгээр хатдыг байнга үйлчлэн зарагдаж байдаг тайган, шивэгчин болон бусад албат нь нийлээд нэгэн түм (10000) хүрнэ. Их хаан аль нэгэн хатантайгаа энгэр зөрүүлэх болбол тэднийг ордондоо урих буюу эсвэл өөрөө тэдний өргөөгөөр ирдэг<sup>134</sup>.

Их хаан бас олон татвар эмстэй тухай одоо ярья. Тартаруудын харьяаны Хонгирад (Kungurat) хэмээн муж, мөн тийм нэрт хотод тэдгээр бүсгүйчүүл суудаг. Тэд маш царайлаг, үзэмж, ааль төгс билээ. Хоёр жил тутам, мөн Их хааны хүссэн цагт энэ нутаг руу элч төлөөлөгчид илгээгдэж, эзний таалалд нийцэх шалгуураар хамгийн үзэсгэлэнтэй дөрөв, таван зуун, түүнээс олон, эсхүл цөөн залуу охидийг сонгож авдаг. Эдгээр элч төлөөлөгчид ирмэгцээ Хонгирад нутгийн бүхий л залуу охидийг дуудан цуглуулж сонголтыг ингэж хийдэг байлаа. Охин бүрийг тусгайлан үнэлэн цэгнэж оноо өгдөг. Тэр үнэлгээ нь охидын бие галбир, нуруу туруу, царай зүс, үс хөмсөг, уруул хүзүү гэх мэт эрхтэн бүрээр үнэлэн арван зургаа, арван долоо, арван найм болон хорь, заримыг нь бүр хорь илүү оноогоор шагнаан гоо үзэсгэлэнгээр нь дэс дараалуулан байр эзлүүлнэ. Ингээд хорь юм уу, түүнээс дээш өндөр оноо авсан охидыг хааны ордонд авчирна. Ордонд ирсэн охидыг бас дахин шинжиж, сонжиж шалгаруулах бөгөөд гуч дөчин үзэсгэлэн төгс охидыг хааны ордонд авна. Тэдгээр охидыг эхлээд тусгай даалгавар авсан ноёд, язгууртны хатадад даалган өгөх бөгөөд тэд нар уг охидыг шөнө унтахад нь ажин танадаж онгон эсэх, унтахдаа хурхирах, шүдээ хавирах зэрэг согоггүй байх, амьсгал нь жигд, элдэв гажууд үнэр танар ялгаруулдаггүй байх зэргийг харж хянан үзнэ. Энэ шалгалт давааг давсан охидыг зургаан бүлэг болгон хувааж, гурван өдөр, гурван шөнө хааны өргөө ба түүний ор хөнжил, ер түүнд хэрэгтэй бүхэнд үйлчлүүлэхээр үлдээнэ. Тэдгээр охидыг хаан өөрийн хүсэл зоргоор эдэлнэ. Гурван өдөр, шөнө өнгөрмөгц дараагийн зургаан охин ирнэ гэх мэтээр жилийн турш тасралтгүй үргэлжилнэ. Эзний өргөөнд уригдсан гурван охин ажил үүргээ амжуулж байхад нөгөө гурван охин ордны хонгилд цаг нөгцөөж суух албатай. Хааны



өргөө ордонд хийх ёстой бүхий л ажил, үүргийг эдгээр охид хийх бөгөөд өөр хэнийг ч оруулдаггүй байна. Оноо нь үнэлгээнд хүрээгүй охидууд хааны ордны бусад бүсгүйчүүдтэй хамт оёх шидэх, урлах хатгах ажилтай болдог. Ордны ноёд, язгууртнууд авах эхнэр хайж байвал эдгээр охидын аль таалагдсаныг баян инж дагуулан нөхөрт гаргах бөгөөд энэ нь их хүндэтгэлтэй гэрлэлтэд тооцогдоно.

Хонгирад нутгийн эрчүүд, охидын эцгүүд нь “Их хаан охидыг нь шилэж сонгоод аваад явчихыг хэрхэн яаж хүлээж авдаг бол “ гэж асуумаар байгаа биз, тэгвэл тэр нутгийн хэн бэ гуайч элдэв юм ярьдаггүй. Энэ зан заншилд тэр нутгийнхан маш хүндэтгэлтэй ханддаг, үзэсгэлэн төгс охинтой айл бол түүгээрээ бахархаж баярладаг. Тэр нутгийнхан: “Хэрэв миний охин аз хийморийн одонд төрсөн бол Их хаан сонгож авна, эсвэл дээд язгууртан сайн үйлтэй эрд эхнэр болгон өгнө энэ нь миний хөрөнгө зоориор гүйцэлдүүлэх аргагүй аз завшаан мөн” гэж боддог. Хэрвээ охин нь элдэв ааш авир гарган сонгох шалгаруултад эс тэнцвэл: “охины маань аз хийморийн од харвачихаж” гэж халаглана. Их хааны дөрвөн их хатан нийлээд хорин хоёр хүү төрүүлцгээжээ. Тэдний ууганыг Их Эзнийхээ дурсгалыг мөнхлөн Чингиз (Chinghiz)135 гэж нэрлэв. Чингиз эзэн хааны ор залгамжлан Их Монголын эзэнт гүрнийг захирах ёстой байлаа. Харин тэр хүү цэл залуугаараа ертөнцөөс хальж одов. Чингизээс Төмөр (Temur) нэртэй хүү үлдэж хоцорсон бөгөөд одоо тэр хүү Их Монгол улсын эзэн хааны сэнтийд заларч их хааны ор суух ёстой, учир нь тэр Их хааны ууган хүүгийн нуган үр төдийгүй, Их хааны өөрийнх нь ач хүү билээ. Энэ Төмөр хэмээх хүү бол ухаалаг сэргэлэн, холч бодолтой, цэргийн эрдэмд төгс боловсорсон эр гэдгийг би андахгүй мэдэх бөгөөд Төмөр хүү ч дайн тулааны талбарт эрэлхэг, ухаалаг жанжин гэдгээ дахин дахин баталсан эр. Их хааны татвар эмсээс төрсөн хорин таван хөвгүүд байх агаад тэд цөм эрэлхэг дайчин цэрэг эрс, эрдэм төгс ноёд болон торницгоосон юм.

Их хааны дөрвөн их хатнаас төрсөн долоон хүү нь их монгол гүрний том том муж, ханлигийг захирсан хаад болсон. Тэдгээр хөвгүүд хаан эцгийнхээ засаг засаглалыг ухаалаг залж, шударга үйлийг бүтээж яваа билээ. Учир нь тэд бүгдээрээ энэ хорвоогийн хамгийн цэцэн цэлмэг, шударга шулуун Хубилай хааны хөвгүүд билээ, ийм ухаалаг, цэцэн мэргэн хаан тартаруудын түүхэнд өмнө нь байгаагүй л болов уу.

Жил бүрийн өвлийн гурван сар буюу арванхоёр, нэг, хоёрдугаар сарыг Их хаан Катай орны нийслэл Хан-балик хотноо өнгөрөөнө. Энэ хотод түүний асар том орд өргөө байх бөгөөд тэр тухай би одоо та нарт ярьж өгье136.

Ордныг тэгш өнцөгтэй, тэгш хэмтэй дөрвөлжин хэрмээр хашиж хүрээлсэн байх бөгөөд хэрмийн ханы урт нь тус бүр нэгэн бээр урт, хэрмийн (тойрог) нийт урт нь дөрвөн бээр болой. Энэ хэрмийн хана маш зузаан, ханын өндөр нь арван тохой. Хэрэм нь бэхлэлт хамгаалалтын хэлбэр хийцтэй. Хэрмийн дөрвөн өнцөгт уран гоё хийц, тоноглолтой дөрвөн том ордон байх бөгөөд тэдгээр нь цэрэг зэвсгийн дэлгүүр юм. Мөн хэрмийн ханы дунд биед дээрхийн адил дөрвөн том ордон бий бөгөөд тэдгээр ордон нь цөм зэвсгийн агуулах билээ, ийнхүү хэрэм дотор найман том орд өргөө байдаг. Эдгээр зэвсгийн агуулах нь төрөлжсөн агуулах тул нэг агуулахад нэг л чиг, төрлийн зэвсэг хадгалах боловч эмээл, хазаар, хударга, дөрөө гэх мэтийн морь унахад зориулагдсан эдлэл хэрэглэл бол агуулах бүрт тусгайлан хурааж бэлэн зэхээстэй байдаг. Эдгээр агуулахын нэгэнд нь жад, жадны зэв,

дүүгүүр, нум, сум эгнүүлэн хураасан байхад нөгөөд нь хуяг, дуулга, идээлж элдсэн арьсан хуяг хураасан байх жишээтэй бусад агуулах нь төрөл бүрийн зэр зэвсгээр дүүрэн байна.

Хэрмийн урагшаа харсан нүүрэн талын хананд таван хаалгатай. Дунд талын хамгийн өндөр дааман хаалга нь Их хаан орж, гарахаас бусад цагт үргэлж хаалттай байх. Үүний хоёр талын арай намхавтар хаалгаар бусад хүмүүс орж, гарч хөлхөлдөнө. Хэрмийн өнцөг рүү ойрхон хоёр том дааман хаалга байх бөгөөд түүгээр мөн л гадна дотнын хүн, цэрэг харуул болон энгийн иргэд орж гарч хөлхөлдөнө.

Энэхүү гадаад хэрмийн дотор гонзгой дөрвөлжин хэлбэртэй бас нэгэн давхар хэрэм буй. Энэ хэрэм мөн ялгаагүй гадаад их хэрэмд байдаг бүхнийг давгах мэт байршуулсан байх. Харин хэрмийн баруун, зүүн умарт хананд тус бүр нижгээд хаалгатай.

Энэ давхар хэрэм дотор Их хааны орд өргөө байх бөгөөд энэ орд өргөөний тухай би одоо та нарт ярья. Энэ бол миний л үзэж харсан орд харш дотроос хамгийн том нь гэж бодогдоно<sup>137</sup>. Энэ харш өргөө нь давхар шалгүй, харин газрын гадаргаас дээш арван төө өндөр суурь засаж түүн дээрээ барьжээ. Тэр сууриа хоёр төө зузаантай гантиг хавтангаар хашиж гадарласан байдаг. Ордны эргэн тойрон гудамлаж зассан саравчтай тагттай, энэхүү тагтаар хүмүүс зугаацан ордныг бүтэн тойрон үзэх боломжтой, тагтын дээврийг уран гоё сийлбэртэй баганаар тулж тэвхлэн тогтоосон байдаг. Ордны дөрвөн талаас орохоор авируулан тавьсан гантиг шагтай. Ордны адар нь их өндөрт байршсан. Ордон доторх өрөө, танхимуудыг алт, мөнгөөр доторлож луу, шувууд, морьтон эрсийн болон янз бүрийн зэрлэг ан араатны тулалдааныг дүрсэлсэн зурагаар чимсэн. Адар нь мөн ялгаагүй алт, мөнгөөр доторлож зурагаар чимсэн байлаа. Гол танхим нь маш уудам саруул төдийгүй зургаан мянган (6000) эрс элбэг багтахаар уужим зайтай билээ. Ордон дотроо маш олон өрөө, танхимтай. Хааны ордон нь үнэнхүү аварга том байшин, энэ дэлхий дээр Хубилай хаанаас өөр хэн ч ийм уран гоё хийцтэй, уудам саруул өрөө, танхимтай асар том харш ордныг бариулна гэхэд ухаан хүрэхгүй юм. Ордны дээврийг час улаан, нов ногоон, гүн цэнхэр, алтан шар өнгийн паалан гүйлгэж будсан нь наранд гялалзан нүд гялбуулна. Ийм дээвэр маш баг бөх бөгөөд олон олон он жилийг элээхдээ огтхон ч эвдэрч сэвтдэггүй юм.

Ордны хойт хэсэгт уужим саруул өрөө тасалгаатай сууц, өргөө, танхим байрласан байх бөгөөд энд Их хааны хувийн эд хөрөнгө хадгалаастай байдаг. Энэ хэсэгт хааны эрдэнэсийн сан байх бөгөөд тэнд алт, мөнгө, эрдэнийн чулуу, сувд тэргүүтэн овоолоостойгоос гадна, алтан, мөнгөн болон болор шилэн сав суулга дүүрэн байх. Энэ хэсэгт хааны хатад, татвар эмс байрлах бөгөөд тэдний өргөө танхим, өрөө тасалгааны тохи тухтай, тансаг гоёлыг үгээр дүрслэн хэлэхэд үг үл хүрэлцэнэ. Ордны энэ хэсэгт гаднын хүн хөл тавих хориотой.

Миний түрүүн танилцуулж байсан гадаад хэрэм, дотоод хэрэм хоёрын хоорондох зайд гайхам сайхан мод ойтой цэцэрлэгт зурвас байдаг. Энд ногоо нь өвдөг шүргэм өндөр, өтгөн саглагар ургасан байдгийн учир нь газрын гадаргаас бараг хоёр тохой өндөр хөндий, явган зам тавьсан бөгөөд хэн ч зүлэг ногоон дээгүүр гишгэж явдаггүй, борооны ус тунаж шавар шавхайтай шалбааг тогтдоггүй, зүлэг ногоог үргэлж чийглэн услаж байдаг. Энэхүү цэцэрлэгт зурваст цагаан буга, заарт хүдэр, гур зүр, буга согоо, хэрэм өөр бусад гайхам гоё зэрлэг ан амьтан дураараа бэлчин нүд хужирлана. Цэцэрлэгт зурвасын хүн зорчдог явган замаас бусад орон зайд нь зэрлэг ан амьтад дүүрэн бөгөөд дураараа сэлгүүцэнэ.

Ордны баруун хойт өнцөгт том бөгөөд гүнзгий нүх ухаж, шороогоор нь далан засаад усаар дүүргэсэн байх. Энэ жижиг хиймэл нуур руу цэвэрхэн устай горхи гаднаас урсан орж ирнэ. Энэ нуур нь цэцэрлэгт зурваст бэлчих ан амьтныг ундаалдаг усан сан болой. Хиймэл нуураас дахин нэгэн жижиг горхи шороон далан дундуур татсан хоолойгоор урсан гарч Их хааны ордон болон түүний хүү Чингизийн ордны хооронд зассан хонхорыг дүүргэн бас нэгэн жижиг хиймэл нуур үүсгэжээ. Энэ хоёр жижиг хиймэл нууранд тун олон төрлийн загас тавин үржүүлсэн байх. Их хаан эдгээр хиймэл нууранд маш олон төрлийн загасыг олноор нь өсгөн үржүүлэхийг зарлиг болсон тул төрөл бүрийн загас нуураар дүүрэн, хэрэв хаан загасаар хоол хийлгэх гэвэл түүний аль дуртай загасыг сонгон авчирч идээ хоол зэхэх бөлгөө. Эдгээр хиймэл нуурын ус тогтмол биш, хэрмийн нэгэн өнцөг доогуур урсан гадагшилна. Ус ингэж гадагшаа урсахад загаснуудаа хамт урсгачихгүйн тулд ган болон зэс тороор хаасан байдаг. Эдгээр нууранд хун болон бусад төрлийн усны шувууд амар тайван хөвнө. Хоёр ордны хооронд зорчих, зугаацах гүүртэй.

Ордноос хойшоо харвасан сум тусахуйц зайтай боловч гадаад хэрмийн дотор өндрөөрөө зуун тохой орчим, сууриараа нэгэн бээр илүү урт тойрогтой хиймэл уул байх бөгөөд тэр уул нь газар газраас авчирсан мөнх ногоон моддоор битүү хучаастай жилийн дөрвөн улиралд ногоорон байх бөлгөө. Хаа нэгтэй, газрын хол усны уртад энэ хиймэл ууланд байхгүй мөнх ногоон мод ургаж байгааг Их хаан сонсож мэдэнгүүтээ тэр модыг орчны нь газартай хамт ухаж аван, заанаар тээж авчраад уг ууланд суулгаж тарьдаг нь Их хааны нэгэн онцгой зуршил билээ. Иймэрхүү байдлаар энэ хиймэл ууланд энэ хорвоогийн бараг л бүх төрлийн мөнх ногоон моддыг нүүлгэн авчирч суулган ургуулж байгаа юм. Үүгээр зогсохгүй хиймэл уулын газрын хөрсийг ногоон хаш чулуу нунтаглан цацаж битүү бүрхсэн байх бөгөөд эндхийн хөрс шороо, хад чулуу нь цөм ногоон өнгөөр туяаран дуниартана. Тийм учраас энэ хиймэл уулыг Ногоон Толгой гэж нэрлэнэ. Мөн энэхүү ногоон толгойн орой дээр мөнх ногоон моддын дунд засаг төрийн дээд албаныхан болон харь орны элчин төлөөлөгчдийг хүлээн авч уулздаг маш уран хийцтэй тансаг ногоон харш байдаг. Энэхүү мөнх ногоон ойгоор битүү хучигдсан ногоон харш сүндэрлэх, ногоон толгойг харсан хэн хүнгүй гайхан шагширч, бахдан алмайрах нь энүүхэнд билээ. Энэ бүхэн Их хааны амгалан тайван амарч зугаацах, бие сэтгэлээ тэтгэн тэнхрүүлэхэд зориулан ёстой л үлгэр домгийн ид шидээр бүтээсэн мэт ганган хээнцэр, уран тансаг зүйлс билээ.

Их хааны ордны дэргэд яг тийм хийц, хэмжээтэй, мөн тийм гоёл чимэглэлтэй тансаг харш барьсан нь эзэн ор суух хан хүүгийн харш билээ. Энэхүү харшийг заавал тэгэж барихын учир нь хан хүү төр жолоодох их ухаан, ур дүйд суралцахдаа эцэг хааны өдөр тутмын үйл хөдлөлийг үргэлж ажин харж, хуулан шингээж байхаар бодолцжээ. Одоо бол энэ харшид Чингизийн ууган хүү, Их хааны ач хүү Төмөр сууна. Хан хүү Төмөр энд байнга оршин сууж Өвөг хаан хэрхэн төрийн ажил, ёслол хүндэтгэл, шагнал шийтгэлийг хослуулан төр улсаа удирдаж, залаж буйг ажин харж, үзсэн сонссон бүхнээ тунгаан өөртөө шингээн хоногшуулж буй бөгөөд Их хааныг мөнх тэнгэрт халимагц Их Монгол гүрний төрийн жолоог залахаар бэлтгэгдэж буй хан хүү юм. Хан хүү Төмөр их ор суухаар бэлтгэгдэн төрийн тамга түүний гарт шилжин ирсэн боловч Их хааныг амьд сэрүүн байхад төрийн дээд эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг эдлэх хараахан болоогүй байгаа билээ<sup>138</sup>.

Их хааны орд харшийн талаар та бүхэнд тодорхой ярьж таниулсан тул одоо Дайду хэмээх том

хотын тухай, тэр хотыг хэрхэн юуны учир барьж байгуулсан талаар ярья.

Катай хэмээх энэ нутгийн арвин устай их мөрний эрэг дээр эртний түүхт Хан-балик хот орших бөгөөд энэ нэр нь манай хэлээр бол “Бурхадын хот” гэсэн утга санааг илэрхийлж байгаа юм. Гэтэл Их хааны зурхайч, төлөгч нар Хан-балик хотын иргэд оршин суугчид нэгэн цагт Их Монгол гүрний эсрэг босон тэмцэлдэх юм байна гэж мэргэ төлгөнд бууж байгааг Их хаандаа айлтган сонордуулжээ. Зурхайч, төлөгчдийн энэ мэргэ Их хааныг шинэ хот барьж байгуулах үйл хэрэгт түлхэн, дав даруй санаа оноогоо хэрэгжүүлэх ажилд шуурхайлуулжээ. Ингээд шинэ хотоо их устай голын нөгөө эрэгт, хуучин хотын зэргэмжээ барьж байгуулсан бөгөөд шинэ хотоо Дайду хэмээн нэрийдэж амой. Шинэ хотод Их хаанд шударга үнэнчээр хүчин зүтгэх албат, харьяат нараа давын өмнө нүүлгэн шилжүүлж шинэ хотод суурьшуулсан бөгөөд хот шинээр барьж байгуулж байгаа учраас тэнд орон байрын хүрэлцээ муухан болохоор бүхнийг шилжүүлэн суурьшуулах боломжгүй байлаа.

Дайду хот нь тэг дөрвөлжин тэгш өнцөгт хэлбэртэй, тэгш өнцөгтийн тал болгоны урт ижил бөгөөд хэрмийн нийт урт нь хорин дөрвөн бээр хэмжээтэй. Хотын хэрэм нь шороон далан дээр барьсан хорин тохой өндөр, сууриараа арван тохой зузаан, дотогшоо налуу, хэрмийн орой нь гурван тохой өргөн билээ. Хэрэм нь хамгаалалтын цайз хэлбэрээр бүтээгдсэн орж, гарах арван хоёр хаалгатай, хаалга бүр нь уужим саруул өргөө ордтой. Хэрмийн тал бүр гурван хаалгатай, хаалга бүр нь орд өргөөтэйгөөс гадна хэрмийн өнцөг бүрт мөн уужим саруул өрөө, танхимтай бөгөөд тэдгээрт хотын харуул хамгаалалтынхан зэр зэвсэгтэйгээ байрлан сууцгаана.

Хотын гудамж нь өргөн бөгөөд шув шулуухан хэрмийн аль нэгэн ханын оройгоос нөгөө тал нь халхлах бараа, саадгүй тул чөлөөтэй харагдана. Хот нь уран ганган хийц загвартай өргөө харш, дэн буудал, айл өрхийн хувийн сууцаар дүүрэн. Гол гудамжуудын дагуу дэлгүүр, мухлаг олонтой. Шинээр барилга барьж буй талбай нь бүгд тэгш өнцөгт хэлбэртэй. Айл болгон өөр өөрийн онцлог хийц, загвартай орд, өргөөтэйгөөс гадна өөрийн гэсэн эзэмшил газар, цэцэрлэгт хүрээлэнтэй. Эдгээр эзэмшил газар, орд өргөө нь тийм омгийн, тэр гэдэг хүний гэр бүлийн эзэмшил газар гэсэн тов тодорхой нэр, хаягтай байдаг. Эзэмшил газар болгоныг холбосон нийтийн зорчих замтай, энэ бүхнийг дээрээс нь харвал эгээл шатрын хөлөг мэт тэгш хэмтэй дөрвөлжинд хуваан байршуулсан үзэсгэлэн төгс хотын дүр зураг нүдэнд харагдан, сэтгэлд буух нь урамтай.

Хотын хэрэм дотор болон хэрмийн гадна түг түмэн хүмүүс, оршин суугчид байх бөгөөд хэн ч тэдний тоо байг мэдэхгүйгээр барахгүй барагцаалан хэлэх ч баримжаагүй билээ. Харин хэрмийн гадна орших хүмүүс нь хэрмийн доторхоосоо олон гэдэг бол үнэн. Хотын дүүрэг, хороод нь хаяа хаяагаа дэрлэн гурав, дөрвөн бээр алслан үргэлжилнэ. Хотын төвөөс барагцаалбал нэгэн бээрийн зайд орших дүүргүүдэд тохилог сайхан нийтийн байр байх бөгөөд тэдгээр нийтийн байрыг харь холоос ирсэн худалдаачид, жинчид, аялагчид хөлслөн сууцгаана. Мөн эдгээр нийтийн байр нь овог аймгийн болон улс үндэстний онцлог, зан заншилд тохируулан барьсан ч бий, жишээлбэл: Ломбардийн, Германы, Францийн гэх мэт өөр өөрийн чиг зориулалттай байх. Хорвоо дэлхийн өнцөг булан бүрээс худалдаачид, наймаачид, аянчин жинчин, албан амины хэргээр түм буман хүн энэ хотыг зорин ирэхийн учир нь энэ хотод Их хаан оршин суудагт, энэ хотын зах зээлд олз ашигтай наймаа худалдаа

хийж болдогт тэр олон хүмүүн соронзон мэт татагдан ирдэг билээ. Хотын дүүрэг, хороолол нь хотын төвөөс огт ялгарах юмгүй цэвэр цэмцгэр, гоё ганган байшин барилгатай, ялгаа нь гэвэл хааны ордон л тэнд байхгүй.

Үхэгсэдийг хэн боловч заавал хотоос зайдуу гаргаж тусгай оршуулгын газар нутаглуулдгийг та бүхэн лав дуулсан байх учиртай. Хэрэв Онго шүтлэгтэн (бөө мөргөлтөн) байвал хотоос хол зайдуу тэдний шарилыг чандарладаг газарт аваачиж чандарлана. Бусад ямар ч шашин мөргөлтэй байсан ялгаагүй хотоос зайдуу оршуулгын газар нутаглуулдаг. Хот, дүүргийн дэвсгэр нутагт элдэв хэрэг төвөг, хулгай зэлгий, дээрэм тонуул огт гардаггүй.

Бас нэгэн зүйлийг та бүхэнд сонирхуулахад: Нүгэлт эмс буюу мөнгө төгрөгөөр биеэ үнэлдэг бүсгүйчүүд хотын хэрэм дотор нэгээхэн ч үгүй, тэд цөм хотын дүүрэг хороодод амьдарцгаана. Хот тойрсон дүүрэг, хороодод бараг хоёр түм (20000) орчим биеэ үнэлэгсэд байдаг гэдэгт итгэхэд бэрх ч яах аргагүй тийм тооны биеэ үнэлдэг бүсгүйчүүд байдаг билээ. Тэднийг нэгтгэн захирдаг ахлах захирагч байхаас гадна, зуут, мянгатын дарга нар ч байдаг. Харь орны элчин төлөөлөгчид Их хаанд бараалхан айлчилж, ихээхэн үнэ цэнэтэй бэлэг сэлтгэй ирэхэд биеэ үнэлэгсэдийн ахлах захирагч тэр элчин төлөөлөгч болон түүнийг дагалдагсдад шөнө бүр нэгэн сайхан биеэ үнэлэгч бүсгүйг оруулан өгч зугаацуулдаг байна. Эдгээр бүсгүйчүүдийг шөнө болгон сольж өөр өөр бүсгүйгээр үйлчлэх боловч тэднээс мөнгө төгрөг авдаггүй, тэд хааны санд татвар төлдөг билээ. Ер нь хотын дүүрэг, хороодод амьдрах биеэ үнэлэгсэдийн тоогоор өдөр тутам хотод орж, гарч буй худалдаачин, наймаачин, аянчин жинчний тоог барагцаалан хэлэхэд бараг л зөрөхгүй байх шүү.

Хан-балик хотод зөөж тээж авчирдаг, борлуулдаг үнэ цэнэтэй бараа таваар, тоног төхөөрөмж шиг их хэмжээний эд, бараа дэлхийн өөр аль ч хотын зах зээлд орж, гарч байдаггүй гэдэг нь хөдлөшгүй баримт юм шүү. Би одоо та бүхэнд тодорхой мэдээгээр иш татан өгүүлсү. Энэтхэг оронд олзворлодог үнэт чулуу, сувд эрдэнэ, мөн тэнд үйлдвэрлэдэг ховор нандин эдлэл, гар урлалын бүтээлүүдийг бараг бүгдийг нь энэ хотод зөөж, тээж авчирдаг.

Мөн Катай болон эзэнт гүрний муж, нутаг бүрээс хамгийн дээд зэргийн амт, чанартай хүнс, тэжээлийг энд авчирч борлуулна. Энэ бүхэн Их хаан, түүний түм буман албат, хаад ноёд, хатад эмс болон хотод оршин суух тоо томшгүй энгийн ард иргэд, тоогүй олон дэн буудал, хоолны газар, тэр бүхнийг эзэгнэн хөлхөж байдаг явуулын хүмүүс нэгэн дор бөөгнөрөн хуримтлагдсантай холбоотой билээ. Ийм учраас энд гадаадаас зөөж тээж авчрах эд эрдэнэс, бараа таваар, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, гүйлгээний эргэлт, олох ашиг орлого мөн дотоодын тариачид, малчдийн авчрах хүнсний зүйл, гар урчуудын бүтээл, эд бараа нь дэлхийн алив нэгэн хот байтугай улстай ч зүйрлэмгүй их, элбэг дэлбэг байдаг. Баримт болгон нэгэн зүйлийг нэрлэхэд зөвхөн чамин гоё нэхээстэй, өндөр үнэтэй хоргой, торго л гэхэд эндхийн зах зээлд нэг хоногт нэг мянган (1000) тэрэг139 даачаагаар тээж авчрах боловч тэр өдөртөө л борлуулж дуусах жишээтэй. Хан-балик хотын эргэн тойронд хоёр зуу илүү хот тосгод байдаг бөгөөд тэндхийн худалдаачид наймаачид энэ хотод өөрийн гэсэн худалдаа арилжааны дэлгүүр, мухлагтай байдаг. Тийм болохоор Хан-балик хот бусад ямар ч хоттой зүйрлэшгүй том, барагдашгүй бараа таваартай, зах зээлийн төв гэдэгт эргэлзэж тээнэгэлзээд гайхаад байх зүйлгүй билээ.

Хотын төвд орших өндөр харшийн адраас нэгэн том хонх дүүжлээстэй байх агаад тэр хонх

орой болгон гурван удаа нүргэлэн дуугарах нь хотод хөл хорьж буйн дохио билээ. Хонхны сүүлчийн дохио дуугарснаас хойш хэн ч хотын гудамд гарч зугаацаж сэлгүүцэх хориотой. Ийм үдэш орой болсон хойно зөвхөн хүүхэд төрүүлэх гэж байгаа эх болон өвдөж зовсон хүнийг эмчид хүргэхээр авч явахыг зөвшөөрөх агаад тэдгээр хүмүүсийг авч яваа хүн нь заавал дохионы галт бамбартай явах ажгуу. Шөнө бүр хотын амгалан тайвныг сахиулах үүрэгтэй гуч дөчин цэрэгтэй эргүүл харуул гарч хотын гудамж зээлийг эргэн явахдаа хонх гурван удаа дуугарч дохио өгснөөс хойш хот дотор яваа хүн болгоныг барьж гянданд хорино. Маргааш өглөө нь алба ажил цугласны хойно тэдгээр хүмүүсийг өнгөрсөн шөнө хэн хэн чухам ямар хэргээр тэнэж яваад харуулд баригдсаныг нэхэн тогтоож, үйлдсэн хэрэгт нь тохирох тоогоор ташуурдаж шийтгээд суллан тавих бөгөөд зарим нэг нь ташуур даалгүй үхэх нь бий. Ташуурдаж баалах нь хүний цус урсгахаас цээрлэж байгаа хэлбэр бөгөөд хүний цус урсган баалаж шийтгэх нь их нүгэл хилэнц хураадаг гэж зурхайч багш (bakhshi) нар номлон хориглох тул ташуурдаж шийтгэдэг болжээ.

Хотын хаалга болгоныг нэг мянган цэрэг сахин хамгаалж байдаг нь хотын оршин суугчдад үл итгэсэн буюу тэднээс айж эмээсэндээ биш харин нэг талаар Их хаандаа хүндэтгэл үзүүлж буйн, нөгөө талаар хорон муу санаатнаас сэргийлэн хамгаалж байгаагийн илрэл билээ. Зурхайч, төлөгчдийн мэргэнд буусан зөн зөгнөлөөс хойш Их хаан Катай нутгийн хятад иргэдээс байнга сэрэмжлэн болгоомжлох болсон билээ.

Нэгэн удаа Катайн хятад иргэд хааны эсрэг бослого гарган тэмцэхээр зэхэж байсан тухай өгүүлье. Эзэнт гүрний муж орон, газар нутгийн үйл ажиллагааг Их хааны томилсон арванхоёр их ноёд захиран тохинуулж, удирдан зохицуулдаг нь хэвшил болон мөрдөгдөж байдаг засаг засаглалын хэлбэр, хэв хэмжээ билээ. Тэдний нэг нь Ахмад хэмээх Сарацин угсааны хүн байжээ. Тэрхүү Ахмад нь эрч хүчтэй, арга ухаантай нэгэн байсан төдийгүй Их хаанд ихээхэн үнэлэгддэг, бас ч бусдыгаа бодвол хааны бодол санаанд тодорхой хэмжээгээр нөлөөтэй нэгэн байжээ. Их хааны бодол санаанд буруу номын бузар хар хүч, илбэ шидийн мансууруулах арга хэрэглэн нөлөөлж байсан түүний бузар үйл, хар хэргийн талаар Ахмадыг үхэж үрэгдсэний дараа олж тогтоожээ. Ахмад нь ордонд болж байсан албан уулзалт яриа, хэрэгтэн гэмтнийг байцаах шийтгэх бүхий л үйл ажиллагааг гардан зохион байгуулдаг байв. Ахмад нь хэн нэгэн хүнийг үзэн ядах, шударга болон шударга бусаар ял шийтгэл оноох, цаазлан хороохоор буруу явдал, бузар үйлийг сэдэн түүнийгээ хэрэгжүүлэхээр зэхэхдээ Их хаанд бараалхан ингэж айлтгана: “Тэр тэр гэдэг хүн үхэх ялтай тэд нар таны үйл хэрэг, ажил төрөл, амгалан тайван байдалд заналхийлсэн гэх” тэгж хэлэхээр нь хаан тэгвэл та өөрийнхөө бодож байгаагаар асуудлыг аль болох зөвөөр шийдчих гэдэг байсан бөгөөд Ахмад ч хааны үгээр халхавчлан тэр хүнийг буюу тэдгээр хүмүүсийг цаазлан хороодог байжээ. Ахмадын үйлдэж буй хар хэрэг нь өнгөн талаасаа Их хааны зарлиг тушаалыг гүйцэлдүүлж байгаа мэт харагдаж, Ахмад ч өөрөө хааны итгэл найдварт дулдуйдан ёстой л “намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ” гэдэг шиг дураараа дургиж дунд чөмгөө жиргэж байжээ. Их хааны ноёд, түшмэдийн дунд Ахмад шиг их эрх мэдэлтэй нэгэн үгүй болж хэн ч түүнд халдан үг хэлэх зориг зүрхгүй айцгаадаг болжээ. Хэрэв ээ хэн нэгэн зоримог шулуун эр Ахмадын үнэн нүүр царайг илчлэн Их хаанд үнэн мөнөөр нь айлтган ойлгуулж чадах юм бол түүнийг хамгаалан ганц үг ган хийх хүн хааныг тойрон хүрээлсэн эрхтэн дархтан, дээдэс ноёдын дундаас огт гарахгүй байсан бөгөөд түүнд тулгах ял зэмийг Ахмад хэрхэвч өөрөөсөө зайлуулж чадахааргүйгээр ганцаардан тасарсан өнчин хайлаас шиг ганцаардмал болсон хүн байлаа.

Ахмад энэ бурангуй замаараа будаа тээн ямар ч гэм зэмгүй олон олон хүнийг цаазлан хороосон нүгэлтэн бөгөөд буцах замдаа өөрийнхөө үхлийг тээх нь зайлашгүй болсон амьтан байв.

Үзэсгэлэн гоо охид хүүхнүүдийг харах болгонд Ахмадын сэрэл тачаалыг өдөөж тэднийг эзэмдэн эдлэх, эхнэрээ болгох, нөхөртэй бол зарлиг тушаалаар далайлгах бүхий л арга чаргаар бүсгүйчүүдийг эзэмддэг байв. Мөн хэн нэгнийх царайлаг гоо охинтой гэж мэдвэл охины эцэг рүү өөрийнхөө балмад танхай зарц нараа илгээн хэлүүлэх нь: “Та төрийн өндөр алба хаших хүсэлтэй гэдгийг бид дуулсан, харин та охиноо яая гэж бодож байна даа? охиноо манай Байло (Ахмадыг бурхан-дэслэгч гэж хочилдог) руу илгээчих, тэр таныг гурван жилийн дотор хүссэн албанд чинь томилно” гэж дарамталж шахамдуулдаг байв. Ингээд уг хүн охиноо Ахмад руу явуулахаас өөр аргагүй болдог. Үүний дараа Ахмад Их хаанд бараалхан: “Тийм тийм албан тушаалд хүн томилоогүй байгаа гэх буюу эсвэл удахгүй тийм албан тушаал чөлөөлөгдөнө гээд энэ ажил албанд тэнцэх тийм угсаа удмын, тэр гэгч хүн байна” гэхэд хаан тэгвэл та өөрийнхөөрөө шийдчих гэдэг байжээ. Ахмад ч өөрийнхөө бодож санасныг төвөггүй хэрэгжүүлнэ. Ийм арга замаар энэ хүний алба тушаал дэвших хүсэл шунал, өөрөөс нь айн ширвээдэх айдас хүйдсийг ашиглан гоо үзэсгэлэнтэй, царайлаг охид бүсгүйчүүдийг эзэмдэн авч эхнэрээ буюу татвар эмээ болгодог байна. Ахмад хорин тав орчим нас бие гүйцсэн хөвгүүдтэй байсан бөгөөд тэд нарыгаа бүгдийг төрийн өндөр албанд томилуулан дэвшүүлж амжсан байлаа. Түүний хөвгүүдийн ихэнх нь эцгийнхээ алба тушаал, нэр алдарт дулдуйдан бузар бурангуй үйлд гаршин, эцгийнхээ зам мөрөөр замнан янз бүрийн гэмт үйлийг хийхээс буцаж няцдаггүй болцгоожээ. Ахмад өөрийнхөө алба тушаал, зэрэг дэвийг ашиглан том жижиг бэлэг сэлт, хээл хахууль авсаар асар их хөрөнгө зoorь, эд бараа хуримтлуулжээ.

Ахмад нь амбан захирагч гэсэн төрийн өндөр албыг тасралтгүй хорин хоёр жил хашиж байгаа билээ. Катай орны үндсэн иргэд нь хятадууд бөгөөд төдий урт удаан хугацаанд амбан захирагчийн албыг хашиж буй Ахмадын бузар булай үйл явдал, эмс охид, эхнэр хүүхнүүдийг нь бузарлан гутаах шившигт хэрэг, эд бараа хөрөнгө зoorио шулуун шударга иргэдийг цаазлан хороох, хээл хахууль авах замаар арвижуулах нь эцэс төгсгөлгүй болж хятад хүмүүсийн жигшил зэвүүцэл, уур хилэн дэврэн дэвэрсээр савнаасаа аль хэдийн халин гарчээ. Хятадууд Ахмадыг алах, хотын засаг захиргааны эсрэг бослого гарган тэмцэхээр нэгэнт шийджээ. Эдгээр босогчдын дунд ээж, эхнэр, охиноо Ахмадад бузарлуулсан мянганы ноён Чиен-ху, хотын засаг захиргааны тушаал шийдвэрт жигшин дургүйцсэн түмтийн ноён Цагаан –ху буюу Ван-ху гэгч бас нэгэн хятад байлаа. Тэд энэхүү бослого тэмцлээ Их хаан Хан-баликт суудаг гурван сараа өнгөрөөж Шанду хотод зусахаар нүүх, мөн хан хүү Чингиз өөрийн эзэмшил эдлэн газартаа очиж зусах тэр агшинд гүйцэлдүүлэхээр төлөвлөцгөөж байв. Их хаан, Хан хүү хоёр зусландаа гарсан хойгуур хотын захиргааны бүрэн эрхэт эзнээр Ахмад үлддэг бөгөөд шаардлагатай үед Шандуд суугаа Их хаанд хэл хүргэж хариу зарлиг тушаал хүлээн авч өөрийн хүсэл зоргоор хэрэгжүүлдэг байв. Хуйвалдагч хоёр ноён бослого тэмцлийнхээ тухай Катай орны хятад хүмүүс болон бусад хот суурин газар оршин суудаг өөрсдийн итгэлт нөхөд, танил талдаа сэм мэдэгдэж амжсан байв. Катай орны иргэд ялангуяа хятад хүмүүс Их хааны засаг засаглалыг үзэн яддаг байсан нь тэр орныг удирдан захирах албанд Тартарчуудыг, ялангуяа маш олон сарацин хүмүүсийг томилон ажиллуулж байгаа нь тэдэнд огт таалагддаггүйгээр барахгүй Катай орны эзэн хятадууд боолын боол болцгоосонтойгоо эвлэрэх аргагүй байлаа. Катай орныг цэрэг зэвсгийн хүчээр эзлэн захирсан Их хаанд тэр газар орныг нэрлэх

тухайлсан нэр, тохинуулан захирах хууль дүрэм аль аль нь үгүй байв. Эзлэгдсэн орны хүн ардад төр улсаа жолоодох эрх мэдлийг итгэн өгөх аргагүйн эрхэнд Катай орныг удирдан захирах эрх мэдэл, засаг захиргааг Тартаруудынхаа гарт атгуулж, төрийн бусад алба тушаалд хааны гэр орны ажлыг эмхлэн ойр зуурын нь зарлиг тушаалыг хэрэгжүүлэхээр авчирсан Сарацин хүмүүс болон Загалмайн шашинтнуудаас шилэн сонгож төрийн албанд дэвшүүлэн ажиллуулсан бөгөөд уг нутгийн уугуул иргэд болох хятадууд нь боолын зэрэгт үлджээ. Ван-ху Чиен-ху хоёр бослого гаргахаар товлосон өдрийнхөө шөнө нь ордонд ирж хааны өргөөнд орцгоов. Ингээд Ван-ху эргэн тойрон зул дэнгээр гэрэлтүүлсэн хааны сэнтийд суув. Тэгээд тэр хуучин хотод гэртэй Ахмад руу зарлага илгээж Хан хүү Чингиз дөнгөж сая ордонд ирчихээд Байлог үтэр түргэн ир гэж дуудуулж байна гэж хэлүүлэв. Үүнийг сонссон Ахмад ордны зүг яаран явахдаа юу болоод яагаад ингэж яаралтай дуудуулах болсон учрыг тааж ядан бодлогоширч бас бага зэрэг догдолж явлаа. Хотын хэрэмний хаалгаар орж явахдаа, хотын харуул, эргүүлд гарсан хишигтэн захирагч Когатай хэмээх тартартай таарав. “Энэ оройн цагаар та хаа хүрч явна гэж гайхаж эргэлзсэн Когатай асуув”. Ахмад түүнд “Хан хүү Чингиз дөнгөж сая ордондоо ирээд намайг үтэр түргэн ир гэж дуудуулжээ” гэв. Энэ хариуг сонссон Когатай “энэ мөн сониноо” гэж өөрөө өөрөөсөө асуугаад “Хан хүү надад харагдалгүй, сонсогдолгүй тийм нууцгайгаар ирсэн гэхэд итгэх аргагүй” гэж өөрөө өөртөө хариулаад харуулын цэргүүдээ дагуулан Ахмадын хойноос явав. Хуйвалдагсад хоорондоо ийн хэлэлцэнэ: “бид хоёр Ахмадыг алчихвал өөр айх аюулгүй болно” гэж хоорондоо шивнэлдэн хэлэлцэж байв. Энэхэн мөчид Ахмад ч ордонд орж ирээд галын дөлний гэрэлд тодорч, бүдгэрэх Ван-хуг Хан хүү Чингиз гэж бодон өмнө нь сөгдтөл хажууд нь байсан Чиен-ху ирт сэлмийнхээ ганцхан далайлтаар Ахмадын толгойг тас цавчиж унагав. Яг энэ агшинд үүдээр орж ирсэн Когатай үүнийг харангуутаа “Урвалт” гэж өндөр дуугаар хашгиран хааны сэнтийд залран буй Ван-хуг харван сэнтийдэй нь хадаж орхиод, дагалдан яваа харуулын цэргүүдээрээ Чиен-хуг бариулав. Когатай тэр даруй хотын гудамж, талбай, зах зээлээр яваа хэнийг боловч газар дээр нь цавчин алах тушаал буулгав. Энэ үед хятадууд тэдний хуйвалдаан нуран унаж, нэг толгойлогч нь алуулж, нөгөөх нь баригдсаныг мэдмэгцээ гэр гэртээ нам гүм сууцгаан юу болохыг ажиг хүлээцгээв. Бусад хот сууринд бослого хөдөлгөөн эхлэх мэдээ, дохио өгөх ямар ч боломжгүй бөгөөд утгагүй болжээ. Когатай тэр даруйдаа Их хаан руу элч илгээж болсон явдлыг нэгд нэгэнгүй илтгэн танилцуулаад хариуд нь болсон үйлийг шүүн байцааж учир шалтгаан болон хамрагдагсаныг илрүүлэн зохих цааз, шийтгэл хүлээлгэх зарлиг тушаалыг Их хаанаас авчээ. Маргааш өглөө нь Когатай бүх л Катай орныг хамарсан байцаалт явуулж бослогын толгойлогч болон оролцогч байж болох магадлалтай бүхнийг цаазлан хороов. Мөн бүх л орны хот, сууринг хамарсан байцаалт, мөрдөлт явуулан сэжигтэй бүхнийг устгав.

Их хаан Хан-баликт эргэж ирэнгүүтээ чухам юунаас болж бослого тэмцэл гарахаар болов, шалтаг шалтгаан нь юу байсныг тодруулж мэдэхийг хүсчээ. Энэхүү мөрдөн байцаалтын үед Ахмад болон түүний хөвгүүд хэрхэн яаж дур зоргоороо дургиж хэн боловч жигшин зэвүүцэм бузар үйлийг санааныхаа зоргоор хийхдээ Их хааны нэрээр халхавч хийдэг байсныг олж тодруулав. Мөн Ахмад болон түүний төрийн өндөр зэрэг хэргэмтэй долоон хүү нь тоо томшгүй олон эхнэр авснаар барахгүй тэдний хүчээр эзэмдэн бузарласан бүсгүйчүүдийн тоо хэлэх багцаагүй олон болжээ. Ахмадын хуучин хот дахь орон байрандаа хурааж хуримтлуулсан асар их эд бараа, эрдэнэсийг хураан авч хааны санд нийлүүлэхэд бүгд нэг ч бүртгэл тооцоогүй бэлэг сэлт, хээл хахуулиар цуглуулсан хөрөнгө байлаа. Их хаан Ахмадын хүүрийг ухаж гарган гудамжны золбин ноходод тасчин өгөхийг зарлиг болгоод эцгийнхээ зам



мөрөөр бузар булай хэрэг үйлдсэн хөвгүүдийн нь арьсыг амьдаар нь хуулж тамлан алахыг тушаав. Лал шашинтан сарацинууд өөр шашинтай хэнийг боловч алах, тамлахыг нүгэл гэж тооцдоггүй номлол, сургаалтай бөгөөд тэдний энэ номлол сургаалыг Их хаан яснаасаа үзэн яддаг, жигшин зэвүүцдэг байжээ. Үүний дараа лал шашинтан сарацинуудыг дуудан цуглуулж тэдний шашин номлолын дагуу хийдэг олон олон буруу, бусармаг зан үйлийг чандлан хориглов. Ялангуяа гэр бүл болох эхнэр авахдаа зөвхөн монголын хууль дүрмийг ягштал мөрдөж байхыг зарлигдав. Мөн хонь муулахдаа хоолойгий нь хэрчин цустай нь хутгахыг зогсоож тартар маягаар өрлөн алж байхыг тушаав. Энэ бүх үйл явдал ид өрнөж байхад эрхэмсэг Марко гуай Катай оронд ирчихсэн байж билээ.

Их хааны харуул, хамгаалалтын албыг нэгэн түм хоёр мянган (12000) цэрэг эрс хаших бөгөөд тэднийг Хишигтэн (Keshikten) гэх бөгөөд манай хэлээр утгачлан орчуулбал “эзний харьяат баатрууд” гэсэн санааг илэрхийлж байгаа билээ. Их хаан хэн нэгнээс айж эмээсэндээ харуул хамгаалалтын нэг түм хоёр мянган цэрэг эрсийг цуглуулсан юм биш ээ, “хишигтэн” гэгдэх хааны торгон цэрэг нь Монголын эзэнт гүрний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсоор ирсэн учиртай. Энэхүү нэг түм хоёр мянган хишигтэн цэрэг нь тус бүр гурван мянгаар (3000) хуваасан дөрвөн хороо болдог бөгөөд тус бүр өөр өөрийн захирагчтай. Гурван мянган цэрэгтэй нэг хороо нь гурван өдөр, гурван шөнө хааны ордныг сахин хамгаалж тэндээ хооллож ундлан байнга эргүүл, харуул хийнэ. Гурван хоног өнгөрмөгц дараагийн гурван цэрэгтэй хороо ээлж халаагий нь авах бөгөөд ийм маягаар “хишигтэн”-ий алба завсаргүй эргэнэ. Амарч буй есөн мянган цэрэг эрс өдөртөө хааны ордонд байрлан зарим нь Их хааны зарлиг тушаалыг биелүүлэх ажилд зарагдан, зарим нь ордны доторх ажил үйлд тусална. Хэн нэгэн хишигтэн хааны зарлигийг биелүүлэхээр явахдаа буюу бас бус үүрэг даалгавар гүйцэтгэхдээ захирагчдаа заавал мэдэгдэн, зөвхөн түүний тушаал зааврыг даган биелүүлнэ. Хишигтний ар гэрийнхэн өвдөж зовох, үхэж үрэгдэх зэрэг хойшлуулашгүй ажил гарч, хишигтэн цэрэг гэр орондоо заавал очих, тэнд байх хэрэг гарвал Их хаанаас чөлөө авч явдаг. Өдөр ордонд байсан есөн мянган хишигтэн шөнө нь гэр гэртээ харьдаг.

Их хаан ордондоо чуулган зөвлөлгөөн хийх, найр хурим хөгжөөх үед хэн хэрхэн, хаана, ямар байранд, яаж суудаг талаар өгүүлбэл: Их хаан өөрөө их танхимийн хойморт өндөр сэнтийд өмнө зүгт харан заларна. Их хатан хааны зүүн гарт сууна. Баруун гар талд нь хааны сэнтийгээс нэлээд намхан сэнтийд хан хөвгүүд насныхаа эрэмбээр дэс дараалан сууцгаана. Хаан ор суух хүү Чингиз нь бусдаасаа арай өндөр сэнтийд заларна. Тэдний дараа эгнээнд хааны ач нар болон алтан ургийн ахан дүүс сууцгаана. Тэдгээр ихэс ноёдын толгой нь хааны хөлийн орчимд байхаар суудал сэнтийг зассан байдаг. Тэдний араар хаад, ноёд болон бусад язгууртан дээдэс зэрэг дэвийнхээ дэс дарааллаар сууцгаана. Хааны хатад, охид, зээ, бэр, бэргэнүүд мөнхүү эрчүүлийн суусан дэс дарааллаар хааны зүүн гар талд сууцгаана. Их хааны ордонд хэн хаана суух байр суудлаа хүн бүхэн ягштал мэддэг билээ. Ноёдын суудал, хоолны ширээ болон ордны доторх бүхнийг Их хаан тов тодорхой харж болохоор байршуулсан байдаг. Бүх ноёд дээдэс өөрийн гэсэн тусгай суудалд заларна уу гэвэл бас үгүй, ингэж суух эрхтэй, гэрэгтэй ноёд л тусгай суудалд заларна. Ихэнх ноёд, дээдэс болон ордныхон хивсэн дээр морилон хооллоцгооно.

Ордны их танхимийн гадна талд дөчин түм (40000) илүү зочид гийчид хуран цугларсан байдаг. Тэдгээр зочид гийчдийн дунд асар их үнэ цэнэтэй бэлэг сэлт авчирсан, төрийн өндөр

алба тушаал хашдаг бөгөөд мөн улам цаашаа, дээшээ дэвших тэмүүлэл мөрөөдөлтэй эрхэм дээдэс олон олон байх. Их хааны чуулган зөвлөлгөөн болон хурим найранд уригдан ирдэг зочид гийчид иймэрхүү л хүмүүсээс бүрдэнэ. Их хааны залрах их танхимийн голд гурван алд урт, гайхамшигтай нарийн ур хийцтэй, элдэв амьтан араатны дүрс сийлэн алтдаж гоёсон гонзгой дөрвөлжин, идээ ундааны ширээ зассан байх. Ширээний голд домбон хэлбэртэй асар том шижир алтан савыг дарсаар дүүргэн тавьсан байх. Ширээний дөрвөн өнцөгт тус бүр нэгэн торхны багтаамжтай вааранд сүү (айраг), тэмээний сүү (хоормог) болон бусад ундаа сөгнөн тавьсан байна.

Их хааны өмнөх ширээн дээр төрөл бүрийн алтан сав суулгатай дарс, ундаа сөгнөөстэй байх. Том ширээн дээрх алтан савтай дарснаас тус бүр наймаас арван эрчүүлд элбэг хүрэлцэхүйц багтаамжтай алтан саванд юүлж түүнийгээ хоёр эрийн дунд сөгнөнө. Тэдгээр эрчүүдэд амсар дүүртэл дарс хундагалсан сэнжтэй алтан аяга бариулна. Хатад бүсгүйчүүдэд мөн ялгаагүй дарс хундагалсан алтан аяга бариулна. Дарс, ундаа хундагалдаг эдгээр алтан аяга, сав суулга бүгд маш их үнэтэй эд билээ. Их хааны санд алтан, мөнгөн сав суулгаар дүүрэн тусгай өрөө танхим буй бөгөөд түүнийг нүдээрээ хараагүй хүн ийм олон алт, мөнгөн сав суулга байдагт итгэхэд бэрх. Найрын ширээнд идээ, ундаа түгээн үйлчлэх зөөгчид маш эелдэг шуурхай, аажуу тайван, өөртөө итгэлтэй хүмүүс байх. Идээ, ундаа зөөн түгээх хүмүүс бүгд алтан саатай торгон алчуураар ам, хамраа таглан боосон байх нь зочид, гийчдэд түгээж буй идээ, ундааг амьсгалаараа бохирдуулахгүй 140гэсэн санаа билээ.

Найрын ёс жаяг, дэг журмыг чандлан сахиулах, хоцорсон болон шинээр ирэх зочид гийчдийг байр суудалд нь тухлуулах, хаана хэнд юу хэрэгтэйг гүйцэлдүүлэх үүрэгтэй тусгай ноёд хүмүүсийн дундуур байнга цааш нааш сүлжилдэн хэнд юу хэрэгтэйг асууж лавлана. Зочид гийчдэд дугаж гучсан зүйл байх аваас тэдний хүсэл, захиалгыг үтэр түргэн гүйцэлдүүлж хэрэгтэй бүхнийг зөөгчид авчирч өгнө. Танхимд орох хаалга бүрийн хоёр талд мөн Их хаан очих, орж гарч болзошгүй газар болгонд бэрээ барьсан хоёр өндөр чийрэг эрийг харуулд зогсооно. Энэ нь хэн нэгэн зочин, гийчин хаалганы босго гишгэх, босгонд тээглэхээс сэргийлэн хамгаалж буй хэрэг билээ. Босго гишгэх, босгонд бүдрэх нь тартаруудын хувьд гаргаж болошгүй олтгойлол төдийгүй бузар нүгэл билээ. Хэрвээ хэн нэгэн хүн босгонд бүдрэх буюу гишгэвэл түүний хувцсыг тайлан авч торгууль онооно, торгууль төлөхөөс зайласхийвэл бэрээдэж баална. Харин тартар ёс жаягийг мэддэггүй зочид гийчдэд үүнийг сайн тайлбарлан ойлгуулна. Найр өндөрлөж халамцуу, согтуу зочид гийчид тарахдаа дээрх дэгийг зөрчихөд хэн ч тоож хэлэлцдэггүй журамтай.

Их хаан ширээ дүүрэн өрөөстэй дарс, ундаанаас уухаар зэхмэгц сөнч хаанд аяга дүүрэн дарс өргөн барих бөгөөд хаан суудлаасаа босч гурван алхам урагшлан өвдөг нугалан сөхөрч мөргөл үйлдээд уухад танхим дахь бүх хүн түүний үйл хөдлөлийг даган давгаж номхон хүлцэнгүй болон сүсэг бишрэлийн жишиг үзүүлэнэ. Үүний дараа хаан дарсаа ууна. Хааныг дарс уух бүрийд дээрх ёслол заншлыг үйлдэнэ. Их хааны найр хуриманд ирсэн ноёд дээдэс зөвхөн авааль гэргийгээ дагуулж ирдэг. Энд өрж тавьсан идээ будааг нэрлэн тоочих аргагүй олон бөгөөд элбэг хангалуун болой. Их хаан болон уригдаж ирсэн зочид гийчид хооллож, ундалж дууссаны дараа их танхимыг зайцуулан зарлагч, уран нугараач, саваачлагч тэргүүтэн олон авьяаслаг жүжигчид, бүжигчид, дуучид өөр өөрийн ид шид, ур ухааныг үзүүлэн зочид гийчдийг баясуулан цэнгүүлнэ. Зочин гийчин бүхэн Их хааны дэргэд найрлан цэнгэж,

хамтдаа уран сайхан үзүүлбэр үзсэндээ сэтгэл хангалуун, баяр баясгалантай инээж наргин хөөрнө. Энэ бүхэн дуусмагц зочид гийчид гэр гэрийн зүг одмой.

Тартарууд төрж мэндэлсэн өдрөө баярлан тэмдэглэдэг заншилтайг та бүхэн андахгүй билээ. Их хаан сарны (билгийн) тооллын есдүгээр сарын хорин наймны өдөр хорвоод мэндэлсэн билээ. Их хааны мэдэлсэн өдрийг их найр цэнгэл хөгжөөн, хаандаа ёс төртэй хүндэтгэл үзүүлэн, бэлэг сэлт барин тэмдэглэн өнгөрөөдөг, энэ баяр нь цагаан сарын дараа орох нүсэр баяр болдог бөгөөд харин цагаан сарын баярын талаар би хойно өгүүлэхээ амлаж байна.

Их хаан төрсөн өдрөөрөө алтан утсаар хээ угалз хатгасан чамин гоё хувцас өмсөнө. Нэг түм хоёр мянган ноёд дээдэс, баатар жанжингууд нь өнгө хийцээрээ хааны хувцас шиг боловч арай хямд дээл хувцсаар гоёцгоож, цөм алтан бүс бүсэлнэ. Эдгээр гоё дэгжин хийцтэй, хээнцэр тансаг хувцсыг хаан тэдэнд бэлэглэсэн байдаг. Эдгээр ноёд дээдсийн заримынх нь өмссөн хувцас, гоёж чимсэн эрдэнийн чулуун болон сувдан эрдэнэ нь нэг түмэн (10000) бэзангийн үнэ хүрэх нь энүүхэнд. Ийм үнэтэй гоёл чимэглэлтэй ноёд, ихэс олон байх. Нэг түм хоёр мянган ноёд дээдэс, жанжин баатрууддаа Их хаан жилдээ арвангурван удаа эгээл өөрөө өмсөх юм шиг дэгжин гоё хийцтэй, баян тансаг хувцас бэлэглэнэ. Эдгээр хувцас гоёл нь асар үнэтэй болохыг хэн ч тоймлон хэлэх аргагүй, ингэж албат иргэдээ тэтгэн тэнхрүүлдэг өгөөмөр өглөгч хаан эзэн энэ хорвоод өөр хаана ч үгүй билээ. Хааны төрсөн өдрийн энэ их баярт зориулан хорвоогийн бүх тартарууд, Их хааны хишиг буянаар эзэнт гүрний муж, нутагт газар эзэмшин эдэлж буй баячууд, чинээлэг тариачид, малчид хааны өглөгч өгөөмөр сэтгэлд дүйцэх, хариу болохуйц үнэт эдлэл, бэлэг сэлтийг өргөн талархана. Мөн төрийн өндөр алба горилон мөрөөдөгсөд, Их хааны цэрэг, иргэний зөвлөлд өргөмжлөн томилогдохоор зэхэж буй арванхоёр язгууртан, бусад ихэс дээдэс асар үнэтэй бэлэг сэлт өргөн барина. Энэ өдөр Онгод шүтлэгтэн-бөө мөргөлтнүүд, Загалмайтнууд болон Лал шүтээнтэн сарацинууд шашин шүтлэг, үндэс угсаа ялгаварлалгүй Их хааныхаа эрүүл байж, урт удаан наслахын хутаг ерөөлийг бэлэгдэн өөр өөрийнхөө шашны хурал номыг хурж, зул, хүжээ өргөн залбирцгаана. Сая би Их хааны төрсөн өдрийн баярыг хэрхэн тэмдэглэж, найр хурим хөгжөөн цэнгэж, залбирал ерөөлөө илгээн, үнэт бэлэг сэлтээ хаандаа өргөн барьдаг тухай тов тодорхой өгүүлсэн тул одоо Цагаан сар хэмээх шинэ жилийн баярын талаар өгүүлсү.

Тартаруудын цагаан сар буюу шинэ жилийн баяр нь хоёрдугаар сард болох боловч – чухам хэдний өдөр шинэ оноо угтаж, хуучин оноо шилгээж байгаагаа Их хааны зарлиг шийдвэрийн дагуу гүйцэлдүүлнэ. Тэдний уламжлал заншил ёсоор эр эм, хүүхэд хөгшид ялгаагүй өөр өөрийнхөө зэрэг дэв, боломж бололцоогоор бүгд цагаан хувцсаар гоёно. Тэд нар цагаан өнгийг ээвэргүү зөөлөн, найрсаг тавлаг байхын бэлгэдэл гэж үздэг тул ирж буй шинэ ондоо жилийн турш амар амгалан, элбэг баян байж, бүх юм дэгжин дэлгэрч байхын билгэт сайн ерөөлийг зөгнөн буй нь энэ ажгуу. Энэ өдөр эзэнт гүрний ихэс ноёд, жанжин баатрууд болон муж нутгийн амбан захирагчид, төрийн өндөр дээд албан хаагчид, хааны өршөөл ивээлээр газар нутаг, эд баялаг эзэмшигчид хэн боловч Их хаандаа алт, мөнгө, үнэт чулуу, сувд эрдэнэ, дэгжин хээнцэр торго даавуу тэргүүтэн ер зүсэн зүйлийн үнэ цэнэтэй эд бараагаар бэлэг сэлт өргөнө. Тэдний өргөн барих бэлэг сэлт нь Их хааныг ирж байгаа жилийн турш элбэг хангалуун, баяр жаргалтай байгаасай гэсэн сэтгэлийнх нь илрэл билээ. Мөн энэ өдөр ноёд дээдэс, баатар жанжнууд болон энгийн ард иргэд ялгалгүй харилцан бие биедээ цагаан

өнгийн эд зүйлсээр бэлэг барина. Хүмүүс харилцан бие биеэ хүндэтгэн мэндчилж золгохдоо: Ирж байгаа онд ажил төрөл чинь бүтэмжтэй байж санасан бүхэн чинь сэтгэлчилэн бүтэх болтугай” гэсэн ерөөл билэгдэл дэвшүүлнэ. Ингэж мэндчилж золгох үйл нь тэр жилийнхээ туршид үргэлжилж уулзаж учраагүй танил тал, ахан дүүс, энгийн хүмүүс ч золгож мэндчилнэ.

Цагаан сарын шинийн нэгний өдөр Их хаан үзэмж төгс, омголон догшин арван түмэн (100000) цагаан адууны бэлэг авна<sup>141</sup>. Мөн араатан амьтан, жигүүртэн шувуудын дүрс хатгаж урласан үнэт торгон нэмнээ тохоштой, тус бүр шатдаггүй хоёр том авдар дүүрэн ёслолын хувцас хунар, алт эрдэнэс нуруунд нь тэгнэн ачсан таван мянган зааны цуваа аажуу тайван алхлах нь сүртэй бөгөөд үзүүштэй. Зааны цувааны араас цагаан сарын идээ, ундаа найрын сав суулга ачсан тоо томшгүй тэмээн жингийн цуваа хөврөн ирж зогсонгуутаа хааны ордны өмнөх талбайг хорголон мөндрөөр булах нь ёстой л байн байн тохиохгүй, хараад хараад ханашгүй гайхалтай үзмэр мөн гэлтэй.

Шинийн нэгний өглөө найрын ширээ засахын өмнө хаан, хан, гүн, бэйл, бээс, хишигтэн, хэвгүүл баатар эрс, зурхайч-төлөгчид, эмч домч, шонхор сургагч анчид болон эзэнт гүрний газар нутаг, муж, хотын захирагчид, өндөр албан тушаалтнууд, цэргийн эрхтэнүүд Их хааны ордны их танхимд ирж хаанд бараалхан золгоно. Их танхимд багтахгүй үлдэгсэд ордны өмнөх талбайд Их хааны нүд, хараанд өртөх газар цугларна. Одоо эдгээр хүмүүс ямархан дэс дараа, зэрэг дэвээр цувран золгохыг өгүүлье. Эхлээд хааны хөвгүүд, ач нар, дараа нь алтан ургийнхан золгоно. Үүний хойноос хаад, ноёд зэрэг дэвийнхээ дарааллаар цувран золгоно. Золгож дуусаад бүх хүмүүс өөр өөрийн ногдсон байр суудлыг эзлэнэ. Бүх хүн байр суудалдаа суусны дараа ахмад, хүндтэй эрхэм түшмэл босож өндөр дуугаар ийн өгүүлэв: “Мэхийн сөгдөж, хүндэтгэн мөргөцгөө” гэхэд танхим дүүрэн хүмүүс өвдөг нугалан бөхийж духаа шаланд хүргэн эгээл бурханд мөргөхийн адил Их хаандаа сөгдөн мөргөцгөөв. Тэгээд дээрх эрхэмсэг түшмэл: “Бурханы өршөөлөөр Их хааны насан хутаг мөнхрөн, аз жаргал, эрүүл энхийг хайрлатугай” гэхэд сөгдөн мөргөж буй бүх хүн нэгэн дуугаар: “Бурхан өршөөг” гэгцгээнэ. Эрхэмсэг түшмэл дахиад: “Эзэнт гүрнийхээ газар шороог арвижуулан тэлж, хүн ардынхаа амьдрал ахуйг сайн сайхан болгож, юм бүхнийг өөд татан, нүгэлт хорвоог ариун санаагаар цэвэршүүлэн, эзэмшил нутгаа алагчлалгүй хөгжүүлж байна” гэхэд бүх хүн нэгэн дуугаар: “Бурхан өршөөг” гээд энэ мэтээр дөрвөн удаа Их хаандаа сөгдөн мөргөж залбирал ерөөлөө айлтгана. Хүмүүс мөргөл залбирлаа өндөрлөн Их хааны нэрийг сийлсэн час улаан гэрэгэтэй гүнгэрваа тахиж, уран гоё хийцтэй бойпорт арц, хүж уугиулсан тахилийн ширээнээс адис авцгаагаад эргэж суудалдаа сууцгаана. Энэ бүхний дараагаар Их хаандаа авчирсан бэлэг сэлтээ өргөн гардуулана. Их хаан бэлэг сэлтийг хүлээн авсны дараа найрын ширээнээ идээ, ундаа залж, зочид гийчид байр суудлаа эзлэн их найр эхэлнэ. Гагц Их хаан Их хатаныхаа хамт өндөр сэнтийд залран бусад нь зэрэг дэвийнхээ дарааллаар суудлаа эзлэн их найр хөгжөөн цэнгэцгээнэ. Найрын цагаалга дууссанаас хойш дуучид, бүжигчид, жүжигчид зочид гийчдийг хөгжөөн цэнгүүлж өндөрлөөд бүгд гэр гэрийн зүг тархан явгаана.

Би та бүхэнд Их хаан арвангурван их найр цэнгэл хийх бөгөөд энэ нь сарны тооллын сар бүр нэгэн баяр ёсолж, найр наадам хийнэ гэсэн хэрэг. Хамгийн сүүлчийн буюу арвангуравдугаар найраа Их хаанд хамгийн ойр дотно байж, түүнийг байнга хамгаалан сахиж, манаж байдаг нэг түм хоёр мянган “хишигтэн” дайчдад зориулдаг. Их хаан хишигтэн бүрт арвангурван

төрлийн янз бүрийн өнгөтэй хувцас бэлэглэсэн байдаг. Эдгээр хувцас нь үнэт чулуу, сувд эрдэнээр гоёж чимсэн асар их үнэ цэнэтэй хувцас билээ. Их хаан хишигтэн бүртээ ижилгүй гоё хийцтэй алтан бүс, мөнгөн утсаар хээ угалз хатгаж чимсэн бөх бат, дэгжин хээнцэр ширэн гутал (тэдгээр гутлыг *canaut* буюу *borgal* гэдэг) бэлэглэсэн байдаг. Хишигтний хувцас хунар нь үнэнхүү дэгжин гоё, баян тансаг, бөх бат билээ. Бүрэн хувцастай хишигтэн бүхэн хэн хүний нүдэнд тусах төдийгүй хаанах газрын хаад, ноёд вэ гэж андуурам тансаг дэгжин хувцаслацгаана. Нэг төрлийн хувцсыг нэг л баяр ёслолоор өмсөнө<sup>142</sup>. Их хаан өөрөө тэдгээр хишигтэнтэй өнгө төрхөөрөө ижил хувцсаар гоёх бөгөөд хааны өмсгөл нь онцгой содон гоёл чимэгтэй, ихээхэн баян тансаг байдаг билээ. Их хааны хувцасны өнгө төрх нь түүний шадар ноёд, сайдынхтай төстэй байдаг. Эдгээр нэг бум таван түм зургаан мянган (156000) хувцас хэрэглэлийн үнэ цэнэ нь арвин их зоос, алт мөнгөөр үнэлэгдэнэ. Үүний дээрээс хишигтэн бүрийн алтан бүс, ширэн гутал нь мөн чиг чамгүй их үнэ цэнэтэй эд билээ гэдгийг оролцуулан тооцох учиртай. Их хаан энэ бүхнийг хийхдээ Эзэнт гүрнийхээ нэр сүрийг өргөх, найр наадмынхаа нүүр царайг бусдад сайн сайхан талаас нь харуулахад чиглүүлжээ.

Энэ номонд заавал оруулан уншигч, сонсогч авгай нарт сонордуулах өөр нэгэн сонин гэвэл: Гинжилж бэхэлсэн уяатай аварга том арсланг Их хааны дэргэд хөтлөн авч ирэхэд хааныг хармагцаа тэнхэл алдран номхорч Их хааныг энэ миний эзэн гэж мэдэрч байх шиг болдог төдийгүй уяа гинжгүй сул хааны хөлд амгалан тайван хэвтэх нь үнэнхүү гайхан биширмээр байдаг.

Одоо би Их хааны ав хомрогын тухай өгүүлсү. Дүн өвлийн арванхоёр, нэг, хоёрдугаар сарыг Их хаан Хан-балик хотноо сууж өнгөрөөдгийг та бүхэн мэдэх бөгөөд хотын дүүргээс гадуур эргэн тойрон зургаан өдөрчийн газар нутаглан суух эрчүүд ав хоморго хийж, алсан олсон ангаа арилжиж борлуулахыг хаан зарлигдан тушаадаг. Ийм зарлиг тушаалыг нутаг, муж бүрийн амбан захирагч нарт хүргэн алсан агнасан гахай, бодон, буга согоо, гур, баавгайн тураг махны дийлэнхийг хааны санд тушаахыг үүрэг болгон зарлигддаг. Үүний дагуу амбан захирагч бүр нутаг нугынхаа анчид шувуучдыг цуглуулан ав хоморгод гарцгаан дээр дурьдсан амьтдыг хаана, хэдийд нутагшиж бэлчдэгийг мөшгин тодруулаад нохойгоор хоргоон бариулах буюу ихэнхийг нь харваж намнадаг<sup>143</sup>. Агнаж авласан ангийнхаа гэдсийг авчихаад тураг махыг нь хөлдөөн тэргэнд ачиж авчран Их хааны сан хөмрөгт тушаана. Ийм үүрэг даалгаврыг нийслэл хотоос гучин өдөрчийн газар орших муж, хот, тосгодод хүргэсэн тул тэдний нийлүүлж буй тураг мах асар их болдог. Гучин өдөрчийн газраас цааших жаран өдөрчийн газар нутаглах нутгийнханд тураг мах тушаах үүрэг ногдуулдаггүй, харин арьс үс, эвэр туурай, доньт болон элдэв дотор эрхтэн бэлтгэн хатааж нийлүүлэх үүргийг ногдуулдаг. Энэ бүхэн Их хааны цэрэг армид хэрэглэх зэр зэвсэг хийх, худалдаж авахад зориулдаг билээ. Эзэн хаанд ан авд сургасан, гарын тэжээвэр цоохор ирвэс, шилүүс олон бий. Мөн түүнд олон арслан байх бөгөөд тэд Мисир нутгийнхаас ч биеэр том, сүрлэг амьтад төдийгүй хар, ягаан, цагаан урт урт зурвастай алаг эрээн арьстай. Эдгээр арсланг зэрлэг бодон, зэрлэг үхэр, баавгай, хулан, буга, гур агнаж намнахад сургаж дадлагажуулсан байдаг. Эдгээр сүрлэг арслангуудын ан ав хийхийг харах гэдэг үнэнхээр нэгэн гайхамшиг билээ. Арслангуудыг ав хоморгод авч явахдаа торонд суулгаж тэргэнд ачиж явах бөгөөд арслан болгоны торонд түүнтэй хамт жижигхэн нохой хамт авч явна. Тэдгээр зэрлэг догшин, хүчирхэг арслангууд нь ан авд гарч амьтан араатан хөөж агнах зөн совиндоо хөтлөгдөн тэсэж ядах тул бүгдийг бат бэх торонд суулган авч явна. Арслангуудыг авч явахдаа агнах авлах ангийнхаа салхин дороос

гэтэж хүргэнэ, эс тэгвээс арслангийн үнэр авсан амьтад аль хэдийн дүрвэж зугтан алга болно. Мөн үнэг, чоно, зээр, гөрөөс ангуучилж сургасан олон тооны бүргэдтэй, ялангуяа чонын авд сургасан бүргэд бол аварга том бие, асар урт дальтай хүчирхэг жигүүртэн байх бөгөөд тэдгээр бүргэдийн савраас амь хэлтрэх чоно нэгээхэн ч үгүй билээ.

Одоо би та бүхэнд Их хааны анч нохдын онцлог, тоо толгойн талаар тодруулан хэлье. Их хааны ноёдын дотор Баян, Минган гэгч төрсөн ах дүү хоёр бий. Тэд хуягч (kuuyukchi) хэмээх цолтой ба хааны нохой сургагчид юм. Ах дүү хоёрын захиргаанд тус бүр нэг түмэн албат ажиллах бөгөөд нэг түмэн нь нэгэн өнгө загвартай хувцас өмсөхөд нөгөөх нь өөр өнгийн хувцас хэрэглэлтэй байж хоорондоо хувцасныхаа өнгөөр ялгагдана. Энэ хоёр өнгөний нэг нь ухаа улаан, нөгөө нь хөх билээ. Их хаанд бараа болон дагалдаж ан авд гарах бүрийдээ тэр хоёр дээрх хоёр өнгийн хувцас өмсөцгөөнө. Тэдний түмэн албатын дотор нохой сургаж малладаг хоёр мянган хүн байх бөгөөд тэд тус бүр хоёр буюу түүнээс олон нохой дагуулах бөгөөд нийт нохойн тоо нь толгой эргэм олон болно. Их хаан энэ ах дүү хоёрыг дагуулан ав хоморгод мордоход тэдний нэг нь нэг мөр болон түмэн эр, таван мянган нохойтойгоо эгнэн, нөгөө нь нөгөө мөр болон мөн төдий тооны эрс нохойтойгоо эгнэн өргөөшөө бүтэн өдөрчийн газрыг хамран самнаж ан ав хийнэ. Ингэж ан араатнаа үргээж агнахад зугтаж дүүлэн амь гарах араатан жигүүртэн үл үзэгдэх бөгөөд харин үхэдхийн унаж буй ан араатан, ав шувуу архиран дайрах ноход, шунган шуугих бүргэд л хараа хүрэх газрыг эзлэн ноёрхоно.

Хөндий талын хоёр талаас бүслэн нөмөрсөн анчид үргэн давхилдах баавгай, буга болон бусад ан араатан руу улайран тэмүүлэх анч нохдоо тавьж, шонхор шувуугаа гар дээрээ суулгасан Их хаан ноёд, баатруудынхаа манлайд довголгон яваа дүр зургийг та бүхэн сэтгэл оюундаа зурж дүрслээд хар даа үнэхээр агуу гайхамшиг мөн байгаа биз<sup>144</sup>. Баян, Минган ах дүү хоёр аравдугаар сараас гуравдугаар сарыг дуусталх хугацаанд өдөр болгон Их хааны ордонд ятуунаас бусад шувуу, загас оролцуулан мянган толгой ан араатан тушааж байх үүрэг хүлээсэн буй. Гурван эр хүн цадахуйц хоол хийхэд хүрэлцэх загасыг нэг толгой анд тооцож авдаг байна.

Их хаан дүн өвлийн гурван сарыг хотод сууж өвөлжөөд хаврын урь унамагц буюу гуравдугаар сард өмнө зүг далайн эрэг рүү хоёр өдөрчийн газар явж хүрнэ. Ингэж явахдаа нэг түмэн шонхор сургагч-анчдаа бүгдийг бараа болгон дагуулж, тэдний ан авд сургасан цагаан шонхор, саарал шонхор, начин-шонхроо авч явахаас гадна далайн эргийн зурвас дагуу болон голын сав дагуу нүүдлийн шувууд агнах харцага шувуудыг оролцуулан бүгд таван мянган жигүүртэнтэй анчдын отог явна. Гэхдээ энэ бүх анчид болон ангууч жигүүртнийг нэгэн дор цуглуулан бөөгнөрүүлдэггүй, харин тэднийг зуу, хоёр зуугаар нь буюу түүнээс олон тоотой хэсэг бүлэг болгон тараан байршуулна. Тэдгээр хэсэг бүлэг бүр шувуу агнах ав хоморгоо эхлэн алсан шувуу, олсон олзоо хааны санд нийлүүлнэ. Их хаанд бараа болон дагалдсан түмэн анчид оролцсон их ав эхэлж харцага, шонхроо тавихийн өмнө тэднийг хос хосоор нь хувааж энд тэнд тархаан байрлуулах бөгөөд тэднийг toscaor гэх агаад манайхаар бол “харуул” гэсэн үг. Хос хосоор нь тараан байрлуулсан шонхорчид өргөн уудам талбайг эзлэн байршиж тархацгаасан байх. Шонхорч бүр шүгэл, жижиг ширэн дуулга барьсан байх бөгөөд тэд тэр шүглээрээ шонхор, харцагаа дуудан авчирч ширэн дуулга өмсүүлэн суулгадаг билээ. Их хаан харцага, шонхроо тавих тушаал өгмөгц бүх л шонхорчид шонхор, харцагаа нисгэчихээд хойноос нь явахгүй, зөвхөн нүд салгалгүй мөрдөн харах бөгөөд шонхорт нь ямар нэгэн юм

учирвал үтэр түргэн очиж салган авахад бэлэн зэхий зогсоцгооно.

Их хааны болон бусад ноёд, язгууртан дээдсийн шонхоруудын хөлд эзний болон шонхорчийн нэрийг бичсэн жижиг мөнгөн гархи зүүгээстэй байдаг. Шонхор, харцагнууд эзэндээ буцаж ирэлгүй төөрчихвөл тэрхүү гархин дээрх нэрээр эзний нь олж өгдөг. Хэрвээ шувуудыг барьсан хүн эздийг нь танихгүй, олохгүй бол Буларгучи (Bularguchi) хэмээх ноёнд хүргэж өгөх бөгөөд энэ нэрийн утга нь “хаясан гээсэн эд хадгалагч” гэсэн үг болой. Хэрвээ хэн нэгэн хүн хулжиж цойлсон морь мал, хаяж гээсэн зэр зэвсэг, төөрч будилсан харцага шонхор зэргийг барьсан буюу олсон боловч эзний нь олж эргүүлэн өгч чадахгүй бол олсон эд, барьсан амьтнаа үтэр түргэн Буларгучи ноёнд хүргэж өгөх үүрэгтэй, эс тэгвээс олсон, барьсан хүнийг бусдын эд малыг хулгайлах гэж санаархсан буюу хулгайлсан гэж үзнэ. Буларгучи ноён нь хэн хүн олж очиход хялбар дэв, довцог зэрэг өндөр газар асар майхнаа босгож, туг хиураа хаанаас ч болов үзэгдэх өндөрт мандуулан хийсгэнэ. Юмаа хаясан, гээсэн хүн болгон Буларгучи ноёнд очиж хаясан гээсэн зүйлээ олж авах бөгөөд энэ нь хаана ч, хэзээч хаягдаж гээгдсэн эд юмс олдоно гэсэн үг. Их хааныг далайн эрэг рүү аялах замд нэгэн ёсондоо анч шонхор, харцага шувуудыг хэрхэн үржүүлж, сургадаг талаар үзүүлэх аян мэт зүйл болно. Үнэндээ үүнтэй эгнэж зэрэгцэх ав хоморго, анч шувуудын ид хавыг гайхуулсан тэмцээн өрсөлдөөн энэ ертөнцөд өөр хаана ч байхгүй гэдэгт эргэлзэх зүйлгүй билээ. Их хаан аяны цувааны сүүл даран дөрвөн заан хөлөглөн, дотор талыг нь алтан саа, хээ угалзтай цэмбээр доторлосон, гадна талыг нь арслангийн арьсаар бүрж хучсан үзэсгэлэнт сайхан модон өргөөнд залран аялна.

Их хаан энэ өргөөндөө шилдэг сайн арван хоёр цагаан шонхор авч явдгаас гадна хааны шадар хэдэн ноёд түүнд бараа болон дагалдаж явах бөлгөө. Ингэж аялаж явахад хааны бараа бологсод эзэн минь ээ тогоруун цуваа өнгөрч байна шүү гэхэд хаан өргөөнийхөө өрхийг цэлийтэл татуулаад шонхроо тогоруун цуваа руу тавина. Тэдгээр цагаан шонхорууд тогоруун цуваа руу шунган орж шүүрэн барихыг тооноороо харсан Их хаан сэтгэл хангалуун амран сууна. Энэ үед хааны өргөөг тойрон бараа бологч ноёд, баатрууд бужигнан хөөрөлдөнө. Энэ хорвоод аян, амралтаа Их хаан шиг эдлэн жаргадаг нэг ч хүн байхгүй гэдэгт би эргэлздэггүй.

Хаан эзэн аажуу тайван аялсаар Чачар мод (Cachar modun) хэмээх нутагт ирэхэд хааны орд өргөө, хөвгүүдийн асар орд, ноёд язгууртны суух байр, татвар эмсийн байр сууц гээд нэгэн түм гаруй хүмүүсийн суух гоё тансаг байр сууц бэлэн зэлэн хүлээж байна. Одоо би та бүхэнд аяны энэ өргөө ордыг юугаар барьж босгодгийг ярьж өгье. Юуны өмнө хааны зөвлөгөөн цуглаан хийдэг гол асар байх бөгөөд тэнд мянган баатар эрс элбэг багтах уужим зайтай. Урагшаа харсан үүдтэй энэ өргөө асарт хааны ноёд, сайд, язгууртан дээдэс байрлана. Үүний баруун талын асар өргөөнд Их хаан заларч алба ажлаа явуулна. Уулзах учрах, ярилцах хөөрөлдөх хүмүүсээ Их хаан энэ асарт дуудаж уулзана. Гол асрын ар талд Их хааны амарч унтах өргөө асар байрлана. Мөн гол асартай хаяа хатган босгосон өөр асрууд байх. Дээрх хоёр өргөө асрыг яаж тоноглон, хэрхэн барьсныг өгүүлсү. Асрыг уран гоё сийлбэртэй удган модон багануудаар дотор талаас нь тулж тэлэн босгоод хар-цагаан, ягаан зурвас хээтэй арслангийн арьсаар хучиж нөмөргөсөн байх. Эдгээр асар салхи шуурганд хөдлөхгүй, бороо цас нэвчихгүй бөх бат билээ. Эдгээр асрыг хамгийн үнэтэй, хамгийн торгомсог зөөлөн булга, үенгийн арьсаар өвч доторлосон нь гайхам тансаг болжээ. Сайн чанартай булганы арьс хоёр мянган бэзантин үнэ хүрдэг бол жирийн арьс нэг мянган бэзантин үнэ хүрнэ. Тартарууд булганы

арьсыг “үсний хаан” гэж нэрлэж хүндэлнэ. Булга бол суусрын хэртэй л амьтан. Мөн тэнд булга, суусар, үенгийн годоор зүйж хийсэн маш уран тансаг дэвсгэр дэвссэн нь нүд булаана. Хааны суух өргөөтэй зэрэгцүүлэн босгосон унталгын өргөөг нь арслангийн арьсаар хучиж, булга, үенгийн арьсаар доторлоогүй боловч үнэнхүү уран хийцтэй, тансаг заслагатай болжээ. Эдгээр асрыг уяж тогтоодог оосор нь торго томж хийсэн уяа байх юм. Ийм уран гоё хийц, тоноглолтой баян тансаг гурван асрыг бол бусад ямар ч улсын хаад эзэд эдэлж хэрэглэх юм гэж зүүдэнд ч орохгүй дээ.

Энэ гурван өргөө асрыг тойруулан бусад асар, цацрыг босгосон бөгөөд тэд бүгд дээд зэргийн уран хийцтэй цэвэр цэмцгэр. Татвар эмсийн асар мөн л их уран тансаг. Анч шонхор, харцага болон бусад нохой шувуудаа бүгдийг цацар, майханд байрлуулна. Аяны энэ хүрээ нь үнэнхээр түм түжигнэж, бум бужигнасан их хөлийн хот суурин газар мэт болжээ. Их хаан энэ газар суурьшин нутаглахаар зэхэж байгаа мэт сэтгэгдэлд хэн хүнгүй эзэмдэгдэн, хаа холын хот, тосгод, харь гүрнээс хүмүүс нүүн ирж суурьшин нутаглах ажээ. Энд Их хааны ордныхон тэр аяараа ирсэн төдийгүй хааны эмч домч, зурхайч төлөгч, шонхор сургагч –анчид болон ноёд, түшмэд гээд тоо томшгүй хүмүүс бөөгнөрөн цугларчээ.

Их хаан энэ нутагт хаврын дунд хүртэл буюу манайхны Мацгийн өдрүүд эхлэх хүртэл сууна. Ингэж суухдаа нэг ч өдөр алгасалгүй ав шувуу ангуучилж эндхийн далайн эрэг, гол горхийг нэгжин самнаж асар олон тогоруу, хун болон бусад жигүүртэн шувууд авлан хуримтлуулдаг билээ. Мөн түүний бараа бологсод ойр орчны гол, нуур цөөрмийг даган ав шувуу агнан, агнасан ан, олсон олзоо хааны санд нийлүүлнэ. Энд хаваржих өдөр хоногийг Их хаан ав шувуу эргүүлэн, биеийн алжаал ядаргаагаа тайлан амарч өнгөрөөх бөгөөд энэ дэлхий дээр өөр хаанах газрын, хаад ноёд ингэж ав шувуу агнан амарч, цэнгэж чаддагийг өөрийн нүдээр үзээгүй болохоор миний үгэнд итгэхгүй байх нь аргагүй. Их хааныг агуу их болгож буй ав хоморго, мөн түүний эзэнт гүрнийг ч агуу том улс гүрэн болгож байдгийг би үгээр хэлж, цаасан дээр буулгах гэхээр миний оюун санаа, үгийн ур цэцийг давж гарчихаад байна.

Би та нарт бас нэгэн зүйлийг сануулж өгүүлье. Их хаан буудаллан суурьшиж ав шувуу хоморголож буй газар нутгийн эргэн тойрон хорин өдөрчийн газар суух худалдаачид, гар урчууд, тариачид болон өөр бусад хэн боловч анч шонхор, харцага мөн нохой барьж байх хориотой, харин хорин өдөрчөөс цааших нутгийнхан ан авд явах, жигүүртэн шувууд авлах бол чөлөөтэй. Араатан, жигүүртэн зэрлэг амьтад үр төлөө тээж, төрүүлж өсгөдөг гуравдугаар сараас аравдугаар сарыг дуустал хаад, ноёд, язгууртан дээдэс, жанжин баатар, энгийн ард иргэд хэн боловч ан ав хийхийг Их хааны зарлигаар чандлан хорьсон байдаг бөгөөд үүнийг зөрчсөн хэн боловч маш хатуу шийтгэл, цээрлэл хүлээнэ. Урин хаврын сайхан цагийг ав шувуутай хөөцөлдөн авлаж агнаж өнгөрөөгөөд Манайхны Мацгийн өдөр эхлэх үеэр бүхий л бараа болон дагалдагсад, шонхор сургагч анчид, ордны албат зарц боол ер бүхий л хүмүүсээ дагуулан ирсэн замаасаа гажиж хазайлгүй мөн ав шувуутай хөөцөлдөн авлах намнахаа үргэлжлүүлсээр Хан-балик хотноо буцаж ирдэг билээ.

Хан-балик хотноо Их хааны мөнгө зоосны ордон байрлах бөгөөд энэ газар маш нягт нямбай зохион байгуулсан ажил үйлтэй газар билээ. Харин хаан эзэн өөрөө хувилхуйн ухааныг төгс төгөлдөр эзэмшсэн нэгэн гэмээр бодогддог учир нь цаасан мөнгийг юугаар, яаж, хэрхэн үйлдэх тухай тов тодорхой зааж чиглүүлсэн хааны зарлиг гарсан байдаг. Навчаар нь торгоны



хүр хорхой тэжээдэг ялмын модны холтосыг хуулж холтос модны гол хоёрын завсар байх нэгэн зүйлийг хуулан авч нунтаглаад цавуутай хольж элдэж хатаахад хүрэн бор өнгийн муутуу цаасархуу цаас болдог. Тэдгээр цаасаа гонзгойвгор тэгш өнцөгт хэлбэртэй, том жижиг янз бүрийн хэмжээгээр зүсэж хамгийн жижиг нь тал ливр, арай том нь нэг ливр гэх зэргээр Венецийн мөнгөөр бол тал мөнгөн зоос, нэг мөнгөн зоос гэх мэтчлэн тав, арван бутархай мөнгөн зоостой, томроод нэг, хоёр, тав, арван алтан бэзантинтай дүйж тэнцэхээр ханштай цаасан мөнгө үйлдэн Их хааны тамгаар тамгалж баталгаажуулдаг байв. Цаасан мөнгө үйлдвэрлэх, хэрэглэх дэг журам нь энгийн мөртлөө эгээл жинхэнэ мөнгө, алтаар зоос цуггахаас огт ялгаагүй нэр хүнд, ач холбогдолтой үйл болсон. Энэхүү цаасан мөнгөн дээр хэд хэдэн түшмэд нэрээ бичиж, гарынхаа хээг дарж үлдээдэг бөгөөд үүний дараа Их хааны итгэмжилсэн түшмэл хааны тамгыг зосдож мөнгө бүрийн дээд зах дээр тамгална. Ингээд цаасан мөнгө жинхэнэ мөнгө болж баталгаажна. Цаасан мөнгийг дуурайлган үйлдэхийг оролдсон хэн боловч онцгой хатуу ял цааз, хүнд торгууль хүлээдэг байв<sup>145</sup>.

Энэхүү цаасан мөнгөөр дэлхийн бүхий л үнэт эрдэнэсийг худалдаж авсан ч хүрэлцэхээр тийм их тоо, хэмжээтэй үйлдвэрлэжээ. Эзэнт гүрний нутаг, газар, муж, хот болон харьяат, хараат бүх орон даяар цаасан мөнгө гүйлгээнд оруулах Их хааны зарлиг гарч газар сайгүй цаасан мөнгө хэрэглэхийг хэвшүүлж, баримталж эхлэв. Их хааны зарлигийг зөрчвөл амиараа төлөх ял цаазтай тул хэн ч үүнийг эсрэглэн гажаах зүрх үгүй билээ. Эзэнт гүрний хүн ард цаасан мөнгө гүйлгээнд гарсан тэр цагаас эхлэн түүнийг дуртайяа хэрэглэж заншсан бөгөөд алт, мөнгө, үнэт чулуу, сувд эрдэнэ худалдаж авсан ч энэ цаасан мөнгөөр л төлбөр хийцгээнэ. Худалдаа арилжааны бүхий л төлбөр, тооцоог зөвхөн цаасан мөнгөөр хийдэг гэдгийг би та бүхэнд тодорхой ярьж өгүүлэв. Арван бэзантийн ханштай цаасан мөнгө нь нэг бэзантийн жингээс ч хөнгөн авсаархан билээ.

Жилдээ хэд хэдэн удаа харь орны худалдаачид, аянчид, жинчид алт, мөнгө, үнэт чулуу, сувд эрдэнэ болон бусад үнэт эрдэнэс, алтан саатай хоргой, торго тэргүүтнийг их хэмжээгээр зөөж тээж авчраад бүгдийг Их хааны эрдэнэсийн санд нийлүүлдэг билээ. Тэгмэгц Их хаан худалдаа наймааны үйлд нэвтэрхий мэргэжсэн арван хоёр мэргэн түшмэлээ дуудан цуглуулж авчирсан бараа таваар, үнэт эрдэнэс, багаж төхөөрөмжийн жинхэнэ бодит үнэ цэнийг ягштал тогтоон худалдаачдыг хохироож гомдоолгүй үнэ цэнийг нь төлөхийг даалгадаг билээ. Арван хоёр эрдэмт мэргэн түшмэд бүх зүйлийн үнэ ханшийг алдаа мадаггүй тогтоож төлбөр тооцоог дээр миний ярьсан цаасан мөнгөөр хийх бөгөөд харь орны худалдаачид тэр мөнгийг дуртай нь аргагүй хүлээн авдаг бөгөөд Эзэнт гүрний бүх нутаг, Их монгол гүрний харьяат, хараат орон улс бүхэнд<sup>146</sup>энэ цаасан мөнгөөр юу хүссэнээ худалдан авдаг тул хэн ч цаасан мөнгө авахаас цааргалдаггүй. Жилийн турш эзэнт гүрэнд авчирч борлуулсан багаж, тоног төхөөрөмжийн үнэ дөчин түмэн (400000) бэзантийгаас давах боловч тэр их мөнгийг цаасан мөнгөөр саадгүй бүрэн төлдөг билээ.

Би та нарт бас нэгэн зүйлийг сонирхуулан хэлье. Жилдээ хэд хэдэн удаа эзэнт гүрний нутаг газрыг хамарсан дараах утгатай зар, тушаал тараах, үүнд: Үнэт чулуу, сувд эрдэнэ, алт, мөнгөтэй хэн бүхэн түүнийгээ Их хааны эрдэнэсийн санд тушаагаарай гэх бөгөөд тушааж байгаа эрдэнэсийг үнэлэн оронд нь цаасан мөнгөөр төлбөр тооцоог хийж гүйцэлдүүлнэ. Ингэж Их хаан өөрийн эзэмшил эзэнт гүрний нутаг газар дээр байх алт, мөнгө, эрдэнийн чулуу, сувд эрдэнэсийг бараг оронгоор нь худалдан авч байгаа нь энэ билээ.

Бас нэгэн хаа сайгүй хэрэглүүштэй баримтыг иш татан өгүүлье. Цаасан мөнгө нь урт удаан хугацаанд эргэлт, гүйлгээнд байснаас болж элэгдэж хуучран, урагдаж сэмрэх нь олонтой, тийм мөнгөө эзэд нь хааны мөнгө зоосны ордонд авчран гурван хувийн урамшуулалтай, шинэ цаасан мөнгөөр сольж авдаг. Мөн өөр нэгэн хэрэглүүштэй үйлийн талаар номондоо дурьдан өгүүлбэл: Хэн нэгэн хүн бүс хийх буюу өөр бусад гоёл чимэглэлд хэрэглэх алт, мөнгө хэрэгтэй болвол хааны мөнгө зоосны ордонд ирж хэрэгцээнийхээ хэрээр цаасан мөнгөөр төлбөр хийж оронд нь алт эрдэнэс худалдан авдаг байна. Цэрэг армийнхаа цалин пүнлүүг ч энэхүү цаасан мөнгөөр талбин олгодог билээ.

Цаасан мөнгө хэрхэн яаж хийдэг, түүгээр худалдаа наймааны төлбөр, тооцоог нэгд нэгэнгүй хийж гүйцэлдүүлдэг талаар ярилаа. Яг үнэндээ бол энэ газар дэлхий дээр Их хаан шиг их алт эрдэнэс хурааж хуримтлуулсан нь үгүй билээ. Түүгээр ч үл барам хорвоогийн бүхий л хаадын алт эрдэнэсийг нийлүүлсэн ч Хубилай хааны алт эрдэнэсийн хаана ч хүрэхгүй гэдэгтэй маргах явдалгүй.

Одоо би та бүхэнд Хан-балик хотноо сууж эзэнт гүрний засаг, засаглалын эрх мэдлийг атган, бодлого шийдвэрээ хэрэгжүүлж байдаг дээдсийн тухай өгүүлье. Юуны өмнө Их хаан цэрэг армийн үйл ажиллагаа, хөдөлгөөн, шилжилтийг хянан зохицуулах, цэргийн дээд удирдлагын өөрчлөлт, томилолтыг зөв зүйтэй зохицуулах, байлдаж буй цэрэг дайчдыг нэгэн хэсгээс нөгөө рүү нь нүүлгэх, шилжүүлэх болон хэрэгцээ шаардлагатай газарт нэмэлт хүч илгээх зэрэг чухал чухал зүйлсийг шийдэх, хэрэгжүүлэх арван хоёр эрхэм дээд ноёд, түшмэдийг тохоон томилдог билээ.

Мөн эдгээр арван хоёр ноёны шийдэх ажлын хүрээнд эр зоригтой, дайчин эрсийг шагнаж урамшуулах, зэрэг дэв дэвшүүлэх болон мулгуу муу, хулчгар шантрамтгай хүмүүсийг зэрэг дэв бууруулах, шийтгэж баалах эрх үүрэг багтана. Жишээ нь: Мянгатын ноён дайны талбарт эрх үүргээ муу биелүүлсэн бол түүнийг зуутын дарга болгон тушаал бууруулдаг, харин тэр хүн дайны талбарт онцгой сайн тулалдаж, мянгатаа жинхэнэ жанжин ёсоор удирдсан бол түүнийг түмтийн ноёноор өргөмжилдөг. Гэхдээ зэрэг дэв дэвшүүлэх, бууруулах, шагнаж урамшуулах, шийтгэж баалах аль алиныг нь Их хаантай зохицон үйлддэг. Хэрвээ хэн нэгний зэрэг дэвийг бууруулахаар бол “тэр гэгч мянганы ноён албан үүргээ муу биелүүлсэн тул түүний зэрэг хэргэмийг бууруулан зуутын дарга болгохоор шийдэв” зөвшөөрнө үү гэх. Хэрвээ хэн нэгнийг дэвшүүлэх болвол “тэр гэдэг мянганы ноён тийм тийм гавьяа байгуулсан тул түүнийг түмтийн ноён болгон дэвшүүлэхээр шийдэв” зөвшөөрнө үү гэсэн айлтгалыг Их хаанд өргөн толилуулах бөгөөд хаан зарлиг тушаалаа гарган уг хүнд эдлэх эрхийг нь баталгаажуулсан гэрэгэ шагнаж, үнэ цэнэтэй шагнал урамшил олгон түүний эрдэм чадал, ухаан авьяасыг үнэлнэ.

Энэхүү арван хоёр ноёд түшмэдийн зөвлөлийг Тай (Thai) гэж нэрлэх бөгөөд “Дээд шүүх” гэсэн утгатай, учир нь эдгээр арван хоёр ноёд, түшмэдээс дээших эрх мэдлийг зөвхөн Их хаан эдэлнэ. Үүнээс гадна бас нэгэн арван хоёр эрхэмсэг ноёд, түшмэдийн зөвлөл буй бөгөөд Шиен (Shieng) гэх бөгөөд тэд эзэнт гүрний гучин дөрвөн мужийн хэрэг явдлыг шийтгэн захирна. Тэдний үйл ажлыг хэрхэн яаж зохион байгуулсан талаар өгүүлье. Юуны өмнө тэдгээр ноёд, түшмэд Хан-балик хотноо орших олон олон албан өрөө тасалгаатай, тэндээ амьдран суух орон байртай асар том, хээнцэр ордонд сууцгаадгийг хэлье. Муж бүрийн үйл

ажлыг хариуцан хянаж тохинуулдаг заргач-шүүгч болон хэд хэдэн албан хаагч байх бөгөөд тэд цөм энэ ордондоо амьдарцгаана.

Энэхүү заргач-шүүгч нь мужийн бүхий л үйл ажлыг дээрх арван хоёр эрхэм ноёд түшмэдийн хүсэл зориг, заавар зөвлөгөөнд нийцүүлэн зохицуулан тохинуулдаг. Мужийн амбан захирагчийг тохоон томилох эрх мэдэл нь дээрх арван хоёр ноёд, түшмэдийн шийдэх эрх мэдлийн хүрээнд багтана. Мужийн амбан захирагчаар тохоон томилох хүнийг сонгож олмогцоо Их хаанд танилцуулах бөгөөд хаан түүнийг батламжилсан зарлиг тушаал гарган, эрх мэдлийг нь баталгаажуулсан гэрэгэ гардуулна. Дээрх арван хоёр ноёд, түшмэд нь мужийн татвар, орлогын болон зарлага зардлын хэмжээг мужийн захиргаатай хамтран хянаж зохицуулна, тэд муж нутагт хамаарах бүхий л ажил үйлийг хянан зохицуулж тохинуулах эрх, үүрэгтэй бөгөөд тэдний ажлын хүрээний гадна зөвхөн цэрэг армид хамаатай асуудал үлдэнэ, ажил үйлээ явуулдаг болон амьдардаг ордныг мөн шиен гэнэ.

Тай болон Шиен нь нэг нь цэргийн хэрэг эрхэлсэн, нөгөө нь иргэний хэрэг эрхэлсэн “дээд шүүх” бөгөөд энэ хоёроос дээших эрх мэдлийг зөвхөн Их хаан л эдэлж хэрэгжүүлнэ. Энэ хоёроос цэргийн хэрэг эрхэлсэн Тай нь эрх мэдэл, нэр хүндээрээ арай илүү жинтэйд тооцогдоно.

Энэ удаа би муж нутгийг нэрлэн тоочиж цаг бармааргүй байгаа бөгөөд энэ тухай хойно тусгайлан өгүүлнэ. Одоо Их хааны өртөө, шуудан холбооны тухай өгүүлсү. Бүхий л муж нутгийг холбосон их замын төв зангилаа нь Хан-балик хот гэдгийг та юу эс андах билээ. Хан-баликаас муж бүрийг чиглэн гарах зам тэрхүү мужийнхаа нэрээр нэрлэгдэнэ.

Хааны өртөө-шуудан холбоо нь үнэнхүү гайхамшигтай зохион байгуулсан нэгдмэл нэгэн бүтэц билээ. Их хааны элч болон зарлага тахар эдгээр замын аль нэгнээр гараад хорь-хорин таван бээр замыг туулан аль нэгэн өртөөн дээр хүрч очих бөгөөд түүнийгээ тэдний хэлээр Ямба (Yamb) гэх бөгөөд энэ нь ямбалах, амрах гэсэн санаа агуулсан байдаг. Харин манай хэлээр бол “морин шуудан буюу морин өртөө” гэмээр. Өртөө болгон өөрийн гэсэн уужим саруул, маш тохилог дэн буудалтай. Эдгээр дэн буудалд торгон дэвсгэр, хөнжил, бүтээлэгтэй гоё дэгжин ор байх бөгөөд ямар ч өндөр зэрэг дэвтэй элч, тахар ирсэн хэний ч өмнө нүүр улайхааргүй тохижуулсан байдаг. Хэрвээ Их хаан ирсэн ч тав тухтай амрааж, хооллож ундлах боломжтой билээ. Эдгээр өртөө нь шууд эмээллээд мордох дөрвөн зуун хүлэг морь үргэлж бэлэн зэхий байж Их хааны үүрэг тушаал, захиа даалгаврыг саатал, доголдолгүй биелүүлж байдаг.

Эзэнт гүрний бүхий л гол зам гудас дагуу хоорондоо хорь-хорин таван бээр зайтай байрласан өртөө байх бөгөөд тэнд хэзээч эмээллэхэд бэлэн гурав, дөрвөн зуун хүлэг морьд бэлэн зэхээстэй байхаас гадна сайхан тохижуулсан тав тухтай дэн буудал таныг хүлээж байдаг гэдгийг та бүхэн минь ойлгож байгаа биз дээ. Энэ бол Их хааны эзэмшил гэсэн бүхий л газар нутгийг хамран тархсан өртөө-шуудангийн албан билээ.

Хүн амьтан оршин суудаггүй зэрлэг зэлүүд хээр тал, говь цөлд ч дээр миний бичиж дурьдсан өртөөний албан яг л тийм хангамжтай, морьдтой байх бөгөөд харин хоорондох зай нь гуч-гучин таван бээр заримдаа дөчин бээр хүрдэг<sup>147</sup>. Их хааны элч, тахар хэн боловч эзэнт гүрний газар нутаг болон хараат улс орны нутаг дэвсгэрээр аялан довтолгохдоо хаана л бол

хаана унах унаа, орогнох сууц, идээ ундаа хэзээд бэлэн хүлээж байдаг гэдэгт огтхон ч эргэлзэх хэрэггүй билээ. Энэ бол тэр улс орны хүмүүсийн хүртэж эдлэх онцгой эрх дарх, дундрашгүй нөөц бололцоо бөгөөд хэзээч урьд өмнө нь газар дэлхий дээрх улсын эзэд, хаад, иргэд ард ийм өртөө, шуудан холбоотой байсангүй. Өртөөний энэ албыг хашиж, залгуулахад хорин түмэн (200000) морьд, нэг түмэн хүн үргэлж оролцож байдаг билээ. Энэхүү өртөө шуудангийн албан хэр нүсэр хэмжээтэй, хэдий хир зардал мөнгө хэрэгтэй байдгийг хэлэх гэхэд хэл эвлэрэхгүй, бичих гэхэд цаас хүрэмгүй санагдана.

Их хаан энэ их үйлийг хийж гүйцэлдүүлэхэд ямар олон хүн хэрэгтэй байх бол? Тэр олон хүнийг юугаар, яаж хооллож тэжээдэг бол? Тэдгээр хүмүүсийн амжиргааны эх булаг нь юу байдаг бол? гэж хэн хүнгүй гайхан бодлогошрох нь аргагүй - эдгээр асуултын хариу болгож би ингэж хэлнэ. Онгод шүтлэгтэн болон сарацинууд зургаа, найм зарим нь арван эхнэр авдаг, ер тэд нар хэдэн эхнэр тэжээж, хувцаслаж чадах чадал тэнхээ, хөрөнгө зоорьтой байнав төдий тооны эхнэр авч тоо, томшгүй олон хүүхэд төрүүлдэг. Тэр олон хүүхдүүд дотор эр хүйстэй хүүхэд мөн олон байх бөгөөд тэд өсөж өндийнгүүтээ л эцгийнхээ захиргаан дор нэгдэн нэгэн овог үүсгэдэг. Биднийг хар л даа бид ганц эхнэр аваад тэр маань хүүхэд төрүүлэхгүй бол насан туршдаа гон бие гозон толгой явсаар ертөнцийг элээдэг билээ. Ийм учраас манай хүн ам өсөж олширдоггүй буюу. Тэдний амьдралыг тэтгэн тэжээдэг хүнсээр дутаж гуцах гэж байдаггүй, тэд голдуу тутарга, хар болон шар амуу будаа их хэмжээгээр тарьж ургуулна. Ялангуяа Тартар, Кэтай, Манзи хүмүүс дээрх гурван төрлийн будааг хавар тариалаад намар хурааж авахад хэмжээ нь зуу дахин өссөн их ургац хураадаг. Тэр нутгийн хүн ард нь дээрх будаа тариагаар талх хийдэггүй, харин будаагаа сүүтэй, мах шөлтэй чанаж иддэг. Энэ газар улаан буудай их тарьдаггүй бөгөөд улаан буудай ч бусад будаа шиг арвин их ургац өгдөггүй. Улаан буудайгаар гурил хийж мянтууз, гоймон болгох бөгөөд гамбир, мантуу болгон иддэг. Энд эрүүл сул газар үлдээж атаршуулдаггүй, заавал тариа ногоо тарьсан байдаг. Тэр нутагт гэрийн тэжээмэл амьтан, мал, гахай шувуу маш хурдан үржиж үр төлөөрөө өснө. Цэргийн албан хаахаар ирж байгаа нэгэн гэхэд л унах эдлэх зургаа, найман морьтой ирэх бөгөөд зарим нь түүнээс ч олон морьдтой ирэх нь бий. Үүнээс үзвэл тэр нутагт яагаад ийм олон хүнтэй байдаг хүмүүсийн хүнс тэжээлийн эх үүсвэр элбэг дэлбэг байдгийн учир холбогдол аяндаа ойлгогдоно.

Одоо би та бүхэнд мартаж орхисон нэгэн чухал зүйлийг эргэн сануулж ярья гэж бодож байна. Хоёр өртөөний хооронд бие биеэсээ гурван бээр зайтай дөчин жижиг гацаа буюу байшин байх бөгөөд тэнд Их хааны өртөө шууданд алба хашдаг явган зарлага байрлана. Тэдгээр явган зарлага нь эргэн тойрон хонх зүүсэн өргөн бүс бүслэцгээх бөгөөд тэднийг гүйж явахад хонхнууд нь жингэнэн дуугарч зарлага ирж явааг алсаас дохиолон мэдэгдэх ажгуу. Тэдгээр зарлага нь хоёр өртөөний хооронд хар хурдаараа гүйх бөгөөд өртөө хоорондын зай нь гурван бээрээс огт хэтэрдэггүй. Тэднийг гүйсээр дараагийн гацаанд ирэхэд цаашаа гүйх зарлага аль хэдийн бэлэн зэхий хүлээж байдаг. Нэгэн зарлага гүйж ирэхэд дараагийн зарлага түүнээс мэдээ, шуудан хүлээн авангуут арилж өгөх бөгөөд ийм маягаар зохион байгуулсан гүйдэг зарлагууд нь арван өдөрчийн газрыг ганц өдөрчийн зай болгон товчилдог байжээ. Эдгээр явган зарлага нь арван өдөрчийн зайг нэгэн өдөрт товчилдог тул зуун өдөрчийн газрыг арван хоногт туулна гэсэн үг. Жимс жимсгэнэ хураах үеэр Хан-балик хотод өглөө хураасан шинэ жимс тэр өдрийнхөө орой Шанду хот дахь хааны зоогийн ширээнд хүрсэн байх бөгөөд энэ хоёр хот хоорондоо арван өдөрчийн зайтай билээ. Өртөөний даамал буюу түшмэл гурав

гурван бээрийн зайтай орших өртөөнд гүйж ирж байгаа зарлага болон түүнээс шуудан хүлээж аваад явж байгаа зарлагуудын ирсэн, явсан өдөр, цагийг бүртгэж тэмдэглэдэг журамтай. Мөн сар бүр тусгай байцаагч эдгээр өртөөгөөр явж явган зарлагууд оногдсон үүргээ хэрхэн биелүүлж буйг шалган доголдол зөрчил гаргасан зарлагыг баалж шийтгэнэ. Явган зарлага болон өртөөний албатуудыг татвараас бүрэн чөлөөлөхөөс гадна ажил үйлээ саадгүй сайн хийхэд хэрэгтэй бүхнээр хангаж өгдөг билээ<sup>148</sup>.

Өртөө бүрд бэлэн байх морьдын тоо толгойг яаж бүрдүүлдэг тэдгээр адуун сүргийг яаж адуулж хариулдаг зэргийг Их хаан хэрхэн шийдэж зохицуулдгийг харцгаая. Их хаан эхлээд уг өртөөнд хамгийн ойр орших ямар хот суурин байдгийг тодруулж тогтооно. Мөн тэдгээр хот суурингууд хэд хичнээн тооны морьд гаргаж бэлтгэх боломжтойг судлана. Энэ маягаар нутгийн захиргааныхан ойр зэргэлдээх хот суурингууд хэд хичнээн морь эмээллэх чадал бололцоотойг тогтоон айл бүрт бүтэн хагас морь эмээллэх татвар ногдуулан түүнтэй тэнцэх хөрөнгө мөнгийг айл бүрээс гаргуулдаг байна. Өртөөн дээр сэлгэж эмээллэх дөрвөн зуун морьдыг нэгэн зэрэг байнга барьж байдаггүй бөгөөд нэг сард хоёр зуун морьдыг эмээллэхэд бэлэн байлгаж байхад нөгөө ээлжийн хоёр зуун морьдыг онгон соргог бэлчээрт адуулан тарга тэвээрэг авахуулж байдаг бөгөөд ингэж тасралтгүй сар сараар ээлжлэн морьдоо сэлгэнэ.

Хэрэв хоёр өртөөний хоорондох замд нуур ус, гол мөрөн байдаг бол тэнд дөрвөн ээлжийн завь, салыг заавал бэлэн байлгадаг. Мөн айл амьтан, хот суурин үгүй говь цөл, ус ундаагүй элчилгүй тал газарт элч тахарыг заавал улаач дагалдуулан илгээх бөгөөд ойр зэргэлдээх хот суурингууд орон байр, хоол ундаар хангах бөгөөд тийм хот суурингуудад Их хаан тусгай хангамж, дэмжлэг үзүүлдэг. Мөн өртөөний эмээллэх морьдын талыг Их хааны сүргээс хангана.

Эзэнт гүрний төр улсын байдал, бослого тэмцэл гарах, зарим хаад ноёд урван тэрсэлж дайн самуун дэгдээх зэрэг хойшлуулашгүй мэдээ, мэдээлэл байнга авч байх шаардлага гарвал Хааны элч, тахар хоногт хоёр зуун заримдаа хоёр зуун тавин бээр замыг туулдаг. Ийм яаралтай довтолгох буухиа элч бүхэн шонхорын дүрстэй гэрэгэтэй байх бөгөөд энэ нь яаралтай довтолгох буухиа элч гэсэн таних тэмдэг билээ. Ийм элч тахар хоёр өртөөний хооронд хөтөлгөө морьтой довтолгон морьныхоо давхиан дунд морио юүлдэг билээ. Буухиа элч, тахар нь өргөн бүсээр биеэ чанга ороож, нүд нүүрээ даавуугаар ороон таглаж давхина. Буухиа элч довтолгон ирж буйг бүрээ, дун үлээж алсаас мэдээлэх өгөөд өртөөн дээр эмээллэж зэхсэн морьд хүлээж байдаг билээ. Ирсэн элч, тахарууд эмээллэж зэхсэн моринд үсэрч мордонгуутаа хурд хуваан арилж өгнө. Ийм маягаар өртөө бүхнийг дайран өнгөрөхдөө зөвхөн морьдоо л юүлэн цаашаа зогсоо зайгүй довтолгон одно. Эдгээр морины гүйхээр дотолгох элч, тахарууд ургах нарнаас жаргах нарны хооронд давхин гэгээ тасартал хурдална. Онцгой шахамдуу яаралтай үед элч, тахарууд шөнө ч үл амран довтолгох бөгөөд шөнийн цагт довтолгох хурд саардаг боловч нэг хоногийн дотор элбэг гурван зуун бээр газрыг довтолгон туулна. Шөнө довтолгох элчийн өмнө бамбар асаасан улаач довтолгон замыг нь гэрэлтүүлэн давхисаар дараагийн өртөөнд хүргэж өгнө. Ганцхан хоногийн дотор энэ урт замыг морины нуруун дээрээс буулгүй, морьдын хар гүйх хурдаар, өлсөж ядрахыг үл хайхран довтолгох элч, тахаруудыг хэн бүхэн гүнээ хүндлэн, асар ихээр үнэлж цэгнэдэг билээ.

Одоо би та бүхэнд Их хааны өглөгч өгөөмөр зан төрх, албат харьяат ардынхаа амьдрал ахуйг

дээшлүүлэх, тэднийгээ баян чинээлэг амьдруулахын төлөө хэрхэн яаж санаа тавин сэтгэл, зүтгэл гаргадаг талаар өгүүлсү. Нэгэн баримтыг иш татан ярихад эзэнт гүрнийхээ өргөн уужим нутгийн өнцөг булан бүрт амьдрах түм түмэн тариачдынхаа будаа тариа хэрхэн ургаж буй, ган гачиг, үер ус, царцааны нүүдэл, хортон шавжид ургац нь нэрвэгдсэн эсэхийг шалган тогтоолгохоор хянагч, байцаагч нарыг байнга илгээн харьяат, хараат гэж ялгалгүй тариачин бүхэнтэй уулзаж учрахыг зарлиг болгон тушаана. Хэрэв хаа нэгэн газрын хэн нэгэн буюу хэсэг тариачид ургац авалгүй зовлон гачаалд нэрвэгдсэн бол тэднийг бүтэн жилийн татвар гувчуураас бүрэн чөлөөлдөг төдийгүй эзэн хааны сангаас тэр жилдээ идэж хүрэх тариа будаа нөхөн олгож ирэх жил тариалах үр хүртэл өгдөг байна. Энэ үнэнхээр эзэн хааны өглөгч өгөөмөр сэтгэлийн илрэл мөн буйза. Энэ бүхнийг Их хаан зун, намрын цагт хийнэ. Өвлийн цагт аль муж газрын малчид зуд зурханд нэрвэгдэх буюу малын элдэв халдварт өвчинд нэрвэгдэн малаа барж, хотоо харлуулсан эсэхийг дээрхийн нэгэн адил байцаан тогтоож тэгэж малгүй, хоолгүй хоцорсон ядуусыг мөн нэг жилийн татвар гувчуураас чөлөөлөөд зогсохгүй бусад муж, газраас хааны санд татварлан авдаг мал сүргээс өгч хоол хүнс залгуулахаар барахгүй малжиж хөлжих хишиг хүртээдэг билээ.

Заримдаа хорсон, хурсан мал сүрэг рүү аянга буугаад бүгдийг нь ниргэчих гай гамшиг тохиолддог тийм нөхцөлд тэдгээр мал сүрэг олон байсан эсэх, нэгэн эзний өмч байсан уу? хэсэг бүлэг хүмүүсийн өмч байсан уу гэдгээс үл хамааран тэдгээр хүмүүсийг гурван жилийн татвар гувчуураас чөлөөлнө. Хэн нэгнийг буюу хэн нэгний эд юмсыг тэнгэр ниргэх нь муу ёрын совин гэж ихээхэн сэжиг болгоомжтой ханддаг билээ. Мөн ялгаагүй бараа таваар ачсан хөлөг онгоц болон жингийн цувааг аянга ниргэчихвэл тэднийг мөн л татвар гувчуураас чөлөөлдөг бөгөөд тэр хүний эд юмс, бараа таваарыг тэнгэр ниргэж байгаа бол тэнгэр түүнийг таалахгүй байна гэж үзээд уг хүний үлдсэн бараа таваарыг хааны санд авах, оруулхыг тас хорьдог байна. Их хаан бүхий л гол замын хоёр талаар хоорондоо хоёр хоёр алд зайтай мод суулган тарьж ургуулах зарлиг буулгасан нь ач буянаа өгч хаанахын хэн боловч зам алдан төөрч будилахаас бүрэн сэргийлжээ. Элчилгүй их талын дундах зам гудаст ч ингэж мод суулгаж тарьсан нь худалдаачид наймаачид, аянчин жинчин хэн бүхний талархал ерөөлийг хүлээсэн буянтай үйл болжээ<sup>149</sup>. Мод тариад ургахгүй говь цөл, уул хадтай газрын зам гудас дагуу зам заасан шон мод босгох, овоо босгох зэргээр зам алдаж төөрөхгүй байх бүхий л зүйлийг хийжээ. Ингэж мод тарьж ургуулах нь Их хааны ердийн нэгэн хүсэл мөрөөдөл дээр “мод тарьсан хүн урт насална” гэсэн зурхайч төлөгчдийн мэргэ төлөг бас нэмэгдсэн нь гарцаагүй.

Катай нутгийн иргэдийн ихэнх нь дарс уух дуртай бөгөөд тэрхүү дарсыг хэрхэн хийдэг талаар би та нарт ярьж өгье. Тэр нутгийнхан дарсаа цагаан будаа исгэж нэрэх бөгөөд дараа нь сайхан үнэр амттай халуун ногоогоор амтална. Ийм дарс уухад таатай, согтоох нь хурдан.

Одоо би та бүхэнд шатдаг чулууны тухай өгүүлсү. Катай газар шатдаг хар өнгийн чулуу элбэг гэдэг нь маргашгүй үнэн баримт билээ. Энэ чулууг уулын хажуу налуугаас ухаж авна. Түлээ модыг бодвол удаан шатна. Хэрвээ та орой зуухандаа шатдаг чулуу хийгээд асаагаад орхисон бол өглөө босоход чинь унтраагүй асаж л байна<sup>150</sup>. Шатдаг чулуу нь мод түлээ мэт дүрэлзтэл асахгүй, харин модны нүүрс мэт уугин улалзаж асах бөгөөд маш их илч дулаан ялгаруулна. Хятадууд шатдаг чулууг хааяагүй газар сайгүй түлнэ. Тэр нутагт мод, түлээ элбэг гэдэг нь үнэн боловч оршин суугчид нь хязгааргүй олноос гадна айл болгон үргэлж галлаж халааж

байдаг халуун усны газартай, хүмүүс нь долоо хоногт дор хаяж гурван удаа халуун усанд ордог, өвөл бол өдөр болгон орно. Ийм нөхцөлд ямар ч их мод, түлээ байлаа гэхэд барагдалгүй тэсэхэд бэрх санагдана. Шатдаг чулуу тэнд хааяагүй газар сайгүй байхаас гадна маш хямдхан учир мөн ч их мод түлээг хэмнэдэг билээ. Тариа будааруу нэг эргэн орохгүй бол болохгүй нь байна. Тариа будааны ургац гарц сайн, үнэ ханш нь хямд төсөр байхад Их хаан улаан буудай, арвай, хар будаа, тутарга, шар будаа болон бусад төрлийн үр тариаг их хэмжээгээр худалдан авч хааны сангийн аварга том тарианы агуулахуудыг дүүргэн хадгалах бөгөөд ингэж хадгалсан тариа гурав, дөрвөн жил огт муудахгүй. Ингэж төрөл бүрийн тариа болон үрийн нөөцтэй болдог юм. Тариа будааны ургац муу, ган гачигтай жил эдгээр нөөцөлсөн тариагаа гаргаж хэрэглэнэ. Дамын худалдаачид нэг дүү тариаг нэг бэзантинаар борлуулж байвал хааны сангийн тариа будааг нэг бэзантийнд дөрвөн дүү өгөхөөр хямдруулдаг байна. Их хааны ивээл дор хийж байгаа үйл бүхэн эзэнт гүрний иргэн бүрт ээлтэй, өгөөж байгаасай гэсэн чин санаа агуулж байдгийн нэгэн жишээ энэ билээ.

Одоо би Их хаан Хан-балик хотын дордос ядуусыг хэрхэн тэтгэн тэжээж өглөг буяны хишиг хайрлан түгээж байдаг талаар өгүүлэе. Шулуун шударга үйлтэй, хүн олны өмнө нэр цэвэр, нүүр бардам амьдарч явсан зарим нэгэн хүмүүс амьдралын даваа нугачаанд хөл алдан бүдрэх буюу өвчин зовлонд ээрэгдэн нэрвэгдэж үгүйрэн хоосорч, үгээгүй ядуу болсныг Их хаан дуулж мэдмэгцээ тэдний амьдралыг янз бүрээр тэтгэн дэмжихийг албат, ноёддоо зарлиг болохын зэрэгцээ тэр айлын ам бүл зургаа, арав түүнээс олон байхаас үл хамааран нэгэн жилийн турш өмсөх хувцастай, идэх хоолтой байлгах тусламж дэмжлэг үзүүлдэг. Ийнхүү тэтгэлэг авах багламжтай айл өрхийхөн тэтгэлэг хариуцсан ноёд, түшмэдтэй уулзан тодорхойлуулаад хааны хангамжийн сангаас хувцас хунар, хүнс тэжээлийн зүйлсээ авна. Эзэнт гүрний нутаг, харьяат, хараат орнуудад бэлтгэдэг ноос ноолуур, торгон утас, таримал олс зэрэг даавуу нэхэх түүхий эдийн аравны нэг хувь нь хааны санд хуримтлагдаж байдаг. Гар урчууд, жижиг үйлдвэрлэгчид хэн боловч долоо хоногийн нэг өдөр Их хааны нэхмэлийн үйлдвэрт ажиллацгаах бөгөөд тэр үед нэхсэн даавууг хоосон ядуу хүмүүсийн өвөл, зуны хувцас хийхэд зориулан тараана. Мөн тийм нэхмэл сулжмэл нь цэрэг армийн хувцас хунар хийхэд зориулагдана.

Тартарууд онго шүтлэгтэн болохоосоо өмнө тэдний эртний уламжлал заншлаараа гуйлга гуйсан хүнд өглөг өгдөггүй байжээ. Үнэнхээр гуйлгачин юм гуйж ирвэл “Хараал идсэн чамайг бурхан таалахгүй учраас гуйлга гуйж яваа тул үтэр түргэн зайл” гэж хөөж туудаг байжээ. Харин онгон шүтэх болсноос хойш бурханы сургаал номлолыг даган ядуу дордосыг энэрэн тэтгэж өглөг буянаа хайрлаж байхын гүн утга агуулгыг ойлгон шүтэх болсон бөгөөд бурханы шашны багш нар ч Их хааныг сургаал номлолдоо шүтэн биширтэл чамгүй зүтгэж цөхрөлтгүй ном айлджээ. Их хаанаас өглөг буян гуйсан хэн боловч гар хоосон буцдаггүй билээ. Ядуу дордосыг хооллоход зориулан өдөр бүр хоёр, гурван түмэн шанага тутарга, шар будаа, хар будааг ядуучуудад тараан түгээх бөгөөд энэхүү өглөг буяны үйл жилийн турш тасралтгүй явна. Их хааны энэхүү гайхан бишрэм өглөгч өгөөмөр зан төрх, өр нимгэн өрөвдөх сэтгэлийг эзэнт гүрний ядуу хоосон төдийгүй бүхий л албат иргэд нь дээдлэн биширч Их хаанаа бурхан мэт хүндлэн дээдэлнэ<sup>151</sup>.

Хан-балик хотноо ойролцоогоор таван мянга илүү Загалмайн шашинтан, Сарацин болон Хятад үндэстэн зурхайч, төлөгчид амьдарцгаах бөгөөд тэд өөрийн гэсэн эд хөрөнгө эдлэн

газаргүй бараг л “гахай явган, нохой нүцгэн” хүмүүс байх Их хаан тэднийг үргэлж хооллож, хувцаслана. Тэд нар өөр өөрсдийн хэлээр туурвисан од гарагийн хөдөлгөөн тохиолыг цаг, минутаар тооцон тодорхойлсон судар номтой. Жилийн жилд эдгээр зурхайч, төлөгчид өөр өөрийнхөө хэл, ёс заншлын дагуу сарны тооллын хуанлийн зохиож гаргана. Тэрхүү хуанлийдаа: аль сард, хаана ямар үйл явдал болох, дайн самуун дэгдэх, бороо хур орж үер усанд автах, ган гачиг нүүрлэж газар дэлхий хатах, өвчин тахал дэлгэрч хүн, мал үхэж үрэгдэх, зуд турхан нүүрлэх, газар хөдлөх гээд ер тохиолдож болох байгаль, цаг уур, нийгмийн үйлийг ч өдөр, сар, цаг, минутаар тооцон тодорхойлно. Ингэж сар сараар нь тооцож гаргасан үйл явдлын явцад зөвхөн Бурхан л нөлөөлөн эрч хүчийг нь сулруулах, нэмэгдүүлэх, гамшиг хөнөөлийг тойруулах, дайруулахыг шийдэж мэднэ гэж тайлбарладаг билээ. Тэд мөн такуим (tacuim) хэмээх жижиг товхимол гаргаж түүнийгээ борлуулах бөгөөд түүнийг худалдаж авсан хүмүүс сар сард юу болохыг урьдчилан мэдэж байх учиртай билээ. Энэхүү зурхайч, төлөгчдийн мэргэ, тооцоо аль хэр таарч байгаагаар тэдний билиг оюуныг үнэлэн өргөмжилдөг.

Хэн нэгэн хүн чухал ажил үйл бүтээхээр хөөцөлдөх, алс хол газар худалдаа наймааны ажлаар буюу аян жинд гарахынхаа өмнө зурхайч, төлөгчдөөр ажил үйл нь хэр бүтэмжтэй байхыг баримжаалан мэдэхийн үүднээс мэргэлүүлдэг. Зурхайч, төлөгчид уг хүнээс төрсөн он, сар, өдөр, цаг, минутыг тов тодорхой хэлээрэй гэх бөгөөд энэ нь хүний хувь заяа, ажил үйл нь төрсөн өдрийн төөрөг, од гарагийн тохиолтой нягт уялддаг гэж үздэг учраас ингэж нарийн асууж тодруулна. Эцэг, эх нь ч хүүхдийнхээ төрсөн цаг мөчийг аль болохоор яг таг тогтоохыг хичээн тэмдэглэж, бүртгэж авдаг зуршилтай. Тэд жилийг арванхоёр амьтнаар төлөөлүүлэн нэрлэж тойргоор давтан тоолно. Жишээлбэл: эхний жил нь арслан, дараагийнх нь үхэр, гуравдахь жил нь луу, дөрөвдэх нь нохой гэх мэтчлэн арванхоёр дахь жилийг хүртэл үргэлжлээд л эргээд арслан жилээр дараагийн арванхоёр жил эхэлдэг. Тийм болохоор хүмүүс нь: “Би тийм жилийн тийм сарын тэдний өдрийн тэдэн цагт тийм сартай байхад төрсөн” гэж өчინө. Үүний дагуу зурхайч, төлөгчид уг хүний төрсөн өдрийн төөрөг, од, гарагийг тооцон олж уг хүний цаашдын зам мөр хэрхэн явах талаар тодорхой хариу хэлнэ. Жишээлбэл: Худалдаа наймааны ажил ямар ямар од, гарагтай өдөр олз омог ихтэй байх, ямар үед тааруухан байх, аль замаар хаашаа чиглэн зам мөрөө гаргавал ажил үйлс нь бүтэмжтэй байх, аль зүг рүү явж болохгүй гэх буюу хэдний өдөр, хаана дээрэмчин тонуулчтай учирч болзошгүй, хэдийд морь мал нь гэмтэж эндэх вэ? гэх мэтчлэн хэлж анхааруулдаг байна. Ингэж зурхайч, төлөгчид хүмүүсийн ажил амьдралд тохиох сайн сайхан болон муу муухай зүйлсийг мэргэлэн хэлдэг од, гарагийн тохиол ээлтэй сайн байх, эсвэл сөрөг муу нөлөөтэй байхыг урьдчилан хэлж анхааруулдаг байна.

Катай нутгийн оршин суугч-тартарууд бүгд онгон шүтлэгтэн билээ. Хүн бүрийн гэр оронд хоймор талд нь залаастай буюу ханын толгойд өлгөөстэй онгон сахиус байдаг бөгөөд түүнийгээ Мөнх тэнгэрийн бурхан гэх бөгөөд тийм онгон сахиусны дүрсгүй айлд бол бурханы нэрийг нь бичсэн онгон байх. Тэд өдөр болгон онгондоо зул өргөж, хүж уугиулан гараа тэнгэр өөд өргөн гурвантаа залбиран мөргөнө. Ийнхүү залбирал мөргөл үйлдэхдээ онгон сахиус бурхан тэнгэрээс зөвхөн саруул ухаан, эрүүл энхийг л хүсэж гуйхаас өөр юу ч эс хүснэ. Эдгээр онгон сахиусны чанх дор газар юм уу ханын шийрэнд өөр нэгэн онгоны дүрс байх бөгөөд түүнийг начигай гэх энэ бол газар дэлхий, лус савдгийн онгон сахиус билээ. Энэ онгон сахиусанд айл гэрийн эзэгтэй, хүүхэд багачуул мөргөн залбирах агаад түүнээс тэнгэр



хангайг ээлтэй байх, арвин их ургац өгөх, мал сүргээ өсөж үржихийг л гуйдаг билээ.

Тартарууд өөрсдийн төрх байдлаараа, мэдлэг оюунаараа бусад үндэстэн ястнаас давуутай байдгийн учир нь тэд хорвоо ертөнцийг танин мэдэх, эрдэм ном сурахад ихээхэн цаг нар зарцуулж өөрсдийгөө шахан дайчилдагт байдаг болов уу. Тэд хоорондоо аядуу тайван ярилцана, бие биеэ мэндэлж хүндлэх ёс нь намбатай эвлэг, үргэлжид инээмсэглэл тодорсон гэгээлэг царайтай сэтгэл татам хүмүүс билээ. Тэд оршин буй энэ цагтаа нэгэн биеийнхээ жаргал цэнгэл, сайн сайхныг эрхэм болгохоос биш хойт нас, сүнснийхээ тухай санаа тавин сэтгэл алдрах нь үгүй. Хүн энэ ертөнцөөс халин одмогц сүнс нь өөр биед шилжин оршиж мөнх амьдардаг бөгөөд сүнс бол үхэлгүй мөнхийн хутаг оршсон зүйл гэж үзнэ. Хүн энэ насандаа буянтай үйл үйлдэж, бусдын төлөө санаа тавин амьдарсан бол сүнс нь сайн төрөлд хувиран улам сайжран сайжирсаар бурханы хутгийг олдог, харин энэ насандаа муу муухай үйл үйлдсэн бол муугаас муухай руу доошилсоор шулам бэрд болж хувирдаг гэсэн бурханы сургаалыг мөрдөн амьдарна.

Эгэл жирийн иргэн энэ насныхаа амьдралд бүтээж босгосон сайн үйлийнхээ шанд дахин төрөхдөө язгууртан болох бөгөөд ахин дахин төрсөөр ноён, хаан болсоор эцсийн эцэст бурханы хутгийг олно. Энэ насандаа өндөр дээд язгууртан байвч муу муухай үйл хийсээр дахин төрөхдөө ядуу тариачны гэрт мэндлэн амьдрал ахуй нь доошлон доошилсоор дахин төрөхдөө адгуус амьтан болно гэх мэтчлэн уруудсаар уруудсаар эцэстээ бэрд шулам болон төрдөг.

Эцэг, эхээ дээдлэн хүндлэх нь монгол ёсны хамгийн эрхэм дээд буянтай үйл гэж үзнэ. Төрүүлсэн үр хүүхдүүд нь эцэг эхийгээ ядарч доройтох, өвдөж зовохын цагт асран харж, өргөн тэтгэх үүрэгтэй бөгөөд үүнийгээ хэлбэрэлт үгүй хэрэгжүүлэх ёстой. Эцэг, эхийгээ ядарсан цагт харж үзэхээс төвөгшөөсөн, зайласхийсэн хүүхдүүдийг нь тусгай нэгэн газарт авчирч залхаан цээрлүүлж, торгууль, шийтгэл оноодог. Энэ газар эцэг эхээ асран тэтгэхээс зайласхийсэн үр хүүхдүүдийг нь залхаан шийтгэхээс өөр ажил эрхлэдэггүй.

Элдэв төрлийн гэмт хэрэгт орооцолдсон гэмт хэрэгтнүүдийг барьж шоронд хорих бөгөөд гурван жил тутамд шоронд хоригдож буй ялтан, гэмтнийг Их хааны зарлигаар өршөөн суллаж тавьдаг, шоронгоос суллахын өмнө тэдгээр ялтангуудын аль нэгэн хацар дээр “гэмт хэрэг хийж явсан”-ы тэмдэг<sup>152</sup> болгон улайдмал төмөр тамгаар тамгалж гаргана.

Их хаан бүх төрлийн мөрийтэй тоглоом тоглох, илбэ шидийн хүчээр хэн нэгнийг хуурч залилан мэхлэх гэх мэт энэ нутагт бусад газраас илүү хор нөлөөтэй тархан дэлгэрсэн муу муухай зуршлийг чандлан хориглосон зарлиг буулгажээ. Их хаан: “Би та бүхнийг газар нутаг, эд баялагтай чинь хамт ирт мэсийн хүчээр дайлан дарж, байлдан эзэлсэн билээ. Та бүхний мөрийд тавин алдаж байгаа мөнгө төгрөг, эд юмс чинь бүгд миний юм” гэж хэлэх бүрэн эрхтэй боловч энэ тухай ганц ч үг өгүүлбэр дурьдан дурсаж дээрх хоригийн шалтаг шалтгаан болгоогүй билээ.

Их хааны ордныхон болон ойр тойрны оршин суугчид хэрхэн яаж ханддаг талаар ганц хоёр үг хэлье. Их хааны эргэн тойронд хагас бээрийн зайтай оршин суугчид болон хөлхөлдөн зорчигсод хааныг явж өнгөрөх бүрийд номхон хүлцэнгүй, айван тайван хүндэтгэн ёсолж өнгөрөөнө, элдэв дуу чимээ гаргаж, хашгирч хөөрөн дуугаа өндөрсгөдөггүй. Ордонд орж

ирсэн ноёд, язгууртан хэн боловч тус тусдаа дэгжин хэв хийцтэй, тагтай бумба, бойпор мэт савтай явцгааж түүндээ шүлсээ хаяна. Хэн боловч шал руу нулимах, хог хаях хориотой. Хурал чуулган, цуглаанд ирж буй ноёд, түшмэд цөм танхимд орохын өмнө цагаан арьсан углааш өмсдөг учир нь ордны өрөө, танхимуудад дэвссэн алтан саа хатгамалтай, төрөл бүрийн гоё хээ хуартай хивс дэвсгэрийг бохирдуулахаас цээрлэн тийн гутлаа сольж углааш өмсөн гутлаа дагалдан яваа зарц, боолууддаа өгнө.

## Дөрөвдүгээр бүлэг

### Бээжингээс Бенгал орох замд



Одоо би Хан-балик (Khan-balik) хотоос гарч Катай орныг туулан аялах замд тааралдах энэ орны тансаг сайхан газар нутаг, үнэт эд эрдэнэсийн талаар ярьж өгсү.

Их хаан Хубилай эрхэмсэг Марког баруун зүг элчээр илгээжээ. Марко энэ ажлаар Хан-балик хотоос хөдөлж дөрвөн сарын турш аялан явжээ. Тийнхүү аялан очих, ирэх зам зуураа үзэж харсан бүхнээ ярина.

Хотоос гараад арван бээр орчим алслахад, ачаа бараа тээсэн олон олон худалдаачид урсаж Далайд хүрэх их устай, нэгэн том гол таарсан агаад тэр голыг Пулисангин (Pulisanghin) хэмээх аж. Тэр гол дээгүүр гарах гайхам сайхан чулуун гүүр бий. Энэ ертөнцөд түүн шиг сайхан гүүр өөр байхгүй биз ээ. Энэ гүүрийн урт нь гурван зуун алд, өргөн нь найман алд бөгөөд арван морьтон өлхөн зэрэгцэн явна. Гүүрийн хорин дөрвөн нуман гулдмайг хорин дөрвөн баганаар тулж бүгдийг саарал өнгийн гантиг чулуугаар урлан маш бат бөх хийжээ. Гүүр өөд өгсөх зам бага зэрэг нарийсаж ирснээ гүүрэн дээр гарангуут гүүрийн зорчих нурууны хэмжээгээр өргөсөн тэлнэ. Гүүрийн хоёр талын хашлагыг хоорондоо бүтэн хагас

алд зайтай, гантиг яст мэлхийн нуруун дээр суурилуулан тогтоож, гантиг арслангаар түшүүлэн тулж, орой дээр нь маш уран гоё хийцтэй арслангийн баримал дүрстэй баганануудыг зэрэгцүүлэн босгож баганын хоорондох зайг уран гоё хээ угалз сийлсэн гантиг хавтангаар холбож бэхэлсэн нь үнэнхүү гайхамшигтай уран тансаг болжээ. Гүүрнээс уруудах зам нь мөн гүүр өөд өгсөх замтайгаа адилхан хэмжээтэй байх юм.

Гүүрээр гараад баруун зүгийг зорин гучин бээр газар аялах зам гудаст тохилог сайхан дэн буудал, буурчийн газар олноороо дайралдах бөгөөд замын хажуугаар усан үзмийн тариалан, бусад тариан талбай ээлжилсээр Чочау (Cho-chau) хэмээх нэгэн том, сайхан хотод хүрч ирнэ. Энд онго шүтлэгтний сүм хийд олон байх юм. Энэ хотынхон худалдаа, үйлдвэрлэл эрхлэх бөгөөд энд торго, торгомсог даавуу нэхэн үйлдвэрлэхээс гадна дэн буудал, аялагчид зорчигсодод зориулан гоёмсог алтан углааш шаахай хийх юм.

Хотоос гараад нэг бээр орчим яваад зам хоёр салаалах агаад баруун зүгт үргэлжлэх салаа нь Катай орныг нэвт шувт туулах бөгөөд зүүн өмнө зүг рүү чиглэх салаа нь Манзи (Manzi) хэмээх том муж орно. Баруун зүг чиглэх зам арван өдөрчийн газар үргэлжлэн Катай орныг нэвглэн Тайюаньфу (Tai-yuan-fu) хүрнэ. Энэ замын дагуу үйлдвэр, гар урлал ихээхэн цэцэглэн хөгжсөн хот балгад, цайз хэрэм олонтой, сайхан арчилж тордсон тариан талбай, усан үзмийн тариалан хааяагүй үргэлжлэн тааралдана<sup>153</sup>. Энд өөр үзэж хараад байх сонин содон зүйл үгүй боловч хот балгад олон, зам гудсын аянчин жинчний хөл хөдөлгөөн, бараа таваарын урсгал тасардаггүй тул хүмүүс нь их иргэншиж, нийгэмшсэн байдаг. Энэ замаар таван хоног аялсны эцэст эндхийн бусад хот балгадаас том, тохилог Ак-балик (Ak-balik) хэмээх хотод хүрч очно. Энэ газар бол Их хааны ан ав хийдэг тусгай газрын хилийн зааг бөгөөд энд Их хаан түүний гэр бүлийнхэн мөн шонхорчдын ноёны зөвшөөрөл, бүртгэлтэй хүмүүсээс өөр хэн ч ан ав хийдэггүй. Энэ газрын хилийн заагийн гадна язгууртнууд ан ав хийхийг хориглодоггүй. Гэвч ан ав хийх энэхүү тусгай газар Их хаан бараг ирдэггүй учраас эндхийн ан араатан тоо томшгүй ихээр өсөж үржсэн төдийгүй ялангуяа туулай маш их өсөж элбэгшин энэ нутгийн тариа будааг идэж цөлмөх аюул нүүрлээд байв. Энэ тухай Их хааны сонорт айлтгал өргөн сонордуулмагц Их хаан ордныхоо ноёд, түшмэд шадар бараа бологсодын хамт бүгдээрээ хүрэлцэн ирж их ав хоморго хийжээ.

Арван өдөрчийн аяны замыг туулсны эцэст Тайюаньфугийн ханлигт хүрэлцэн ирнэ. Тайюаньфу үзэсгэлэнтэй сайхан, том хот төдийгүй худалдаа, үйлдвэрлэл төвлөрч Эзэн хааны цэрэг армид хэрэгцээтэй зэр зэвсэг, бусад эд хэрэгслийг их хэмжээгээр нийлүүлнэ. Энд сайн чанарын усан үзэм маш их тариалдаг бөгөөд түүгээрээ усан үзмийн дарс нэрж бүх муж, нутагтаа тараан нийлүүлнэ. Мөн торго их хэмжээгээр үйлдвэрлэдэг учир нь энд ялмын мод арвин ургаж, торгоны хүр хорхой ихээр үржүүлнэ.

Тайюаньфугээс баруун зүгт долоон өдөрчийн газар аялахад газар орны байдал нь сэтгэлд таатай, хот тосгод нь цэцэглэн дэлгэрч, зам харгуй нь ачаа бараа, аянчин жинчиндээ хахаж ядан хотолзох мэт хааяагүй худаалдаа наймаа дэлгэрсэн Пинянфу (Ping-yang-fu) хэмээх том бөгөөд баян тансаг үйлдвэрийн хотод хүрнэ. Энэ хотод торго маш ихээр үйлдвэрлэнэ. Пинянфугаас гарч баруун зүг хоёр хоног аялсны дараа Кайчу (Caichu) хэмээх эртний нэгэн цайз тааралдах агаад энэ цайзыг эрт дээр үед энэ газар орныг захирч байсан Алтан хаан хэмээх хаан бариулжээ. Энэ цайз дотор нэгэн сайхан харш байх бөгөөд тэр харшид энэ орны

эртний хаадын хөргөөр чимсэн их танхимтай. Энэ орныг захиран тохинуулж байсан эрт цагийн хаадаас эдгээр хөрөг л үлджээ.

Алтан хаан бол баян чинээлэг, хүчирхэг эзэн байжээ. Түүнийг орд өргөөндөө заларч байх үед хааны ордноор дүүрэн байх залуу охид бүсгүйчүүд хаанд үйлчлэх алба ажлыг чин шударгаар гүйцэлдүүлэх бөгөөд учир нь тэнд нэгээхэн ч эр хүн үгүй билээ. Ордны эргэн тойрны хэрэм хашаанд зугаалахад нь түүнийг хөнгөн жуузанд залан хялбархан зөөж тээж явцгаадаг байв. Тэдгээр охид бүсгүйчүүд түүнийг аль болох тохь тухтай, сэтгэл хангалуун амраах арга боломжийг сүвэгчлэн зүтгэцгээнэ. Алтан хаан ч өөрийнхөө захирах, засаглах үйлийг ивээл энэрэлтэй, шулуун шударга, ёстой л хааны ёсоор хэрэгжүүлдэг байжээ<sup>154</sup>. Түүний Прэстэр Жонтой хэрхэн харилцаж байсан тухай та бүхэнд ярьж өгье, учир нь энэ явдал энэ орны ард түмэнтэй нягт уялдаа холбоотой билээ.

Урьд өмнө нь эдгээр хаадын хооронд дайн тулаан болж байжээ. Алтан хаан нь Прэстэр Жоны хараат албат байсан боловч өөрийнхөө дээгүүр занд хөтлөгдөн эзнийхээ эсрэг босож тэмцжээ. Энэ дайн сөргөлдөөний явцад Прэстэр Жон Алтан хааныг ялан дийлэх байтугай өчүүхэн ч хор хохирол хүргэж эс чадсандаа ихээхэн хорсол занал өвөрлөж явах болжээ. Гэтэл түүний долоон зарц боол нь бид танд Алтан хааныг амьдаар нь авчирч тушааж чадна гэв. Прэстэр Жон тэдгээр зарц боолдоо их шан харамж амлан тэднийг илгээжээ. Тэр долоо Алтан хааны газар ирж түүнд бараалхан “бид харь хол орноос таны албат боол болон зүтгэхээр ирэв” гэхэд, Алтан хаан маш дуртай, элэгсэг дотно хүлээн авч би та бүхний сайхан сэтгэлийн хариуд хүссэн бүхнийг чинь гүйцэлдүүлнэ гэж амлав.

Тэгээд тэр долоон эр Алтан хааны албат болов. Хоёр жил гаруй хаанд алба хашин зүтгэж түүний итгэлтэй албатууд болсон төдийгүй Алтан хаан тэр долоог өөрийнхөө төрсөн үр шиг хайрлаж, ан авд явахдаа үргэлж хамт явцгаана. Нэг удаа Алтан хаан цөөн албат дагуултай анд явахад нөгөөх долоог бас авч явжээ. Хааны ордноос нэгэн бээр орчим зайтай гол гарах үед нөгөөх долоон эр хааны дэргэд үлдэж бусад дагалдагсад нь хоцорсон байсныг нөгөө долоо овжин ашиглаж хаанд ирт мэс тулган “та одоо бидэнтэй хамт яв, эсвэл бид таныг одоо ална” гэхэд хаан гайхахын дээдээр гайхан алмайрч, хүүхдүүд минь та нар юу ярина вэ? би хаана, хэнд очих юм бэ? гэхэд тэд нар та манай эзэн Прэстэр Жонд очно гэв. Үүнийг сонссон Алтан хаан үнхэлцгээ хагартал айн эмээж, “та нар миний амийг өршөөгтүн” гээд “би та нарыг өөрийнхөө ордонд хүлээн авч эцгийн ёсоор хайрлан хүндэтгэж байгаагүй билүү, тэгэхэд та нар намайг миний дайсанд барьж өгөх гэж байдаг, ийм итгэл алдаж, сэтгэл гутаасан муу үйл бүү хийгтүн” гэхийг тэдний хэн ч тоосонгүй түүнийг Прэстэр Жонд хүргэж өгөв. Түүнийг харсан Прэстэр Жон хагартлаа баярлаж, чиний үйл явдал тун ч бүтэлгүй байгаа юм байна гэхэд Алтан хаан хариуд нь ганц үг ган хийсэнгүй. Ингээд Прэстэр Жон Алтан хааныг зэлүүд хөдөө аваачиж малчин болгохыг тушаан зарлигдав. Энэ бол Алтан хааныг үл тоон доромжилж үзэн ядсан хорслоо тайлах арга байлаа. Ингээд Алтан хаан малчин болж хоёр жилийн турш мал адуу хариулан өнгөрөөв. Ингэж хоёр жил болсны дараа Алтан хааныг дуудан авчруулж тансаг сайхан хувцас хунар бэлэглэж, ихэд хүндэтгэн дайлаад: “Алтан хаантан та надтай сөргөлдөн тэмцэлдэж, дайтан тулалдах зиндааны хүн биш гэдгээ ойлгов уу?” гэхэд Алтан хаан “Эзэнтэн минь, таны түмэн зөв, надад маргах сөргөх зүйл үгүй билээ” гэв. Прэстэр Жон: Та үүнийг ухаарч байгаа бол би танаас өөр юу ч хүсэж шаардахгүй. Та өөрийн улсдаа эргэн очиж ханлигаа захиран, эзэн хаантнаа хүндэтгэн явтугай гээд Алтан

хаанд унаа морь, эдлэл хэрэглэл, эд агуурс бэлэглэн бараа болох хүмүүс гаргаж нутаг оронд нь хүргүүлжээ. Алтан хаан нутаг орондоо эргэн ирсэн цагаас хойш Прэстэр Жоны сайн анд, дуулгавартай зарц болсон гэдэг. Одоо бид түрүүний аялж явсан зам руугаа эргэн орж, аяллаа үргэлжлүүлье.

Энэ цайзаас гараад баруун зүг рүү хорь орчим бээр яваад Хармөрөн (Kara-moran) хэмээх их мөрөнд тулж ирнэ. Энэ гол маш өргөн, гүн устай, гүүр тавих боломжгүй тул гүүргүй билээ. Хармөрөн гол урссаар далайд цутгана. Хармөрний хоёр эргийн дагуу олон олон хот тосгод, суурин газартай, худалдаа наймаа ихээхэн дэлгэрсэн нутаг ажээ. Голын дагуух нутаг оронд цагаан гаа, торго мяндас их үйлдвэрлэнэ, маш бөх бат зэгэс хааяагүй их ургах бөгөөд бөх, бүдүүн зэгэсийг хүмүүс ахуйн хэрэглээнд өргөн ашиглана. Тоо томшгүй олон зэрлэг жигүүртэн шувуудтай. Венецийн нэг задгай мөнгө(asper)-өөр эндхийн зээлээс гурвын гурван гургууль худалдаад авчих тийм хямдхан.

Хармөрнийг гатлаад баруун зүгийг чиглэн хоёр өдөрчийн газар явахад Хочунфу (Ho-chung-fu) хэмээх нэгэн тансаг хот таарна. Оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн, ер нь Катар орны хүмүүсийн ихэнх нь онгон шүтлэгтэн билээ<sup>155</sup>. Энэ хот худалдаа, үйлдвэрлэл дэвжин дэлгэрч буй төв бөгөөд алтан саатай хоргой, төрөл бүрийн торго, торгомсог даавуу ихээр үйлдвэрлэнэ. Зэргэмжээх хот нь торго ихээр үйлдвэрлэхээс гадна цагаан гаа, сахал өвс, болон өөр олон төрлийн хоолны хольц амттан, үнэртэн үйлдвэрлэдэг, харин тэдгээрийг бидний оршин амьдардаг ертөнцийн тэр хэсэгт хүргэх арга зам олдохгүй байгаа билээ. Энэ хотод өөр сонин сайхан зүйлээр ховор тул цаашаа одсугай. Хочунфу хотоос гараад найман хоног аялахад зам гудаст цэцэглэн хөгжиж буй үйлдвэр, худалдааны хот суурингууд, жимс ногооны цэцэрлэг талбай үй олноороо таарна. Мөн энэ замын дагуу ялмын мод, түүний навчаар хооллодог торгоны хүр хорхой элбэг тааралдана. Оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтнүүд байх бөгөөд зэрлэг ан араатан, жигүүртэн шувууд төрөл бүрээрээ байх тэднийг агнах ав хоморго их хийдэг ажээ. Найман хоногийн аяны төгсгөлд Синганфу (Si-ngan-fu) хэмээх баян тансаг хотод хүрнэ. Энэ хот нь Синганфугийн ханлигийн нийслэл болой. Синганфу нь нэгэн цагт баян тансгаараа болон шулуун шударга засаглалаараа алдартай хаант улс байжээ. Тэр улсыг олон сайн хаад удирдаж байсан байдаг. Одоо бол Их хааны хүү Мандалай хаан захиран сууна. Түүнийг Эзэн хаан эцэг нь хаан өргөмжлөн хаан ширээнээ залжээ. Синганфу нь үйлдвэр, худалдааны төв бөгөөд торго ихээр үйлдвэрлэнэ. Энд алтан саатай хоргой, торго, торгомсог даавуу үйлдвэрлэхээс гадна бүх л төрлийн зэр зэвсэг үйлдвэрлэнэ. Эндхийн хүмүүс элбэг дэлбэг, үрлэг зарлага багатай амьдрах бүхий л нөхцөл боломж бүрдсэн газар мөн. Хот нь баруун зүгт орших агаад хүмүүс нь онгон шүтлэгтнүүд.

Мандалай хааны ордон нь хотоос нэлээд зайдуу гол горхи, нуур цөөрөм элбэгтэй нэгэн сайхан тал хөндийд оршино. Ордныг тойруулан таван бээр орчим урт тойрогтой, шүдэн хэлбэр оройтой өндөр хана хэрмээр хүрээлэн хашжээ. Хэрмэн хашаан дотор зэрлэг ан араатан, жигүүртэн шувууд бэлчсэн цэцэрлэгт хүрээлэнтэй, хэрмийн гол дунд үүнээс илүү гоё хийц загвартай, тансаг орд харш байдаг болов уу гэмээр гоё сайхан ордон цогцлоожээ. Хааны ордонд гантиг чулуугаар доторлож, өнгийн паалан гүйлгэсэн давтамал алтаар өнгөлж, уран зурагаар чимсэн өрөө, танхим олонтой.

Мандалай хаан хууль ёс, дэг журмыг дээдлэн сахиж, засаг төрөө тэгш сайхан захирч

тохинуулдаг тул ард олон нь ам сайнтай, ихэд хүндэтгэн ханддаг байна. Хааны цэргүүд нь ордныг тойрон байрлаж, ан ав хийж, уралдаан тэмцээн үүсгэн сууцгаадаг байна. Эндээс гурван хоног баруун зүг рүү явахад хот, тосгодоор дүүрэн, хүмүүс нь худалдаа, үйлдвэрлэл, гар урлал эрхэлж, торго үйлдвэрлэдэг үржил шимтэй тал нутгаар дайран өнгөрч явсаар өндөр өндөр уулстай, уулсын хоорондох гүн хавцал хөндийтэй Ханчун (Han-chung) мужид хүрэлцэн ирнэ. Уул, хөндийгөөр нь хот балгад, хэрэм цайз хааяагүй харагдана. Хүмүүс нь онгон шүтлэгтнүүд, жимс ногоо идэж, ан ав хийж амьдарна. Энэ нутгийн ихэнх хэсгийг битүү, шигүү ой эзлэх бөгөөд тэр ойд нь арслан, баавгай, шилүүс, буга, гөрөөс маш элбэг хөдөө нутгийнхан эдгээр ан араатныг агнан борлуулж багагүй ашиг орлого олно. Энэ нутгаар хөндлөн гулд хорин хоног аялахад газар сайгүй тосгон суурин дайралдаж, амарч хоноглох тохилог дэн буудал элбэг таарна.

Уулсын дундуур аялан зорчсон хорин хоногийн эцэст Ак-балик-Манзи (Ak-balik-Manzi) хэмээх тэгш тал нутгийн нэгэн муж руу орж ирнэ. Баруун зүгт орших энэ муж хот балгад олонтой. Нутгийн хүмүүс нь онгон шүтлэгтнүүд бөгөөд худалдаа арилжаа, үйлдвэр, гар урлал эрхлэн амьдарна. Энэ нутагт асар их хэмжээний цагаан гаа тариалан түүнийгээ Катай орны гол гол бүх мужаар зарж борлуулан тариачид нь ихээхэн ашиг хонжоо олдгийг та бүхэнд сонин болгон сонсгож байна. Мөн энд улаан буудай, тутарга болон бусад тариа будаа арвин ихээр хураан авах бөгөөд маш хямдхан зарж борлуулна. Нийслэл хот нь Ак-балик-Манзи, тэрхүү хот тосгод дүүрэн дэлгэр сайхан тэгш тал нутаг хоёр өдөрчийн газар үргэлжлэн цэлийнэ.

Энэ нутгаас гараад өндөр өндөр уулс сүүхийсэн, уулсын хөндийд тосгон суурин, модчины оромж овоохойн хажуугаар баруун зүгийг баримжаалан хорин хоног явахад хааяа энд тэнд тосгон суурин таарна. Нутгийн хүмүүс нь мөн л онгон шүтдэг, зэрлэг жимс ногоо идэж, ав шувуу агнан, гэрийн тэжээвэр амьтад үржүүлэн амьдарна. Ой тайгаар нь арслан, баавгай, шилүүс, буга согоо, бор гөрөөс элбэгээс гадна сайхан үнэртэй заартай хүдэр элбэг. Уулсын дундуур аялан бэдэрсэн хорь хоногийн урт замын төгсгөлд тал газрын Чэнтүфу (Cheng-tu-fu) хэмээх мужид хүрэлцэн ирэх агаад энэ муж Манзи нутгийн хил дотор оршино. Нийслэл хот нь мужтайгаа ижил нэртэй эргэн тойрон хорин бээр урт, цуутай баян, том хот билээ. Харин энэ хот нэгэн цагт хэдэн хэсэгт хуваагдаж байсан гэнэ.

Энэ мужийн хаан гурван хүүтэй хүн байсан бөгөөд насан өөд болох үедээ хотоо гурав хуваан гурван хүүдээ эзэмшүүлэн захируулжээ. Хотын хэсэг тус бүр өөр өөрийн хана хэрмээр зааглагдаж байсан боловч бүгд хотын их хэрэм дотор багтаж байжээ. Тэр хааны гурван хүү өөр өөрийн эзэмшил газар ханлигтай тус тусдаа хаанд өргөмжилөгдсөн эрх мэдэл, эд баялгаар дутахааргүй хүмүүс байсан гэж би бодож байна, учир нь тэр гурвын эцэг хүчирхэг, баян хаан байсан гэдэг. Энэ газар орныг Хубилай хаан байлдан дагуулж тэдгээр гурван хүүгийн хаан цол, эрх мэдлийг эвдэн устгажээ.

Энэ хотыг дайран цэвэр цэнгэг устай хэд хэдэн гол урсах агаад тэдгээр гол нь алсын уулсаас эх аван зарим нь хот дундуур, зарим нь хотыг тойрон урсана. Голын өргөн нь зуун тавин алдаас хагас бээр хүртэл янз янз боловч бүгд маш гүн устай. Хотоос урсан гарахдаа голууд нийлж нэгэн аварга том их устай мөрөн болж түүнийг Киансүй (Kiang-sui) мөрөн хэмээн нэрлэнэ. Энэ мөрөн ная юм уу, зуун өдөрчийн газар үргэлжлэн урссаар гадаад далайд

цутгана. Энэ мөрний сав газар, хоёр эргийн дагуу тоо томшгүй олон хот суурингууд орших агаад мөрний усаар өөдөө сөөргөө тээж тээвэрлэж байгаа ачаа барааг тоймлож хэлье гэхэд санаанд багтахгүй арвин их тул түүнийг өөрийн нүдээр үзэж хараагүй хэн боловч итгэж үнэмшихэд бэрхтэй. Мөрний голдирол доошлох тусмаа өргөссөөр гол гэхээсээ нуур юм уу, далай гэвэл зохилтой. Хот дундуур урсах голын салаан дээгүүр маш сайхан, том чулуун гүүр тавьсан буй. Гүүрийн өргөн нь найман алд, урт нь голынхоо голдирлын өргөний хэмжээтэй буюу хагас бээр хүрнэ. Гүүрийн хоёр талаар гоёмсог гантиг багана зоож баганын оройд бэхлэн тогтоосон нар, хураас гүүрийг нөмөрлөж хаасан модон дээврээр хучжээ. Модон дээвэр нь гоё хээнцэр сийлбэр, зурагтай, ув улаан өнгөтэй. Гүүрээр гарах замын хоёр хажуугаар худалдаа арилжааны модон лангуу эгнүүлэн элдэв бараа, амттан, хүнсний зүйл дэлгэж зарна, тэдгээр лангууг өглөө байршуулж орой хураана. Гүүрэн дээрх худалдааны лангууны орлогоос Их хааны гаалийн байцаагчид, түшмэдүүд татвар хураан хааны санд нийлүүлэх бөгөөд эндээс хураасан татвар нь нэг мянган алтан безантин болдог<sup>156</sup>. Хотын оршин суугчид нь бүгд онго шүтлэгтнүүд. Аялагсад маань Чэнтүфу мужаас гараад таван хоногийн турш тэгш тал, хөндий хоолойг туулан олон олон тосгод суурингийн хажуугаар өнгөрнө.

Энэ нутгийнхан газрын гарц тариа будааныхаа ургац, өгөөжид шүтэн амьдарна. Энд хаа сайгүй арслан, баавгай болон бусад зэрлэг ан араатан элбэг. Үйлдвэр, гар урлал бага сага эрхлэх бөгөөд сүлжмэл шаахай, нэхмэл даавуу үйлдвэрлэнэ. Энэ бол Чэнтүфу мужийн нутгийн нэгэн хэсэг билээ<sup>157</sup>. Таван хоногийн аяны төгсгөлд Төвд (Tibet) хэмээх мужид орж ирнэ.

Төвд нутгаар Мөнх Хааны цэргүүд дайран өнгөрөхдөө түрэмгийгээр цөлмөн хоослосон бөгөөд одоо болтол гацаа тосгод нь нурангид дарагдсан балгас хэвээрээ л байна.

Энэ нутагт гайхалтай бүдүүн, өндөр хулс ургана. Хулсны тойрог нь гурван төө орчим бүдүүн, өндөр нь арван таван алд, нэг үенээсээ нөгөө үеэ хүртэл бүтэн гурван тохой зайтай. Энэ нутгаар аялж яваа аянчин жинчин, худалдаачид наймаачид орой үдшийн цагаар хулс түлж гал бадраана, хулс галд асахдаа тас няс хийн их дуу чимээ гаргах тул арслан, баавгай болон бусад ан араатан галаас айж цэрвэн холуур тойрох агаад хүмүүсийн отог буудал руу дайрч довтолдоггүй. Аянчид, аялагсад гал түлж, гэрэл гэгээ гарган отог буудал, унаа унаш, ачаа бараагаа араатнаас хамгаалах амой. Нойтон хулс галд ороод шатахдаа жигтэйхэн их дуу чимээ гарган тас няс хийх нь айж ширвээтмээр байхаас гадна дуу чимээ<sup>158</sup> нь шөнийн нам гүмд арван бээр газар ч сонсогдоно. Шатаж байгаа нойтон хулсны дуу чимээнээс морь мал үргэн хулжих нь энүүхэн энд, хулсны шатах дуу чимээнд дасаагүй морь малыг нүдийг нь боож, сайн чөдөрлөөд уяхгүй бол уяа, аргамжаа тасчин хулжиж одно.

Аюултай зэрлэг араатан алхам тутам отоож анасан, хоосон зэлүүд энэ нутагт орон байр, айл амьтан огт үгүй шахам, унд хоол олдоно гэж санах ч бараг хэрэггүй. Гурав дөрөв хоног аялан явж байж хааяа нэг айл таарна, тэгэхэд л нэг идэх хоол, уух ундаагаа базааж авна. Ийм маягаар хорин хоног аялсны эцэст тосгон суурин олонтой нэгэн мужид ирнэ. Эндхийн хот балгад нь эгц цавчим хад асганд асааж нааж барьсан барилга байшинтай хэд хэдэн хоттой. Эндхийнхний гэрлэх уламжлал заншил нь нэн сонин. Эр хүн эхнэр авч гэрлэхдээ бие нь эвдрээгүй онгон залуу охиныг хэзээч эхнэрээ болгож авдаггүй байна. Нутгийн заншлаар эр



хүнтэй хавьгаж ойртоогүй охид, бүсгүйчүүд бол онгон бурханд гологдсон, эрчүүд ч мөн тоогоогүй тааруухан хүүхэнд тооцогддог байна. Харь орны аянчид жинчид, худалдаа наймааныхан, аялагсад энэ нутагт ирж буудалламагц ойр орчны тосгон суурин, хэрэм цайзнаас эмгэд хөгшид хорь гуч заримдаа дөчин залуу охидоо дагуулан ирж явуулын хүмүүсийг тэдгээр охид, бүсгүйчүүдтэй унттугай гэж хүсэх, захирахын хооронд хэлээд охидоо тэдний мэдэлд орхиод явцгаана. Тийнхүү харь холын аянчид, аялагсад онгон залуу охидтой цэнгэл жаргалаа эдлэн хүссэн бүхнээ гүйцэлдүүлэх бөгөөд харин өөр тийш нь дагуулан явахыг үл зөвшөөрнө. Аяны хүмүүс явахдаа унтаж цэнгэсэн охиндоо ямар нэгэн жижиг сажиг бэлэг сэлт өгөх учиртай тэдгээр бүсгүйчүүд уг зүйлсийг хэлхэн зүүгээд хичнээн олон хүнтэй унтаж дур хүслээ хангасны илэрхийлэл болгон гайхуулах бөгөөд ийм охид бүсгүйчүүд хамгийн хүсэмжит эхнэр болно, учир нь онгод бурхан түүнийг таалан соёрхсон байна гэгцгээнэ. Ийм бүсгүйчүүдийг авч гэрлэсэн хүн эхнэрээ ихээхэн үнэлж хүндэлнэ, нэгэнт гэрлэсэн бол өөр бусад бүсгүйчүүдтэй хавьтахыг нүгэл хилэнц гэж үзэж жигшин зэвүүцэнэ. Энэ нутгийн гэрлэх зан заншил ямар байдаг тухай өгүүллээ. Ер нь энэ сонин сайхан нутгаар арван зургаагаас хорин дөрвөн насны эрчүүд аялж зугаалах юм бол жаргалаа эдэлнэ.

Нутгийн уугуул иргэд нь бүгд онго шүтлэгтнүүд бөгөөд тун ч муу хүмүүс билээ. Бусдыг залилан мэхлэх, тонон дээрэмдэх, харааж зүхэх, зодож занчихийн алийг ч муу муухай зүйл, нүгэл хилэнц гэж үздэггүй хорвоогийн хамгийн өөдгүй луйварчид, хулгайчид бол тэд мөн. Тэд мал маллаж, зэрлэг жимс ногоо түүж амьдарна. Энэ нутагт хүдэр элбэгээс гадна гюддэри хэмээх бас нэгэн төрлийн маш олон тооны хүдэртэй. Тэдгээр хүдэр асар олон бөгөөд газар сайгүй хүдрийн заар сэнгэнэн үнэртэнэ. Заар гэж чухам юуг хэлээд байгааг би дээр нэг удаа тайлбарлан ярьсан билээ, заар бол хүдрийн хүйсний зэргэмжээ ургадаг нэгэн төрлийн цусаар дүүрсэн жижиг хүүдий-тэр цус нь анхилам сайхан үнэртэй заар билээ. Нэмэж хэлэхэд тэргэл сарнаар хүдрийн заарны хүүдий нь цусаар дүүрэх бөгөөд тэр тухай бүрт нь заараа шахаж гарган хүүдийгээ суллана. Асар олон хүдэр нутагшсан энэ газар хаана л бол хаана хүдэр заараа асгасаар бүх газар нутагт нь хүдрийн заарны үнэр нэвт шингэжээ. Нутгийн уугуул иргэд болох луйварчин хулгайчууд маш сайн үүлдрийн нохой тэжээдэг бөгөөд тэдгээр ноход нь хүдрийг олноор нь ангуучлан барьдаг тул эндхийнхэн хүдрийн заараар дутаж гуцдаггүй билээ.

Нутгийн уугуул хүмүүс зоосон мөнгө буюу Их хааны цаасан мөнгөний аль аль нь байхгүй бөгөөд мөнгийг давсаар орлуулна. Тэд хувцас хунар муутай, ангийн арьс, ёрог даавуу болон олсоор нэхсэн бүдүүн бараг эд хэрэглэнэ. Тэдгээр хүмүүс өөрсдийн гэсэн хэл яриатай бөгөөд өөрсдийгөө “Төвд” гэж нэрлэнэ.

Төвд гэх энэ мужийн газар нутаг асар уудам, Манзи болон бусад олон мужтай хил залган оршино. Уугуул оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн боловч адгийн муусайн дээрэмчид. Муж бол асар том учраас найман ханлиг нутаглах төдийгүй тоо томшгүй олон хот балгадтай. Хааяагүй уул ус, горхи булаг, нуур цөөрөм элбэг бөгөөд тэр нутагт алттай элс маш их хэмжээгээр олдсон. Энэ мужид шүр159 маш өндөр үнэлэгдэхийн учир нь бүх л эмс, охид нь шүрэн зүүлт хүзүүндээ зүүхээс гадна онгонуудынхаа хүзүүнд шүрэн зүүлт зүүцгээнэ. Мөн энд “камлот” даавуу, алтан саатай хоргой, торго болон цэмбэ үйлдвэрлэнэ. Түүнчлэн манай нутагт үзэгдэх нь байтугай дуулаач үгүй олон төрлийн халуун ногоо хийнэ. Энэ нутагт

хамгийн мэргэн зурхайч, төлөгч нар байх агаад хөрш зэргэлдээх мужуудад ч тийм зурхайч төлөгчид олон. Тэдгээр зурхайч төлөгчид олон олон ид шидийн гайхамшгийг үзүүлдгийн дотор салхи шуурга босгох, аянга цахилгаан дуудах нь мөн байгалийн тэдгээр аюулт үзэгдлийг зогсоох нь тэдний дурын хэрэг билээ. Тэд нар хүний санаанд багтамгүй гайхам сонин зүйлсийг ид шидийн хүчээр бүтээдэг тухай энэ номондоо нэг их бичиж уншигч, сонсогч та бүхний эргэлзээ тээнэгэлзэл, гайхашрал бишрэлийг өдөөмөөргүй байна. Тэдний ёс заншил нь сэжиглэж жигшмээр эвгүй. Энэ нутагт илжиг шиг том биетэй сайн анч ноходтой тэдгээр нохдоороо ан ав хийнэ. Мөн өөр үүлдэр удмын анч ноход олонтой, бас шунгаач болон саарал толгойт шонхор элбэг тэдгээр шонхроороо жигүүртэн шувууд авлахаас гадна үнэ хүргэж зарна. Төвд нутгийг орхин одохынхоо өмнө энэ газар орон, хүн ардын нь тухай нэлээд тодорхой ярьж өгүүллээ, харин одоо би та бүхнийг нэгэн зүйлийг ягштал ойлгоосой гэж бодож байна.

Энэ номонд дурьдан дурсаж өгүүлж байгаа газар орон, улс үндэстэн, муж, ханлигууд бүгдээрээ Их хаан Хубилайн эзэмшил, харьяат, хараат нутаг орон, хүн ард нь мөн түүний албат боолууд гэдгийг бүү мартаарай. Харин энэ номын эхэнд өгүүлсэн Левантий нутаг бол Аргун хааны үр садын эзэмшил билээ. Үүнээс үүдээд энэ ном бүхэл бүтнээрээ Их хаан Хубилайд зориулагдаж буйг ухаарч байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Бид одоо эндээс баруун зүгт орших Кайнду (Kaindu) мужийн тухай өгүүлье. Энэ мужийг нэг хаан захиран сууна<sup>160</sup>. Энэ нутгийнхан бүгд онго шүтлэгтнүүд бөгөөд Их хааны албат иргэд болой<sup>161</sup>. Энд хот тосгод олон. Гол хот нь мужид орох зам тосон байрласан Кайнду билээ. Тэр нутагт сувд, тана элбэгтэй нэгэн нуур<sup>162</sup>байх агаад тэр нуурын сувд тана нь ижилгүй сайхан цагаан өнгөтэй боловч бөв бөөрөнхий хэлбэртэй бус харин дөрөв, тав, зургаагаараа буюу түүнээс олноор ч бие биедээ наалдан ургасан байдаг. Их хаан энэ сувд, таныг өөр бусад хүн авч хэрэглэхийг зөвшөөрдөггүйн учир нь хичнээн олон хүн авч хэрэглэх тусмаа газар сайгүй хэрэглэх тэдгээр сувд танын үнэ цэнэ нь шалдаа буутал унана. Эдгээр сувд таныг Их хаанаас өөр хэн ч авч ашиглаж болохгүй, хааны сангаас өөр газар хурааж хуримтлуулахыг цаазаар хорьсон байдаг. Мөн тэндэх нутгийн нэгэн уулнаас маш сайхан өнгө, чанартай оюу чулуу их хэмжээгээр олджээ. Тэр оюу чулуунаас авахыг хүсвэл зөвхөн Их хааны тогтоосон үнээр л авахаас бусдыг хориглодог.

Би та бүхэнд энэ мужийн бүсгүйчүүдтэй холбоотой нэгэн хөгийн ёс заншлын талаар өгүүлье. Харь холын буюу үл таних аяны хүн тэр нутгийн айлын эхнэр, охин, эгч болон бүсгүй дүүтэй тэдний гэрт хамт хонож өнжихийг хүсвэл гэрийн эзэн тэр даруй дуртай зөвшөөрөн өөрөө үл таних гийчнийг яван явтал гэр орондоо ирэлгүй тэнэж алга болно. Тийм болохоор явуулын хүн тэр айлын гэргий, охид, бүсгүйчүүдтэй юу дуртайгаа үйлдэн цэнгээд зогсохгүй өөрийгөө тэр айлд байсаар байгааг мэдэгдэх дохио болгон малгайгаа буюу өөр ямар нэгэн тэмдэг гэрийн нь гадаа өлгөнө. Тэр нутгийнхан үүнийгээ өөрсдийн бурхан шүтээн, онгоноо тайн тайтгаруулж цэнгүүлж байна гэж үзнэ. Их хаан тэдний энэхүү замбараагүй ёс заншлыг чандлан хориглосон боловч хэн ч тэрхүү хоригийг үл дагана. Зам дагуух зарим тосгон, суурингийн царайлаг эхнэртэй эрчүүд зам гудас өнгөрөх худалдаачид, аянчдад эхнэрийнхээ биеийг үнэлэн оронд нь бараа таваар авна. Аян замын хүмүүс тэдний энэ үйл ажлыг элэг доог болгон инээд наадам хийсээр явцгаана, тэд ч өөрсдийнхөө энэ мунхаг мулгуу үйлийг үргэлжлүүлсээр л байна.

Тэдний хэрэглэдэг мөнгө зоосны талаар хэдэн үг хэлье. Тэдний мөнгө нь нарийхан зүссэн алтан гулдмай байх агаад сагги гэх нэгжээр хэмждэг бөгөөд энэ нь хүндийн жин билээ. Тэдэнд тамга тэмдэг дарсан буюу цутгамал өөр ямар нэг мөнгө үгүй. Задгай мөнгө нь бүр ч сонин. Тэд давстай усыг саванд хийж ширгэтэл буцалгаад ус нь ууршиж, давс нь тунаж үлдмэгц тэр давсаа хэвэнд цутган талх мэт хавтгай суурьтай, мөлгөр дугуй нуруутай хэлбэр оруулан хатаана. Эдгээр хэрчим давсаа галд хатаагаад дээр нь Их хааны дүртэй тамгаар тамгалаад зүсэж хуваана<sup>163</sup>. Наян зүсэм давс нь нэг сагги алттай тэнцэнэ. Худалдаачид наймаачид эдгээр зүсмэл давсан задгай мөнгийг хүн амьтан хүрэхийн аргагүй уулын тагт, ой шугуйд амьдардаг нутгийнхандаа жаран хэрчим давсыг нэг сагги алтаар солино. Хүн амьтнаас хол тасархай, алс зэлүүд зарим газар нь нэг сагги алтыг дөч, тавин хэрчим давсаар ч солих нь бий. Уул тайгад нутаглах уугуул хүмүүст алтаа борлуулах наймаачин олдохгүй ховор мөн хүдрийн заарыг нь худалдаж авах наймаачид ирэхгүй зовооно. Ингэж тэр нутгийн өндөр уулын хүмүүс алтаа, хүдрийн заараа хямдхан зарж борлуулна. Худалдаачид наймаачид эндээс асар их олз ашиг олдог учир нь энд бол давс зөвхөн задгай мөнгө төдийгүй хоол хүнсэнд ихээр хэрэглэдэг хүнсний хольц болой. Хот газрынхан бол бүтэн үлдсэн давсан мөнгөөрөө худалдаа арилжаа хийнэ.

Энэ нутагт заар гаргадаг хүдэр хязгааргүй олон бөгөөд анчид тэднийг барьж авч заарыг нь ихээр авна. Эндхийн сувд танатай нууранд төрөл бүрийн сайхан амттай загас элбэг. Мөн арслан, баавгай, шилүүс зэрэг махчин араатан, буга, гөрөөс болон бусад ан амьтан, жигүүртэн шувууд толгой эргэм олон. Усан үзэм энд ургадаггүй, нутгийн хүмүүс улаан буудай, тутаргаар архи, дарс нэрж төрөл бүрийн амттан, үнэртэн хольж уусган сайхан амттай дарс гаргана. Энэ мужид лиш цэцэг асар ихээр ургана. Лишийн мод намхан бөгөөд навч нь лавартай төстэй боловч түүнээс арай нарийхан бас урт. Лишийн цэцэг бол иштэйгээ адлигтар цагаан өнгөтэй. Энд мөн гаа, шанцай арвин ургахаас гадна төрөл бүрийн эмийн ургамал хаа сайгүй элбэг боловч манай нутагт байдаггүй учраас юу гэж хэлэх, нэрлэхээ ч мэдэхгүй тулгамдчихаад байна.

Аялагсад маань Кайнду хотыг орхин гараад арван хоногийн турш хот балгад олонтой, араатан жигүүртэн элбэгтэй, ан ав арвин нутгаар явж өнгөрнө. Энэ нутгийн хүмүүсийн төрх байдал, ааш араншин, ёс заншил нь миний дээр өгүүлсэнтэй эгээ адил. Арван хоног аялсны эцэст Бриус (Brius) хэмээх нэгэн их устай гол замд таарах агаад тэр гол Кайнду мужийн хилийн зааг болой. Энэ голд алттай элс их байдаг аж. Гол урссаар далайд цутгана.

Бриус голоос нэлээд алсран холдох замд Каражан (Kara-jang) хэмээх долоон ханлигаас<sup>164</sup> бүрэлдэн тогтох том муж тааралдана. Эндхийн хүн ард нь бүгд онгон шүтлэгтэн бөгөөд Их хааны харьяат албат билээ. Энэ мужийг Их хааны хүү хүчирхэг, баян Есөнтөмөр (Essen-temur) хаан захиран тохинуулна. Есөнтөмөр хаан өөрөө голч ухаантай, голч бодолтой эзэн учир нутаг орон, хүн ардаа ээл, ивээлтэй захирч, засаг засаглалаа шулуун шударга жолоодоно.

Бриус голыг гаталснаас хойш баруун зүгийг барин таван хоног аялахдаа олон олон хот тосгодтой, сайн үүлдрийн сайхан адуу үржүүлдэг нутгаар явж өнгөрнө. Хүмүүс нь мал сүрэг өсгөн үржүүлж, газар тариалан эрхлэн аж төрнө. Тэр нутгийнхан өөрийн гэсэн хэл яриатай түүнийг нь ойлгож харилцахад маш төвөгтэй хүнд. Таван хоногийн аяны төгсгөлд хаант улсын нийслэл<sup>165</sup> Яачи (Yachi) хэмээх баялаг том хотод хүрнэ. Энэ хотод худалдаачид, гар

урчууд маш олон. Оршин суугчид нь хэд хэдэн ястан үндэстнээс бүрэлдэхээс гадна зарим нь Магоменийг шүтдэг лал мөргөлтөн, зарим нь онгон шүтлэгтэн мөн Нестор урсгалыг шүтэгч загалмайн шашинтнуудтай. Энд улаан буудай, тутарга сайн ургах боловч цагаан талх огт иддэггүй, учир нь энэ нутагт тохирдоггүй хүнс гэдэг. Нутгийн уугуул иргэд нь зөвхөн тутарга идэх бөгөөд мөн маш сайхан амттай тутрагын ундаа хийх бөгөөд тэрийг нь уухад дарс уусан мэт болно. Тэд мөнгөний оронд манайхны нохойн хүзүүвч хийдэг далайн цагаан ювуу хэрэглэнэ. Наян (80) ювуу нь нэг сагги мөнгөтэй буюу венецийн хоёр задгай мөнгөтэй тэнцэнэ, найман сагги цэвэр мөнгө нь нэг сагги шижир алттай тэнцэнэ. Тэр газар далайн устай худаг байх бөгөөд тэр уснаас давс шүүн авч бүх оршин суугчид нь хоол хүнсэндээ хэрэглэнэ. Энэхүү давснаас хааны санд ихээхэн ашиг орно. Энэ нутгийн хүний эхнэр өөр эрд сэтгэлтэй аваас авааль нөхрөө орхин одох нь тийм ч буруу буюу муу үйл гэж тооцдоггүй.

Энэ хаант улсаас явахынхаа өмнө мартаж орхисон зарим зүйлсээ эргэн санаж өгүүлье. Энд эргэн тойрон эргийнхээ дагуу зуу орчим бээр урт нэгэн том нуур байх агаад тэр нууранд хорвоод хосгүй сайхан загас төрөл төрлөөрөө маш элбэг. Зарим нь их том байдаг. Нутгийн уугуул хүмүүс нь үхэр, хонь, тахиа шувууны махыг түүхийгээр нь идэх дуртай. Мал амьтныг муучлан гаргангуутаа элгий нь тэр дор нь авч жижиглэн хэрчээд сармисны цуунд дүрж түүхийгээр нь идэцгээнэ. Түүхий махыг мөн ялгаагүй жижиглэж хэрчээд сармисны цуунд дүрж, халуун ногоогоор амтлан иднэ.

Яачи хотоос гараад баруун зүгийг барин арав хоног аялаад Каражаны хаант улсад ирнэ. Нийслэл хот нь мөн Каражан нэртэй. Хүмүүс нь бүгд онгон шүтлэгтнүүд бөгөөд Их хааны албат иргэд билээ. Энэ хаант улсыг Их хааны хүү Хукажи (Hukaji) захирна. Энэ мужийн гол горхинд алттай элс их бөгөөд уул нурууд, нуур цөөрмөөс нь цул шижир алт олдоно. Энд алт элбэг учраас саггитай тэнцэх шижир алтыг зургаан мөнгөн саггигаар арилжина. Энд мөнгөний оронд цагаан ювуу хэрэглэх авч энэ нутагт ювуу байдаггүй ювууг Энэтхэг орноос авчирна. Энэ нутагт аварга могой элбэг 166. Харахад жихүүдэс хүрмээр зэвүүн хүйтэн амьтан болой. Эндхийн могой хэр зэрэг бүдүүн, урт байдгийг би та нарт хэлье. Зарим нэгэн том аварга могойн урт нь арван тохой, бүдүүн нь тэвэрч хүрэхийн аргагүй том торх шиг байдаг бөгөөд элбэг арван төө хүрнэ. Тэдгээр могой нь эрүүн дороосоо ургасан арслангийн юм уу, шонхорынх шиг хурц хумстай, гурван салаа хуруутай, хоёр богинохон тавхайтай. Асар том данхар толгойтой, хоёр том бүлтгэр нүд нь том дугуй талх шиг. Ам нь бол хүнийг бүхлээр нь залгихад торхооргүй. Шүд нь асар том. Энэ аймшигт мангастай таарсан ан амьтан, хүн алин боловч айж дагжина Эдгээр могой нь миний саяын нэрлэснээс богино найм, зургаа бүр таван тохой ч урттай байдаг.

Тэдгээр мангасыг хэрхэн барьдаг, агнадаг талаар та бүхэнд хэлье. Энэ нутагт өдөр нь нохой гаслам бүгчим халуун болох тул тэдгээр могой чийгтэй газар нүхэн дотроо өдрийг өнгөрөөнө. Орой үдшийн сэрүүн болмогц нүхнээсээ гарч ан ав хайн юу дайралдсанаа барьж иднэ. Тэр могойнууд маш бүдүүн, хүнд учраас элсэн дээгүүр дүүрэн дарстай модон торх өнхөрүүлсэн юм шиг гүн мөр үлдээн явж өнгөрсөн байдаг. Анчид могойг агнахдаа тэдний идэш тэжээлээ хайн гарах буюу ус ундаанд орохдоо байнга явдаг зам мөр дээр тонгорог шиг хурц иртэй төмөр цувруулан зоосон гуалин мод мөн жадны зэв шиг иртэй төмөр зоосон шор мод зэргийг элсэнд булан орхих бөгөөд могой түүн дээгүүр гулсан мөлхөхдөө хэвлийгээ хага зүсэн үхнэ. Анчид могой үхэж байгааг харсаар байж ойртож зүрхлэхгүй, шувуу шиг дуугарч

бусаддаа мэдээ чимээ өгөөд могой нэгэнт хөдөлгөөнгүй болмогц ойртон очицгооно. Анчид могойн гэдсийг хагалмагцаа юуны өмнө цөсийг нь салган авдаг. Энэхүү могойн цөс нь маш хүчтэй сайн эм төдийгүй өндөр үнэ хүрнэ. Галзуу нохойд хазуулсан хүн нэгэн дусал цөс уугаад л дороо эдгэнэ. Төрж чадахгүй өвдөж буй тулгар эмд нэгэн дусал өгөхөд тэр дороо өвдөх нь зогсож хүүхэд нь төрдөг. Төрөл бүрийн хавдар, хамуунд бага зэргийг шингэлэн түрхэхэд хэдхэн хоногийн дотор эдгээж илааршуулах ид шидтэй эм тул маш их үнэ хүрнэ. Тэдгээр могойн мах их амттай тул хүмүүс дуртай идэхээс гадна зарж борлуулна. Тэр аймшигт могойнууд арслан, баавгай болон бусад араатан амьтны үүрэнд орж үр төлийг нь мөн өөрсдийг нь ч барьж идэх нь элбэг тааралдана.

Энэ мужид сайхан, хурдан хүлэг морьд үржүүлэх бөгөөд тэдгээрийг даага, шүдлэн насанд нь Энэтхэг оронд олноор нь зарж арилжна. Тэд худалдаж авсан адууныхаа сүүлний үзүүрээс хоёр, гурван үеийг тайран хаяж шодон сүүлтэй болгоно. Морь нь унаж яваа эзнээ сүүлээрээ шавхуурдах, хурдлан давхиж явахад нь сүүл нь салхи сүүгүүлэх зэргээс болгоомжилж байгаа нь тэр ажээ. Эндхийн хүмүүс дөрөө нь мориныхоо гэдэснээс доош санжигнан унжсан эмээл тохож морио унах бөгөөд үүнийгээ франц маяг гэнэ. Харин тартарууд бол эмээл дээрээ босоо зогсож мориныхоо давхиан дунд харваж болохуйц богинохон сойсон дөрөөтэй байдгаараа тэднээс ялгаатай.

Энэ нутгийнхан одос үхрийн арьсан хуягтай, жад, бамбайгаар голцуу зэвсэглэнэ. Мөн хордуулсан сумтай нумаар зэвсэглэнэ. Нутгийн уугуул эр, эм ялгаагүй хор хадгалж явна, ялангуяа муу муухай үйлд гаршсан хүмүүс нь бол заавал хор авч явна. Хулгай, дээрэм болон бусад муу үйл хийж яваад баригдахдаа тамлал, зодуураас зайлж хялбархан үхэхийн тулд хороо иднэ. Хууль, засаглалынхан нь үүнийг сайн мэдэх тул хор залгисан хүний аманд маш гашуун, муухай амттай нохойн жогорхой чихэж бөөлжүүлээд хорыг нь шингээлгүй гадагшлуулдаг байна. Энэ газар орныг Хубилай хаан байлдан дагуулж эзлэн захирахаас өмнө эндхийн хүн ардын дунд нэгэн бузар муухай ёс заншил элбэг байжээ, тэр юу гэвэл хэн нэгэн язгууртан дээдэс, үзэсгэлэнтэй сайхан төрсөн бие галбиртай хэн боловч аян замд явж байгаад айлд хоновол түүнд хор өгөх болон өөр бусад аргаар хоноцоо алдаг байжээ. Энэ аллага нь эд баялгийг нь дээрэмдэх гэсэндээ бус уг сайхан хүний сүнс сүүдэр, ухаан санааг гэр орондоо шингээн үлдээх гэсэн мунхаг хар санаа билээ. Их хаан энэ орныг байлдан дагуулснаас хойших гучин таван жилийн дотор энэхүү нүгэлт муу ёс заншлыг цаазлан хориглож зогсоосон билээ.

Каражан мужаас гараад баруун зүгийг барин таван хоног аялсны дараа Зардандан (Zardandan) мужид хүрнэ. Энэ мужийн гол хот нь Вочан (Vochan) хэмээнэ. Хүмүүс нь бүгд онгон шүтлэгтэн, Их хааны харьяат албатууд билээ. Эндхийн эрчүүл нь шүд болгоноо алтаар бүрсэн бүгд алтан шүдтэй төдийгүй дээд доод бүх шүдэндээ углаж тогтоодог цул алтан бүрээс хийлгэсэн эрчүүл ч элбэг. Харин бүсгүйчүүд нь алтан шүд хийлгэдэггүй. Эрчүүд нь гарын бугуй, хөлийн шуугаа тойруулан хийсэн шивээстэй байдаг. Тэд энэхүү шивээсээ таван зүү холбож бэхлээд түүгээрээ арьс мах руугаа шивж цус нь нэвчсэн арьсаа хар бэхээр үрж орхиход арьс махны нь завсар хэзээч арилж угаагдахгүй бэхний хар толбо суудаг. Тэр нутгийнхан эр хүн бол “эзэн ноён” гэсэн ойлгоцтой байх тул гэр орны ажил, ахуйд огт гар дүрэхгүй, гэрийн бүхий л ажлыг гэрийн эзэгтэй нар хийх бөгөөд тэдний ажилд тус дэм болгохоор дайнд олзлогдсон эрчүүдийг боол болгон зарна.

Жирэмсэн эхнэр амаржиж сая төрсөн нярай хүүхдээ угааж, өлгийдсөний дараа эр нөхөр нь өлгийтэй хүүхдээ асран халамжилж дөчин хоногийн турш өлгийтэй хүүхэдтэйгээ орондоо хэвтэн бөөцийлнө. Энэ хугацаанд эрчүүд морь харах гэж л орноосоо өндийж, хүүхдээсээ холдохоос бусад цагт үргэлж хүүхэдтэйгээ хамт байна. Энэ хугацаанд ураг садан, танил нөхөд нь тэднийхээр байнга ирж эр нөхрийг нь магтан, элдэв сайхнаар хөгжөөнө. Энэ нь нялх үрээ арван сар хэвлийдээ тээсэн эхнэрээ төрснөөс нь хойш эхнэртээ үзүүлж буй хүндэтгэл, хайр гэлтэй. Эхнэр нь дөнгөж амаржингуутаа л босож гэр орны ажлаа хийх дээрээс нь хүүхэдтэй нөхрөө асрах их ажилд ханцуй шамлан орно. Нутгийн уугуул иргэд махыг болсон, түүхий аль алианаар нь иднэ. Тэд тутаргаа мах болон өөр бусад хүнсний зүйлтэйгээ хольж иднэ. Цагаан будааны нэрмэлээ сайхан үнэртэн болон халуун ногоотой хольж халааж ууна. Тэр нутгийнхан мөнгөний оронд алт, ювуугаар арилжаа наймаагаа хийнэ. Энэ газар нэг сагги алтыг таван саггий мөнгөөр арилжана, мөнгө ийм их үнэд хүрэхийн учир нь энэ газрын эргэн тойронд таван сарын газар мөнгөний уурхай байдаггүй. Тийм учраас мөнгөний наймаачид тэрэг тэргээр мөнгө ачиж авчран таван сагги мөнгөөр нэг сагги алт худалдан авч баяжицгаана.

Эндхийн хүмүүс ямар нэгэн бурхан шүтээн тахиж мөргөдөггүй, сүм дуган байхгүй. Түүний оронд төрөл овгийнхоо хамгийн ахмад настанг шүтэн мөргөж тэр хүнээс бид удам, угшил залган яваа бидэнд байгаа бүхэн тэр хүнээс өвлөгдөж яваа гэж мөргөж шүтнэ. Тэдэнд бичиг үсэг, ном судар үгүй, уншиж бичиж мэдэхгүй. Үүнийг ч нэг их гайхаад байх зүйл биш учир нь тэд аглаг зэлүүд ууланд, битүү ой тайгад амьдарна. Зун цагт бол энэ их ой шугуйд нэвтэрхийн аргагүй, бас агаар нь хүн амьтан оршин амьдрах нөхцөлгүй бохир, бүгчим тул хариас ирсэн хэн боловч өвдөж, үрэгдэж дуусна. Нутгийн хүмүүс худалдаа арилжаа хийх, өглөг авлагаа бодож тооцохдоо дөрвөлжин буюу гурвалжин хэрчим модыг дундуур нь хувааж, эсвэл хэд хэд хувааж хэсэг тус бүр дээр нөгөө хүндээ хожим өгөх өр зээлээ хэрчлээс гарган тэмдэглээд хоорондоо солилцоно. Хожим нь тэдгээр хэрчмийн тал дээрх тэмдэг, хэрчлээсийн дагуу өгөх юм аа өгч, авах юм аа аваад хэрчмээ солилцон тооцоогоо дуусгана.

Каражан, Вочан, Яачи муж, тэндхийн хотуудын алинд нь ч эмч, оточ гэж үгүй. Хэн нэгэн хүн өвдөж өвчилбөл догшин сахиус оршсон бөө, домч нарыг урина. Өвчтөн тэд нарт юу, яаж өвдөж зовоож байгаагаа нэгд нэгэнгүй тоочин хэлмэгц домч бөө нар хөгжим үүсгэн тарни шившлэгээ уншин цамнаж бөөлж эхлэх бөгөөд тэдний хэн нэгэн нь амнаасаа цагаан хөөс сахруулан ухаан мэдээгүй унатлаа цамнан дэвхцэнэ. Тэр бөөгийн биед ад зэтгэр шилжин оршиж байгаа учраас бөө ухаан мэдрэлгүй болж байгаа гэнэ. Ингээд бусад бөө домч нар нь ухаангүй хэвтэх бөөгөөсөө өвчтөний гай барцад юу вэ? Яавал хурдан илааршиж эдгэх вэ? гэх зэргээр асуухад: “Өвчтөн тийм гэдэг ад зэтгэрийг тэгж ингэж хилэгнүүлсэн байна” гэж хариулахад нь бусад нь: “Танд залбиран мөргөө, та л энэ хүнийг ад зэтгэрийн хорлолоос аварч алтан амийг нь авраач” гэгцгээн үглэн мөргөцгөөнө. Ийнхүү домч бөө нарыг үглэн гуйж олон удаа залбиран мөргөсний хариуд: Ухаангүй байгаа домч бөө: Өвчтөн үхэх нь гарцаагүй бол: “Энэ хүн ад зэтгэрийн өмнө үлэмж их нүгэл үйлдсэн тул хичнээн амиа гуйж мөргөвч өршөөхгүй боллоо” гэнэ. Харин өвчтөн илааршиж гайгүй болох төлөвтэй бол: “Тэд төчнөөн хонь гаргаж шөл уу, төчнөөн аяга ундаа цай уу тэгвэл илааршиж эдгэнэ” гэх. Ингээд бөөгийн биед шилжин оршсон албин чөтгөр, ад зэтгэр цааш нь улам лавшруулан ийн тоочно: “Сайн чанарын, өндөр үнэтэй арван сав дарс ундаа, хар толгойтой буюу өөр ямар нэгэн содон тэмдэгтэй хонь гаргаж тийм тийм онгонд идээ будаа, тахил цацал өргө, тэдгээр онгодын догшин сахиус сүнс оршсон тэд төчнөөн удган, бөө домч нарыг найрлуулж наргиулж

цэнгүүл” гэх зэргээр ухаангүй хэвтээ бөөгийн амаар хөврүүлж өгнө. Ингээд өвчтөний төрөл төрөгсөд, ойр дотнынхон өргөл тахилга, найр тойд шуурхайлан бэлтгэж заасан, тоочсон бүхнийг бэлтгэн заасан хонийг тоо ёсоор нь гаргаж цусаар нь хилэгнэсэн ад зэтгэр, авран өршөөсөн онгод бурхадад тахил өргөн удган, бөө домч нарыг хэлсэн тоогоор нь урьж цэнгүүлнэ. Домч бөө, удган нар арц, хүж уугиулан ойр орчныг угаж ариутгана, их гал өрдөж асаагаад түүнийгээ тойрон бөөлж дуу хөгжим хөгжөөж, бүжиглэж цамнацгааж байгаад нэг нь ухаангүй унахад бусад нь түүнээс ад зэтгэр өвчтөнөөс зайлж, онгод бурхад түүнийг өршөөв үү гэхэд “арай ч бүрэн эдгэрч илааршаагүй байна, дахиад тийм тийм юм өргөж даатгавал эдгэнэ” гэх бөгөөд түүнийг бүрэн гүйцэлдүүлсний дараа бөөгийн амнаас өвчтөн бүрэн эдгэрч илааршсан тухай үг унана. Ингээд найр тойд бэлтгэсэн идээ ундаагаа идэж ууж дуусгаад тайлга тахилга, найр цэнгүүн өндөрлөхөд өвчтөн эдгэрсэн байдаг. Домч бөө, удган нар гэр гэртээ буцацгаана. Иймэрхүү тахилга тайлга, ад зэтгэрийг хөөх ёслол сардаа хоёр, гурван удаа баян чинээлэг айл болгоныг тойрон үйлдэнэ.

Албин чөтгөрийг зайлуулах, ад зэтгэрийг хөөх, онгод бурхадыг тахиж тайж цэнгүүлэх тайлга, ёслол онгон шүтлэгтэн суурьшин нутаглах Катай, Манж орноор газар сайгүй болдог учир нь энэ нутаг оронд эмч оточ маш ховор цөөн байдагтай холбоотой билээ.

Вочаны ханлигт болсон нэгэн их сүрлэг ширүүн тулалдааны тухай та бүхэнд ярихаа мартчихаад яваа юм байна. Тэр тулалдааны талаар энэ номонд заавал бичиж үлдээх учиртай юм. Тэр тулалдаан чухам юунаас болж гарах болсон шалтгаан, хэрхэн яаж төгссөн талаар өгүүлсү. Их хаан 1272 онд Вочан болон Каражаны ханлиг руу болзошгүй дайралт халдлагаас сэргийлэн хамгаалах үүднээс цэргийн томоохон хүчнийг илгээжээ. Энэ үед тэр газар нутгийг Их хааны удам угсааны хүн хараахан захиран тохинуулах ажилд тохоон томилогдоогүй байсан бөгөөд үүнийг нэлээд хожуу хийж өөрийн ач хүү Есөнтөмөрийг тэр улсын хан эзнээр томилсон билээ. Миэн ба Бенгал (Mien and Bengal) хэмээх газар нутаг уужимтай, хүн ард олонтой, баян чинээлэг хоёр улсыг захиран суух хан нь арайхан Их хааны захиргаанд ороогүй биеэ даасан тусгаар улс байжээ. Тэр хан Хубилай хааны цэрэг арми Вочанд ирж хуарагнан суусныг олж мэдмэгцээ монгол цэргийг өөрийн их цэргийн хүчээр дайран цохиж мохоовол дахин хэзээч тэр нутагт халдан довлохгүй гэж сэтгэн цэргээ хуралдуулж эхэлжээ.

Тэр ханы цэрэгт хоёр мянган том заан байсан бөгөөд заан бүрийн нуруун дээр модон халхавч-цайз босгож, зэр зэвсгээр өвч тоноглон халхавч-цайз болгонд арван хоёр цэрэг, заримд нь арван зургаа түүнээс ч олон цэрэг суулгажээ. Мөн дөчин түм орчим цэрэг эрстэй байсны дийлэнх нь морин цэрэг байв. Ийнхүү агуу их үйл хэргийг бүтээхээр зорьж асар хүчирхэг армийг зэвсэглэн Эзэн хааны цэргийг даран сөнөөхөөр Вочаны зүг хөдлөөд монгол цэргийн байршилд гурван өдөрчийн газар дөхөж ирээд хуарагнан буудаллаж, тулалдах заан, унаа морьд, цэрэг эрсээ амраан дайралтад зэхэж байв.

Тартар цэргийн жанжин түүний эсрэг өөрөөс нь хэд дахин илүү олон хүнтэй арми тулалдахаар ирж явааг мэдээд сэтгэл нэлээд зовонгуй байлаа. Түүний цэрэг нь ердөө л нэг түм хоёр мянган (12000) морьт цэрэг байв. Гэвч тэр ёстой хал үзэж халуун чулуу долоосон ухаалаг, эрэлхэг жанжин байсан бөгөөд түүнийг Насруддин (Nasr-uddin) гэнэ. Энэ тулалдааны өмнөх бэлтгэлийг ингэж уртын урт түүх болгохын учир бол тартарууд нь ердөө л нэг түм хоёр мянгахан морьтон байсан бөгөөд тэд дайсныг угтан хөдөлж Вочаны талд

тулалдах байршлаа эзлэн дайсны довтолгоог хүлээв. Энэ бол ухаалаг жанжны алдаагүй зөв бодлого байсан. Учир нь тэр талыг захлан эмжсэн их ой шугуйд хаан цэргээ байршуулжээ. Одоо бид дайсныг отон хүлээж буй тартар цэргийн байршлийг түр орхиж тэдний сөрөг дайсан хэрхэн юу хийж байгааг ярь. Миэнийн хан цэргээ аван хуарагнасан газраасаа хөдлөн Вочаны талд орж ирэхэд тартар цэргүүд тулалдааны байраа хэдийн эзлэсэн хүлээж байв. Тэр хан заануудаа эгнүүлэн жагсааж араас нь морин болон явган цэргээ эрэмбэлэн жигдэрмэгц бүх хүчээрээ нэгэн зэрэг тартар цэргийн эсрэг дайран оров.

Тэр их цэргийн ирж явааг харсан тартарууд огтхон ч айн сүрдсэн шинжгүй эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтайн үлгэр үзүүлэн нэгэн зэрэг эгнэн дайран ортол морьд нь заанаас сүрдэн почирдож оройтож өгөхгүй үргэн бусгаж байлаа. Ингээд тартар цэргүүд эргэн зугтаж ардаа байх битүү шугуй руу шурган оров. Дайсны цэрэг ч тэднийг гэзэг даран хөөв. Үүнийг үзсэн тартарууд нэлээд сандарсан боловч тэр дороо уран ухаан сийлж морьдоо шугуйд нуугаад эргэн гарч дайсны зааныг харван намнаж эхлэв. Тэдгээр тартар цэргүүд харваж намнахдаа хэнтэй ч зүйрлэмгүй хавтай идтэй тул дайсны зааныг толгой дараалан шархтуулж эхэлмэгц шархатсан заанууд туйлан цамнаж газар дэлхийг донсолгох мэт хурдалж дээрх жууз-цайзтай хүмүүсээ сэгсчин туйлж, заримыг нь модны мөчирт хавсран хэмхчиж орхиод ойгоор нэг тархан одов. Тартарчууд мориндоо мордон дайсны эгнээ рүү харвалдсаар дайран ороход дайсан ч мөн суман мөндөр буулган угтав. Хоёр этгээд сумаа харваж дуусаад илд, жадаа барин зууралдан цавчилдаж алалдахуй орилоон хашгираан тэнгэрт хадан аянга ниргэсэн ч сонсогдохооргүй болов. Хүн, малын толгой мөчийг тасар цавчин хөсөр унаж буй биеийг ч хага яран тулалдсаар үхсэн, шархадсан хүн, морь тулалдааны талбарыг бүчин хөглөрөн хэвтэнэ. Тийнхүү аймшигт тулалдаан болж өнгөрөв. Энэ тулалдаанд хан үй олон цэрэг эрсээ хайр найргүй хядуулж, үд өнгөрөхөд тэсэж тэвчих аргагүй болсноо ухааран зугтаж эхэлмэгц Тартарууд араас нь хөөн хядаж гарав, үүнийг харахад үнэнхүү сэтгэл шимширч, нүд хальгармаар байлаа. Тартар цэргүүд дайсныхаа үлдэгдлийг үлдэн хөөчихөөд ойгоор нэг тархан одсон заануудыг цуглуулан авахаар ирцгээв. Тэд юуны өмнө заан шурган орсон ойг тойруулан мод унаган хашиж олзлогдсон болон амьд бүгэж үлдсэн цэргүүдэд хөл залгуулчихгүйг хичээж заануудыг ойд хашин хоргоов. Харин тэдгээр заануудыг олзлогдсон цэргүүд барьж өгөөгүй бол тартар цэргүүд хэзээ ч барихгүй байлаа. Тийнхүү хоёр зуу гаруй зааныг олзлон барьж авчээ. Заан нь бусад амьтнаас илүү ухаалаг амьтан болой. Энэхүү тулалдаанаас сургамж авсан Их хаан үүнээс хойш зааныг маш ихээр өсгөн үржүүлж гаршуулж сургаад ачаа бараа тээх, дайн тулаанд ороход эдэлж хэрэглэх болжээ<sup>167</sup>. Ийм нэгэн дайн тулаан болж өнгөрсөн болой.

Аялагчид маань дээр миний цухас дурьдсан Зардандан мужийг орхин одохуй бүтэн хоёр, нэг хагас өдөрчийн газар дандаа уулын хажуу хижлүүрээр уруудан бууна. Энэ зам гудааст тэр нутгийн нэгэн том зээлийн газар дайралдах агаад тэнд хүмүүс долоо хоногийн гурван өдөр арилжаа наймаа хийнэ. Энэ зээл дээр хүмүүс алтаа мөнгөөр арилжих бөгөөд нэг сагги алтыг таван сагги мөнгөөр арилжана. Ийнхүү мөнгийг алтаар арилжигчид асар их ашиг олз олох тул алс холоос мөнгөний арилжаа наймаа хийх худалдаачид олноор ирнэ. Энд алт арилжиж байгаа нутгийн уугуул хүмүүс чухам хаанаас ирдэг, тэдний орон нутаг хаана байдгийг хэн ч хэлж мэдэхгүй тийм зэлүүд бөглүү ойн хаа нэгтэй тэд нар оршин амьдарна. Тэд хаана амьдардгийг хэн ч мэдэхгүй, тэр нутагт нь хэн ч очиж байгаагүй тул тэдэнд алтаа дээрэмдүүлчих болов уу, амь насаа алдчих болов уу гэж айх аюул, болгоомжилж сэрэмжилэх



зүйл мөн үгүй билээ. Энэ замаар уруудаж Энэтхэгийн хилээс өмнүүр орших Миэн мужид ирнэ. Миэн мужийн нутаг уужим, тэнд хүний мөр огт гараагүй, нэвтэрч туулахад нэн бэрхтэй халуун орны өтгөн шигүү ой шугуйгаар өвч хучигдсан, зэрлэг заан, хирс тэргүүтэн хааяагүй чөлөөтэй бэлчих арван таван өдөрчийн газар үргэлжилнэ. Энэ ой шугуйд амьд хүн, орон байшин огт үгүй эл хуль газар. Ингээд халуун орны битүү ой шугуйн талаарх яриагаа өндөрлөн цаашдынхаа аяны мөрийг хөөе.

Энэхүү арван таван хоногийн замыг туулсны эцэст ханлигийн төв Миэн хэмээх том бөгөөд гял цал болсон хотод ирнэ. Оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтнүүд, өөрийн гэсэн хэл яриатай, бүгд Их хааны харьяат албатууд болой. Энэ хотод нэгэн гайхам сонин газар буй бөгөөд тэр тухай би та нарт одоо ярья.

Эрт дээр цагт энэ хотод нэгэн баян чинээлэг, хүчирхэг хаан амьдарч байжээ. Тэр хаан таалал төгсөхдөө өөрийнхөө шарил дээр алтан, мөнгөн хоёр бунхан-цамхаг босгохыг гэрээсэлжээ. Одоо би тэр хоёр бунхан-цамхгийн байдал төрхийг дүрслэн өгүүлье: Бунхан-цамхгийг сайн чанартай чулуугаар барьж Оройноос нь оёорыг хүртэл хуруу зузаан алтаар бүрсэн тул цул алтан цутгамал суварга мэт болжээ. Бунхны өндөр нь арван тохой өргөн нь өндөртэйгөө ижил, сууриараа дугуй тойрог, эргэн тойрон салхинд жингэнэн дуугарах алтан хонх зүүлттэй. Нөгөө бунхан-цамхаг нь мөнгөөр өнгөлсөн болохоос яг алтан бунхныхаа ихэр хуулбар ажээ. Энэхүү бунхан цамхгийг бүтээсэн хэлбэр хийц нь өөд болсон хааны сүр хүчийг илэрхийлэн мөнхөлж, сүнсийг нь баясгах учиртай байв. Эдгээр бунхан-цамхаг нь үнэнхүү хорвоод хосгүй үзэмж төгс юугаар ч үнэлэх аргагүй бүтээл болжээ.

Одоо би та бүхэнд энэ мужийг Их хаан хэрхэн яаж байлдан эзэлснийг өгүүлсү. Хааны ордонд тоогүй олон уран нугараач, бүжигчид, саваачлагч мэтийн овжин сэргэлэн хүмүүс байх бөгөөд Их хаан нэг удаа тэдэнд ийн өгүүлэсэн нь: “Та бүхэн Миэний хаант улсад одож байлдан дагуултугай! Би та нарыг дэмжин тулалдах цэрэг эрс, бүхнийг удирдан захирах ноён гаргаж өгсү гэхэд тэд бүгд дуртайяа зөвшөөрч аян замд гарчээ. Тэгээд тэд Миэний хаант улсыг нэг их төвөг чирэгдэлгүй байлдан дагуулсан ажгуу.

Байлдан эзлэгсэд Миэний төв хотод орж ирээд алтан, мөнгөн бунхан-цамхгийг үзэнгүүтээ баярлан бахархаж, мэлрэн гайхацгаажээ. Ингээд Их хаанд элч илгээн энэ оронд ийм сайхан алтан, мөнгөн хоёр бунхан суварга буй бөгөөд хэрэв Их хаан хүсвэл бид түүнийг нураагаад алтан, мөнгөн хучаасыг хуулан авч илгээсүгэй гэхэд Их хаан бурхан болооч хааны сүнс сүлдийг тахин тайвшруулахаар босгосон энэ сүмийн тухай мэдэж байснаар барахгүй түүнийг огт гэмтээж сэвтээж болохгүй байсанаар нь хамгаалан хадгал гэсэн зарлиг тушаал буулгажээ. Үүнийг гайхаад байх зүйлгүй тартарууд168 өөд бологсодын булш бунхныг ухаж тонодоггүй заншилтай билээ.

Энэ нутагт зэрлэг заан, том биетэй сайхан зэрлэг үхэр, буга согоо, гөрөөс зэрэг амьтан элбэг олон байна.

Одоо би Бенгал хэмээх өөр нэгэн мужийн тухай өгүүлсү. Энэ муж Энэтхэгийн өмнөт хязгаартай залгаа оршино. Марко миний бие Их хааны ордонд байсан 1290 онд тэр орныг хараахан эзлэн захиргаандаа оруулаагүй байсан боловч хааны цэрэг, иргэд тэр нутгийг аль хэдийн байлдан эзэлж эхлээд байсан. Энэ муж улс нь өөрийн гэсэн хантай, хэл яриатай,

оршин суугчид нь онгон шүтлэгт дэндүү их итгэж мунхарсан байдаг. Энэ мужид маш их тайган эрстэй төдийгүй хөрш зэргэлдээх улс орныхоо хаад, язгууртны ордныг тайган эрсээр хангана. Үхэр нь заан шиг өндөр боловч тарга тэвээрэг муутай, тамир тэнхээтэй бус. Хүмүүс нь мах, сүү, тутаргаар хооллоно. Хөвөн их тарина. Эндхийн хүмүүс худалдаа арилжаанд эрвэгтэй сахал өвс, цагаан гаа, чихэр болон олон төрлийн халуун ногоо их хэмжээгээр зарж борлуулна. Энэтхэгчүүд эндээс тайган худалдаж авахаар их ирцгээнэ. Тайган энд маш элбэг учир нь хэрэгтэн ялтан бүхнийг агтлан тайган болгоод эцэс сүүлд нь боол болгон худалдана. Худалдаачид тайган болон боол болгох охид бүсгүйчүүдийг олноор нь худалдан авч явцгаана. Энэ мужийн талаар өөр яриад байх онцлог зүйл үгүй тул эндээс дорно зүгт орших Каугигу (Kaugigu) хэмээх нутгийн талаар ярья.

Каугигу нь өөрийн хаантай. Хүмүүс нь бүгд онгон шүтлэгтэн бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц хэл, яриатай. Энэ орон Их хааны хараат улс агаад жил бүр ихээхэн алба, татвар төлнө.

Энэ улсын хаан нь маш хүүхэмсэг, тачаангуй эр гурван зуун хатантай авч үзэсгэлэн гоо бүсгүйчүүд үзэгдвэл тэр дор нь хатнаа болгон авдаг байна. Энэ муж маш их алттай, бас төрөл бүрийн амтаг болон халуун ногоо элбэг. Тэнгис далайгаас алс хол орших тул тэндхийн бараа таваарыг алс хол нутаг, бусад улс оронд дамлан борлуулах боломжоор хомс учраас нутаг орондоо хямд үнээр борлогдоно. Заан болон бусад зэрлэг ан араатан элбэг баян тул ав хоморгоор дутна гэж үгүй. Хүмүүс нь мах, сүү, тутаргаар хооллоно. Тэнд усан үзмийн дарс үгүй боловч тутаргаар сайхан дарс нэрж халуун ногоогоор амталж ууна. Эндхийн хүмүүс эр, эм ялгаагүй биеэрээ дүүрэн зураг шивээстэй байдаг. Тэр хүмүүсийн биеийн шивээс зураг голдуу арслан, луу, төрөл бүрийн шувуудын дүрс голлоно. Эдгээр зурагаа зүүгээр шивх тул арилна гэж байхгүй. Ийм шивээсийг тэд нүүр, хүзүү, гар, хөл, гэдэс ер аль л шивж болох бүх газраа шивсэн байх. Тэдний энэ шивээс нь гарвал язгуурыг нь тодруулах хэмжээс болдог тул хэн их бөгөөд гоё зураг шивээстэй байнав тэр хүн хамгийн эрхэмд тооцогдоно<sup>169</sup>. Ийм зураг шивээс хийлгэх хүмүүс бүх биеэ нэгэн сэдэвт дүрс зурагаар эхнээс нь дуустал шивүүлдэг бөгөөд шивээс хийхийн тулд уг хүний гар, хөлийг хүлээд хоёр хүн дарж байдаг байна. Шивүүрчин таван зүүг холбон боож бэхлээд урьдчилж зурсан дүрсээ шивж гарах бөгөөд шивх явцад зүүний үзүүр дэх бэх хүний биед нэвтрэн шингэж хоцроно. Шивүүлж байгаа хүн өвдөхийн туйлыг үзэж ухаан алдах ч энүүхэн энд мөн олон хүн шивүүрээ даалгүй цус алдаснаас болж үхэх нь элбэг.

Каугигу мужаас дорно зүгт Аниу (Aniu) хэмээх муж оршино. Оршин суугчид нь мөн л Их хааны харьяат албатууд болой. Тэд бүгдээрээ онгон шүтлэгтнүүд бөгөөд өөрийн гэсэн хэл яриатай. Газар тариалан, хөдөө аж ахуй эрхлэн амь зууна.

Бүсгүйчүүд нь гарын шуу, хөлийнхөө шилбэнд их үнэ цэнэтэй алтан, мөнгөн бугуйвч зүүнэ. Эрчүүд нь мөн ийм бугуйвч зүүх бөгөөд тэдний бугуйвч нь маш сайн чанартай, өндөр үнэтэй байдаг. Тэр нутгийнхан сайхан морьдтой, тэдэнтэй арилжаа наймааны уламжлалт өргөн харьцаатай энэтхэгчүүдэд тэр сайхан морьдоо бөөн бөөнөөр нь зарна. Энэ нутагт үхэр, одос маш их учир нь өвс бэлчээр сайнтай. Хоол хүнсний зүйлээр элбэг баян муж болой. Аниугаас арван таван өдөрчийн зайд Каугигу муж орших агаад түүнээс цааш гучин өдөрчийн газарт Бенгал муж оршино.

Одоо бид Аниу мужаа орхин дорно зүгт найман өдөрчийн газар аялаж Толман (Toloman)

хүрье. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтэн, өөрийн гэсэн хэл яриатай, Их хааны албат харьяатууд билээ. Хот тосгод нь өндөр өндөр хадтай уулсын дунд орших бөгөөд хүмүүс нь хүрэн бор арьстай, товир том биетэй, эрэлхэг зоригтой овог билээ. Тэр нутгийнхныг өөд болмогц чандарлах бөгөөд үлдсэн үнс чандрууг жижиг хайрцаганд хийгээд хүн, амьтан хүрэх аргагүй өндөр уулын агуйд аваачиж оршуулна.

Энэ нутагт алт элбэг. Ювууг задгай мөнгөний оронд гүйлгээнд хэрэглэнэ. Алт болон ювуу нь энэ бүс нутагт буюу Бенгал, Каугигу Аниуд мөнгөний оронд гүйлгэнэ. Худалдаачид цөөхөн боловч маш баян чинээлэг худалдаа арилжаа нь ихээхэн олз ашигтай байдаг. Гол хоол хүнс нь мах, сүү, тутарга. Усан үзмийн дарс үгүй боловч цагаан будаагаар дарс нэрж халуун ногоогоор амтлан ууна. Энд өөр сонирхоод байх зүйл үгүй тул эндээс дорно зүгт орших Куйжу (Kuiju) орохоор зүглэе.

Куйжу нь Толоманаас арванхоёр өдөрчийн зайд оршино. Толоманаас гараад олон хот тосгодтой нэгэн голын эхийг даган аялах боловч сонин содон зүйлээр ховор билээ. Ингээд арванхоёр өдөрчийн зам туулж байж Куйжу хотод ирэх агаад энэ хот тансаг чинээлэг хот билээ. Эндхийн хүмүүс худалдаа арилжаа, гар урлал үйлдвэр эрхлэн аж төрнө. Эндхийн хүмүүс модны холтосоор нэгэн сайхан давуу нэхэж зуны хувцас оёж өмсөнө. Хүн ард нь дайч дайчин омгийнхон болой. Энэ нутагт Их хааны цаасан мөнгийг гүйлгээ, арилжаанд хэрэглэх бөгөөд эндээс эхлээд л хааяагүй хааны цаасан мөнгийг хэрэглэнэ.

Энд арслан маш элбэг олон тул шөнө ил задгай газар хэн ч унтдаггүй, хэрэв унтвал шөнө нь арслан ирээд бариад идчихнэ. Би та нарт бас нэгэн зүйлийг сонин болгон ярья: Голоор завьтай хөвж яваа хүн гол дотор хаа нэгтэй хоноглохоор зогсоход арслангууд нь шөнө болмогц завин дээр авиран гарч хүмүүсийг нь барьж иддэг байна. Гэвч нутгийн хүмүүс арслангаас хэрхэн хамгаалах аргаа олсон төдийгүй арсланг агнадаг байна. Арслан агнах ав хоморго хэрхэн хийдэг талаар хэлбэл: Арслан хэдийвээр бие бялдар том, бяр чадал ихтэй, зэрлэг догшин авиртай араатан авч түүнээс огт айж хулгалгүй барьж агнадаг нохой энэ нутагт байдаг ажээ. Харин арслан агнахад ийм анч нохой хоёр хэрэгтэй болдог бөгөөд ийм хоёр нохойтой анчин ямар ч том нас бие гүйцсэн арсланг агнан авладаг байна.

Арслангийн анчин хоёр том нохой дагуулан, нум сумтай арсланг хайсаар очих агаад ноход нь нэг нь урдаас нь нөгөө нь араас нь арсланг дайран ноцож хазахад арслан ч ноход руу үсрэн дүүлэн буух боловч ноход арслангийн ам, саварт үл оногдоно. Уурсаж улайрсан арсланг ноход хаа дайралдсан газраас нь хазаж хэмлэсээр зугтаалгахад арслан том мод налан зогсож нохойтой тэмцэлдэх энэ агшинд анчин арсланг харван алдаг. Хоёр сайн анч нохой дагуулсан анчин бол ямарч арслангаас айхгүй агнадаг билээ. Энэ мужид мөн сайхан торго үйлдвэрлэх агаад түүнийгээ голын хөндий даган суурьшсан муж, улсуудад тараан борлуулна.

Бидний зам хот тосгод дүүрэн суурьшсан энэ голын хөндийг даган арван хоёр өдөрчийн газар үргэлжилнэ. Эндхийн оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн, Их хааны албат, харьяат нар билээ. Энэ нутгийнхан Их хааны цаасан мөнгөөр худалдаа арилжаагаа хийнэ. Ингэж арванхоёр хоног аялсны дараа энэхүү номонд дээр өгүүлсэн Чэнтүфуд буцаад ирнэ. Тэндээс гараад бүтэн наян хоног аялсны эцэст дээр бидний өгүүлсэн газар орон, муж улсыг дайран явсаар Чочауд эргэж ирнэ.

# Тавдугаар бүлэг

## Бээжингээс Амой орох замд





Чочау (Cho-chau) хотоос гарч өмнө зүгийг барин дөрвөн хоног аялахад худалдаа, үйлдвэрлэл эрхэлдэг, онгон шүтлэгтэй Их хааны харьяат байж түүний цаасан мөнгийг хэрэглэдэг ард зон бүхий хот тосгодоор дүүрсэн нутаг орныг дайран өнгөрнө. Дөрвөн хоног аялсны төгсгөлд Катар мужийн Хокианфу (Ho-kien-fu) хотод хүрэлцэн ирнэ. Одоо энэ тухай та бүхэнд ярья.

Хокианфу бол алдартай том хот. Хүмүүс нь бүгд онго шүтлэгтнүүд, өөд бологсодоо чандарлан шатаана 170. Тэр нутгийнхан бүгд Их хааны албат харьяат, худалдаа арилжаандаа цаасан мөнгө гүйлгэнэ. Хүмүүс нь худалдаа арилжаа, үйлдвэрлэл гар урлал эрхэлнэ. Тэнд алтан саатай хоргой, торго болон торгомсог эд ихээр үйлдвэрлэнэ. Энэ хот нь өөрийн хараат, харьяат олон хот тосгодтой. Хотын дундуур нэгэн том гол урсах агаад тэр голоор болон түүнээс салаалан татсан олон сувгаар Хан-балик хотод аваачиж борлуулах бараа таваарыг зөөж тээвэрлэнэ.

Хокианфу хотоос гарч өмнө зүгийг барин гурван хоног аялсны эцэст Чанлу (Changlu) хотод хүрнэ. Чанлу бол Катар мужийн маш том хот, Их хааны захиргаанд харьяалагдана, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ. Оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн бөгөөд өөд бологсодыг шатааж чандарлана. Энэ нутгийнхан давс маш ихээр үйлдвэрлэх бөгөөд одоо давсыг хэрхэн үйлдвэрлэдэг талаар ярья. Эндхийн эрчүүд нь хужиртай газрын хөрсийг хуулан овоолго

хийгээд түүнийгээ нэвчтэл нь усална, тэр ус нь хөрсний овоолгоос давсыг уусган нэвчиж урсана. Тэр усыг тусгай хоолойгоор урсган нэгэн том төмөр торхонд дөрвөн хуруу гүн байхаар бодож юүлэх агаад тэр давстай усаа буцалган ширгээхэд маш цэвэрхэн цав цагаан давс тунаж үлдэнэ. Энэ хотынхон тэр давсаа ойр орчныхоо хот балгад, хөрш зэргэлдээх улсад дамлан худалдаж ихээхэн ашиг олоод зогсохгүй Их хааны санд чамгүй орлого оруулна.

Энэ мужид маш том сайхан тоор ургах бөгөөд хоёр ширхэг тоор л нэг жин хүрнэ. Энд өөр үзэж харах сонин содон зүйл үгүй тул аяллаа цааш үргэлжлүүлэн Катай мужийн Чанли (Changli) хэмээх бас нэгэн хотоор оръёо.

Энэ хот мөн Их хааны харьяа захиргааны хот бөгөөд оршин суугчид нь бүгд онгон шүтлэгтэн, худалдаа арилжаагаа цаасан мөнгөөр хийнэ. Чанлугаас таван өдөрчийн зайд оршино. Хотын эргэн тойронд олон тосгон суурин орших бөгөөд бараа таваар элбэгтэй, худалдаа арилжаа дэлгэрсэн нутаг тул Их хааны сан хөмрөгт ихээхэн ашиг орлого оруулна. Чанли хотын дундуур нэгэн том гол урсана, тэр голоор өөдөө, сөөргөө хөвөх завь онгоцоор торго дурдан, халуун ногоо, багаж зэмсэг, тоног төхөөрөмж зогсоо зайгүй тээвэрлэнэ.

Чанли хотоос гарч өмнө зүгийг барин зургаан хоног аялахад зам зуурт олон олон баян чинээлэг хот тосгод дайралдах агаад тэдгээр хот тосгодод онгон шүтлэгтэн хүмүүс амьдрах бөгөөд өөд бологсодоо шатааж чандарлана. Энэ нутгийнхан арилжаа наймаа, үйлдвэрлэл гар урлал эрхлэн амьдарна, төрөл бүрийн хоол хүнс элбэгтэй нутаг билээ. Яван явсаар Тандинфу (Tandinfu) хотыг хүртэл нэг их сонирхоод байхаар сонин содон зүйл үл таарна. Тандинфу бол маш том хот, нэгэн цагт биеэ даасан ханлиг байсан бөгөөд Их хаан цэрэг зэвсгийн хүчээр буулган эзэлсэн билээ. Одоо ч гэсэн энэ мужийн хамгийн сайхан хот нь Тандинфу гэдэгт эргэлзээд байх юм алга. Эндхийн худалдаачид 171 маш баян чинээлэг агаад тэдний хүчин зүтгэлээр худалдаа арилжаа нь цэцэглэн дэлгэрсээр байх ажгуу. Энд торго гайхмаар элбэг. Төрөл бүрийн жимс жимсгэнэ дүүрэн ургасан цэцэрлэгт хүрээлэнтэй. Тандинфу хотын нөлөөн дор сүр жавхлан, бэл чинээ бүхий өөр арван нэгэн хот оршино. Эдгээр хотууд нь худалдаа арилжааны нэгдмэл зах зээл болж ихээхэн ашиг орлоготой ажиллахаас гадна торго маш ихээр үйлдвэрлэнэ.

Энэ хот болон мужийг захиран тохинуулахаар Литан Сангон гэгч язгууртныг томилон түүнд найман түмэн цэрэг захируулан суулгажээ. Литан мужийг захиран сууж хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр мужийн олон хотын захирагч, толгойлогч нарыг цуглуулан хуйвалдаж Их хааны эсрэг босож тэмцэхээр шийдэн нутгийн ард олныг ч энэ хуйвалдаандаа хамран оруулжээ.

Ингээд Литан Их хааны харьяа, захиргаанаас гарч байгаа зарлан бослого тэмцлээ эхэлжээ. Их хаан энэ тухай мэдээ авмагцаа Ажул, Монготай хэмээх хоёр ноёнд арван түмэн цэрэг захируулан бослого тэмцлийг дарахаар илгээжээ. Энэ зүйлийг нэг их урт түүх болгоод байх шаардлагагүй билээ. Литан арван түмэн морин цэрэг, тоо томшгүй олон явган цэрэг хуралдуулж чадсан боловч хоёр ноёны эсрэг тулалдаанд өөрөө болон олон олон шадар туслахуудынхаа хамт алагдаж, бусад нь бууж өгчээ. Энэхүү бослого тэмцлийг зохион байгуулж оролцсон хүмүүсийг бүгдийг цаазлан хороож, харин түүнд татагдан орсон энгийн ард иргэдэд огт гар хүрэлгүй 172 өршөөн хэлтрүүлжээ.

Катай нутгийн охид, залуу бүсгүйчүүд төлөв даруу зан аальтай, ёс заншил дэг журмыг чандлан сахицгаана. Тэд элдэв аальгүй зан аашгүй, хөнгөн хуудам салхин дэвүүр шиг үсчихгүй, муур нохой зэрэг гэрийн амьтадтай зууралдахгүй. Тэр охид бүсгүйчүүд гудмаар өнгөрөх хүмүүсийг гөлрөн ширтэхгүй, өөрсдийгөө ч өрөөлийн үзэсгэлэн болгон бусдын анхаарлыг татахгүй, бас элдэв хов живд хошуу дүрж амаа урчих гээд байдаггүй. Зугаа цэнгэл хөөцөлдөн ажил төрлөө цалгардуулдаггүй. Тэд олны хөлийн газар очихдоо, сүм дуганд мөргөл үйлдэхдээ, ахан дүүсийнхээрээ айлчлахдаа дандаа ээжтэйгээ хамт явна. Зарим нь нүүр толгойгоо далдалсан юүдэнтэй явна, ах зах хүмүүсийг дуугараагүй байхад түрүүлж яриа өдөхгүй. Ер нь дуу цөөтэй байдаг. Харин өөрсдийнхөө орон гэрт бол эзэн шиг, эзэгтэй шиг бүх зүйлсээ өөрөө хийж, өөрөө шийдвэрлэнэ. Хийж байгаа зүйл, бодож санаснаа эцэгтээ, ахдаа ховорхон үзүүлж зөвлөнө. Язгуур сурвалжтай айлын идэр залуус болон хүүд нар ч мөн ялгаагүй охид шигээ даруу төлөв, дэг журамтай байцгаана. Энэ нутгийнхны айл гэр, төрөл төрөгсөдийн хооронд тогтож зуршсан харьцаа нь ийм ажгуу.

Хэн нэгэн айлын охиныг бэр буулгахаар гуйх юм уу эсвэл хэн нэгэнд охиноо богтлож өгөхөөр болвол охиноо “онгон” гэдгийг нотлох учиртай бөгөөд онгон биш охиныг бол хэн ч авдаггүй. Эцэг эх нь ярилцаж тохирон хуримын гэрээ байгуулсны дараа охин хүү хоёрын ээж, төрөл садангийн бүсгүйчүүд хоёр талд итгэмжилэгдсэн асрагч бүсгүй нар охиныг угаалгын өрөөнд оруулан тагтааны өндгөөр онгон гэдгийг нь шалгаж тогтооно.

Хүргэн хүүгийн талынхан энэ шалгалтыг сайн болсонгүй гэж үзвэл тэдний нэг нь торгомсог эдээр хуруугаа ороон охины бэлэг эрхтэнд шургуулан бага зэргийн цустай болгон гаргаж ирээд угаахад цусан толбо нь арилахгүй байвал охин онгон гэсэн шинж, цусан толбо угаагдаж байвал охин онгон биш гэх бөгөөд хуримын гэрээ цуцлагдаж охины эцэг торгууль төлдөг. Охидын онгон төрөхийг хадгалахад тэдний явдал гишгэдэл их нөлөөтэй байдаг гэдгийг та бүхэн санаж авах нь чухал хамаа намаагүй алхаж гишгэх, гүйж харайх нь охидын онгон төрөхийг эвддэг учраас Катай нутгийн охид нэг ч илүү алхам хийдэггүй байна. Харин тартарууд бол энэ талаар нэг их санаа зовдоггүй учир нь тэдний охид бүсгүйчүүд эрчүүдтэйгээ адил морь мал унах, ачаа тээш зөөх, байлдаан тулалдаанд оролцох тул охидын онгон төрх аль хэдийн эвдэрсэн байх магадлалтай байдаг. Мэнз нутгийнхан мөн ялгаагүй Катай газрынхан шиг охидынхоо онгон төрхийг эвдэж сэвтээхгүйг эрхэм болгодог.

Өнөө болтол Катай нутгийнханд уламжлагдан ирсэн нэгэн дадал заншлын тухай өгүүлбэ. Онго шүтлэгтнүүдийн тахиж шүтдэг, мөргөж залбирдаг өөр өөрийн нэртэй онго шүтээн наян дөрөв байдаг билээ. Эдгээр онгодыг бурхан бүтээхдээ тус тусын хариуцаж даасан үүрэг чиглэлтэй бүтээжээ. Нэг нь хаясан гэсэн зүйл олоход тус болохоор, нөгөө нь тариа будааны ургац сайн байж ган гачиг болохгүй байхаар, гуравдахь нь хурааж хуримтлуулсан эд хөрөнгийг арвижуулж хамгаалахаар, дараагийнх нь ажил үйл дэлгэрэн дэгжиж хоосорч ядуурахаас хамгаалах гэх мэт өөр өөрийн үүрэгтэй, мөн тус тусын хэлбэр дүрстэй, тус бүртээ өөрийн гэсэн нэр хочтой. Жишээ нь: Хаясан гэсэн зүйл эрж олоход тусалдаг онгон нь арванхоёр настай хүүхдийг дүрсэлсэн, угалз хээгээр чимсэн хоёр жижигхэн модон сийлбэр байх. Тэр онгоны сүмд байнга амьдран суудаг тахилч эмгэн байдаг. Хэн нэгэн эд юмаа хаяж гэсэн, хулгай дээрэмд алдсан, хаана орхисноо санахаа байсан, эд юмаа авч чадахыг байсан хүмүүс өөрсдөө юм уу өөр хэн нэгнийг сүм рүү илгээж эмгэнтэй уулзуулаад онгоноос асууж өгөхийг хүснэ. Эмгэн хариуд нь онгонд зул хүж өргөж, мөргөж гуйхыг зөвлөнө. Ийм зан

үйлийн дараагаар эмгэн нөхцөл байдалд нь тохируулан хаясан гэсэн юм аа: “Тийм тийм газраар хай, эсвэл тийм тийм хүнтэй уулзаж сурагла” хэрэв хэн нэгэн олсон бол олсон, авсан зүйлээ эзэнд нь буцааж өг гэх зэргээр зааж зааварлана. Эмгэн энэ ажлаа зогсоо зайгүй үргэлжлүүлэн: Хэрвээ хэн нэгэн хүн эд юмыг чинь авчихаад өгөхгүй байгаа бол тэр хулгайч гар хөлөө хугалах буюу бие эрхтэнээ гэмтээнэ, тиймээс өөрийн чинь эд юмыг заавал буцааж өгнө гэх. Үнэнхээр л хулгайч нь бүсгүй хүн байсан бол гал тогоондоо гараа эсгэх, галдаа түлэгдэх гэх мэт зүйл болно, эр хүн байсан бол түлээ модонд явж байгаад юм уу мужаан дархан хийж байгаад хөл гараа цавчих зэрэг элдэв муу зүйл тохиолдоно. Хүмүүс энэ бүхнийг сайн мэдэх тул авсан, олсон эд юмаа нэн даруй эзэнд нь буцааж өгнө. Хэрвээ онгон нь хурдан шуурхай хариу өчихгүй байвал эмгэн ингэж хэлнэ: “Одоохондоо онгоны сүнс сүлд энд ирээгүй байна. Одоо та харь, тийм өдрийн тэдэн цагт ирээрэй гэж хэлнэ. Тэр цагт нь очиход эмгэн онготойгоо ярилцах бөгөөд онгон нь шивнэж исгэцсэн нарийн хоолойгоор эмгэнд шивнэнэ, эмгэн онгондоо баярлаж талархсанаа илэрхийлэн мөргөж залбираад өгүүлрүүн: “Тийм тийм газар оч тэндээс та юмаа олно гэх буюу эсвэл хулгайч тэр эд юмыг чинь буюу адуу малыг чинь аваад тийшээ явж байна” гэж хэлнэ. Эмгэний хэлсэн ёсоор болж хаяж гэсэн эд юмаа буюу алдаж осолдсон адуу малаа эзэн нь олно. Ингэж эд юм аа олсон хүмүүс онгоны хувцас баринтаг хийхэд зориулж үнэтэй сайхан хоргой торго бэлэглэнэ. Нэг удаа Марко би зүүж явсан бөгжөө гээчихээд дээрхийн адилаар онгонд хандан олуулж билээ, харин би онгонд нэг их бэлэг сэлт өргөөгүй юм даг. Аянчин маань Тандинфу хотоос гарч өмнө зүгийг барин гурван хоног явахдаа худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал дэлгэрэн дэвжсэн олон хот балгадыг дайран өнгөрнө. Энэ оронд төрөл бүрийн хүнсний зүйл болон ан ав элбэг арвин. Ингэж явсаар Синжу Мату (Sinju Matu)<sup>173</sup> хэмээх худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал дэлгэрсэн үзэсгэлэнтэй бөгөөд том хотод хүрнэ. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтэй, Их хааны албат харьяат, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ. Энэ хотын дундуур нэгэн гол урсах бөгөөд нутгийн хүмүүс тэр голыг хэрхэн өөрчилсөн талаар та бүхэнд ярьж өгье. Өмнө зүгээс Синжу Мату хот руу урсан ирэх голыг хотынхон хоёр сувгаар хуваан урсгаж нэгийг нь зүүн зүгт, нөгөөг нь баруун зүгт урсгахдаа нэг нь Мэнз мужид, нөгөө нь Катай оронд хүрэхээр болгож хотдоо багтаж ядсан ачаа тээшээ голоор зөөх болжээ.

Катай нутгаар дайруулан Мэнз руу зөөвөрлөх бараа таваар олон янз төрөл бөгөөд маш их гэдгийг та бүхэн нүдээрээ хараагүй болохоор итгэхэд бэрх. Ачаа тээш зөөсөн онгоц завьнууд буцаж ирэхдээ мөн л дүүрэн ачаа тээштэй ирнэ. Энэ голоор өдөө сөөргөө хөвөх завь онгоцыг харахад гайхмаар сонин дүр зураг сэтгэлд бууна.

Синжу Матугаас гарч өмнө зүгийг барин найман хоног аялахад худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал ихэд дэлгэрсэн олон хот балгад, баян чинээлэг нутаг орныг дайран өнгөрнө. Энэ нутгийнхан бүгд онгон шүтлэгтэн бөгөөд өөд бологсодыгоо шатааж чандарлана. Оршин суугчид нь бүгдээрээ Их хааны албат харьяат, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ. Найман хоног аялсны эцэст Линжу(Linju) нэртэй хот болон мужид хүрнэ. Линжу хот нь баян тансаг ханлигийн төв хот, энэ ханлигийн ард иргэд нь бүгд зэр зэвсэг үйлдвэрлэх боловч мөн үүнийхээ хажуугаар худалдаа, гар урлал эрхлэнэ. Хотын эргэн тойронд ан араатан, ав шувуу хааяагүй, хоол хүнс элбэг дэлбэг нутаг билээ. Нутгийн тариачид улаан чавга их тарьж хоёр ч удаа ургацаа хураана, түүгээрээ талх хийхээс гадна тэдний орлогын эх үүсвэр болдог. Дээр миний ярьсан гол мөн энэ нутгаар урсан өнгөрөх бөгөөд нутгийнхан том том усан онгоцоор ачаа бараа, үнэт эдлэл зөөж тээвэрлэнэ.



Одоо Линжу мужийг орхин одож, би та нарт өөр бусад сонин хачныг өгүүлсүгэй.

Зам маань биднийг өмнө зүгт хөтлөн гурван хоногийн турш гоё гоё хот балгадтай нутгийг дайран өнгөрнө. Эндхийн хүмүүс мөн л онгон шүтлэгтэн, Их хааны харьяат албатууд мөн л цаасан мөнгөөр худалдаа арилжаа хийнэ. Энд ан араатан, ав шувуу төрөл төрлөөрөө маш их тул ав хоморго хийхэд нэн тааламжтай газар. Ингэж гурван хоног аялсны эцэст Пижу (Piju) хэмээх нэгэн баян тансаг, худалдаа үйлдвэрлэлийн төв хотод ирнэ. Энд торго маш ихээр үйлдвэрлэнэ. Энэ хот бол Манзи нутагт орох босгон дээр оршино. Энэ нутгийн худалдаачид тэрэг даачаандаа хүнс бараагаа ачаалан Манзи нутгийн хот тосгодоор арилжиж худалдаалахаар гарцгаана. Энэ хотынхон Их хааны санд чамгүй их орлого оруулна. Энд өөр сонирхоод байхаар гоц гойд зүйлгүй тул өмнө зүг аялах аян замаа хөөсүгэй.

Пижу хотоос гараад хоёр хоног явсны дараа тариа будаа, ав шувуу элбэг баян сайхан нутагт ирэх агаад энэ хотыг Сижу (Siju) гэнэ. Эндхийн хүн ам нь онгон шүтлэгтэй, өөд бологсдоо шатааж чандарлана. Энэ нутагт цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ, оршин суугчид нь бүгд Их хааны албат харьяат болой. Хот болон муж нь үржил шимтэй сайхан тал хөндийд орших агаад энд улаан буудай бусад тариа их тарьж өндөр ургац хурааж авна. Өөр сонирхуулаад байх гоц гойд зүйлгүй тул аянаа үргэлжлүүлсүгэй.

Сижугээс гараад өмнө зүгийг барин гурван хоног аялахад олон хот тосгод дайран гарч сэтгэлд таатай нутаг орноор аялна. Энд хагалж зассан тариан талбай хааяагүй бас ан ав, жигүүртэн шувууд элбэг, улаан буудай болон бусад тариа будаа арвин ургана, хүмүүс нь онгон шүтлэгтэй, Их хааны албат харьяат, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ. Аянчид маань ингэж явсаар Хармөрөн (Kara-moran) хэмээх аварга том голд тулж ирнэ. Хармөрөн гол Прэстэр Жоны нутгаас эх аван урссаар энд ирэх бөгөөд өргөн нь нэгэн бээр хүрдэг гэдгийг мэдээрэй. Энэ голоор ямар ч том усан онгоц чөлөөтэй хөвнө. Энэ голын загас нь маш том, хот балгад нь голынхоо сав дагуу оршино.

Энэ голоор хэд хичнээн онгоц хөвж явааг хэлэхэд бэрхтэй, учир нь хүн намайг худлаа яриад байна гээд итгэхгүй байж мэднэ. Голоор хөвөж яваа онгоц нэг түм таван мянга орчим байгаа болов уу гэж бодож байна, тэдгээр усан онгоц бүгд Их хааны цэргийн онгоц бөгөөд эдгээр онгоцоор Их хааны цэргийг далайн арал руу зөөнө. Нэг усан онгоцны баг хорин хүнтэй бас арван таван морьтон цэргийг морьтой нь, зэр зэвсэгтэй нь, хүнс тэжээлтэй нь ачиж тээвэрлэнэ. Голын хоёр эрэгт нэг нь Вайнганчау (Hwai-ngan-chau) нөгөө нь Кайжу (Kaiju) хэмээх хоёр хот оршино, Вайнганчау нь том, Кайжу нь жижигхэн хот билээ. Голоор гатлангуут л Мэнз (Manzi) нутагт хөл тавина. Энэ газар нутгийг Их хаан хэрхэн эзлэн захирсан тухай одоо ярья<sup>174</sup>. Харин та бүхэн миний ярьж байгаа нутаг орон, муж хотууд Катай орныг бүхэл бүтнээр нь хамарч байна уу, эсвэл түүний хорины нэг хувьтай тэнцэх газар орны тухай ярьж байна уу гэж гайхах хэрэггүй, Марко би бол зам гудаст дайрч өнгөрсөн газар нутаг, хот тосгодын тухай л өгүүлж байгаа билээ. Тэдгээр газар орон, хот тосгодыг нэрлээд л орхиод байвал та бүхэнд мөн ч уйтгартай байх тул би аль болохоор сонин содон зүйлийг нь өгүүлэхийг л хичээж байгаа юм.

Нэгэн цагт Мэнз нутгийг Факфур хэмээх хан эзэгнэн захирч суусан бөгөөд тэр, эд баялаг арвин, газар нутаг уудам, хүн ард олонтой байжээ. Гэвч тэрээр эр зоригтой, эрэлхэг дайчин эр байсангүй. Харин эмс охидод дуртай, ядуу хоосон хүмүүсийг энэрч өрөвддөг нэгэн

байжээ. Энэ нутагт морь адуу огт байдаггүй байв. Эндхийн хүмүүс нь дайн тулалдаанд бэлтгэх, сургууль дасгал хийхийн оронд бөгсөө холготол хоосон сууж дэмий л цаг нөгцөөх агаад учир юу гэвэл Мэнз нутгийн байгалийн унаган төрх, байршил нь цаанаасаа заяасан хамгаалалт цайз болдог. Мэнзийн хот балгад нь гүн устай өргөн өргөн голоор хүрээлэгдсэн байдаг. Оршин суугчид нь цэрэг дайны талаар өчүүхэн ч болов дадал зуршилтайсан бол энэ газар хэнд ч хэзээ ч эзлэгдэхгүйсэн. Аль ч хотод нь ороё гэвэл зөвхөн гүүрээр л гарах, орох гарцтай билээ.

Христ бурхан дахин мэндэлсний 1268 онд одоогийн Их хаан Хубилай Мэнз улсыг байлдан дагуулахаар өөрийн жанжин Баян Чинсанг илгээжээ. “Баян Чинсан” гэсэн нь “зуун нүдэт Баян” 175 гэсэн утгатай нэр ажээ. Мэнзийн хааны төлөг зурхайд Мэнз улс хэнд ч эзлэгдэхгүй, харин зуун нүдтэй хүн л эзлэх юм байна гэж бууж байжээ. Гэтэл Хубилай хааны илгээсэн Баян жанжин хүчирхэг морьтон цэрэг болон явган цэрэгтэйгээ, цэрэг зэвсэг, хүн морьдоо тээвэрлэх олон онгоцтой усан флотоор Мэнз нутагт нэвтрэн орж иржээ. Баян жанжин Вайнганчау хотод тулж ирээд оршин суугчдыг бууж өгөн Их хааны харьяат албат болохыг тулган шаардахад тэд бүгд татгалзжээ. Ингээд Баян жанжин дараагийн хотынхныг мөн бууж өг гэж тулган шаардахад оршин суугчид нь мөн л татгалзжээ. Гэвч Баян жанжин энэ мэтээр таван хотыг дайран өнгөрч бүгдэд нь бууж өг гэсэн тулгалт, шаардлага тавьжээ. Гэвч аль ч хот нь бууж өгсөнгүй, Баян жанжин ч саатаж зогссонгүй, учир нь түүний араас шил даран туслахаар Их хааны илгээсэн их цэрэг ирж яваа гэдгийг мэдэж байжээ. Ингээд Баян жанжин зургаа дахь хотыг шулуухан дайран эзэлжээ 176. Тэр эрчээрээ довлон нүд ирмэх зуур арван хоёр хотыг эзлэн авчээ. Баян жанжин эдгээр хотыг эзлэн авсныхаа дараа Мэнз улсын хаан, хатад амьдран суудаг нийслэл хот Кинсай (Kinsai)-г чиглэн довтолгов. Мэнзийн хаан Баян жанжныг ирж явааг мэдэнгүүтээ айн ширвээдэж мянган усан онгоцонд ачаалан их далайн арал руу зугтаажээ. Хотоо сахин үлдсэн хатан нь хотоо хамгаалан тэмцэлдэж эсэргүүцэв. Нэг удаа хатан довлон ирж яваа дайсны цэргийг “зуун нүдэт Баян” жанжин захирч яваа гэдгийг дуулангуугаа тэр нэгэн цагт зурхайч төлөгч нар нь Мэнзийн хаант улсыг зуун нүдтэй хүн эзлэн захирна гэдгийг эргэн санангуугаа Баян жанжныг эсэргүүцэлгүй бууж өгчээ. Үүний дараагаар Мэнзийн бүх хот, улс нь бууж өгчээ. Энэ бол агуу их байлдан дагуулалт байлаа учир нь энэ ертөнцөд тэр улстай эгнэх баян чинээлэг орон байсангүй. Тэдний хаан эзэн нь ямар их хөрөнгө мөнгийг юунд зарж үрдгийг үзэхэд гайхмаар. Тэдний хааны энэрэнгүй сайхан үйлсийн талаар өгүүлбэл: Тэр хаан жил бүр хоёр түмэн дөнгөж төрсөн нялх хүүхдийг асран тэжээж өсгөх учир нь тэндхийн ядуу зүдүү бүсгүйчүүд хүүхэд төрүүлээд тэжээж чадахгүйн эрхээр хүүхдээ төөрүүлж хаядаг байна. Хаан тэдгээр хүүхдийг нэгд нэгэнгүй цуглуулан авч ямар од гарагт төрсөн, ямар төөрөг заяатай хүүхэд гэдгийг тодруулан хааны ивээл тэтгэлэгээр ажилладаг олон асран тэжээх газарт өгдөг байна. Мөн хэн нэгэн үр хүүхэдгүй баян чинээлэг хүн хүүхэд авахыг хүсвэл хэд хичнээнийг авахаа хаанд айлтган мэдүүлээд хүүхэд үрчлэн авдаг байна. Эдгээр тэжээвэр хүүхдүүд нас бие гүйцэн эр эм бололцоход эд хөрнгө, орон байр өгч айл болгодог бөгөөд ийм маягаар жил бүр хоёр түмэн өрх айлийг өндийлгөдөг байжээ. Хаан нэг удаа замаар явж байтал хоёр өндөр сайхан байшингийн дунд нэгэн муу ядуу оромж байхыг үзээд учрыг асуувал энэ оромж нэгэн ядуу эрийнх гэжээ. Хаан тэгвэл тэр ядуу эрд мөн ийм сайхан байшин барьж өг гэж зарлиг буулгажээ.

Тэр хаан нэг мянга гаруй идэр залуу зарц шивэгчинтэй ажээ. Хаан эзэн засаг засаглалаа шулуун шударгаар удирдан явуулах тул энэ газар элдэв хулгай дээрэм үгүй бөгөөд хэн ч гэр

орноо цоожилж цуургалдаггүй байна. Шөнийн цагт гудамж зээлээр явахад ямар ч айх аюулгүй амар тайван алхаж болдог байв. Энэ орны эд баялгийг барагцаалж баримжаалж бичих аргагүй элбэг их билээ.

Би сая та бүхэнд хаант улсын тухай өгүүлэн ярилаа, харин одоо тэдний хааны хатны тухай хэдэн үг хэлье. Олзлогдож ирсэн хатныг Их хаанд хүргэн ирэхэд хаан тэр хатныг ихэд эрхэмлэн хүндэтгэж хатан хүний ёсоор үйлчилж байхыг зарлиг болжээ. Харин нутаг орноо орхин гадаад далайн арал руу дайжин дүрвэсэн хаан эзэн нь тэр арал дээрээ үхсэн гэдэг. Энэ орны хаан, хатны тухай хангалттай ярилцсан тул одоо Мэнз (Manzi) орны талаар өгүүлсү. Яриагаа Вайнганчау хотоос эхэлье.

Вайнганчау бол Мэнз орны баруун хойт талд орших тэр оронд нэвтрэх үүд болсон том бөгөөд баян тансаг хот билээ. Оршин суугчид нь онгон шүтлэгтэй, өөд бологсдыгоо чандарлан шатаадаг заншилтай, бүгд Их хааны албат харьяат болой. Тэр улсад тоолж барахааргүй олон усан онгоцтой, учир нь тэндхийн хот тосгод их устай Хармөрөн голын дагуу тархан байрласан байдаг. Харь холын улс орон, өөрийн улсын хот тосгодоос асар их хэмжээний бараа таваарыг энэ хотод зөөж тээвэрлэж авчирна, мөн эндээс асар их бараа таваарыг гадагш нь тээж тээвэрлэнэ. Энд үйлдвэрлэж бэлтгэсэн давсыг хөрш зэргэлдээх дөчин хотод гаргаж борлуулна. Эндхийн давсны борлуулалт, гаалийн татвараас Эзэн хааны санд арвин их орлого орно. Вайнганчау хотоос гарч зүүн өмнө зүгийг барин Мэнз орны гүн тийш аялахад цардаж зассан сайхан зөрөг замаар нэгэн өдөрчийн газар явна. Энэ замыг сайхан чулуугаар эгнүүлэн өрж тавьсан байдаг. Энэ замын нэг талаар битүү намаг шалбаагтай нэвтрэх аргагүй газар нөгөө талаар нь завь онгоц чөлөөтэй хөвөх их устай том голтой. Энэхүү засмал замаас өөр Мэнз орны гүнд нэвтрэх хуурай зам үгүй билээ. Энэ замын төгсөх үзүүрт Паоинг (Pao-ying) хэмээх сайхан том хот оршино. Эндхийн хүмүүс нь онгон шүтлэгтэн, өөд бологсдоо шатааж чандарлана<sup>177</sup>. Бүгд Их хааны албат харьяат бөгөөд цаасан мөнгөөр арилжаа худалдаагаа хийдэг, худалдаа арилжаа, гар урлал, үйлдвэрлэл эрхэлнэ. Торго дурдан, саатай хоргой ихээр үйлдвэрлэнэ. Хоол хүнс элбэг. Өөр онцлож үзэх зүйл үгүй билээ.

Паоингаас гарч зүүн өмнө зүгийг барин явсаар дараа өдөр нь Каоюу (Као-уу) хэмээх тансаг том хотод ирнэ. Энэ нутгийнхан мөн л ялгаагүй онгон шүтлэгтэн, цаасан мөнгөөр гүйлгээ хийдэг, Их хааны албат харьяат, арилжаа наймаа, гар урлал, үйлдвэрлэл эрхэлнэ. Хоол хүнсний зүйл элбэг дэлбэг, загас бол хэмжээ хязгааргүй ихээр барих бөгөөд ан ав ч их хийнэ, Венецийн нэг задгай мөнгөөр гурван гургууль худалдаж авах жишээтэй.

Каоюугаас гарч зүүн өмнө зүгийг барин явахад хот тосгод олонтой мужаар дайран гарч маргааш өдөр нь Тайчау (Tai-chau) хотод ирнэ. Энэ хот нэг их том биш боловч газар дэлхий дээр байдаг бүхий л бараа таваар элбэгтэй, хүмүүс нь онгон шүтлэгтэн, үйлдвэр, худалдаа эрхлэн амьдрах бөгөөд цаасан мөнгөөр гүйлгээ хийдэг Их хааны албат харьяат нар билээ. Худалдаа арилжаанаас ихээхэн ашиг орлого олдог, тэр нутгийнхан усан онгоц олонтой, араатан жигүүртэн элбэг учир ав хоморго их хийнэ.

Эндээс зүүн тийш гурван өдөрчийн зайтай газар их далай залган оршино. Энэ нутаг далай хоёрын завсарт орших газар давс маш ихээр олзворлон бэлтгэнэ. Мөн энд Чинжу (Chinju) хэмээх хот буй бөгөөд эндээс бүх муж нутгийн хэрэгцээний давсыг нийлүүлнэ. Давснаас хааны санд маш их олз ашиг орно. Хүмүүс нь онгон шүтлэгтэн, цаасан мөнгөөр гүйлгээ

хийдэг Их хааны албат харьяатууд билээ. Одоо бид Тайчау хотод буцаж очоод зүүн өмнө зүг рүү аяллаа үргэлжлүүлье.

Тайчаугаас гараад бүтэн өдөржин хот тосгод олонтой сайхан нутгаар явсаар Янчау (Yang-Chau) хэмээх хотод хүрнэ. Янчау хот нь хүчирхэг том хот төдийгүй түүний эрхшээл захиргаанд худалдаа арилжаа, гар урлал, үйлдвэр ихээр хөгжсөн бусад хорин долоон хот захирагдана. Энэ хотод Их хааны тохоон томилсон арван хоёр их ноёны нэг оршин суух бөгөөд тус орны засаг захиргааны арванхоёр нэгжийн нэг нь энд төвлөрнө. Хүмүүс нь онгон шүтлэгтэн бөгөөд цаасан мөнгөөр худалдаа арилжаагаа хийдэг, Их хааны албат харьяат нар билээ. Энэхүү номыг өгүүлэн туурвигч Эрхэмсэг Марко Поло гуай энэ мужийн захирагчаар гурван жил ажиллаж, энэ хотод амьдран сууж байжээ 178. Эндхийн хүмүүс худалдаа арилжаа, гар урлал, үйлдвэр эрхлэнэ. Энд цэргийн унаа морьдын хэрэглэл, эр цэргийн зэр зэвсэг, эдлэл хэрэглэлийг маш ихээр үйлдвэрлэнэ. Мөн түүний хөрш зэргэлдээх хотод цэргийн зэр зэвсэг ихээр үйлдвэрлэхээс гадна цэрэг эрс маш олноороо оршин сууна. Энэ газар өөр илүү сонин содон зүйл үгүй учир эндээс баруун зүгт орших мөн Манзийн нэгэн хэсэг болох хоёр том мужийн тухай өгүүлсү.

Тэр хоёр мужийн нэгийг Нанкин (Ngan-king) гэнэ. Оршин суугчид нь онгон шүтлэгтэй, цаасан мөнгөөр наймаа арилжаа хийдэг, Их хааны албат харьяат нар болой. Үйлдвэр, худалдаа эрхлэн амьдрах бөгөөд торго, алтан саатай хоргой их хэмжээгээр үйлдвэрлэнэ. Газар нутаг нь үржил шим сайнтай тул тариа будаа элбэг, өндөр ургац хураана. Хааяагүй ан ав хийцгээнэ. Өөд бологсдоо шатааж чандарлана. Энэ газар арслан маш элбэг. Баян чинээлэг худалдаачид олонтой тул хааны санд их хэмжээний татвар гувчуур төлнө.

Сианянфу (Siang-yang-fu) энэ хот бусад арван хоёр хотыг өөрийнхөө эрх захиргаанд барьж байдаг алдартай том хот билээ. Худалдаа, үйлдвэрийн тун чухал төв хот. Хүмүүс нь бүгд онгон шүтлэгтнүүд, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ, өөд бологсдоо шатааж чандарлана. Бүгд Их хааны албат, харьяат нар билээ. Маш их торго, хоргой үйлдвэрлэнэ. Энэ хот бүх юм бүрдсэн баян чинээлэг хот билээ. Мэнзийн төр улс мөхөж тэр аяаараа Их хааны эрхшээл захиргаанд орсноос хойш бүтэн гурван жилийн турш энэ хот бууж өгөөгүй л байжээ. Их хааны цэрэг энэ хотыг хааж хуарагнан буухдаа зөвхөн хотын умарт хэсгийг л хааж буудаг байв. Нөгөө гурван талыг нь маш гүн устай том нуур эргэн тойрон хашсан байдаг байсан бөгөөд тэр нуурын усаар хотынхон хоол хүнс, зэр зэвсгээ залгуулсаар байжээ. Одоо миний та бүхэнд ярих учрал тохиол болоогүйсэн бол Их хааны цэрэг энэ хотыг эзлэн авах боломжгүй байлаа. Их хааны цэрэг бүхэл бүтэн гурван жил энэ хотыг бүслэн сахиж суугаад эзлэн авч чадахгүйдээ залхаж гүйцжээ.

Нэгэн удаа эрхэмсэг Никколо, эрхэмсэг Маффео болон Марко гурав аргаа ядсан цэргийнхэнд ийн өгүүлрүүн: “Бид бүхэн хотыг буулган авахад тус болох зэр зэвсэг сэдэхгүй бол эзэлж чадахгүй нь байна шүү” гэцгээв. Тэдний энэ үг, санааг цэргийнхэн Их хаанд айлтган мэдүүлжээ. Үүнийг сонссон Их хаан өгүүлрүүн: “Энэ хотыг буулган авахын тулд хэрэгтэй бүхнийг хийх ёстой” гэв. Хааны энэ үгийн хариуд Никколо, Маффео болон Марко гурав: “Их эзэнтэн минь бүслэгдэн суугаа хотынхон зөөж, зайлуулж даахгүй том том чулуу харвах машин бүтээж түүгээрээ чулуу харвах юм бол хотынхон үг дуугүй бууж өгнө.

Манайханд үүнийг хийх уран дархчуул хүрэлцээтэй бий” гэхэд Их хаан энэ саналыг маш

ухаалаг санаа байна гэж хүлээн авч үтэр түргэн чулуу харвах машин бүтээхийг зарлиг болов. Их хааны албат иргэдийн дотор Поло нарын таних чулуу харвах зэвсэг хийдэг нэг Герман бас нэгэн Нестор урсгалын загалмайн шүтлэгтэн уран дархан байсан бөгөөд тэр хоёр тус бүр 300 фунт жинтэй чулууг алсад харвах гурван машиныг 179 ахархан хугацаанд хийж бүтээв. Эдгээр машиныг хотыг бүслэн суугаа монгол цэргүүдийн дунд зөөж авчран байршуулж суурилуулахад бүгд гайхан шагширч ийм гайхалтай зэвсэг байдаг гэдэгт итгэж ядан байв. Ингээд анхныхаа чулууг хот руу харвахад аймшигтай дуу чимээ гарган нисэж ирэх чулуун сум туссан газрынхаа байшин барилга байгаа бүхнийг зад ниргэн устгаж байв. Үүнийг үзэж харсан хотын оршин суугчид урьд өмнө нь ийм аймшигтай эвдрэл сүйтгэл, үхэл зовлон тээж авчрах чулуун сум байдаг гэдгийг үзэх байтугай дуулж сонсоогүй тул бүгд айн ширвээдэж алмайран гайхацгаав. Хотын оршин суугчид их зөвлөгөөн хийгээд одоо бууж өгөхгүй бол бүгд л үхдэл хүүр болох юм байна гэдгийг ойлгон бууж өгөхөөр шийдэн монгол цэргийн жанжинд хэл хүргүүлжээ. Ингэж Никколо, Маффео болон Маркогийн мэргэн санал, санаачлага ялалт авчирч маш чухал муж, хотыг буулган авсан билээ. Энэ хот Их хааны харьяат хот төдийгүй асар их орлогын эх үүсвэр болдог газар нутаг билээ. Ийм нэгэн явдал болсныг тодорхой ярьж өглөө.

Аянчин маань Янчаугаас гарч зүүн урд зүгийг барин арвантаван бээр яваад л Синжу (Sinju) 180 хэмээх жижигхэн хотод хүрнэ. Энэ хот жижиг боловч бараа таваар элбэгтэй усан онгоцны зогсоол хот билээ. Эндхийн хүмүүс нь онгон шүтлэгтэй, цаасан мөнгөөр гүйлгээ хийдэг, Их хааны албат харьяат нар билээ. Энэ жижиг хот дэлхий дээрх хамгийн том мөрөн болох Киан (Kiang) мөрний эрэг дээр оршино. Энэ мөрөн зарим газраа арван бээр, зарим газраа найман бээр, бүр нарийн газраа зургаан бээр өргөн бөгөөд уртаараа зуун өдөрчийн газар үргэжлэн урсана.

Их мөрний усаар тоо томшгүй олон том жижиг усан онгоц, завь, сал өөдөө сөөргөө хөвөн бараа таваар тээвэрлэн Их хааны орлого олзыг улам арвижуулна. Энэ их мөрөн тэр холын замыг туулан урсахдаа хэдэн арван муж, хэдэн зуун хотыг дайран өнгөрөх бөгөөд мөрний усаар өөдөө сөөргөө тээх зөөх ачаа бараа, хөвөх усан онгоц нь Загалмайн шашинтан бүх улсын гол мөрөн, далай тэнгисээр хөвөх бүхий л усан онгоцыг нийлүүлснээс ч хавьгүй олон гэдэгт би огтхон ч эргэлзэхгүй байна. Миний очсон жижигхэн хотын орчим л гэхэд хагас түмэн усан онгоц хөвж байсныг бий зэрвэс харсан юмдаг. Тэгэхээр энэ их устай урт мөрнөөр хэд хичнээн онгоц хөвөж байдгийг баримжаалж хэлэхэд төвөгтэй билээ. Энэ их мөрөн маань арван зургаан мужийг дайран урсах агаад түүний эргээр болон голын сав дагуу хоёр зуу илүү том жижиг хот, тосгод оршино гээд бодохоор ямар олон усан онгоц 181 голоор аялж хөвж, өөдөө сөөргөө ачаа бараа тээвэрлэж байх нь тодорхой. Голоор хөвөх онгоц болгон Синжу хотыг дайран өнгөрнө. Их мөрнөөр зөөж тээвэрлэж байгаа барааны гол нь давс бөгөөд түүнийг голын сав дагуух бүх муж, хотод хүргээд зогсохгүй их мөрөнд цутгах бусад голоор салаалж салбарлуулан тээвэрлэнэ. Эдгээр усан онгоц буцахдаа зарим нь төмөр, мод, модны нүүрс, олсны ургамал зөөж тээвэрлэнэ. Ингээд ч зөөх тээх ачаа нь багтахгүй тул багаж төхөөрөмж болон бусад овор ихтэй ачааг салаар зөөнө. Энэ голын гол голдирол дээр байгаа Синжу хотын боомт Их хааны сан хөмрөгт ихээхэн орлого ашиг авчирна. Голын дундах хадан уулс, том жижиг арлууд дээр онгон шүтлэгтний сүм дуган, тосгон суурин хааяагүй байх. Усан онгоцнууд нь эрээлж мяраалж будсан нэг шурагтай онгоцнууд байх боловч хоёр зуугаас зургаан зуун тонн ачаа даах даацтай. Синжу хотын тухай та бүхэнд их зүйлийг ярилаа, харин

нэгэн зүйлийн тухай мартсанаа эргэн саналаа. Голоор хөвөх усан онгоцнуудын заримд нь олсон аргамж байхгүй юм. Гэхдээ усан онгоцыг урсгал сөргөөн чирэхдээ татдаг аргамжааг зэгсээр хийсэн байх нь олонтой. Эндхийн зэгс урт бөгөөд бөх юм, тэдний урт нь арван таван тохой байх нь элбэг. Тийм урт зэгсийг дундуур нь зүсэж хуваагаад хооронд нь нийлүүлж томоод хийсэн аргамжааны урт гурван зуун тохой хүрдэг бөгөөд олсны ургамлаар томсон аргамжаанаас хавьгүй бөх байдаг байна. Усан онгоц болгон өөртөө найм, арав зарим нь арван хоёр морь ачиж явдаг бөгөөд онгоцоо урсгал сөргүүлж татах үед тэдгээр морьдоо аргамжаанд оруулан онгоцоо татдаг байна. Одоо эндээс Куачау (Kwa-chau) хот руу хөдөлө.

Куачау хот бол зүүн өмнө зүгт их мөрөний эрэгт орших жижигхэн хот билээ. Хотын оршин суугчид нь онгон шүтлэгтэй, цаасан мөнгөөр арилжаа наймаа хийдэг, Их хааны албат харьяатууд билээ. Энэ жижиг хотынхон асар их үр тариа, тутарга Хан-балик хотод, Их хааны ордонд нийлүүлнэ. Энэ үр тариа, тутаргаа усан замаар тээвэрлэн хүргэнэ, үүнийг далай тэнгисийн усан зам гэж андуурав, энэ бол гол мөрөн нуур цөөрмийг дамжуулан холбосон усан зам билээ. Энэ хотынхны нийлүүлдэг үр тариа нь хааны ордонд нийлүүлдэг тариа, тутрагын гол нь болдог. Куачауг Хан-балик хоттой холбосон усан замыг Их хааны санаачилга, зарлигийн дагуу барьж байгуулсан гэдгийг та нар мэдэхэд илүүдэхгүй. Энэ усан замыг барихдаа голыг голтой, нуурыг нууртай холбосон өргөн бөгөөд гүн суваг татан гол, нуурын усаар дүүргэж хийсэн тул ямар ч том хөлөг онгоц хөвөх боломжтой болсон юм. Ингэж манзи нутгийг Хан-балик хоттой усан замаар холбосон билээ. Усан сувгийн эрэг дагуу аянчин жинчин, тэрэг чарга явах хуурай замтай тул Мэнзээс Хан-балик хүртэл усан болон хуурай замын алинаар ч явж болно гэсэн үг.

Хотын яг хажууд голын дунд нэг том асга хадтай арал байх агаад тэр арал дээр хоёр мянган (2000) лам хуврагтай том сүм хийд байрлана. Тэр сүмд хэдэн мянган онгод бурхад тахиастай байдаг. Тэдгээр онгод бурхадыг ойр орчны сүм хийдүүдээс цуглуулан авчирсны учир нь энэ сүмд эндхийн хамба лам суудаг билээ.

Одоо би гол хөнлөн гарч Чинкианфу (Chin-kiang-fu) хэмээх хотод очиж тэр хотын талаар та бүхэнд ярьж өгсүгэй. Энэ бол Мэнзийн хот. Хүмүүс нь цөм онгон шүтлэгтэн, үхэн үхтэлээ Их хааны албат харьяат байх учиртай, цаасан мөнгөөр гүйлгээ хийцгээнэ. Энэ нутгийнхан худалдаа арилжаа, үйлдвэрлэл, гар урлал эрхлэнэ. Торго, алтан саатай хоргой төрөл төрлөөр нь үйлдвэрлэнэ. Ан араатан, ав шувуу, тариа будаа элбэг дэлбэг учир хоол хүнсээр дутаж гуцахын зовлонгүй. Энд нестор урсгалын загалмайн шашинтны хоёр ч сүмтэй. Эдгээр хоёр сүм энд 1278 оны үед буй болсон бөгөөд хэрхэн яаж буй болсон талаар би та нарт ярьж өгье. 1278 оныг хүртэл энд загалмайн шашны сүм байтугай, Христ бурханыг шүтдэг нэг ч хүн байгаагүй билээ. Их хааны зарлиг тушаалаар 1278 оныг хүртэл гурван жилийн хугацаатай Мар Сергиус гэдэг нестор урсгалын загалмайн шашинтан хүн энэ мужийг захиран сууж байхдаа загалмайн шашны хоёр сүм байгуулсан юм.

Аянчин маань Чинкианфу хотоос гарч зүүн өмнө зүгийг барин гурав хоног аялахдаа худалдаа, үйлдвэрлэл ихэд дэлгэрсэн хот балгад олонтой нутгаар дайран өнгөрнө. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтнүүд бөгөөд Их хааны албат харьяат нар, цаасан мөнгөөр арилжаа наймаа хийнэ. Гурван хоног аялсны эцэст Чанчау (Chang-chau) хэмээх сайхан, том хотод хүрч очно. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтэй, Их хааны албат харьяат нар, цаасан мөнгөөр арилжаа

наймаа хийж, худалдаа, үйлдвэрлэл эрхлэн аж төрнө. Энд маш их торго дурдан, саатай хоргой төрөл төрлөөр нь үйлдвэрлэнэ. Араатан жигүүртэн элбэгтэй, ав хоморго их хийнэ, хөрс шороо нь үржил шимтэй тул тариа будаа арвин ургана.

Энэ хотын оршин суугч иргэд нэгэн өөдгүй муу үйл үйлдэж түүнийхээ өр төлөөсийг амь насаараа төлсөн удаатай. Юу гэвэл Мэнз улсыг Их хааны цэргүүд Баян жанжны удирдлага дор дайлан дарж хураан авчээ. Харин энэ хотыг байлдан эзлүүлэхээр Баян жанжин Алан цэргүүд болон Загалмайтан цэргийг илгээжээ. Алан цэргүүд хотын гадаад хэрмийг хялбархан эзлэн авчихаад хэрмэн дотроос сайхан амтат дарс баахныг олцгоомогц түүнийг согтотлоо ууцгаажээ. Хотын дотоод хэрмэнд 182 амьдардаг ард иргэд алан цэргүүд ухаан мэдээ алдатлаа согтуу байхыг үзмэгц тэднийг хайр найргүй нүдэж балбасаар алж орхижээ. Үүнийг сонссон Баян жанжин их цэрэг илгээн хотын иргэдийг нэгийг ч үлдээлгүй хүйс тэмтрэн устгаж бүхэл бүтэн хотын оршин суугчдыг бүрэн мөсөн сөнөөжээ.

Эндээс хөдлөөд маш том бөгөөд гоёмсог хот Сучау (Su-chau) – д хүрнэ. Эндхийн хүмүүс онгон шүтлэгтэй, бүгд Их хааны албат харьяат, цаасан мөнгөөр арилжаа наймаа хийнэ. Тэд нар худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал эрхэлнэ. Торго болон торгомсог даавуу ихээр үйлдвэрлэнэ. Худалдаачид нь ихээхэн баян чинээлэг байдаг. Хотыг тойрон явбал дөчин бээр газар хүрнэ. Хотын оршин суугчдын тоог хэн ч барагцаагаар ч хэлж чадахгүй олон хүнтэй. Мэнз нутаг нь маш олон эрчүүдтэй, хэрвээ тэд эрэлхэг дайчин, эрэмгий зоригтой дайн ч омгийнхон байсан бол дэлхий ертөнцийг амархан байлдан дагуулах олон эрчүүлтэй билээ. Харамсалтай нь тэд нар эрэмгий дайчин эрс бишээ. Харин тэд эрвэгтэй наймаачид, уран гартай гар урчууд төдийгүй тэдний дунд цэцэн мэргэн гүн ухаантан, байгалийн нууцыг танин мэдсэн эмийн ургамлын талаар их мэдлэг хуримтлуулсан эмч оточ олон. Энэ хотод зургаан мянга (6000) гаруй чулуун гүүртэй, тэдгээр гүүрийн доогуур цэргийн хоёр хөлөг онгоц чөлөөтэй зөрж хөвнө. Хотыг тойрсон ууланд гишүүнэ, цагаан гаа их хэмжээтэй ургана. Венецийн нэг задгай мөнгөөр дөчин жин сайн чанарын сайхан цагаан гаа худалдаж авч болно. Хот өөрийн захиргаанд бусад арван зургаан том хотыг эрхшээн захирна. Сучау гэдэг нь манай хэлээр бол “Газар буюу газрын” гэсэн утгыг илэрхийлнэ. Энэ хотоос холгүй “Тэнгэр буюу тэнгэрийн” гэсэн хот оршино. Эдгээр хот нь үнэнхүү сайхан хотууд учраас ийм онцгой нэр өгсөн нь гарцаагүй, удахгүй би та бүхэнд тэнгэрийн хотын тухай өгүүлнэ.

Ингээд би Сучау хотыг орхин одож тэндээс нэг өдөрчийн зайд орших Вужу (Vuju) хотод хүрэлцэн очлоо. Гэвч энэ хотод бусдаасаа ялгараад байх онцлох юмгүй үйлдвэр худалдааны том хот байлаа. Ингээд цаашаа явсаар Вугин (Vughin) хэмээх үйлдвэр худалдааны том хотод хүрлээ. Энэ хотын иргэд нь мөн л онгон шүтлэгтэй, Их хааны албат харьяатууд, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ. Энэ нутагт торго маш элбэг, нутгийн хүмүүс нь худалдаа арилжаа, гар урлалд мэргэшсэн байдаг. Вугин хотоос гараад Чанган (Changan) хэмээх том хотыг дайран өнгөрнө. Хүмүүс нь мөн ялгаагүй онгон шүтлэгтэй, Эзэн хааны албат харьяат, цаасан мөнгөөр арилжаа наймаа хийцгээнэ. Худалдаа, гар урлал эрхэлнэ. Эндхийнхэн төрөл бүрийн торгомсог эд хийдэг бөгөөд ав хоморго үргэлж хийнэ. Энд өөр онцлон цохож өгүүлээд байх сонин хачин зүйл ховор тул цаашид аяллаа үргэлжлүүлэн Манзийн хааны гол хот Кинсайн тухай ярьж өгсүгэй.

Чанганаас гараад гурван хоног аялахад олон олон хот тосгодтой, хүмүүс нь худалдаа арилжаа,

гар урлал эрхлэх сайхан нутгаар дайрч өнгөрнө. Эндхийн хүмүүс бүгд Их хааны албат харьяат нар, цаасан мөнгөөр гүйлгээ хийнэ, онгон шүтлэгтэй, амьдрал ахуй нь элбэг хангалуун. Ингэж явсаар баян тансаг Кинсай хотод хүрнэ. Кинсай гэдэг нь “Тэнгэрийн хот” гэсэн агуулгатай юм. Кинсай хотод энэ нэрийг үнэнхүү олж өгсөн байх бөгөөд энэ дэлхий дээр өөр ийм гоё, тансаг хот үгүй байхаа. Энэ хотын тухай өгүүлэхдээ тэр хот болон Мэнз улсыг байлдан дагуулж, эзлэн захирсан Баян жанжинд тэр орны хатан хааны бичсэн захидлыг иш татан өгүүлэх нь зүйтэй гэж үзээд ишлэвэл: “Их хаан энэ хотыг агуу их, баян тансаг, үзэмж төгс гэдгийг мэдээд бүү устган сөнөөтүгэй” гэсэн гуйлт хүслийг өргөн айлтгана уу гэж захианд бичсэн янзаар нь буулгав. Энэ бүхэн гарцаагүй үнэн болохыг Марко Поло би өөрийн нүдээр үзсэн билээ 183.

Тэрхүү захианд Кинсай хотын эргэн тойрны урт нь нэг зуун (100) бээр хүрэх агаад гудамжнууд нь урт шулуун, суваг шуудуу нь өргөн уужим. Зах зээлийн газар олонтой тэдгээр нь өргөн цэлгэр тул олны хөл дүүрэн байдаг. Хотын нэг талд цэвэр тунгалаг устай том нууртай, нөгөө талаар нь их устай мөрөн урсах бөгөөд түүнд хотоос гарах тоо томшгүй олон суваг шуудуугаар хотын хог шороо урсан цутгаж, нуураар дайран гадаад их далайтай нийлнэ. Эндхийн агаар нь маш тунгалаг цэвэр ариун билээ. Хотын хаагуур ч ялгаагүй их устай суваг, урт шулуун гудамж зэрэгцэн оршино. Гудамж болон усан суваг нь өргөн уужим тул тэрэг чарга явах, хөлөг онгоц хөвөхөд саад тээг болдоггүй. Энэ хотод нэг түм хоёр мянган гүүр (12000) бий гэх бөгөөд ихэнх нь чулуун гүүр болой. Гол гол усан суваг дээгүүр тавьсан гүүр нь доогуур нь ямарч том хөлөг онгоц далбаагаа буулгаад л хөвж гарахаар өндөр нуман бөгтрөгтэй боловч гүүрэн дээгүүр нь тэрэг чарга, морь мал явахад саад төвөг болохооргүйгээр барьж байгуулсан байна. Бусад гүүрийн нуман бөгтрөг нь намхавтар боловч хөлөг онгоц хөвж өнгөрөхөд саад болдоггүй. Ийм олон гүүртэй гэхийг сонсоод гайхах явдалгүй, хот маань бүхлээрээ усан дунд орших төдийгүй хотыг сүлжсэн тоогүй олон усан сувагтай 184 учир хүмүүсийн зорчих явахад зориулсан түм илүү гүүртэй билээ. Хотын нэг талаар маш өргөн, гүн устай дөчин бээр (40) бээр урт сувагтай бөгөөд тэр нь их устай мөрөнтэйгөө нийлнэ. Энэ сувгийг хотыг захирч байсан эртний хаад хийлгэсэн учир нь хот дундуур урсах их мөрөн үерлэж савнаасаа халихад үерийн усыг зайлуулах мөн хотыг хамгаалах хоёр зорилготой хийсэн байдаг. Тэр сувгаас ухаж гаргасан шороогоор хотыг тойруулан намхан шороон далан босгожээ.

Кинсай хотод үй түмэн худалдаа, арилжааны мухлаг дэлгүүртэй боловч арван (10) том зах ажилладаг. Эдгээр зах нь тэг дөрвөлжин хэлбэртэй тал бүр нь хагас бээр урт. Тэдгээр захын дундуур тус бүр дөчин алхам өргөн гол зам байх агаад эдгээр зам нь хотыг нэг захаас нь нөгөө захад нь гартал нэвт сүвлэн гарсан байдаг. Эдгээр замын хажуугаар өргөн бөгөөд гүн устай сувагтай, суваг дээгүүр тоогүй олон гүүр тавьсан байх агаад гүүрийн бөгтрөг бүрийг тэрэг чарга хальтраад, явган хүн гулгаж тороод байхааргүйгээр нарийн нягт тооцоолон аядуухан өгсөх, буух замтай хийжээ. Зам, сувгийн дагуу дөрвөн бээр тутамд нэг зах байрших агаад захын дөрвөлжин ханын урт нь нийтдээ хоёр бээр байна. Сувгийн эргийн дагуу, дөрвөлжин захад ойрхон том том чулуун байшингууд барьсан байх бөгөөд эдгээр том агуулахад Энэтхэг орноос ирсэн худалдаачид өөрсдийн авчирсан бараа таваар, тоног төхөөрөмжийг хадгална. Зах долоо хоногт гурван удаа нээгдэж ажиллах бөгөөд зах бүрт дөрвөн түмээс таван түмэн (40000-50000) хүн худалдаа арилжаа хийнэ. Эдгээр зах дээр хоол хүнсний зүйл, ав шувууны мах хааяагүй зарагдана. Жишээлбэл: Гур, буга, туулай, молтогчин,



гэрийн тэжээмэл шувууд болон зэрлэг ятуу, гургууль, тахиа, нугас, галуу гэх мэтийн ангийн болон ав шувууны мах газар сайгүй овоолгоотой байх. Хүнсний захаас нь галууны нэг хэлхээс эсвэл нугасны хоёр хэлхээс махыг Венецийн нэг ширхэг задгай мөнгөн зоосоор л худалдаад авчихна. Энд мөн мал нядалгааны газартай, тэнд нь үхэр, хонь, хурга, тугал нядлах бөгөөд тэдгээр нядалсан малын шинэ, тураг махыг баячууд, язгууртнууд худалдан авна, гэдэс дотор, толгой шийрийг нь энгийн ардууд болон ядуучууд худалдаж авна.

Тэдгээр дөрвөлжин зах дээр худалдаалдаг хүнсний зүйлийн дотор төрөл бүрийн жимс ногоо ихээхэн жин дарсан бүтээгдэхүүн болдог бөгөөд арван жин татах том том маш амттай лийр, шар цагаан тоор зэрэг ховор жимс элбэг. Усан үзэм, усан үзмийн дарс ховор боловч сайхан том, сайн чанарын үзэм бусад боомтоос бөөн бөөнөөр нь авчирч борлуулна. Нутгийн хүмүүс нь цагаан будаагаар нэрж халуун ногоогоор амталсан нэрмэл ууж дассан тул усан үзмийн дарс нэг их хэрэглэдэггүй билээ. Өдөр болгон далайгаас барьсан шинэ загас хорин таван бээр газраас зөөж тээж авчирч борлуулна. Мөн ойр орчимийн нуураас барьсан цэнгэг усны загас ч элбэг. Эдгээр цэнгэг нуурын загаснууд нь хотоос урсан гарах хог хаягдлаар хооллосоор байгаад таргалж томорсон, амтлаг сайхан загаснууд байдаг. Эхлээд харахад хэзээ энэ их бараа таваар, хоол хүнсний зүйлийг зарж борлуулж гүйцэх бол гэж гайхширч байх хооронд хэдхэн цагийн дотор л лангуугий нь хоосолчихно. Эдгээр арван том дөрвөлжин зах нь эргэн тойрон өндөр байшингаар хүрээлэгдсэн байдаг. Тэднээс арай доогуур гоё чимэглэл, халуун ногоо, үнэт чулуу, шүр сувд худалдаалдаг тансаг дэлгүүрүүдтэй. Зарим нэгэн дэлгүүрт нь худалдаа наймаа огт хийхгүй зөвхөн цагаан будааны хямдхан архи нэрж шинээр нь зарна. Захыг тойрсон олон олон гудамжинд төрөл бүрийн үйлчилгээ үзүүлнэ. Маш олон хүйтэн усанд орох газар ажиллана. Учир нь эндхийн хүмүүс хүүхэд ахуй наснаасаа хүйтэн усанд орж эрүүл мэндээ сахих заншил зуршилтай байдгаас ийм олон хүйтэн усанд орох газар, тэдгээр хүмүүсийг усанд оруулах бүсгүйчүүд хааяагүй ажиллана. Гадаадын иргэд хүйтэн усанд орж зуршаагүй тул тэнд бас халуун усанд орох газар ч бэлэн байна. Өдөр болгон усанд орж биеэ угаах нь эдний тогтож зуршсан заншил бөгөөд усанд оролгүй хоол унд идэхээр нэг ч хүн хоолны ширээнд суудаггүй билээ.

Хотын гудамж, зээлээр хүүхнүүд дүүрэн байх тул тэднийг төд өд гэж тоо хэлэх аргагүй олон. Тэдгээр хүүхнүүд дөрвөлжин захын зэргэмцээх гудамж, талбай болон хотын хаана л бол хаана хааяагүй дайралдана. Тэд маш дэгжин гоё хувцастай, элдэв гоё үнэртэн заар ханхлуулсан, олон зарц шивэгчин дагуулсан язгууртан дээдэс шиг уран гоё хийцтэй байшинд сууцгаана. Тэдгээр бүсгүйчүүд эр болгоны ааш авир, дур хүсэлд тохируулан энхрийлж, эрхлүүлэхдээ дээд зэргээр дадлагажсан байх бөгөөд нэг удаа тэдэнтэй уулзаж учирсан харь орны эрчүүд бол дахин дахин уулзаж учрахаар тэмүүлнэ. Тийм эрчүүд эргэж нутагтаа очоод би Тэнгэрийн хот Кинсайд очиж үзсэн одоо дахиад очихоо тэсэж ядан хүлээж байна гэцгээдэг билээ.

Зах талбайг тойрсон гудамж зээлээр эмч домч, мэргэч төлөгчид, унших бичихийг хүмүүст заадаг номын багш нар, бусад ажил үйл эрхэлдэг тоо томшгүй олон төрлийн гар урчууд оршин суурьшиж ажил үйлээ явуулцгаана. Дөрвөлжин зах, талбайн хоёр үзүүрт хоёр гоё сайхан байшин байх бөгөөд тэнд хааны томилсон шүүгчид байрлаж зах, талбайгаар дүүрэн орших худалдаачид болон хотын оршин суугчдын хооронд гарах маргаан, хэрүүл бүхнийг зохицуулах, эцэслэн шийдэж тохинуулах үүрэгтэй. Эдгээр шүүгчид нь тэр орчноо байнга

хянан шалгаж дэг журам зөрчсөн болон бусад гажуудлыг зэргэлдээх гүүрийн дор байрлах харуулынханд хэлж хэнийг хэрхэн шийтгэж баалах талаар зохицуулан арга хэмжээ авна.

Хотыг нэвт сүвлэн гарах гол гудамжны хоёр талаар үзэсгэлэн төгс том том байшин барилга тэднийг тойрсон цэцэрлэгт хүрээлэнтэй байх бөгөөд тэдгээр байшингийн хооронд байх мянга түмэн дэлгүүр мухлаг, гар урлалын газарт үй түмэн хүн ажиллаж амьдран бужигналдана. Энэ олон хүнийг хоол хүнсээр тасралтгүй хангах гэдэг ямар их нүсэр ажил болохыг санаандаа ч төсөөлөхөд бэрхтэй билээ. Гэвч өдөр болгон зах зээлийн дөрвөлжин талбайгаар хоол хүнс ачсан тэрэг, завь онгоц, бусад тээврийн хэрэгсэл гишгэх газаргүй дүүрэн болж тээж зөөж авчирсан хоол хүнсний зүйлс нь уул овоо шиг хааяагүй овоолгоотой байна. Үүний жишээ болгон ганцхан халуун чинжүүг энэ хотын оршин суугчид нэг хоногт хэд хичнээн хэмжээтэй хэрэглэдгийг Их хааны гаалийн албаныхнаас Марко Поло гуайн асууж тодруулсан тоо хэмжээгээр жишиг болгон иш татъяа. Үүнээс ургуулаад мах, загас, жимс ногоо, архи ундаа, боов чихэр хэд хичнээнийг хэрэглэдгийн баримжааг тооцож болох билээ. Кинсай хотын өдөр тутмын хэрэгцээнд зориулан дөчин гурван (43) тэрэг халуун чинжүү авчирч борлуулдаг байна. Нэг тэрэг нь 223 фунт жинтэй байдаг билээ.

Хотод ажиллагсад нь гол мэргэжил-үйлдвэрлэлээрээ арванхоёр том нийгэмлэг-холбоонд хуваагдан харьяалагдах бөгөөд бусад төрлийн жижиг сажиг холбоо, нийгэмлэгийг үл тооцов. Эдгээр том нийгэмлэг-холбоо нь өөртөө тус бүр нэг түм хоёр мянган (12000) жижиг үйлдвэр, гар урлалын газрыг нэгтгэсэн байдаг бөгөөд тэд нь тус бүртээ арваас дөч (10-40) хүртэл ажиллагсадтай байдаг. Энэ бүхнийг тоочиж тооцохын учир гэвэл энэ хот өөрийн хөрш зэргэлдээх хот, мужуудыг хэрэгцээтэй бүхнээр хангадаг билээ. Эндхийн худалдаачид асар олон бөгөөд маш баян чинээлэг, тэдний зарж борлуулдаг бараа таваарыг нэрлэж хэлэх, тоо хэмжээгийг нь баримжаалах аргагүй их билээ. Хотын язгууртан дээдэс тэдний эхнэр хүүхдүүд болон үйлдвэр, худалдааны эзэд нь хаад ноёд шиг элбэг хангалуун амьдарна. Тэд өөрсдийн гараар бүтээх, урлах ажил огт хийдэггүй. Хүн бүхэн зөвхөн эцэг өвгөдийнхөө хийж байсан ажил үйлийг үргэлжлүүлэн хийх хааны зарлигтай, үүнээс өөр ажил хийх хориотой. Хэн нэгэн арван түмэн (100000) алтан бэзантинтай байлаа ч өөр төрлийн үйл ажил эхлэх, эрхлэх боломжгүй байдаг. Энэхүү дүрэм журмыг Их хаан Хубилайн өмнөх тэр нутгийн хаад тогтоож мөрдүүлж байжээ. Хубилай хаан энэ газар нутгийг элэн захирснаас хойш хэн юу хийх нь огт сонин биш харин хэн юу бүтээж чадаж байна гэдэг нь илүү сонин байсан учраас хэн боловч өөрийн хүсэл авьяасын дагуу ямар ажил эрхлэх нь уг хүний дурын хэрэг болсон билээ. Хүний дур хүсэл, мэргэжил чадвар, авьяас билгийг хориглох нь тун зохимжгүй бөгөөд шударга бус үйл учраас Хубилай хаан энэ нутгийг захирч байсан өмнөх хаадын мулгуу зарлигийг өөрчилжээ.

Хотын өмнөд этгээдэд нэгэн сайхан нуур буй бөгөөд түүний эргийн тойргийн урт нь гучин бээр орчим урт, одоо энэ нуурын тухай өгүүлсү. Нуурын эргээр гайхамшигтай уран гоё хийц загвартай орд харш дүүрэн байх агаад эдгээр орд харшид тэндхийн язгууртан дээдэс, баян чинээлэг хүмүүс амьдарна. Энд олон тооны сүм хийд, онгон шүтлэгтний лам хувраг тоогүй олон. Нуурын дунд хоёр арал байх агаад тэдгээр арал дээр үгээр хэлэхэд үг хомсдмоор уран гоё хийцтэй, олон өрөө танхимтай, зөвхөн эзэн хааны л ордон баймаар гайхам сайхан загвар дүрстэй хоёр ордон байрлана. Нутгийн язгууртан дээдэс, баян чинээлэг хүмүүс найр хурим хийх, баяр ёслол тэмдэглэх болохоор эдгээр орд харшийг хөлс түрээсээр авч зугаалж цэнгэнэ.

Эдгээр ордонд ер дутуу юм гэж үгүй нэгэн зэрэг хэдэн зуун зочид гийчдийг хүлээн авч тус тусад нь үйлчлэх боломж бололцоотой. Нуурын дундах харшид ирсэн зочид гийчид нуурын усаар завь, онгоц, салаар хөвж зугаалах, амарч цэнгэх хүсэлтэй бүхэн өөрийн дуртай завь онгоцыг авч нуураар зугаалах боломжтой бөгөөд ихэнх зочид гийчид ингэж зугаалдаг. Эдгээр завь, онгоцонд арван таваас хорин зорчигч суудаг, завь онгоцны урт нь арван таван алдаас багагүй байхаас гадна хавтгай оёортой, өргөн тэнэгэр тул усан дээр ганхаж дайвалзах нь бага байдаг. Завь онгоцонд ширээ суудал бэлэн, хоол ундаагаар дүүрэн байхаас гадна салхи савираас хамгаалсан өрөө тасалгаатай, өрөө бүр цэлгэр өргөн цонхтой. Энэ нууран дээр завь онгоцоор хөвөн сэлгүүцэж зугаалах шиг амралт, алжаал тайлах боломж бололцоо өөр хаана ч байхгүй бөгөөд юутай ч зүйрлэх аргагүй сайхан тааламжтай байдаг билээ. Нуурын нэг талд мод цэцэрлэгт умбасан хотын байшин барилга, сүм дуган, орд харш сүндэрлэнэ. Ажил үйлээ амжуулж цэгцэлсэн хүмүүс энэ нууран дээр санаа амар, сэтгэл тэнүүн зугаалж цэнгэх шиг сайхан зүйл энэ хорвоо дээр өөр хаана ч үгүй билээ.

Хот дотор хаа сайгүй том том чулуун цамхагнууд байх агаад гал түймэр гарах үед хотынхон тэр цамхагт өөрсдийн үнэ цэнэтэй эд агуурсаа аваачиж хадгалдаг байна. Энэ хотод модон байшин барилга элбэг учир байн байн гал түймэр гарна. Хотын байшин барилга нь маш сайхан загвартай, зураг, сийлбэр, баримлаар чимэж гоёсон байх агаад эдгээр гоёл чимэглэлийг хийхэд хөрөнгө мөнгө хайрлаагүй янзтай. Кинсай хотын уугуул иргэд нь айван тайван амьдралын хэв маягтай, найр наадамд дуртай, хаад ноёд нь ч мөн тиймэрхүү ааш араншинтай хүмүүс байдаг байжээ. Кинсай нутгийнхан харвах намнах дадал зуршилгүй, гэр орондоо ямар ч зэвсэг хэрэглэлгүй байдаг. Тэндхийн хүмүүс алив нэгэн тэмцэл тулаан, хэрүүл маргааныг үнэн сэтгэлээсээ үзэн ядна.

Тэр хотынхон өөрсдийн эрхэлж дадсан гар урлал, дархан, мужаанаа сэтгэлийнхээ угаас, чин санаанаасаа хийж даджээ. Хүмүүс нь хоорондоо маш найрсаг элэгсэг бүхэл бүтэн дүүрэг хороод нь эвсэг эелдэг амьдралтай тул бараг л нэгэн өрх айл байна уу даа гэж андуурмаар нэгэн санаа нэгдмэл бодолтой. Биеэ биеэ хүндэтгэх хайрлах энэ ёс нь тэр хотынхны ааш араншин билээ. Хэн нэгэн эр бусдын эхнэрийг чангаах санаа өвөрлөж үг хаявал тэр хүнийг хүн бүхэн жигшин үздэг байна. Эндхийн хүмүүс зөвхөн өөр хоорондоо ийм элэгсэг найртай төдийгүй харь орны хүмүүсийг ч гүнээ хүндэтгэн харилцаж, тус дэм болохыг хичээнэ. Тэндхийн хүмүүсийн үзэж тэвчдэггүй хүмүүс бол Их хааны цэргүүд, бие хамгаалагчид юм. Эдгээр цэрэг дайчид энэ нутгийн хаад, ноёд, эрхтэн дархтаныг устган үгүй хийсэн эзэд нь билээ.

Хүмүүс нь онгон шүтлэгтэй, бүгд Их хааны албат иргэд бөгөөд цаасан мөнгөөр арилжаа хийнэ. Эрчүүд нь эмэгтэй хүн шиг торгомсог зөөлөн цагаан арьстай, царайлаг байдаг. Хүмүүс нь цөм торгомсог хувцас өмсөнө, торго ч хааяагүй элбэг. Бараг л бүх төрлийн мах идэх төдийгүй нохойн мах ч иднэ. Мөн Загалмайтнууд бол нэг нүдээрээ ч харахгүй төрөл бүрийн бузар бохир амьтны махыг ч иднэ.

Хот доторх нэг түм хоёр мянган гүүрийг өдөр шөнөгүй ээлжлэн хамгаалах бөгөөд өдөр тав, шөнө таван хүн харж манана. Эдгээр хамгаалагчид хотын доторх гэмт хэргээс урьдчилан сэргийлхээс гадна хотод бослого тэмцэл гарахаас сэргийлнэ. Манааны байрын дэргэд том модон бул байх агаад түүнд цаг, хонх байршуулсан байдаг. Цаг тутам тэр хонхыг цагийн

тоогоор цохиж хэдэн цаг болж байгааг мэдээлнэ. Шөнийн нэг цагт нэг удаа, хоёр цагт хоёр удаа гэх мэтээр хонхыг дэлдэн цаг мэдээлнэ. Тэдгээр харуул манааныхан шөнө огт унтахгүй харуул хийнэ. Өглөө нар мандмагц цаг заах хонхыг нэгэн удаа цохино, энэ нь өглөөний гэгээ тусаж өдөр эхэлсний дохио болой. Харуулууд шөнөжин хотыг эргэн манах агаад хөл хорьсон цагаас хойш гэрэл гэгээгээ унтраагаагүй айл байвал үүд юм уу цонхон дээр нь өглөө болмогц шүүхэд ирэх зар дуудлага нааж өглөө болсон хойно учир явдлыг шүүхээр шүүж тогтооно, яагаад гал гэрэлтэй байснаа тайлбарлаж чадаагүй бүхнийг баалж торгоно. Хөл хорио эхэлснээс хойш хотоор тэнэж сэлгүүцсэн бүхнийг барьж хорих бөгөөд өглөө болмогц мөн л шүүхээр шүүн тунгаана. Өдрийн эргүүл гүүрэн дээр өвдөж зовсон ядуустай таарвал аль ойр байх эмнэлэгт хүргэж өгдөг бөгөөд эмнэж эдгээгээд гаргахдаа бага сага худалдаа арилжаа эрхлэн амьдрах боломж олгоно. Хаа нэгтэй орон байшинд гал түймэр гарахыг харсан харуул бусаддаа мэдээ чимээ өгч ойр хавийнхаа гүүрийн харуултай хамсран гал түймрийг унтраах бөгөөд шатаж байгаа айлын эд хөрөнгө буюу худалдаачдын бараа таваарыг чулуун цамхгуудад хураах болон завь саланд ачин голын арал дээр аваачиж галаас авран хамгаална.

Бас нэгэн сонин зүйл гэвэл хот дотор нэгэн толгой дээр титэм хэлбэртэй модон байшин орой дээр нь барьсан байх бөгөөд хотод гал түймэр гарах, хүн ард нь бужигнах цагт тэр том модон байшинг дотроос нь дэлдэж их дуу чимээ гарган дохио өгнө, тэр байшин өөрөө том бөмбөр болдог бөгөөд түүний дуу чимээ хотод хааяагүй сонсогдоно. Энэ хотыг ингэж нүд ирмэлгүй хамгаалахын учир бол Кинсай хот зөвхөн Мэнз мужийн гол хот төдийгүй Их хааны санд асар их орлого оруулдаг бодит эх үүсвэр учраас хотод бослого тэмцэл гарахаас сэргийлэн цэргийн хүчээр хамгаалан, харуул манааг огтхон ч сулруулдаггүй билээ. Мөн энэ хотын нэртэй язгууртан дээдсийг энгийн ард олонтой нийлүүлэхгүй байхаар тооцож үргэлжид сэргийлэн хамгаална.

Хотын гудамж зээлийн замыг чулуу, туйпуу дэвсэн тэгшилж хүн болон унаа хөсөг явахад тээглэж бүдрэх юмгүй сайхан болгожээ. Харин Их хааны элч, зарлага тахрууд морьтойгоо ингэж зассан замаар давхих боломжгүй тул зам дугуу элс хайргаар дүүргэж тэгшилсэн нэгэн зурвасыг үлдээсэн байдаг. Гудамж замыг зөвхөн засаж тэгшлээд орхилгүй борооны ус, шавхай шалбаагийг урсган зайлуулах суваг татсан учир зам нь үргэлж хуурай цэвэр байдаг билээ. Энэ гудамж замаар тааран хөшиг татаж, торгон олбог дэвссэн зургаан хүний суудалтай хөлсний тэрэг, тэргэнцэр өөдөө сөөргөө хөврөх агаад тэдгээр тэргэн дотор язгууртан баячууд эхнэр хүүхэдтэйгээ залран явна. Тэдгээр тэргийг баячууд бүтэн өдрөөр хөлслөн зугаална. Ийм хөлсний тэрэг хот дотор хааяагүй газар сайгүй хөврөхөөс гадна цэцэрлэгт хүрээлэнд эздээ хүлээн өдөр өнжинө. Тэрэг хөлсөлсөн язгууртан болон баян чинээлэг хүмүүс хотын цэцэрлэгт хүрээлэнд эмс охидынхоо хамт өдөржин зугаацаж цэнгэх авай. Хотод гурван мянга (3000) гаруй халуун усны газар 185 зогсоо зайгүй ажиллана, тэд нэгэн зэрэг зуун хүнийг тав тухтай усанд оруулж, угааж амраах уужим саруул өрөө тасалгаатай. Ийм сайхан, хамгийн шилдэг, хамгийн том халуун усны газар энэ дэлхий дээр өөр хаана ч байхгүй байх шүү гэж бодном. Кинсай хотоос зүүн, зүүн хойшоох зүгийн завсар хорин таван бээр яваад Далайд (The Ocean) тулж очно, тэнд Канпу (Kan-pu) хэмээх том усан боомт байх агаад тэр боомтод Энэтхэг болон бусад харь орноос ирсэн бараа таваарыг буулган хүлээж авна. Тэгж авсан бараагаа онгоцонд шилжүүлэн ачаад хотоор дайран урсах голоор тээвэрлэж Кинсайд авчирна. Хотын зүүн хойд ба зүүн зүгт орших далай хүртэл 25 бээр зайтай ажгуу.

Мэнз орныг Их хааны зарлиг шийдвэрийн дагуу есөн ханлигт хуваан тус тусад нь есөн хан захиран суудгийг би та нарт дуулгах ёстой. Тэдгээр хан нь засаг захиргааг зөвхөн Их хааны нэрийн өмнөөс захиран тохинуулна. Эдгээр ханлигийн орлого, зарлага, ажил үйлийн талаар Их хааны төлөөний түшмэл жил болгон тайлан мэдээг Их хаанд хүргүүлнэ. Мужийн удирдлага захирагчдыг гурван жил тутамд өөрчилж сольдог журамтай бөгөөд энэ журам Эзэн хааны харьяат 140 том, жижиг баян чинээлэг хотыг ялгаагүй хамрана. Мэнз нутгийн 1200 хот суурин газрыг харж хамгаалах цэргийн хуарангууд дараах бүтэц бүрэлдэхүүнтэйгээр бүгдэд нь суурьшин суудаг гэдгийг та бүхэн саначих. Хуарангуудын доод тал нь мянган цэрэгтэй, хот орны байршил, байдлаас хамааран түм (10000) хоёр түмэн (20000) цэрэгтэй байдаг төдийгүй Кинсай мэтийн том хотуудыг гурван түмэн (30000) цэргээр сахиж хамгаалдаг гээд бодохоор хэд хичнээн цэрэг бараг тоолох аргагүй билээ. Эдгээр цэрэг нь бүгд Тартарууд биш. Тартарууд нь морин цэргүүд байх тул ус намгархаг эдгээр хотуудын дэргэд бус морьт цэргийн сургууль хийхэд тохиромжтой хуурай газраар байрлана. Харин эдгээр ус намгархаг нутгийн цэргийн ихэнх нь Катай нар, Мэнз газрын уугуул хүмүүсээс татсан цэрэг голлоно. Цэргийн албан хаах нь нутгийн иргэдэд хуулиар оноосон алба болно. Цэрэгт татагдсан мэнзүүдийг өөрийнх нь төрөлх хот суурингаас хорин өдөрчийн зайд байх хот сууринд алба хаалгах бөгөөд цэргийн албаны хугацаа нь дөрөв юм уу таван жил байдаг. Энэ дүрэм журам Катай нутгийн бусад иргэдэд нэгэн адил хамаарна.

Энэ нутгаас авдаг хураадаг татварын ихэнх нь дээр өгүүлсэн цэргийн ангиудын зардалд зориулагдана. Хаа нэгтэй, аль нэгэн хотын иргэд оршин суугчид бослого тэмцэл гаргавал зэргэлдээх хотын цэргийг дайчлан авчирч тэр бослого хөдөлгөөнийг даран номхотгодог журамтай.

Мэнз орны тухай яриагаа өндөрлөхийн өмнө энэ баян чинээлэг, том мужаас Их хааны авдаг татвар, олдог орлогыг нэрлэвэл хэн ч чихэндээ итгэх аргагүй тоо гарна, тийм учраас энэ тухай хэн ч ярьдаггүй харин санаандаа л хадгалж байдаг билээ. Энэ бүхнийг зөвхөн нүдээрээ үзсэн хүн л итгэж үнэмшинэ. Энэ нутаг орны гайхам сайн сайхны тухай номонд бичиж, үгээр дүрслэн гаргахад ихээхэн хэцүү ажил билээ. Би өөрийнхөө үзсэн харсан бүхнээ өөртөө шингээн хадгалах бодолтой байгаа тул та бүхэнд зөвхөн зах зухаас нь л өгүүлж байгаа билээ. Би одоо та нарт нэг зүйлийн тухай ярьчихаад цааш хөдөлбө. Энэ газар хүүхэд төрөхөд түүний төрсөн он, сар, өдөр, цаг минут, од гараг төөрөг заяа нь чухам ямар байх талаарх бүхий л мэдээ мэдээллийг эцэг эх нь тодорхой тэмдэглэж үлдээдэг. Хэн боловч алс хол явах, ямар нэгэн ажил үйл эхлэхдээ заавал зурхайчид очиж мэргэлүүлээд явах эсэхээ, ажил эхлэх болихоо шийддэг. Эндхийн зурхайч төлөгчид бараг л алдаа зөрөөгүй мэргэлдэг учир хүмүүс тэдэнд бүрэн итгэдэг. Хүмүүс гэр бүл болохынхоо өмнө заавал зурхайч төлөгчдөөр мэргэлүүлэх агаад тэд нар эхнэр, нөхөр болох хүмүүсийн төрсөн төөрөг заяа нийлэх эсэхийг хэлнэ. Эр эм хоёрын заяа төөрөг нийлэхээр бол гэр бүл болно, үгүй бол хурим найр хийх, сүй тавихаас татгалзана. Иймэрхүү ажил үйл эрхэлдэг зурхайч, төлөгч нар газар сайгүй байх.

Хэн нэгэн баян чинээлэг хүн өөд болоход түүний төрөл төрөгсөд, ахан дүүс, эхнэр хүүхэд нь бүгд гашуудлын цагаан ёрог хувцас өмсөцгөөн бурхан болоочийн цогцосыг даган бурханы ном тарни уншицгаан, хөгжим дуу хөгжөөн чандарлах газар руу явцгаана. Цогцсыг чандарлахын өмнө цаасаар амьтан араатан, зарц боол, эдэлж хэрэглэх эд баялгийг хийж цогцостой хамт шатаан чандарлана. Энэ бүхэн өөр ертөнцөд 186 очиход нь жинхэнэ ёсоороо

амилан өөд бологчийн эд хэрэглэл, хувцас хунар, боол шивэгчин болдог гэж итгэцгээнэ. Мэнз эрчүүд нь бусад үндэстнийг бодоход уур хороо гаргахдаа амиа егүүтгэх нь элбэг байдаг. Тэд нар хэн нэгний доромжлол дарлалыг эсэргүүцэж чадахгүй бол түүнийг дарлаж доромжилсон хүний гэрийн үүдэн дээр дүүжлэн өөрийнхөө амийг егүүтгэнэ. Үүнийг үзсэн хүмүүс үхсэн хүнийг зохих хүндэтгэл ёслолтой өөр ертөнцөд үдэх зарлага зардлыг түүнийг үхэлд хүртэл гомдоосон хүнээр гаргуулдаг байна.

Энэ хотод Мэнз орноо орхин зугтаж одсон өмнөх хааны ордон байх бөгөөд түүний гоё сайхныг ямарч үгээр дүрслэн хэлэх аргагүй тийм сайхан, өөр тийм ордон энэ дэлхийд үгүй байхаа. Миний үг хэллэг тэр ордны сайхныг дүрслэн зурж хүрэлцэхгүй нь мэдээж боловч зарим нэгэн гол гол онцлогоос нь дурдъя. Тэр хааны өвөг дээдэс нь барагцаалбал эргэн тойрон арван бээр урт, маш өндөр хамгаалалтын бэхлэлт цайз барьж түүнийгээ гурван хэсэгт хуваасан байжээ. Гол хэсэгт нь өргөн том хаалгатай, угалз хээтэй багануудаар тулж тогтоосон дээвэртэй харш байх агаад түүнийг тэнгэр өнгөтэй паалан гүйлгэж өнгөлөөд алтаар урлаж чимсэн байх. Хамгийн том танхим нь зураг хээ хуараар чимсэн, хана, багана, адар нь алтадмал. Ханан дээр нь баатар эрс, дэгжин хээнцэр эмс хатад, араатан жигүүртэн болон урьд үеийнхээ хаадын аж амьдралыг дүрслэн харуулсан төгс төгөлдөр ур хийцтэй зурагаар чимсэн байх. Энэ танхимд жил болгон нэгэн тогтсон өдөр Факфур хаан өөрийн эрхэмсэг ноёд язгууртан, сайд нар болон баян чинээлэг худалдаачид, үйлдвэрлэгчдийг цуглуулан их зөвлөгөөн хурал хийгээд найр хурим хөгжөөдөг байжээ. Энэ их найр тойд нэг буюу хоёр түмэн ихэс дээдэс уригдан ирж арваас арванхоёр хоног найрлаж зугаална. Уригдаж ирсэн зочид гийчид нь алт мөнгө, үнэт чулуу, шүр сувдаар нүдээ гартал гоёж чимсэн, хоргой торгон хувцасанд умбаж шумбасан байх тул хорвоогийн сайхан бүгд нэгэн дор цогцолсон мэт байдаг байжээ.

Баян жанжин Кинсай хотыг байлдан эзлэхээр бүслэн хаасан үед болсон нэгэн гайхам явдлын тухай та бүхэнд өгүүлсү. Мэнз улсын хаан Факфур хот, улсаа орхин амь зулбан зугтааж одмогц хотын ард иргэд бөөн бөөнөөрөө завь, онгоц, саланд ачаалан хотын хажуугаар урсах их устай өргөн голоор хөвж эхэлтэл гэв гэнэт голын ус татран тасарч, голын голдирол ёроолдоо хүртэл ил гаран хуурай сайр болжээ. Энэ хачин сонин үзэгдлийг дуулж мэдсэн Баян жанжин ирж дүрвэгсдийг хот руу буцаан гэр оронд нь хариулжээ. Гэтэл голын усыг хааж, голын голдирлыг таглан хэвгэх нэгэн аварга загас байсан бөгөөд түүний урт нь элбэг зуун алд, биеийн овор хэмжээ нь урттай нь харьцуулашгүй том байснаас гадна бүх бие нь үсээр хучигдсан байжээ. Олон олон хүн тэр аварга загасны махнаас идсэн бөгөөд махсаг хүмүүс дараа нь бүгд үхсэн билээ. Ийм аварга загасны хатаасан толгой онгон шүтлэгтний нэгэн сумд хадгалагдаж байхыг эрхэмсэг Марко гуай өөрийн нүдээр үзсэн гэдэг билээ.

Одоо би та нарт Кинсай хот болон түүний харьяа хотууд, Мэнз орны есөн мужаас Их хааны авдаг алба татварын тухай өгүүлье. Эхлээд давсны тухай ярья учир нь давсны татвар нь орлогын ноён нурууг босгодог билээ. Энэ хотын давсны татварын нэг жилийн орлого нь дунджаар наян түмэн (80 tomauns) алт болдог. Нэг түмэн алт гэдэг нь долоон түмэн (70000 saggi) саггитай тэнцэх агаад жилдээ таван сая зургаан буман (5600000saggi) сагги алт болдог гэсэн үг. Нэг сагги гэдэг нь нэг алтан флориноос юм уу, нэг алтан дукатаас их хэмжээ билээ. Ингээд тооцож үзэхээр тэр орлогын хэмжээ нь толгой эргэм их мөнгө юм шүү.

Давс их олзворлодог арга боломж нь зуны халуунд далайн ус хотын ойролцоох далайн булан тохой болон түүнийг тойрсон намагт түрэн орж ууршсаар тэнд нь хэдэн давхар давсан үе тогтох бөгөөд тэр нь Мэнз орны таван ханлигийг бардаагаар хангадаг хэмжээ билээ. Энд иш татан ярьсан зүйл бол зөвхөн давсанд л хамаатай билээ. Манзи орон дэлхийн бусад бүх орны үйлдвэрлэдэг элсэн чихрийг нийлүүлснээс их элсэн чихэр үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь асар их орлогын эх үүсвэр болдог. Би татвар төлдөг зүйл бүрийг тус тусд нь тоочилгүй тэднийг нэгтгэн нэг бүлэг болгоод яривал та бүхэнд ойлгомжтой байх болов уу гэж бодном. Жишээлбэл: Халуун ногоо 187 болон амттаны бүлгээс 3.3 хувийн татвар авдаг. Хотуудал газраар болон усан замаар зөөж тээж оруулж ирж байгаа бүхий л бараа таваараас мөн ялгаагүй 3.3 хувийн гаалийн татвар авдаг. Харин далайгаар тээж ирж байгаа бараа таваараас 10 хувийн гааль татна. Тариа будаа, тариалангийн газраас мөн ялгаагүй 10 хувийн татвар авах буюу эсвэл ургацынхаа аравны нэг хувийг Их хааны санд нийлүүлнэ. Цагаан будааны архи, модны нүүрс болон дээр миний өгүүлсэн арванхоёр төрлийн мэргэжлийн холбоод, тэдний тус бүрийн нэг түм хоёр мянган (12000) нэгж бүрээс татвар авах бөгөөд тэдний нийлбэр дүн нь асар их хуримтлал болдог. Дээр миний нэрлэсэн мэргэжлийн холбоод тус бүрийн татвар нь асар их орлогын эх үүсвэр болдог. Ялангуяа торгоноос бол 10 хувийн өндөр татвар хураах тул асар их орлогын хуримтлал үүсгэнэ. Арван хувийн татвар төлдөг өөр олон олон бүлэг зүйл буй билээ. Марко Поло миний өөрийн сонсож мэдсэнээр нэг жилийн татварын орлогын хэвийн хэмжээ нь давсыг оролцуулалгүй тооцоход 210 түмэн алт болдог бөгөөд энэ нь арван дөрвөн сая долоон буман (14 700 000) алтан зоостой тэнцэнэ. Энэ бол ерөнхийлж баримжаалсан тоо юм шүү. Энэ тоо бол зөвхөн Мэнзийн есөн мужаас хураадаг татварын хэмжээ билээ. Эзэн хааны хурааж татаж байгаа энэ их татвар нь эзэлсэн орон, хотуудыг сахин хамгаалж байгаа цэргийн хэрэгцээнд зарцуулагдана.

Одоо би та бүхэнд маш тодорхой ярьж танилцуулсан Кинсайг орхин замдаа гарья гэж шийдэж байна.

Кинсайгаас гарч зүүн өмнө зүгийг чиглэн өдөржин явахад нүд булаам ганган хийц загвартай харшаар дүүрэн, эргэн тойрон жимсний цэцэрлэгээр хүрээлүүлсэн тосгон сууринг дайран өнгөрнө. Энд хоол хүнс элбэг, амьдрах орчин цэвэр цэмцгэр ажээ. Өдөржин явсан аяны эцэст Танпижү (Tanpīju) хэмээх том сайхан хотод хүрэх бөгөөд тэр хот Кинсай хотод захирагдах бөлгөө. Хотын оршин суугчид нь Их хааны албат харьяатууд бөгөөд цаасан мөнгөөр наймаа арилжаагаа хийнэ. Тэдгээр хүмүүс цөм онгон шүтлэгтэн бөгөөд өөд бологсдоо миний дээр өгүүлсний адилаар шатааж чандарлана. Хүмүүс нь худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал эрхлэн амьдарцгаана, энэ газрын тухай үүнээс өөр ярих онцын сонин зүйл үгүй тул аяллаа цааш үргэлжлүүлье.

Танпижүгээс гараад гурван хоногийн турш зүүн өмнөт зүгийг барин аялахад маш олон хот тосгодыг дайран өнгөрөх агаад энэ замд тааралдах бараа таваарын нэр төрлийг нэрлэж хэлэхийн аргагүй олон боловч маш хямдхан байсан. Хүмүүс нь онгон шүтлэгтнүүд бөгөөд Их хааны албат харьяат нар хот нь Кинсайн захиргаан дор оршино. Энэ аяны төгсгөлд Вужу (Vūju) хэмээх том хотод хүрнэ. Эндхийн хүмүүс нь онгон шүтлэгтнүүд, Их хааны албат харьяатууд, худалдаа гар урлал эрхэлнэ. Бүгд Кинсайн захиргаан дор оршино. Өөр онцлоод байх зүйл үгүй тул аяллаа үргэлжлүүлсүгэй. Вужугээс гараад зүүн өмнө зүгийг баримжаалан хоёр хоног явахад үргэлжилсэн олон хот тосгод дайралдах нь хотоос гараагүй мэт сэтгэгдэл

төрүүлнэ. Хоол хүнсний зүйл элбэг дэлбэг байх. Энэ нутагт өөр хаана ч тааралдахгүй хамгийн бөх, хамгийн урт зэгэс ургана. Тэр зэгэсний бүдүүн нь дөрвөн төө, урт нь арван таван тохой хүрнэ. Үүнээс өөр сонирхуулаад байх зүйлгүй тул аяллаа үргэлжлүүлсээр хоёр хоног өнгөрөхөд Гиюжү (Ghiuju) хэмээх нэгэн том хотод хүрнэ. Энэ хот Их хааны харьяа боловч засаг захиргааны хувьд Кинсайд захирагдана.

Гиюжүгээс гараад зүүн өмнө зүгийг барин дөрвөн хоног аялахад олон хот тосгодыг дайран өнгөрнө. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, Их хааны албат иргэд боловч засаг захиргааны хувьд Кинсайд захирагдана. Хүмүүс нь худалдаа арилжаа, гар урлал эрхлэнэ. Энэ нутагт араатан жигүүртэн элбэг учир ан ав их хийнэ. Асар том биетэй зэрлэг догшин арслан ихтэй. Ер нь Манзи нутагт хонь огт байдаггүй, харин үхэр, ямаа, гахай элбэг. Өөр онцлож цохоод байх сонин зүйл ховор тул аяллаа цааш үргэлжлүүлье. Дөрвөн хоногийн аяны эцэст Чаншан (Chanshan) хэмээх нэгэн том хотод хүрнэ. Энэ хот том голын дундах арал дээрх толгодын оройд оршино. Засаг захиргааны хувьд Кинсайд захирагдах боловч Их хааны эзэмшил газар бөгөөд хүмүүс нь онгон шүтлэгтнүүд худалдаа арилжаа, үйлдвэр, гар урлал эрхлэнэ. Өөр цохож тэмдэглээд байх зүйл үгүй учир аяллаа цааш үргэлжлүүлье.

Чаншанаас гараад гурван хоногийн турш олон хот тосгодтой, худалдаачид, гар урчууд голлон нутагшиж суусан нэгэн сайхан орныг дайрч өнгөрнө. Энэ орон Их хааны эзэмшил газар орон боловч засаг захиргааны хувьд Кинсайд харьяалагдана. Энэ нутаг араатан жигүүртэн элбэг учир ав хоморго их хийнэ. Өөр ч онцолж яриад байх гоц гойд зүйл үгүй учир аяллаа цааш үргэлжлүүлье. Гурав хоногийн аяны төгсгөлд Кужу (Kuju) хэмээх нэгэн том хотод хүрнэ. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, Их хааны харьяат албат нар. Кужу хот нь Кинсайн засаг захиргаанд харьяалагддаг сүүлчийн хот бөгөөд үүнээс цааш Манзийн есөн ханлигийн өөр нэгэн ханлигийн хил хязгаарыг алхах агаад түүнийг Фучау (Fu-chau) гэнэ.

Кинсайн ханлигаас гараад Фучаугийн ханлиг хүртэл зургаан хоногийн турш аялахдаа өндөр уулс, өргөн хөндий талыг туулан олон хот тосгодыг дайран өнгөрнө. Хүмүүс нь онгон шүтлэгтэнгүүд, Их хааны албат харьяатууд бөгөөд энэ мөчөөс эхлэн би Фучаугийн засаг захиргаатай харьцах болж байна. Энэ нутгийнхан худалдаа арилжаа, үйлдвэр, гар урлал эрхлэнэ. Амьдрал ахуй нь хангалуун, асар том бие галбиртай зэрлэг догшин арслангаас гадна ан араатан элбэг тул ав хоморго их хийнэ. Цагаан гаа, таван халуун газар сайгүй элбэг тул Венецийн нэг задгай мөнгөөр 80 фунт шинэхэн цагаан гаа худалдаад авчихна. Энэ нутагт олон төрлийн жимс ихтэйн дотор хач гүргэм шиг нэгэн жимс байх агаад амт, үнэр нь яг л хач гүргэм гэсэн үг. Нутгийн уугуул иргэд нь мах л бол юуныхыг ч хамаагүй иднэ, тэр ч атугай дайн дажинд шарх олоод үхсэн хүнийхээ махыг ч иднэ. Харин жам ёсоороо өөд болсон хүний мах, биед хүрдэггүй. Шархдаж үхсэн хүний мах бол тэдэнд дээд зэргийн амттанд тооцогдоно. Тэр нутгийн цэрэг дайчид нь үсээ хусуулж, чихээ цоолуулан нүүр царайгаа сэлэмний өнгөт хөх будгаар эрээлэн будна. Цэргийн тэргүүлэгч жанжнаас бусад нь бүгд явган явах агаад сэлэм, жадаар зэвсэглэнэ. Тэдгээр цэрэг нь дайнд алсан хүнийхээ цусыг ууж, махыг иднэ, эдгээр цэрэг шиг цусанд шунасан зэрлэг амьтад энэ хорвоод өөр үгүй билээ.

Энэхүү зургаан хоногийн аяны замын гуравдахь хоногийг туулсны эцэст Киеннинфу (Kien-ning-fu) хэмээх Их хааны эзэмшил хотод хүрнэ. Энэ хотод энэ хорвоод өөр хаана ч байхгүй гурван сайхан гүүр бий. Тэдгээр гүүрийн урт нь тус бүр нэгэн бээрээс илүү, өргөн нь есөн



алд, чулуугаар барьж гантиг баганаар чимсэн хосгүй гоё гүүрнүүд билээ. Нэг ийм гүүр барихад ямархан их зардал мөнгө гарахыг төсөөлөн хэлэх ч аргагүй. Эндхийн хүмүүс худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал эрхлэнэ. Энд цагаан гаа, таван халуун, торгоноос элбэг юм алга. Хөвөн даавуу асар ихээр нэхдэг бөгөөд будмал нэхмэл утсаар бүх л Манзи орныг хангана. Энэ нутгийн бүсгүйчүүд нь маш царайлаг дэгжин. Нэг сонин зүйл гэвэл ямарч өд сөдгүй мөртлөө муурын үс шиг зөөлөн үстэй хав хар тахиа байх агаад маш олон өндөг гаргана. Өндөг нь яг л манайхны тахианых шиг идэхэд амттай гэж жигтэйхэн. За өөр ч нэг их сонирхуулаад байх зүйлгүй тул аянаа үргэлжлүүлье.

Үлдэж байгаа гурван өдөрчийн замыг худалдаачид, гар урчууд хөлхөлдсөн, бараа таваараар хахсан хот тосгодоор дайран өнгөрнө. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтэн, Их хааны албат харьяатууд. Энэ газар торго маш элбэг мөн ав хоморго ч их хийдэг юм байна. Том биетэй зэрлэг догшин арслан олонтой агаад тэдгээр арслангууд аянчид жинчдэд маш халгаатай, ихээхэн осолтой араатан болой. Гурван хоногийн аяны төгсгөлд Ункэн (Unken) хэмээх хотод хүрнэ. Энэ хот бол элсэн чихрийн үйлдвэрийн төв билээ. Их хааны ордны хэрэгцээний бүхий л чихрийг эндээс авдаг тул орлого 188 сайнтай байдаг.

Энэ газар орныг Хубилай хаан байлдан эзлэхээс өмнө энэ нутгийн уугуул иргэд элсэн чихрийг юунаас гаргаж авах, яаж цэвэрлэж Мисир оронд хийдэг шиг амтат сайхан чихэр хэрхэн болгохыг огт мэддэггүй байжээ. Урьд нь чихрийн манжинг чанахад нэг л бөөн хар цавуу шиг юм болдог байв. Харин хааны ордонд байдаг Мисир хүмүүс энэ цавуу шиг хар зүйлээс хэрхэн амтат чихэр гаргаж авах, яаж цэвэрлэх, яаж хэв хэлбэрт оруулахыг нутгийнханд зааж сургажээ. Цэвэрлэхдээ тэр цавуу шиг хар зуурмагийг нэгэн төрлийн модны нүүрсээр шүүдэг байна. Энд өөр сонирхоод байхаар зүйл үгүй тул цаашаа аялъя.

Ункэнээс арвантаван бээрийн зайд Фучау хот орших юм. Одоо би энэ хотод үзэж харсан зүйлээсээ та нарт ярьж өгье.

Юуны өмнө Фучау хот нь Чонча (Choncha) ханлигийн төв бөгөөд Манжийн есөн мужийн нэг нь болой. Энэ хот бол маш олон худалдаачид, гар урчууд төвлөрөн суусан худалдааны чухал төв билээ. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, Их хааны албат, харьяатууд. Энэ хотын дэргэд эзэн хааны цэргийн томоохон нэгтгэл анги байрлана. Тэр нэгтгэл ангид хэд хэдэн арми багтана. Учир нь энэ нутагт монголчуудыг эсэргүүцсэн бослого тэмцэл байн байн гардаг газар билээ. Нутгийн уугуул иргэд нь энэ хорвоогийн амьдралын үнэ цэнийг хэтэрхий хямдаар үнэлэдэг төдийгүй хүний амь, амьдралыг юман чинээ тоодоггүй, бас өөрсдийн нь орон байр өндөр уулсаар бат хамгаалагдсан газарт оршдог гэж үзэцгээн бослого хөдөлгөөн байн байн гаргаж хааны илгээсэн захирагч толгойлогчдийг алж устгадаг билээ. Ийм учраас эдгээр хүмүүсийн бослого тэмцлийг няц дарахын зэрэгцээ тийм бослого тэмцэл гаргуулахгүй байх үүднээс ийм олон цэрэг армийг энд байршуулсан байдаг.

Хот дундуур их устай, нэг бээр орчим өргөн гол урсах бөгөөд голын ёроолд бат бэх бөхөлсөн хөвдөг завь, салан дээгүүр тавьсан хөвдөг гүүртэй. Энэ хязгаар нутагт асар олон арслантай агаад тэднийг яаж барьдаг талаар өгүүлсү. Арслан явах зам дээр хоёр гүн нүх ухаж хооронд нь нэг алд илүү урт хуурай хамар үлдээнэ. Тэр нүхээ эргэн тойрон хашаагаар хашиж ганцхан газар орох үүд үлдээнэ. Шөнө болохоор хоёр нүхний хоорондох хуурай хамар дээр нэг гөлөг аргамжиж орхино. Тэр гөлөг нь голдуу цагаан өнгөтэй байх бөгөөд шөнөжин хуцаж, гасалж

цовхчино. Арслан хэдийвээр алс хол байх авч гөлөгний гаслаан гийнаанийг сонсонгуут түүний уур хилэн бадран гөлгийг идэхээр ирээд онгорхой үүдээр орж үсрэн дүүлэн буухдаа гүн нүхэнд унана. Өглөө гөлөгний эзэн хүрч ирж арсланг алаад махыг нь идэж арьсыг нь арилжан шаг хийсэн орлого олно. Хэрвээ арсланг амьдаар нь барих болвол тусгай багажаар нүхнээс татаж гарган авна.

Энд бас үнэгтэй төстэй *pariones* (одой мич) гэх нэгэн амьтан байдаг. Тэр амьтан чихрийн манжинг идэж гэмтээж их хохирол учруулна. Худалдаачдын жингийн цуваа хаа нэгтэй буудаллан хоноход энэ одой мич өөрийнхөө даах чинээгээр эд барааг нь хулгайлан зөөх, урж тасдах зэргээр ихээхэн хор хохирол хүргэдэг байна. Тийм болохоор хүмүүс түүнийг барьж авах элдэв арга сүвэгчилсний нэг нь том гэгч хулууны хальсанд уг амьтны толгой дөнгөн данган багтах нүхнүүд гаргаад дотор нь жаахан өөх тавиад газар хөмөрч орхидог байна. Өөхний үнэр авсан одой мич толгойгоо нүхээр шургуулан ховдоглож зүтгэсээр хулууны том хальсыг хүзүүндээ углачихаад салгаж ч чаддаггүй, зугтааж ч чаддаггүй болохоор нь аянчид барьж аваад алж махаар нь амттай хоол хийж идээд, арьсыг нь өндөр үнээр борлуулдаг байна. Энэ оронд маш том биетэй галуу үржүүлдэг бөгөөд нэг галуу нь 24 фунт татах жинтэй байдаг. Энэ галуу нь эрүүн дороо том хүүдийтэй, хамар дээрээ хунгийх шиг овгор боловч түүнээс том хаалттай байдаг.

Энэ нутагт элсэн чихэр маш ихээр үйлдвэрлэнэ. Мөн энэтхэг орноос авчирсан тана, сувд, эрдэнийн чулуу хааяагүй зарна, учир нь Энэтхэгээс ирэх усан онгоцтой худалдаачид энэ хотыг дайрч гарна. Үүнээс гадна тэр хотоос холгүй Зайтон (*Zaiton*) нэртэй далайн том боомт байх бөгөөд тэр усан боомтод асар их бараа таваар ачсан хөлөг онгоцнууд Энэтхэг орноос ирж Зайтоноос Фучау хүртэл том голоор хөвөн хотод ирнэ. Эдгээр усан онгоцоор төрөл бүрийн багаж төхөөрөмж, бараа таваар Энэтхэгээс ирэх агаад энд ёстой л “ногоон хурганы арьс нохойн битүү туурай”-наас бусад нь байх. Энэ хотод ховор нандин жимстэй цэцэрлэгт хүрээлэн байх. Фучау хотод олдохгүй зүйл, дугуу гуцуу юмгүй ёстой л үлгэрийн гэмээр гайхамшигтай хот 189 билээ.

Эрхэмсэг Марко гуайн ярьсан нэгэн зүйлийг энэ номонд заавал бичиж үлдээх ёстой юм гэдгийг би ойлгож байгаа учир өчсүгэй. Нэгэн удаа Марко гуай өөрийн авга ах Маффео гуайтай хамт энэ Фучау хотод иртэл энэ нутаг орон болон хотыг нэвтэрхий сайн судалж таньсан нэгэн Сарацин эр дараах зүйлийг тэр хоёрт ярьсан байдаг: “Эндхийн ...тийм гэдэг газар, нэгэн ...тийм гэдэг шашны төрлийн хамтлаг байдаг. Гэвч тэр шашин нь лав л онгон шүтлэгийн шашин биш учир нь тэнд нэг ч онгон байдаггүй, бас гал шүтэгчдийнх ч биш. Тэд Магометийг ч шүтдэггүй, загалмайтан бол бүр ч биш гэдгийг би сайн мэдэж байна гээд хамт очиж ярилцаж сонирхоё, та хоёр тэднийг ямар нэгэн хэлбэрээр, аль нэгэн ажилд ашиглаж хэрэглэх ч байж мэднэ” гэжээ. Ингээд тэр гурав тэдгээр хүмүүстэй уулзаж тэдний ёс, зан заншил, шашин мөргөлийн тухай асууж лавлахад тэдгээр хүмүүс ихээхэн болгоомжлон цэнэж олигтой юм ярьж өгөхгүй байв. Маффео гуай Марко гуай хоёр: “Та бүхэн биднээс айж болгоомжлох хэрэггүй, бид та нарт муу муухай юм хийхгүй, харин та бүхний амьдралын нөхцөл байдлыг ойлгон тус дэм болох гэсэн юм” гэж хичнээн тайлбарлавч тэдгээр хүмүүс тэднийг Их хааны илгээсэн заншлаачид тэдний шашин, зан үйлийг судлахаар ирж гээд тун ч болгоомжилсоор байв.

Гэвч Маффео болон Марко Поло нар энд өдөр болгон ирж тэдгээр хүмүүсийн амьдрал ахуй, ёс заншилтай улам улам ойртон танилцаар байгаад тэдний шүтлэг нь загалмайн шашны нэгэн урсгал гэдгийг олж мэджээ. Тэдэнд нэгэн ном байдаг байв. Маффео, Марко хоёр тэр номыг үг үгээр нь нэг хэлнээс нөгөөд орчуулан утга санааг нь тунгаан үзсээр байгаад psalter (дуулалт номлол) гэсэн нэгэн үг байгааг олжээ. Та бүхний энэ шашин шүтлэг чухам хаанаас, юунаас уламжлагдан ирсэн бэ? гэж асууж лавлахад “Бидний өвөг дээдсээс уламжилж ирсэн” гэцгээж байв. Тэдний мөргөлийн сүмд гурван зураг байсан агаад тэр зураг дээр “далтын сургаал”-ыг хорвоо дэлхийгээр түгээн номлож явсан гурван архадыг дүрсэлсэн байлаа. Тэдгээр хүмүүс энэ гурван архад бол бидний мөргөж шүтдэг шүтээн, бидний өвөг дээдсээс уламжлагдан долоон зуун (700) жилийн турш шүтэж мөргөсөөр ирсэн бурхад маань гэв. Харин тэдний дунд урт удаан хугацаагаар шашин номын сургалт яваагүй учир загалмайн шашинд гарсан үндсэн өөрчлөлт шинэчлэлийг огт мэдэхгүй байцгаав. Гэвч тэд нар эцэг өвгөдөөс уламжлагдан ирсэн энэ номондоо, дээрх гурван архаддаа мөргөж шүтсээр байна гэв.

Үүнийг сонссон Маффео, Марко хоёр ийн өгүүлрүүн: “Бид хоёр загалмайн шашинтай, та нар ч мөн ялгаагүй загалмайтан ажээ. Та нар Их хаанд элч зараалаа илгээж бид ийм шашин шүтлэгтэй гэдгээ тайлбарлан таниулж, та нарын шашин мөргөлийг хуульчлан зөвшөөрхийг гуй” гэж зөвлөжээ. Учир нь тэдгээр хүмүүс онгон шүтлэгтний дэргэд өөрийн шашнаа ил цагаан явуулж, мөргөж шүтэхээс машид эмээн болгоомжилдог тул нууцхан шүтэцгээдэг байжээ. Тэгээд тэд нар Маффео, Марко нарын зөвлөсний дагуу хоёр төлөөлөгчөө Их хаанд элч болгон илгээхэд тэднийг хааны ордны загалмайн шашин хариуцсан түшмэл хүлээн авчээ.

Сонин болгож сонсоход: Их хааны ордны загалмайн шашин хариуцсан түшмэл хоёр элчийг Их хааны дэргэд хүлээн авч тэднийг яах аргагүй загалмайн шашинтан учир тэдний энэ шашин мөргөлийг хуульчлан зөвшөөрөх учиртайг Их хаанд айлтгатал тэнд байсан онгон шүтлэг хариуцсан түшмэл эрс татгалзан эдгээр хүмүүс угаасаа онгон шүтээн шүтдэг байсан тул тэр л хэвээрээ байх ёстой гэснээр Их хааны дэргэд хоёр тал маргаан үүсгэжээ.

Тэдний маргааныг удтал сонсож суусан Их хаан ихэд дургүйлхэн маргааныг таслан зогсоож хоёр элчийг дуудан уулзаж: Та нар загалмайн шашнаа шүтэх үү? эсвэл онгон шүтлэгтэн болох уу? гэж асуухад хоёр элч: Хэрвээ Их хаан та болгоон соёрхвол бид загалмайн шашинтан хэвээр үлдмээр байна гэцгээв. Тэгээд Их хаан: Эдгээр хүмүүсийг загалмайн шашинтан гэдгийг хүлээн зөвшөөрч тэдэнд шашин мөргөлөө чөлөөтэй явуулах эрхийг хуулиар олгож баталгаажуул гэсэн зарлиг буулгав. Үүнийг олж мэдсэн Манзи газрын далан түмэн (700000) иргэд тэр шашныг шүтдэг загалмайтан байсан нь тодрон илэрчээ.

Өөр бусад ажилдаа эргэн орж Фучау хотыг орхин одоод нэгэн голыг хөндлөн гараад зүүн өмнөт зүгийг барин таван хоног аялахад байгалийн баялаг ихтэй, олон хот тосгодтой, газар нутгаар дайран өнгөрнө. Энэ нутагт уулс, хөндий, тал газар ээлжлэн үргэлжилнэ. Зарим газар нь өргөн шигүү ойн зурвастай, тэнд нь гаврын мод ургана. Энд араатан жигүүртэн элбэг тул ан ав хийцгээнэ. Хүмүүс нь бараа таваар их хэмжээгээр үйлдвэрлэн, гар урлал эрхлэх агаад бүгд Их хааны албат харьяатууд билээ.

Таван хоногийн аяны төгсгөлд Зайтон хэмээх усан боомт хотод хүрнэ. Энэ боомт хотод Энэтхэг орноос ирэх бүх төрлийн хөлөг онгоцны зогсоол бөгөөд Энэтхэгээс үнэ цэнэтэй

тоног төхөөрөмж, үнэт эрдэнийн чулуу, дээд зэргийн чанартай сувд эрдэнэ дүүрэн ачиж авчирна. Энэ хот нь мөн Манзи нутгийн худалдаачдын усан боомт болдог. Энэ боомтод Энэтхэгээс ирсэн эрдэнийн чулуу, сувд эрдэнэ бусад бүхий л тоног төхөөрөмж, эд барааг эндээс Манзи нутгаар тархаан худалдах төв болдог билээ. Түүнээс цаашлаад үзвэл Мисирийн Александрийн усан боомтод нэг хөлөг онгоц дүүрэн халуун ногоо хүргэх, эсвэл Загалмайтны ертөнцөд хүргэх халуун ногоо тээх зуу зуун хөлөг онгоц Зайтон буудалд ирнэ. Зайтоны болон Александрийн усан боомт нь энэ хорвоогийн хамгийн том, хамгийн их хөл хөдөлгөөнтэй, хамгийн их бараа таваар орж гардаг, зөөж тээвэрлэдэг усан боомтууд болой.

Энэ хот болон усан боомтоос Их хааны санд орж байгаа орлого бол агуу их гэдгийг би гэрчлэн хэлж чадах байна. Энэтхэгээс ирж байгаа хөлөг онгоц, түүнд ачсан ачаа, бараа тус бүрээс 10 хувийн гааль татна. Бага оврын ачаа бараа тээвэрлэхээр хөлөг онгоц түрээслэхэд 30 хувийн, чинжүү тээвэрлэхэд 44 хувийн, агар, зандан мод болон овор ихтэй ачаа бараа тээвэрлэхэд 40 хувийн гааль татвар авна. Худалдаачид хөлөг онгоц түрээслэн авах, гааль татварыг төлөхөд ачиж ирсэн бараа таваарынхаа тал хувийг өгдөг боловч үлдэж байгаа хагасыгаа борлуулахад дээрх бүх татвараа нөхөөд бас бараа, таваар ачаад буцах боломжтой байдаг учраас хэн ч юу ч ярьдаггүй, хэл ам таталдаггүй билээ. Дээрхээс үзэхэд энэ хот Их хааны санд тун их орлого оруулдаг нь тодорхой. Зайтон боомт орчмоор далайд цутгадаг их устай том гол нь маш эрчтэй урсгалтай 190 билээ. Голын урсгалын хүч, хурдыг сааруулахын тулд суваг татан голын урсгалыг хэд хэд хувааж урсгажээ. Эдгээр суваг салаан дээгүүр таван том гүүр тавьсан байх агаад хамгийн том урт нь гурван бээр хүрнэ. Гүүрийн тулгуурыг дээр дээр нь тавьж хураасан чулуугаар өрж хийсэн байна.

Эндхийн хүн ард нь онгон шүтлэгтэй, Их хааны албат харьяатууд. Энэ сайхан нутагт хүнд хэрэгтэй бүхэн буй бөгөөд оршин суугчид нь найрсаг тайван хүмүүс хөнгөн зугаа цэнгэл, амрах наадах дуртай. Энэ нутагт Дээд Энэтхэгээс хүмүүс олноороо ирж суурьшин сууцгаана.

Энэ мужийн Тинжу (Tinju) хэмээх хотод янз бүрийн хэлбэр хэмжээтэй шавар ваар хийдэг тухай өгүүлсү. Эдгээр ваар нь гайхам гоё чамин, энэ хотоос өөр хаана ч хийдэггүй, эндхийн ваарыг хорвоогийн бүхий л газар орноор тархаан худалдана. Энэ хотдоо бол ваар шиг элбэг бөгөөд хямд бараа үгүй билээ, венецийн задгай мөнгөөр та нар гурван ваар худалдаж авч болно. Эдгээр ваар тавгийг тусгай газраас ухаж гарган овоолоод нар, бороо, салхинд гуч, дөчин жил хатааж хадгалсан нунтаг шороо болон шавраар хийнэ. Энэ урт удаан жилүүдэд шороон овоолго бүрэн цэвэрших агаад ийм шороогоор хийсэн ваар сав хөхөмдөг туяа татсан гайхам сайхан гялалзсан өнгөтэй болдог. Ваар сав хийх шороон овоолго хийж байгаа хүн бол тэр овоолгоо үр хүүхэд, хойч үедээ бэлтгэн үлдээж байгаа гэсэн хэрэг 191. Өөрөө бол тэр шороон овоолгоор юм хийж амжихгүй л өөр ертөнцөд одох нь их байдаг. Энэ хотын оршин суугчид нь өөрийн гэсэн өвөрмөц хэл яриатай. Ер нь бол Манзи муж нь нэг хэлтэй, нэг бичиг үсэгтэй боловч Ломбардийн болон Провансалийн францууд өөр өөр аялга дуудлагаар ярьдаг шиг Манзийн газар нутаг, мужууд нь өөр өөрийн өвөрмөц хэл яриатай.

Фучаугийн ханлигаас Их хааны татдаг албан татвар, гувчуур нь Кинсайгаас 192 авдаг албан татвар, гувчуураас ихүүл гэхээс багагүй билээ. Манжи газрын есөн мужаас дөнгөж Янчау, Кинсай, Фучау гурвын тухай л та бид маш дэлгэрэнгүй тодорхой ярилцлаа. Бусад зургаан мужийн талаар яривал ярих хэлэх зүйл тоймгүй их байгаа боловч та бүхнийг яриагаараа уяж

залхаахгүйн тулд ингэс гээд зогсоё193. Энэхүү гурван мужийн талаар ийнхүү дэлгэрэнгүй тодорхой ярих учир нь бол Эрхэмсэг Марко Поло гуай эдгээр гурван мужийг өөрийн биеэр хөнлөн гулд туулж, нүдээрээ харж, чихээрээ сонссон тул Марко Поло гуай ингэж тов тодорхой өгүүлсэн гэж бодож байна. Бусад зургаан мужийн талаар Марко Поло гуай мэдэх боловч газар нутгийг нь өөрийн биеэр туулаагүй учраас нэг их дэлгэрэнгүй өгүүлээгүй гэж бодож байна.

Манзи болон Катай орны тухай, тэр нутагт тархан суурьшсан хүн ардын тухай, тэндхийн араатан жигүүртний тухай, тэндээс олж олборлож болдог алт мөнгө, үнэт эрдэнийн чулуу, шүр сувдны тухай, тэнд үлйдвэрлэдэг бараа таваар, гар урлалын бүтээлийн тухай болон өөр олон олон сонин сайхныг та бүхэн сонсож дууллаа. Гэвч бидний номондоо оруулах гэсэн, өгүүлэх гэсэн зүйл маш олон байгаа бөгөөд бид ч оруулна гэж бодож байна. Энэ номонд Энэтхэг орны тухай, энэтхэгчүүдийн тухай, зөвхөн тэр газар нутагт байдаг сонин хачныг ертөнцийн хаанаас ч эрээд олохгүй тул энэ тухай өгүүлэх нь зүйн хэрэг гэж бодож байна.

Тэгвэл би одоо та нарт нэгэн баримтыг өгүүлсү. Эрхэмсэг Марко Поло гуай Энэтхэг оронд урт удаан хугацаагаар байж тэндхийн ажил үйл, дэг жаяг, гааль, худалдааг нягт нарийн судалж танилцсан хэрээрээ Энэтхэгийн талаар хамгийн үнэн зөв мэдээ, мэдээллийг өгч чадна гэж бодож байна. Марко Поло гуайн ярих зүйл нь ямар ч хүний ухаан санаанд ормооргүй хачин сонин зүйлс байгаа тул та бүхэн “амаа ангайлган, нүдээ бөлтийлгөн” сонсох нь дамжиггүй. Марко Поло гуайн ярих үнэн түүхийг тэр хэвээр нь буулган номондоо оруулна. Та бүхэн энэ яриаг сонсоход бэлэн болсон бол эндээс яриагаа эхэлье.

## Зургаадугаар бүлэг

### Хятадаас Энэтхэг орох замд



Би та бүхэнд хорвоогийн олон олон газар орноор аялсан тухайгаа аль хэдийн тов тодорхой ярьж өгүүлсэн тул одоо аяныхаа жолоог Энэтхэг орны зүг залж тэр орны олон гайхамшгийн тухай та бүхэндээ ярьж өгье. Юуны өмнө та бүхэнд Энэтхэг оронтой худалдаа наймаа хийдэг худалдаачдын хөлөг онгоц, тэдний аяллын тухай өгүүлсү<sup>195</sup>.

Хөлөг онгоцоо юугаар, хэрхэн, яаж хийдэг талаар өөрийнхөө мэдэх бүхнийг та нарт ярья. Хөлөг онгоцыг гацуур модоор хийдэг. Хөлөг онгоц нь нэг тавцантай байх агаад тэрхүү тавцан дээр дор хаяж жаран өрөө тасалгаатай сууц барьж байршуулна. Хөлөг онгоц бүр нэгэн чиглүүлэх залуур, дөрвөн шурагтай байна. Мөн хоёр шураг нэмж байршуулах тохиолдол олон. Хөлөг онгоцны их биеийг өвч хоёр давхар банзаар хийж, хадаасаар бэхэлнэ.

Зарим томоохон хөлөг онгоцны дотор талыг арвангурван хэсэгт хуваан бөх бат банзаар таслан хааж бэхэлсэн байдаг. Хөлөг онгоц усан доторх шүрэн хад мөргөөд юм уу, эсвэл идэш хайсан халим хөлөг онгоцыг мөргөж энд тэнд нь цоолчихвол ус тэрүүхэн хэсэгт нь нэвчээд бусад хэсэгт нь ус нэвчилгүй хуурай үлддэг. Хаагуур ус нэвчиж байгааг усан цэргүүд андахгүй бөгөөд ус нэвчсэн хэсгийн ачаа тээшийг хуурай хэсэгт шилжүүлэн зөөгөөд нэвчсэн усыг шавхаж, цоорсон хэсгийг бөглөнө. Хөлгийн доторхыг таслан хаасан хана нь яавч ус нэвгэрхээргүй бөх бат хийгдсэн байдаг агаад нэвчсэн усыг шавхаж дуусмагц зөөсөн ачаа бараагаа эргүүлж оруулна.

Хөлөг онгоцоо давирхайгаар шавдаггүй учир нь тэр нутагт давирхай байдаггүй. Харин

давирхайн оронд түүхий шохойг жижиглэж тагсан олсны ургамалтай холиод газрын тосоор зуурч хөлөг онгоцоо шавна. Энэ шаваас нь яг л цавуу шиг наалдаж нүх сүв бүхнийг дүүргэж таглана. Энэ зуурмаг давирхайнаас дордох юм ер үгүй.

Онгоцны багийг онгоцны хэмжээ, даацтай уялдуулан бүрдүүлэх бөгөөд 150-иас 300 хүний хооронд хэлбэлзэнэ. Тэдний хөлөг онгоцнууд манайхыг бодвол хавигүй их даацтай. Нэг онгоцонд 5000-аас 6000 сагс халуун чинжүү ачна. Урьд өмнө эндхийн хөлөг онгоцнууд бүр их том байсан боловч олон олон арал, олтиргийн усан боомт, зогсоолын эрэг элэгдэж налууссаар онгоц зогсох усны гүн нь том хөлөг онгоцыг даахгүй хайрдуулчих гээд байдаг болохоор бага суулттай, жижиг онгоц хийх болжээ. Хөлөг онгоцнууд нь эхлээд сэлүүрийн хүчээр урагшлах агаад нэг сэлүүр дээр дөрвөн усан цэрэг сууна. Эдгээр хөлөг онгоцны баг нь урьдынхаасаа хоёр, заримдаа гурав дахин цөөн хүнтэй байх буюу жар, ная, заримдаа нэг зуун хүнтэй байна. Гэсэн хэдий боловч маш их даацтай зарим нь мянган сагс чинжүү элбэг ачна. Хөлөг онгоцнууд нь хэд хэдэн жижиг завь онгоц чирч явах агаад зарим нь арван завь чирч явдаг. Эдгээр жижиг завь онгоцондоо ачаа ачихаас гадна хөлөг онгоц зангуугаа хаяж зогсоход ойр зуурын бусад ажил амжуулах хөсөг болдог төдийгүй далайд загасчилах, онгоц засах хэрэглүүр болдог.

Эдгээр хөлөг онгоцнуудыг далайгаар нэг жил аялсны дараа засах, сэлбэх болдог, ингэж засаж сэлбэхдээ хуучин хоёр давхар банзан их бие дээр нь дахин нэг үе банз давхарлан хадаж, шавж цавууддаг. Ийм засвар үйлчилгээг жил болгон хийх агаад онгоцны их бие зургаан давхар банзан ханатай болтлоо далайгаар хөвж ачаа бараа тээсээр байх агаад зургаан давхар үелсэн ханатай хөлөг онгоц дахин далайд гарахгүй бөгөөд түүний хөвөх чадвар эрс муудаж хуучин банзнууд нь илжирч өмхөрсөн байдаг<sup>196</sup>.

Одоо би та бүхэнд далайчид, худалдаачид далайд гарахынхаа өмнө энэ удаагийн далайн аялал өгөөж хишигтэй байх нь уу, эсвэл аюул осол дагуулсан гарз хохиролтой төдийгүй амь насанд ч аюултай байх нь уу гэдгийг урьдчилан баримжаалах нэгэн туршилт буюу мэргэ төлгийн талаар товчхон өгүүлье.

Далайчид дөрвөлжин жаазанд тор бэхэлж хадаад түүнийхээ дөрвөн өнцөг, дөрвөн талаас найман уяа бэхэлж хооронд нь томж урт олстой залгана. Үүний дараа ухаан санаа мулгуу балай буюу мал болтлоо согтсон архичин олж уг тортой жаазандаа хүлээд, аялалд гарах хөлөг онгоцны нэрийг хадаж далайн шуурга босохыг хүлээж байгаад шуурга эхэлмэгц хүн хүлсэн жаазаа салхинд хөөргөнө. Далайн салхинд хөөрч туугдсан жааз эгц дээшээ хөөрөн хөөрсөөр нүдний үзүүрт торолзсоор арилж өгвөл энэ удаагийн далайн аялал бүтэлтэй болно гэсэн дохио, эс тэгвээс энэ аялалд элдэв саад тотгор, аюул осол тохионо гэсний дохио юм. Ингээд туршилт буюу мэргэ төгсөнө. Хөлөг онгоцны нэр заасан жааз салхинд хөөрөн алга болсон бол тэр онгоц руу бүхий л далайчид, худалдаачид хошууран түрээсийн мөнгөө төлөн хөлсөлж авна, хөлөг онгоцны нэртэй жааз салхинд хөөрөлгүй далайд живсэн бол тэр онгоцыг бүтэн жилийн турш хэн ч хөлсөлж авалгүй боомтод зангуугаа хаян зогссоор жил өнжинө.

Сая би далайчид, худалдаачид болон Энэтхэг орноос бараа таваар зөөж тээдэг далайн хөлөг онгоцны тухай нэлээд тодорхой ярьсан тул одоо Энэтхэгээс дорно зүгт орших далайн арлуудын тухай өгүүлсү. Энэ яриагаа Японы арлаас эхэлье.

Японы арал дорно зүгийн их далайн дунд эх газраас мянга таван зуун (1500) бээр алс зайд оршино. Энэ бол маш том арал. Хүмүүс нь цайвар цагаан арьстай, тэгш сайхан бие бялдартай, найрсаг хүмүүжилтэй байдаг. Тэд бүгд онгон шүтлэгтэй, их биеэ даасан, бусдын засаг засаглалын эрх нөлөөнд ороогүй хүмүүс байх.

Тэр арлынхан алтан эдлэл маш ихээр хэрэглэх бөгөөд тэр нутгаас асар их алт олдсон юм байна. Тэр арлынхан тэр их алтаа хааш нь ч зарж борлуулдаггүй учир нь эх газраас хэн ч очиж тэндээс алт худалдаж авдаггүй байна. Одоо би та бүхэнд арлын захирагчийн суудаг гайхамшигтай ордны тухай ярьж өгье. Энэ арлын захирагчийн ордон маш том боловч ордны дээврийг цул алтаар хучсан байх нь манай нутагт сүм дуган, хаадын орд харшийн дээврийг тугалгаар бүрдэгтэй адил авай. Алтан дээврийн үнийг баримжаалан хэлэхэд ч бэрхтэй билээ. Ордны шалыг хоёр хуруу зузаан алтаар битүү хучиж, өрөө, тасалгааны хаалга, цонхыг алтаар хийж, тасалгаа, танхимийн доторх ханыг алтаар битүү доторлосон байна. Захирагчийн ордныг тоогүй их алт эрдэнэсээр бүтээсэн тул түүнийг үнэлэх гэж оролдвол эрүүл саруул ухааны хязгаарыг хаа хамаагүй давж одох билээ. Тэнд сувд эрдэнэ хязгааргүй их байхаас гадна улаавтар өнгөтэй сувд ч бий. Тийм улаавтар сувд цагаан цайвар сувд шигээ үнэ цэнэтэй байна. Арлынхнаас хэн нэгэн нь өөд болоход заримыг нь булшилж оршуулах, заримыг нь шатааж чандарлах. Аль ч хэлбэрээр өөд бологсдоо оршуулахдаа ялгаагүй аманд нь том бөөрөнхий сувд хийдэг заншилтай. Энэ арал дээр өөр бусад төрлийн үнэт эрдэнийн чулуу маш элбэг. Арал бол үлгэрийн орон шиг баян тансаг бөгөөд арлын баялгийг хэн ч хэзээч тоолж тооцож байсангүй.

Энэ баян тансаг арлын тухай мэдээ Хубилай хааны 197 сонорт хүрмэгц Их хаан урт удаан хугацаанд тунгааж цэгнэж бодсоны эцэст тэр арлыг байлдан дагуулахаар шийджээ. Ингээд Их хааны зарлигаар морин болон явган цэргээс бүрдсэн армийг тээсэн олон хөлөг онгоцтой усан флотыг Абакан, Вонсамчин хэмээх хоёр их ноёноор удирдуулан Зайтон, Кинсайн боомтоос тэрхүү арлын зүг илгээжээ. Хоёр жанжны аль аль нь ухаалаг, эрэлхэг жанжид байсан. Хоёр жанжин арлын эрэг орчмын тосгон суурингуудыг эзлэн аваад арлын төв хот руу аялах дайнд бэлтгэж байлаа. Яг энэ үед тэр хоёрыг армитай нь хамт нэгэн гамшиг дайрсан билээ. Хоёр жанжин бие биедээ атаархан өрсөлдөж, үг хэлээ ололцдоггүй байсан тул хэн нь ч хэндээ тусладаггүй байлаа. Яг ийм үед умар зүгээс далайн шуурга дэгдэж арлаас хөлөг онгоцнуудаа холдуулахгүй бол бүх онгоц нь эвдэрч сүйрэх аюул нүүрлээд байсан тул бүх цэргээ онгоцондоо ачиж аваад задгай далайд гарцгааж дарвуулаа дэлгэн дөрвөн бээр орчим хөвж байтал шуурганы хүч галзуурсан мэт нэмэгдэж хөлөг онгоцнуудыг нь эвдэж далайд живүүлж эхэлжээ. Энэ үед ойролцоох нэгэн жижиг аралд хүрч арлын хөрсөн дээр хөл тавьсан цэргүүд амьд мэнд гарч бусад нь далайн шуурганд сүйрчээ. Хар шуурганы хүч аажим аажмаар суларч, далайн давалгаа номхорч эхэлмэгц хоёр жанжин хар шуурганаас амь мэнд гарсан хөлөг онгоцнуудаа цуглуулан арлын эрэг дээр буцаж иржээ. Тэдгээр хүмүүс нь голцуу зуут, мянгат, түмтийн захирагч ноёдоос бүрдсэн байв. Харин арал дээр хоргодон амь гарсан хүмүүсийг тэдний онгоцнуудад багтаах шингээх зай байсангүй. Хөвөх боломжтой хөлөг онгоцнууд дарвуулаа босгон нутгийн зүг жолоо залж, хөлөг онгоцгүй үлдсэн цэргүүд арал дээр амь хоргодон үлдэв. Арал дээр үлдэгсэд нь гурван түм орчим хүн байжээ. Эдгээр үлдэгсэд хэзээ нэгэн цагт энэ арлаас хөвхорч нутгийн бараа харна гэх горьдлого найдлага бараг тасарсан байв.



Далайд гарсан хөлөг онгоцнууд нутгийн зүг жолоо залан хөвөн одож, арал дээр үлдэгсэдийг хувь заяанд нь даатган орхижээ. Тэдгээр онгоцнууд нутаг орондоо хүрсэн гэдэгт эргэлзэх юмгүй. Одоо би арал дээр амьдрал үхлийн 198 заагт үлдсэн хүмүүсийн тухай өгүүлсү.

Аюулт хар шуурганаас амьд мэнд гарч, арал дээр хоцорсон гурван түмэн цэрэг эрс эндээс яаж гарах арга зам олдохгүй байгаа тул өөрсдийгөө үхсэнээс ялгаагүйд тооцож байв. Тэдгээр хүмүүсийн уцаар бухимдал туйлдаа хүрч яах учраа олохыг больжээ. Арал дээр амьд үлдэгсэд ийм хүнд хэцүү байдалтай нүүр тулан үлджээ. Арлын орны нь байлдан дагуулж эзлэн авахаар ирсэн цэрэг дайчдын усан флот далайн хар шуурганд сүйрч бүтэн үлдсэн нэг хэсэг нь нутгийн зүг жолоо залж, амьд үлдсэн нэг хэсэг нь нэгэн жижиг арал дээр амь хоргодон буйг олж мэдсэн арлынхан хувь заяандаа баярлаж бахадсанаа багтааж ядан байцгаав. Хар шуурга намдаж далай номхормогц арлын захирагч далайн флотоо хөдөлгөн уг арал дээр шуудхан цэрэг армия буулгаж эхэлжээ.

Арал дээр хоцорсон гурван түмэн цэрэг эрсийг даран устгахаар ирсэн цэргүүд хөлөг онгоцоо ямар ч хамгаалалтгүй үлдээж бүх хүчээрээ тэдний зүг хөдлөхийг хармагцаа маш хурдан арлын нөгөө өнцөг рүү шуурхайлан хөдөлж тэнд хөндөлсөх нэгэн өндөр уулыг даван арлын эрэг даган тойрч дайсныхаа ар хударгаар орж тэнд зогсох дайсны хөлөг онгоцнуудыг ямарч эсэргүүцэлгүй хялбархан эзлэн авчээ. Олзолж авсан онгоцондоо сууцгаан арлын төв хот руу хөдлөхдөө дайсны туг хиурыг босгон довтолгоход хотынхон өөрийн цэрэг эрсийг эргэн ирж байна гэж бодон тэднийг хотдоо чөлөөтэй оруулжээ. Хотод зөвхөн хөгшид өвгөд, бүсгүйчүүд үлдсэн байсан тул хотыг мөн хялбархан эзэлж царайлаг залуу охид бүсгүйчүүдээс бусдыг нь хядан тонилгожээ. Ингэж Хубилай хааны цэргүүд харь арлын хотыг эзлэн авчээ.

Арлын захирагч болон түүний цэргүүд дайсны мэхэнд унаж хотоо эзлүүлснийг үзмэгц бүгд амиа егүүтгэн үхэхэд бэлэн байлаа. Тэдгээр цэрэг дайчид захирагчийнхаа хамт өөр онгоцоор аралдаа эргэн ирж нийслэл хотдоо хэн ч орж гарах нүх сүв үлдээлгүй хааж бүслэн сууцгаав. Ийм байдалтай бүтэн долоон сар бүслэгдсэн Хубилай хааны цэргүүд Их хаандаа энэ байдлаа дуулгахаар олон удаа элч, илгээмж явуулсан боловч нэг нь ч бүслэлтийг нэвтэрч чадсангүй. Бүслэгдсэн цэргүүд гарах гарц үгүй болохыг ойлгомгоц бууж өгөхөөр шийджээ. Харин бууж өгсөн цэрэг эрсээс нэг ч хүний амийг хороохгүй байх, мөн тэдгээр цэрэг эрс өөрсдөө насан эцэс болтлоо энэ арлаас гарч хаа нэгтэй очихгүй байх нөхцөл тавьсан бөгөөд энэ явдал манай бурхан мэндэлсний 1269 онд болсон бөгөөд бууж өгсөн цэргүүд тэндээ шингэн суурьшиж амьдрах болжээ. Энэхүү аян дайны төгсгөл, үр дүн иймэрхүү янзтай болжээ.

Энэ аяныг толгойлон цэрэг эрсийг захирч явсан хоёр ноён хэрхэн өөр хоорондоо эв түнжингүй аашилж авирласнаас болоод аян дайн үр дүнгүй болсныг Их хаан олж мэдмэгцээ ахлагч ноёныг нь цаазлан хороож үлдсэнийг нь хүнд гэмт хэрэгтнүүдийг цээрлүүлэн цөлдөг Зорза арал руу илгээжээ. Энэ арал дээр цөлсөн ялтныг бухын нойтон ширээр өвч ширлэж орхидог бөгөөд шир хатан хатсаар ялтан ч ширтэйгээ хамт ялзран үхдэг бөгөөд хоёр дахь ноёныг ийн шийтгэжээ.

Би та бүхэнд нэгэн сонин гайхамшигт учирлын тухай өгүүлсүгэй. Дээрх хоёр ноён эзэлсэн арлынхаа шоронд хоригдож байсан хүмүүсийг олзлон авчээ. Тэдгээр хоригдлууд бууж өгөхөөс татгалзсан тул бүгдийг цаазлан хороосон боловч найман хүний толгойг авч дийлэлгүй үлдээжээ. Үүний учир нь тэдгээр найман хүний гарын арьс махны завсар нэгэн төрлийн ид

шидтэй чулуу байх агаад тийм чулуутай хүн төмөр мэсэнд үл даагдах аж. Цаазыг гүйцэтгэсэн цэргүүд энэ тухай жанжиндаа хэлмэгц жанжид нь тэдгээр хүмүүсийг бороохой шийдмээр цохиж нүдэж алаад чулууг ухаж ав гэсэн тул ёсоор болгожээ. Үхдэл хүүрнээс салгаж авсан эдгээр чулуу яваандаа асар их үнэд хүрсэн ажээ.

Ийнхүү Их хааны цэрэг ялагдал хүлээн бут цохигдож уг аян дайн эцэслэсэн тул үүнийг ингэсхийгээд орхиж номоо цааш үргэлжлүүлэн өгүүлсү.

Энэ арлынхны шүтдэг онгод нь Катай болон Манзи орныхтой адил төстэй юм. Үүнээс гадна арлынхан үхэр толгойтой, гахай, нохой толгойтой, хонин дүрстэй болон бас бус хэлбэр дүрстэй онгонуудыг шүтэх юм. Мөн дөрвөн нүүртэй, гурван толгойтой онгодыг шүтэх бөгөөд түүний нэг толгой нь хүзүүн дээрээ бусад хоёр нь мөрөн дээрээ байх жишээтэй. Зарим нь дөрвөн гартай, зарим нь арван гартай бүр мянган гартайгаар дүрсэлсэн онгон ч байх юм. Эдгээр онгоны дүрс хэлбэр хичнээн сүртэй, толгой гар нь олон байх тусам тэдний ид шид нь улам их байна гэж итгэн шүтдэг байна. Загалмайн шашинтай хүмүүс арлынхнаас та бүхэн яагаад онгон шүтээний ийм олон хэлбэр дүрстэй хийдэг юм бэ? гэж асуухад: “Бидний өвөг дээдсээс ийм л хэлбэр дүрстэй уламжлан дамжиж ирсэн тул тэр хэвээр нь бид хадгалан мөргөж шүтдэг төдийгүй үр хойчдоо ч энэ л хэлбэр дүрсээр нь уламжлуулан үлдээнэ” гэж хариулцгаана. Эдгээр онгодын үүрэг чиглэл нь асар олон бөгөөд тэдний ид шид нь нэрлэж тоочих аргагүй тул тэр тухай бид энэхүү номондоо дурсаж дурьдахаас цээрлэн үлдээлээ. Тэр бүхнийг Загалмайн шашинтан хүний сонорт хүргээд байх зүйл огтхон ч биш билээ.

Энэ яриагаа өндөрлөж өөр зүйлийг өгүүлсү. Энэ арлын онгон шүтлэгтнүүд нь өөрийн омгийн биш олзны хүнийг амиа золих мөнгө зоосгүй буюу түүний амийг худалдан авах эзэнгүй болвоос: өөрсдийн ахан дүүс, төрөл төрөгсөдөө хоолонд урин зална. Тэгээд олзны хүнийг алж түүний махаар хоол хийх бөгөөд үүнийгээ дээд зэргийн эрхэм зоогт тооцон идэцгээнэ.

Дээр эхэлсэн яриагаа эргэж үргэлжлүүлэн, цааш өгүүлбэл: Энэ арал оршиж байгаа далайг Хятадын тэнгис гэж нэрлэж байгаа нь Манзи нутагтай залгаа орших тул тэгж нэрлэх агаад арлынхны хэллэгээр Манзи гэдэг нэрийг “Хятад” гэсэн үгээр илэрхийлдэг байна. Энэ арлын орон дорно зүгт орших агаад тэр нутгаар аялж үзсэн туршилга дадлагатай ахмад далайчдын өгүүлэхээр арлын орон нь долоон мянга дөрвөн зуун дөчин найман (7448) арлаас бүрдэх агаад бараг бүгд дээр нь хүн амьдарна. Эдгээр арал дээр анхилам сайхан үнэртэй агар зандан модод ургахаас гадна нэн үнэтэй олон төрлийн амттай халуун ногоо их ургана.

Арал дээр цас шиг цагаан өнгийн чинжүү их ургахаас гадна хар чинжүү ч элбэг ургана. Эдгээр арал дээр алт болон бусад үнэт эрдэнэсийн зүйл нэн элбэг нь гайхмаар. Тэдгээр алт эрдэнээр элбэг арал нь үлэмж зайтай орших тул далайгаар хөвж хүрэхэд ихээхэн төвөг, осолтой. Зайтон болон Кинсайгаас ирсэн хөлөг онгоцнууд ихээхэн ашиг орлоготой арилжаа наймаа хийдэг. Эдгээр арал руу аялж ирэх, буцахад бүтэн нэг жилийн хугацаа болно. Өвөл гарч ирээд зун буцаж харина. Эндхийн далай тэнгисийн салхи нь зөвхөн хоёрхон чиглэлд үлээх бөгөөд өвөл ирэх чиглэлд зун буцах чиглэлд салхи нь үлээнэ.

Энэ арлаас Энэтхэг орох далайн зам үнэнхүү урт холын зам гэдгийг та бүхэн ойлгоно биз дээ. Миний Хятадын тэнгис гэж нэрлээд байгаа тэнгис бол үнэндээ бол далай юм шүү. Бид

нутагтаа Английн тэнгис, Рошэлийн199 тэнгис гэж нэрлэдэг шиг энэ нутгийнхан бас Хятадын тэнгис, Энэтхэгийн тэнгис гэж нэрлэх авч үнэндээ бол эдгээр тэнгис нь далай билээ.

Одоо би энэ арлын тухай дахин дахин нуршиж өгүүлэхээ больёо, эдгээр арал нь маш алсад орших төдийгүй би тэдгээр арал дээр хөл тавьж байгаагүй билээ. Их хааны засаг захиргаа, эрх мэдлийн алин ч тэдгээр аралд хүрээгүй учраас тэр арлынхан ямар нэгэн татвар гувчуур Их хаанд төлдөггүй. Одоо би Зайтон боомтод эргэн очиж тэндээс200 цаашдынхаа аян замыг ч, номоо ч үргэлжлүүлсүгэй.

Аялагч маань Зайтон боомтоос гарч бараг өмнө зүгийг чиглэн нэг мянга таван зуун бээр (1500) хөвж нэгэн өргөн далайн буланг огтлоно. Тэр буланг Чейнам (Cheynam)–ын булан гэх агаад дарвуулт хөлөг онгоцоор бол бүтэн хоёр сар хөвж туулах уужим их усан мандал агаад умарт талаараа Манзи нутгийн эрэгт тулна. Зүүн өмнөд талаараа Анию болон Толоман мужуудын эрэгт тулах агаад бусад талаар нь өөр бусад олон муж газартай хил залгана. Далайн булан дотроо түм буман арал, олтирогтой тэдгээр нь бүгд хүн ам шигүү суусан газар орон болой. Тэдгээр арал дээр далайн усаар угаагдан түрэгдсэн тоосонцор алт байхаас гадна, зэс, тугалга болон өөр бусад эрдэс, эрдэнэстэй. Тэдгээр арлууд өөр хоорондоо худалдаа наймаа хийж нэг арлын бүтээгдэхүүнээ нөгөө арлынхаар солино.

Далайн булангийнхан эх газартай худалдаа арилжаа хийхдээ тэдэнд алт, тугалга болон өөр бусад зүйл борлуулж оронд нь өөрсдийн хэрэгцээт зүйлээ худалдан авна. Ихэнх арал дээр тариа будаа элбэг дэлбэг ургана. Далайн энэ булан аварга том бөгөөд түг түмэн ястан үндэстэн тархан суурьшсан, эгээл нэгэн биеэ даасан дэлхий ертөнц мэт санагдана. Одоо би ирсэн замаараа эргэж, аялалд гарсан газартаа очих минь. Зайтон боомтоос гарсан аялагч маань нэг мянга таван зуун бээр өргөн далайн буланг туулан хөвсөөр Чамба (Chamba) хэмээх уужим дэлгэр нутагтай, баян чинээлэг оронд хүрнэ. Энэ орон өөрийн гэсэн хантай, өөрсдийн хэл яриатай, онгон шүтлэгтэй. Энэ улс жил бүр Их хаанд заан болон агар зандангаар алба барих агаад өөр бусад татвар гувчуур төлдөггүй. Их хаанд жил бүр алба гувчуур төлдөг болсон тухай та нарт өгүүлсү. Энэ явдал манай бурхан мэндэлсний 1278 онд болсон бөгөөд тэр жил Их хаан өөрийн Согату (Sogatu) нэртэй ноёноор удирдуулсан их цэргийг Чамба улсын эсрэг хөдөлгөхөд их цэрэг тэр улсын газар нутагт хялбархан нэвтрэн оржээ. Чамба улсын хан201 нь насан өтөл хүн байсан төдийгүй тэр улсад тартар цэргийн довтолгооныг сөрөн зогсох цэрэг арми ч үгүй байжээ. Гэвч тэд хот цайзаа бэхлэн дайсны өмнө сөхрөлгүй эсэргүүцэн тэмцэлдсээр байлаа. Энэ хооронд тартарууд тэр орны бусад газар нутгийг бүрэн эзлэн цөлмөн хоослож орхив. Эзэнт улсаа хоосрон мөхөхийг харсаар суух сэтгэл төвдөлгүй Хубилай хаанд өөрийн элчин төлөөлөгчдийг яаралтай илгээн ийн айлтгаруун: “Эзэн дээдэс минь, эцэг хаан минь Чамба улсын хан таныг Эзэн хаанаа гэж хүлээн зөвшөөрч буйгаа мөргөн өчмү. Би өөрөө насан өндөр болсон, энэ улс орныг урт удаан хугацаанд эв найртай, энх амгалан удирдаж ирсэн. Би таны албат боол байж жил бүр агар зандан, амьд заанаар алба барьж байя. Их эзэн хаан та миний гуйлт хүслийг хүлээн авч биднийг энэрэн өршөөж, манай газар нутагт довтолгон орж газар нутаг, хүн ардыг маань цөлмөн хоослож буй их цэргээ эргүүлэн татаж биднийг чөлөөлнө үү” гэжээ. Чамбын ханы элчин үүнээс өөр үг эс өгүүлэв. Хөгшин ханы өчил, гуйлтыг сонссон Хубилай хаан тэр ханыг өрөвдөн зарлиг болруун. Согату ноёныг цэргээ Чамба нутгаас үтэр түргэн гаргаж, өөр бусад газар нутаг, улс орныг эзлэн авахыг

тушаав. Согату ноён ч Их хааныхаа зарлиг тушаалыг цаг алдалгүй, үг гээлгүй биелүүлж тэр орноос цэргээ татан өөр зүгт хөдөлжээ. Тэр цагаас хойш Чамба улсын хан жил бүр Хубилай хаанд агар зандан мод, Чамба нутгаас барьсан хамгийн том хорин заанаар алба барих болжээ.

Ингэж тэр хан Хубилай хааны албат боол болсон бөгөөд үүнийг нь та бид ч бас хүндэтгэн үзэх учиртай. Одоо бид тэр ханы тухай, Чамба орны тухай үргэлжлүүлэн өгүүлсү.

Энэ орны ямарч царайлаг охид хан эзэндээ эхлэн бараалхалгүй эр нөхөрт гардаггүй. Бараалхаж буй охид хан эзэндээ таалагдвал түүний хатан болж ханы ордонд үлдэнэ, эс таалагдвал хан өөрөө тэр охинд ихээхэн мөнгө зоос шагнаж өөр эрд нөхөрт гарахыг зөвшөөрнө. Би Марко Поло энэ улсад 1285202 онд очиж байсан бөгөөд тэгэхэд тэр хааны үр хүүхэд нь гурван зуун хорин зургаан (326) бүстэй, бүсгүй хүмүүс байсан агаад бас нэг зуун тавин (150) цэргийн насны идэр эрчүүд байж билээ.

Энэ ханлигт заан ихээр өсгөж үржүүлнэ, агар зандан мод ихтэй. Мөн хар мод гэж нэрлэх модон шугуй элбэг. Тэр модоор шатар сийлж шатрын хөлөг хийнэ. Өөр гоц гойд яриад байх буюу номондоо оруулах зүйл үгүй тул цаашдынхаа зам мөрийг хөөе.

Чамбагаас гарсан аялагч маань өмнө-зүүн өмнө зүгийг баримжаалан дарвуулаа босгон мянга таван зуун (1500) бээр замыг туулан хөвсөөр Ява (Java) хэмээх нэгэн том аралд хүрэлцэн ирнэ. Энэ том арлыг таван хуруу шигээ мэдэх болсон хашир туршлагатай далайчдын ярьснаар бол энэ арал дэлхийн хамгийн том арал агаад эргийн дагуух эргэн тойрны урт нь гурван мянган (3000) бээр гаруй урт гэнэ. Хүмүүс нь бүгд л онгон шүтлэгтнүүд, арлыг захирагч эзэн нь маш хүчирхэг нэгэн агаад энэ дэлхий дээр өөр хэнд ч захирагддаггүй биеэ даасан эзэн гэнэ. Арал маш баян бөгөөд чинжүү, наргил модны самар, задь, поваарь, таван халуун, лиш хийгээд энэ ертөнц дээр байдаг өөр ямар л үнэтэй, үнэртэй, амттан, эмийн ургамал байваас цөм ургана. Энэ арлыг зорин асар олон худалдаачид, хөлөг онгоц тасралтгүй ирж төрөл бүрийн бараа таваар худалдан авах агаад түүнээсээ хэд нугалсан ашиг олно. Арал дээрх эрдэнэсийг хэмжих, тоолох аргагүй их. Энэ аралд хүрэх далайн зам дэндүү урт хол, үргэлж аюул осол отоож байх тул Их хаан хэзээч энэ арлыг байлдан эзэгнэх боломжгүй гэж би бодож байна. Гэвч Зайтон болон Манзийн худалдаачдын уг сурвалж энэ арлаас гаралтайгаар барахгүй эд баялгийнхаа ихэнхийг энэ арлаас одоо болтол авсаар байдаг билээ. Элдэв төрлийн халуун ногоо, амттаны эх орон эдгээр арал бөгөөд дэлхий ертөнцийн зах зээлийг эндээс л хангаж байдаг билээ.

Чамбагаас хөдөлсөн дарвуулт хөлөг онгоцнууд өмнө - баруун өмнө зүгийг барин долоон зуун (700) бээр замыг хөвөн туулсны эцэст Сондур (Sondur) болон Кондур (Condur) хэмээх том жижиг хоёр аралд хүрэх боловч эдгээр арал дээр хүн амьтан оршин суудаггүй эзэнгүй тул орхин одохоос өөр аргагүй. Эндээс таван зуун бээр зайтай зүүн өмнө зүгт Локак (Lokak)203 нэртэй эх газрын нэгэн баян муж оршино. Эндхийн хүмүүс онгон шүтлэгтэй, өөрийн хэл яриатай, тэднийг нэгэн хүчирхэг хаан захирна. Энэ нутгийнхан хэнд ч алба гувчуур төлдөггүйн учир нь маш хол орших учир хэн ч очдоггүй. Хэрвээ энэ газар нутаг хүрч очиход хялбар дөхөм байсан бол Хубилай хаан өөрийн эзэнт гүрэнд аль хэдийн нэгтгэн захирах байсан. Энэ мужид сум модон ойтой204. Мөн алт маш их хэн ч үүнийг өөрийн нүдээр үзээгүй учир итгэдэггүй. Заан элбэгтэй, хүмүүс нь ав хоморго их хийнэ. Энэ ханлигаас юуу маш ихээр ирэх агаад бусад мужид мөнгөний оронд хэрэглэдэг. Өөр ч яриад, бичээд байх гоц

гойд зүйлгүй тул өөр зүйлийн тухай ярилцъя.

Локакаас дарвуулт онгоцоор гарч өмнө зүгийг чиглэн таван зуун бээр аялахад Бинтан (Bintan) хэмээх нэгэн зэлүүд, бөглүү аралд хүрнэ. Эндхийн ой шугуй бүх модод нь анхилам сайхан үнэртэй. Энэ арлаас гараад жаран бээр орчим хөвж хоёр арлын хоорондох хоолойгоор гарна. Тэр хоолойгоор гармагц хааяагүй дөрвөн тохой гүнээс үл хэтрэх гүехэн устай газар орох бөгөөд хөлөг онгоцнууд зорчиход нэн бэрхтэй бөгөөд бүх л хөлөг онгоцнууд дарвуулаа эвхэн зөвхөн сэлүүрээр залан хөвнө. Энэхүү гүехэн устай далайгаар зүүн өмнө зүгийг барин гучин бээр хөвсөөр Малаюр (Malayur) хэмээх нэгэн ханлигт хүрнэ. Энэ ханлиг өөрийн гэсэн хэл, яриатай бас өөрийн хантай. Мөн Малаюр нэртэй том, тансаг хоттой бөгөөд тэнд худалдаа арилжаа хааяагүй дэлгэрэн хүмүүс нь багтаж ядна, ялангуяа төрөл бүрийн халуун ногоо мөн ч элбэг байна. Энд өөр гоц гойд сонирхоод байх зүйл үгүй тул аяллаа цааш үргэлжлүүлье.

Бинтанаас зүүн өмнө зүгт нэг зуу орчим (100) бээр зайд бага Ява арал оршино. Энэ арлыг жижигхэн болохоор нь бага Ява гэж нэрлээгүй гэдгийг та бүхэн ойлгож байгаа гэж бодож байна, арлын эргэн тойрны эргийн урт нь хоёр мянган (2000) бээр гаруй юм шүү дээ. Одоо би энэ арал дээрээс та бүхэнд үнэн бөгөөд бүрэн тайлангаа тавья гэж бодож байна. Бага Ява арал дээр найман өөр ханлиг орших агаад ханлиг бүр тус тусдаа хантай, өөр өөрийн онцлогтой өвөрмөц хэл яриатай. Арал нь үнэт эрдэнэс, ховор эд бараагаар баян. Арал дээр агар зандан, суман мод, хар мод, поваарь болон өөр олон олон төрлийн халуун ногоо болон амттан, үнэртэн ургах авч урт холын, аюул осол хааяагүй отож байдаг далайн замыг туулж дийлэхгүй тул тэдгээр ховор нандин зүйлс хэзээч манай нутаг оронд хүрч ирдэггүй боловч Манзи, Катай орноор дүүрэн байх. Арлыг эзэгнэн суух янз бүрийн овог аймаг, үндэстэн ястны тухай өгүүлэхийнхээ өмнө арлын талаар та бүхэнд ярьж өгсүгэй. Миний яриа та бүхний гайхшралыг төрүүлэх нь эргэлзээгүй – энэ арал маш хол алс өмнө зүгт орших тул шөнийн цагт энд “Алтан гадас” од бараг үзэгдэхгүй. Одоо би яриагаа Фэрлэк (Ferlec) – ийн ханлигаас эхэлье.

Фэрлэкийн хүмүүс нь урьд онгон шүтлэгтэн байсан боловч энэ газар үргэлж ирж худалдаа наймаа хийдэг, бас энд оршин суудаг Сарацин худалдаачдын нөлөөгөөр хот газрын хүмүүс нь Магоменийг шүтэн мөргөх болжээ. Уул ойгоор амьдардаг хүмүүс нь бараг л зэрлэг араатан шиг аяг ааштай, хүний мах иднэ, махыг цэвэр бохир гэж цээрлэх юмгүй дайралдсан болгоноо иднэ. Тодорхой нэгэн шүтэж мөргөдөг шашин бурхан үгүй агаад өглөө босоод юуг түрүүлж харна түүндээ мөргөн сүслэнэ.

Фэрлэкээс хөдлөөд тун удалгүй Басман (Basman) – ы ханлигт хүрнэ. Басман нь биеэ даасан ханлиг төдийгүй өөрийн гэсэн өвөрмөц хэл яриатай. Басман хүмүүс нь хууль зүй, дэг жаяг гээч юмыг бараг гадарлахгүй. Энд мөн бүдүүлэг зэрлэг ан араатан элбэг. Эндхийн хүмүүс өөрсдийгөө Хубилай хааны үнэнч албат харьяат гэгцгээх боловч Их хаанд алба гувчуур төлдөггүй нь дэндүү алс хол нутагтайгаас болдог. Арлын оршин суугчид бүгд л өөрсдийгөө Хубилай хааны албат гэж тооцох төдийгүй хааяа нэг таарах аянчид жинчдээр Их хаандаа бэлэг сэлт илгээдэг билээ. Ялангуяа тэдний илгээдэг хар элээ маш сонин бэлэг болдог. Энэ нутагт зэрлэг заан маш их бас ганц эвэртэй хирс заанаасаа дутахгүй олон. Эдгээр хирс нь усны үхэр шиг үстэй, заан шиг хөлтэй. Духан дээрээ ганц том хар эвэртэй. Тэд хэн нэгэн рүү дайрахдаа ганц эврээрээ мөргөдөггүй, харин өвдөглөж нухаад хэлээрээ долоож хөнөөдөг.

Тэдний хэл нь маш хурц, урт ясан өргөстэй. Алив нэгэн амьтныг эхлээд дайрч унагаад дараа нь өвдөглөж дараад өргөстэй хэлээрээ долоочихдог байна. Толгой нь зэрлэг бодонгийнхтой төстэй, толгойгоо үргэлж духайлгаж явдаг. Хирснүүд үргэлж шавар шалбаагтай хутгалдаж өнхөрч хөрвөөж байх агаад эрэмдэг зэрэмдэг юм шиг эвгүй муухай дүр төрхтэй. Энд маш олон төрлийн сармагчинтай. Хэрээ шиг тас хар өнгөтэй хур агнадаг том хар элээ элбэг бөгөөд тэдгээр элээ нь шувуу ангуучлахдаа гарамгай.

Хэрэв хэн нэгэн хүн одой хүнийг Энэтхэгт байдаг, тэндээс тэднийг авчирсан гэж яривал тэр хүн худал хэлж байгаа буюу таныг мэхэлж байгаа нь тэр. Одой хүмүүсийг энэ арал дээр бүтээдэг гэвэл та итгэх үү? Тэгвэл тэднийг хэрхэн бүтээдгийг та бүхэнд би өгүүлсү. Энэ арал дээр нэгэн төрөл одой сармагчин амьдрах агаад нүүр царай нь хүнийхтэй нэн төстэй. Хүмүүс тэдгээр одой сармагчинг барьж аваад нэгэн төрлийн тос түрхэж биений нь үсийг гуужуулдаг. Үс нь гуужиж нүцгэрсэн сармагчны эрүүнд байх үсний нүхээр урт үс сүвлэж хатаахад тэр нь ургасан мэт харагдана. Сармагчны хөл, гар болон биеийн бусад хэсгийг татаж, сунгаж хүнийхтэй төстэй болгоод төрөл бүрийн гавар түрхэж, сармагчиндаа мансууруулах эм уулган хүнтэй аль болох төстэй болгодог. Ингэж та бидний нүдийг хуурдаг одой хүнийг бүтээдэг билээ. Энэтхэг болон бусад алс холын зэлүүд бөглүү нутагт хаана ч гэсэн “одой хүн” гэдэг хүн байхгүй<sup>205</sup> болохыг ойлгоорой. Басман арлын тухай яриагаа өндөрлөөд түүнтэй зэргэлдээ орших Суматра (Sumatra) арлаар аялъя. Энэ ханлигийн нутагт Марко Поло би аян замдаа гарах аятай таатай цаг агаарыг хүлээн бүтэн таван сарыг үдэж өнгөрөөсөн билээ. Энэ нутагт Алтан гадас од огт үзэгдэхгүй, харин Долоон бурхан зэрвэсхэн үзэгдээд өнгөрнө. Хүмүүс нь онгон шүтлэгтэн болон зэрлэг омгийнхноос бүрдэнэ. Тэдний хан нь хүчирхэг чадалтай баян чинээлэг боловч Хубилай хааны албат харьяат гэж өөрсдийгөө тооцоно.

Энд таван сарыг хэрхэн яаж өнгөрөөснөө өгүүлбэл: Бид<sup>206</sup> хөлөг онгоцныхоо ачаа барааг янзалсны дараа хүний махаар хооллодог энэ нутгийн зэрлэг омгийнхноос хамгаалан отогоо тойруулан гүнзгий нүх ухан түүнийхээ хоёр үзүүрийг далайн эрэгт тулган бэхлэв. Энэхүү нүхэн хамгаалалт дотроо таван газар харуул хамгаалалтын шовгор босгоод таван сарын турш тэр хамгаалалтын цайз дотроо сууцгаасан. Модоор дутах гуцахын зовлон үгүй билээ. Арлынхантай харилцан эв найртай байх хэлцэл, тохиролцоо хийсний ачаар тэд бидэнтэй хоол хүнсний наймаа хийж айван тайван байсан. Эндхийн загас шиг амттай сайхан загас өөр хаана ч байдаггүй байх. Энд улаан буудай ургадаггүй боловч тутарга элбэг. Энд миний та бүхэнд дээр өгүүлснээс өөр ямар ч дарс байдаггүй.

Харин энд нэгэн төрлийн дарс нэрдэг гэмээр мод ургана. Арлынхан тэр модныхоо мөчрийг тайраад дор нь том гэгчийн сав тосгуулан тавиад нэг хоногийн турш орхичихно. Тайрсан мөчрөөс модны шүүс дуслан дусалсаар тосгуур саваа дүүргэх агаад тэр нь маш сайхан дарс болой. Мөн тэр дарс нь элдэв цэврүү гувруу, маажуур зовуурийг хялбархан илааршуулах чадвартай. Тэр мод хасарваанийн дал модтой төстэй, дөрвөн салаа мөчиртэй байх. Бүр сонин болгоод хэлэхэд огтолсон мөчрөөс модны шүүс дусах нь цөөрмөгц уг модныхоо үндэс ёзоор руу зэргэлдээх голоос шуудуу татан хэдий хэрийн дарс хэрэгтэй байвал төдий чинээ усаар усална. Ингэж усалснаас хойш нэг цаг хэртэй болоод модны мөчрөөс дарс дусалж эхэлнэ. Энэ дарс нь цагаан буюу гүн улаан өнгөтэй байдаг. Энд маш том бөгөөд сайхан амттай наргил модны самар ургана. Хүмүүс нь бүх л төрлийн махыг цэвэр бохир гэлтгүй идэцгээнэ.

Одоо бид эндээсээ хөдлөөд Дагроиан (Da-groian) гэдэг ханлигт очсугай. Дагроиан нь биеэ даасан ханлиг бөгөөд өөрийн гэсэн хэл яриатай, бас хантай боловч энэ арал дээр нутагшин суурьшсан омог билээ. Хүмүүс нь Хубилай хааны албат харьяат гэх боловч зэрлэг омгийнхон. Тэд нар онгон шүтлэгтэй. Одоо би та нарт тэдний нэгэн олиггүй муу заншил ёсны тухай өгүүлсү. Тэдний хэн нэгэн нь өвдөж өвчлөхөд түүний ахан дүүс, төрөл төрөгсөд нь илбэч домчид хүн илгээн өвдсөн хүн эдгэрэх эсэхийг асуулгаж мэргэлүүлдэг байна. Тэдгээр илбэч домчид нь уг хүн эдгэрэх буюу үхэх алин болохыг онгодоос асууж мэргэ төлөг тавьдаг болой. Тэдний мэргэ төлгийг би зүгээр ч нэг “шулмын ид шид” гээгүй билээ, харин тэдгээр илбэч домчид бол үүнийгээ онгон шүтээний хүчин чадал гэж тайлбарладаг. Хэрвээ илбэч домчин өвдсөн хүн үхэх нь гарцаагүй гэвэл түүний ахан дүүс нь хүмүүсийг нөгчөөх аргад мэргэшсэн хүнийг урин авчирч өвчтэй садан төрлөө нөгөө ертөнцөд илгээлэгдэг байна. Тэдгээр нөгчөөгчид өвчтний аманд нэгэн зүйл хийнгүүтэй түүнийг багалзуурдан алаад үхсэн биеэр нь хоол хийж зэхдэг. Тэгээд уг алсан өвчтний ахан дүүс, төрөл төрөгсөд бүгд цугларан уг хоолоо идэж бардаг төдийгүй ясыг нь мөлжиж дуусгадаг байна. Тэд уг хүний бие махбодоос юу ч үлдээлгүй идэх учиртай бөгөөд эс тэгвээс үлдэгдэл нь ялзарч муудан өт хорхой төрүүлдэг агаад тэдгээр өт хорхой нь идэх юмгүй өлсөж өлбөрч үхнэ. Энэ бол өөд бологсдын сүнс ихээхэн нүгэл хилэнцэд унаж байгаа хэрэг бөгөөд үүнээс зайласхийхийн тулд түүний махбодыг дуустал идэж үгүй хийгээд ясыг нь тусгай саванд хайрцаглан өндөр уулын агуйд аваачин ан араатан хүрэхээргүй газар өлгөж оршуулдаг заншилтай. Харь орны аянчин жинчин, аялагч худалдаачдыг барьж аваад амиа золих төлбөр нэхээд тэр нь үл гүйцэлдвээс уг хүний алж иддэг бузар муухай зуршил заншилтай овог омгийнхон билээ.

Одоо би та нарт Ламбри (Lambri) – ийн ханлигийн тухай өгүүлье. Ламбри нь өөрийн гэсэн хантай боловч өөрсдийгөө Хубилай хааны албат харьяат гэж тооцно. Хүмүүс нь онгон шүтлэгтэй. Суман мод, гавар болон төрөл бүрийн үнэтэй халуун ногоо их элбэг. Энэ нутгийнхан суман мод тарихдаа эхлээд түүний үрийг газарт булж соёолуулаад дөнгөж цухуйж буй соёолсон үрээ дахин өөр газарт шилжүүлэн суулгаад гурван жил ургуулж байгаад үндэстэй нь ухааж авдаг<sup>207</sup>. Би ч бас энэхүү суман модны үрийг Венецид аваачиж тэр янзаар тарьсан боловч юу ч ургаагүй. Үүнийг хүйтэн сэрүүн цаг агаараас болсон гэж боддог.

Одоо би та нарт жинхэнэ хачин зүйл сонирхуулая. Ламбрийн ханлигт алга дарам хэрийн шодон сүүлтэй хүмүүс амьдарна. Тэдгээр хүмүүсийн биеэр үсгүй. Тэд голдуухан хөдөө нутагт уулархаг газар амьдарцгаана. Хотод бол байдаггүй. Тэдний сүүл нь шодон боловч нохойн сүүл шиг бүдүүн. Энд зэрлэг ан араатан, жигүүртэн шувууд ялангуяа хирс маш элбэг.

Фансур (Fansur) – ийн ханлиг руу аяныхаа жолоог залъя. Фансур нь мөн л Суматра арал дээр суурьшиж нутагшсан улс билээ. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, өөрийн гэсэн хантай боловч өөрсдийгөө Хубилай хааны албат харьяат гэж үзнэ. Энэ ханлигт Фансури нэртэй дэлхийд ховорхон гавартай бөгөөд маш үнэтэй. Фансури гаврыг зөвхөн алтаар л арилжина. Энд улаан буудай буюу өөр ямар нэгэн тариа ургадаггүй, зөвхөн тутарга л ургах бөгөөд хүмүүс нь сүү тутарга хоёроор хооллоно. Эндхийн хүмүүс дал модны дарс нэрэх нь үүний түрүүн миний өгүүлсэнтэй яг адил. Та бүхэнд дуулгамаар нэгэн сонин зүйл бол Эндхийн хүмүүс гурилаа модноос гаргаж авдаг. Үүнийг хэрхэн яаж хийдэг тухай өгүүлье<sup>208</sup>. Тэнд нэгэн төрлийн маш өндөр, хоёр хүн тэвэрч хүрэхээргүй шахуу бүдүүн мод ургана. Уг модны холтосыг хуулмагц гурван хуруу зузаан гурилан давхарга байх. Тэр гурилаа тэвшинд хийгээд дээрээс нь ус

хийгээд саваа модоор сайн гэгч хутгамагц холтосны хэлтэрхий, хог шороо нь усан дээр хөвөөд ирэнгүүт усыг нь асгачихаад гурилаа хатааж аваад элдэв төрлийн боов, бусад зүйлс хийнэ.

Тэнд байхдаа бид энэхүү гурилаар элдэв хоол, хүнс хийж иддэг байсан тул тэр тухай сайн мэднэ. Энэ модны гурил нь төмөр шиг хүнд, усанд хийнгүүт л ёроолд нь живчихнэ. Энэ гурилыг хулс, зэгс адил нарийхан зүсэж болдог. Модны холтосыг хуулмагц модны голыг гурван хуруу зузаан бүрхсэн гурилан давхарга байдаг. Нутгийнхан тэрхүү гурилийг зүсэж аваад богинохон жад хийдэг, жадаа урт хийчихвэл дааж хэрэглэх аргагүй хүнд болно. Тэд уг жадаа үзүүрлээд үзүүрийг нь галд цогшуулан хатаана. Тэр жад нь ямар ч хуягийг нэвт хатгах үзүүртэй төмөр жад шиг бөх бат болно.

Дөнгөж сая би арлын энэ хэсэгт орших ханлигуудын тухай та нарт ярилаа. Харин арлын нөгөө хэсэгт очиж байгаагүй болохоор ярьж хэлэх юм үгүй билээ. Ингээд эндээс хөдөлж Гавэниспола (Gauenispola)<sup>209</sup> хэмээх нэгэн жижгэвтэр аралд очоод тэр арлынхаа тухай ярья.

Аялагч маань Бага Ява арал болон Ламбрийн ханлигаас гараад дарвуулаа босгон умар зүгийг чиглэн нэг зуун тавин (150) бээр орчим хөвөөд хоёр арал дээр хүрнэ. Түүний нэгийг Никобар (Nicobar) гэж нэрлэнэ. Энэ аралд хан эзэн гэж үгүй хүмүүс нь араатан амьтан шиг шав шалдан явцгаана. Тэд нар мөн онгон шүтлэгтнүүд болой. Тэд маш гоё, гурван алд илүү урт өнгө өнгийн торгоор хийсэн бүрээс буюу бүстэй. Тэд тэр даавуугаа үүгээр өнгөрөх худалдаачдаас худалдан аваад гэр орныхоо гадуур хучих буюу тэлж татсан байдаг нь бид алт мөнгө, сувд эрдэнэ, үнэт чулуугаараа баярхдаг шиг тэндхийн хүмүүсийн баян чинээлгийг илэрхийлэх эд болдог. Тэд эдгээр даавуугаар өөр юу ч эс хийх агаад зөвхөн бусдын нүдэнд баян чинээлгээ илтгэх үзүүлбэр л болгодог. Энэ арлын ойд улаан зандан, наргил модны самар (манайханд бол Фараоны самар гэж нэрлэдэг), диваажингийн алим, лиш, суман мод болон бас бус үнэ цэнэтэй, ховор нандин мод ургана. Өөр ч гоц гойд яриад байх зүйл үгүй тул Андаман (Andaman) арлын тухай өгүүлсүгэй.

Андаман бол маш том арал. Тэнд хаад, эзэд байдаггүй, хүмүүс нь онгон шүтлэгтэн боловч зэрлэг адгуус араатан шиг амьдарна. Одоо би та нарт энэ номондоо тодорхой бичиж оруулсан нэгэн овог угсааны хүмүүсийн тухай ярья. Энэ арал дээр амьдрах тэр овог угсааны хүмүүс нохой шиг толгойтой, ялангуяа шүд, нүд хоёр нь яг л нохойнх шиг. Тэдгээр хүмүүс маш зэрлэг догшин ааш авиртай өөрийнхөө овог угсааны л биш бол таарсан хүнээ бариад иднэ. Элдэв амттан, халуун ногоо элбэг. Тутарга, сүүгээр голлон хооллох авч дайралдсан махаа юуных ч байсан хамаагүй идэцгээнэ. Тэнд наргил модны самар, диваажингийн алим зэрэг манай нутгийнхаас эрс ялгаатай бас бус олон төрлийн жимс ногоо ургана.

Энэ арал маш гүн устай, үргэлж долгио давалгаатай байдаг тэнгист орших тул тэнд ирсэн хөлөг онгоцнууд зангуугаа хаяж зогсох аргагүй. Хэрэв тэр далайн буланд хөлөг онгоц нэвтрэх л юм бол буцаад тэр тэнгисийн булангаас мэнд гарах бараг боломжгүй давалгаа долгиотой билээ. Тэнгисийн булан үргэлжийн давалгаа долгиотой байхаар барахгүй эргийнхээ шороо чулуу, ургамал модыг үргэлж идэж нураах тул унасан мод далайн булангаар овоолгоостой байх. Далайн тэр булан овоолгоостой унанги модоор дүүрэн байх нь харахад гайхаш төрүүлэм.




Андаманы арлыг орхин гарч дарвуулаа босгоод баруун өмнөд зүгийг барин нэг мянган (1000) бээр аялаад ертөнцийн хамгийн сайхан, хамгийн том Цейлон (Ceylon) аралд хүрнэ. Цейлон арлын эргийн эргэн тойрон урт нь барагцаагаар хоёр мянга дөрвөн зуун (2400) бээр хүрнэ. Яг үнэндээ бол түүнээс ч урт бололтой, учир нь зарим нэгэн далайчдын зурагт гурван мянга таван зуун (3500) бээр гэж тэмдэглэсэн байж билээ. Умрын салхи энэ орчимд маш хүчтэй, байнга үлээх тул арлын нэлээд хэсэг нь байнга усан дор орших агаад үүнээс үүдээд арлын хуурай газар их бага хэмжээтэй байдаг болой<sup>210</sup>.

Одоо би та бүхэнд энэ арлын тухай зарим зүйлийг ярьж өгье. Арлын захирагч ханы нэрийг Сэндэрнам (Sendernam) гэнэ. Хүмүүс нь онгон шүтлэгтэй. Харь орны аль нэгэн хаанд даган орж захирагдаагүй. Хүмүүс нь зөвхөн бэлэг эрхтнээ хаацайлах төдий хаалт зүүгээд бусад бие нь нүцгэн байна. Энэ газар тутарганаас өөр тариа будаа байдаггүй. Тэнд гүнжид арвин их ургах агаад түүгээрээ тос хийнэ. Хүмүүс нь сүү, тутарга, махаар хооллох агаад дээр миний өгүүлсэн шиг дарс нэрж ууна. Энд дэлхийд ховорхон сайн суман мод ургана. Энэ арал дээр ертөнцөд өөр хаана ч байхгүй, хаанаас ч эрээд олдохгүй нал эрдэнэ буюу бадмаараг чулуу байдаг. Түүнээс гадна индранил, молор, цэнхэр башига, анар зэрэг эрдэнийн болон үнэт чулуу энэ арал дээр элбэг. Арлын эзэн хан дэлхий дээр өөр хаана ч байхгүй гоц сайхан бадмаараг чулуутай, бадмаараг чулуу нь төө илүү урт, хүний гарын шуу шиг бүдүүн галын дөл шиг улаан өнгөөр гэрэлтэнэ. Түүнийг мөнгөөр үнэлэх үг олдохгүй бөгөөд ер нь мөнгөөр худалдан авна гэж бодоход ухаанд буухгүй байна.

Та нарт бас нэгэн зүйлийг хэлэхэд Хубилай хаан Цейлон арлын ханд элч илгээн түүнд байгаа бадмаараг чулууг худалдаж аваад оронд нь бүхэл бүтэн хот өгсүгэй гэхэд хан энэ бадмаараг чулуугаа энэ дэлхий дээр байх юугаар ч үл арилжина, учир нь миний өвөг дээдсээс надад уламжилж ирсэн удам угсааны маань эрдэнэс баялаг билээ гэсэн хариу өгчээ. Ийм учир шалтгаантай тул Клиан (Klian) энэхүү бадмаараг чулуугаа ямар ч үнэ хүрсэн зарахгүй гэжээ. Цейлон арлын оршин суугчид нь зүрх зориг шантрамхай, урваж шарвах зуршилтай өөдгүй муу хүмүүс тул цэрэг хөдөлгөх хэрэг гарвал харь орноос цэрэг хөлслөн авдаг бөгөөд ялангуяа Сарацин хүмүүсийг голдуу хөлслөнө. Энд одоо өөр гоц гойд үзээд, сонирхоод байх зүйл үгүй тул Энэтхэг орны зүг аяны жолоогоо зальяа.

## Долоодугаар бүлэг

### Энэтхэг орон



Аялагч аянчин маань Цейлон арлаас гараад баруун зүг рүү жар орчим бээр хөвөөд Маабар (Maabar) хэмээх нэгэн том мужид хүрэлцэн ирэх агаад энэ мужийг Их Энэтхэг<sup>211</sup> гэж нэрлэнэ. Үнэнхээр энэ бол Энэтхэгийн нутгийн ихэнх хэсэг билээ. Энэ муж өөрөө эх газрын нэгэн хэсэг болно. Энэ нутгийг ах дүү таван хан захиран удирдах агаад би та бүхэнд хан бүрийн тухай тусгайлан ярьж өгнө. Энэтхэг бол ертөнцийн хамгийн гайхамшигтай, хамгийн баян орон гэдгийг та минь бүү мартаарай. Би ч та бүхэнд мэдэх хэрээрээ ярьж өгнө.

Энэтхэгт очиход эхлээд таарах ханлигийг дээр миний ярьсан ах дүү таван ханы нэг Сэндэр Банди Дивар (Sender Bandi Devar) гэгч захиран сууна. Энэ ханлигаас маш том бөгөөд үзэсгэлэн төгс сувд эрдэнэ олджээ. Ер нь Маабар болон Цейлон арлаас энэ дэлхийд гайхагдсан эрдэнийн чулуу болон сувд эрдэнэ олддог гэдгийг та бүхэн юу андах билээ. Харин би одоо эдгээр сувд эрдэнийг яаж олсон, хэрхэн цуглуулдаг талаар өгүүлье.

Эх газар арал хоёрын хооронд найман алд, арван алд зарим газраа бүр хоёр алд орчим гүнтэй гүехэн устай далайн тохой бий. Энэхүү гүехэн устай тохойгоос сувд эрдэнэ шүүрдэг билээ. Хэсэг бүлэг худалдаачид хоорондоо нэгдэн нөхөрлөл юм уу компани үүсгэн байгуулж сувд шүүрэхэд зориулсан том хөлөг онгоц хөлслөн авахаас гадна мөн хэд хэдэн завь авч хөлөг онгоцондоо бэхлэн чирч явна. Энэхүү гүехэн устай далайн тохой нь сувд шүүрдэг худалдаачдын онгоцоор дүүрэн байна. Тэдгээр худалдаачид мөн сувд шүүрдэг шумбагч эрсийг хөлслөн аваад дөрөвдүгээр сарын эхнээс таван сарын дунд хүртэл эх газрын эрэгт орших Бекталла гэдэг боомтод хуран цугларна. Хөлөг онгоцнууд тэндээс өмнө зүгт жаран бээр зайд далайд гарцгаан зангуугаа хаяж зогсоно. Тэдгээр хөлөг онгоцноосоо чирч авчирсан завиндаа

сууцгаан загас барих, сувд шүүрэх ажилдаа орно. Үүнийг хэрхэн хийдэг тухай ярьж өгсү. Худалдаачдын хөлсөлж авсан шумбагчид завьнаас далай руу үсрэн орж гурван алд, дөрвөн алд, заримдаа бүр арван алдын гүнд шумбан орж амьсгалсан агаараа дуустал байж байгаад гарч ирж амраад дахин шумбах зэргээр өдөржин зогсолтгүй шумбана<sup>212</sup>.

Ингэж шумбан далайн ёроолд хүрэх тоолондоо хясаа цуглуулна. Эдгээр хясааны зөөлөн нялцгай биед том жижиг төрөл бүрийн сувд шигтгээтэй байдаг. Хясааныхаа дунг нээж модон хөнөгтэй усанд хийгээд орхиход нялцгай зөөлөн эд нь задарч сувд нь тунаж үлдэнэ. Ингэж далайн хясаанаас сувдыг нь салган авдаг. Далайгаас шүүрч цуглуулсан сувдны тоог баримжаалж хэлэх ч аргагүй билээ. Ийм аргаар далайн энэ тохойгоос шүүрч цуглуулсан сувд солонгорон туяарсан өнгөтэй, бөөрөнхий голдуу байх агаад тэдгээр сувдыг хорвоо дэлхийгээр дамлан худалдаална. Тавдугаар сарын дундаас сувдтай хясаа олдохоо больдог. Эндээс бараг гурван зуун бээр зайтай далайн булангаас есдүгээр сарыг дуустал аравдугаар сар гартал сувдтай хясаа шүүрч болдог.

Энэ ханлигийн захирагч хан нь энэхүү сувд шүүрэх ажлаас асар их орлого олдог. Худалдаачид өөрийнхөө олзны аравны нэг хувийг ханд татвар болгон хураалгана. Үүнээс ч их орлого олдог хэсэг хүмүүс байх агаад тэднийг бярман гэх, тэдгээр бярмангууд тарни уншиж сувд шүүрдэг шумбагчдыг махчин загаснаас хамгаална. Бярмангууд тарниа зөвхөн өдрийн цагаар уншина, шөнө загаснууд юугаа хийх нь тэдэнд хамаагүй билээ<sup>213</sup>. Бярмангууд зөвхөн загас ч биш бусад бүхий л араатан, жигүүртнийг номхотгох тарни уншина. Энэ Маабар нутагт хувцас эсгэдэг эсгүүрчин, оёдог оёдолчин гэж огт байхгүй төдийгүй тийм ойлгоц ухагдахуун ч үгүй учир нь хүмүүс нь жилийн турш шав шалдан явцгаана. Эндхийн цаг агаар нь мөнх зунаараа байна. Хүмүүс нь зөвхөн бэлэг эрхтнээ хаасан хэсэг даавуунаас өөр ямар ч хувцас өмсдөггүй. Хан эзэд нь ч жирийн иргэдээсээ илүү хувцас өмсөх нь үгүй, харин зарим нэгэн гоёл, зүүлтээрээ л ялгардаг тухай би та нарт өгүүлсү.

Хан нь бадмаараг, индранил, маргад эрдэнийн чулуугаар гоёж чимсэн бүс даавуугаар ташаан толгойгоо даруулан ороосон байдаг. Тэндхийн хан нь мөн гайхам сайхан нэг зуун дөрвөн (104) сувд хэлхэж, бадмаараг чулуугаар гоёж чимсэн нэгэн тохой илүү урт эрих хүзүүндээ зүүж явна. Эрихний сувд 104 байдаг учир нь хан өглөө, оройн цагаар хоногт хоёр удаа онгон шүтээндээ нэг зуун дөрвөн удаа мөргөж залбирал үйлддэг учиртай билээ. Энэ ёс заншлыг тэр өөрийн өвөг дээдсээс уламжлан авсан бөгөөд одоо түүнийг залгамжлах үр хүүхэддээ өвлүүлэн үлдээх учиртай. Ийм л учраас хан нь зуун дөрвөн сувдтай эрих зүүнэ. Мөргөл залбирлын уншилга тарни нь “расаута, расаута, расаута (пакаута)” гэхээс өөр үг үгүй билээ<sup>214</sup>. Мөн тэр хан гарынхаа шуу болон хөлийнхөө шилбэнд тус бүр цул алтаар хийж эрдэнийн чулуу, сувдаар чимсэн гурван алтан бугуйвч зүүж явна. Мөн хөлийнхөө хуруунд маш үзэсгэлэнтэй том сувд болон эрдэнийн чулуу зүүсэн нь хэний ч нүдэнд тусна. Түүний зүүсэн, гоёсон сувд эрдэнэ, эрдэнийн чулууны үнэ цэнийг баримжаалан хэлэх аргагүй бөгөөд нэгэн сайхан том хотын үнэнээс давж гарна гэж бодож байна. Эдгээр үнэт эрдэнэсийн үнэ цэнийг хэн ч тооцож гаргах гэж оролдож байсангүй агаад тэр их чулуун, сувдан эрдэнэс нь энэ ханы захиран суух ханлигийн нутгийн баялаг учраас түүний эрдэнэсээр биеэ чимэж гоёсныг гайхах зүйлгүй.

Энэ ханлигийн газар нутгаас нэг саггиогоос илүү жинтэй эрдэнийн чулуу буюу сувд эрдэнэ

авч гарахыг хэнд ч зөвшөөрдөггүй. Жилдээ хэд хэдэн удаа ханлигийнхаа бүх нутаг даяар маш том бөгөөд үзэмж төгс эрдэнийн чулуутай, сувд эрдэнэтэй хүн байвал ханы ордонд авчирч өгөөрэй үнийг нь хоёр нугалж төлнө гэсэн зар тарааж тийм эрдэнийн чулуу, сувд эрдэнэсийг худалдан авдаг заншилтай. Хүмүүс ч дуртайяа өгнө. Ийм учраас тэр ханд ийм их ёувд эрдэнэ, үнэт эрдэнийн чулуу хуримтлагдсан байдаг байна.

Одоо би та нарт хачин гайхалтай зүйлсийг өгүүлье. Тэр хан таван зуун эхнэртэй байсан бөгөөд тэд нар нь цөм татвар эм билээ. Тэр хан нүдэндээ тусаж сэтгэлдээ таашаагдсан эмс охидийг эхнэрээ болгодог зуршилтай байжээ. Заримдаа түүний энэ хязгааргүй хүсэл шунал нь эрүүл ухааны хэм хэмжээг умартан мунаглахад хүргэдэг байна. Түүний дүүгийн гэргий нь үзэсгэлэн төгс бүсгүй байсныг ордондоо авчран хүчээр хорьж байсан авч дүү нь ухаалаг, холч бодолтой эр байсан тул юу юуны туханд хүрэлгүй хэрүүл маргаан дэгдээсэнгүй. Харин ахтайгаа дайтан тулалдах гэтэл төрүүлсэн эх нь хоёр хүүгээ дуудан авчирч хоёр хөхөө ил гарган үзүүлж, “та хоёр миний энэ хоёр хөхийг хөхөж хүн болсон гэдгээ мартаж хоорондоо дайтаж тулалдах юм бол би хоёр хөхөө огтлон хаясугай гэж” сүрдүүлэн эвдрэл, тэмцлийг зогсоосон байна.

Одоо өөр бас нэгэн гайхмаар зүйлийг өгүүлье. Тэр хааны түшмэд, зарц нар нь хандаа хязгааргүй үнэнч тул зөвхөн энэ насанд нь төдийгүй хойд насанд нь ч хамтдаа байна гэж өчицгөөдөг байжээ. Ханыгаа ордондоо байхад, улс орноороо хэрэн хэсэж явахад хаана л бол хаана тэд нар үргэлж хамт байсан төдийгүй өөд болсон ханыг шатаан чандарлах их түүдэг галд үсрэн орж хамтдаа шатаж үхэцгээсэн байдаг.

Энэ оронд мөрддөг бас өөр нэгэн заншлын талаар өгүүлье. Өөд болсон хан эцгийнхээ орыг залгамжилсан хүү нь: “Надад хан эцгээс минь үлдэж өвлөгдсөн улс байна. Түүний хүн ард, газар нутаг нь байна” гээд хан эцгийнхээ хурааж хуримтлуулсан эд баялаг, эрдэнэсийг огт хөнддөггүй бөгөөд өөрөө түүн шиг эд баялаг хурааж хуримтлуулдаг тул тэр орны эд баялаг үеэс үе дамжин арвижсаар асар их баялаг эд хөрөнгө, эрдэнэс хуримтлагджээ.

Энэ нутагт адуу огт байдаггүй. Ийм учраас бүтэн жилийнхээ орлогыг, эсвэл түүний дийлэнхийг морьд худалдаж авахад зориулдаг, харин хэрхэн хаанаас, яаж худалдаж авдаг талаар би та нарт ярья. Хормуз (Hormuz), Дофар (Dhofar), Шихр (Shihr) болон Аден (Aden) нутгийн худалдаачид адуу өсгөж үржүүлдэг муж нутгаас хамгийн шилдэг сайн байлдааны унаа, ачааны зүтгүүр болдог морьдыг худалдан авч тэр ханлигийн хан болон түүний ах дүү дөрвөн ханд авчирч өндөр үнээр борлуулдаг байна. Зарим морь 500 алтан саггийн үнэ хүрдэг, энэ нь 100 мөнгө маркаас илүү үнэ хүрлээ гэсэн үг. Эндхийн хан жил бүр 2000 морь худалдаж авах агаад түүний ах дүү нар ч мөн үүнээс цөөнгүй морьд худалдан авдаг. Жилийн эцэс гэхэд тэдгээр морьдоос нэг зуу хүрэхтэй үгүйтэй нь л амьд мэнд үлдэнэ. Тэр ханлигийн хүмүүс адуу хэрхэн маллах, яаж арчилж хамгаалах, яаж тэжээж тэтгэх, хэрхэн эмчилж сувилах талаар юу ч мэддэггүй учраас худалдаж авсан морьд нь үхээд дуусдаг байна. Морьд худалдаж байгаа худалдаачид ч адууг хэрхэн арчилж хамгаалах, тэжээж хооллох, эмчилж эдгэрүүлэх талаар ганц ч үг хэлдэггүйгээр үл барам малын эмч байдаг талаар тэдгээр хан нарт ганц үг дурсдаггүй. Учир нь тэдний худалдаж авсан морьд хэр хурдан үхэж дуусвал худалдаачдад тэр хэрээр ашигтай байдаг.

Өөр бас нэгэн хачирхалтай заншлын тухай өгүүлье. Эндхийн хэн нэгэн хүн хүнд ялт хэрэг

Үйлдвэл ханы зарлигаар уг хүнийг цаазлан хороох болдог байна. Тэр ялтан нь аль нэгэн онгод шүтээнд үнэн ч учраас өөрийгөө хороон тэр онгод өргөж тахих боллоо гэж нийтэд зарладаг байна. Уг ялтны ахан дүүс, төрөл төрөгсөд нь уг хүнийг тэргэн дээр суулган арван хоёр илд мэс өгөөд хот дундуур тэрэгтэй ялтныг чирч: “Энэ эрэлхэг эр тийм онгоныг шүтэн мөргөдөг тул түүнийхээ төлөө амиа өргөж золихоор шийдлээ” гэж зарлан хашгирцгааж явдаг байна.

Ингэж явсаар цаазын газар ирэнгүүт ялтан маань хоёр хутга авч, өндөр дуугаар: “Би тийм гэдэг онгоныг шүтэж мөргөдөг тул түүнийхээ төлөө өөрийгөө егүүтгэж байна гээд хоёр сүвээ рүүгээ хутгаа дүрж орхино. Энэ маягаар хутгаа хоёр хоёроор нь авч хавирга, цээж, хоолой руугаа дүрэх тоолондоо нөгөө үгээ хашгирсаар үхэдхийн унана. Үүний дараа маш хурц илдээр түүний толгойг огтлон салгана. Ингэж ялтан өөрөө өөрийгөө цаазлан хороомогц ахан дүүс, төрөл төрөгсөд нь ихээхэн хөөр баяртайгаар түүний бие цогцсыг шатаан чандарлана.

Бас нэгэн ёс заншлыг өгүүлбэл: Эр нөхөр нь үхээд шарилийг нь чандарлаж байгаа гал руу эхнэр нь үсрэн орж хамтдаа шатаж үхэх нь цөөнгүй байдаг. Ингэж өөд болсон эхнэрийг олон түмэн жигтэйхэн магтан хэлэлцэх агаад ингэж өнгөрдөг эхнэрүүд ч мөн цөөнгүй таарна.

Энэ ханлигийн хүмүүс онгон шүтлэгтэй бөгөөд ихэнх нь үхэр шүтнэ. Эндхийн хүмүүс үхрийн мах иддэггүй, үхэр алдаггүй. Харин үхрийн мах иддэг нэгэн омгийнхон буй бөгөөд тэднийг гави гэж дуудана. Гави нар үхэр алдаггүй, харин элдэв тохиолдлоор үхсэн үхрийн махыг иддэг. Орон гэр, байшин саваа үхрийн баасаар шавж хатаана.

Энэ нутгийн өөр бас нэгэн сонин ёс заншил гэвэл, хан, язгууртан нар нь цөм газар сууцгаана. Тэднээс та бүхэн ширээ сэнтий дээр морилон суухгүй юунд газар суудаг вэ? гэж асуухад: Газар суух бол хамгийн хүндтэй дээд ёсон, учир нь бид газар эхээс ургаж төрсөн эргээд газартаа шингэх билээ гэж хариулана. Үүний учир хэн ч атугай газраас дээгүүр жаалах нь зохимжгүй бөгөөд үүнийг хэн бүхэн хайхрахгүй алгуурлаж болдоггүйг мэдвэл зохилтой гэнэ.

Дээр миний өгүүлсэн үхрийн мах иддэг гави омгийнхон нь дээр нэгэн цагт гэгээн хутагт Томасыг хорлон алсан омгийнхон билээ. Томас хутагтийг оршуулсан тэр газарт эдгээр хүмүүсийг огт ойртуулдаггүй байх агаад арван эр нэгэн гавийг хүчлэж үл дийлэх төдийгүй хорин эрс ч хүчлээд Томас хутагтийн шарил орших газар тэднийг ойртуулж чаддаггүйн учир нь риди хувилгааны хүчин шингэсэн энэ газарт тэднийг цаанаасаа үлдэн хөөж ойртуулдаггүйнх гэдэг билээ.

Энэ ханлигт тутарганаас өөр тариа ургадаггүй. Хэрвээ энэ газар сайн үүлдрийн азарга гүү хээлтүүлбэл тэр гүүнээс муруй сарий хөлтэй явж чаддаггүй муу унага төрнө. Энэ нутагт адуу үржүүлэх боломжгүй нутаг билээ.

Эндхийн хүмүүс дайн тулаанд орохдоо жад, бамбайгаар зэвсэглэн шав шалдан явцгаана. Эндхийн хүмүүст эр хүний эр зориг, ид хав гэж огтхон ч үгүй. Тэд ан араатан агнадаггүй, амьд амьтны амь тасалдаггүй. Хонь мал муучилах, шувуу тахиа нядлах хэрэг гарвал өөрсдөөс нь өөр шашин шүтлэгтэй Сарацин болон бусад хүмүүсийг хөлслөн уг ажлаа гүйцэлдүүлнэ. Мөн тэдний өөр нэгэн зуршил гэвэл эр, эмгүй ялгаагүй хоногт хоёр удаа буюу өглөө, орой хоёр хүйтэн усаар биеэ угаана. Харин энэ угаалгыг эс үйлдсэн хүмүүнийг даяанч буюу буруу номтон хэмээн үзэн ядна.

Энэ нутгийн хүмүүс хоол хүнсэндээ хүрэх, идэх уухдаа зөвхөн баруун гараараа хүрнэ. Солгой гараараа юманд хүрэхийг ихэд цээрлэн бузар гар гэж үзнэ. Хүн бүхэн өөрийн гэсэн аягатай зөвхөн тэр л аягаараа ус, ундаа ууна, өөр хэнтэй ч аягаа солихгүй<sup>215</sup>. Тэд аягаараа юм уухдаа аяганыхаа амсарыг зууж сорж уудаггүй, харин аягатайгаа ам руугаа юүлж уудаг. Тэд аяганыхаа амсарт уруулаа үл хүргэх агаад, бас өөр хэнд ч аягаа дамжуулдаггүй. Аягагүй хүмүүс юм уухаар бол гар дээрээ хийлгэж байгаад алганыхаа хонхороос юм уудаг. Энэ орны хууль цааз нь маш хатуу ялангуяа хүн алсан, хулгай хийсэн хүмүүсийг нэн хатуу шийтгэнэ. Өр авлагын талаар бол дараах маягаар шийдэнэ. Өртэй хүн өрөө төлөхгүй элдэв шалтаг шалтгаан заан бултсаар ахул авлагатай хүн түүнийг хаа нэгтэй гүйцэж аваад түүнийг тойруулан газар дээр тойрог зурахад өртөн тэрхүү тойргоос үл гаран өр ширээ тэр өдөртөө төлж дуусгахаар амлана. Амласнаа үл биелүүлэн тойрог зурааснаас өөрөө гарвал маш их торгууль төлөх буюу цаазаар авахуулах ч ял хүлээнэ.

Эрхэмсэг Марко Поло гуай нэгэн удаа тэр газрын хан харийн худалдаачнаас авсан бараа таваарынхаа үнийг төлөхөөс зайласхийсээр удсан тул худалдаачин өрөө нэхэн ийм явдал болохыг өөрийн нүдээр үзжээ. Аргаа барсан худалдаачин ханыг өөрийнхөө улс орныг тойрч явахтай таараад түүний хөсөг, унаа унаш юу байгаагий нь багтаасан тойрог зурж орхиход хан тэр газартаа хөдлөлгүй зогсож худалдаачны нэхсэн өрийг бүрэн төлж барагдуулсан байна. Үүнийг харсан хүмүүс харав уу хан өөрөө хууль дүрмээ чандлан сахиж байна шүү гэж шуугицгаана. Харин хан: “Энэхүү дүрэм журмыг би өөрөө тогтоосон билээ. Гэтэл энэ маань миний эсрэг үйлчилдэг байна шүү, үүнийг эвдэн залруулах ёстой “ гэж өгүүлэв.

Эндхийн ихэнх хүмүүс архи дарсанд үл шунан дурлана. Харин далай тэнгисээр аялан архи дарс уусан хүмүүсийг ямар нэгэн зүйлийг гэрчлэх буюу батлан даах чадваргүй гэж үзнэ. Далай тэнгисээр аялагсад бол яахаас ч үл буцах найдаж болохгүй хүмүүс гэж тооцоно. Харин хуял тачаалаа ямар ч байдлаар тайлж тайтгарахыг нүгэл хилэнц гэж үл тооцоно. Цаг агаар нь маш халуун дулаан учир хүмүүс нь үргэлж нүцгэн шалдан явна. Зөвхөн зургаа, долоо, наймдугаар сард<sup>216</sup> л бороо орно. Хэрэв энэ гурван сард бороо хур ордоггүй байсан бол энэ газар амьд амьтан тэсэж байх аргагүй халуун байхсан. Энэ гурван сарын хур бороо эндхийн цаг агаарыг зөөллөж өгдөг билээ.

Эндхийн хүмүүс дунд маш олон мэргэн шинжээчид бий. Тэд нар хүний нүүр царай, нүдний харц төрх байдлыг шинжин тунгааж тэр хүн сайн хүн үү, муу хүн үү гэдгийг хэлнэ. Мөн араатан, жигүүртний байдлыг шинжин харж юу болохыг урьдчилан тааж хэлнэ. Тухайлбал хэн нэгэн хүн аян замд гарч явтал хаа нэгтэй хэн нэгэн хүн найтаавал уг хүн тэр газартаа зогсоно, хоёрдахь удаа найтаахыг сонсвол шууд л гэр рүүгээ буцаад явна<sup>217</sup>.

Мөн дээрхийн нэгэн адилаар долоо хоногийн гараг бүрт нэгэн муу цаг байдаг гэж үзэх агаад тэр цагаа чойач (choiach) гэж нэрлэнэ. Ийм байдлаар муу цаг хэдийд таарахыг тогтоосон байдаг бөгөөд Даваа гарагт өглөөний долоон цагаас, Мягмар гарагт өглөөний есөн цагаас, Лхагва гарагт үдээс хойш нэг цагаас гэх мэтчилэн муу цаг эхлэдэг байна. Эдгээр муу цагийг тодорхойлон тусгай номонд бичиж тэмдэглэсэн байдаг. Мөн муу цагийг хүний сүүдрийн уртаар баримжаалан хэмжиж тогтоох ч бий агаад жишээлбэл тийм тийм өдөр, тэр тэр цагт хүний сүүдрийн урт тэдэн алхам урт байвал тэр мөчөөс муу цаг буюу чойач эхэлнэ гэх мэт. Энэ мэтээр наран хөөрөх үед хүний сүүдэр богиносох буюу наран унах үед сүүдэр уртсахад

Чойач болоод өнгөрсөн гэсэн үг. Энэ бүхнээ тэд хуанли шиг бичиглэн үлдээнэ. Чойач цагийн үеэр тэд нар элдэв ажил үйл эхлэх, арилжаа наймаа хийхийг эрс цээрлэнэ. Худалдаа арилжаа ярилцан, наймаа тохиролцох гэж байсан хүмүүсийн хэн нэг нь наран сөрөг зогсож сүүдрээ хэмжингүүт “чойач цаг” болж байна яриа хэлцлээ зогсоо гэж хашгирах жишээтэй. Хэсэг хугацаа өнгөрмөгц сүүдрээ дахин хэмжиж үзээд за чойач цаг өнгөрсөн байна наймаа арилжааныхаа хэлцлийг үргэлжлүүлье гэгцгээх. Чойач цагт хийсэн ямар ч ажил үйл бүтэлгүй болох агаад арилжаа наймаанд бол ашиг хонжоо гарахгүй гэж үзэцгээнэ.

Тэдний орон байшингийн хана, адраар тэмээн аалз хэмээх хортой аалз гүрвэл мэт гүйлдэнэ. Тэдгээр аалз хазвал хүн хорддог. Тэр аалзнууд “чис” гэсэн дуу гаргана. Энэ дуунд нууц увдис, зөгнөл шингэсэн байдаг гэж хүмүүс итгэнэ. Хэрвээ хүмүүс наймаа арилжааныхаа хэлцэл тохироог хийж байхад тэмээн аалзны “чис” гэх дуу гарвал сайн үйл бүтэх буюу муу үйл тохиох зөгнөл болдог гэж үзнэ. Гэхдээ хүмүүсийн чухам аль нэгэн талд буюу толгой дээр дуу нь гарав уу гэдгээс хамааран сайн, муу үйлийн зөгнөл, ёрлол болно. Энэ тухай дээр нэгэн газар Марко Поло гуай ярьж байснаа давтан өгүүлэв бололтой. Хэрэв тэмээн аалзны “чис” сайн зүгээс гарвал арилжаа наймаа бүтэмжтэй боллоо гээд харилцан тохиролцоно. Эсвэл худалдаачинд сайн худалдан авагчид муу байж мэдэх, эсвэл эсрэгээрээ тохиох, бүр хоёуланд нь муу гэж үзвэл арилжаагаа ч зогсооно. Энэ бүх шинж тэмдэг, зөн совин нь урт удаан хугацаанд амьдралаар шалгагдсан мэдлэг оюуны шалгарсан арга, мэдрэмж гэхэд хилсдэхгүй билээ.

Энэ ханлигт хүүхэд төрмөгц эцэг, эх нь хүү юм уу, охиныхоо төрсөн цаг нар, өдөр сар, сарны мөчлөгийг маш тодорхой бичиж тэмдэглэж авна. Эндхийн хүмүүс тэр нутгийн мэргэч төлөгч, зурхайч, идтэн шидтэнд гүнээ итгэн бараг л алхам бүхнээ тэдний мэргэ төлөг, зааврын дагуу хийдэгтэй холбоотой билээ.

Хүүтэй айл хүүгээ арван гурван нас хүрмэгц гэр орноосоо явж өөрөө биеэ даан амьдар гээд гаргана. Ингэхдээ хүүдээ хорь юм уу хорин дөрвөн зоос, эсвэл тэр хэмжээний эд бараа өгөөд явж наймаа арилжаа хийгээд олсон ашиг орлогоороо амь зуу гэнэ. Тэр газрын хүмүүс ингэж хүүгээ арилжаа наймааны ажилд сургаж дадлагажуулдаг байна. Энэ бол зөхөн хөвгүүдэд хамаарна. Тэдгээр хөвгүүд өдөржин зогсоо зайгүй шогшин эндээс нэг эд бараа авч тэнд аваачин борлуулах зэргээр ээрүүл шиг эргэлдэнэ. Сувдны худалдаа эхэлмэгц усан боомт руу очиж загасчдаас тав зургаан сувд худалдаж аваад сувдны наймаачдын мухлагт очиж: “Би энэ сувдыг тийм үнэ хүрнэ гэж бодож байна, танд таалагдаж байвал тийм үнээр авна уу?” гэж санал болгох агаад сувдны наймаачид ч уг сувдны бодит үнэнээс арай дээгүүр үнээр худалдан авч урамшуулна. Тэндээс буцахынхаа өмнө наймаачинд хандан: “Би бас өөр бусад бараа авчирвал та худалдаж авна биз дээ” гэж лавлана. Ингэсээр тэдгээр хөвгүүд маш ухаалаг хэрсүү, мэдрэмж сайнтай худалдаачид болж өснө. Гэртээ харихдаа ээждээ хоол хүнс, өөртөө хувцас хунар авч харих бөгөөд үүнээс хойш эцгийнхээ нуруунд үүрүүлсэн ачаа бололгүй биеэ даасан амьдралаа эхэлнэ. Энэ ханлигийн болон бүх Энэтхэг орны ан араатан, жигүүртэн шувууд ятуунаас бусад нь бүгд манай нутгийнхаас эрс ялгаатай. Мөн энд сарьсан багваахай гэж нэгэн төрлийн шөнийн шувуу байх, тэр амьтан өд сөд гэж огт үгүй зөвхөн харанхуй шөнө л нисдэг, манай нутгийн хур агнадаг харцгай шиг том. Эндхийн хур агнадаг харцгай нь хэрээ шиг хав хар өнгөтэй. Бас нэгэн нэмж хэлэх зүйл бол энэ нутгийнхан морьдоо тутаргатай чанасан мах болон бас бус чанамал хоолоор тэжээдэг гэдгийг сонирхуулж байна.

Эндхийн сүм хийдүүдэд залсан онгон шүтээнүүд нь эр, эм хүйстэй маш олон төрөл байх агаад охид бүсгүйчүүд шүтэж мөргөхдөө дараах дэг жаягийг баримтлана. Эцэг эх нь охидоо өөрсдийнхөө мөргөж шүтэж ирсэн онгондоо даатган өргөнө. Ингэж охид онгон шүтээнээ сонгож авсан цагаас эхлэн тэр сүм, хийдийн лам нар охидыг онгон шүтээндээ байн байн ирж мөргөж, онгон шүтээнээ цэнгүүлж байхыг шаардана. Охидууд лам нарын шаардлагын дагуу сүмд ирж дуу дуулан бүжиг бүжиж онгоноо тахих найр цэнгээнд оролцоно. Ингэж мөргөж шүтдэг охид маш олон тул долоо хоногт хэд хэдэн удаа онгон шүтээнээ цэнгүүлэх найр цэнгээн болно. Тэдгээр охид онгон шүтээнээ хооллох амттай идээ хоол бэлтгэн ирж шүтдэг онгоныхоо өмнөх ширээн дээр өрж тавиад өөрсдөө дуу хуур хөгжөөн дуулж, бүжиглэж наадна. Ийм маягаар нэлээд хугацаа өнгөрсний дараа онгод шүтээнүүд хооллож дууссан гээд өөрсдөө идээ будаа, хоол ундаа хувааж идээд гэр гэртээ харьцгаана. Тэдгээр охид, бүсгүйчүүд эр нөхөрт гаран гартлаа энэхүү мөргөл, цэнгээнээ тасралтгүй хийх агаад ийм охид бүсгүйчүүд энэ ханлигт маш олон байдаг<sup>218</sup>. Онгод шүтээнүүдээ ингэж ойр ойрхон цэнгүүлж, хооллож байхын учир нь эр, эм онгод хоорондоо хамтран амьдардаггүй, хамтран ярилцаж баяр цэнгэлээ хуваалцдаггүйгээс үүдэлтэй гэх ажээ. Ингэж онгод шүтээнүүд нь хоорондоо эв түнжин муутай, бие биендээ уур уцаартай байвал хүмүүсийн ажил үйл бүтэлгүйтэх нь энүүхэн энд төдийгүй улам улам муудах муу үр дагавартай гэж үздэг. Ийм учраас охид бүсгүйчүүд сүм хийдэд ирж онгод шүтээнийхээ өмнө чармай нүцэглэн зөвхөн нууцгайгаа хаагаад дуулж, бүжиглэн онгоны сэнтий доогуур шурган ордог. Энэ үед онгод бурхад нь тэдэнтэй хамт цэнгэн наргидаг гэх бөгөөд охид бүсгүйчүүд дуулж бүжиглэхдээ: “Эзэн бурхан минь та яагаад эзэгтэйтэйгээ эв эвдэрч тоохгүй байна?” гэж хашгирцгаана. “Онгон бурхан минь та яагаад эзэгтэйдээ ингэж хүйтэн хөндий хандана вэ? Тэр бүсгүй бурхан чинь эрхэмсэг наалинхай, уян налархай, түүнтэй хамт байх шиг дээдийн жаргал үгүй билээ” гэцгээн хөлөө өргөн бурхад онгодынхоо хүзүүн дээгүүр тавина. Ингэж дуулж, бүжиглэсэн охид гэр гэртээ харьцгаана. Маргааш өглөө нь сүмийн лам нар эр эм онгод бурхад хоорондоо эвлэрч эв найртай болсныг баяртайгаар зарлана. Энэ мэдээг сонссон бүхэн баярлаж бахархацгаана. Эдгээр охид бүсгүйчүүд эр нөхөрт гараагүй байхдаа бие махбод нь маш чанга хатуу төдийгүй биений нь хаанаас ч чимхээд авах сул махгүй чийрэг байдаг. Эр нөхөрт гараад бие нь зөөлөрч сулрах боловч хөх нь үргэлж сэргэр босоогоороо байдаг.

Хүмүүс нь зэгсээр сүлжиж хийсэн хөнгөн ортой. Унтах болохоороо орондоо ороод олсоор татан ортойгоо байшингийнхаа адар дор дүүжлэгдэнэ. Энэ нь хүмүүс тэмээн аалз, нохой бөөс болон бусад шавж хорхойноос болгоомжлохоос гадна арай сэрүүн салхитай унтах гэсэн оролдлого билээ. Өрх гэрийн тэргүүн болон язгууртнууд л ингэж унтана. Бусад хүмүүс бүгд их зам дагуу хээр унтана, учир нь хүмүүс шөнийн сэрүүнд газар хороохоор явцгаадаг, мөн ажил үйлээ амжуулдаг. Ингэж яваа хүмүүс хүүдий савтай сувд болон бусад эд бараагаа дэрлэн хэвгэцгээх агаад хулгай зэлгийд юм аа алдана гэж айж эмээдэггүй. Хэрэв эд юмаа алдвал түүнийг нь шуурхай олж өгөх буюу хохирлыг нь төлж барагдуулах, учир нь уг хүн бүгд унтах ёстой зам дээр унтаж байсан. Зам дээр унтаагүй буюу босож яваад юмаа алдсан бол хэн ч түүнийг нь олж өгөхгүй, төлж хохирлыг нь барагдуулахгүй уг хүний хохь болно. Учир нь замаас өөр газар байсан. Энэ газар орны зан заншил, хүмүүсийн амьдрал ахуйн талаар нэлээд зүйлийг ярилаа, одоо эндээс хөдөлж Мотупалли (Motupalli)–н ханлигт очицгооё.

Мотупаллийн ханлиг нь Маабараас хойт зүгт нэг мянга<sup>219</sup> орчим бээр зайтай оршино. Мотупаллийн ханлигийг нэгэн домч эхнэр удирдан захирна. Эр нөхрөө үхсэнээс хойш бүтэн



дөчин жилийн турш энэ ханлигийг хаанчилж байгаа билээ. Тэр эхнэр эр нөхөртөө аминаасаа илүү хайртай байсан тул цэл залуугаараа бэлэвсэрсэн боловч дахин эрд гараагүй бөгөөд хэрэв дахин эрд гарвал бурхан намайг үл таална хэмээн зарласан байна. Улиран одсон дөчин жилийн турш тэр эхнэр улс орноо шулуун шударгаар удирдан, шүүх цааз, засаг захиргааг эр нөхрөө амьд байсан үеийнхээс огт дордуулаагүй билээ. Тэр эхнэр шиг алба үүргээ шударгаар гүйцэтгэдэг эзэн ноёд, бүсгүй хаад тэр болгон тааралдах нь ховор билээ. Эндхийн хүмүүс бүгд онгон шүтлэгтэй, тутарга, мах, сүү, загас, жимсээр хооллоно.

Энэ ханлигийнхан очир эрдэнийн чулуу олзворлоно. Харин түүнийг яаж олж авч, яаж олзворлодог талаар би та нарт өгүүлье. Энэ ханлигийн нутагт очир эрдэнийн чулуутай уулс олон байх. Үерийн ус тэдгээр уулсын хавцал, агуйг дүүргэн доошоо урсахдаа замдаа таарах бүхнийг хаман одох аж. Бороо татарч, уулсын хавцал хуурай сайр болмогц хүмүүс очир эрдэнийн чулуу хайх, түүх ажилд гарч түүнийг хааяагүй олдог билээ. Зун цагийн ус татраагүй байхад уулсын хавцлаар урсах голын голдирлоос очир эрдэнийн чулуу их олдоно. Зун цагт энд тэсвэрлэж тэвчих аргагүй халуун бас уулсын хавцал, хадны завсар агуйгаар нь дүүрэн асар урт бүдүүн бүдүүн могойтой тул хүмүүсийг аюул осол үргэлж отожд байдаг. Гэвч хүмүүс очир эрдэнийн чулуу эрсээр маш том сайхан эрдэнийн чулуу олсоор л байдаг ажээ. Тэдгээр том том могойнууд нь маш хортой, хорлонтой амьтан тул хүмүүс агуй руу бараг шагайхгүй. Гэвч тэд нар очир эрдэнийн чулууг арай өөр аргаар олзворлодог билээ. Өндөр өндөр уулс, эгц цавчим хадан цохиогоор битүү хүрээлэгдсэн хүн амьтан орох аргагүй уулсын хавцал байдаг. Хүмүүс тэндээс яаж очир эрдэнийн чулуу түүдэг талаар ярьсугай. Цус нь хатаагүй шинэхэн нойтон махыг бөөн бөөнөөр нь уулын хавцал руу хаяхад тэнд байгаа очир эрдэнэс түүхий маханд наалдан шигддэг аж. Тэр үед эндхийн уулсаар могой агнадаг цагаан бүргэд шувууд очир эрдэнэс наалдсан нойтон махыг шүүрэн авч нисэн одох тул бүргэд шувуу хаана очиж суухыг харуулдаж байгаад тэр зүгт хар хурдаараа гүйцгээнэ. Үүнийг үзсэн бүргэд шувуу махаа орхин нисэн одно. Хүмүүс бүргэдийн үлдээсэн махнаас наалдсан очир эрдэнийг түүж авна. Бүргэд шувуу маханд наалдсан очир эрдэнэсийг махтай нь хамт залгиж орхиод шөнө үүрэндээ очмогц залгисан очир эрдэнийн чулуугаа гулгиж гаргах тул хүмүүс бүргэдийн үүрнээс очир эрдэнийн чулуу түүнэ. Та бүхэн очир эрдэнийн чулуу түүдэг гурван аргыг сонсож мэддэг боллоо. Өөр ч бас олон арга бий.

Энэ ханлигаас түүдэг очир эрдэнэ шиг том, сайн чанарын чулуу өөр хаана ч байдаггүй. Та бүхэн эндээс түүсэн очир эрдэнэс манай Загалмайтны ертөнцөд шууд ирж борлогддог гэж бодож байвал тэр чинь ташаа ойлголт шүү. Тэдгээр очир эрдэнэс зөвхөн Хубилай хааны эрдэнэсийн сангаар дамжин бусад оронд, бусад орны хан, язгууртнуудын гарт хүрдэг билээ. Эдгээр үнэт эрдэнийн чулууг хөрөнгө мөнгөтэй хүмүүс л худалдаж авдаг билээ. Одоо та бид өөр бусад зүйлсийн талаар ярилцъя. Энэ ханлигт өөр хаана ч хийдэггүй гоёмсог, нарийн торгон нэхмэл үйлдвэрлэх агаад тэр нь Реймийн нэхмэл даавуутай төстэй. Ийм нэхмэл даавуугаар хийсэн хувцас эдлэлийг хаанхын ч хаад, хатад өмссөн хэний ч өмнө нүүр бардам гангарах билээ. Энэ оронд гэрийн тэжээмэл амьтад элбэг байхын дотор дэлхий дээрх хамгийн том хонь энд байдаг. Хоол хүнс элбэг төрөл зүйл нь олон. Өөр яриад байх онцгой содон зүйл үгүй тул эндээс явж гэгээн хутагт Томас (Thomas) – ыг нутаглуулсан газар очицгооё.

Гэгээн Томасийн шарил нь Маабар нутгийн нэгэн жижигхэн хотод оршино. Тэр хот цөөхөн

оршин суугчидтай, наймаачид худалдаачид очдоггүй, зарж борлуулах бараа таваар үгүй алс бөглүү газар билээ. Гэвч Загалмайтаны болон лал шүтлэгт Сарацин нарын мөргөл шүтлэгийн ариун газар билээ. Энэ нутгийн сарацинууд Томас хутагтыг сарацин хүн байсан гэх агаад агуу зөнч төдийгүй үнэнхүү гэгээрсэн хутагт байсан гэгцгээнэ.

Сүмийг манаж суух загалмайтаны харуулын хүмүүс сайхан дал мод ургуулсан байх агаад мөн тэр модноосоо дарс гаргаж авахаас гадна наргилийн “баавгай самар” хэмээх том том самартай. Нэг ийм самар нь нэг хүний хоол, ундаа элбэг болно. Наргилийн самар гадна талаараа үс хялгас шиг зүйлээр битүү бүрхээстэй байх агаад тэр бүрээсээр нь янз бүрийн зүйл хийдэг. Самрын дотор хоол, ундаа нь хамтдаа байдаг. Наргилийн самар нь чихэр шиг амтлаг, сүү шиг цагаан махлаг эд, том аяга дүүрэхээр шүүстэй байна. Наргил самрын шүүс нь тунгалаг, хүйтэн ундаа болно. Хүн наргилийн самрын цөм дэх махлаг эдийг идээд шүүсийг нь уухад цадталаа хооллож ундаалснаас огт ялгаагүй цадна. Нэг дал модны татварт Загалмайтнууд Маабар нутгийн ханд сард нэг зоос төлнө.

Гэгээн Томасийг оршуулсан газрын тухай гайхалтай сонинг өгүүлэе. Энэ газар мөргөл үйлдэж тахиж шүтэхээр ирсэн загалмайн шашинтнууд оршуулгын газрын шорооноос авч харьцгаадаг. Хэн нэгэн хүн гурав дөрвөн өдрийн халуун хумхаа юм уу, шар чичирдэс өвчнөөр өвдвөл энэхүү шорооноос усаар даруулан увал тэр дороо илааршиж эдгэдэг байна. Энэ шороог уусан өвчтөн эдгэрээгүй нэг ч тохиолдол үгүй билээ<sup>220</sup>. Шороо улаан өнгөтэй гэдгийг анзаараарай.

Манай бурханы мэндэлсний 1288 онд бас нэгэн гайхамшигтай сайхан үйл болсон тухай та бүхэнд өгүүлсүгэй<sup>221</sup>. Энэ нутгийн ноён тэр жил маш их тутарга хураан авчээ. Тэгээд тэр ноён гэгээн Томасийн сүмийг тойрсон байшин сав бүхнийг тутаргаар дүүргэж эхэлжээ. Сүмийг харж хамгаалдаг болон эргэл мөргөл хийхээр ирсэн Загалмайтнууд эндхийн байшин савыг тутаргаар бүү дүүргээч бидэнд орж суух, толгой хоргодох орон байргүй боллоо гэж гуйцгаасан боловч тэдний гуйлтыг үл ойшоосон онгон шүтлэгтэн ихэмсэг дээрэнгүй ноён улам л тутаргаар дүүргэсээр байжээ. Ингээд гэгээнтний сүм болон ойр орчны нь бүхий л байшин савыг тутаргаар дүүргэж орхиод тэндээ хоножээ. Шөнө нөгөө ноёныг унтаж байхад нь гэгээн Томас гартаа сэрээ барин ирж ноёны хоолойд сэрээгээ тулган өгүүлсэн нь: Чи тутаргаар дүүргэсэн байшин сав, сүм хийдийг үтэр түргэн сулла, эс тэгвээс үхлийн муугаар үхэх болно гээд сэрээгээрээ хойлоогий нь шахахад золтой л амь тавьсангүй гэнэ. Маргааш өглөөнөөс нь нөгөө ноён зарлиг буулган бүх орон байшингаас тутаргаа хураан авч бүгдийг суллан цэвэрлэжээ. Энэ тухайгаа ноён ярьж гэгээнтний ид шидийн хүч гэдэгт огтхон ч эргэлзсэнгүй. Загалмайтнууд ч бөөн хөөр баяр болон гэгээн Томасыгаа улам ч илүү шүтэн биширч өргөл мөргөл үйлдэцгээв. Энэ сүмийн орчинд жилийн турш олон олон гайхамшигт зүйлс болдог бөгөөд Загалмайтнуудыг эмчилж эдгэрүүлэх тахир дутуу хүмүүсийг эмчилж эдгээдэг тухай яриа домог үлэмж олон.

Одоо би та бүхэнд гэгээн Томас хэрхэн хорлогдож үхсэн тухай өгүүлсү. Түүнийг хэрхэн амь үрэгдсэн тухай энэ газрын хүмүүс ярьцгаана. Энэ үед гэгээн Томас гэрээсээ хол ойд бурхандаа залбиран мөргөж байжээ. Гэгээнтний эргэн тойронд маш олон тогос шувуу байжээ. Гэтэл нэгэн онгон шүтлэгтэн анчин түүнийг тойрсон олон тогос шувуунаас агнах санаатай харватал гэгээн Томасын баруун сүвээг нэвт харвачихжээ. Тэр анчин үнэндээ гэгээн

Томасыг энд байна гэж бодоо ч үгүй, харвахадаа үзээч үгүй билээ. Томас гэгээн энэ шархаа даалгүй өөд болсон билээ. Тэр энэ нутагт ирэхээсээ өмнө Нубии газарт олон сайхан буянт үйлийг бүтээж явсан байдаг, тэр тухай нь би арай өөр газар, өөр цагт ярих болно.

Одоо өөр бусад зүйлийн тухай ярья. Энэ нутгийнхан шинээр төрсөн хүүхдээ долоо хоногт нэг удаа гүнжидийн тосоор тослох агаад энэ нь түүнийг хар арьстай болгодог байна. Энд хэн хамгийн хар арьстай байнав тэр хүн бусдаас илүү итгэл, хүндэтгэл хүлээнэ. Энэ нутгийнхан бурханаа хав хараар, харин чөтгөрийг цас мэт цав цагаанаар дүрслэн үзүүлнэ.

Энэ нутгийн хүн зон нь үхрийг машид хүндлэн шүтнэ. Эрчүүд нь дайнд явахдаа үхрийн үс авч явж мин цэргүүд нь мориныхоо дэлэнд сүлжих агаад, явган цэргүүд нь бамбайндаа уяж бэхэлнэ. Зарим нь бүр өөрийнхөө үсэнд сүлжинэ. Үхрийн үс тэднийг үхэл хагацал, шарх зовлонгоос хамгаална гэж итгэцгээнэ. Тийм учраас зэрлэг үхрийн үсийг машид үнэлэн шүтэцгээнэ.

Одоо гэгээн Томасыг оршуулсан нутгаас баруун зүгт орших Лар (Lar)<sup>222</sup> мужийн тухай ярилцъя. Бярман (Brahman) нар энэ мужаас анх түрүүн үүсэн гарч хорвоо ертөнцөөр аялан тархсан гэх. Бярмангууд бол хэзээч худал ярьдаггүй, хамгийн үнэнч шударга худалдаачид билээ. Энэ нутгийн хүмүүсийн ааш араншин, зан заншлыг огтхон ч гадарлахгүй харь орны худалдаачид энд ирэнгүүтээ энэ нутгийн аль нэгэн бярмантай уулзаад өөрийнхөө бараа таваар, тоног төхөөрөмжийг бүгдийг түүнд даатган үлдээж өөрийнхөө нэрийн өмнөөс арилжаа наймаа хийхийг хүсэж тохиролцоод орхино. Тэр цагт бярман бүхий л үүрэг хариуцлагыг өөртөө үүрч эгээл өөрийнхөө хувийн худалдаа арилжааг хийж байгаа мэт шударга шулуун хандаж ажиллана. Энэ хийсэн ажлынхаа төлөө тэд хэзээч шан хөлс нэхдэггүй. Харин юмны эзэн худалдаачин сайхан санааныхаа үүднээс тэдэнд бэлэг сэлт өгөхгүй бол юу ч авахгүй. Бярман хүн мах идэхгүй, архи дарс уухгүй, авааль гэргийгээсээ өөр авгай хүүхэн эргүүлэхгүй, амьтны амь хороохгүй, ер нь нүгэл хилэнцтэй гэсэн бүхнээс зайласхийнэ. Хорвоогийн бүх бярмангуудыг тусгай тэмдгээр нь амархан таниж болно. Бярмангууд хөвөнгөөр томсон нарийн шидмэсийг мөрөндөө углан нөгөө үзүүрийг эсрэг талын сугандаа зангидах агаад тэр хөвөн шидмэс нь түүний цээж, нуруун дээр ил харагдана. Энэ тэмдгээр нь тэднийг хаанаас ч олж, бусдаас ялган таниж болдог. Бярмангуудын эзэн хан нь маш баян, их эрдэнэс хурааж хуримтлуулсан нэгэн ажээ. Энэ хан эрдэнийн үнэт чулуу, сувд эрдэнэ ихээр худалдан авна. Тэр хан өөрийнхөө орны худалдаачдаас сувд эрдэнэ, үнэт эрдэнийн чулуу худалдан авах хэлцэл тохироотой байх бөгөөд худалдаачид ч Маабарын ханлиг буюу тэдний нэрлэж заншиснаар Чола (Chola) – н ханлигаас Энэтхэг орны өөр хаанаас ч эрээд олохгүй сайн чанартай сувд, үнэт чулууг хандаа авчирч өгөх агаад хан нь тэдэнд үнийг нь хоёр нугалан төлнө. Бярмангууд ч Маабарын ханлигаас олзворлох сайн чанарын сувдыг орвонгоор нь худалдаж аваад хандаа авчирч өгнө. Хан нь тэдний авчирсан сувдны үнийг тэр дор нь хоёр нугалан төлнө. Тийм болохоор бярмангуудын арилжаа наймаа үргэлж ашиг хонжоотой байх агаад хан ч хамгийн сайн чанартай сувдын цуглуугатай болдог.

Бярмангууд онгон шүтлэгтэй, тэд нар энэ дэлхий дээрх бусад аль ч орны хүмүүсээс илүү араатан, жигүүртний аяг араншинг ажин тандаж юу болох гээд байгааг тааварлан мэдэхээс гадна өөрсдийнхөө зөн совинд жигтэйхэн их итгэдэг. Тэдний хувьд долоо хоногийн өдөр бүр өөрийн гэсэн өнгө төрхтэй. Тэд худалдаа арилжаа хийж байгаад гэнэт наран сөрөг зогсож

сүүдрээ хэмжинэ, тэгээд өнөөдөр чинь ямар гараг билээ гэж асуугаад тийм гараг гэсэн хариу сонсонгуутаа сүүдрээ хэмжиж үзээд сүүдрийн урт нь зохих ёсоороо байвал арилжаа наймаагаа хийнэ, сүүдрийн урт нь хүрэхгүй байвал сүүдэр сунасаар зохих хэмжээндээ хүртэл хүлээнэ. Бас нэгэн сонин зүйл гэвэл байшин барилга дотор арилжаа наймаа хийж байхад нь аль нэгтэйгээс тэмээн аалз ирж яваа харагдвал аль зүгээс ирж байгааг шинжин уг хүнд ээл ивээлтэй зүгээс ирж явбал худалдан авах зүйлээ даруй авна. Хэрэв өлзий бус зүгээс ирж явбал эс авна. Бярман хүнийг гэрээсээ гарахад нь хэн нэгэн хүн найтаахад тэр найтаалга сэтгэлд нь эвгүй санагдвал гэрээсээ үл гарна. Бярманыг явж байтал түүний замыг тосон хараацай шувуу нисэн ирэхдээ ээлтэй гэсэн зүгээс ирж байвал цаашаа явна, өлзий бус зүгээс ирж байвал цаашаа явалгүй гэр рүүгээ буцна. Энэ дэлхий дээр хамгийн урт насалдаг хүмүүс бол бярмангууд бөгөөд тэд биед тохиромжтой, шингэц сайнтай, хөнгөн хоол иднэ. Тэд нар тусгай нэгэн төрлийн ургамал идэж заншсан учир маш жигдхэн, бөх, сайхан шүдтэй тэр нь эрүүл саруул байж урт наслахад тустай. Бярмангууд хүний биеийн аль ч хэсгээс цус гаргах дургүй.

Бярмангууд дунд йоги (yogus) гэж нэрийдэх хэсэг хүмүүс байх агаад тэд нар бол нэг зуун тавь (150), хоёр зуу (200) нас элбэг насална. Тэд нарын бие мах бодь нь уян хатан чанараа бүрэн хадгалж, сүм хийдийн залуу лам нараас юугаараа ч үл ялгаран тэдний хийдэг бүхнийг хийнэ. Энэ нь тэдгээр йоги нар маш бага иддэгтэй холбоотой билээ. Тэд нар голдуу сүү, тутаргаар хооллоно. Мөн тэдгээр йоги нарын иддэг тусгай хүнсний тухай та бүхэнд дурьдан өгүүлбэ. Та нар тэр хүнсийг гайхах буй за. Тэд нар мөнгөн усыг хүхэртэй хуган нэгэн төрлийн ундаа бэлтгэх агаад түүнээсээ сард хоёр удаа ууна. Энэ ундаа нас уртасгадаг гэж ярина. Тэд нар энэ ундаагаа бүр хүүхэд наснаасаа ууж эхэлсэн тул мөнгөн ус хүхрийн холимогтоо аль хэдийн дасан зохицсон байдаг.

Маабарын ханлигт нэгэн зүйл онцгой шүтлэг буй бөгөөд түүнийг шүтэгсэд нь хорвоогийн олон олон зүйлээс татгалзан маш хатуу хэцүү, тарчиг амьдралаар амьдрах Йоги нар юм. Тэд нар нуудгайгаач хаах юмгүй шав шалдан явцгаана. Тэд нар үхрийг шүтэж мөргөх агаад олонх нь алтаар шарсан зэс буюу хүрэл үхрийн дүрийг духан дээрээ зүүнэ. Тэд үхрийн аргал шатааж аргалын үнс биеэдээ түрхэх нь эгээл Загалмайтнууд ариун рашаанаар биеэ угаахтай адил. Тэд нарын шашин шүтлэгийг хүндэтгэн үздэг хэн боловч гудамж зээлд тэдэнтэй учрахдаа тэдний үнснээс авч духандаа түрхэнэ. Тэд нар аяга тавагнаас хооллож ундаалдаггүй. Идэх юмаа хатсан навчин дээр тавьж иднэ. Ногоон навчин дээр хоол хүнсээ тавьдаггүй нь ногоо навч амь сүнстэй гэдэгтэй холбоотой бөгөөд тэгж амьд амьтныг хорловол нүгэл гэж үзэцгээнэ. Тэдгээр бярмангууд амьтай голтой амьтанд өвчин шаналал учруулах, амийг нь таслах нь арилашгүй их нүгэл болох тул өөрсдөө үхсэн нь дээр гэж үзнэ. Хүмүүс тэднээс яагаад та нар дандаа нүцгэн шалдан явцгаадаг юм бэ яадаж нуудгайгаа халхалхад яадаг юм бэ гэхэд: “Бид энэ хорвоод ирэхдээ нүцгэн ирцгээсэн тул энэ газар дэлхийгээс юу ч авахыг үл хүснэ. Бидэнд хүн амьтнаас нуугаад нууцлаад байх юм юуч үгүй, бид шунал тачаалыг мэдэхгүй тул нуух юм алга.

Та нар нүүр, гараа ил гаргахаас ичдэггүй мөртлөө нуудгайгаа нуудаг нь шунал тачаалын нүглийг мэдэрдэгтэй чинь холбоотой” гэж хариулна. Та бүхэн шунал тачаалын нүглээ нуудгай эрхтнээрээ үйлдэх тул түүнийгээ нууцлаж нуудаг. Бидний тэр эрхтэн бол гарын хуруунаас маань ч бага нүгэлтэй тул бид нуудаггүй, учир нь бид тэр эрхтнээрээ нүгэл

үйлддэггүй. Яагаад та нар нүцгэн явахаас ичдэггүй юм бэ гэхэд хүмүүст ийм хариу хэлдэг. Тэд энэ хорвоогийн амьтай нэг ч амьтныг алдаггүй бөгөөд тэр нь ялаа, нохой бөөс, бөөс болон бусад ямар ч шавж хорхойг үл алах агаад тэр бүхэн өөрийн гэсэн амь сүнстэй гэж үзнэ. Мөн энэ учир шалтгаанаас амьд амьтныг идэж нүгэл хураахаас цээрлэнэ.

Йогиуд нь шинэ өвс ногоо, үндэс зэргийг хатахаас нааш иддэггүй, учир нь тэдний сүнс биедээ оршоор байна гэх. Бас гэдсээ суллахдаа далайн эргийн элсэн дээр очиж ялгадсаа гаргаад түүнийгээ саваа модоор элстэй хутган нүдэнд үзэгдэхгүй болтол нунтаглаад усанд урсгана. Яагаад үүнийг хийж байна гэхэд бидний ялгадас өт хорхой төрүүлэх бөгөөд тэр нь наранд хатаж үхэх нь мөн л том нүгэл хилэнц болдог гэнээ. Биднээс гарч байгаа ялгадас нь өт хорхойг төрүүлэх агаад тэдгээр өт хорхой нь яваандаа өлсөж, хатаж үхэх нь бидний буруу үйлээс үүдэлтэй нүгэл хилэнц мөн гэнэ. Тэд унтахдаа дайралдсан газартаа дороо дэвсгэргүй, дээрээ хучлагагүй унтана. Тэд хоол бараг идэхгүй хааяа нэг ус уугаад явахдаа үхэж үрэгддэггүй урт удаан наслах нь үнэнхүү гайхмаар.

Яримаар бас нэгэн зүйлийг өгүүлье. Тэдний сүм хийдэд онгон шүтээнээ тахиж байдаг лам нар байх. Аль нэгэн лам нь өөд болвол түүний оронд залах ламаа тусгай шалгалтаар шүүн тодруулдаг ажээ. Тэр шалгалт нь уг ламыг залуу сайхан охидууд үнсэн таалж, энхрийлэн эрхлүүлэх агаад тэр бүхнийг давж гарсан хүнийг лам болгож, бүсгүй хүний уран арга, уян наалинхай ааль авирт уярч уургалуулсныг нь сүмээсээ хөөдөг байна.

Өөд бологсдоо заавал шатааж чандарлана. Эс тэгвээс хүүрэнд үржсэн өт хорхой хожим нь өлсөж хатаж үхэх агаад энэ нь их нүгэл гэж үздэг учраас өөд бологсдоо шатааж чандарлана. Сая би та нарт эдгээр онгон шүтлэгтнүүдийн зан заншлын талаар тодорхой өгүүллээ. Харин одоо тэдний Цейлон арлын тухай ярьж байхдаа орхигдуулсан үүх түүхээс өгүүлье<sup>223</sup>. Энэ түүхийг та бүхэн заавал сонсох учиртай гэж бодном.

Цейлон арал бол маш том арал энэ тухай би дээр өгүүлсэн билээ. Энэ арал дээр эргэн тойрон эгц цавчим хадан цохиогоор хүрээлэгдсэн нэгэн өндөр уултай. Тэр ууланд авиран гарах ганцхан замтай. Тэр уулын хадан хавцалд урт төмөр гинжин замтай бөгөөд түүгээр дамжин авирч уулын оргилд хүрнэ. Тэр уулын орой дээр бид бүхний дээд өвөг Адамын хөшөө бий гэх. Сарацинууд тэр бунханд Адамыг оршуулсан гэх, харин онгон шүтлэгтнүүд бол тэнд Шакъяамуни Бурханыг онголж оршуулсан гэх. Тэр Шакъяамуни гэдэг нь анхны хүн байсан бөгөөд түүнийг онголон шүтэцгээдэг гэнэ. Тэдний уламжлал ёсоор бол хүн төрөлхтний дунд амьдарч байсан хамгийн онцгой гоц хүн байсан агаад түүнийг анх түрүүн гэгээрсэн хүн гэж өөрсдийнхөө шүтдэг анхны онгон болгожээ.

Шакъяамуни нь баян чинээлэг, эрх дархтай хүчирхэг хааны хүү байжээ. Тэр өөрөө маш ариун тунгалаг санаатай, газар дэлхийн эд юмсад сэтгэл татагддаггүй, хаан болох хүсэлгүй хүү байжээ. Эцэг хаан хүүгээ хаан болох ямарч хүсэл сонирхолгүй, энэ хорвоогийн амьдрал үйл, жаргал цэнгэлээс хол хөндийг мэдмэгц машид гуниж гутарч байжээ. Ингээд хаан эцэг нь хүүгээ хаан ширээнд суулган хаан өргөмжлөхдөө хаант улсаа зөвхөн өөрийнхөө үзэмж сэтгэлээр удирдаарай гээд өөрөө хаан ширээгээ хүүдээ шилжүүлжээ.

Гэтэл ганц хүү нь хаан ор суух хүсэлгүйгээ эцэгтээ хэлжээ. Үүнийг сонссон эцэг нь хүүгээ хаан ор суухгүйг үзээд гунихын ихээр гуниж насан өөд болохдоо тулж иржээ. Тэр хаанд өөр

хүү байсангүй. Хаант улсынхаа хувь заяаг хэнд даатгахаа мэдэхгүй байлаа. Тэгээд хаан хүүгээ хаан төрийн жолоо атгуулахаар дараах зүйлийг бодож олжээ. Ингээд хүүгээ гайхам сайхан баян тансаг орд өргөөнд суулган, үзэсгэлэн төгс гурван түмэн охид бүсгүйчүүдээр хүрээлүүлжээ. Тэр ордонд өөр нэг ч эр хүн оруулдаггүй байсан бөгөөд тэр олон гоо үзэсгэлэнтэй охид бүсгүйчүүд хан хүүг өөртөө татах гэж өдөржин бүжиглэж, дуулж, түүнийг цэнгүүлэн оронд нь хүртэл хамт хэвтэх авч хан хүүгийн шунал тачаалыг өдөөж эс чадацгаав. Хан хүү тэдний арга ухаанд унахгүй харин ч урьд урьдынхаасаа улам хатуу чанга дэг журмыг сахих болжээ. Хан хүү маш сайхан эр байсан бөгөөд орд харшаасаа огт гарч үзээгүй, үхэж үрэгдсэн нэгч хүнийг хараагүй, эрүүл чийрэг эр байв.

Эцэг хаан хүүгийнхээ ордонд өтөл хөгшид болон эрэмдэг зэрэмдэг хүмүүс ойртохыг чандлан хорьдог байжээ. Нэг удаа хан хүү замаар явж байгаад үхсэн хүний хүүрийг хараад хамт явсан бараа бологсдоосоо энэ хүн яасныг асуухад бараа бологсод нь үхсэн хүн гэхэд хан хүү, “Хүн болгон үхдэг үү” гэж лавлав. Бараа бологсод нь, “Тэгдэг” гэж хариулцгаав. Ингээд хан хүү гүн бодолд дарагдан явж байтал нэгэн амандаа ганц ч шүдгүй, явж чадахгүй болсон хөгшин хүнтэй тааралдав. Үүнийг харсан хан хүү “Энэ хүн яагаад явж чадахгүй бас амандаа ганц ч шүдгүй байгаа юм бэ?” гэхэд бараа бологсод нь, “Хүн хөгширхөөрөө ийм болдог юм” гэв. Ингэж үхэл, хөгшрөлийг нүдээрээ харсан хан хүү өөрийнхөө тансаг орд харшаас оргон гарч энэхүү нүгэлт ертөнцөөс ангижран хэн ч хөгширдөггүй, үхдэггүй мөнхийн ертөнцийн<sup>224</sup> эрэлд гарчээ. Хан хүү эцэг хаан, баян тансаг орд харшаа орхин алс холын эзэнгүй зэлүүд ууланд гарч үлдсэн амьдралаа сайн сайхан юм бүхэнд зориулан даяанчилж суужээ. Хэрвээ тэр хүн манай эзэн Ийсус Христтэй учирсансан бол яах аргагүй Христийн нэгэн богд гэгээн болох нь гарцаагүй гэж бодном. Хан хүү тэр ууланд өөд болон хальсны дараа эцэг хаанд нь хүүгийнх нь шарилыг авчирч өгөхөд хаан эцгийн уй гашуунд хэмжээ хязгаар байсангүй. Тэр хаан өөрийнхөө аминаас ч илүү хайрлаж өсгөсөн ганц хүүгээ оршуулах нүсэр ёслол үйлдээд хүүгийнхээ дүрийг алт эрдэнэсээр мөнхлөн урлаж тэр орны бүх хүн хүүгийн нь дүрс онгоныг бурхан гэж шүтэх зарлиг буулгажээ. Тэр бурхан хан хүү наян дөрвөн удаа ахин дахин төрж төрөл бүрийн амьтны дүрд хувиран байснаа наян дөрөвдөх удаагаа төрөхдөө жинхэнэ бурханы дүрийг олсон гэж ярьцгаана. Онгон шүтлэгтнүүдийн бүтээсэн анхны онгон шүтээн нь тэр хан хүүгийн дүр байсан бөгөөд бусад онгодыг түүнээс үүсэж гарсан гэх агаад энэ бүхэн Энэтхэг орны Цейлон арал дээр болсон билээ. Онгон хаанаас, яаж анх буй болсон түүхийг та бүхэн сонслоо. Энэ ариун газар дэлхийн хамгийн алслагдсан өнцөг булан бүрээс онгон шүтлэгтнүүд эргэл мөргөл хийхээр энэ газар ирэх нь Загалмайтнууд Эрхэмсэг гээгэн Жеймст<sup>225</sup> мөргөдгийн нэгэн адил билээ. Онгон шүтлэгтнүүд энэ уулын оргилд байх бунхан бол хан хүүгийн бунхан, мөн энд байгаа шүд, үс болон бумба нь хан хүүгийнх гэдэгт огтхон ч эргэлздэггүй бөгөөд тэр хан хүү нь Шакъяамуни Бурхан мөн гэнэ.

Харин энд эргэл мөргөл үйлдэхээр бөөн бөөнөөрөө ирэх сарацинууд бол хүн төрөлхтний өвөг Адамын булш, тэнд байх шүд, үс, бумба ч мөн түүнийх гэнэ. Онгон шүтлэгтнүүд тэр булш бунхныг тэдний анхны онгон, анхны бурхан болох хан хүүгийнх гэгцгээхэд сарацинууд тэр бол хүн төрөлхтний өвөг Адамын булш гэнэ. Чухам хэний булш бунхан бэ гэдгийг бурхан л мэдэх байхдаа. Адамын булш энд байх учиргүй гэдгийг бид ойлгож байна. Учир нь манай бурханы ариун номд Адамын булшийг ертөнцийн өөр хэсэгт байгаа гэж өгүүлснээс үзэхэд энэ бол Адамын булш биш бололтой.

Хубилай эзэн хаан энэ ууланд Адамын булш болон түүний шүд, үс, бумбыг бунхлан оршуулсан гэдгийг сонсож мэджээ. Хубилай хаан тэр бүх бурханы ариун эд өлөг нь Их хааны санд байх ёстой гэж сэтгэжээ. Тэгээд тэр бүх зүйлсийг олж авчруулахаар манай бурханы 1284 онд томоохон элч зараалыг хөдөлгөжээ. Их хааны элч зарлага урт удаан хугацаагаар далайгаар хөвж, газраар аялсаар Цейлон аралд хүрчээ. Тэдгээр элч зарлага тэр нутгийн ханд бараалхаж хэрэг зоригоо хэлжээ. Тэгээд тэндээс маш том, зузаан хоёр ширхэг дээд шүд, үс, сайхан ногоон чулуун аяга аваад нутаг буцжээ. Тэдгээр элч зарлага Их хааныг Хан-балик хотод байхад нь хааны даалгасан үйлийг бүтээж авчрах ёстой зүйлсийг авч ирлээ гэдгээ урьдчилан хэл хүргүүлж элч довголгожээ.

Энэ мэдээг хүлээн авсан Их хаан хотын бүх иргэд, лам хуврагууд болон бусад бүх хүн гудамнаа гарч Адамын шарилыг гүн хүндэтгэлтэйгээр хүлээн авах зарлиг буулгажээ. Зарлигийг даган Хан-балик хотын бүх иргэд гудамнаа гарч ариун шарилыг угтан авчээ. Энэ үйлийг хүндэтгэн Их хаан их найр цэнгээн хөгжөөж, өөрөө асар их баяр баясгалантай, сэтгэл хангалуун болой. Ариун ном сударт Адамын аяганд хийсэн нэг хүний хоол, ундаа нь даруй таван хүн идэж, ууж цадахаар өсөж үрждэг гэж өгүүлсэн байдаг билээ. Их хаан энэхүү ид шидтэй аяганд өөрөө хоол ундаа хийж идэх тул тэр домог гарцаагүй үнэн болохыг бэлхнээ харуулсан билээ.

Их хаан Адамын шарил, түүний эдэлж хэрэглэж байсан зүйлсийг олж авчрахад асар их хөрөнгө мөнгө зарж билээ. Энэхүү үнэн түүхийг та бүхний сонорт нэгэнт хүргэсэн тул одоо өөр үйлийн зүг хандаж, өөр зүйлийг өгүүлсү.

Юуны өмнө та бүхэнд Каял (Kaya) хэмээх нэгэн том бөгөөд алдартай хотын тухай өгүүлье. Тэр хот ах дүү таван ханы ахмад нь болох Аслиар (Asliar) ханы эзэмшил захиргаанд оршино. Энэ хот мөн том далайн боомт хот агаад баруун зүгийн орнуудтай худалдаа, арилжаа хийдэг Хормуз, Кайс, Аден болон бүхий л Арабынхантай арилжаа наймаа хийж морьд худалдан авдаг зээл билээ. Худалдаачид энэ хотыг хамгийн тохиромжтой байршилтай далайн боомт төдийгүй эд бараа, тоног төхөөрөмж арилжихад нэн аятайхан зах зээл гэж тооцдог. Хорвоогийн өнцөг булан бүрээс энэ хотод худалдаачид цугларан адуу, морьд болон бусад бараа таваар наймаалалцана.

Эндхийн хан их баян чинээлэг эрдэнэсийн сантай. Тэр өөрийгөө үнэт эрдэнийн чулуугаар гоёж чимэн явах агаад хан төрийнхөө үйл ажиллагааг хамгийн зөв голдирлоор явуулж, ухаалгаар удирдан хөтөлнө. Ялангуяа шүүх цаазынхаа үйлийг шулуун шударга байлгаж харь орны худалдаачид, наймаачдын эрхийг үл шамшигдуулах тул тэдгээр худалдаачид энэ оронд ирэх дуртай, тэр хэрээрээ энд худалдаа, арилжаа цэцэглэж, ашиг орлого нь арвин байна. Энэ хан гурван зуу илүү эхнэртэй агаад энэ газар хэн хичнээн олон эхнэртэй бол тэр хамгийн чинээлэг, хүндтэйд тооцогдоно. Харин ах дүү таван ханы хооронд байн байн хэрүүл маргаан дэгдэнэ. Иймэрхүү хэрүүл маргаан дэгдэх бүрийд эх хатан тэдний хооронд орж эвлэрүүлдэг билээ. Ийм хэрүүл маргаан байн байн гарах агаад зарим үед тэдгээр ахан дүүс ээжийнхээ гуйлт хоригийг үл ойшоон тэмцэлдэхэд: Хөвгүүддээ гомдож цөхөрсөн Эх хатан хутга шүүрэн авч хэрэв та нар хоорондоо эвлэрэн эв найртай амьдрахгүй юм бол би та нарын нүдэн дээр та нарыг хөхүүлж өсгөсөн хөхөө огтлон хаяж, амиа егүүтэгсүгэй” гэхэд хан хөвгүүд сая нэг юм ухаарч эхийгээ ямар их гомдоосноо ойлгон тэмцэлдэхээ больж эвлэрдэг байна. Гэвч ийм

явдал хэд хэдэн удаа тохиосон агаад эх хатнаа тэнгэрт хальсан хойно эдгээр таван хан эв эвдрэлцэн тэмцэлдэж хэн нэгийгээ хөнөөх нь гарцаагүй 226 мэт.

Зөвхөн энэ нутгийнхан төдийгүй бүхий л Энэтхэг хүмүүс тэдэнд бага ч болов таашаал өгдөг нэгэн зуршилтай. Тэр зуршил нь тамбур хэмээх нэгэн төрлийн навчинд гаа, халуун ногоо бага зэргийн түүхий шохой ороож амандаа хийгээд зажлан, шүлсээ үргэлж нулимж байдаг. Энэ зуршил язгууртан, ноёд, хаадын дунд бүр ч их тархжээ. Ийм навч зажлах нь тэдний эрүүл мэндэд ч тустай байдаг байна.

Хэн нэгэн этгээд нөгөөдөө өширхөж хорссондоо ямар нэгэн хэлбэрээр доромжлох гэвэл гудамж, зээлд тэр хүнтэйгээ учрангуут амандаа зажилж явсан навчаа эсрэг этгээдийнхээ нүүр рүү нулимж “Энэ ч чамд ахдана” гэж хашгирна. Ингэж доромжлуулсан этгээд голоо харалтал өширхөн хорсож хандаа гомдоллохдоо тэр доромж манай овог омогийнхны эсрэг үү, эсвэл зөвхөн надад хандав уу гэдгийг ялган салгаж өшрөл хорслоо тайлахыг хүснэ. Ингээд хан нь тэдэнд өшөө хорслоо тайлахыг зөвшөөрмөгц овог омогоороо нэгдэн нэг хэсэг нь нөгөө хэсэгтэйгээ тэмцэлдэн тулалдана.

Тэр хоёр тал хоорондоо тэмцэлдэн тулалдах зодоон, алалцааныг хан болон үй олон хүн үзэж сонирхоно. Зодолдож буй хоёр талаас олон олон хүн үхэж үрэгдэн, гэмтэж шархдах агаад нэг тал нь нөгөөгөө дийлж эхэлмэгц хан нь зодооныг зогсоож, талуудыг эвлэрүүлнэ. Хэрэв тэрхүү зодоон хоёр хүний хооронд болох бол хоёр этгээд хурц хутгаар зэвсэглэн тулалдана. Тэд нар хутгаа эзэмшихдээ гайхалтай дадамгай. Хэн нэг нь нөгөөгийнхөө арьсан дээр дугуй хэрчлээс тэмдэглэн дараагийн удаа тэр дугуй дотор хутгаа зооно шүү гэж нөгөөгөө сүрдүүлнэ. “Өөрийгөө хамгаалаарай” гэж хашгиран нэг нь нөгөөгөө хутгалан хорооно.

Энэ ханлигийн тухай өгүүлж дууссан тул одоо Куйлон (Quilon) хэмээх ханлигийн тухай үргэлжлүүлэн өгүүлсү. Куйлон нь Маабараас баруун урагш таван зуун бээр орчимд оршино. Хүмүүсийн ихэнх нь онгон шүтлэгтнүүд боловч цөөн тооны загалмайтан бас жүүд нар бий. Тэд өөрийн гэсэн хэл, яриатай. Хан нь хэний ч хараат биш. Одоо би та бүхэнд энэ ханлигаас юу олддог, энд юу үйлдвэрлэдэг талаар ярья. Энд Куйлоны суман мод гэдэг маш чанартай суман мод ургахаас гадна ой дотор нь поваарь арвин их ургана. Поваариа тав, зургаа, долоон сард хурааж авна. Поваарийн модыг эндхийхэн гаршуулан тарьж усалж, бордож ургуулдаг гэдгийг хэлэх нь зүйтэй. Мөн энд индиго хэмээх нэгэн зүйл будгийн ургамал арвин их ургана. Тэр ургамлаас индиго будгийг нь гаргаж авахын тулд үндэсгүйгээр тайран авч том торхон дотор усанд хийгээд орхих агаад ногоо нь ялзарч будаг нь ялгарна. Дараа нь торхтой будгаа наранд тавихад аажмаар өтгөрөн жонхуу болдог.

Ингэж өтгөрч хатсан будгаа дөрвөлжлөн зүсэж хадгална. Энэ нутагт халуун гэдэг жигтэйхэн, нарны элч нь маш хүчтэй. Хэрэв та нарийхан голын усанд өндөг хийгээд хэсэг хугацаа өнгөрөхөд ус нь буцалж, өндөг нь болно шүү. Энэ газар Манзи, Араб болон Левантийн худалдаачид олноороо ирж хүнс хоолны зүйл, бараа таваар ачиж ирж борлуулаад оронд нь энэ газрын бараа таваар, эд баялгаас ачиж аваад буцна.

Энэ оронд бусад орон газарт байдаггүй маш олон төрлийн араатан жигүүртэн байдаг. Энд хөө хар өнгөтэй арслан бий. Маш олон төрлийн тоть шувууд байхын дотор цас шиг цагаан биетэй час улаан хошуу, хөлтэй байх. Бас зарим нь час улаан болон хөв хөх өнгөтэй байх.



Маш өчүүхэн жижиг мөртлөө гоё амьтад ч байх. Тогос шувуу нь манай нутгийнхаас том болоод гоё, бас тахиа нь хүртэл манай нутгийнхаас өөр. Энэ нутгийн ургамал, амьтан нь манай нутгийнхаас хэлбэр хэмжээ, өнгө төрхөөрөө эрс ялгаатай байдаг нь маш их халуун байдагтай холбоотой билээ. Мөн манай нутагт ургадаг жимс жимсгэнэ энэ газар байдаггүй бас ямар ч тариа ургадаггүй зөвхөн тутарга л ургана. Тэр нутгийнхан дарсаа чихрээс<sup>227</sup> гаргаж авна. Тэр дарс нь сайхан амттайгаас гадна уусан хүн усан үзмийн дарс ууснаас хурдан бөгөөд илүү согтоно.

Хүний амьдралд хамгийн хэрэгтэй зүйл бол хямд үнэтэй тариа будаа элбэг дэлбэг байх л чухал юм.

Тэр нутагт нарийн мэргэшсэн зурхайч хааяагүй элбэг. Бас мэдлэг чадал сайнтай эмч домч олон. Хүмүүс нь тас хар арьстай, зөвхөн нуудгайгаа халхалсан даавуу зүүнэ. Эр эмгүй шалдан нүцгэн явах агаад элдэв хурцал, тачаалын ажлыг муу муухайд тооцдоггүй. Үеэл дүүтэйгээ гэрлэнэ, эцгийгээ болон ахыгаа үхсэний дараа авааль гэргийтэй нь дэр нэгтгэх ёс бүхий л Энэтхэг орны зуршил болсон байдаг. Энэ ханлигийн талаар өөрийнхөө үзэж мэдэх хэрээр өгүүлсэн тул одоо бид цаашаа явж Коморин (Comorin) хэмээх ханлигт очсугай.

Коморин бол Энэтхэгийн газар нутаг агаад Ява<sup>228</sup> арлаас гарснаас хойш нэг ч удаа үзээгүй Алтан гадас одыг эндээс зэрвэсхэн харж болдог. Энэ газраас гучин бээр зайтай далайн эрэгт очиход далайн мандал дээр бүтэн тохой дээгүүр гялалзах Алтан гадас одыг зэрвэсхэн харна. Энэ газар тийм ч их иргэншиж төлөвшсөн нутаг хараахан биш. Ан араатан төрөл төрлөөр байхын дотор сармагчин нэн олон төрөл. Мөн энд “Полийн муур” хэмээх сонин сармагчин байдаг. Арслан, ирвэс, шилүүс нэн элбэг өөр сонин содон зүйл үгүй тул Эли (Ely) нутаг руу явсугай.

Элийн ханлиг нь Комориноос гурван зуун бээр баруун зүгт оршино. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, өөрийн гэсэн хантай, өөрийн хэл, яриатай. Одоо би та бүхэнд энэ газрын зан заншил, эд өлгийн талаар ярья. Энэ бүхэн та нарт илүү ойлгомжтой байх болно. Учир нь бид иргэншиж төлөвшсөн<sup>229</sup> газар нутаг руу аажим аажмаар ойртсоор байгаа билээ. Энэ мужид далай болон далайн боомт үгүй боловч маш том өргөн гол нь уужим бэлчир, сайхан тохойтой. Энд чинжүү, гаа элбэг ургана. Хан нь баян чинээлэг боловч ажил хийх хүн хүчээр хомс орон. Гэвч энэ оронд нэвтрэх зам хялбархан хамгаалах боломжтой тул бусдын халдлага дайралтаас төдийлөн их эмээж айдаггүй. Би та бүхэнд нэгэн хачирхалтай зүйлийг өгүүлье. Далайн хөлөг онгоц тэдний нутгийн их голын бэлчрээр өгсөн ирэхэд нь угтан тосож ирэх ёстой онгоц биш байвал тэр онгоцыг эзлэн авч бүхий л эд баргий нь хураан авдаг байна. Тэгээд та нар өөр газар очих ёстой атал манай энд ирчихжээ, тийм болохоор та бүхнийг бурхан бидэнд илгээжээ гэж хээв нэг тайлбарлана. Ийм явдал Энэтхэг орон даяар элбэг тохиолдоно. Цаг агаар муу, салхи шуурга ихтэй үед хөлөг онгоцнууд хаа нэгтэй зогсоход тэднийг заасан газар зогссонгүй гэж далимдуулан ачаа бараагий нь дээрэмдэн авах нь энүүхэн энд.

Манзи нутгийн хөлөг онгоцнууд энэ газар зөвхөн зуны улиралд ирэх агаад ачаа бараагаа дөрөв бүр удлаа гэхэд найман хоногийн дотор ачиж, аль болох хурдан шуурхай эндээс хөдлөхийг хичээнэ. Учир нь энэ газар усан буудал, онгоцны зогсоол байдаггүй учир элсэрхэг эрэгт тулж зогсоод ачаа бараагаа буулгах, ачих нь маш осолтой. Харин Манзи газрын

онгоцнууд тэгтлээ их айдаггүйн учир нь тэдний зангуу маш бат бөх байдаг билээ. Энэ нутагт арслан болон бусад махчин араатан элбэг. Одоо бид эндээс баруун зүгт нэлээд алс орших өөртөө хантай, өөрийн гэсэн хэл яриатай Малабар (Malabar) - ын ханлигийн тухай ярих болно.

Эндхийн оршин суугчид нь харь орныхонд алба татвар төлдөггүй. Энэ газар Алтан гадас од арай илүү тод үзэгдэх агаад далайн мандлаас бүтэн хоёр тохой дээгүүр харагдана. Малабарын ханлигийнхан болон түүний хөрш зэргэлдээх Гужарат (Gujarat) мужийнхан жил бүр зэвсэглэсэн дээрэмчидтэй зуу гаруй хөлөг онгоц далайд гарган худалдаа арилжааны бусад онгоцыг дайран олзолж ачаа бараагий нь дээрэмдэнэ. Тэд нар бол яах аргагүй далайн том дээрэмчид мөн. Тэдгээр далайн дээрэмчид хөлөг онгоцон дээрээ эхнэр хүүхдээ авч явцгаах агаад зуны турш худалдаачдын хөлөг онгоцыг тонон дээрэмдэж худалдаа арилжаанд асар их хор хохирол учруулна.

Тэдгээр дээрэмчдийн хөлөг онгоц нь худалдааны хөлөг онгоц хайн далайгаар газар сайгүй тархан тэнүүчилнэ. Заримдаа тэдгээр дээрэмчид өөр хоорондоо тав таван бээр зайтай хөвж дээрэмчдийн хорин хөлөг онгоц зуун бээр өргөн зурвасыг харуулдан отно. Худалдааны хөлөг онгоц үзэгдмэгц бие биендээ галаар дохио өгөн дээрэм тонуулынхаа ажилд шуурхайлан орох тул ямарч худалдааны хөлөг онгоц тэдний савраас мултрахгүй.

Далайн дээрэмчид отоож байгааг андахаа байсан худалдаачид өвч зэвсэглэн тэдэнтэй амь дүйн үзэлцэхээс буцахаа больсон төдийгүй дээрэмчдэд ихээхэн хохирол учруулах болсон. Гэвч хааяа хааяа дээрэмчид худалдааны онгоц олзлон авч бүх ачаа бараагий нь хуу тонож авчихаад хүмүүсийн нь аминд гар үл хүрэх агаад “Буцаад явцгаа дахиад өөр бараа таваар ачаад ир. Тэр чинь ч бидний олз болог” гээд тавьж явуулна. Энэ ханлигийн нутагт поваарь, чинжүү, цагаан гаа, шанцай болон бас бус олон төрлийн халуун ногоо тариалахаас гадна турбит, наргилийн самар ургана. Энэ газар ертөнцөд ховорхон хамгийн нимгэн, хамгийн үзэмжтэй торгомсог нэхмэл нэхнэ. Мөн өөр бусад янз бүрийн бараа таваар худалдаална. Харь орноос энд ирэх худалдаачид онгоцоо тэнцвэржүүлэхээр их хэмжээний зэс гулдмай буюу эсвэл хайрга ачна. Арилжаалах бараа нь саатай хоргой, торго, торгомсог нөмрөг, алт, мөнгө, лиш цэцэг болон энэ газар ургадаггүй бусад олон төрлийн халуун ногоо байна. Худалдааны хөлөг онгоцнууд хорвоогийн өнцөг булан бүрээс энд ирнэ, ялангуяа Манзи орноос маш олон хөлөг онгоц ирэхээс гадна мөн Аден болон Александрий руу аялж яваа хөлөг онгоцнууд энэ газраар дайран өнгөрнө.

Малабарын тухай та бүхэнд дэлгэрэнгүй ярилаа. Одоо Гужаратын тухай ярья. Энэ ханлигийн бүх хотыг тоочин ярина гэвэл маш сунжруу яриа болно.

Гужарат нь Малабар шиг том ханлиг. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, өөрийн гэсэн хантай, бас өөрийн хэл, яриатай, өөр бусдад алба даяг төлдөггүй. Гужарат нь баруун зүгт оршино. Алтан гадас од эндээс улам ч тод харагдах агаад далайн мандлаас дээш зургаан тохой өндөрт гялалзана. Гужарат бол жинхэнэ далайн дээрэмчдийн орон ажээ. Эндхийн далайн дээрэмчид нэгэн ёс бус бузар зүйлийг хийж зуршил болгосон нь олзолж авсан худалдаачиддаа энэтхэг чавгыг далайн усаар даруулан идүүлмэгц тэдгээр худалдаачид ходоодоо эргэтэл бөөлжиж бас суулгана. Тэгээд тэдгээр дээрэмчид тэдний бөөлжис болон ялгадсыг нэгэд нэгэнгүй хутгаж үнэт эрдэний чулуу, сувд байгаа эсэхийг шалгаж үзнэ. Худалдаачид дээрэмчдээс эрдэнийн

чулуу, сувдаа нуухын тулд залгичихдаг байна. Түүнийг нь гэдэснээс нь хөөж гаргахын тулд тэр муухай шингэнийг уулгадаг ажээ.

Энэ нутагт чинжүү, цагаан гаа, индиго будаг маш элбэг. Мөн хөвөн их элбэг бөгөөд хөвөнгийн мод их ургана. Хөвөнгийн модны зарим нь хорин жил ургахдаа өндрөөрөө зургаан алд хүрдэг. Хорин настай хөвөнгийн модноос хөвөн утас нийтгэж болохоор зөөлөн хөвөн гарахаа больдог. Настай модны хөвөнгөөр шуудай, бүтээлэг зэрэг зүйлийг нэхэхэд тохиромжтой. Эдгээр мод арван хоёр нас хүртлээ утас ээрч болох зөөлөн хөвөн өгөөд түүнээс хойш зөөлөн хөвөн гадаггүй.

Ямаа, усны үхэр, зэрлэг үхэр, хирс болон бусад амьтны арьсыг элдэж төрөл бүрийн арьсан эдлэл үйлдвэрлэнэ. Эдгээр арьсан эдлэл нь жилдээ хэд хэдэн хөлөг онгоцыг дүүргэхээр их болдог. Арьс ширэн эдлэлээ Арабын болон бусад оронд нийлүүлнэ. Мөн өөр бусад олон оронд гаргаж борлуулна. Эндхийн хүмүүс алтан, мөнгөн утсаар араатан амьтан, жигүүртэн шувуудын дүрс товойлгон хатгамалласан улаан арьсан дэвсгэр бүтээлэг хийсэн нь хараад хараад ханашгүй дэгжин гоё эд болдог. Ийм улаан арьсан дэвсгэрийг сарацин хүмүүс маш ихээр худалдан авах агаад дэвсэж унтахад нэн таатай гэнэ. Мөн алтан утсаар хээ угалз хатгамаллаж оёсон жинтүү хийнэ. Тэр жинтүү зургаан мөнгөн марк, дэвсгэрийн арьс шиг арьсаар хийсэн нь арван мөнгөн марк хүрнэ. Энэ ханлигт үйлдвэрлэсэн арьсан эдлэл нь энэ ертөнцөд өөр хаана ч байхгүй сайн чанар, сайхан үзэмжтэйг магтаад магтаад барахгүй.

Энэ ханлигийн тухай ярих зүйл маань ингэс гээд өндөрлөж байгаа тул аяллаа цааш үргэлжлүүлэн Тана (Thana) хэмээх ханлигт айлчилъя. Тана нь эндээс баруун зүгт 230 орших том бөгөөд баян тансаг ханлиг билээ. Тана нь биеэ даасан хантай. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, өөрийнхөө өвөрмөц хэлээр ярина. Энд чинжүү болон бусад халуун ногоо үл ургана. Харин тэнд анхилам үнэртэй гүгэл элбэг боловч өнгө нь цайвар цагаан бус бор хүрэн болой. Энэ ханлиг нь худалдаа арилжааны томоохон төв төдийгүй газар газрын худалдаачид ирж алжаалаа тайлан амсхийдэг газар. Эндээс төрөл бүрийн хийц загвартай, чанар сайнтай арьсан эдлэл, нарийн сайхан нэхмэл, хөвөн бөс бараа худалдаж авна. Харин худалдаачид алтан, мөнгөн сав суулга, зэс гулдмай ихээр авчирч борлуулах агаад энэ ханлигийнхан дараа нь тэдгээр эд барааг өөр газар дамлан худалдаалах сонирхолтой байдаг байна. Энэ нутгийнхны нэгэн тааруухан үйлийн тухай өгүүлье. Энэ ханлигаас олон олон далайн дээрэмчид төрөн гарч далай тэнгисээр хэсүүчлэн худалдаа арилжааны зам тосон дээрэм тонуул хийдэг билээ. Түүгээр үл барам эндхийн хан нь далайн дээрэмчидтэйгээ харилцан тохиролцож дээрэм тонуулыг нь хөхүүлэн өөгшүүлж дээрэмдэж авсан морьдоо бүгдийг нь хандаа өгч байх, бусад олзыг нь дээрэмчид өөрсдөө авч байхаар үгсэн хуйвалдаж байдаг байна. Морьд бол дээрэмчдийн олзны нэлээд жинтэй хэсэг болдог төдийгүй морьд ачаагүй худалдааны хөлөг онгоц бараг байдаггүй байна. Учир нь Энэтхэг оронд морьдны хэрэгцээ асар их бөгөөд тэр хэрээрээ үй түмэн морьд худалдан авдаг байна. Ийм учраас тэндхийн хан дээрэмчдийн олзолсон морьдыг өөртөө авч алт, мөнгө, үнэт чулуу болон бусад бараа таваарыг дээрэмчдийн олз болгон дээрэмчдэд үлдээдэг нь хан хүн үйлдээд баймааргүй шившигтэй үйл билээ.

Одоо эндээс баруун зүгт орших Камбай (Cambay) хэмээх томоохон ханлигт очиж тэдний талаар ярилцъя. Энэ ханлиг өөрийн гэсэн хантай, өөрийн хэл яриатай, хэнд ч алба гувчуур

төлдөггүй. Хүмүүс нь онгон шүтлэгтэй. Энэ ханлигийн нутгаас Алтан гадас од улам тод харагдах бөгөөд баруун тийшлэх<sup>231</sup> тусам улам улам тодроно. Энэ ханлиг нь худалдаа арилжаа дэлгэрэн цэцэглэсэн газар юм. Эндхийн индиго будаг сайн чанартай бөгөөд хааяагүй элбэг. Торгомсог нэхмэл болон хөвөн даавуу ихээр үйлдвэрлэж ханлигийнхаа бусад мужуудыг хангана. Арьс ширэн эдлэлийг янз янзаар нь хийж их хэмжээгээр борлуулах нь арьс ширэн эдлэл хийх арга ухаан энд гайхалтай хөгжсөний гэрч гэлтэй. Өөр бусад төрлийн бараа таваар асар ихээр үйлдвэрлэх тул тэр бүхнийг тоочих нь надад ч төвөгтэй, танд ч ядаргаатай санагдах тул ингэс гээд хязгаарлая. Харь орны худалдаачид олноороо ирж янз бүрийн бараа таваар авчрахын дотор алт, мөнгө зэсээр хийсэн эд эдлэл их байх<sup>232</sup>. Тэдгээр худалдаачид өөрийнхөө улс оронд үйлдвэрлэдэг бараа таваарыг энд авчирч борлуулаад оронд нь энэ нутгийн эд бараа, хүнсний зүйлийг худалдан авч өөрийнхөө орон руу тээвэрлэнэ. Харин энэ ханлигт далайн дээрэмчид огт байдаггүй тул хүмүүс нь худалдаа арилжаа, гар урлал, үйлдвэр эрхлэдэг шулуун шударга иргэд билээ. За өөр дурьдаад байх сонирхолтой зүйл үгүй билээ.


Камбейн ханлигаас гарч баруун зүгт явсаар Сонмат (Sonmath) – ын ханлигт хүрэх агаад энэ нэлээд том ханлиг юм. Хүмүүс нь онгон шүтлэгтэй, өөрийн гэсэн хан болон өөрсдийн хэл, яриатай, бусдад алба даяг төлдөггүй биеэ даасан ханлиг. Энэ нутгийнхан далайн дээрэм хийдэггүй, худалдаа арилжаа, гар урлал, үйлдвэр эрхлэн амьдардаг шулуун шударга иргэд билээ. Энэ ханлигт худалдаа арилжаа ихэд дэлгэрсэн, газар газрын худалдаачид наймаачид их ирдэг, худалдааны диваажин болсон газар. Тоног төхөөрөмж авчирч их наймаалах бөгөөд оронд нь эндхийн эд бараа, тоног төхөөрөмжийг худалдан авна. Харин хүмүүс нь онгон шүтлэгтнүүд мөртөө нэлээд омголон догшин бас зөрүүд зантай. Өөр ч онцлоод байх зүйл үгүй учир цаашаа аялж Кеч-Макран (Kech-Makran) – ны тухай ярья.

Кэч-Макран өөрийн хантай, өөрийн хэлтэй нэлээд том ханлиг билээ. Хүмүүсийн нэг хэсэг нь онгон шүтлэгтэй боловч ихэнх нь Сарацинууд<sup>233</sup> байдаг. Хүмүүс нь худалдаа арилжаа, үйлдвэр гар урлал эрхлэнэ. Энэ нутагт тутарга, улаан буудай арвин ургана. Хүмүүсийн гол хүнс нь тутарга, мах, сүү болно. Худалдаачид энэ оронд далайгаар, хуурай газраар аль алианаар нь ирнэ. Энэ ханлигаас тариа будаа их хэмжээгээр авна. Өөр ч яриад байх гоц гойд зүйл үгүй юм даа.

Энэ ханлиг бол бидний очсон Энэтхэг улсын сүүлчийнх нь ханлиг бөгөөд баруун, баруун өмнө зүгийн завсарт оршино. Маабарын ханлиг Кэч-Макраны хооронд орших муж, ханлигуудаас Их Энэтхэг бүрэлдэн тогтоно. Энэ бол Энэтхэг газрын ихэнх хэсэг гэж ойлгоорой. Гэвч би Их Энэтхэгийн далайн эргийн дагуух хэсгийн тухай л ярилаа, харин эх газрын гүн рүү нь огт ороогүй билээ. Энэтхэгийн эх газрын гүн дэх муж газрын тухай яривал бидний яриа төгсөхгүй билээ. Ингээд эдгээр ханлигийг орхин одож мөн Энэтхэгийн бүрэлдэхүүн хэсэг болох зарим нэгэн арлаар орцгооё.

## Наймдугаар бүлэг

### Арабын тэнгист



Одоо бид яриагаа Эрчүүдийн арал, Эмэгтэйчүүдийн арал хэмээх хоёр арлаас эхэлье. Эрчүүдийн арал нь Кэч-Макранаас (Kech Makran) өмнө зүгт таван зуун (500 miles) бээр орчим зайд оршино. Оршин суугчид нь Хуучин гэрээ (Old Testament) - ний жаяг, заншлын дагуу мөргөлөө үйлддэг Загалмайтнууд болой. Хэрвээ айлын авгай жирэмсэлбэл эр нөхөр нь эхнэрээ төрөн төртөл нь дахин хавьтдаггүй байна. Мөн төрснөөс нь хойш дөчин хоногийн турш эхнэртэйгээ хавьтаж эр эмийн ажил үл хийнэ. Дөч хоног өнгөрсний хойно эхнэр нөхөр хоёр эр эмийн харьцаанд ордог. Гэвч энэхүү Эрчүүдийн арал дээр нэг ч бүсгүй хүн оршин сууж амьдардаггүй бөгөөд бүх бүсгүйчүүд нь Эмэгтэйчүүдийн хэмээх арал дээр амьдарна.

Эрчүүдийн арлын эрс Эмэгтэйчүүдийн арал дээр ирж жил бүрийн гурав, дөрөв, тавдугаар сард эндээ оршин сууж эхнэр хүүхэд болон бүсгүйчүүдтэйгээ хамтдаа амьдарна. Үүний

дараа эрчүүд өөрийнхөө арал дээр эргэн ирж ажил үйлээ үргэлжлүүлнэ. Эрчүүдийн арлаас маш содон сайхан үнэртэй халимны заар олддог байна. Оршин суугчид нь тутарга, мах, сүүгээр голдуу хооллоно. Энэ арлынхан гайхалтай сайн загасчид агаад загас ихээр барьж борцолж хатаагаад жилийн турш түүнийгээ хүнсэндээ хэрэглэхээс гадна зарж борлуулна.

Арлынхныг захирдаг эзэд ноёд гэж үгүй, харин хамба ламтай, тэр нь Сокотрын ширээт ламд захирагдана. Арлынхан өөрийн гэсэн хэл, яриатай. Эрчүүдийн арал нь Эмэгтэйчүүдийн арлаас барагцаалбал гучин бээрийн зайд оршино. Арлынхны бодол санаагаар бол жилийн турш эхнэр нөхөр хоёр хамтдаа амьдрах боломжгүй гэж үздэг учраас тус тусдаа өөр өөр арал дээр амьдран сууна. Айлд хүү төрвөл арван дөрвөн нас<sup>234</sup> хүртлээ Эмсийн арал дээр эхтэйгээ хамт байж байгаад арвандөрөвтөйдөө Эрчүүдийн арал дээр эцэг дээрээ ирж амьдардаг байна. Эрчүүд Эмэгтэйчүүдийн арал дээр суух хугацаандаа тариа тарьж орхих агаад дараа нь бүсгүйчүүд хураан авдаг байна. Мөн бүсгүйчүүд нь тэр арал дээр хааяагүй элбэг ургах үр жимс түүж нөөцлөнө. Эс тэгвээс Эмэгтэйчүүдийн арлын бүсгүйчүүдэд үр хүүхдээ асарч өсгөхөөс өөр ажил үгүй болно. Өөр яриад байх гоц гойд зүйл үгүй тул Сокотра (Socotra) арлын тухай өгүүлье.

Сокотра арал нь дээрх хоёр арлаас өмнө зүгт таван зуун (500) бээр зайтай оршино. Оршин суугчид нь загалмайн шашинтнууд агаад ширээт ламтай. Эндээс халимын заар маш ихээр<sup>235</sup> олно. Халимын заарыг далай тэнгисийн хамгийн аварга том хоёр амьтан халим болон кашалотын гэдэснээс авдаг. Эндхийн хүмүүс халим болон кашалотыг хэрхэн барьж агнадаг талаар ярья. Халимийн ангуучин загасчид халим агнахын тулд маш олон туна загас барьдаг. Эдгээр тарган туна загасаа жижиглэн хэрчиж том торхонд хийгээд давсалж ус нэмэн нэгэн төрлийн давсалсан туна загасны шөл мэт зүйлийг бэлтгэнэ. Ингээд зургаан загасчин жижиг онгоцонд давсалсан туна загасны шөлөө ачиж аваад далайд гарна. Далайд гарсан хойноо давсалсан загасны шөлөндөө элдэв бөс даавуу, бусад зүйлсийг дүрж давстай, тостой шөлөө уусгаад хөлөг онгоцноосоо уячихна. Энэ бүх ажлаа амжуулсны дараа дарвуулаа босгон далайгаар хэрэн хэсэж цаашаа наашаа сүлжин хөвөхөд далайн мандлаар хааяагүй тостой загасны шөлний мөр үлдэж тосон толбо нь хөвнө. Ингэж далайгаар хэрэн хэсэж туна загасны тостой шөл тарааж явахад халимийн бэлчээр таарах юм уу, эсвэл салхиар туна загасны тостой шөлний үнэр авсан халимын сүрэг уг хөлөг онгоцыг мөрдөн хэдэн зуун бээр ч хамаагүй хөвнө. Халим хөлөг онгоцыг гүйцэж ирэхэд загасчид хэд хэдэн зүсэм тарган туна загасыг халиманд хаяж өгнө. Давсалсан тарган туна загасны мах идсэн халим архи уусан хүн шиг согтож элий балай болно. Халимыг мансуурч эхэлмэгц ган арамаар зэвсэглэсэн загасчид түүний нуруун дээр үсрэн гарч ган арамаа халимын толгой орчим зооно. Энэ үед бусад загасчид нь модон мунаар халимын толгой руу нүдсээр түүнийг муужруулна. Мансуурч муужирсан халим түүний нуруун дээр юу болоод байгааг төдийлөн мэдрэхгүй, ган арамьн ишэнд гурван зуун алд илүү урт, бүдүүн олс бэхлэх агаад тавин алд тутамд дээр нь дарцаг хатгасан хоосон торх бэхэлнэ. Олсныхоо үзүүрийг халимыг чирэх онгоцонд бэхлэх агаад тэр нь хэд хэдэн халим агнуурын завийг хооронд нь холбосон онгоцны цуваархуу юм байдаг. Шархадсан халим мэдээ орж эхэлмэгц нуруун дээр нь авирсан загасчид ус руу үсрэн бууж завиндаа суугаад дарцаг бэхэлсэн нэгэн хоосон торхоо ус руу хаяна. Шархадсан халим ухасхийн хөвж далайн гүн рүү шумбах гэхээр хоосон торх живэхгүй, халимыг ч шумбуулахгүй усны мандалд хөвнө. Ингэж халим хэлхээтэй онгоцнуудыг чирч шумбах гэж оролдсоор хүч тамираа баран шархаа даалгүй үхмэгц түүнийг чирэн далайн эрэгт өөрсдийнхөө арал дээр

авчрах буюу өөр зэргэлдээ арал дээр аваачин зарж борлуулна. Ингээд нэг л халимнаас мянган (1000) ливрийн<sup>236</sup> цэвэр ашиг олно.

Арлын оршин суугчид маш сайхан, сайн чанартай хөвөн даавуу болон бусад бараа таваар үйлдвэрлэхийн зэрэгцээ том том давсалсан загас их хэмжээгээр борцолж борлуулна. Тэд нар тутарга, мах, сүүгээр хооллоно. Хүмүүс нь энэ нутгийн онгон шүтлэгтэн энэтхэгчүүд шиг шав шалдан явцгаана. Энэ арал дээр маш олон худалдаа арилжааны хөлөг онгоцнууд төрөл бүрийн бараа таваартай ирж арилжаа наймаа хийгээд арлын эд бараа, хүнс хоолыг өндөр үнээр худалдан авна. Аденийг зорьж яваа хөлөг онгоц бүхэн энэ арлыг заавал дайран өнгөрдөг гэдгийг бид бүхэн анзаарч ойлгох учиртай.

Сокотра арлын ширээт лам нь Ромын Пап ламд үл захирагдах агаад харин Багдад хотноо оршин суух их хамбад захирагдана. Багдадын их хамба ламтан дэлхийн олон олон оронд тархан суух Загалмайтнууд руу өөрийн ширээт лам нарыг томилон илгээх нь эгээл Ромын хамба лам мэт. Эдгээр загалмайн шашинтнууд нь католик урсгалын Загалмайтнууд биш билээ. Энэ арал дээр далайн дээрэмчид буудаллан хуарагнаж дээрмийнхээ олзыг борлуулна. Энэ арал бол тэдгээр дээрэмчдийн эд бараагаа борлуулдаг бэлэн зэлэн зах зээл болдог. Арлын Загалмайтнууд эдгээр эд бараа нь онгон шүтлэгтэн болон сарацин худалдаачдаас дээрэмдэн авсан зүйлс гэдгийг мэддэг авч тэдгээр бараа таваарыг худалдан авахдаа сэжиглэдэггүй, нүгэл хилэнц хурааж байна гэж эвгүйрхэж жийрхдэггүйн учир нь тэр бүхнийг загалмайн шашинтнуудаас дээрэмдээгүй гэдгийг сайн гадарладаг билээ. Хэрэв Сокотра арлын ширээт лам тэнгэрт хальчихвал<sup>237</sup>Багдадын их хамба ламтан шинээр ширээт лам тохоон томилно.

Энэ арлын Загалмайтнууд нь дэлхий дээрх хамгийн их арга туршлагатай илбэчин-шидтэнгүүд гэдгийг би батлан хэлж чадна. Ширээт ламтан тэдний энэхүү илбэ-шидийн арга ухааныг огт дэмждэггүйгээр үл барам чандлан хориглодог боловч хэн ч түүний хориг цаазыг үл ойшоох агаад өвөг дээдсээсээ уламжлан авсан энэхүү илбэ-шидийн арга ухаанаа гээхгүй гэдгээ тэд ч тов тодорхой илэрхийлдэг ажээ. Ийм учраас тэд илбэ-шидийн ухаанаа огтхон хязгаарладаггүй юм. Би энэ талаар хэдэн үг хэлье.

Арлын илбэ-шидтэнгүүд өөрийнхөө хүсэл санааг биелүүлэхийн тулд ёстой л гавьяат үйлсийг бүтээх ид шидийг үзүүлдэг. Далайн дээрэмчид заримдаа арлынханд хор хохирол учруулдаг байна. Ингэж аашилсан далайн дээрэмчдийн хөлөг онгоц энэ арлаас салан явж чадахаа больдог. Учир нь тэдгээр хөлөг онгоц дарвуулаа босгон далайд гармагц далайн салхи гэнэт чиглэлээ өөрчлөн хөлөг онгоцыг буцаагаад аралд хөөж авчирдаг. Далайн дээрэмчид арлынханд учруулсан хор хохиролоо нөхөж барагдуулахаас нааш тэдний хөлөг онгоц энэ арлаас салж явах аргагүй болдог. Арлын илбэ-шидтэнгүүд өөрсдийн хүссэнээр далайг амгалан тайван болгож чадна, бас аймшигт аюул дагуулсан далайн хар шуургыг өдөөж чадна. Тэд өөр бас бус олон олон зүйлийг санааныхаа зоргоор хийж үйлдэж чадах билээ. Ингээд би энэ арлыг орхин аяллаа цааш үргэлжлүүлж Мадагаскар (Madagascar)<sup>238</sup> аралд очсугай.

Мадагаскар арал Сокотра арлаас урагш нэг мянган (1000) бээр зайд оршино. Хүмүүс нь Магометийг шүтэж мөргөдөг Сарацинууд байна. Арлын засаг захиргааг дөрвөн шейх буюу ахлагчид эрхлэн захирна. Мадагаскар бол энэ дэлхийн хамгийн том арлуудын нэг бөгөөд эргэн тойрон эргийн урт нь дөрвөн мянган (4000) бээр орчим болдог. Хүмүүс нь худалдаа,

гар урлал, үйлдвэр эрхэлнэ. Энд бусад газар мужийг бодоход хамгийн олон заантай боловч хорвоогийн бусад муж газарт эндхийн болон Занзибарын зааны соёо тийм ч ихээр зарагдаж борлуулагдаагүй гэдгийг би мэдэх юм. Энэ нутагт иддэг мах нь зөвхөн тэмээнийх<sup>239</sup>. Өдөр бүр хүнсэнд зориулан гаргадаг тэмээний тоог хэлбэл хэн ч үнэмших аргагүй их тоо сонсогдоно. Тэр нутгийнхан тэмээний мах бол бусад махтай зүйрлэмгүй амт чанартай бас ашигтай<sup>240</sup> гэцгээх бөгөөд тийм учраас жил тойрон зөвхөн тэмээний мах л иднэ. Арал дээр улаан зандан мод их ургана. Энэ зандан мод өөр бусад оронд бол их л өндөр үнэ хүрмээр харин энд зандан модон ой шугуйтайгаар барахгүй өөр бусад сайхан мод ч элбэг ургана. Мадагаскар аралд халимын заар хааяагүй элбэг, учир нь арлыг тойрсон далай тэнгисээр халим, кашалот элбэг бэлчинэ. Арлынхан эдгээр хоёр амьтныг маш олноор нь агнана. Энд бас цоохор ирвэс, шилүүс, арслан маш их. Буга, гөрөөс мэтийн амьтан тоогүй олон байхаас гадна төрөл бүрийн жигүүртэн шувууд элбэг. Асар том биетэй тэмээн хяруул элбэг. Мөн манай нутагт огт байдаггүй олон төрлийн жигүүртэн шувуудтай. Янз бүрийн эд бараа ихээр үйлдвэрлэнэ. Харь орноос алтан саатай хоргой, торго, торгон нэхмэл ачсан хөлөг онгоцнууд их ирэх агаад тэдгээр нь эд бараагаа нутгийн бараа таваараар сольж наймаална. Ирж байгаа хөлөг онгоц буцаж байгаа хөлөг онгоц аль алин нь дааж ядсан ачаа тээштэй ирж, буцна.

Мадагаскар болон Занзибар (Zanzibar) – аас өмнө зүгт орших арлууд руу хөлөг онгоц хөвж очдоггүйн учир нь эндхийн далайн урсгал зөвхөн өмнө зүгийг чиглэн маш хүчтэй урсах тул өмнө зүгийн арлууд руу очсон хөлөг онгоц буцаж ирэх боломж бараг үгүй билээ. Ийм учраас ямар ч хөлөг онгоц тийшээ очдоггүй. Тухайлан хэлэхэд Маабараас Мадагаскар юм уу, Занзибарт ирэхэд хөлөг онгоц хорин хоног аялаад ирдэг агал буцаад Маабар орохдоо бүтэн гурван сарын хугацаа зарцуулна. Энэ бол өмнө зүгийг чиглэсэн далайн их урсгалыг сөрж хөвдөгтэй холбоотой билээ. Энэ урсгал нь ямагт өмнө зүгийг чиглэсэн байдаг. Өмнө зүгт орших арлуудаар хүн бараг очдоггүй нь өмнө зүгийг чиглэсэн далайн урсгалтай холбоотой байдаг. Тэдгээр арал дээр хангарьд шувуу олноороо нутагшин оршино. Хангарьдийг бид шувуун цээжтэй арслан биетэй гэж төсөөлдөг билээ гэтэл тэдгээр арал дээр орших хангарьд шувууд нь асар том л болохоос ерөнхийдөө бүргэдтэй тун төстэй гэж түүнийг нүдээрээ харсан хүмүүс гэрчлэн ярина. Мөн хангарьд шувууг нүдээрээ үзсэн тэдгээр хүмүүс өгүүлэх нь: Хангарьд шувуу зааныг шүүрэн авч өндөрт хөөрөн нисээд тэндээсээ шүүрсэн заанаа газар хаяж хэмхлэн алаад иддэг гэнэ. Хангарьд шувууны дэлгэсэн далавчны урт нь гучин алд, далавчны өд сөд нь арван хоёр тохой урт мөн төдий чинээ өргөн байдаг<sup>241</sup> гэж хэлцэнэ. Би өөрийнхөө нүдээр үзэж харсан бүхнийг та нарт энэхүү номондоо багтаан, арай өөр хэсэгт өгүүлнэ.

Та бүхэнд хангарьд шувууны тухай домог мэт зүйлийг өгүүлсэн дээрээ нэмж хэлэхэд тэр арал руу яваад баригдаж олзлогдсон элчээ чөлөөлж авах тэр далиманд нь тэдгээр арлын тухай заншилан мэдэж ирэх үүрэг даалгавартай элч нарыг Их хаан илгээсэн билээ. Эдгээр элч нар болон өмнө нь очоод олзлогдсон элч эргэж ирэхдээ тэдгээр арлын тухай хачин сонин мэдээ сэлт арвинтай ирснээр барахгүй нэгэн зэрлэг бодонгийн соёо авчирсныг би өөрөө үзсэн.

Тэр соёог жигнэж үзэхэд 14 фунт хүрч байсан бөгөөд иймэрхүү соёотой бодон гахайн бие ямаршуухан аварга том байхыг та бүхэн төсөөлөн бодоорой<sup>242</sup>. Элч нар ярихдаа тэдгээр зэрлэг бодон нь усны үхэр шиг том гэцгээнэ. Тэр арал дээр анааш болон зэрлэг илжиг маш олон. Тэр арлын араатан амьтан, жигүүртэн шувууд нь манай эндхийнхээс эрс өөр хачин



сонин гэдгийг сонсож дуулахад жигтэйхэн байгаа юм чинь нүдээрээ үзвэл мөн ч гайхалтай байх ажгуу. Хангарьд шувууны талаар эргэн цухас дурьдахад: Арлын оршин суугчид тэр шувууг rukhs (рух) гэж нэрлэх агаад хангарьдийн талаар тэндхийн хүмүүс дуулаач үгүй байдаг билээ. Тэр шувууны гайхам томыг дуулаад лав хангарьд биш гэдэгт би эргэлзэхгүй байна. Мадагаскар арлын тухай та бид нэлээд зүйлийг ярилцлаа, одоо Занзибарын тухай ярьж аяллаа үргэлжлүүлье.

Занзибар бол сайхан бөгөөд том арал, эргэн тойрон эргийн урт нь хоёр мянган (2000) бээр урт. Хүмүүс нь онгон шүтлэгтэй. Занзибар арал өөрийн гэсэн хантай, өөрийн хэл яриатай, өөр бусдад алба гувчуур төлдөггүй. Тэндхийн хүмүүс биеэрхүү том харагдана, биеийн өндөр, бүдүүн хоёр нь тэнцвэргүй, тарган махлаг хүмүүс олон тул аварга биетэн мэт санагдах нь олон. Харин тэдгээр хүмүүс дөрвөн хүний даахгүй ачааг ганцаараа өргөж, таван хүний барахгүй хоолыг ганцаараа идэх нь гайхмаар. Хүмүүс нь тас хар өнгөтэй, зөвхөн нуудгайгаа халхлаад бусад бие нүв нүцгэн явцгаана. Тэдний үс жигтэйхэн буржгар, усаар сайн норгож байж л тэнийлгэнэ. Мөн их онгироодуу, хамар нь навтгар сартгар, уруул нь зузаан даравгар, нүд нь дүрэлгэр том харахад тун ч үзэмжгүй. Харь холын өөр оронд тэднийг үзвэл алмас, чөтгөр гэж л нэрлэнэ.

Занзибар нутгийнхан зааны соёо ихтэй түүнийгээ зарж борлуулна. Тэндхийн арслан нь олон төрөл агаад бусад нутгийнхаас ялгаатай, үүнээс гадна шилүүс эрээн ирвэс элбэг байх. Тэндхийн ан араатан бусад нутгийнхаас эрс ялгаатай. Хонь нь бүгд хар түрүүтэй, цагаан биетэй үүнээс өөр өнгөтэй хонь, хуц энэ арал дээр байдаггүй. Мөн тэнд анааш маш элбэг. Анаашийг харахад сайхан амьтан билээ тэд чухам ямархан төрхтэй болохыг би та бүхэнд ярья. Анаашний их бие охорхон, хойт хөл нь богинохон, урд хөл нь урт тул үргэлж оцойж байгаа юм шиг харагдана. Хүзүү нь маш урт толгой нь жижигхэн, толгой нь газраас дээш гурван алд илүү өндөрт байх. Хар, цагаан дугуй толботой арьстай, маш гоёмсог амьтан билээ. Зааны талаар нэгэн зүйлийг нэмж өгүүлье гэж бодсон агаад юу гэвэл хээлтүүлгийн үед эр заан нь эм заанаа хүн шиг нуруугаар нь хэвтүүлнэ. Энэ арлын бүсгүйчүүд нь их царай муутай. Асар том даравгар амтай, хар цагаанаар эргэлдсэн том нүдтэй, хамар нь том болоод хавтгай, хөх нь бусад газрын бүсгүйчүүдийнхээс дөрөв дахин том. Биеийн гадаад төрх, хэлбэр нь хүний сэтгэл татахааргүй үзэмж муутай бүсгүйчүүдтэй. Хүнсэндээ тутарга, мах, сүү, чавга голлон хэрэглэнэ. Тэнд усан үзмийн дарс үгүй боловч тутарга, элсэн чихэр, халуун ногоогоор нэрсэн сайхан нэрмэл хийнэ. Энэ арал дээр янз бүрийн бараа таваар ачсан газар газрын хөлөг онгоц олноороо ирэх тул арилжаа наймааны хөл ихтэй. Хариас ирсэн худалдааны хөлөг онгоцнууд эндээс зааны соёо маш ихээр худалдан авч ачна. Мөн эндхийнхэн халим их агнадаг тул халимын заар элбэг.

Арлын эрчүүд нь эрэлхэг зоригтой дайчид бөгөөд тэд ямар ч тулаанд шантралгүй тэмцэлддэг бөгөөд үхэхээс бараг үл айна. Тэр нутагт морьгүй тул тулалдахдаа тэмээ буюу заан хөлөглөнө. Зааны нуруун дээр хамгаалалт бэхлэлттэй суудал засаж түүндээ жад, сэлэм, чулуугаар зэвсэглэсэн арван зургаагаас хорин хүн сууж тулалдаанд орно. Зааны нуруун дээрээс тулалдана гэдэг маш том үйл билээ. Ингээд тулалдаж буй хоёр этгээд аль алин нь ихээхэн хохирол амссан хүнд тулаан болдог. Тулалдаанд орохынхоо өмнө заандаа өөрсдийнхөө уудаг дарснаас ханатал уулгана. Ингэж архи уусан заан зоригтой шийдмэг болох агаад тулалдаанаас ухарч гэрэвшилгүй дайран тулалдана. Энэхүү арлын тухай яривал зохих

ярианыхаа голыг ярьж арлын оршин суугчид, ан араатан, хүнс тэжээл гээд ер орхисон зүйлгүй өгүүлсэн тул Абиссини (Abyssinia) хэмээх томоохон мужийн тухай ярья. Эхлээд Энэтхэгийн тухай нэмж хэдэн үг хэлье. Энд би Энэтхэгийн хамгийн алдартай муж, ханлиг, арлын талаар ярьсан, харин Энэтхэгийн нутаг, арлуудын талаар үнэн мөнийг бүгдийг нь ярих хүн энэ дэлхийгээс эрээд ч олдохгүй билээ. Би та бүхэнд Энэтхэгийн хамгийн сайн сайхан зүйлсийн дээжсийг өгүүлсэн. Үүний цаана нэр нь дурьдагдалгүй үлдэж буй олон олон арлууд бол дээр миний дурьдаж ярьсан том арлуудад захирагдан эрхшээсэн арлууд билээ. Ер нь Энэтхэгийн далай дунд эзэнтэй, эзэнгүй нэг түм хоёр мянга долоон зуун (12700) арал байдгийг Энэтхэгийн далайгаар хөндлөн гулд хэрэн хэссэн хашир туршлагатай далайчдын хийсэн зураг, үлдээсэн тэмдэглэлд дурьдсан байдаг.

Дөнгөж саяхан би Их Энэтхэгийн тухай өгүүлж дууслаа. Их Энэтхэг нь Маабараас Кэч-Мартан хүртлэх асар уудам нутгийг эзлэн орших агаад арван гурван гол ханлигаас бүрдэнэ. Тэдгээрийн арван ханлигийн талаар би та бүхэнд ярьж танилцуулсан. Харин Бага Энэтхэг нь Чамбагаас Мотупилли хүртлэх газар нутагт орших агаад найман гол ханлигаас тогтоно. Миний ярьсан зүйлс нь зөвхөн эх газарт орших ханлигуудад хамаарах агаад тоо томшгүй олон арал дээр өчнөөн төчнөөн ханлиг, хот балгад оршиж буй гэдгийг ямагт санаж байх учиртай.

Одоо би Дундад Энэтхэг хэмээдэг Абиссини мужийн талаар ярья. Энэ том мужийг ерөнхийлөн захирдаг гол хан нь загалмайн шүтлэгтэй хүн байдаг. Харин бусад зургаан бага ханы гурав нь загалмайн шашинтай, гурав нь сарацин хүмүүс байдаг. Абиссиний Загалмайтнууд нь нүүрэн дээрээ гурван янзын тэмдэгтэй байдаг. Нэг хэсэг нь духныхаа дундаас хамрынхаа хянга хүртэл, нөгөө нь аль нэгэн хацар дээрээ халуун төмрөөр тамгалуулсан байдаг. Эхлээд тэднийг усан угаалга хийж ариутган ёслоод дараа нь тамгалж тэмдэг тавих бөгөөд үүнийг загалмайлах ёс гэнэ. Загалмайлах ёслолыг хүүхэд ахуй цагт нь үйлдэнэ. Энд мөн жүүдүүд байдаг бөгөөд тэднийг аль нэгэн хацар дээр нь тамгална. Харин сарацинуудыг духны дундаас хамрын хянга хүртэл тамгална. Их хан нь мужийнхаа төв дунд суурьшин сууна. Сарацинууд нь Аден тал руугаа сууцгаана. Энэ мужид гэгээн архад Томас өөрийн сургаал номоо айлдаж явжээ. Энэ нутгийн ард олныг загалмайн шашинд оруулсныхаа дараа Маабар нутгийг зорин очиж номоо айлдаж яваад амиа алдсан бөгөөд түүний шарилыг хаана, яаж онголсон<sup>243</sup> талаар би та бүхэнд түрүүчийн бүлэгт нэлээд тодорхой өгүүлснийг санаж буй гэж итгэнэм. Абиссини хэмээх энэ том мужид эрэлхэг дайчин морьтон эрс хааяагүй байх билээ. Энэ нутагт морь унаа маш элбэг. Ийм морьтон дайчдын хэрэгцээ шаардлага ч асар их байдаг. Учир нь Абиссини мужийнхан Адений Султан, Нубийчүүд (Nubians) болон бас бус олон овог аймгийнхантай дайны байдалд оршоор байгаа билээ<sup>244</sup>. Би та бүхэнд манай бурханы мэндэлсний 1288 онд болсон нэгэн явдлын тухай өгүүлье.

Абиссини мужийн захирагч хан өөрийн биеэр Иерусалим орж Христ бурханы шарил онгонд мөргөх бодолтой байгаагаа дэргэдийн хүмүүстээ айлтгажээ. Гэтэл Абиссини дээдэс, ноёд ам амандаа ийм эргэл мөргөл хийх аян ханы хувьд маш их осол аюул дагуулсан зүйл болох тул өөрийнхөө орноос ширээт ламаа юм уу өөр аль нэгэн өндөр мяндаг тушаалтай хуврагийг илгээх нь зөв гэцгээв. Захирагч хан ч тэдний хориг, саналыг хүлээн соёорхож өөрөө явахаа алгуурлав. Ингээд ширээт ламаа дуудуулан авчирч Иерусалимд байгаа бидний эзэн бурхан Ийсус Христийн онгон шарилд эргэл мөргөл хийж ирэхийг даалган тушаажээ. Ширээт лам ч ханыхаа зарлиг тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлнэ гэжээ. Ингээд хан нь ширээт ламыг аль

болох үтэр түргэн аялалдаа гарахыг үүрэг болгов.

Ширээт лам хан эзэнтэйгээ салах ёс үйлдэн жирийн мөргөлчний дүрээр аян замдаа гаран далай тэнгис туулан явсаар Иерусалимд иржээ. Иерусалимд ирэнгүүтээ Эзэн бурханыхаа онгон шарилд загалмайн шашинтан хүн ямар л янзаар хамгийн дээд хүндэтгэл ёслол үзүүлж болох бүхнийг хийж гүйцээжээ. Мөн хан эзнийхээ нэрийн өмнөөс асар их өргөл барьц өргөн мөргөл, залбирал үйлдэн зорьж ирсэн хэргээ бүтээгээд нөхдийнхөө хамт нутгийн зүг жолоо залав. Буцах замдаа Аден хүртэл амар амгалан явсаар Аденд иржээ. Энэ нутгийнхан загалмайн шашинтан хүнийг үнэн сэтгэлээсээ үзэн ядаж тэднийг өөрсдийхөө заналт дайсан гэж тооцдог.

Адений Султан Абиссиний захирагч ханы зарлагаар тэр нутгийн ширээт лам элч болон явааг олж мэдэнгүүтээ түүнийг олзлон барьж авчээ. Тэгээд тэр ширээт лам үнэнхүү загалмайн шашинтан эсэхийг мэдэхийг хүсэж ширээт ламыг байцаан шүүжээ. Ширээт лам би үнэнхүү загалмайн шашныг шүтэн мөргөдөг билээ гэж өчжээ. Үүнийг сонссон Султан хэрвээ чи Магометийг шүтэн мөргөхгүй юм бол чамайг шившиг шидтэй нь хутган шийтгэх болно гэв. Ширээт лам хариуд нь би өөрийн шашин мөргөлөөсөө татгалзан бусдын шашинд орсноос үхсэн нь дээр гэж үзнэ гэв. Үүнийг сонссон султан ширээт ламыг лалын ёсны дагуу бэлгийн хөвчийг нь таслан тамлаж шийтгэ гэж зарлигджээ.

Энэхүү гутамшигт тамлал, шившигт шийтгэлийг даван гарсан ширээт ламд Султан ийн өгүүлрүүн: Энэ шившигт шийтгэл бол зөвхөн чамайг шийтгэснээр хязгаарлаж байгаа зүйл биш бөгөөд танай захирагч ханыг дамаа давхар басамжлан доромжилж буй билээ. Чи үүнийг эргэж очоод хандаа хэлээрэй гэжээ. Ингээд ширээт ламыг суллан тавьжээ. Лал шүтлэгтэн мэт бэлгийн хөвчөө таслуулсан ширээт ламд шившигтэй, ичгүүртэй байсан боловч энэ бүхнийг би өөрийн шашин бурханаа хамгаалан тэмцэж хүлээсэн тул насан эцэслэх цагт Эзэн бурхан маань намайг харж үзнэ гэж сэтгэлээ тайвшруулан хатамжилсаар нутгийн зүг явахаар зэхжээ. Энэ тухай яриа хөөрөөгөө сунжруулахаа татаж өндөрлөө. Ширээт ламын шарх эдгэрч, бие нь илааршин замын аян даахтай болмогц бараа бологсдынхоо хамт нутгийн зүг явцгаажээ. Абиссинид иртлээ далай тэнгис гатлан урт зам туулсан билээ. Ширээт ламыг эргэж ирэхэд захирагч хан нь хагартлаа баярлаж, халуун дотно угтан аян замын сонин болон бурханы онгон шарилын талаар асууж сонирхов. Ширээт лам бурханы онгон шарилд хэрхэн мөргөсөн талаар нэгд нэгэнгүй айлтган өгүүлжээ. Дараа нь Адений Султан түүнийг хэрхэн баривчилж, хэрхэн тарчлаан доромжилсон талаар өгүүлж “энэ бол зөвхөн ширээт ламыг доромжилсон хэрэг бус давхар түүний захирагч ханыг басамжлан доромжилж байгаагаа нуулгүй хэлснийг” айлтгав. Адений Султан ширээт ламыг хэрхэн тарчлаан доромжилсон болон түүнийг өөрийг нь хэрхэн басамжлан доромжилсныг дуулаад хилэгнэн бахардаж арай л амь тавьсангүй. Хэрвээ би ширээт ламыг тамлан зовоосны, өөрийг нь басамжлан доромжилсны өш хонзонг Адений Султанаас нэн даруй авч хорвоо дэлхийн сонорт хүртэл, мэлмийд харагдтал доргиохгүй юм бол хан титэм тэргүүндээ залж, эзэнт улсаа захирах эрх мэдлээсээ татгалзана гэж андгайлан хашгичав.

Абиссинийг захирагч хан маш олон морьт болон явган цэрэг засаж, олон зааныг хамгаалах цамхгаар тоноглон тус бүрт нь хорин зэвсэгт дайчин суулган<sup>245</sup> дайнд мордон Адений ханлигт довтлон иржээ. Сарациний хан ч ялгаагүй цэрэг зэвсгээ базаан дайсны

довголгооноос нутаг усаа хамгаалан гурав дөрвөн газар бат бэх цайзад хориглолт, бэхлэлтээ зэхэн дайсныг тосон хүлээжээ. Абиссиний цэргийн хүчирхэг түрэмгий довголгооныг сарацин цэргүүд тэсэн тогтоох аргагүй үй олноороо хядуулан үхэж Аденийг эзлүүлжээ. Абиссиний хан Адений газар нутаг дээр сар гаруй болохдоо эзэлсэн газар болгоноо цөлмөн хоослож, эвдэн сүйтгэж, сарацин хүмүүсийг үй олноор нь хядан устгаж ширээт ламаа доромжлуулсны өшөө хорсолыг ханатлаа тайлжээ. Абиссини хан их ялалт байгуулсан тул нутаг орондоо буцахад нүүр улайхааргүй болсон байв. Үүнээс гадна тэдний буцах замыг хаан тосож буй бэхлэлт цайзыг даван гарахад тун их осол аюул хүлээж байжээ. Ингээд Загалмайтнууд үтэр түргэн гэдрэг буцаж зогсоо чөлөөгүй довголгон нутаг орондоо иржээ. Сарациний муусайн нохдыг хэмх дайлан газар нутгийг нь цөлмөн хоосолж, хүн ардыг нь үй олноороо нь алж устган ширээт ламынхаа өш хонзонг хангалттай авчээ. Сарацины муусайн ноход Загалмайтнуудыг захирч сөхрүүлнэ гэвэл ёстой санааны гарз.

Одоо би та бүхэнд Абиссиний тухай ярьж өгье. Энэ муж хоол хүнсний зүйл, эд бараагаар элбэг баян болой. Хүмүүс нь хүнсэндээ тутарга, улаан буудай, мах, сүү, гүнжидийн тос ихээр хэрэглэнэ. Энэ газар заан олон боловч энэ нутагт төрж өссөн заан үгүй бөгөөд тэдгээрийг Энэтхэгийн аль нэгэн муж, арлаас зөөж тээж авчирсан байдаг. Нутгийн анааш маш их. Арслан, цоохор ирвэс, шилүүс болон манай нутгийнхаас эрс ялгаатай бусад төрлийн зэрлэг ан араатан маш элбэг. Мөн зэрлэг илжиг маш элбэг, бусад аль ч нутаг оронд байдаггүй жигүүртэн шувууд олонтой. Тэр нутагт мөн маш үзэмжтэй гоё тахиа шувуу, илжигнээс үл ялих бага шиг аварга том тэмээн хяруул элбэг. Эндхийн ан араатан, жигүүртэн шувуудыг нэрлэж тоолно гэвэл нас гүйцэхгүй олон төрөл билээ. Энд өнгө өнгийн будгаар будчихсан юм шиг тоть, төрөл бүрийн мич олон төдийгүй “Полийн мий, Маймоний мий” хэмээх хүн шиг нүүр царайтай 246 мичнүүд ч байдаг. Эцэст нь нэмж хэлэхэд Абиссинид хот, тосгод олон, оршин суугчдын нэгэн хэсэг нь зөвхөн худалдаа эрхлэн амьдардаг наймаачдаас бүрдэнэ. Сайн чанарын хөвөн даавуу, нимгэн торго нэхнэ. Ярьж сонирхуулмаар бас бус зүйл байвч манай энэ номонд оруулахаар зүйлс биш тул ингэс гээд энэ яриагаа өндөрлөө. Одоо би та бүхэнд Адений тухай ярьж өгсүгэй. Адений эзэн захирагчийг Султан гэж өргөмжилнө. Хүмүүс нь бүгд сарацинууд бөгөөд Магометийг шүтэж мөргөнө. Загалмайн шашинтнуудыг нэг нүд үзэхгүй. Энэ нутагт хот, суурин олонтой, Аден өөрөө далайн боомт хот агаад Энэтхэгээс ирэх худалдааны хөлөг онгоцнууд бүгд Аденаар дайрч өнгөрнө. Аден хот нь далайн хөлөг онгоцнууд хуран цугларч, амарч алжаал ядаргаага тайлдаг газар. Далайн том хөлөг онгоцнуудаар ачиж ирсэн бараа таваараа жижиг хөлөг онгоцнуудад шилжүүлэн ачиж голоор илгээх агаад тэдгээр жижиг онгоцнууд нь голын усаар долоо хоног хөвсний эцэст ачиж ирсэн эд бараагаа тэмээнд шилжүүлэн ачаад нэг сар аялсны дараа Александрий 247 хэмээх их голд хүрч эндээс дахин хөлөг онгоцонд ачиж сая нэг юм Александрийн боомтод хүрнэ. Аденаас Александрий хүртэл чинжүү, халуун ногоо болон үнэ цэнэтэй бусад эд бараа тээдэг зөөдөг өөр зам үгүй бөгөөд энэ замыг хамгийн осолгүй, хамгийн богино зам гэж Александрийн сарацинууд үзэцгээнэ.

Энэтхэг орж худалдаа, арилжаа хийхээр явж байгаа хөлөг онгоц бүхний гараа нь Аденаас эхэлнэ. Араб үүлдрийн сайхан сайхан морьдыг эндээс Энэтхэг оронд гарган зарна. Араб морьдыг Энэтхэгт зарах нь маш их ашиг өгөөжтэй наймаа болдог бөгөөд нэг сайхан морь гэхэд Энэтхэгт нэг зуун (100) мөнгөн маркнаас илүү үнэ хүрдэг. Адений эзэн Султан нь Адений боомтод орж ирж байгаа худалдааны хөлөг онгоц, бараа таваараас гааль, татвар

авсаар асар их хөрөнгө хуримтлуулжээ. Үнэнхээр энэхүү гааль татвараас баяжсан Султан бол энэ дэлхийн хамгийн баян чинээлэг хүмүүсийн нэг билээ.

Загалмайтнуудыг сөхрүүлхийн тулд энэ Султаны хийсэн нэгэн үйлийн талаар өгүүлье. Мисирийн султан өөд болохынхоо өмнөхөн Акра хотыг байлдан эзэлж Загалмайтнуудад ихээхэн хор хохирол учруулсан билээ. Энэ дайнд Адений султан өөрийн гурван түмэн морьтон цэргийг илгээж, дээрээс нь дөрвөн түмэн тэмээгээр Мисирийн султаныг дэмжсэн нь Загалмайтнуудад ихээхэн гарз хохирол, үхэл зовлон авчирч, саранцинууд ялалт байгуулахад үнэлж барамгүй тус болсон билээ. Тэр энэ зүйлийг хийхдээ Мисирийн султаныг хайрлан хүндэтгэсэндээ биш бөгөөд харин Загалмайтнуудыг нэг нүд үзэлгүй хялайн өширхөж 248 явдагтаа л хийсэн үйл билээ.

Аден, Хормуз, Кайс болон өөр бусад хотуудад хийсэн онгоцны дарвуул нь хэврэг тул Энэхэгийн далайд аялж явахад байн байн урагдана. Хэрэв энэ газрын далай тэнгис манай нутгийнх шиг догшин ширүүн авиртай, үргэлж хүчтэй салхи шуурга болж байдаг бол эндхийн нэг ч хөлөг онгоц эсэн мэнд аянаас эргэж ирэхгүй билээ. Ийм хэврэг дарвуулыг эндхийн худалдаачид хийж, далайчид нь хэрэглэдэг гэж бодвол өрөөсгөл зүйл болно. Тэдгээр хүмүүс далайд гарахдаа хүн бүхэн хийлдэг арьсан тулам авч явдаг билээ. Далайн шуурга дэгдэж, аюул осол нүүрлэх цагт далайчид болон худалдаачид тэдгээр арьсан тулмандаа сувд, үнэт эрдэнийн чулуу, зарим хувцас хунар, хоол хүнсээ савлан хийлээд хооронд нь холбон нэгэн төрлийн хөвдөг завь, сал мэт болгоно. Хөлөг онгоц нь сүйрсэн хүмүүс тийм салаар хөвөн амь мэнд гардаг байна. Далайн ааш араншингийн эрхээр хөвж яваа хүмүүс идэх хоол, уух усаа тулмалсан тул олон хоног өдрөөр далайгаар эсэн мэнд хөвж амь гардаг байна. Бараа таваартай хөлөг онгоц нь аль хэдийн далайд живэн сүйрсэн байдаг.

Одоо Аден мужийн өчүүхэн захирагчтай, нэгэн том хотын тухай өгүүлж яриагаа үргэлжлүүлье. Энэ хот Аденаас баруун хойшоо дөрвөн зуун (400) бээр зайд орших Шихр хэмээнэ. Энэ хотыг нэгэн гүнтэн захирах агаад тэр гүнтэн өөрийнхөө эзэмшин захирсан мужид хууль журмыг хатуу чанд мөрдүүлнэ. Гүнтэний засаг захиргааны эрхшээл дор хэд хэдэн хот балгад хамаарагдах авч өөрөө адений султанд захирагдана. Хотын оршин суугчид нь Магоменийг тахин шүтдэг сарацинууд. Энэ хот маш аятайхан далайн боомттой бөгөөд тэр боомтод нь бараа таваар дүүрэн ачсан худалдааны хөлөг онгоцнууд Энэтхэг орноос ирнэ, мөн эндээс төрөл бүрийн эд бараа ачиж аваад Энэтхэг орон руу аялна. Энэ нутгаас бол маш их үнэ цэнэтэй, уналга, ачилгын сайхан сайхан морьд хэдэн зуу, мянгаар нь ачиж Энэтхэг оронд борлуулан ихээхэн ашиг олз олно.

Энэ мужид сайн чанарын цагаан гүгэл болон хасарваань их ургана. Энэ нутагт тутарганаас өөр 249 тариа ургадаггүй. Харь орноос маш их загас худалдан авна. Загас маш элбэг ялангуяа том том туна загас бол бүр ч элбэг тул хоёр том туна загасыг венецийн нэг задгай зоосоор худалдан авдаг. Гол хүнс нь тутарга, мах, загас болой. Энд усан үзмийн дарс гэж үгүй тул дарсаа тутарга, элсэн чихэр, чавгаар нэрнэ. Бас нэгэн сонин зүйл дуулгая. Энд огт чихгүй хонь байх агаад чих байх газар нь ядаж юм сонсох сүв ч үгүй, харин чих байх газар нь бяцхан эвэртэй. Тэдгээр хонь нь маш хөөрхөн жижигхэн амьтад байдаг. Та бүхэнд гайхмаар санагдах зүйл бол тэндхийн гэрийн тэжээмэл амьтад болох хонь, үхэр, тэмээ, одой морьд нь загасаар хооллоно. Тэдгээр амьтдад идэх ногоо өвс хаана ч ургадаггүй, энэ газар бол хорвоогийн

хамгийн хуурай гандуу нутаг билээ. Тэдгээр гэрийн амьтдыг тэжээдэг жижигхэн загасыг гурав, дөрөв, тавдугаар сард асар ихээр барина. Барьсан загасаа хатааж хадгалан жилийн турш малаа тэжээнэ. Эндхийн гэрийн тэжээмэл амьтад нь тэрхүү жижиг загасыг барьсан дор нь амьдаар нь ч идчихдэг.

Мөн энэ газар нэгэн төрлийн маш том, тарган бөгөөд хямдхан загас элбэг. Нутгийн хүмүүс энэ загасаар жигнэмэг хийж иднэ. Тэдгээр загасыг зүсэж нимгэлээд барагцаалбал нэг нэг фунт орчим хэмжээтэй хэсэглэн хатаагаад жилийн турш жигнэмэг хийж идэцгээнэ. Энэ газар цагаан гүгэл их ургадаг талаар би дээр өгүүлсэн билээ. Энэ нутгийн эзэн захирагч гүнтэн нэг кантар жинтэй цагаан гүгэлийг иргэдээсээ арван алтан бэзантинаар худалдан авч харь орны худалдаачдад дөчин алтан бэзантинаар дамлан худалдана. Шихр хотын захирагч гүнтэн энэ наймаагаа Адений султаны нэрийг барьж хийнэ. Адений султан нь өөрийнхөө хараат, харьяат нутаг орноосоо гүгэлийг 10 бэзантинаар худалдан авч харийнханд 40 бэзантинаар дамлан худалдаж үнийн зөрөөнөөс нь асар их ашиг хонжоо олдог билээ. Энд одоо нэмээд яриад байх сонин содон зүйл үгүй тул Дофар (Dhofar) – ийн тухай өгүүлж яриагаа үргэлжлүүлье.

Дофар бол Шихрээс баруун хойт зүгт таван зуун (500) бээр зайтай орших маш том сайхан хот билээ. Тэнд Сарацинууд оршин амьдарна, тэд цөм лал шүтлэгтэй. Эндхийн хүмүүс нь Адений оршин суугчидтай эгээ адил омог угсаатай. Хот нь далайн эрэг дээр орших агаад маш сайхан усан боомттой, олон газар орноос худалдааны хөлөг онгоц төрөл бүрийн бараа таваар ачиж тээж авчрах төдийгүй мөн эндхийн бараа таваар, эд өлгийг ачиж буцна. Энд хөрш зэргэлдээх газар нутгаас маш сайн үүлдрийн сайхан араб адуу, морьд авчирч зарж борлуулан наймаачид нь ихээхэн ашиг хонжоо гаргана. Энэ хотын нөлөө захиргаанд олон олон хот балгад харьяалагдан оршино. Энд маш сайн чанарын гүгэл элбэг ургана. Гүгэл ургадаг мод нь жижигхэн гацуур шиг мод байдаг билээ. Гүгэлий нь авахын тулд модон дээр нэлээд гүн хэд хэдэн хэрчлээс гарган орхиход гүгэл буюу модны шүүс нь өөрөө урсан гарч дусална. Энэ нутагт маш халуун тул модны гүгэл нь нарсны давирхай шиг аяндаа урсан гарч өтгөрөн царцах агаад гүгэлийн модыг хэрчиж шархлуулах хэрэггүй билээ. Харийнхнаас худалдан авч цуглуулсан араб адуу, морьдыг Энэтхэг оруулан үнэ хүргэж зарна. Өөр сонирхуулаад байх зүйлээр ховор тул Калхат (Kalhat) – ын булан орж яриагаа үргэлжлүүлсүгэй.

Калхат хот нь Калхат нэртэй далайн буланд оршдог том хот. Энэ хот Дофараас баруун умар зүгт зургаан зуун (600) бээр зайтай байдаг. Хүмүүс нь сарацинууд, Магометийг шүтэж мөргөнө. Калхат нь Хормузийн засаг захиргааны нөлөө хүрээнд багтана. Хормузийн малик өөрөөсөө хүчтэй өрсөлдөгч дайсантай тулалдахаар болохдоо Калхатын хэрэм цайзад ирж хоргодоно. Энэ хэрэм цайз нь маш бөх бат төдийгүй дайсныг оруулахгүй эсэргүүцэхэд тун зохимжтой билээ. Энд тариа ер тарьдаггүй, харь орноос далайгаар зөөж тээж авчирна. Энэ хот нь маш сайхан далайн боомттой бөгөөд тэрхүү боомтод Энэтхэг орноос худалдааны хөлөг онгоцнууд байн байн ирнэ. Харь орны худалдаачид энд бэлэн зэлэн зах зээл дээр авчирсан эд бараа, тоног төхөөрөмжөө борлуулна. Харин эндээс Энэтхэг орон руу цэргийн унаанд хэрэглэх морьдыг илгээж худалдаачид асар их ашиг олно. Эндээс Энэтхэг рүү илгээсэн морьдын тоог хэн ч хэлж, нэрлэж мэдэхгүй билээ.


Калхат хот нь далайн булан руу ордог нарийн хоолойн аман дээр орших агаад тэрхүү булан руу хөлөг онгоц орох, тэндээс гарах нь зөвхөн Калхатын захирагчийн хүсэл зоригоос бүрэн

хамаарах талтай. Калхат хотын энэхүү байршил нь тэндхийн эзэн маликийг хүчирхэг болгож байгаа гол гогцоо төдийгүй түүний эзэн захирагч Керманы султан ч зарим үед түүнтэй эвлэрэхээс өөр замгүй байдалд хүрдэг. Заримдаа султан нь Хормузийн маликийг буюу түүний ахан дүүсийг 250 дааж давахад төвөгтэй алба гувчуураар дардаг явдал цөөнгүй тохиодог, тэр үед тэд Хормузаа орхин Калхат хотноо бүгэж далайн буланд орох нарийн хоолойг чандлан хамгаалж сахин суух агаад хэн ч түүгээр нэвтэрч үл чадна. Ийм нөхцөлд Керманы султан Хормузийн маликаас сохор зоос ч авч чадахгүй болж эвийн хэлцэл хийхээс өөр замгүй болдог. Мөн Хормузийн маликийн эзэмшил захиргаанд бас нэгэн үүнээс ч хавьгүй хүчирхэг хамгаалалттай цайз буй бөгөөд тэр цайзнаас далайн булан болон бүх орц, гарцыг хянан тохинуулж байдаг билээ. Эндхийн хүмүүс хасарваанийн чавга, давсалсан загасаар голдуухан хооллох авч баян чинээлэг нэг нь илүү сайн чанартай төрөл бүрийн хүнс хоолоор элбэг хангалуун хооллож бусдаасаа ялгарахаар тансаг амьдардаг нь яах аргагүй үнэн билээ. Сая би та бүхэнд Калхат хот болон Калхатын булангийн тухай нэлээд тодорхой ярилаа харин одоо Хормузийн тухай ярьж өгье.

Хормуз нь Калхатаас хойт, баруун–хойт зүгийн завсар чигт гурван зуун (300) бээр зайтай оршино. Калхатаас гарсан аянчин баруун, баруун-хойт зүгийг чиглэн таван зуун (500) бээр аялахад Кайс хүрнэ. Гэвч бид Кайсаар оролгүй орхиж Хормузийн тухай л ярилцъя. Хормуз бол тэнгисийн эрэг дээр орших том бөгөөд сайхан хот. Хотыг түүнд харьяалагдах хөрш зэргэлдээх хэдэн хотын хамт малик захирна. Хүмүүс нь сарацинууд, Магометийг тахин шүтнэ. Эндхийн цаг агаар байж тэсэхэд бэрх хэтэрхий халуун, орон байшин бүрт салхи оруулж байх нүхэн салхивчтай агаад салхины чиг дагуу амыг нь эргүүлж болдог. Өөрөөр тэр их халуунаас зайлах бага ч болов сэрүүцэх арга үгүй билээ. Бид номынхоо түрүүчийн нэг бүлэгт Хормуз, Кайс, Керманы тухай нэлээд тодорхой ярилцсаныг санаж байгаа биз дээ. Харин энэ удаа Хормузад ирэхдээ өөр замаар аялж, өөр зүгээс ирсэн тул товчхон боловч энэ тухай өгүүлсэн билээ. Энэ нутаг, газар орны тухай урьд нь нэлээд ярилцсан тул энэ хавиар эргэлдээд байлгүй цаашаа аялж Туркестан орж тэр тухайгаа өгүүлсү.

## Есдүгээр бүлэг

### Умарт бүс нутаг ба Тартаруудын дайн



Туркестанд Хайду нэрт хаан байдаг бөгөөд тэр Их Хааны ач хүү билээ. Хайду бол Цагаадайн хүүгийн хүү<sup>251</sup>, харин Цагаадай бол Их хааны төрсөн ах (авга ах)<sup>252</sup> билээ.

Хайду хааны эзэмшил захиргаанд олон олон хот балгад захирагдах агаад тэр бол ихээхэн эрх сүртэй, хүчирхэг эзэн. Хайду өөрөө тартар, түүний хүмүүс ч мөн тартар. Тэд нар маш эрэлхэг дайчид. Тэр хүмүүс бүгд дайтан тулалдах дадал заншилтай, дайн тулаанд дасал болсон хүмүүс гэдгийг гайхаад байх зүйлгүй билээ. Хайду хаан Их хаантай хэзээч эвсэг найртай харилцаж байгаагүй, мөнхийн сөргөлдөөн, дайсагналаар заналхийлсээр ирснийг бид мэдэх юм. Туркестан нь бидний аялж яваа зам буюу Хормузаас баруун хойт зүгт оршино. Энэ нь Гихон (Gihon) голын чанад эргээр, Их хааны хараат нутгийн умарт хязгаартай хил залгаа гэсэн үг.

Хайду Их хааны цэрэгтэй олон удаа дайтан тулалдсан. Тэр хоёрын хооронд хэрүүл, тэмцэл хэрхэн үүссэнийг тайлбарлая. Хайду хаан Их хаанаас байлдан дагуулсан газар нутгаасаа өөртөө хувь хишиг хүртээхийг үргэлжид шаардсаар байсан бөгөөд ялангуяа Катар болон Манзи нутгийн хэсгээс өг<sup>253</sup> гэж зогсоо жолоогүй шахаж шавдуулсаар байсан билээ. Их хаан ч хувь хишиг хүртээхээс огт татгалздаггүй байснаар барахгүй, өөрийнхөө хөвгүүдэд өгсөн



хувь хишгээс дутуугүй өгнө. Ганцхан чи намайг дуудсан цагт хааны ордонд ирж бай, ургийн зөвлөгөөнд оролцож бай, бусдын нэгэн адил надад захирагдаж бай гэсэн хариу шаардлага тавьдаг ажээ. Энэ л нөхцөлийг биелүүлбэл Их хаан юу ч өгөхөөс үл татгалзана гэдэг байв. Гэвч Хайду хаан авга ахдаа үл итгэх тул хааны ордонд очдоггүй байжээ. Харин би байгаа газар нутагтаа байж Их хааны зарлиг тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлж байя, хааны ордонд очих ямар ч шаардлагагүй гэдэг байсан бөгөөд хааны ордонд очвол амиа алдана гэж айдаг байжээ. Энэ байдал тэр хоёрын тэмцэл сөргөлдөөний эхийг тавьсан билээ. Энэ бүхнээс болоод тэр хоёрын хооронд олон удаа хатуу ширүүн дайн тулаан болж байсан. Сөргөлдөөн тэмцэл үргэлжилж байсан он жилүүдэд Их хаан Хайдугийн харьяат, хараат газар нутгийг өөрийн цэргийн хүчээр бүслэн хаасаар байлаа. Ийнхүү бүслэн хаах нь Хайду болон түүний албат харьяат нар Их хааны эзэмшил газар нутаг, хүн ард руу дайран довтолж эзлэн түйвээхээс сэргийлж байсных билээ. Гэсэн хэдий боловч Хайду хаан Их хааны эзэмшил нутаг, цэрэг, ард руу байн байн уулгалан довтолж, тосон ирсэн цэрэгтэй нь үхэн тулалдсаар байсан билээ. Ер нь Хайду хаан чармайн зүтгэж, бүх хүчээ дайчилвал: байлдааны ур ухааныг төгс эзэмшиж, дайн тулаанд ширээсэн ган шиг хатуужил тэсвэр суусан нэг буман (100000) морьт цэрэг нэгэн зэрэг гаргах боломжтой байсныг би гадарлах юм.

Үүнээс гадна Хайду хааны дэргэд алтан ургийн угшил гарвалтай буюу Эзэн Чингисийн удам угсааны бага хаад, ноёд олон байдаг байв. Чингис бол эзэнт гүрнийг үндэслэгч төдийгүй дэлхийн талыг байлдан эзэлсэн агуу их эзэн байсан гэдгийг бид мэдэх билээ. Одоо би та бүхэнд Их хааны цэргийн эсрэг Хайдугийн хийсэн зарим нэгэн тулааны талаар ярьж өгье.

Эхлээд тэдний тулалдааны арга барилын талаар ярья. Цэрэг эр болгон тулалдаанд орохдоо жаран сумтай орох агаад түүний гучин ширхэг нь нэвт хавах хүчтэй нарийн сум, гуч нь дайсны эгнээг сарниулах өргөн зэвтэй урт сум байна. Урт сумаараа харваж дайснаа шархтуулан эгнээ жагсаалыг нь сарниулангуутаа, нарийн сумаараа харваж дайснаа нэвт хаван сөнөөнө. Бүх сумаа харваж дууссаны дараа сэлэм, жадаараа хатгалдан цавчилдаж үхэн тулалдана. Хэрхэн алалдан тулалддагийг тайлбарлан ярьсан тул дээр өгүүлж эхэлсэн зүйлдээ эргэн орьё.

Манай бурхан мэндэлсний 1266 онд Хайду хаан өөрийн үеэл Есүдэр (Yesudar) нарын хамт Их хааны хоёр ноёны эзэмшил нутагт довтолж оржээ. Тэр хоёр ноён нь Хайду хааны үеэл төдийгүй Их хаан Хубилайн ах, загалмайн шашинтан Цагаадайн хөвгүүд Чибай (Chibai) болон Чибан (Chiban) нар байсан юм. Ингэж Хайду хаан өөрийн ураг төрлийн Чибай болон Чибан хаад руу уулгалан довтолжээ. Тэр хоёр ноёд ч мөн л ихээхэн цэрэг дайчидтай байсан билээ. Хоёр этгээдийн тулалдаанд орсон морьтой дайчдын нийт тоо нь бум орчим болж байсан. Энэхүү амь дүйсэн ширүүн тулалдаанд аль аль талаас нь олон олон цэрэг дайчдын амь үрэгдэж хэн хэн нь ихээхэн гарз хохирол хүлээсний эцэст Хайду хаан их үнэ цэнээр ялалт байгуулжээ. Гэсэн хэдий боловч түүний эсрэг зогсон тэмцэлдэж байсан үеэл хоёр дүү нь хүлэг сайн морьдынхоо ачаар, тулалдааны талбараас эсэн мэнд зугтан зайлж амжижээ.

Энэ ялалтын дараа Хайду хаан улам ч биеэ тоон бардам дээрэнхүй байх болжээ. Тэр ялалтаасаа хойш Хайду хаан Их хааныхаа газар нутаг, албат иргэдэд зэвсэглэн халдалгүй бүтэн хоёр жил амар жимэр аж төрөхөд Их хааны зүгээс нэг ч дайн довтолгоон өдөөсөнгүй. Айван тайван хоёр жил өнгөрмөгц Хайду хаан асар олон морин цэрэг бөөгнөрүүлэн

довтолгоонд бэлтгэж эхлэв. Хайду хаан Хархорум хотноо Их хааны хүү Номоган (Numughan) Прэстэр Жоны ач хүү Жорж нар байгаа гэдгийг сайн мэдэж байлаа. Тэр хоёр ноёны захиргаанд асар олон дайчидтай, хүчирхэг морин цэрэг бэлэн байжээ. Хайду хаан их цэргээ авч нутгаасаа гараад Хархорум хотод дөхөж очтолоо элдэв саад тотгортой нүүр учран тулсангүй явсаар хүрчээ.

Хайду хаан цэрэглэн довтолгож яваа мэдээг авсан хоёр ноён өчүүхэн ч балмагдаж тэвдсэн зүйлгүй угтан тосож тулалдахаар зориг шулууджээ. Ингээд тэр хоёр ноён өөрсдийхөө захиргаанд байсан зургаан түмэн (60000) морин цэргийг хөдөлгөн Хайду хааны буудлаас арван бээрийн зайд очиж буудаллан хуарагнаж тулалдаанд шаргуу шахамдуу бэлтгэж эхлэв. Хоёр этгээд их тулааны өмнө нам гүм харгалдан буудаллаж тулалдаанд бэлтгэцгээв.

Энэ түүхийг сунжруулалгүй ингэсгээд товчилъё. Их хааны хүү, Прэстэр Жоны ач хүү хоёр, гуравдахь өдрийн өглөө эрт их цэргээ засаж тулалдаанд бэлтгэв. Хоёр этгээд цэрэг зэвсгийн хувьд хэн нь ч хэнээсээ илт давуу зүйл үгүй байлаа. Аль аль нь нум сум, илд бамбай, жадаар өвч зэвсэглэсэн зургаан түмэн морьтон дайчидтай байв. Тал бүр цэргээ зургаан түмтэд хуваан эмхлэж түмэт бүрийг дайн тулааны дадлага туршилгатай шилдэг жанждаар захируулсан байлаа. Тун ч удалгүй хоёр этгээд тулалдаанд бэлэн болцгоож, тулалдаан эхлэх бөмбөрийн дохиог тэсэж ядан хүлээцгээнэ. Тартарууд тулалдаан эхлэх дохиог эзний бөмбөр дэлдээгүй байхад аль ч тал нь тулалдааныг үл эхлэн хоёр чавхдастай<sup>254</sup> хөгжмөө эгшиглүүлэн дуу хөгжөөн, бүжиг наадам наадна. Хоёр этгээдийн дайчид тулааны өмнө ингэж дуулж, хөгжимдөх нь үнэнхүү гайхамшигтай, сонсоод ханамгүй байдаг. Гэнэт тулалдааны бөмбөр нижигнэн дэлдэж, цэргүүд урт амьсгал авах мэт түр зуурхан нам гүм болж хэн хэн нь эсрэг талынхнаа энэ дайд буруутгах мэт түгдрэсхийнэ.

Харваачид нумаа онилон сумаа тавихад зэхэж, бусад нь жадаа атган хатгалдаанд бэлтгэн дайран орцгооно. Энэ үед харвасан сум тэнгэрийг үүл мэт бүрхэн, бороо мэт буухад эр цэрэг, хүлэг морьд харвасан суманд хавуулан үхэдхийн унацгаана. Тулааны үед дэгдэх дуу чимээнд тэнгэрийн аянга ч үл сонсогдох агаад тэр үед л эд нар чинь үнэнхээр бие биенээ үзэн ядсан өшөөтөн дайснууд байж шүү гэж бодогдоно. Суман мөндөр буусаар, үхэл хагацал тээсэн энэ өдрийн тулаан ч үргэлжилсээр хоёр этгээдийн аль алинд нь ээл өршөөлгүй ширүүн тулаан эхлэх нь тэр. Харваачид сумаа тавьж дуусмагц дайчид илд, жадаа далайн бие биерүүгээ дайран орж, зууралдан тулалдахад тас цавчуулсан гар, эрхтэн шороотой хутгалдан унаж, үхлийн шарх авсан цэрэг амаараа шороо үмэхлэн тийчилж байх нь нүд хальтрам. Гэвч энэ бүхэн урт удаан үргэлжлэхгүй шархадсан, унасан цэрэг эрс удалгүй үхэж дуусна.

Энэ тулаанд Хайду хаан цэрэг эрийн шантрашгүй зориг, ид хав, эрэлхэг жанжны ур ухааныг гайхуулан тулалдаагүйсэн бол түүний цэргүүд тулалдааны талбарыг орхин сарнихад ойрхон үе олон удаа нүүрлэсэн. Хайдуг сөрөн тулалдаж буй Их хааны хүү, Прэстэр Жоны ач хүү хоёр ч цэрэг эрсийн гайхамшигийг үзүүлж байлаа. Энэ тулаан бол тартаруудын хоорондоо хийсэн дайн тулаанаас хамгийн их цус асгаруулж, хамгийн олон цэрэг дайчдын амийг авсан аймшигт ширүүн тулааны нэг яах аргагүй мөн байсан. Дайн тулалдааны дуу чимээнд аянгын нүргэлээн ч үл сонсогдом байсан билээ. Хоёр этгээд шинэ шинэ цэргээр хүч сэлбэж өглөөнөөс үдэш болтол үхэн тулалдсан боловч хэн нь ч хэнийгээ дийлэх янзгүй болж тулалдааны талбар хүүрээр дүүрч, цэрэг эрсийн тамир тасарч эхэллээ. Тулалдааныг тэр

өдрийн гай барцад дагуулсан муу цагт эхэлжээ. Хичнээн эхнэр бэлэвсэрч, хичнээн хүүхэд өнчирч, хичнээн эх хүүгийнхээ царайг дахин харахгүй болж, хичнээн охид бүсгүйчүүд хайртай хүнийхээ энхрийллийг эргэн ололгүй нулимсан далайд живхийг үгээр илэрхийлэхэд бэрхтэй. Нар шингэх гэж байхад тулалдаан үргэлжилсээр хэн нь хэнийгээ дийлэхийг хэлэхэд бэрх байсан. Үдшийн бүрэнхийтэй өрсөлдөн ядарч туйлдсан цэргүүд өөр өөрийнхөө хуаранд эргэн ирж амь өрсөн тулаанаасаа амсхийж ухаан орцгоов. Өдөржин үргэлжилсэн үхэл, амьдралыг дэнсэлсэн тулаанаас түр ч болов хагацан амрах нь хүн бүхэнд баяр цэнгэл авчирсан мэт болов.

Их хаан өөрийнхөө хүүд туслуулахаар нэмэлт хүч илгээснийг сонссон Хайду хаан цаг алдаж алмайралгүй үтэр түргэн тулалдааны талбарыг орхих нь зүйтэйг ойлгожээ. Үүрийн гэгээтэй уралдан Хайду хааны цэргүүд морио эмээллэн, хуяг дуулга агсаж нутгийн зүг хүлгийн жолоо залав. Их хааны хүү, Прэстэр Жоны ач хүү хоёр Хайду хааныхныг үтэр түргэн буруулж байгааг харсаар байгаа боловч өчигдрийн тулалдаанд ядарч туйлдсан тэд Хайду хааны цэргийг нэхэн байлдах тэнхэлгүй болсон байв. Хайду хаан болон түүний цэрэг дайчид зам гудаст амасхийлгүй довтолгосоор Туркестаны хаант улс, Самарканд хотноо эргэн иржээ. Тэд дахин дайн самуун дэгдээлгүй нам жим сууцгаах болсон. Хайду хаан өөрийнхөө газар нутаг руу зогсоо жолоогүй довтлон, өөрийнхөө хүмүүс, албат иргэдээ өөрсдөө сөнөөн устгаж буй дайныг өдөөн турхирч байдаг Хайдуг Их хаан ихэд жигшин дургүйцэж байдаг ажээ. Хэрвээ Хайду Их хааны ач хүү, алтан ургийн угсаа гарвальтай байгаагүйсэн бол түүний эзэмшил газар нутгийг хураан авч өөрийг нь хамгийн муу үхэлээр тарчлан үхэх ял онооход бэлэн байжээ.

Хайду хаан Айярук (Айярук)255 хэмээх гүнжтэй байсан агаад түүний энэ нэр нь тартараар “Гэгээн саран” гэсэн үг болой. Энэ гүнж гайхам их тэнхээ чадалтай охин байсан агаад Хайдугийн хаант улсад тэр гүнжтэй барилдаад дийлдэг нэг ч эр хүн байдаггүй байв. Эцэг хаан охиноо эрд гаргаж нөхөр, ханьтай болгохыг хүсэн шаардахад гүнж ийн өчив: Надтай барилдаад намайг дийлсэн эрийн гэргий болно гэв. Үүнийг сонссон эцэг хаан эр нөхрөө өөрийнхөө шалгуураар тэнсэн256 сонгож авахыг зөвшөөрөв.

Тартаруудын дунд дэлгэрсэн нэгэн уламжлал заншил бол хаан ч бай, ханхүү ч бай, язгууртан дээдэс ч бай эхнэр авахдаа тэдний угсаа гарваль, удам судрыг нэг их онцгойлон үздэггүй, харин үзэсгэлэн төгс царай зүстэй, ухаалаг сайхан зан аальтай бол эхнэр болгох бүсгүйнхээ язгуур угсаа, нийгэмд эзлэх байр сууринд нэг ч их уягдаад байдаггүй билээ. Тартаруудын аль нэгэн гэр бүл болон овог отгийнхон зөвхөн эрчүүдийнхээ нэрээр угсаа залгаж, удам судраа үргэлжлүүлдэг бөгөөд хэзээч Бертагийн хүү юм уу, Мэрийгийн хүү гэж ярьдаггүй, зөвхөн Питерийн хүү, Мартиний хүү гэх зэргээр эцгээр нь овоглож ярилцах тул эх нь ухаалаг, царайлаг бол хэн ч байсан хамаагүй байдаг.

Хайду хааны охин эр нөхрөө өөрөө сонго гэсэн эцгийнхээ шийдийг сонсоод хагартлаа баярласан. Тэгээд хорвоогийн олон улсад: Айярук надтай барилдаад дийлсэн идэр залуу, язгууртан эр миний нөхөр болно гэсэн зар тараажээ.

Энэ зар мэдээ хорвоогийн улс орноор түгэн тархаж хаа холын газар нутгаас эр бяраа нь жагсаж жигдэрсэн, идэр залуу хаад, ноёд, язгууртан дээдэс Хайду хааны гүнжтэй барилдан эр бяраа үзэж дийлэн хатнаа болгох чин хүсэлдээ хөтлөгдөн иржээ. Энэ сорилго тэмцээн хааны ордны

нэгэн том гоё асарт болжээ. Хаан ч өч төчнөөн зочид, язгууртан дээдсээр бараа болгон иржээ. Энэ үед хааны гүнж эрдэнэс чулуугаар чимсэн гоёмсог торгон өмсгөлтэй их асарт орж ирэхэд гүнжтэй барилдаж хүчээ сорих идэр залуу язгууртан эрс ч мөн гоё ганган торгон өмсгөлтэй<sup>257</sup> их асарт цугларцгаав.

Сорилго барилдааны бооцоо нь: Хааны гүнжтэй барилдаад давсан эр түүнийг эхнэрээ болгож авах агаад, гүнжид унасан эр түүнд нэг зуун адуу өгөх ёстой байжээ. Ингээд сорилго барилдаан өндөрлөхөд хааны гүнж нэгэн түм (10000) гаруй морьд бооцоонд хожиж, нэг ч идэр эр гүнжийг унагаж дийлсэнгүй. Үүнд гайхаж мэлрээд байх зүйл үгүй билээ. Учир нь Айярук гүнжийн бие цогцос тэгш шулуун, булчин шөрмөс нь ган шиг уян, эд эрхтэн бүхэн нь төгс төгөлдөр зохицолтой бөгөөд хүдэр чийрэг бие бялдар нь түүнийг аварга биетэн мэт харагдуулна.

Энэ явдал манай бурханы 1280 онд болж билээ. Хайду хааны ордонд харь нутгийн хүчирхэг, баян ханы идэр залуухан, дэгжин цэвэрхэн ханхүү зочлон иржээ. Тэр ханхүү өөрийнхөө үнэнч нөхдийг дагуулан мянган адуу туусаар, Хайду хааны гүнжтэй хүч чадлаа сорин үзэж түүнийг эхнэрээ болгон авахаар зорин иржээ. Хайду хаан ч охиноо хань нөхөртэй болгохын түмэн хүслэн болоод байсан тул охиноо ханхүүд буугаад өгчих гэж ятгажээ. Ханхүү бол Пумар (Pumar)<sup>258</sup> ханы хүү гэдгийг Хайду мэдэж байсан билээ. Охин эцгийнхээ ятгалгыг сонсоод хүзүү толгой үргэлж байсан цагт хэнд ч бууж өгөхгүй гэж эрс хариулжээ. Барилдаан болох сорилгын өдөр хаан, хатан, тоогүй олон ноёд, дээдэс тэмцээн болох их танхимд цугларчээ. Зочид гийчид цугларсны хойно гүнж болон ханхүү танхимд ирэхэд тэр хоёрыг хараад хараад ханашгүй үзэсгэлэн төгс ёстой л гайхамшиг гэгч тэр байлаа. Эр, эм хоёр залуу үнэнхүү чийрэг бадриун, өндөр өсгөлөн залуус байсан агаад ханхүүтэй бие бялдар, бяр чадлаараа эн тэнцүү өрсөлдөх хүн бол Хайду хааны гүнж яах аргагүй мөн байлаа. Сорилго барилдаан эхлэхийн өмнө ханхүү бооцоо тавин ийн өгүүлэв: Би барилдаад гүнжийг хаявал эхнэрээ болгоно, дийлэхгүй унавал тууж ирсэн мянган адуугаа өгнө гэв. Сорилго эхэлж хоёр залуус барьцалдан авахад их танхимд байсан хүн болгон, тэр тусмаа хаан хатан хоёр ч ялгаагүй ханхүүг дийлээсэй гэж үнэн сэтгэлээсээ хүсэмжлэн уухайлж, хааны гүнжийг эр нөхөрт богтлон өгөх хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөцгөөнө. Үүнийг ингэж урт сунжруу олон үгээр тайлбарлахаа болиод барилдаандаа эргэн оръёо. Эр эм хоёр залуу бие биенээ дийлэхгүй удаан тэмцэлдэн ноцолдсоны эцэст хааны гүнж ханхүүг өргөн танхимийн шалан дээр<sup>259</sup> хаяж орхив. Ингээд ханхүү тууж ирсэн мянган адуугаа бооцоонд алдав. Ханхүүгийн уй гашуу, ичиж зовсныг үгээр илэрхийлэхэд бэрхтэй бөгөөд шалнаас өндийн босож, наалдсан тоосоо гүвэнгүүт анд нөхдөө дагуулан үтэр түргэн нутаг буцахаар хөдлөв. Үүнээс өмнө энэ ханхүүг дийлдэг нэгээхэн ч эр байгаагүй билээ харин энэ удаад гүнжийн гарын үзүүрт унаснаасаа хязгааргүй их ичиж зовсоор арилж өгөв. Ханхүүгийн уй гашууг хуваалцаагүй нэг ч хүн энэ их танхимд байгаагүй гэж би бардам хэлнэ.

Үүнээс хойш Хайду хаан өөрийн охиныг олон олон дайн тулаанд авч явсан бөгөөд түүний охиныг давж гарах ид хавтай, эрэлхэг зоригтой баатар эр нэг ч байгаагүй билээ. Тэр гүнж амь дүйсэн их тулалдааны голомт руу шуугин орж дайсны баатар эрс олныг өөрийн гараар олзлон авчирч байсан юм.

Сая та бүхэнд Хайду хааны охин гайхамшигтай бяр тэнхээтэй, эрэмгий зоригтой гүнжийн

тухай өгүүллээ. Одоо Хайду хаан болон Левантийн хаан Абага (Abaka) - ын хүү Аргун (Arghun) нарын хооронд болсон их тулалдааны тухай өгүүлье. Абага бол Левантийн эзэн хаан гэдгийг та бид аль дээрээс мэдэх болсон билээ. Түүний эзэмшил газар нутаг нь Сулхарнайн тухай номонд “Хуурай мод” нэрээр гардаг Ганц модны хавиар Хайду хааны нутагтай хил залган оршдог билээ. Хайду хааны халдлага довтолгооноос газар нутаг, хүн ардаа хамгаалах зорилгоор Абага хаан өөрийн хүү Аргунд хүчирхэг морин цэрэг голлосон ихээхэн хүчийг захируулан Хуурай модны муж, Гихон голын дагуу хуарагнан сууж хамгаалалт бэхлэлтээ чангатгахаар илгээжээ. Ханхүү Аргун ч хуурай модны орчмын тал хөндийг эзэгнэн тэр нутгийн олон олон хот тосгодыг маш хичээнгүй, болгоомжтойгоор хамгаалан суужээ.

Хайду хаан маш олон морьт цэрэг цуглуулан нэгэн цул хүчин болгоод өөрийн дүү эрэлхэг зоригтой, цэргийн эрдэмд төгс Барах (Barak) ноёноор захируулан ханхүү Аргуны эсрэг хөдөлгөжээ. Барах ноён ханхүү Аргун болон түүний цэрэг эрсийг даран сөнөөж, дагуулан эзлэхийг амлан алсын замд гарчээ. Барах ноёны их цэрэг Гихон голын сав газар хүртлэх хол замыг туулахдаа ямар нэгэн саад тотгор, элдэв дайралт халдлагад огт өртөлгүй айван тайван аялсаар ханхүү Аргуны цэргийн хуарангаас арван бээрийн саахалтад бууж хуарагнав260. Барах ноён их цэрэг аваад өөрийнх нь эсрэг ирж яваа гэдгийг ханхүү Аргун мэдэж байсан тул цэргээ засаж байлдахад бэлэн болгоод хүлээж байжээ. Хөрш зэргэлдээ харгалдан буусан хоёр их цэрэг гурван хоногийн дараа зэр зэвсгээ агсан тулалдаанд бэлэн болжээ. Тулалдаан эхлэх бөмбөрийн дуу нижигнэн сөргөлдөн эгнэсэн хоёр их цэрэг уухайлан ухасхийж үхлийн тулалдаан эхлэв. Харвасан сум тэнгэр бүрхэж, нар халхлахаар зайгүй нисэн мөндөр мэт бууж хоёр талын цэрэг эрс, хүлэг морьдын хүүрээр тулалдааны талбар хучигдав. Харваачдын сум дуусах агшинд илд жад харшилдан цавчуулж сэглүүлсэн цэрэг эрс үхэдхийн унаж, шархадсан хүн, морьд хааяагүй тийчлэнэ. Дайны талбар дахь дуу шуугиан тэнгэрт хадаж, аянга ниргэсэн ч сонсогдохооргүй болжээ. Хээр тал цэрэг эрс, хүлэг морьдын хүүрээр хучигдав. Олон үг нуршилгүй шуудхан хэлэхэд удалгүй Барах ноёны цэрэг дайчид ханхүү Аргуны дайралтыг торгоон тогтоож дийлэхгүйд хүрэн хүчин мөхөсдөж ухарсаар голын цаад эрэгт гарав. Ханхүү Аргуны цэрэг дайчид тэднийг гэзэг даран хөөж хядаж эхлэв.

Энэ ялалтын дараа ханхүү Аргун тун удалгүй эцэг хаан Абага тэнгэрт хальсан тухай гунигт мэдээ авчээ. Уй гашууд дарагдсан ханхүү эцэг хааны ордонд очихоор хөдөлсөн боловч энэ алс замыг туулахад бүтэн дөчин өдөрчийн хугацаа хэрэгтэй байв. Тэр хооронд Абага хааны дүү, лал шүтлэгтэй ноён Ахмад султан, ханхүү Аргуныг алс хол байгааг далимдуулан их цэрэг цуглуулан ахынхаа хаан орыг булаан эзлэхээр шийджээ. Тэгээд Ахмад султан сарацин цэргээс бүрдсэн их хүчин хуримтлуулан хааны ордонд дайран орж хаан ширээг булаан эзэлжээ. Ахмад султан хаан орыг булаан эзлээд хааны эрдэнэсийн санг нээхэд сэтгэлд багтаж, нүдэндээ итгэмээргүй асар их эрдэнэс цуглуулсан байжээ. Ахмад султан өөрийгөө даган урваж, дэмжин зулгуйдах ноёд, язгууртан дээдсийг баруун солгойгүй эд эрдэнэсээр шагнаж урамшуулав. Ноёд, язгууртан дээдэс ч бидэнд Ахмад султанаас өөр хаан хэрэггүй гэгцгээх болжээ. Гэвч Ахмад султан нэгэн буруу үйлийг хийсэн нь юу гэвэл ах Абага хааныхаа хатад, эмсийг өөртөө авчээ.

Ахмад султан хаан эзний орыг булаан эзлээд төд удалгүй ханхүү Аргун их цэрэгтэйгээ ойртож яваа мэдээ авчээ. Тэр огтхон ч сандарч тэвдэлгүй, цаг алдалгүй ноёд ихэсээ дуудаж, өөрийгөө тойрон хүрээлэгсдийг цуглуулжээ. Ингээд долоохон хоногийн дотор их цэрэг

цуглуулж Аргуныг тосон байлдаж чадвал амийг нь егүүтгэх, эсвэл олзлон авч тамлан хорихоор өөр хоорондоо тохиролцоцгоов. Ахмад зургаан түмэн морьтон цэрэг цуглуулж чадсан бөгөөд ханхүү Аргуныг тосон арван өдөрчийн газар явсны дараа Аргун зогсолтгүй довтолгон тавхан өдөрчийн газар ирээд байгааг олж мэджээ. Хоёр этгээдийн цэрэг дайчдынхаа тоогоор яг ижил байв. Ахмад нэгэн их уужим хөндийд хуарагнан сууж Аргуныг хүлээхээр зэхсэн агаад энэ хөндийд тосон байлдахад нэн тохиромжтой газар байлаа. Их цэрэг хуарагнан байрласны дараа тэр шадар хүмүүсээ дуудан цуглуулж ийн өгүүлэв: “Эрхэм ноёдоо, би бол миний ах Абага хааны ширээ, хэргэм зэргийг залгамжлах эрхтэй нэгэн гэдгийг та бүхэн мэднэ, учир нь бид хоёр нэгэн эцгийн хөвгүүд билээ. Одоо бидний эзэгнэн суугаа энэ газар нутаг миний эрх мэдлийнх байх ёстой. Зарим нэгэн хүн хаан ширээг миний ахын хүү Аргун залгамжлах ёстой гэж бодож байх магадгүй. Тэгвэл тэдний зөв. Гэвч миний ах Абага хаан ширээг эзлэн дэндүү удаан суусан тул түүнийг нөхцсөний дараа би яагаад хаан ор залгамжилж болохгүй гэж. Түүнийг амьд сэрүүн байхад энэ газар нутаг, эд баялгийн талыг би эзэмших эрхтэй байсан боловч тэгээгүй. Харин одоо бол энэ бүхнийг эзэмдэн эдлэхийн тулд хамтын хүчээр ханхүү Аргуны эсрэг нэгдэн тэмцэж би хаан ширээг, та бүхэн эд баялаг, эрх мэдлээ хамгаалан тэмцэлдэх учиртай. Та бүхний мэргэн ухаанд би эргэлзэхгүй байгаа тул эрх мэдэл, эд баялгийн эзэд байхын төлөө бид бүхний үйл хэргийн төлөө нэгдэн тэмцэцгээе” гээд үгээ өндөрлөв. Ахмад султаны үгийг сонссон ноёд, жанжид, язгууртан дээдэс нэгэн дуугаар: “Ахмад султаны үйл хэргээс хэзээч урваж шарвахгүй, сүүлчийн амьсгалаа тасартал ханхүү Аргуныг сөрөн тэмцэлдэнэ гэж андгайлав. Тэд Ахмадыг айж эмээх хэрэггүй бид Аргуныг барьж авчраад өөрт чинь тушаана” гэцгээв. Ахмад ч тэдний үгийг сонсож, сэтгэлийг мэдэрсэн тул тойрон хүрээлэгсэдийнхээ амлалтад эргэлзээгүй итгэж байв. Үнэнхээр амь дүйсэн тулаанд орохын өмнөхөн үүнээс өөр илүү үг ч хэрэггүй байсан бизээ. Харин одоо ханхүү Аргуны талаар ярья.

Ахмад султан асар их цэрэг хуримтлуулан түүнийг тосон хүлээж байгаа мэдээ авч ихэд хилэгнэн бачимдсан боловч зам зууртаа саатан зогсолгүй аажим тайван урагшилсаар байв. Харин ахан дүүс, ураг төрөл нь түүнээс урван тэрслэж буй энэ үед ухаан сэтгэлээ хөвчлөн чангалж, уй гашуу, айдас сандралын алийг ч үзүүлж болохгүй, харин эрэлхэг дайчин зоригтой байж, дайчин нөхдөө зоригжуулан, уравсан хулгай дайсантай тэмцэх ёстой гэж хатамжлан байв. Ханхүү Аргун хуарагнан бууж, амсхийх газраа өөрийнхөө асар ордыг цогцлоон ноёд, жанжид, зөвлөхүүдээ урин залж их зөвлөгөөн хийхдээ ийн өгүүлрүүн: “Ахан дүүсээ, анд нөхөд минь, миний эцэг амьд ахуйдаа та бүхнийг хичнээн их хайрлан хүндэлдэг байсныг та бүхэн санаж байгаа. Эцэг маань амьд ахуйдаа та бүхэнд өөрийн ахан дүүс, үр хүүхэд шиг ханддаг байсан. Та нар миний эцэгтэй мөр зэрэгцэн хичнээн олон амь дүйсэн тулалдаанд орж, ямар их газар нутгийг байлдан дагуулснаа санаж байгаа биз. Тэгвэл та бүхнийг хүндэтгэн хайрлаж асан тэр хүний төрсөн хүү би гэдгийг та бүхэн андахгүй, би өөрөө та бүхэнд амь шигээ хайртай, та бүхнийг амьдрал шигээ хайрлаж явдаг билээ. Би та бүхэнд чин үнэнээ хэллээ, харин одоо бидний эрх чөлөө, эд хөрөнгө, эхнэр хүүхэд, газар нутгийг маань булаан эзэлсэн хүнээс тэр бүхнээ эргүүлэн авахад надад тусална уу гэж та бүхнээс хүсэж байна. Тэр хүн манай шашин, ёсноос урван тэрсэлж Магометийг шүтэн мөргөдөг – Сарацин болсон хүн. Сарацин хүн тартар биднийг эрхшээн захирч, эзэгнэн суух нь зохимжтой гэж бодоцгооно уу? Ахан дүүс, анд нөхөд минь ийм байдалд хүргэхгүйн тулд хүн бүхэн зүрхээ чангалан, сэтгэлээ хатамжлан, зоригоо хөвчлөн тулалдаасай гэж хүсэж байна. Үнэн шударга нь бидний талд осол хуурмаг нь Сарацины талд байгаа тул үнэн ялж,

бид дийлэх учиртай” гэж хэлээд тэрээр үгээ төгсгөв.

Ханхүү Аргуны хэлсэн ухаалаг, үнэн үг ноёд, жанжид болон бусад бүх хүний зүрх сэтгэлд хүрч хүн бүхэн сэтгэл дотроо, өөрөө өөртөө чин шударга үйлийн төлөө үхэх амь, үрэгдэх биеэ үл хайрлан тэмцэн тулалдана. Үнэн бидний талд осол хуурмаг нь дайсны талд байгаа цагт бид заавал ялах учиртай гэж өөрөө өөртөө андгайлан нам гүм сууцгаана. Гэтэл нэгэн их жанжин босож бүгдийг төлөөлөн өгүүлсэн нь: “Эрхэм эзэн Аргун минь, таны хэлсэн үг бүхэн үнэн гэдэгт эргэлзэх нэг ч хүн үгүй бөгөөд бид ч өөрсдөө хэлүүлэлтгүй мэдэх билээ. Би энд байгаа ноёд, жанжид, цэрэг дайчид ялгаагүй амьсгалаа тасарч, амиа тавьтал үнэн мөний төлөө, эзэн таны төлөө, эх нутаг газар шорооныхоо төлөө тулалдаж ялна гэдэгт итгэлтэй байна. Яагаад гэвэл үнэн бидний талд, худал хуурмаг дайсны талд байгаа билээ. Тийм учраас тулалдаанд маш нямбай чандлан бэлтгэж, аль болох хурдан давшиж тулалдахыг та бүхэнд зөвлөж, та бүхнээс хүсэж байна. Анд нөхөд, цэрэг дайчид минь бидний алдар гавьяа, нэр сүр хорвоо дэлхийгээр түгэн тархана гэж итгэн залбирч байна” гэв. Их жанжны хэлсэн үг бүгдийн зүрх сэтгэлд хүрч, өөр хэн ч үг хэлсэнгүй, бүгд жанжинтай санаа бодол нэг байж, нэгэн үзүүрт бодолд хөтлөгдөж байв.

Маргааш өглөө нь Аргун болон түүний цэрэг дайчид үүр цүүрээр довтолгон давшиж Ахмадын хүрээ хуарангаас аравхан бээрийн зайд хүрээлэн бууж, тулалдаанд бэлтгэгцээв. Аргун өөрийн итгэлт хоёр хүнийг сонгон авга ах руугаа илгээв. Аргуны илгээж буй хоёр элч нас бие тогтсон эрс агаад эзэнтэйгээ салах ёс үйлдэн, мориндоо мордож илүү дутуу үггүйгээр Ахмадын хуаранг чиглэн одов. Тэр хоёр Ахмадын өргөөнд бараалхаж ороход Ахмад өөрийнхөө ноёд дээдэстэй цугларсан байв. Ёс жаягийг мэдэх хоёр эрхэм тэд нарыг хүндэтгэн мэндчилэхэд Ахмад нэлээд хөхүүн хөгжингүй авир, царайтай хоёр элчтэй мэнд мэдэлцээд өмнөө суулгав. Мэнд ёсоо мэдэлцсэний дараа хоёр элчийн нэг нь босож ийн өгүүллүүн: “Эрхэм дээдэс минь, таны ач дүү Аргун таны үйлдсэн хэрэг явдлыг гайхахын ихээр гайхаж байна. Та эзэн төрийн хаан ширээг булаан эзлээд зогссонгүй, ханхүү Аргунтай байлдан тулалдаж үхэх сэхэхээ үзэхээр тосон ирээд байна. Энэ бол муугийн цаадах муу үйл бөгөөд элбэрэл энэрэлтэй авга ах хэзээч ингэж авирлаж аашилдаггүй билээ. Аргун таныг өөрийн эцэг шиг хүндэтгэн хайрладаг тул сэдэж санасан нүгэлт үйлээсээ татгалзан орхиоч хэмээн гуйж байгаагаа хэлүүлж биднийг зарж ирүүлсэн билээ. Та нарын хооронд дайн тулаан бүү болог, өнөд үл цайрах өшөө хорсол бүү зангидаг. Аргун таныг хаан эцэг шигээ хүндэтгэн хайрлах агаад өөрийнхөө бүх газар нутгийг эзэмшүүлэн хаан өргөмжлөхөд бэлэн байна гэсэн ач дүүгийн чинь үгийг дамжуулан айлтгаж байна. Түүний чин хүсэл энэ ажгуу” хэмээгээд өөр үг нэмж айлтгасангүй. Ачийнхаа хэлүүлсэн үгсийг сонссон Ахмад хариу ийн өгүүллүүн: Эрхэм элч нараа миний ач дүүгийн ярьж байгаа зүйл шал дэмий зүйл. Энэ газар нутаг бол түүний юм биш, үүнийг байлдан эзлэхэд би түүний эцэгээс бага зүтгээгүй. Ийм учраас эргэж очоод түүнд ингэж хэл гээд: Би түүнийг их эрх мэдэлтэй ноён болгож, эзэмшин захирах хангалттай газар нутаг, албат иргэд өгье, тэгээд тэр миний хүүхдүүдтэй хамт их ноёд болцгоож надад захирагдан үйлчилж байг. Миний энэ саналыг эс зөвшөөрвөөс би түүнийг цаазлан хороохоор хичээн зүтгэнэ гэж байна” гэж эзэндээ очиж хэл гэв. Энэ бол миний эцсийн шийд, сүүлчийн үг. Өөр ямар ч нөхцөл болзол тавихгүй гэв. Султаны энэ үгийг сонссон элч нар энэ үнэнхээр таны сүүлчийн үг бөгөөд эцсийн шийдвэр үү? өөр ямар нэгэн хариу бидэнд өгөхгүй юу гэж лавлав. Энэ толгой мөрөн дээр байсан цагт өөр ямар ч хариу өгөхгүй гэж Ахмад султан хэлэв.

Энэ хариуг сонссон элч нар үтэр түргэн хуарандаа эргэн ирж Ахмадын хэлсэн хариу үгийг Аргунд нэгд нэгэнгүй ёсоор айлтгав. Авга ахынхаа хариуг сонссон ханхүү Аргун машид хилэгнэн тэнд байгаа хүмүүст тодоос тод сонсогдохоор: “Авга ах маань намайг маш хорсолтойгоор гутаан доромжилж байх тул хорвоо дэлхийгээр нэг шуугин шагширтал өшөө хорслоо авахгүй бол надад алтан амь, агуу төр юусан билээ” гэв. Тэгээд тэр ноёд, баатрууддаа хандан: “Бузар санаа өвөрлөн хаан ширээ булаан эзэгнэж, эзэнт төрийг бусниулсан муу хулгай нарыг үнсэн товрог болгон хийсгэхээс өөр зам үгүй боллоо. Маргааш эртлэн довтолж байлдан устгасугай” гэж зарлиг болов.

Ханхүү Аргун тэр шөнөдөө их тулалдаанд бэлтгэн цэрэг зэвсгээ зэхэж бэлэн болгов. Ахмад султан Аргуныг их тулалдаанд бэлтгэж байгааг өөрийн заншлаачдаас олж мэдээд мөн л шөнөжин бэлтгэж хонов. Үүр гэгээрмэгц Аргуныхан зэр зэвсгээ агсан тулалдааны байраа эзлэн жигдрэв. Аргун өөрийн цэрэг дайчдыг маш ухаалаг зөв байрлуулж, хүн бүхэн хүчээ шавхан үхэн тулалдхын учрыг халуун дотноор хандан сануулав. Ахмад султан ч мөнхүү огт хоцролгүй тулалдаанд бэлтгэн Аргуны довтолгоог хүлээлгүй угтан байлдахаар зэхэв.

Хоёр их цэрэг улаан нүүрээрээ тулгаран улангассан тулалдаанд ороход харвасан сум бороо шиг шаагиж үхлийн шарх олсон хүн, морьд гишгэх зайгүй шахам хавтгайлдан унаж, ёолох, хашгирах дуун тэнгэрт хадна. Харваачид үхэл тээсэн сумаа тавьж дуусмагц илд, жадаа сэрэлзүүлсэн цэрэг эрс гардан тулж хатгалдан тэмцэлдэхэд хүний гар, толгой тасар тасар цавчуулан унаж цэрэг эрс газар сайгүй үхэдхийн унацгаана. Энэ өдөр хичнээн олон идэр залуу, эрэлхэг дайчин эрс хөрст шороо дэрлэн унаж, хичнээн олон эх, охид бүсгүйчүүд насан туршдаа уйтгарлан гуних зовлонгийн нулимсанд живсэн нь тоо алга. Аргун болон түүний цэрэг дайчид эр зоригийн ид хавыг үзүүлэн тулалдсан боловч хүчин мөхөсдсөөр эцсийн эцэст амьд үлдсэн нь амь зулбан зугтацгаав. Ахмад султаны цэргүүд тэднийг мөрдөн хөөж мөртөө дайралдсан бүхнийг хядсаар ханхүү Аргуныг олзлон авч мөрдлөг, хядлагаа зогсоон хуарандаа эргэн ирцгээв. Ахмад ч ялалтын баяртаа мансууран ачаа янгинатал агдлан хүлж, хар гэрт хорин харуул манаа гаргаж чандлан сахиулав.

Энэ ялалтынхаа дараа Ахмад султан ордон руугаа буцаж олон олон эмс хүүхнүүдтэйгээ жарган цэнгэхээр, торгон цэргээ дагуулан яаран сандран одов. Их цэргийг захиран тохинуулах, ханхүү Аргуныг агдлан хүлж ордонд хүргэх үүргийг оноож нэгэн их мелик-ноёныг тохоон томилж үлдээв. Их цэрэг буцах замдаа аажуу тайван, амарч хоноглосоор дөт замаар явахыг зарлиг болгов. Мелик ч эзнийхээ үүрэг, тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлэхээ амлан хоцров. Хүлээс, гинжиндээ тарчлан зовсон Аргун хувь заяаныхаа даажигналд хорсон гуниж үхэх өдрөө хүлээнэ.

Энэ үед тартарын нэгэн өндөр хэргэмтэй, сурвалжит их ноён ханхүү Аргуныг өрөвдөн хайрлаж, тэд бүгд нийлэн ямар гээч их нүгэл хилэнц үйлдэн, эзэн дээдсээ олзлон, агдлан хүлж хорионд тамлан, хороохоор зэхэж буйг эрэгцүүлэн бодсоор энэхүү бузар үйлийг таслан зогсоож ханхүү Аргуныг суллан тавих нь зөв гэдэгт эргэлзсэнгүй. Тэр сурвалжит тартар язгууртан өөрийн итгэлт нөхдөө цуглуулан жинхэнэ эзэн хаанаа олзлон барьж агдлан хорьж, хороон нөхцөөхөөр зэхэж байгаа нь уучилж болошгүй нүгэл хилэнц гэдгийг нөхөддөө тайлбарлан таниулахад: энэ яахын аргагүй гарцаагүй үнэн гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч, Аргуныг нэн даруй суллах учиртай гэцгээв. Учир нь тэр өвөгжөөр тартар язгууртан олны



дунд маш их нэр хүндтэй төдийгүй цэцэн ухаан, шударга үйлээрээ нэрд гарсан нэгэн ажээ. Ингэж тохиролцсон тэдгээр тартар язгууртан ноёд Буга (Boga), Элчидэй (Elchidai), Туган (Togan), Тигана (Tegana), Тогачар (Togachar), Улатай (Ulatai), Самагар (Samagar) нар Аргуныг хорьсон асар руу очиж, энэхүү хуйвалдааныг түрүүчлэн толгойлсон Буга ноён Аргунд хандан ийн өгүүлрүүн: “Эзэн таныг хорьж, бид ямархан осол буруу хэрэг үйлдсэнээ ойлгон наманчилж байна. Одоо бид шударга үнэнийг баримтлан Эзэн дээдэс таныг чөлөөлж буй төдийгүй бидний хууль ёсны хаан гэдгийг хүлээн зөвшөөрч байна” гэв.

Бугын хэлэхийг сонсоод доог тохуу хийж өөрийг нь тавлаж байна гэж Аргун бодоод: Өршөөлт эрхэм ноёд минь, та бүхний надаар доог тохуу хийх чинь нүгэл хилэнц биш гэж үү. Та бүхэн миний албат харьяат байх атлаа урвасан хулгайн гар хөл болж намайг олзлон барьж хүлж гинжлэн агдлан хорих чинь нүгэл хилэнц биш гэж үү, та бүхний үйлдсэн энэ осол гэм чинь аюумшигтай нүгэл хилэнц гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа, надаар тоглоом тохуу хийхээ больж эндээс үтэр түргэн зайлж мөр мөрөө хөө” гэж хилэгнэн хөөв.

“Өршөөлт эзэн Аргун минь, бид тоглоом тохуу хийж таныг гутаан доромжлох санаа өчүүхэн ч агуулсангүй билээ. Бидний хэлсэн үг, хийсэн үйл маань чин үнэн гэдгийг дээдсийнхээ уламжлал заншлыг барин андгайлъя” гээд Буга болон түүний нөхөд Аргуныг өөрсдийн жинхэнэ хаан эзэн гэж хүлээн зөвшөөрч буйгаа, хаан эзэндээ сөгдөн мөргөж тангараглав. Аргун ч тэдний хэлж ярьж байгаа үнэн болохыг итгэн түүнийг барихад тэдний оролцсон ялыг хэлтрүүлэн эцэг хаан Абага амьд сэрүүндээ тэдгээр ноёдод үзүүлж байсан хайр хүндэтгэлийг нэгэн адил үзүүлнэ гэдгээ амлав. Ийнхүү харилцан амлалт өгч тангараг өргөсний дараа тэд нөхөд Аргуныг суллан чөлөөлөв.

Тэд нар суллагдаж чөлөөлөгдсөн Аргуныг жинхэнэ эзнээ гэж хүлээн зөвшөөрсөн төдийгүй түүний тушаал зарлигаар жанжны сууринд суун гол өргөөнд заларч байсан мелик-ноёныг харван алав. Ингээд тэнд байсан бүх цэрэг дайчид Аргуныг хууль ёсны хаан гэдгийг бүгд хүлээн зөвшөөрч түүнд үг дуугүй захирагдав. Ахмадыг төлөөлөн, бүхнийг захиран үлдээд тартар ноёдод харвуулан хальсан мелик-ноён өөрийнхөө зэрэг дэвээр Ахмадын дараа ордог байсан Султан хэмээгч сарацин эр байжээ.

Аргун, хаан эзний эрх засгаа хүлээн авмагц ганц ч мөч алгууралгүй үтэр түргэн хааны ордны зүг довтолгон хөдөлжээ. Яг энэ үед Ахмад хааны ордны гол танхимд их найр хурим хөгжөөн цэнгэж суутал түүний зараал элч яаран сандран ирж ийн өгүүлрүүн: “Эрхэм дээдэс минь намайг нигүүлсэн өршөөгөөрэй, би танд маш таагүй муу мэдээтэй ирлээ. Ноёд дээдэс Аргуныг хорионоос чөлөөлөн өөрсдийн жинхэнэ эзэн гэдгийг хүлээн зөвшөөрснөөр барахгүй манай итгэлт хүн Султаныг хороогоод одоо наашаа ирж таныг барьж авахаар довтолгон айсуу. Ийм цагт юу хийх нь зөв бэ гэдгийг сонгон түүнээ гүйцэлдүүл” гэж айлтгав. Энэ мэдээг хүргэж ирсэн элчид эргэлзэх аргагүй үнэнч боол тул үнэн эсэхэд эргэлзэх нь илүүц зүйл байлаа. Аймшигт мэдээнд цочирдон балмагдсан Ахмад айдас хүйдэстээ хүлэгдэн юу хийх, юу хэлэхээ ч таг мартан хөшилдөж орхижээ. Гэвч Ахмад эрэлхэг зоригтой нэгэн байсан тул мэдээ хүргэж ирсэн элчийг энэ талаар нэг ч үг, хэнд ч дуугарч болохгүй гэж чандлан тушааж цаазлан хориглов. Ахмад өөрийнхөө хамгийн итгэлт нөхөд, тойрон хүрээлэгсэдээ цуглуулан яаралтай оргон Мисирийн султанд орогнол гуйн очихоор яаран довтолгов. Ахмад хэзээ, хэнтэй, хаашаа оргон зайлсныг хамт бараа болж яваа нөхдөөс нь өөр хэнч үл гадарлах ажээ.

Зургаан хоног довтолгон явсаар нэгэн даваанд тулж ирсэн агаад тэр даваагаар нэвтрэн давах цорын ганцхан нарийн зөрөгтэй ажээ. Энэхүү давааг хамгаалан суугаа цэргийн захирагч нь Ахмадыг ч таниж, оргон зайлахаар зугтаж яваа гэдгийг ч мэдэж. Ингээд захирагч түүнийг саатуулан барихаар шийдэв, хэдхэн бараа бологсодтой Ахмадыг барихад ямар ч төвөггүй байв. Ахмад захирагчаас түүнийг тавьж явуулахыг гуйн сөгдөж асар их эд баялаг өгөхийг амласан боловч захирагч Аргун хааны үнэнч албат байсан тул надад хорвоогийн бүх эрдэнэсийг өгсөн ч авахгүй, харин чамайг барьж хууль ёсны хаандаа амьдаар чинь тушаана гэж эрс шууд хэлжээ. Үүнийг нуршин тоочоод яахав, харин захирагч Ахмадыг барьж оргон зайлах аргагүй агдлан хорьж, цагдан харуулдсаар зогсоо чөлөөгүй довтолгон хааны ордонд хүргэн иржээ. Дөнгөж гурван хоногийн өмнө ордондоо эргэн ирж амжсан Аргун хаан Ахмадыг оргон зайлсныг мэдээд машид харамсан бухимдаж байтал хилийн харуулын захирагч түүнийг барьж авчирч тушаахад Аргун хаан хязгааргүй их баярлан талархжээ.

Аргун хаан авга ахдаа: Та бол миний тэсэж ядан хүлээсэн хүндэт зочин маань биш ч гэсэн тэсэх аргагүй өшрөн хорссон дайсан маань мөн билээ. Үүний учир өөрийг чинь цаазлан хороох учиртай гэв. Аргун хаан энэ шийдийг гаргахдаа хэнтэй ч зөвлөөгүй билээ. Ингээд харуулын ахлагчид үүнийг аваачиж цаазлаад бие махбодыг нь хэн ч олохооргүй үгүй хий гэж зарлиг буулгажээ. Үүнээс хойш Ахмадыг хэн ч, хаана ч харагүйгээр үл барам хэн ч дурсан санаагүй билээ.

Ингэж Аргун хааныг хаан ширээнд залж, түүний эзэмшил нутгийн бүх ноёд, дээдэс ирж Эзэндээ хүндэтгэл, итгэл үзүүлсэн их ёслол хурим болжээ. Аргун хаан өөрийн хүү Газан (Ghazan) – д гурван түмэн цэрэг захируулан “Хуурай мод” хэмээх хязгаар мужид илгээн газар нутаг, хүн ардаа харийн халдлага довтолгооноос хамгаалан суух зарлиг буулгажээ. Аргуныг хаан ширээнд өргөмжилсөн үйл нь манай бурханы 1286 онд болсон үйл хэрэг билээ. Үүнээс өмнө Ахмад султан хоёр жил хаан ширээг эзэгнэж байсан бөгөөд Аргун хаан өргөмжлөгдөөд зургаан жил хаан ор суужээ. Аргун хаан өвчнөөр өөд болсон боловч түүнд хор уулган алсан гэх яриа тасардаггүй билээ.

Аргун хааныг өөд болсны дараа түүний төрсөн дүү Гахайт хаан төрийг 261 эзлэн захирах болов. Энэ үед Газан өөрийн цэрэгтэйгээ алс холын Хуурай модотын хязгаар нутагт хил хязгаараа хамгаалан суусан Гахайт төрийн эрх булаан эзэгнэх нь амар хялбар байлаа. Эцэг хаан нь өөд болсон, хаан төрийг авга ах Гахайт эзэгнэн захирах болсон мэдээ Газаны сонорт хүрч уй гашуу, гутрал хорслыг нэгэн зэрэг авчирсан боловч Газан урьдын гашуун түүхийг мартаагүй байсан тул хаан ширээ, төрийн эрх мэдлийн төлөө үхэн тэмцэлдсэнгүй. Гэвч цаг нь болохоор Гахайтын эсрэг, хаан төрийн эрх мэдлийн төлөө тулалдана гэдгээ Газан мэдэж байсан авч яаран хөдөлсөнгүй. Газантай хамт түүний цэрэг дайчид л үлдсэн бөгөөд бусад нь цөм Гахайтын захиргааг хүлээн зөвшөөрч түүнд захирагдах болов. Гахайт Аргуны авааль гэргийг хатнаа болгон үргэлж өөрийнхөө дэргэд байлгадаг байсан төдийгүй өөрөө их шалиг завхай эр байжээ. Гахайт хоёр жил орчим хаан төрийг эзэгнэн байснаа гэнэт үхсэн агаад түүнд хор уулгасан байжээ. Гахайтыг үхсэний дараа хаан төрийг Газаны өөр нэгэн авга, загалмайн шүтлэгтэй Байду (Baidu) эзлэн 1294 онд хаан орыг булаан авчээ. Байдуг Газан болон түүний цэргүүдээс бусад нь эзэн гэж хүлээн зөвшөөрсөн байна. Газан Гахайтыг хаан ширээнээс түлхэн унагаж өшөө хорслоо тайлаагүйдээ харамсаад харамсаад үл барна. Харин одоо хаан төрийг эзэгнэн суугаа авга Байдугаасаа хаан ширээгээ эргүүлэн авч хорвоо ертөнц

цочин доргитол өшөө хорслоо авна гэж амлав. Ингээд Газан цэргээ авч саатаж түдэлгүй шуурхайлан Байдугийн эсрэг хөдөлжээ.

Байду ч мөн ихээхэн хүч хуримтлуулж чадсан бөгөөд арван өдөрчийн газраас угтан байлдахаар хөдөлжээ. Арван хоногийн урт зам туулсан Байду хуарагнан бууж Газаныг отон хүлээж байлдахаар зэхэж өөрийн талын дайчдыг эрэлхэг зоригтой тулалдахыг дахин дахин гуйж шаардсаар байлаа. Ингээд Газаныг тосон хоёр хоног хүлээжээ. Газаны цэрэг дайчид дөнгөж хүрэлцэн ирмэгц л хоёр этгээд үхэн тулалдаж эхэлсэн бөгөөд Байдугийнхан энэ тулалдаанд удаан тэссэнгүй агаад Байдуг дагалдан ирсэн олон олон цэрэг дайчид шууд Газаны талд урван орж Байдугийн эсрэг тулалдаж эхэлжээ. Энэ тулалдаанд Байду зөвхөн ялагдаад зогссонгүй өөрөө алагджээ. Ингэж Газан ялж, хааны ордонд эргэн ирж хаан ширээгээ эзлэн, эзэнт улсаа захиран суусан агаад бүх ноёд, дээдэс түүнд үнэнч зүтгэх андгай тангараг өргөжээ. Ингээд 1294 оноос Газаны хаанчлал эхэлжээ.

Та бүхэн Абага хаанаас Газан хааныг хүртэлх түүхийг сонслоо. Энэ түүх бол Багдадыг байлдан эзэлсэн Их хааны дүү Хүлэгээс эхэлсэн үүх түүхтэй гэдгийг та бүхэн бэлхнээ санаж байгаа гэдэгт эргэлзэх зүйлгүй билээ. Хүлэг нь Абага хааны эцэг, Абага нь Аргун хааны эцэг, Аргун нь одоо төр барьж байгаа Газан хааны эцэг билээ.

Би та бүхэнд Левангийн тартаруудын тухай чамгүй их зүйлийг ярьсан тул одоо Туркестаны зүг анхаарлаа хандуулъя. Ер нь Туркестаны талаарх гол гол зүйлсийг ярьсан бөгөөд тэр газар нутгийг Хайду хаан хэрхэн захиран жолоодож буйг ч ярьсан болохоор нэмээд хэлчих зүйл ховор хомс болжээ. Харин одоо бид умар зүгт орших муж нутаг болон тэнд амьдардаг хүмүүсийн тухай ярья.

Умарт нутгийг Кончи (Kaunchi) хэмээх хан захирна. Тэр өөрөө тартар төдийгүй, түүний албат иргэд нь бүгд тартарууд. Тэд нар маш хатуу чанга хуучны тартарын хууль, дэг жаягийг мөрдөн амьдарна. Энэ хууль, дэг жаяг нь жинхэнэ тартар эзэн Чингис хаанаас уламжилж ирсэн улбаатай билээ. Одоо би та нарт энэ тухай бага сага зүйлийг өгүүлсү. Тэд нар өөрсдийн шүтдэг бурханаа Начигай гэх агаад тэр бас эхнэртэй. Начигай болон түүний гэргий нь газар ус, мал сүрэг, будаа тариа болон эх дэлхийн эд баялгийг арвижуулан хамгаалдаг бурхад гэцгээнэ. Тэд энэ бурхандаа залбирч мөргөн тахиж шүтнэ. Хоол хүнс элбэг дэлбэг, газрын гарц, өгөөж сайн байвал бурхадын ач гэж үзэн бурхадынхаа аманд тос өөх, идээ будаа түрхэж мялаана. Хүмүүс нь их бүдүүлэг ан араатан шиг амьдарцгаана.

Кончи хан бол Эзэн Чингисийн удам угсааны, алтан ургаас гаралтай хан бөгөөд хэнд ч тухайлан үл захирагдана. Тэдний нутаг оронд хот балгад, хэрэм цайз үгүй. Тэд цаг үргэлж өргөн тал, өндөр уулсын хөндий хоолойгоор нутаглан аж төрнө. Тэд өөрсдийн мал сүргийн махыг идэж, сүүг ууж аж төрөх агаад тариа будаа огт байхгүй. Хан эзэн нь маш олон албат иргэдтэй боловч хэнийг ч уулгалан үл довтлон айван тайван аж төрнө. Тэд нар тоогүй олон тэмээ, адуу, үхэр, хонь болон бас бусад гэрийн амьтадтай. Тэр нутагт асар том хорин төө илүү урт биетэй цагаан баавгай, хар үнэг, зэрлэг илжиг, маш их үнэтэй арьстай булга тоо томшгүй олон. Булганы арьсан дээл нь элбэг нэг мянган безантийн үнэ хүрнэ. Хэрэм их элбэг, зуны цагт тарвага элбэгтэй. Энэхүү хүний хөл бараг хүрдэггүй зэлүүд зэрлэг нутагт ан араатан маш элбэг билээ.

Энэ их уужим газар орон цас мөс, намаг шалбаагаар битүү хучигдсан байдаг тул мориор туулах аргагүй билээ. Энэ бэрхтэй замыг туулахад бүтэн арван гурав хоног хэрэгтэй болдог. Нэг өдөрчийн замын төгсгөлд дэн буудалтай тэнд зорчигчид хоноглох газартай. Энэхүү дэн буудалтай өртөөн дээр илжиг шиг том биетэй дөчин нохой бэлэн зэлэн уяатай байна. Эдгээр ноход нь зорчигчдыг нэг өртөөнөөс нөгөөд хүргэх унаа болдог.

Цас мөс, намаг шалбаагнаас болоод мориор туулах аргагүй замын тухай өгүүлье. Арван гурван хоногийн турш явж туулдаг энэхүү цас мөсөөр битүү хучигдсан, намаг шалбаагтай зам нь хоёр их уулын хоорондуур үргэлжлэх урт хавцал хөндийгөөр туулж өнгөрнө. Мөс цас, намаг шалбааг нь морь явах аргагүй тул бас дугуйтай тэрэг хөсөг ч туулах аргагүй билээ. Энэ замаар зөвхөн чаргаар л явдаг. Чарга бол цас мөсөн дээгүүр хялбархан гулгахаас гадна намаг шалбаагт шигддэггүй. Манай нутагт ч гэсэн өвлийн цагт өвс, сүрэл тээхдээ чаргаар л зөөдөг, бороо хуртай, намаг шалбаагтай үед мөн чарга хэрэглэнэ. Чарган дээрээ баавгайн арьс дэвсээд түүн дээрээ зорчигчоо суулгана. Чаргандаа зургаан нохой хөллөх агаад хөтөч гэж байдаггүй харин туугч нь чарганыхаа ард зогсоно. Ноход замаасаа огт хазайлгүй нэг өртөөнөөс нөгөө өртөө хүртэл давхих агаад чарга ч хөнгөхөн гулсана. Ингээд дараагийн өртөөн дээр ирэхэд нохой хөллөсөн чарга бэлэн зэхий байх агаад хүргэж ирсэн чаргатай ноход буцна. Ийм маягаар энэхүү урт замыг нохой хөллөсөн чаргаар 262 туулдаг билээ.

Эндхийн уулс, хөндий, зам гудаст амьдардаг хүмүүс бол бүгд маш их арга туршлагатай ангуучид байдаг. Тэд нар үнэ цэнэтэй үс, арьстай булга, суусар, хэрэм, үен болон галт хар үнэг ихээр агнана. Тэр арьс үснээсээ ихээхэн олз ашиг олдог. Тэдний тавьсан хавх, занганаас ямар ч ан мултардаггүй билээ. Цаг агаар нь маш хүйтэн тул хүмүүс нь голцуухан газар ухаж барьсан нүхэн гэрт амьдарна. Энд өөр яриад байх сонин зүйл үгүй тул мөнхөд шөнөөрөө байдаг газар орны тухай өгүүлсү.

Энэ ханлигаас цаашаа алс умар зүгт Харанхуй Газар гэгч муж 263 орших агаад тэнд нар, сар, од алинч эс үзэгдэн мөнхийн харанхуй хучилгатай байдаг агаад манай эндхийн үдшийн бүрэнхий шиг бүүдгэр, сүүмгэр байна. Энэ газар хаад, ноёд, захирагч гэж үгүй тул хүмүүс нь өөр өөрийн дураар зэрлэг ан араатан шиг амьдарна. Заримдаа энэ нутагт тартарууд хүрч ирдэг. Тэд энд ирэхдээ нутгаасаа унагатай гүү унаж гараад энэ харанхуй газрын захад унагыг нь үлдээгээд гүүгээ унан ирнэ. Унагатай гүү буцаж унагандаа хүрэх замыг төвөггүй олох тул төөрхийн аюул осол үгүй билээ. Тартарууд эндхийн оршин суугчдыг тонон дээрэмдэж хэрэгтэй бүхнээ булааж аваад буцахдаа унасан гүүнийхээ унагаа олох зөн совинд хөтлөгдөн төөрч будилалгүй эргэж ирэх авай.

Эндхийн хүмүүст булга, суусар, үен, хэрэм, хар үнэг зэрэг үслэг ангийн үнэт арьс маш их байдаг. Эндхийн хүмүүс бүгд гайхамшигтай сайн ангуучид байх агаад анчин бүр тоо томшгүй их үнэтэй үслэг ангийн арьстай байдаг. Тэд эдгээр арьсаа өдөр шөнийн зааг газарт нутаглах хөрш зэргэлдээх овог аймгийнхандаа зарж борлуулна. Үслэг арьс худалдаж авсан наймаачид асар их орлого олзтой байдаг. Харанхуй газрын оршин суугчид нь өндөр чацархуу, бие эрхтэн нь тэгш сайхан зохицолтой, цонхигор цагаан царайтай байдаг. Энэ муж нутаг нэг талаараа Их Орос (Great Russia) оронтой хил залгаа оршино. Одоо энэ мужийн тухай яриад байх онцын сонин зүйл үгүй тул Орос орны тухай өгүүлсү.

Орос орон бол умар зүгт орших асар том муж билээ. Хүмүүс нь загалмайн шашинтай бөгөөд

герег урсгалын зан үйлийг дагаж мөрдөнө. Орос орон хэд хэдэн хантай, өөрийн гэсэн хэл яриатай. Оросууд тун энгийн хүмүүс агаад цагаан цайвар царайтай, шаргал үстэй тул эр, эмгүй царайлаг байдаг. Орос оронд нэвтрэн ороход төвөгтэй нарийхан хоолой, хавцлаар хамгаалагдсан байдаг. Тэд биеэ даасан тусгаар улс боловч Баруун тартарын хаан Тохтад байн байн алба гувчуур төлөх агаад тэр алба татвар нь тийм ч нүсэр хүнд дарамттай байдаггүй. Энэ орон үргэлж арилжаа наймаа хийгээд байх баялаг эд агуурсгүй билээ. Гэвч орос оронд дэлхийд өөр хаана ч байхгүй үнэтэй, чанартай булга, суусар, хэрэм, үен болон хар үнэгний арьс тоогүй их мөн мөнгөний уурхай олонтой<sup>264</sup>. Орос орны талаар сонирхуулаад байх өөр сонин содон зүйл үгүй учир Хар тэнгисийн тухай яриандаа орьёо. Хар тэнгисийг тойрон орших муж нутаг, үндэстэн ястны тухай ярихын тулд яриагаа Константинопль хотоос эхэлье. Эхлээд та бүхэнд умар, баруун умар зүгийн хоорондох заагаар нутаглах Лак мужийн тухай өгүүлсүгэй.

Энэ муж Оростой хил залгаа орших агаад өөрийн хантай, оршин суугчид нь Загалмайтан болон Сарацин нар. Энд сайхан үслэг эд ихээр үйлдвэрлэж харь орны худалдаачдад зарж борлуулна. Хүмүүс нь худалдаа, үйлдвэр эрхлэн амьдарна. Өөрч нэг их сонирхуулаад байх зүйл үгүй дээ. Яриагаа цааш нь үргэлжлүүлэхийн өмнө Оросын тухай ярьж байхдаа мартаж орхисон нэгэн зүйлийг нэмж хэлье.

Орос орон нь дэлхийн бусад аль ч оронтой зүйрлэшгүй хүйтэн болдог нутаг бөгөөд хүмүүс нь арай ядан өвлийн хүйтнийг давна<sup>265</sup>. Яг үнэндээ бол баян, ядуу ялгаагагүй сайхан муухай нь хамаагүй дулаан галлагаатай байшинд сууцгаах агаад тийм байшингүй бол оршин суугчид нь толгой дараалан осгож үхэх болой. Орос оронд ийм дулаан байшин хаа сайгүй байх агаад тэдгээрийг Оросын баян чинээлэг хүмүүс бариулдаг бөгөөд манайхны эмнэлэг, асрамжийн газар барьдагтай л төстэй юм. Заримдаа хүйтний эрч онцгой чангарах агаад аян замд гарсан хүмүүс осгож үхэх бол энүүхэн энд. Тэр ч байтугай хоорондоо жархан алхам хоёр байшингийн нэгнээс нөгөөд орох хооронд осгож хөлдөх явдал хааяагүй тохиолдоно. Өвлийн хүйтэнд гэрээсээ гарсан хүмүүс осгож үхэхгүйн тулд, зорьсон газартаа очихын тулд нэг дулаан байшингаас нөгөөд дамжин орсоор яваад арай гэж зорьсон газартаа хүрнэ.

Тэд замд гарахдаа заавал хамтдаа гарч дулаан байшин бараадан явна. Хөнгөн нимгэн хувцасласан хүмүүс, хөгшин хөвөө хүмүүс, өлөн зэлмүүн яваа хүмүүс, ерөөсөө байгалиасаа тамир тэнхээ дутуу хагас заяасан хүмүүс осгож үхэх явдал байн байн тохиолдоно. Хэн нэгэн хүн осгож хөлдөж байвал бусад нь үтэр түргэн тусалж дулаан байранд оруулан хувцас өмсгөлийг нь тайлан сувилж хэвийн байдалд нь оруулан амь насыг нь аварна.

Дулаан байшинг хэрхэн барьдаг тухай өгүүлбэл: Тэдгээр байшин нь дөрвөлжин хэлбэртэй, бүдүүн бүдүүн гуалинг дээр дээр нь завсар гаргалгүй өрж барьсан байдаг. Гуалингуудын хоорондох завсар зайлхайг түүхий шохой болон бусад зүйлсээр салхи, хүйтэн нэвгэрхээргүй битүүлэн шавна. Дээвэрт нь галын утаа гарч байх нүхтэй байдаг. Тэдгээр байшинг үргэлж галлаж байхын тулд асар их түлээ бэлтгэн хураасан байх агаад хүмүүс дүрэлзэн асах галаа тойрон сууж дулаана.

Дүрэлзэн асаж байгаа түлээнээс гарах утааг гадагшлуулахын тулд дээврийнхээ нүхийг онгойлгоно. Харин түлээ шатаж гүйцээд цогшоод ирэх үед тэрхүү нүхээ зузаан тагаар битүүлэн хаачих агаад цогшиж улайдсан нүүрсний элч байшинг урт удаан хугацаанд дулаан

байлгана. Дээврээс доошлохоор зузаан зузаан самбараар таглан хаасан цонхтой байх бөгөөд салхигүй үед гэрэл гэгээ оруулахын тулд цонхны хаалт самбарыг нээнэ. Салхитай хүйтэнд бол дээврийнхээ нүхийг нээж гэрэл гэгээ оруулна. Байшинд орох хаалга нь бөх зузаан, завсаргүй нягт хаагддаг байна. Дулаан байшин гэж нэг иймэрхүү байх агаад хүн бүхэн өөрийнхөө хөрөнгө чинээний хэрээр янз бүрийн дулаан байшинтай байдаг билээ.

Тэдний бас нэгэн заншлын тухай өгүүлбэл: Тэд нар зөгийн балыг зөрөг цэцэгтэй хольж исгээд тун сайхан дарс хийх бөгөөд түүнийгээ мёд (mead)<sup>266</sup> гэж нэрлэх агаад маш ихээр ууцгаана. Оросууд хэсэг бүлгээрээ нийлэн бүлгэм байгуулна. Ялангуяа язгууртан, баян чинээлэг хүмүүс ийм бүлгэм олноор нь байгуулдаг бөгөөд бүлгэм бүрт гучаас тавин эрчүүд, бүсгүйчүүд, хүүхдүүд хамрагдана. Бүлгэм бүр өөрийнхөө ахлагчийг сонгож, өөрсдийн дотоодын дэг журмыг тогтооно. Бүлгэмийн дэг журмыг зөрчигсдийг торгож шийтгэнэ. Мөн тэрхүү мёд хэмээх дарсыг нөөцөлж хадгалдаг, зарж борлуулдаг мухлагаас бүлгэмийнхэн дарс худалдан авч өдөр өнжингөө ууж найрладаг. Тэд энэхүү архидалтаа стравица (stravitsa) гэж нэрлэнэ. Орой нь мухлагийн эзэн уусан дарсных нь тооцоог хийхдээ эхнэр, хүүхэдтэйгээ байсан бол хамтруулан тооцож хэн хичнээн дарс уусныг тооцон төлбөр авна. Оросууд энэхүү стравица (здравица. Орч) хэмээх архидалтаа хийхийн тулд Хазар, Судак болон бусад хөрш зэргэлдээх газар орноос ирсэн худалдаачдаас хүүхдээ барьцаалан байж мөнгө зээлж архидаад эцэст нь хүүхдээ мөнгөний барьцаанд өгдөг байна. Бүтэн өдөржин архидаж, идэж суусан эзэгтэй хатагтай нар хөдлөх тэнхээгүй болтлоо согтож мансуурдаг тул тэдний аягач, шивэгчид нь авч явж бие засуулах зэргээр асран тусалдаг байна. Нэгэн хачирхалтай явдал болсон тухай та бүхэнд ярьж өгье. Нэгэн эр авгайтайгаа ээлжит архидалтаасаа буцаж явтал авгай нь бие засаж идэж ууснаа юүлэхээр болжээ. Энэ үед хүйтэн гэдэг ёстой л яс янгинаж, голд ормоор хангинаж байжээ. Гэтэл бие засаж суусан авгайн үс мөстсөн ногоотой зууралдан хөлдөөд авгай нь босож хөдлөх сөгөөгүй орь дуу тавьж эхэлмэгц согтож дэн дун явсан эр нөхөр нь бүлээн амьсгалаараа наалдаж хөлдсөн мөсийг гэсгээх санаатай үлээж эхэлтэл хүйтэн агаарт цантсан сахал нь мөн тэр мөсөнд наалдан хөлджээ. Ингээд эхнэр нөхөр хоёулаа мөстэй наалдан хөлдөөд хөдлөх аргагүй болжээ. Тэр хоёрыг хөдөлгөхийн тулд зууралдаж хөлдсөн мөсийг хагалахаас нааш бүтэхээргүй болжээ.

Эндхийн хүмүүс мөнгөний оронд нарийхан цувимал, жижигхэн хэрчсэн алт хэрэглэх бөгөөд нэг тийм хэрчмийн ханш нь таван их су орчим болно. Бага сага арилжаанд бол суусрын толгойгоор тооцоо хийнэ. Орос орны асар уудам газар нутаг нь гадаад их далай хүртэл үргэлжилнэ. Тэр их далайн арал дээр цагаан шонхор, начин шонхор ихээр үржин өсдөг тул тэднийг барьж хорвоогийн өнцөг булан бүрт худалдана. Оросоос Норвеги ороход тун холгүй боловч хүйтэнд хавчигдаад явах аргагүй.

Одоо Орос орноос явж Хар тэнгисийн эрэг рүү зүглэе. Хар тэнгис орчмын газар нутаг, хүн ардын талаар ярина гэж би ч дээр амласан билээ. Хар тэнгис түүний орчин тойрныг мэдэх хүмүүс тоогүй олон боловч түүнийг огт үзээгүй, мэдэхгүй хүмүүс бас их олон тул тэр хүмүүст зориулан Хар тэнгис талаар бичиж, тэмдэглэж үлдээх нь зөв гэж бодном. Хар тэнгист орох хаалга болсон Константиноплийн хоолойгоос яриагаа эхэлье. Тэнгист орох хоолойн баруу гар талд Фаро хэмээх нэгэн уул бий. Энэ тухай яриагаа эхлэхийн өмнө Хар далайн тухай бичиж тэмдэглэж үлдээх үү, болих уу гэж эргэлзэх, тээнэгэлзэх зүйл их байсан, учир нь энэ газар нутгийг түм буман хүн сайн мэдэх билээ. Тийм учраас би ярианыхаа чиг

сэдвийг жаахан өөрчилж, үүний оронд Өрнө зүгийг эзлэн захирсан тартаруудын тухай ярьж өгье.

Өрнө зүгийг эзлэн захирсан тартаруудын анхны хаан нь маш хүчирхэг, их эзэн байсан бөгөөд түүнийг Сайн хаан хэмээдэг байв. Тэрхүү Сайн хаан Орос (Russia), Куман (Comania), Алан (Alania), Лак (Lac), Мэнжар (Menjar), Черкесс (Circassia), Гот (Gothia) болон Хазар (Khazaria) –уудыг байлдан дагуулж, эзлэн захирсан билээ. Эдгээр улс орнууд нь тартаруудад эзлэгдэхийнхээ өмнө Команчууд гэсэн нэгэн нэрийн дор нэгдсэн нэг том улс байсан. Гэвч эдгээр овог аймаг, муж орон хоорондоо эвлэрэн нэгдэж нэгэн цул болж чаддагүй байсан тул газар нутгаа алдаж хорвоогоор нэг цацагдан тархжээ. Харь холд зугтаж одолгүй үлдсэн нэг нь Сайн хааны албат боол болжээ. Сайн хааны удам угсаа залган суусан хаад гэвэл Бат (Batu), Бэрх (Барка), Мөнхтөмөр (Mongu-temur), Түдэмөнх (Tuda-mongu) болон одоогийн хаан Тохта (Toktai) нар болно. Одоо би та бүхэнд Өрнөд тартаруудын их эзэн Бэрх, Левантийн тартарын эзэн Хүлэг хоёрын хооронд болсон их тулалдааны тухай өгүүлсү. 1261 онд энэ хоёр эзэнт улсын хооронд хил хязгаарын, газар нутгийн өмчлөлөөс үүдэн маргаан тэмцэл үүссэн бөгөөд хэн нь ч хэндээ тэр газар нутгийг өгч маргааныг шийдвэрлэх хүсэл үнэндээ байсангүй. Энэ хоёр их эзэн харилцан бие биедээ дайн зарлан өөрсдийн дэмжигч бүх хүчнийг цуглуулсан тул урьд хожид үзэгдэж байгаагүй их зэвсэгт дайчид цугларан бөөгнөрчээ. Нэг нь нөгөөгөө ялан дийлэхийн тулд хөрөнгө мөнгө эд баялгийг хайр найргүй зарж, юуг ч эс хайрлан үрэн таран хийж байсан билээ. Дайн зарласнаас хойших зургаан сарын турш хоёр тал шуурхайлан бэлтгэж тус бүр өвч зэвсэглэсэн гучин түмэн (300000) морьтон дайчдыг цуглуулж чаджээ. Дайны бэлтгэлээ базааж гүйцсэний дараа Хүлэг хаан цэргээ аван хөдөлсөөр олон хоног аялж Төмөр хаалга болон Сарай<sup>267</sup> тэнгисийн хоорондох их талд иржээ. Хүлэг хаан урт удаан аяныхаа замд элдэв саад, тотгортой учралгүй явж иржээ. Асар үнэтэй асар майхан алагласан Хүлэг хааны цэргийн хуаран нь үнэнхүү баян чинээлэг эзэн буудаллажээ гэдгийг илтгэнэ. Энд хоёр эзэнт гүрний хилийн заагт ирээд Бэрх хаан цэрэг дайчидтайгаа хэзээ ирэхийг харуулдан хүлээнэ.

Одоо Бэрх хааныхны талаар өгүүлсү. Хүлэг хааны давшин ирж эзлэн буудалласан тэр хөндийд түүний хуарангаас арван бээр орчим зайд Бэрх хааны их цэрэг буудаллан хуарагнав. Бэрх хааны цэргийн хуаран Хүлэг хааныхаас юугаараа ч үл дутна. Харин Бэрх хааны цэргийн тоо нь Хүлэг хааныхаас илүү бөгөөд гучин түм тавин мянган морьтон дайчид цугларсан байв. Бэрх хааныхан хуарагнан бууж хоёр өдөр амсхийн амарцгаав. Гуравдахь өдөр нь хаан өөрийн шадар бараа бологсдыг дуудан чуулж ийн өгүүллрүүн: Эрхэм ноёд, анд нараа, Миний бие хаан ор суусан цагаасаа эдүгээ хүртэл та нарыг ямагт ахан дүүс, үр хүүхэд шигээ хайрлан халамжилж ирсэн, та нар дотроос олон олон ноёд надтай хамт олон том тулалдаанд орж бидний оршин суугаа газар нутгийн ихэнхийг байлдан эзэлсэн. Надад байгаа юм бүхэн ялгаагүй та бүхний юм гэдгийг ч та нар мэднэ. Өнөө болтол бид хэнд ч ялагдаагүй билээ. Та бидний энэ алдар нэрийг өндөрт өргөн явахын тулд хүн бүхэн зориг тэвчээрээ хөвчлөн тулалдахыг та нараас хүсэж байна. Одоо бидний өмнө мөн л хэнд ч ялагдаж үзээгүй эрэлхэг дайчин Хүлэг хаан ирчихээд газар нутгаас маань булаан авахаар хараа тулан зогсож байгаа шүү.

Үнэн бидний талд худал хуурмаг нь түүний талд байгаа учраас бид ялна. Үүнээс гадна Хүлэг хаан гучхан түмэн цэрэгтэй, харин бид бол гучин түм тавин мянган цэрэг дайчидтай тул

заавал ялна. Энэ сүрт тулааныг хийхийн тулд л бид энд ирсэн бидэнд өөр ямар ч зорилго үгүй. Би ганцхан ялалт хүсэж байна. Та бид хэнээс ч зүрхшээлгүй, өчүүхэн ч түдгэлзэлгүй давшин тулалдаж ялан дийлэх учиртай. Тэр өдөр гуравхан хоногийн дараа ирнэ. Хорвоо дэлхий гайхан биширтэл эрэлхэг зоригтой тулалдан алдар нэрээ мөнхлөх ёстойг би зүрх сэтгэлээрээ мэдэрч та бүхнээс эр зоригоо хөвчлөн тулалдахыг үнэн зүрхнээсээ гуйж байна” гэв.

“Ахан дүүсээ, анд нөхөд минь, Миний амьдарч ирсэн бүх замын туршид та нар надтай хамт байж намайг тэтгэн дэмжиж, надад тусалсаар ирсэн. Өнөөдрийн өдрийг хүртэлх бүх тулалдаанд бид ялсаар ирсэн. Харин одоо бид Бэрх хааны хүчирхэг цэрэгтэй нүүр тулахаар ирээд байна. Бэрх хааны цэрэг тоогоор биднээс илүү гэдгийг би мэдэж байгаа боловч зүрх алдан сэтгэлээр хямрахгүй байгаагийн учир бол түүний цэрэг та бидэн шиг ган мэт ширээгдэж, гал мэт дүрэлзэх хүмүүс биш билээ. Бэрх хаан гурав хоногийн дараа бидэн рүү халдан довтолж дайран ирэхээр зэхэж байгааг өөрийн заншлаачдаас сонслоо. Энэ бол сайн хэрэг. Үлдэж байгаа гурав хоногт хүн бүр байлдаанд сайн бэлтгэж яаж тулалдахыг заалгасан яг тэр дэгээр тулалдана шүү. Ялагдсанаас үхсэн нь дээр гэдгийг бид сайн ойлгож байгаа тул хэрхэвч ялагдаж болохгүй. Тэр өдөр хүн болгон ид хав, эр зоригоо үзүүлэн тулалдаж нэр сүрээ ч аварна, эсэргүүцэн тэмцэлдэх дайснаа ч дарна” гэв. Тус тусын цэрэг дайчдаа зоригжуулан уриалж хоёр хааны хэлсэн үг хоёр этгээдийг зөвхөн ялалт өөд дуудаж байв.

Тулалдахаар товлосон өдрийн өглөө эрт Хүлэг хаан өөрийн цэрэг дайчдаа эртлэн босгож тулалдаанд бэлдэхдээ ёстой л хал үзэж хашир суусан ухаалаг эрийн зангараг заан тус бүр түмэн морьтон дайчидтай гучин түмт болгон жагсаагаад түмт бүрийн тэргүүнд хамгийн шилдэг жанжидаа тавьжээ. Ингээд аажимхан хөдөлж хоёр этгээдийн хуарангийн голд орших өргөн хөндийн талыг эзлэн жагсав. Энэ үед Бэрх хаан ч өөрийн их цэргээ гучин таван түмт болгон засаж тохинуулаад угтан ирж байлдааны байраа эзлэв. Ингээд хоёр этгээд түр амсхийснээ бүр ойртон хоорондоо сумны хоёр тусгалын зайтай тулан зогсов. Тэдний тулгаран зогссон уудам хөндий үзэсгэлэнтэй сайхан төдийгүй анх удаагаа зургаан бум таван түмэн морьтон эрсийн үхлийн тулааны талбар болохоор анир чимээгүй дүнсийнэ.

Халз тулалдахаар зэхээд бие биенээ отон зогсох хоёр их хаан бол энэ хорвоогийн хамгийн хүчирхэг хаад байлаа. Тэр хоёр үеэл ахан дүүс төдийгүй эзэн Чингисийн алтан ургийн угсаа гарвальтай түүний ач хөвгүүд байсан юм. Ингээд хоёр их цэрэг сөргөлдөн зогсоод нэг урт амьсгал авах мэт түгдрэсхийн зогсмогц тулалдаанд орох бөмбөрийн дуун нижигнэж түүнтэй зэрэгцэн тэнгэр, нарыг халхлан бүрхсэн сум мөндөр бууж эхлэв. Аадрын дусал мэт зай завсаргүй исгэрэн ирэх суманд оногдон үхэдхийн унах болон шархадсан цэрэг, морьд дайны талбарыг бүрхэн хучих шиг санагдана. Харваачдын сум дуусах агшинд илдээ гялалзуулж, жадаа сэрэлзүүлэн хоёр этгээд үхэн тулалдах цавчилдаан эхлэв. Газар дэлхий улаан цусанд умбаж байх шиг болно. Энүүн шиг бум буман цэрэг дайчид агт морьд оролцсон, догшин хэрцгий тулалдаан энэ хорвоод өөр болж байгаагүй байхаа. Энэ тулалдаан өлзий бус цөвүүн цагт эхэлжээ. Хоёр этгээд хэн хэнийгээ заавал устгах учиртай өстөн дайсан гэж үзэн ядаж алалдана. Хүлэг хаан эрэмгий зоригтой, эрэлхэг дайчин эр гэдгээ жинхэнэ ёсоор харуулан хаан титэм магнайдаа асааж, эзэнт гүрнийг захиран удирддаг их хаан үнэнхээр ийм л байдаг байх гэмээр тулалдах нь бахтай. Түүний нөхөд хаанаа харж зоригжино. Түүний дайснууд хааныг харж зүрхшинэ. Хүлэг хаан тэнгэрийн аянга цахилгаан мэт цавчилдан тулалдах нь



жирийн нэгэн эр биш гэдгийг үзүүлнэ.

Дайны талбарт цавчилдах Бэрх хааны эр зориг, эрэлхэг дайчин цог золбоог хорвоо дэлхий харж ханашгүй ид хавтай байлаа. Гэвч Бэрх хааны эр зориг, ид хав, дайчдынх нь амь хайргүй тулалдах эрч хүч аль аль нь Бэрх хааныхныг ялагдлаас аварч чадсангүй. Нар гудайж бүрэнхий болохоос өмнө тэд нар тулалдааны талбарыг орхин хүлэгийн хурдаар зулбан зугатаацгаав. Үүнийг үзсэн Хүлэг хааныхан тэднийг араас нь хөөж намнан өршөөл энэрэлгүй цавчин алсаар байв. Энэхүү аллага үнэнхээр нүд хальтрам аймшигтай байлаа. Хүлэг хааныхан тэгс гээд аллагаа зогсоож хуарандаа буцацгаав.

Амь дүйсэн тулалдаанаас амьд эргэж ирсэн дайчид зэр зэвсгээ тайлан, шархаа боож, цусаа угааж, урагдаж навсайсан хувцас хунараа сольж амарч унтацгаав. Өглөө босоод Хүлэг хаан дайны талбарт унасан дайчдын шарилыг хүний өөрийн гэж ялгалгүй цуглуулан галдан хайлахыг зарлиг болгон ёсоор болгов. Үүний дараа Хүлэг хаан нутгийн зүг жолоо залахдаа олон мянган дайчин эрсийнхээ шарилыг энэхүү тулалдааны талбарт үлдээж буцав. Хэдийвээр Хүлэг хаан гайхам ялалт байгуулсан боловч ялалтын үнэ цэнэ нь дэндүү олон эрсийн амь насаар хэмжигдэж байлаа. Эсрэг дайсны талын хохирол бүр ч их байсан бөгөөд дайны талбарт амь насаа өргөсөн эрсийн тоог хэлэхэд үнэмших хүн гарахгүй байсан гэдэг. Одоо бид энэ дайны талаар яриагаа өндөрлөж Өрнөд тартаруудын хооронд болсон дайн тулааны тухай өгүүлье.

Энэ явдал өрнөд тартаруудын эзэн Мөнхтөмөр тэнгэрт хальж хааны титэм, төрийн эрх идэр залуу Тулабухад шилжин ирсэн эгзэгтэй тэр үед тохиожээ. Түдэмөнх гэгч эрх сүртэй тартар язгууртан тартарын өөр нэгэн хан Ногайтой эвсэн хуйвалдаж Тулабухыг алж, хаан ширээг эзэгнэн булааж өөрийгөө хаан өргөмжилжээ. Тун ч удалгүй Түдэмөнх үхэж өрнөд тартарын хаан эзний ширээ эрэлхэг, ухаалаг Тохтад шилжин очжээ. Энэ хугацаанд Тулабухын хоёр хүү өсөж өндийн эрийн цээнд хүрчээ. Энэ хоёр хүү эрэмгий зоригтой, эрч хүчтэй, ухаалаг эрс болон өсөж өндийгөөд өөрсдийнхөө анд нөхдийг дагуулан Тохтагийн өргөө ордонд очжээ. Тэр хоёр Тохта хаанд өвдөг сөхрөн ёслон мэндчилэхэд хаан тэдэнтэй хариу мэндлэн босоцгоо гэв. Ингээд хоёр хүүгийн ахмад нь хаанд хандан: “Эрхэм дээд эзэн Тохта хаан минь, бидний таныг зорьж ирсэн хэрэг зориг бол Түдэмөнх, Ногай хоёроос тэдэнд алагдсан эцгийнхээ өшөөг авах явдал билээ. Бид хоёр бол Тулабухын хөвгүүд гэдгийг хаан эзэн та юу эс андах билээ. Түдэмөнх нэгэнт үхсэн болохоор түүнтэй ял хэлэлцэх аргагүй болжээ, харин Ногайгаас бид өшөө авч хорслоо тайлах учиртай тул Хаан эзэн та түүнийг ордондоо авчирч ял асуун бидний эцгийг хороосон өшөө хорсолыг авч өгнө үү гэгцгээв.”

Үүнийг сонссон Тохта хаан хөвгүүдэд ийн өгүүлрүүн: “Та хоёрын ярьж байгаа зүйл чин үнэн тул би Ногайг ордонд дуудуулан ял хэлэлцсүгэй” гэв. Тохта хаан хоёр элч зарж Ногайд ийн хэлүүлэв: “Ногай чи хааны зарлигийн дагуу хааны ордонд ирж Тулабухын хөвгүүдийн өмнө тэдний эцгийг хэрхэн алж хороосон ялаа хүлээх учиртай тул би чамайг хаан ордонд үтэр түргэн ирэхийг зарлиг болон дуудуулж байна” гэжээ. Гэвч Ногай хааны зарлигийг үл тоомсорлон элэг доог болгож ордонд эс ирэв. Элч нар эргэн ирж Тохта хаанд түүний илгээлтийг Ногай хэрхэн хүлээн авч, яаж доог тохуу болгосныг нэгд нэгэнгүй айлтгахад, хаан ихэд хилэгнэн: “Бурхан тэнгэр минь намайгаа өршөөн тэтгэж хайрла, Ногай ялаа хүлээхээр хаан ордонд заавал ирэх учиртай, эс ирвэл би бүх цэргээ хөдөлгөн түүнээс ял асууж

устгасугай” гэж эргэн тойрондоо тодхон сонсогдохоор хашгирч билээ.

Тохта хаан дахин хоёр элчийг үтэр түргэн Ногайд илгээв. Тэр хоёр элч Ногайн ордонд очиж Тохта хааны зарлигийг дамжуулан ийн өгүүллрүүн: “Та хаан эзний ордонд хүрэлцэн очиж ялаа хүлээхгүй аваас хаан эзэн бүх цэргээ дайчлан танаас ял асуухаар ирнэ” гэв. Ногай үүнийг сонсоод хариу болгон өгүүлсэн нь: “Эрхэм элч нар минь одоо буцагтун. Хаан эзэндээ очоод миний хэлснийг дамжуул гээд, надад хор хохирол учруулж болохуйц хэнтэй ч болов учрахдаа би бага зэрэг эмээдэг. Хэрэв над руу довтлон ирэхээр зэхэж буй болвоос би хүлээж суулгүй угтан тосож байлдана” гээд энэ миний өгөх хариу өөр хэлэх зүйл үгүй гэв. Ийм хариу аваад элч нар Тохта хаандаа буцаж ирэв.

Ийм хариу авсан Тохта хаан дайтахаас өөр зам үлдээгүйг ойлгож өөрийн харьяат, хараат ноёд дээдэст элч илгээн цэрэг дайчдаа цуглуулан бэлтгэж Ногай хаантай дайтах тулалдаанд хамтран оролцох зарлиг буулган тушаажээ. Олон үг нуршаад яахав, Тохта хаан ойр мөддөө хэн ч цуглуулж байгаагүй тийм их цэрэг дайчид цуглуужээ. Ногай Тохта хаан өөрийг нь дайлахаар асар их хүч хуримтлуулсныг мэдэж байснаар барахгүй өөрөө ч мөн чамгүй их хүч хуримтлуулжээ. Гэвч цэрэг дайчдынхаа тоогоор Тохта хааныг гүйцэхгүй байсан шалтгаан бол Ногайн цэрэг дайчид ерөөсөө цөөвтөр байжээ.

Цэрэг дайны бэлтгэлээ базааж дууссан Тохта хаан хорин түмэн (200000) цэрэг эрсээ захиран довголгосоор Нэрги268 хэмээх нэгэн их талд ирж хуарагнан Ногайг хүлээхээр шийджээ. Тохта хаан маш охорхон хугацаанд тулалдах газартаа ирж амжсан төдийгүй Тулабухын хоёр хүү өөрсдийн дайчин нөхдийн хамт эцгийнхээ өшөөг нэхэхээр мөн иржээ. Тэр үед Ногай ч мөн өөрийнхөө арван таван түмэн (150000) цэрэг эрстэй угтан ирэв. Ногайн цэрэг дайчид нь дайн тулаанд үнэнхүү шалгарсан баатар эрс билээ. Тохта хаан Нэргийн талд ирснээс хойш хоёр хоногийн дараа Ногай их цэрэгтэйгээ ирж хааны хуарангаас арван бээрийн зайтай газар хуарагнан буув. Түүний хуаран нь алтан саатай хоргой торгон асар майхантай үнэнхүү баян чинээлэг хааны тансаг хуаран буудалласныг илчилнэ. Тохта хааны цэргийн хуаран бүр ч илүү тансаг баян цацар орд, асар майхнаар эрээлэн алаглаж хоёр этгээд их тулааны өмнө түр амсхийж буй нь энэ билээ.

Тохта хаан цэрэг дайчид, ноёд дээдсээ цуглуулан тэдэнд хандан ийн өгүүлэв: “Ноёдоо бид энд Ногай хантай тулалдан ял асуухаар ирсэн билээ. Энэ өшөө хорсол, ял асуух нэхэл нь Ногай хаан эзнийхээ хоёр удаагийн зарлиг тушаалыг үл харгалзан ял зэмээ хүлээхээр ирээгүйгээр барахгүй та биднийг тоглоом тохуугаар доромжилсон билээ. Ногай бол Тулабухын амийг хөнөөсөн хоёр ялтны нэг, тийм учраас хоёр хүү нь эцгийнхээ өшөөг авахаар бидэнтэй хамт энд ирээд байна. Тийм учраас бид энэ дайнд заавал ялах учиртай. Та бүхнийг чин сэтгэлээсээ өшлөө өшиж тулалдахыг сануулж байгаа бөгөөд тэгж чадваас бид ялна” гэв.

Мөн энэ цаг үед Ногай өөрийнхөө цэрэг дайчдад хандан ийн өгүүллрүүн: “Ахан дүүсээ, анд нөхөд минь, Та бид үүний өмнө олон олон хатуу ширүүн тулалдаан ялж ирснийг надаар хэлүүлэлтгүй мэдэх билээ. Тэгэхэд бид эднээс хавьгүй илүү эрэлхэг баатарлаг эрстэй тулалдаж байснаа санагтун. Тохта миний эзэн биш мөртлөө намайг хаан эзний орд өргөөнд бусдын амаар будаа идэн дуудсан тул би очоогүй билээ. Одоо би та нараас хүн бүхэн үнэн хэргийн төлөө хичээн зүтгэж, эр зоригоо дайчлан тулалдахыг хүсэж байна. Бидний тухай хорвоо ертөнц, хойч үе маань дурсан ярих болно” гэв.

Хаан хан хоёрын үг хэлсний маргааш өглөө хоёр этгээдийн их цэрэг тулалдаанд орохоор аль хэдийн дадал заншил болсон эгнээ жагсаалаа жигдлэн бөмбөрийн дуу хүлээцгээв. Тохта хаан хорин түмтээ эгнүүлэн, Ногай хан арван таван түмтээ жагсаан бие биенээ отон урагшлав. Харваачдын мэргэн суманд оногдсон үй олон морь цэрэг үхэдхийн унаж, түүнээс ч олон нь үхлийн шарх авцгаав. Сумаа дуустал харвалцсаны эцэст сэлэм жадаа зөрөлдүүлэн үхлийн цавчилдаанд орцгоов. Хүмүүсийн хашгираан орилоон, ёолох дуу тэнгэрт хадаж аянга ниргэвч сонсдохооргүй чимээ шуугиан дэгдэв. Алагдсан шархадсан хүмүүсийн тоо урьд хожид сонсогдож байгаагүй олон болов. Тэдний ихэнх нь Тохта хааны цэрэг дайчид байлаа. Тулабухын хоёр хүү гайхам эр зоригтойгоор тулалдан байлдавч Ногайд дөхөж чадахгүй байв. Энэ тулалдааны талбарт үй олон эрс эрсдэн үхэж, мянга мянган эмс охид бэлэвсрэн хоцорч байлаа. Ийм аймшигт тулалдаанаас өөр юуг ч хүлээх билээ дээ. Тохта хааны эрч хүч, эрэлхэг зориг, ид хавыг тогтоон барих дайсан үгүй мэт байв. Тохта хаан дайсны бөөн дунд дайран орж баруун зүүнгүй цавчин үхэл тарьж байлаа. Хааныхаа эрэлхэг дайчинд урамшсан нөхөд нь үхлээс үл дальдран дайран орцгоож алтан амиа өргөсөөр байв. Дайсан руу дайран ороход нь үхэл түүнээс зугтааж байх мэт санагдана. Ногай хан ч эр зориг, илд мэсийн ид хавыг үзүүлж байлаа. Тэр өдрийн тулалдаанд Ногай хан шиг үхэл тээсэн дайчин өөр байгаагүй гэхэд хилсдэхгүй билээ. Ногай зээрийн сүрэгт халдсан арслан мэт авирлан замдаа тохиолдсон бүхнийг тасар цавчин алж байгааг харсан цэрэг дайчид нь улам ч урамшин зоригжиж эсрэг этгээддээ нөхөж бархааргүй хор хохирол авчирч байв.

Нуршуу сунжруу яриагаа товчлон өгүүлэхэд тэр өдрийн тулалдаанд Тохта хааныхан баргийн хүнд хэтийдсэн их тулааныг баатарлагаар хийсэн боловч ялан дийлэх учиргүй байжээ. Энэ тулалдааныг зогсолтгүй үргэлжлүүлбэл амьд хүн үлдэхгүй гэдэг нь нэгэнт тодорхой болмогц Тохта хааныхан тулалдааны талбарыг орхин зугтаж амь гарахаар тэмцэцгээв. Ногай ханыхан зугтаж байгаа цэрэг дайчдын араас очиж хайр найргүй алсаар авай. Ингэж энэ дайнд Ногай ханыхан ялжээ. Энэ тулаанд багаар бодоход зургаан түмэн цэрэг эрс амиа алдаж, ясаа тавьсан байлаа. Харин хаан Тохта болон Тулабухын хөвгүүд<sup>269</sup> амь мэнд гарчээ.

Тохта хаан энэхүү тулалдаанд дайчилж болох бүх хүчээ нэгтгэн цуглуулалгүй тухайн үед байсан цэрэг дайчдын хүчээр Ногайг ялна гэж бодож тооцсон нь алдаа байжээ. Хэдийвээр Ногайн цэрэг дайчид толгой тоогоор цөөн байсан боловч байлдах ур чадвараараа Тохта хааныхнаас хавьгүй илүү байжээ. Тохта хаан хэсэг хугацааны дараа өөрийн бүх хүчээ төвлөрүүлэн Ногайтай дахин байлдаж ялаад Ногай болон түүний эрэлхэг зоригтой дайчин баатар дөрвөн хүүгийн нь хамтаар дайны талбарт алж устган Тулабухын зангидсан өшөө хорслыг авсан гэдэг.

## Төгсгөл үг

Та бүхэнд харь холын Тартар болон Сарацин нарын тухай, тэдний зан заншил, ёс уламжлалын тухай, мөн энэ хорвоогийн бусад олон газар нутаг, улс орны тухай мэдэх бүхнээ өөрийн үзэж харсан, судалж мэдсэн бодит баримтдаа тулгуурлан өгүүлэв. Харин Хар тэнгис болон түүний эрэг орчин, далайг тойрсон газар нутаг, улс орны тухай ярихаа болихоор шийдсэний учир бол тэр орчмыг бид бараг өдөр бүр дайрч, туулж гардаг төдийгүй өөрийнхөө нутаг орноос ч дутуугүй сайн мэдэх тул тэр тухай ярих нь надад төвөгтэй, та нарт уйтгартай илүү яриа болох юм гэж бодов.

Венецийнхэн, Генуягийнхан, Пизагийнхан болон бусад улс орны аянчид, худалдаачид өдөр болгон Хар далайгаар нааш цааш хөвөн таван хуруу шигээ мэдэх болсон тул энэ талаар юм ярихаа болихоор шийдлээ. Энэхүү номын оршил хэсэгт Их хаан биднийг явуулах дургүй байсан тухай, Их хаантай хэрхэн салах ёс үйлдэн холын аянд гарсан тухай, эх нутгаа зорин гарахад тус болсон азтай учралын тухай, Эрхэмсэг Маффео, эрхэмсэг Никколо болон түүний хүү эрхэмсэг Марко нар нутаг буцах аян замдаа хэрхэн гарсан тухай өгүүлсэн билээ.


Өдрийн бодол, шөнийн зүүд болон өр зүрхийг маань өвтгөн шаналгах өвчин болтол санаж мөрөөдсөн эх нутагтаа хэзээч эргэн ирэхгүй байх тийм магадлал хамгийн өндөр байсан. Гэвч бид гурав эргэж ирлээ. Энэ бол Бурханаас бид гуравт илгээсэн цорын ганц боломж байсан төдийгүй, Бурхан биднийг эх нутаг, газар шороонд маань эргүүлэн авчирсан азтай тавилан гэж боддог. Мөн бид нарыг хүмүүст хорвоо дэлхийн сонин, гайхамшиг бүхнийг ярьж таниулаг гэсэн нь Бурханы санаа бодол байсан гэдэгт огтхон ч эргэлздэггүй.

Хорвоогийн дайдын ихэнхийг өөрийн биеэрээ туулж, нүдээрээ харсан Венеци хотын алдарт иргэн эрхэмсэг Никколо Пологийн хүү эрхэмсэг Марко шиг хүн энэ дэлхийн Загалмайтан, Сарацин, Тартар болон Буруу номтон (Pagan)-ы дунд өөр ганц ч байхгүй билээ.

БУРХАНД ТАЛАРХЪЯ.

АМИНЬ АМИНЬ

# МОНГОЛ ХААДЫН УДАМ ГАРВАЛИЙН ХҮСНЭГТ



И - Ик Хово

Л - Лавлантын жилин

Т - Турканын Хан Цэцэгээн улэс

А - Алтын оргын жилин



ФРАНЦ, ГЕРМАН, АРЖАНТИЙН, УНГАР, ОРОС, БУЛГАР, ТУРК, АРМЕНИ, ИХ АРМЕНИ, ИХ ДЕЛ, АРАЛ ТЭГЭГИС, ЯРКЕНГ, АКРА, ТЭБРИЗ, РАК, БАГДАД, ПЕРС, ХОТМУЗ, ХАКРАН КӨС, КАЛКАН, АРАЛ ТЭГЭГИС, ШИВАРДАН, БАЛХ, ТАЛИХАН, ХЕРАТ, БАГАШМОН ПАШАЙ, ПАШЫР, ВАХАН, КАШМИР, ЛАХОР, ИХ ДЕЛ, КИМБАН, СОМНАМ, ГУШАРАТ, ТАНА, ГОЛКОНДА, МОНУПАЛ, МЛАВЕР, ТОЛАС, ХОЛА, КУШОН, КОЛОРИЯ, ЦЕЙЛОН, АРАЛ ТЭГЭГИС, АББАССИН (ДУНДАВ ЭНЭТХЭГ), СОКОТРА, МАГАДИШ, ЭНН, ЖАНЖИВАР, МАДАГАСКАР, КАИР (ВАВИЛОН), ИЕРУСАЛИМ, БАГА АРМЕНИ, АРАЛ ТЭГЭГИС, ТАНА, ГЕРМАН, ФРАНЦ, АРЖАНТИЙН, УНГАР, ОРОС, БУЛГАР, ТУРК, АРМЕНИ, ИХ АРМЕНИ, ИХ ДЕЛ, АРАЛ ТЭГЭГИС, ЯРКЕНГ, АКРА, ТЭБРИЗ, РАК, БАГДАД, ПЕРС, ХОТМУЗ, ХАКРАН КӨС, КАЛКАН, АРАЛ ТЭГЭГИС, ШИВАРДАН, БАЛХ, ТАЛИХАН, ХЕРАТ, БАГАШМОН ПАШАЙ, ПАШЫР, ВАХАН, КАШМИР, ЛАХОР, ИХ ДЕЛ, КИМБАН, СОМНАМ, ГУШАРАТ, ТАНА, ГОЛКОНДА, МОНУПАЛ, МЛАВЕР, ТОЛАС, ХОЛА, КУШОН, КОЛОРИЯ, ЦЕЙЛОН, АРАЛ ТЭГЭГИС, АББАССИН (ДУНДАВ ЭНЭТХЭГ), СОКОТРА, МАГАДИШ, ЭНН, ЖАНЖИВАР, МАДАГАСКАР, КАИР (ВАВИЛОН), ИЕРУСАЛИМ, БАГА АРМЕНИ, АРАЛ ТЭГЭГИС.









## Товъёг

Киуук (Күюк), 25  
Manzi, 121, 124  
Абага, 31, 218, 219, 222, 224  
Абакан, 169  
Абиссини, 206, 207  
Абушка, 33  
Адамын хөшөө, 191  
Аден, 193, 197, 206, 208, 209  
Ажул, 141  
Айярук, 216  
Акра, 9, 13, 29, 30, 209  
Аламут, 17  
Алаодин, 55  
Александрийн усан боомт, 163  
Алс дорнод, 14  
Амласан газар, 38  
Андаман, 177  
Араб, 9, 20, 195, 208  
Арал далай, 9  
Аргон, 80  
Аргун, 33, 34, 35, 78, 127, 165, 218, 219, 220, 221, 222, 223, 224  
Аргун хан, 33  
Артур хаан, 16  
Африк тив, 9  
Ахмад, 98, 99, 100, 101, 218, 219, 220, 221, 222, 223  
Аяас, 29, 30, 31, 38  
Бага Армени, 38  
Бага Ява, 174  
Багдад, 9, 14, 41, 42, 43, 46, 202  
Багдадын Массуди, 9  
Бадахшан, 60  
Балх, 59  
Барак (Барах), 12, 27  
Барка (Бэрх), 12  
Баруун талын эзэмшил (Алтан ордны улс), 10  
Басман, 175  
Баян жанжин, 144, 150, 157  
Баян Чинсан, 144  
Бенгал, 2, 119, 135, 137  
Бенжамин, 9  
Бирма, 3, 8, 14, 129  
Болдуйн, 26

Бөө мөргөлтөн, 19  
Буга ноён, 222  
Булаган (Булган), 33  
Булгар, 27  
Бундукдари, 31  
Бухара, 12, 27  
Бэрх, 3, 8, 10, 11, 12, 14, 15, 17, 20, 23, 25, 27, 28, 31, 32, 33, 38, 40, 42, 43, 45, 47, 48, 49, 50, 52, 56, 57, 64, 72, 83, 86, 89, 93, 95, 98, 99, 100, 109, 116, 121, 122, 123, 132, 133, 134, 135, 145, 149, 153, 155, 157, 160, 165, 168, 170, 172, 173, 176, 182, 183, 188, 189, 192, 193, 195, 196, 199, 206, 207, 209, 213, 215, 216, 217, 219, 223, 227, 228, 230, 232, 233, 234  
Бэрх хаан, 12, 27, 228, 229  
Бээжин, 12, 14  
Бярман, 190  
Венеци, 3, 11, 16, 22, 26, 29, 36, 38, 188, 234  
Винчестерийн хамба, 11  
Виченцийн Николас, 30  
Вонсамчин, 169  
Газан, 34, 35, 223, 224  
Газан (Хасан), 34  
Газан хаан, 34, 35  
Гахайт, 34, 35, 223  
Генуя, 9, 21, 22, 26, 38  
Гильом де Рубрук, 11  
Грегорий, 13, 30  
Гужарат, 189, 197  
Гүрж, 39, 40, 46  
Гүюг, 25, 74  
Гэрэгэ, 91  
Давид Малик, 39  
Дайду хот, 96  
Дамаска, 56  
Дарий, 54, 59  
Диливар, 51  
дөрөвдүгээр Александр, 11  
Дундад Ази, 9  
Европ, 8, 10  
Евфрат, 40  
Жиамбаттиста Рамусио, 15  
Жүүд, 9, 19, 89, 90  
Загалмайн шашин, 3, 13, 90  
Зайтон, 163, 169, 171, 172, 173  
Занзибар, 203, 204, 205  
Иерусалим, 29, 30, 206  
Ижил мөрөн, 12, 40  
Ирак, 46

Ирланд, 3, 6, 22  
Истанбул, 25  
Их Армени, 26, 39  
Их хаан, 12, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 68, 69, 74, 78, 81, 82, 86, 87, 88, 89, 91, 92, 93, 95, 96, 97, 98, 99, 100, 101, 103, 104, 105, 106, 107, 108, 109, 110, 111, 112, 113, 114, 115, 116, 118, 121, 127, 128, 131, 133, 134, 135, 140, 141, 144, 147, 151, 153, 163, 168, 170, 172, 173, 193, 204, 213, 214, 215, 234  
Кайхагу (Гахайт), 34  
Каракорум, 14  
Караунас, 51  
Католисус, 41  
Катэй, 2, 42, 58, 79, 80, 87, 93, 96, 97, 98, 99, 101, 120, 121, 123, 124, 133, 140, 141, 142, 143, 144, 156, 164, 170, 174, 213  
Кашмир, 51, 62  
Кидан, 10  
Кинсай (Ханьжоу), 15  
Кинсай хот, 155, 158  
Китай, 10  
Клемент, 13, 29  
Когатал, 28  
Кожа, 33, 34  
Кокачин (Хөхчин), 33  
Коморин, 195  
Константинополь, 9  
Кончи хан, 224  
Космас, 8  
Кубилай (Хубилай), 12  
Курдистан, 48  
Кэрайт (Хэрэйд), 20  
Л. Ф. Бенедетто, 16  
Лал, 49, 101, 103, 207  
Левант (Ил хаадын улс), 10, 27  
Линжу(Linju). Линжу(Linju)  
Литан Сангон, 141  
Лобын цөл, 66  
Маабар, 180, 181, 188, 204, 206  
Магомет, 90  
Мадагаскар, 203, 204  
Македоний Александр, 8, 40  
Малабар, 197  
Малабарын эрэг, 8  
Мандалай хаан, 124  
Мануэль Комрофф. See,  
МАРКО ПОЛО, 3, 10, 14, 16, 17, 18, 25, 26, 28, 32, 34, 48, 51, 146, 147, 148, 151, 153, 158, 162, 164, 165, 172, 175, 184, 185, 191, 195, 197, 203

Маффео Поло, 11, 26  
Мацгийн өдөр, 90, 109  
Мин улс, 15  
Мисир, 106, 160  
Мойсей, 90  
Монгол, 10, 11, 14, 20, 21, 25, 32, 34, 35, 86, 93, 95, 96, 156  
Монголчууд, 10, 71, 116  
Монголын эзэнт гүрэн, 14, 15  
Монготай, 141  
Мосулын хаант улс, 41  
Мөнх, 25, 35, 68, 69, 74, 91, 118, 126  
Мулехэт, 55  
Мэтью Парис, 10  
Наварра, 9  
Наян, 86, 87, 88, 89, 91, 128, 129  
Нестор, 19, 20, 30, 41, 45, 46, 64, 79, 123, 129, 147  
Нигудар, 51  
Никколо Поло, 26  
Ноагийн үхэгт-онгоц, 39  
Ногай, 23, 231, 232, 233  
Норвеги, 228  
Нубии, 189  
Одорик ламтан, 15  
Орос, 226, 227, 228  
Памир, 63  
Памирийн уулс, 18  
Пашай, 51  
Перс, 26, 40, 46, 48, 49, 59  
Пиза, 3, 9, 16, 26, 38  
Порденоны Одорик, 14  
Престэр Жон, 20  
Профессор Бенедетто, 23  
Профессор Моули, 23  
Пьяченцийн Тедалдо, 29  
Ром, 41, 70  
Ромын Пап, 10, 11, 13, 20, 28, 29, 30, 34, 90, 202  
Ромын Пап лам, 11, 29, 30, 90  
Рудбар, 50  
Руемедан Ахмад, 52, 53  
Рустичелло, 16, 22, 26  
Сайн хаан, 228  
Саламандра, 69  
Самарканд, 14, 215  
Сарай, 27, 228  
Сарацин, 43, 50, 55, 60, 62, 73, 74, 89, 90, 98, 100, 117, 162, 174, 178, 183, 188, 199, 219, 226,

234  
Сирии, 9  
Сокотра арал, 201  
Судак, 12, 27, 227  
Сулхарнай, 8, 40, 54, 59, 61  
Суматра, 34, 176, 177  
Тангуд, 70, 71, 79  
Тартар, 19, 26, 38, 49, 77, 88, 133, 134, 234  
Тартарус, 11  
Тагар, 11  
Тебриз, 46  
Тедалдо Висконти, 13  
Теофилактус Симокатта, 8  
Тигрис, 27  
Тогорул (Тоорил), 20  
Томас, 188, 189, 206  
Тохта, 230, 231, 232, 233  
Төвд, 83, 126, 127  
Төмөр, 40, 93, 95, 228  
Трансоксиана (Цагаадайн хаант улс), 10  
Трапезунд, 36  
Туркестан, 211, 213  
Туркестаны хан Барак, 12  
Түдэла, 9  
Түдэмөнх, 230  
Түрэг, 10, 25, 67, 69, 123, 129, 146  
Уильям, 13, 30  
Улатай, 33  
Фландри, 9  
Франц, 34  
Францискан шүтлэгтэн, 11  
Хайду хан, 64, 87, 89  
Халиф, 41, 42, 43, 45  
Хами, 68  
Хан-балык (Бээжин), 12  
Хар далай, 29, 40, 228  
Хармөрөн, 146  
Хархорин, 14, 71, 78, 214  
хишигтэн, 100, 101, 104, 105  
Хонгирад, 92  
Хормуз, 46, 52, 193, 209, 211  
Хотон, 65  
Хөхчин хатан, 35  
Христ бурхан, 36, 56, 144  
Хубилай хаан, 2, 35, 74, 81, 84, 86, 87, 89, 91, 125, 131, 153, 160, 172, 173, 178, 193

Хулагу (Хүлэг), 12  
хунтайж Жорж, 20  
Хүлэг, 12, 27, 42, 56, 74, 224, 228, 229, 230  
Хүлэг хаан, 27, 43, 56, 228, 229, 230  
Хятад, 3, 9, 10, 12, 15, 17, 41, 77, 117, 171  
Хятадын тэнгис, 171  
Цаасан мөнгө, 109, 110, 111  
Цагаадай, 51, 213  
Цейлон, 9, 178, 180, 191, 193  
Чингис, 10, 20, 72, 73, 74, 82, 213, 224  
Шакъяамуни Бурхан, 90, 193  
Шанду, 82, 99, 113  
эллин (герэг), 39  
Энэтхэг, 2, 3, 9, 10, 26, 33, 41, 42, 46, 48, 51, 62, 97, 130, 131, 152, 156, 161, 163, 164, 165, 166,  
168, 171, 175, 178, 180, 185, 190, 193, 194, 195, 196, 198, 199, 205, 206, 208, 209, 210  
Ява, 8, 21, 34, 174, 177, 195  
Якобит, 41, 46  
Япон, 8  
Японы арал, 168  
Ярмутын зах, 10

## Тайлбар

- 1 “Dark age” буюу Түүхийн харанхуй үе гэж нэрлэдэг
- 2 Монголын Эзэнт гүрэн (XIII зуун)
- 3 Ариун газрын (Иерусалим) төлөө Загалмайтны аян дайнууд (XII зуун)
- 4 XIII-XIV зуунд Английн П.Мэтью ламын “Түүхийн товчоон” (Chronica Majora) номын зураг ба франц зургууд үлджээ.
- 5 [http://en.wikipedia.org/wiki/History\\_of\\_geography#Medieval\\_Europe](http://en.wikipedia.org/wiki/History_of_geography#Medieval_Europe)
- 6 МЭ 46 онд Хүннүгийн газрын зургийг Хан улсын эзэн хаанд нууцаар явуулсан тухай “Хожуу Хан улсын түүх”-д өгүүлсэн ба 1179 онд Кидан нар өөрийн улсын бүрэн газрын зураг бүтээсэн нь “Ки-дань-го-цзи” түүхэн сурвалжид үлдэж эдүгээ судалгаанд оржээ. Мөн Юань гүрний газрын зургийн цөөнгүй мэдээ байх ба гол баримт нь 1368 онд ордноос гарсан хоёр зурагт үндэслэсэн эдүгээ Японы Нагасакид хадгалагдаж буй “...нэгдсэн газрын зураг” зэрэг болно.
- 7 Laurence Bergreen “Marco Polo: From Venice to Xanadu” (2007. New York)
- 8 XIV-XV заагаар Европын иргэншилд тахал, улс төр, эдийн засгийн хямрал, өлсгөлөн, дайн, шашны уналт зэрэг хүнд цаг тулгарчээ. Энэ үеийг “little ice age” гэдэг.
- 9 “World history: The human odyssey”(J.J. Spielvogel. 2008. х.485 ) номонд ийн өгүүлжээ.
- 10 1375 онд зохиогдов.
- 11 Маркогийн номын хуудсууд дээр Х. Колумб өөрийн гараар бичсэн тэмдэглэлүүд үлджээ. 1492 онд тэрбээр Их хааны нутаг Кятай орох зорилготой далайн аялалд гарчээ. Тэр үеийн худалдаачид, аялагчдын гол гарын авлага Марко Поло болон тархжээ.
- 12 Италийн Венеци дэх үнэт үзмэр. Фра Мауро гэгч 1450 онд гүйцээжээ. Монгол газар усны нэрүүд олон орныг тухайн үеийн Эзэнт гүрний соёлын нөлөө гэж тэмдэглэжээ
- 13 Quoted in J.H. Parry, The age of Reconnaissance: Discovery, Exploration and Settlement, 1450-1650(New York, 1963), номын 113 хуудас.
- 14 Мөн номын мөн хуудсанд
- 15 [http://en.wikibooks.org/wiki/World\\_History/Age\\_of\\_Discovery\\_%26\\_Imperialism](http://en.wikibooks.org/wiki/World_History/Age_of_Discovery_%26_Imperialism)
- 16 Евроазийн эх газар, Сахалин арлын хоорондох тэнгисийн хоолой (Япон тэнгист). Францийн газарзүйч Лаферузо XVIII зуунд анх нээжээ.
- 17 Энэхүү орчуулга номын Есдүгээр бүлгийн эхлэл хэсэг
- 18 John Man “Kublai Khan” (2006. Bantam books)
- 19 Laurence Bergreen “Marco Polo: From Venice to Xanadu” (2007. New York)
- 20 John Man “Kublai Khan” (2006. Bantam books. 365 н.)
- 21 Бүхнийг сайтар тоочилттой бичсэн нь Марког насан туршид дагаж амьдарсан түүний татар боолтой (монгол) холбоотой байж магад гэдэг. Насан өөд болохдоо тэр монгол зарцаа чөлөөлж явуулжээ.
- 22 П. Карпини, В. Рубрук, А.Лонжуми, Б.Поллак нарын тэмдэглэлийг хэлж байна
- 23 X зуунаас хойш (Кидан, Алтан улсын үе) Марко Полог хүртэл 260 гаруй жилийн турш “Цагаан хэрэм”-ийн хуучин байгууламжийг засаж сэлбээгүй хуучран доройтсон байжээ. Хэрмийн ихэнх нь бага овортой, морин цэргийн саад маягтай байсан. 1368 оноос Мин улс 2500 гаруй км урт буюу өнөөгийн хэрмийн 90 гаруй хувийг барьж, сэргээн засжээ.
- 24 Монгол, Хятад хоёр нь Юань гүрнээс хойш харьцангуй хаагдмал орчин байсаар одоо л нээлттэй болж байгаа билээ.



- 25 Япон болон Азийн барууд, Хятадын өсөлт нь Өрнийг дагасан Азийн сэргэлтийн түүх юм
- 26 Олон бурхан шүтэгч Эртний Грек, Ром, Египетийг ч “Онго шүтлэгтэн”-д оруулдаг байжээ.
- 27 Дундад эртний Монголын эзэнт гүрний тухай гол эх сурвалжууд (гар бичмэлүүд) нь түүхэн бичлэгийг дэлхийн хэмжээний өргөн цараатай болгосон анхны өвүүдэд тооцогддог болжээ. Газар дэлхийн түүхэнд урьд байгаагүй бичлэгүүд чухамдаа Монголчуудын тухай буюу Монгол хаадын ивээл дор бүтээгдсэн байдаг. Энэхүү үнэ цэнэтэй сурвалжуудыг Монголын нууц товчоо (1240, Монгол), Плато де Карпини (*Ystoria Mongalorum quos nos Tartaros appellamus*, 1248, Франц), Вилгельм Рубрук (*Hystoria Tartarorum*, 1256, Франц), Ата Мелик Жувейни (*Ta-rikh-i-Jahan-Gusha*, 1260, Перс), Марко Поло (*Le divisament dou Monde*, 1295, Итали), Рашид-Эд-Дин (*Jami' al-Tavarikh*, 1310-аад, Перс) зэрэг XIII-XIV зууны сурвалжууд тэргүүлдэг.
- 28 Уг номын англи орчуулгын “Танилцуулга”-д Р. Лэйтхэм ийн дүгнэснийг үндсэнд нь зөвшөөрч болно (Г.Б).
- 29 “The new Mexican” сэтгүүлд тоймч Сэнди Нильсоний “Марко Пологүйгээр бол Бид хаана байх байсан бэ ” өгүүлэлд (2007)
- 30 Марко Поло “Аялал” (Орч. С. Бүрэнжаргал) номын “Төгсгөл” хэсэгт.
- 31 Монголын Эзэнт гүрэн.
- 32 Перс, Араб, Хятад, Дундад Азид Монголчуудыг “зэрлэгүүд” гэж үздэггүй байв.
- 33 Мэтью, Монтеску, Вольтер, ... нарын зэрэг алдартнууд, Франц голдуу муулагчид, нүүдэлчдийн талаар хамгийн мулгуу, өрөөсгөл баримтлалыг түгээж эхэлжээ
- 34 Бүх нүүдэлчдийг адил гэж үзжээ. Амиа аргацаасан “варвар” (бүдүүлэг) тэнүүлч омгуудаас Морьт иргэншийн төрт тогтолцоог ялгаж үзэлгүй иржээ. Полинез (завьт-загасчин), Эскимос(цаатан-анчин) хоёртой Алтай язгуурын (морьтон) түүхийг адилтгах дүгнэлтийг А.Тойнбий анх гаргаж авчээ. Тэгээд эгээтэй л пигмэйчүүд, абригэнүүд, бидэунүүдийн зэрэгт нэрлэх нь холгүй, газарзүйн эрхэмлэх орон зайгүйчүүд, үзлийн тогтолцоогүй бүлгүүдийн тоонд оруулах шахуу юм болж үлджээ.
- 35 *The Mongols; A History by Jeremiah Curtin, With a Foreword by Theodore Roosevelt* (1908, Boston)
- 36 АНУ, Их Британид Дотоод Ази судлалыг хөгжүүлэгч, Эрдэмтэн Овен Латтимор (1900-1989).
- 37 Owen Lattimore. *The Inner Asian Frontiers of China* (1940).
- 38 А.Тойнбий “A Study of History”(1934-1961) хэмээх 12 боть тулгуур бүтээл нь дэлхийн түүхийн талаарх суут “ажил”-д тооцогддог. Уг бүтээлд бүх нүүдэлчдийг “barbar”(зэрлэг, бүдүүлэг) ангилалд оруулж, Төв Азийн нүүдэлчдийг “хагас иргэншил”-д тооцжээ.
- 39 Варвар гэдэг томъёололд үндсэндээ Нүүдэлчдийг хамруулан үзэх болсон ба янз бүрийн нүүдэлчдийн нийгмийн байгууламж, тэдгээрийн ялгааг бага зүйл мэтээр бүхэлд нь ижилсгэн авч үздэг нь Өрнөдийн онолчдын гол алдаа болдог (Г.Б)
- 40 Хубилай(Их Юань улс), Газан (Ил хаант улс) хаадын соёлын бодлогууд.
- 41 XX зууны түүхийн эцэг хэмээх Английн түүхч А. Тойнбий “Түүх судлал” бүтээлдээ Монгол- Түрэгүүдийг “хагас, зогсонги, барьцаалагдсан” иргэншил гэж ангилсан нь Төв Азийн нүүдэлчдийн талаарх түүхэн үзлийн баримжааг тогтоосон гэж үздэг.
- 42 “The new Mexican” сэтгүүлд тоймч Сэнди Нильсоний “Марко Пологүйгээр бол Бид хаана байх байсан бэ? ” өгүүлэлд.
- 43 “Marco Polo’s Influence On Later Explorers” өгүүлэл. <http://www.123helpme.com/marco-polos-influence-on-later-explorers-view.asp?id=160322>

- 44 ЗХУ-ын тэрс үзэлт гүн ухаантан, түүхч Лев Николаевич Гумилёв (1912-1992)
- 45 Л. Н. Гумилев”Этногенез, Дэлхийн био орчин”( 2007. УБ. 120 н.)
- 46 Нэг үе гэдэг нь 25 орчим жил болно (Ред.)
- 47 Дорно зүгийн улсыг ийн нэрлэж байжээ. Судлаачид Серес нь эртний Хятадыг хэлжээ гэдэг.
- 48 Пологийн үед мөн Хайду нарын толгойлсон эзэнт гүрний харьяаны бусад эзэмшил нутаг бас байжээ.
- 49 Энэ талаар өөр шинэ баримт нэмэгдэж байгаа нь 1260-аад онд Англи Доминиканы Дэвидийн (Ашбийн) тэмдэглэлээс олдоод байгаа тэргүүн хэсэг болж байна.
- 50 Бэрх(Barka) гэж хүний нэр, газар нутаг, хот балгадын нэрийн номын англи эх дэх бичлэгийн хэлбэрийг хадгалсан нь бусад ном, газрын зурагтай харьцуулан үзэхэд хялбар байхыг бодолцов (Орч.)
- 51 Рубрук Хархорум хотод мажар угсааны Базил хэмээх Инглишмэний (Englishman) хүүтэй учирч байсан тухайгаа дурьдсан байдаг. Юүлийн (Yule)(op. cit. I, 449) тэмдэглэснээр Хубилай хааны эмнэлгийн албыг Герег хүн толгойлж байжээ. Мөн Пологийн танил Герман инженер ажиллаж байсан гэдэг(х. ). Гэвч энэ бүхнийг үнэн баримт гэж үзэхэд зарим баталгаа хэрэгтэй.
- 52 Шидэт чулуу Самаркандад биш Багдадад байдаг тухай бичсэн хэсэг нь арвандөрөвдүгээр зууны зохиолч Bauduin de Sebourg-ийн бүтээлийг санагдуулна, зохиогч Марко Пологийн яриа, санааг дутуу ойлгосон бололтой.
- 53 Хятад эх сурвалжид энд өгүүлсэн газар зүйн талаарх эмх цэгцгүй зүйл огт таардаггүй. Мөн гэгээнТомасийн домогт гарч байгаа “a grain called rice” гэх мэтийн утга авцалдаагүй зүйлс бусад эх сурвалжид үгүй билээ.
- 54 Жакобо д’Аккүйн номонд “as liver millions de magnis mirabilibus mundi” гэж өгүүлсэн бий.
- 55 Хятадын усан замын тээвэр-худалдааны тухай ярихдаа Марко Поло: үр тариа, давс, төмөр, мод, модны нүүрс, олсны ургамал зэргийг онцгойлон дурьдсан байдаг.
- 56 Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл бодол Маркод байсангүй. Африкийнхнийг царай муутай, муухай төрхтэй гэснээс биш нийгэмд хамгийн адгийн байранд байх үндэстэн ястан гэж ялгаварлаагүй байдаг (Орч.)
- 57 Хол ойрын зайг “өдөрчийн газар” нэгжээр хэмждэг байсан нь Марко өртөө улаагаар зогсоо зайгүй довтолгодоггүй аажуу тайван аялдаг байжээ гэж бодогдуулна.
- 58 Нохойн толгойтой сүүлтэй хүмүүс, Эрчүүдийн болон Эмсийн арал, Очир эрдэнэсийн хөндий, рух шувууны домог гэх мэтийн үлгэр домог шиг зүйлс Марко Пологийн ярианд хааяагүй тохиолдоно.
- 59 Бенедеттогийн дурьдаж буй “Z”-хувилбар нь арваннаймдугаар зуунд үйлдсэн хурдан бичлэгийн тэмдэглэл хэлбэрээр байх агаад жинхэнэ эх нь арвантавдугаар зууны гар бичмэлээр Толедод хадгалагдаж буй. Түүнийг Профессор Моули болон Пелло нар хянан нягтлаж цэгцэлсэн буй.
- 60 Рамуссиогийн ашигласан латин хувилбар нь F-хувилбараас сүүлд бичигдсэн гэдэг тодорхой баримт сэлт бий.
- 61 Z-хувилбар нь Марко Полог Генуягийн шоронгоос гарснаас хойш хийсэн нэмэлт, тодруулга оржээ гэж үзэх нэгэн баримт бий, тэр нь 1299 оны намар өөд болсон Ногай ханы тухай тэмдэглэл.
- 62 Имаго Мунди гэх нэгэн бүтээл байх агаад зохиогч нь арвандөрөвдүгээр зуунд амьдарч байсан Жакопо д’ Аккүй байж магадгүй, Марко Полог өөд болоход нь байсан гэх боловч

Маркогийн ярьсан зүйлийн тал нь ч энэ бүтээлд орсонгүй.

63 Профессор Бенедеттогийн тодорхойлсноор эдгээр бүтээлд баримт сэлтээс илүү Итализмийн үзэл нэвт шингэсэн зүйлс гэжээ.

64 Марко Поло монгол, түрэг хэлийг төгс эзэмшсэн төдийгүй фарси хэл гадарладаг бас хятад хэлийг ч сайн мэддэг байжээ гэх таамаглал оргүй зүйл биш ээ.

65 Монголчуудыг тартар хэмээх нэрээр уг номонд бичжээ. “Монгол татар” овгийн нэртэй дуудлага ойролцоо үг. Библи сударт там шулмын “Тартарус” нэрт цэргүүд гардаг ажээ. Европчууд үүнийг монгол татарын нэрийг сударт зөгнөн өгүүлжээ хэмээн итгэснээс монголчуудыг “Тартар” гэх болжээ (Орч.)

66 R-хувилбарт бий. Харин Их хааны хараат нутаг орны тухай тун бага зүйл дурьдсан ажээ

67 Эрхэмсэг Понте гэж зөвхөн V хувилбарт л нэг удаа дурьдсан байдаг.

68 Амударья юм уу Сырдарья мөрний аль нэгийг ташааран Тигрис гэж нэрлэсэн бололтой.

69 Их хаан үүнийг загалмайн Нестор урсгалыг шүтэн мөргөдөг өөрийн эхдээ зориулан хийжээ гэж V хувилбарт дурьдсан байна. Их хааны эх нь 1252 онд тэнгэрт хальжээ.

70 V хувилбарт дурьдсанаар Их хааны ач, загалмайн шүтлэгтэй Чаризиера гэгч авгынхаа эсрэг босон тэмцэж говь цөлийг туулах замыг хааж нүх шуудуу ухааж бэхлэлт хийсэн тул аялагсад цаашаа явах замгүй болж саатжээ.

71 V хувилбарт: Тэдний туулан гэтлэх газар нутаг явахын аргагүй салхи шуургатай байв гэжээ.

72 R-ийн дурьдсанаар: Далайн аян аюул осолгүй төгссөн тухай Марко тайлагнасан байв гэжээ.

73 FB (Британы музейд францаар үйлдсэн MS-д) “Английн” гэж нэмсэн байна.

74 Бага Ява гэж Суматра арлыг хэлсэн бололтой.

75 V хувилбарт R-ийн өгүүлсэн “нэгэн эмэгтэй” гэсэн нь амьд мэнд үлдсэн гүнж байсан бололтой.

76 Хубилай хаан 1294 оны эхээр тэнгэрт хальсан тухай мэдээ дэлхий ертөнцөөр тархсан гэж R нэгэнт дурьдан бичжээ. Гэвч энэхүү номонд тэр цагаас бүр хойш Их хааныг амьд сэрүүн мэтээр хааяагүй бичсээр байсныг анзаараарай, тэр ч байтугай Гахайт ханы талаар бичсэн хэсэгт ч Хубилай хааныг амьд сэрүүн мэтээр дурссан байна.

77 Их армений оршин суугчид нь жинхэнэ Загалмайтнууд болж хараахан чадаагүй хүмүүс, тэдэнд Христийн шашныг ёсоор нь номлох хувраг дутаад байгаа юм.

78 MS(LT)-хувилбарт “Пиза” гэж байгаа юм.

79 Орой нь “аяга шиг” гэсэн байх агаад энэ бол Арарат уул (Орч.)

80 Үхэгт онгоц цасан дотор харлаж харагддаг гэх боловч тэр болгон сайн харагддаггүй байна. Нутгийн уугуул хүмүүс харлаж харагдаад байгаа зүйл бол хорвоог аварсан онгоц гэгцгээх.

81 Z-хувилбарт “1000 тэмээ” гэж дурьдсан байдаг. Энэ газар бол яах аргагүй Каспийн далайн эрэг дэх Баку.

82 Македоний Александр хаан.

83 R-хувилбарт “умар талаас нь” гэсэн тул Ижил мөрөн бололтой.

84 Z-хувилбарт бий бөгөөд “бас Арменууд” гэсэн буй.

85 Мосулын ойролцоо оршин суудаг.

86 Яг үнэндээ бол 1258 он.

87 F-хувилбарт товчхон дурьдсан байдаг. Энд R-хувилбарт байгаа янзаар нь буулгав.

88 Z болон F-хувилбарт “1275 он” гэж байх боловч өмнөх бүлгүүдтэй нь харьцуулж үзэх боломжгүй юм.

89 Энэ тухай зөвхөн Z-хувилбарт л бий.

- 90 FB-хувилбарт “ялангуяа Генуягаас” гэж бий.
- 91 Энэхүү сүүлчийн өгүүлбэр зөвхөн V болон R-хувилбарт бий.
- 92 L,V болон R-хувилбарт: Тебризээс Перс хүртэл 12 өдөрчийн зайтай гэжээ.
- 93 Лахор хот байх магадлалтай.
- 94 Z-хувилбарт тэр модыг хатааж байгаад хадаас хийдэг гэжээ.
- 95 V-д: Индранил чулуутай гуравдахь уул гэжээ.
- 96 R-хувилбараар: Марко Хормузад ирсэн цагаасаа хойш бүтэн нэг жилийн турш өвчилсөн бөгөөд өндөр уулын цэвэр агаарт очиж байж эдгэжээ.
- 97 L хувилбарт өгүүлснээр: Үүнээс цааш арван хоёр өдөрчийн газар яваад л чинжүү их ургадаг Бярмануудын ханлигт хүрнэ.
- 98 Хайду ханыг Цагаадай хааны ач гэж андуурсан бололтой. Хайду нь Өгөөдэйн ач (Орч.)
- 99 Z-хувилбарт: Энэ нутгийн хүмүүсийн нэг хөл нь нөгөөгөөсөө том байх боловч явах,хөдлөхөд нь саад болдоггүй гэжээ. Мөн V болон L-хувилбарт: Хүмүүс нь хоолойдоо бахлууртай гэжээ. R-энэ бүхэн тэндхийн уснаас болдог гэжээ.
- 100 R-хувилбарт: Олс, хар тамхи болон үр тариа гэж дурьдсан буй.
- 101 L-хувилбарт: “Өвөл” гэж дурьдсан буй.
- 102 Z-хувилбарт: “амт шимтийг нь сорон иднэ” гэжээ.
- 103 Z-хувилбарт: Хувцастай нь чандарлана гэж байхад, L- хувилбарт өнгийн бөс даавууг хамт шатаана гэжээ.
- 104 Үүнийг R-хувилбараас авав (энэ тухай V болон L хувилбарт зарим зүйлийг дурьдсан буй)
- 105 V-хувилбарт ингэж дурьдсан боловч одоо болтол чухам ямар газрыг ингэж нэрлэж байгааг нэг мөр олж тогтоогоогүй билээ.
- 106 Энэ бузар ёсыг Мөнх хаан хүчээр халах гээд дийлээгүй.
- 107 Нутгийн түрэгүүдийг ингэж нэрлэжээ гэж Z-хувилбарт дурьдсан буй.
- 108 Шөрмөсөн чулууг нэрлэжээ. Бас Z-хувилбарт дурьдсан буй.
- 109 FB-“төрсөн эхээсээ бусадтай нь” гэжээ.
- 110 V-хувилбарт: Ус ихтэй газар нь цурхай болон бусад загас гэжээ.
- 111 “Хархорум” Монголчууд анх түрүүн байлдан эзэлж эзэмшсэн нутаг.
- 112 Хөлөн Буйр нуурын орчим болов уу.
- 113 Хэрэйдийн хан Тоорил Ван буюу Ван Хаан.
- 114 Манжуурт гэж байгаа бөгөөд R-хувилбарт: Байгаль далайн ойролцоох Баргу гэсэн нь Баргужиний тал мөн.
- 115 Өгөөдэй хааныг гэж таамагладаг.
- 116 Бат хаан болон Хүлэг хаан Монголын их хаанд өргөмжилөгдөж байгаагүй гэдгийг MSS-д өгүүлсэн буй. Мөн Altou гэдэг нь Oktai (Өгэдэй) нэрийн гажсан дуудлага гэж Бенедетто тогтоожээ.
- 117 L болон V-хувилбарт өгүүлснээр: Илүү дутуу сав суулга тээж явдаггүй, махаа малынхаа гэдсэнд хийж явах ба хамтад нь чанаж иднэ гэжээ.
- 118 Ааруул.
- 119 Их засаг хууль бололтой.
- 120 Баргужиний тал бололтой.
- 121 Сарлагийн саваг ба хөөвөр.
- 122 Хүдрийн заар.
- 123 Онгудын нутгийг өгүүлж буй бололтой.
- 124 Онго шүтлэгтний энэхүү ид шидийг VB болон R-хувилбарт нэлээд тодорхой өгүүлсэн

- байдаг.
- 125 Хубилай хаан
- 126 R-хувилбарт: Хубилай нь тартар цэргийн дотор урьд хожид гарч байгаагүй ухаалаг, туршлагатай жанжин гэж тэмдэглэжээ.
- 127 R-хувилбарт: Хубилай хаан Наян ноён болон Хайду ханы анхаарлыг татахгүйн тулд зөвхөн Хан-балик хотын эргэн тойрон арван өдөрчийн газар байсан цэргүүдийг дайчлав гэжээ.
- 128 VB хувилбарт зөөлөн аялгуу бүхий хоёр утаст хөгжмийн зэмсэгүүд хийдэг гэжээ.
- 129 Наян ноён нестор урсгалын загалмайн шүтлэгтэн байжээ.
- 130 Зөвхөн R-хувилбарт дурьдсан буй.
- 131 Цэргийн хэргийг эрхлэн шийтэгдэг арван хоёр ноёны зөвлөл байдгийг R-хувилбарт дурьдсан буй.
- 132 Венецийн сагги гэдэг нь унцийн зургааны нэг хувьтай тэнцэнэ.
- 133 R-хувилбарт бий.
- 134 R болон MSS-хувилбарт тодорхой бичиж үлдээсэн буй.
- 135 Хубилай хааны хаан ор залгах хүүгийн жинхэнэ нэр нь Чингэм бөгөөд үүнийг R-хувилбарт Чингэмийн хүү Төмөр эцгийнхээ ор залгамжлан 1294 онд Хубилай хааны орыг залгасан гэжээ.
- 136 R-хувилбарт бүрэн байгаа.
- 137 R-хувилбараас хуулан авав.
- 138 Үүнийг R-хувилбараас авч MSS-хувилбараас авсан хэсгийг нэмэн бичив.
- 139 MS (FG)-хувилбараас авав.
- 140 Зөвхөн R-хувилбарт бий.
- 141 Зөвхөн R-хувилбарт бий.
- 142 R-хувилбарт: Нэг төрлийн хувцсыг арав орчим жил хэрэглэнэ гэжээ.
- 143 Эхний өгүүлбэр нь зөвхөн R-т буй, удаах өгүүлбэр нь F-д бий.
- 144 Түрүүчийн өгүүлбэр нь зөвхөн R-хувилбарт, дараагийнх нь F-хувилбарт тус тус буй.
- 145 R-хувилбарт энэ тухай нэлээд тодорхой бий. Цаасан мөнгөний эдийн засгийн өгөөж, түүнийг бэлтгэх технологийн зарим зүйлс өнөө болтол тодорхой бус.
- 146 R-хувилбарт: Цаасан мөнгөний гүйлгээ, солилцоо, ашиг орлого гэх мэтийг нэлээд тодорхой өгүүлсэн буй.
- 147 R-хувилбарт: Ийм газар нутагт өртөөний алба хашдаг хүмүүсийн амьдрал ахуйг хэрхэн тэтгэдэг тухай бий.
- 148 R-хувилбарт буй мөн MSS-хувилбарт энэ тухай дэлгэрэнгүй бий.
- 149 Зөвхөн R-хувилбарт бий.
- 150 Зөвхөн R-хувилбарт бий. Чулуун нүүрс.
- 151 Энэ тухай R болон MSS-хувилбарт товчхон дурьдсан буй. Харин Z-хувилбарт нэлээд тодорхой бий.
- 152 R-хувилбарт бий.
- 153 R-хувилбарт: Дарс эндээс Хятадад нийлүүлдэг гэсэн нь “хятадын бусад хэсэгт” гэсэн санаа болов уу. Оршин суугчдыг торгоор хангадаг ялмын мод асар их ургадаг гэсэн нь эндүүрэл болов уу. F-хувилбарт Тайюаньфу мужид дарс нэрдэггүй гэсэн нь L-хувилбарт Хятадыг андуурсан шиг юм болсон бололтой. Энэ бүлгийн бусад мэдээг Z-хувилбарын Рэндээс авав.
- 154 Энэ тухай зөвхөн R-хувилбарт дурьдсан буй.

- 155 Z-хувилбарт: Хятадын бусад хотуудад цөөн тооны Нестор шүтлэгтэй Түрэг болон Сарацинууд бий гэжээ.
- 156 MSS-д үүнийг Нэг хоногийн орлого гэж өгүүлжээ.
- 157 Поло гуайн “Түвд” гэсэн нь Түвдийн дорнод хилтэй залгаа Юньнань муж бололтой.
- 158 FB-хувилбарт: Энэхүү дуу чимээнд дасаагүй аялагчид чихээ таглаж, толгойгоо битүүлэн орооно гэжээ.
- 159 Том том сувд хэлхсэн хүзүүний зүүлт байсан байж магадгүй, Z-хувилбарт “хувь” гэж дурджээ.
- 160 Баруун зүгийн ертөнц гэснийг R-хувилбарт: тун харьцангуй ойлголт гэж тайлбарлаад энэ зүг нь бараг л өмнө зүгийг хэлж байгаа юм гэжээ.
- 161 Z болон R-хувилбарт өгүүлснээр: Нутгийн хаадыг халж Их хааны томилсон “амбан захирагчид”-аар сольжээ.
- 162 R-хувилбарт: Давстай том нуур гэжээ.
- 163 R-хувилбарт бичсэнээр авав, мөн F-хувилбарт товч дурьдсан буй.
- 164 Хятадын Юньнани мужийн Түрэг нэр.
- 165 Presumalbu нь Бирма орох замд таарах долоон ханлигийн эхнийх нь бөгөөд Яачи гэдэг нь Юнаньфу болой.
- 166 Матар (Орч.)
- 167 Поло гуайн өгүүлснээр VB болон R-хувилбарт энэ тулалдаан 1277 онд болсон гэжээ.
- 168 R-хувилбарт: Бунхан нь алтан, мөнгөн хавтангаар бүрээстэй гэжээ.
- 169 Шивээс хийдэг талаар Z-хувилбарт дурьдсан байдаг. Харин R-хувилбарт шивээсээр мэргэжсэн шивүүрчний тухай бий.
- 170 Z болон R-хувилбарт: Өөрсдийн сүм дугантай цөөн тооны Загалмайтнууд бий гэжээ.
- 171 Changlu гэдэг нь Tsang-chau-гийн эртний нэр. Тандинфу болон Иенчау хотуудыг хооронд нь хольж хутгасан тал байх шиг байна.
- 172 Энэ үйл явдлыг зөвхөн Z-хувилбарт дурьдсан буй.
- 173 T’si-ning-chau-г хэлж байгаа бололтой. Piju ба Siju гэж Pei-chau, Su-t’sien хоёрыг нэрлэсэн бололтой. Linju гэж чухам юуг нэрлэсэн нь тодорхойгүй байна.
- 174 Энэ тухай Z болон R-хувилбарт бий.
- 175 Өмнөд Хятадын Сүн улсыг байлдан эзэлсэн Их жанжин Баян.
- 176 R-хувилбарт: Хотын оршин суугчдыг толгой дараалан цаазалсан гэжээ.
- 177 Z-хувилбарт: Түрэг гаралтай нестор урсгалын Загалмайтнууд бөгөөд энд өөрсдийн мөргөлийн сүмтэй гэжээ.
- 178 R-хувилбарт: Марко Поло нь Их хааны хянан тохинуулах ноёдын бүлэгт ажиллаж байжээ гэсэн буй. Латин эх сурвалжийн MS-хувилбарт бүлгийн ахлагчаар гэж байгаа.
- 179 MS (FG)-хувилбарт: Жаран бөөрөнхий чулуу бэлтгэж түүнийгээ маш алс зайд харваж байв. Үүнийгээ их хаан болон ордныхонд харваж үзүүлэхэд тэд машид хөхөн баясацгаав гэжээ. Энэ тухай мөн R-хувилбарт дурьдсан буй.
- 180 Яг үнэндээ бол “баруун урд зүг”, Синжу биш Ичинг байсан бол зөв.
- 181 Z-хувилбарт: Голын (Yang tze Kiang) урт нь 120 өдөрчийн газар болох бөгөөд тоо томшгүй олон гол цутгана гэжээ. FG-хувилбарт: Голын урсгал сөрөн жилдээ 200000 онгоц хөвөх агаад уруудахыг нь тоолоогүй гэж гаалийн ажилтан Марко Поло-д ярьсан байдаг, үүнийг Z-хувилбараас авав. Энэ нь “Хөх мөрөн”.
- 182 Үүнийг R-хувилбараас авав.
- 183 Энэ тухай зөвхөн R-хувилбарт бий. Марко Кинсайд олон удаа очсон бөгөөд Хатан хааныг

Баян жанжинд захиа бичихийг Марко Поло зөвлөж байсан гэж FB-хувилбарт тэмдэглэжээ.

184 MS болон A(VA)-хувилбарт: Венецитэй адилхан усан дунд байдаг гэсэн байдаг.

185 Эдгээр нийтийн угаалгын газар нь дан халуун устай юу? Эсвэл хүйтэн устай юу? гэдэг нь тодорхойгүй.

186 Энэ хэсгийг Z-хувилбараас авав.

187 Энэ хэсгийн эх нь зөвхөн Z болон R-хувилбарт байх авч төгсгөлийн ихэнх нь Z-хувилбарт байх.

188 Төрөл бүрийн амттан дотор нь элсэн чихэр орсон байсан тул “хуурай хүнсний” гэж нэрлэсэн бололтой.

189 Энэ тухай зөвхөн Z-хувилбарт бий.

190 R-хувилбарт: Кинсайг дайран урсдаг их голын салаа нь Тинжуг дайран урсана.

191 Энэ тухай Z-хувилбарт ерөнхийлөн, харин R-хувилбарт тодорхой бий.

192 Z-хувилбарт дурьдсан буй.

193 Зөвхөн Z-хувилбарт бий.

194 Марко Поло-өөрийнхөө энэ их мэдлэгийн нэг хэсгийг Их хааны зараалаар Энэтхэг орноор аялан ажил үйл бүтээж явахдаа, бас нэг хэсгийг Аргун хааны хатаныг хүргэх урт аяныг туулахдаа, нэг хэсгийг нь өөрийнхөө гярхай ажигламтгай төрх, харсан үзсэнээ тунгаан цэгнэх ухааны цараагаар, бас нэг хэсгийг нь далайчдын үлдээсэн зураг, тэмдэглэл, тэдний ярианаас олж авсан нь гарцаагүй бөгөөд энэ их мэдлэг, мэдээлэлдээ дулдуйдан... “Энэтхэгийн тухай ном эндээс эхэлж байна”... гэж өгүүлэх бүрэн эрхтэй билээ.

195 Энд болон цаашдаа гарах зүйлс, үйл явдлын ихэнх нь Z болон R-хувилбарт өгүүлсэн зүйлс.

196 Далайн эрэг дагуух аяллын талаар FB-хувилбарт байх боловч ихэнх нь зөвхөн Z-хувилбараас авсан зүйлс.

197 FB-хувилбарт: “Түүний хаанчлалын үед” гэжээ.

198 FB-хувилбарт: “Эзэнгүй хоосон арал байсан” гэжээ.

199 Z-хувилбарт “Эгейн тэнгис” гэсэн бий.

200 Z болон R-хувилбарт: Хятад болон Энэтхэг-Хятадын хоорондох асар өргөн хоолой гэжээ. Чейнам гэдэг нь Хайнань арал байх магадлалтай.

201 R-хувилбарт: “Ассамбала” гэдэг нэр бол чухамдаа “Индраварман” гэсэн үг бөгөөд Чамба гэдэг нь Өмнөд Аннам болой.

202 MSS-хувилбарт: 1275-аас 1288 оны хооронд гэж бий.

203 Сиам эсвэл Малайя.

204 Бразил мод гэсэн нь “berzi” гэсэн үгийг андуурсан бололтой гэж R-хувилбарт өгүүлсэн буй.

205 Z болон F-хувилбараас авав.

206 Z-хувилбарт: “Марко Пологийнхон бараг 2000 хүнтэй баг байсан” гэх ба Z болон R-хувилбарт нэн тодорхой бий.

207 R-хувилбарт бий.

208 Z-хувилбарынхыг авав. VB болон R-хувилбарт бий.

209 Суматра арлын хойт үзүүр.

210 FG-хувилбарт бий.

211 Маабар гэж Энэтхэгийн зүүн эргийн Коромандел орчмыг нэрлэж байна. Z-хувилбарт: Энд дөрөв биш таван ханлиг байдаг. Их Энэтхэг нь Маабараас гадна олон муж газрыг багтаадаг.

- 212 Зөвхөн VA-хувилбарт бий.
- 213 VA-хувилбарт бий бөгөөд шөнө сувдтай хясаа түүхийг зөвшөөрдөггүй.
- 214 Тамил дуудлага Z болон R-хувилбарт бий.
- 215 Зөвхөн Z болон R-хувилбарт бий.
- 216 Чухамдаа Малабарт л ийм байдаг.
- 217 Z-хувилбараас авав. Поло гуай өөр хаана ч энэ тухай дурсаагүй байдаг.
- 218 Зөвхөн Z-хувилбарт.
- 219 R-хувилбарт “500 бээр” гэжээ. 1295 онд Хаан ширээнээс татгалзсан хатан бол Рудрама Деви мөн. Очир эрдэнэсийн уурхайнууд нь араб домогт гардар Хайдарабад нутгийн Голконда болон бусад уурхайнууд.
- 220 Z-хувилбарт: марко Поло энэ шорооноос Венеци рүүгээ авч явсан гэжээ.
- 221 Z-хувилбарт: “дээрх ноён” гээд үргэлжлүүлэн өгүүлсэн буй.
- 222 Гужарат муж.
- 223 R-хувилбар: Энэхүү түүхийг Марко Поло харих замдаа сонссон гэдэг. Монголоор “Бурхан” гэсэн нь Санскритаар “Будда” гэсэнтэй адил утгатай.
- 224 Энэ боломжтой юу гэсэн асуулт.
- 225 VA-хувилбарт бий. Энэхүү түүх гэгээн Иосифийн амьдрал, түүхтэй нэн адилхан.
- 226 Зөвхөн Z болон R-хувилбарт бий.
- 227 V болон Z-хувилбарт: “чавганаас” гэжээ.
- 228 Коморийн хошуу бол Марко Поло Энэтхэг орох замдаа анх түрүүн очсон газар.
- 229 Гэрлүүгээ буюу нутаг орон руугаа ойртсоор буй гэсэн санаа.
- 230 Z-хувилбарт: Марко Поло өөрөө баруун талаас нь ирсэн тул “баруун зүг” гэж ойлгосон бололтой.
- 231 V болон Z-хувилбарт “баруун-хойт зүг” гэжээ.
- 232 Z-хувилбарт: Бас бусад гэсэн байх.
- 233 Z болон R-хувилбарт: “Сарацин болон улаан буудай” гэжээ.
- 234 Z-хувилбарт: “Арван хоёр нас хүртэл” гэжээ.
- 235 Халимын тухай зөвхөн Z-хувилбараас авав. R-хувилбарт маш товчхон дурьдсан буй.
- 236 R-хувилбарт: “халимын заарыг гэдэснээс нь, тосыг толгойноос нь” гаргаж авдаг.
- 237 Z-хувилбарт: “Арлынхан сонгож, Католикус баталдаг” гэжээ.
- 238 Энэ нэр MSS-д янз янзын дуудлагаар орсон буй. Z-хувилбарт Mogdaxo мөн Сомали газрын Могацишу гэх мэт. Энэ газрыг Африк тивийн эх газар, арал хоёрын хооронд орших Занзибар гэж Марко Поло нэрлэсэн агаад Дорнод Африкийн том газар гэсэн боловч Марко Поло өөрөө энэ арал дээр очиж байсангүй.
- 239 Z-хувилбарт: “ихэнх хэсэг нь” гэжээ.
- 240 Z-хувилбарт: “Энэ муж нутагт” гэжээ.
- 241 Z болон R-хувилбарт: “Жигүүрийн урт нь арван зургаан тохой, өд сөд нь найман тохой” гэжээ.
- 242 VA-энэхүү том гахай нь хиппопотам бололтой.
- 243 Z-хувилбарт: Энд Томас гэгээний тухай зүйл дурсагдаагүй.
- 244 R-эндхийн эрчүүд Энэтхэгийн олон мужид хөлсний цэрэг болон очдог.
- 245 Z-хувилбарт: “арван хоёроос арван дөрвөн хүн” гэжээ.
- 246 R-хувилбарт: “Энэ газар алт ихтэй” гэжээ.
- 247 R болон VA-хувилбарт: Нил мөрөн.
- 248 Зөвхөн Z-хувилбарт бий.



- 249 R-хувилбарт: “бас шар будаа” гэжээ.
- 250 Хараал зүхлээр гутаах, хорон үг.
- 251 Цагаадайн биш Өгөөдэйн ач хүү.
- 252 Эзэн Чингисийн хоёрдахь хүү.
- 253 FB-хувилбарт бий.
- 254 Z болон V-хувилбарт: “дөрвөн чавхдастай” гэжээ.
- 255 Хотолон буюу Хотол Цагаан гүнж.
- 256 Z-хувилбарт бий.
- 257 Бугын арьсан хувцастай гэжээ.
- 258 Энэ нэр зөвхөн MS-хувилбарт бий.
- 259 Z-хувилбарт: “газар хаяв” гэжээ.
- 260 Энэ тулалдаан 1269 онд умарт Херат мужид болжээ.
- 261 Аргун хаан 1291 оны гуравдугаар сард өөд болсон бөгөөд орд өргөө нь Тебризэд байсан болов уу.
- 262 MSS (LT and P)-хувилбарт хоёр янзаар дурьдсан буй.
- 263 LT болон R-хувилбарт: “Ихэнхдээ өвлийн сарууд” гэжээ.
- 264 Z-хувилбарт бий.
- 265 Зөвхөн Z-хувилбарт Оросын амьдралын хэв шинжийг бичсэн бий.
- 266 Исгэсэж нэрсэн архи буюу “самогон”.
- 267 Энэ тулааны тухай оршил үгэнд буй бөгөөд Хүлэг хааны хувьд онцгой сайн зүйл болоогүй гэж тэмдэглэсэн буй.
- 268 Энэ нутаг нь Доны их тал газар болов уу даа.
- 269 Z-хувилбарт буй бөгөөд 1299 онд болсон үйл явдал.

## МАРКО ПОЛО АЯЛАЛ

### ДЭЛХИЙГ НЭЭСЭН БИЧИГЛЭЛ

Марко Поло (1254-1324) бол Умард мөсөн далайгаас Ява арал, Японоос Занзибар хүртэл Евроазийн эх газраар 20 гаруй жил хэрэн жуулчилж, урьд өмнөх хэнтэй ч зүйрлэшгүй замыг туулсан гайхамшигт аялагч билээ.

Тэрбээр өргөн далайцтай түүхэн тэмдэглэлийг хүн төрөлхтөнд үлдээжээ.

Дэлхий даяар дуулиантсан түүний энэхүү ном нь Монголын эзэнт гүрний ертөнц ба Энэтхэг, Перс, Ойрх Дорнод хэмээх 800 жилийн өмнөх дэлхийн гол гол иргэншлүүдээр аялсан адал сонинд тулгуурлажээ. Европынхон үүнээс өмнө Дорнын талаар тун базаахгүй, бас арчаагүй бага мэдлэгтэй байжээ.

Түүний аав Николло, авга ах Маффео нар залуу Марког дагуулан Их Монгол гүрний Юань улсад 1271 онд очжээ. Марко Поло нь Хубилай хааны дэргэд бараг 20 жил алба хашиж, Их хааны дипломат элчээр цөөнгүй удаа томилогдож байв. Тэрбээр 1295 онд Өрнөдөд буцаж очжээ. Хот-улс хоорондын дайнд оролцон олзлогдож Генуя хотын шоронд сууж байхдаа туульсын зохиолч Рустичеллод Дорно зүгт аялсан адал явдлаа ярьж, улмаар энэхүү тэмдэглэл-түүхийг хамтран бүтээсэн гэдэг.

Итали нутгийн шоронд зохиолч, худалдаачин хоёрын бүтээсэн энэ түүх нь худалдаа арилжааны ертөнцөд шинэ газар орны эрэлд гарах дуудлага болжээ.

Түүний хүүрнэл зохиол, баримтууд нь Христофор Колумб зэрэг дэлхийн олон аялагчдын гарын авлага болж байснаараа манай гараг дээрх Аяллын аугаа номуудын нэг болж үлдсэн билээ.

Эртний ертөнц, тэр дундаа уг номын суурь сэдэв болсон Монголын эзэнт гүрнээр аялан зорчих аз Уншигч танд тохиож байна!



[www.bolorsudar-publishing.mn](http://www.bolorsudar-publishing.mn)

# Table of Contents

[Орчуулагчын өчил](#)

[Уншигчдад хүргэх үг](#)

[Дундад эртний “Bestseller”-ийн нөлөө ба “Худалч” Марко](#)

[Танилцуулга](#)

[Оршил үг](#)

[Нэгдүгээр бүлэг. Ойрх дорнод](#)

[Хоёрдугаар бүлэг. Катай орох замд](#)

[Гуравдугаар бүлэг. Хубилай хаан](#)

[Дөрөвдүгээр бүлэг. Бээжингээс Бенгал орох замд](#)

[Тавдугаар бүлэг. Бээжингээс Амой орох замд](#)

[Зургаадугаар бүлэг. Хятадаас Энэтхэг орох замд](#)

[Долоодугаар бүлэг. Энэтхэг орон](#)

[Наймдугаар бүлэг. Арабын тэнгист](#)

[Есдүгээр бүлэг. Умарт бүс нутаг ба Тартаруудын дайн](#)

[Төгсгөл үг](#)

[Товьёг](#)

[Тайлбар](#)